Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 2022 оны 6 сарын 30-ны өдрийн дотор Монголбанкнаас банкны системд нөлөө бүхий[1] гэж тогтоогдсон банк энгийн хувьцаагаа нийтэд санал болгох замаар арилжиж, нээлттэй хувьцаат компанид шилжих замаар өөрчлөн байгуулагдах бол бусад банкууд өөрийн сонголтоор нээлттэй эсвэл хаалттай хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх үүрэг тус тус хүлээсэн. Ингэхдээ, нэг хувьцаа эзэмшигч дангаараа болон холбогдох этгээдийнхээ хамт тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20-иос хэтрэхгүй хэмжээний хувийг эзэмшихээр тогтоосон байна. Хуулийн энэхүү шаардлага нь 2023 оны 12 сарын 31-ний өдөр хангагдсан байхаар зохицуулагдсан.

### 2.2.3. Банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөө

Богд Банк нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн иргэдийн, олон нийтийн банк болох зорилт тавин ажиллаж ирсэн бөгөөд Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хийгдэх хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, өөрийн харилцагч, үйлчлүүлэгчдэд банкны хувьцаа эзэмших боломжийг олгон, тэндээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үйл ажиллагаагаа тэлэх, улам боловсронгуй болгох нээлттэй хувьцаат банк болохоор зорин ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь "Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль", Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны "Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах түр

[1] Банкны тухай хуулийн 3.1.20-т зааснаар "банкны системд нөлөө бүхий банк" гэж банкны хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал зэрэг шалгуурыг нэгэн зэрэг баримтлан банкны тогтолцоонд нөлөөтэй гэж Монголбанкнаас тогтоосон банкийг хэлнэ.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ5866 5903858

журам" болон Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу 2021 онд Банкны нийт энгийн хувьцааны 20 хувийг анх удаа олон нийтэд санал болгон, 2023 онд 5 орчим хувийг нийтэд арилжаалахаар төлөвлөж байна.

Богд Банк нь хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгон арилжсаны дараагаар банкны хамгийн том хувьцаа эзэмшигч Бодь капитал ХХК болох бөгөөд Банк 2023 оныг хүртэл дараах байдлаар хувьцааны төвлөрлийг бууруулахаар төлөвлөж байна:

- Банк 2021 оноос эхлэн ажилчдадаа банкны хувьцаа эзэмшүүлэх ESOP хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн ба хөтөлбөрийн хүрээнд жил бүрийн нэмэгдэл цалин, үр дүнгийн урамшууллыг банкны энгийн хувьцаагаар олгоно. Банк нь 2021 онд банкны энгийн хувьцааны 1 хүртэлх хувийг ажилчдадаа эзэмшүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

- Банк нь 2021 онд банкны нийт хувьцааны 20.0 хувийг нийтэд санал болгон арилжаалах ба 2023 онд дахин нийт энгийн хувьцааны 5 хувийг нийтэд санал болгон арилжаалахаар төлөвлөж байна.

- Банк нь нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болж засаглал, хяналтын тогтолцоо сайжран банкны үйл ажиллагаа тэлэх, ашигт ажиллагаа нэмэгдэхийн хэрээр банканд хөрөнгө оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэж байгаа бөгөөд ирэх жилүүдэд банкны хамгийн том хувьцаа эзэмшигч болох Бодь капитал ХХК нь эдгээр хөрөнгө оруулагчдад хувьцаагаа худалдах байдлаар хувьцааны төвлөрлийг бууруулахаар төлөвлөж байна.

## 2.3. Үнэт цаас гаргах тухай шийдвэр

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Үнэт цаас гаргагч нь 2021 оны 2 сарын 2-ны өдрийн ТУЗ-ийн 21/06 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан, Банкийг өөрчлөн байгуулах тухай асуудлыг хэлэлцэхээр хуралдан, Банкны тухай хуулийн 28.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 18.1 дэх хэсэг болон Үнэт цаас гаргагчийн Удирдлагын хорооны 2021 оны 1 сарын 14-ний өдрийн 21/03 тоот хурлаас гарсан шийдвэр, Компанийн дүрмийн 7.3.2, 7.3.4, 7.3.8, 8.12.5, 8.12.6, 13.1, 13.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Богд Банкийг өөрчлөн байгуулах, энгийн хувьцааг шинээр нэмж гарган Биржээр дамжуулан нийтэд нээлттэй арилжих замаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, улмаар хувьцаат компани болгон хэлбэрээ өөрчлөх саналыг банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр

Банкны хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу Үнэт цаас гаргагч нь 2021 оны 4 сарын 1-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 21/06 тоот шийдвэрээр Банкийг өөрчлөн байгуулах тухай хуралдан, Банкны тухай хуулийн 28 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйл болон Үнэт цаас гаргагчийн Удирдлагын хорооны 2021 оны 1 сарын 14-ны өдрийн 21/03 тоот хурлаас гарсан шийдвэр, Компанийн дүрмийн 7.1, 7.3.2, 7.3.4, 7.3.8,

13.1, 13.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Богд Банкны 20 хувьтай тэнцэх энгийн хувьцааг шинээр нэмж гарган, нийтэд нээлттэй арилжих замаар Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулсан саналыг зөвшөөрч, үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбогдох үйлчилгээ үзүүлэх компаниудыг сонгон хамтран ажиллахаар шийдвэрлэсэн байна.

## 2.4. Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг 2021 оны 3 сарын 2-ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2021Y/VAL-001 тоот дугаартай Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээний дагуу БДО Аудит ХХК хийж гүйцэтгэсэн.

Хараат бус үнэлгээний байгууллага нь үнэлгээг олон улсын стандартын дагуу орлогын хандлагын Илүүдэл ашгийн аргыг ашиглаж хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалахаас өмнө болон арилжаалсны дараах байдлаар хийсэн. Банк хувьцаагаа олон нийтэд санал болгох 100 хувийн өмчийн үнэ цэнийн үнэлгээ нь хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалахаас өмнө 105,925 сая төгрөгөөс 127,119 сая төгрөг байх үндэслэлтэй байна гэж үнэлгээний байгууллага дүгнэсэн байна. Үнэлгээний дэлгэрэнгүй мэдээллийг "Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний тайлан"-гаас харна уу.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалтыг үндэслэн Богд Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргаж буй нэгж хувьцааны анхдагч зах зээлд нийтэд санал болгох үнийг 2,540 төгрөг байхаар шийдвэрлэж, 2021 оны 10 сарын 25-ны өдрийн 21/17 тоот тогтоолоор баталгаажуулсан байна.

## 2.5. Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнэ тогтворжуулахтай холбоотой хүлээх үүрэг, хариуцлага

Үнэт цаас гаргагч нь хувьцааны хоёрдогч арилжааны үнэ тогтворжуулах үйл ажиллагааг Андеррайтер компани болон зах зээл үүсгэгчтэй хамтран нэг сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

Биржид шинээр бүртгүүлсэн хувьцаат компаниудын хоёрдогч арилжаа эхэлснээс нэг сарын арилжааны дунг харахад дунджаар нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 16.86 хувьтай тэнцэх дүнг хоёрдогч арилжаагаар арилжаалсан байна.

СЗХ 2021 .11. 10 БҮРТГЭВ № 04
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021 -11- 03 БҮРТГЭВ-03

*Хүснэгт 4 Олон нийтэд хувьцаагаа санал болгосон компаниудын мэдээлэл*

| № | Симбол | Хувьцаат компанийн нэр | Бүртгэгдсэн огноо | Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Хувьцааны тоо ширхэг | Нийт үнийн дүн (сая төгрөг) |
| 1 | BODI | Бодь Даатгал | 8/28/2019 | 47,630,944 | 5,318.2 |
| 2 | INV | Инвескор ББСБ | 3/26/2019 | 10,759,188 | 18,586.5 |
| 3 | MFS | Монос Хүнс | 12/17/2018 | 122,655,128 | 8,585.9 |
| 4 | ADB | Ард Кредит ББСБ | 11/30/2018 | 70,000,000 | 5,285.0 |
| 5 | TUM | Түмэн шувуут | 8/16/2018 | 50,000,000 | 10,000.0 |
| 6 | AIC | Ард даатгал | 6/13/2018 | 7,500,000 | 5,250.0 |
| 7 | MNDL | Мандал даатгал | 5/7/2018 | 1,560,754 | 7,491.6 |
| 8 | ERDN | Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн | 4/4/2018 | 3,898,000 | 2,494.7 |
| 9 | MBW | Монгол базальт | 4/5/2018 | 16,925,100 | 6,431.5 |
| 10 | LEND | Лэндмн ББСБ | 1/26/2018 | 200,000,000 | 5,000.0 |

*Хүснэгт 5 Хүснэгт Олон нийтэд хувьцаагаа санал болгосон компаниудын хоёрдогч арилжааны эхний нэг сарын үзүүлэлтүүд*

| № | Симбол | Хоёрдогч арилжааны эхний нэг сар | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Арилжааны дүн (сая төгрөг) | Арилжааны эргэлт (хувь) | Өдрийн өсөлтийн стандарт хазайлт | Өдрийн хамгийн бага өөрчлөлтийн хувь | Өдрийн өөрчлөлтийн хамгийн их хувь | IPO үнийн өөрчлөлтийн хувь |
| 1 | BODI | 87.8 | 1.7% | 3.3% | -7.08% | 5.1% | -0.2% |
| 2 | INV | 354.4 | 1.9% | 1.3% | -1.7% | 5.1% | 13.3% |
| 3 | MFS | 570.7 | 6.6% | 0.8% | -2.3% | 2.3% | 19.3% |
| 4 | ADB | 711.7 | 13.5% | 1.7% | -5.6% | 8.4% | -5.7% |
| 5 | TUM | 164.4 | 1.6% | 1.4% | -4.3% | 2.2% | -13.0% |
| 6 | AIC | 1,445.8 | 27.5% | 3.6% | -7.5% | 12.0% | 0.5% |
| 7 | MNDL | 1,222.0 | 16.3% | 3.0% | -6.6% | 6.8% | 0.2% |
| 8 | ERDN | 327.3 | 13.1% | 2.0% | -4.7% | 5.5% | 0.0% |
| 9 | MBW | 2,359.6 | 36.7% | 2.6% | -3.4% | 8.0% | 5.2% |
| 10 | LEND | 2,480.9 | 49.6% | 9.6% | -15.0% | 15.0% | 75.2% |
| | | **Дундаж** | **16.9%** | **2.9%** | **-5.8%** | **7.0%** | **9.5%** |

Монголын Хөрөнгийн Биржид хувьцаагаа шинээр гаргасан хувьцаат компаниудаас харахад эхний нэг сар хувьцааны ханшийн дундаж өдрийн өөрчлөлтийн хувь хамгийн багадаа -5.82 хувь байсан бол хамгийн өндөр өсөлтүүдийн дундаж 7.04 хувь байна.

Андеррайтер компани болон зах зээл үүсгэгч нь дээрх мэдээлэлд тулгуурлан үнэт цаас гаргагчийн хувьцааны хоёрдогч арилжааны үнийн хэт өндөр өсөлт болон бууралтаас

БОГД БАНК ХХК БОГД БАНК BOGD BANK УЛААНБААТАР ХОТ ТГЕ8966 9903858

хамгаалах, хувьцааны арилжааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцаа худалдан авах болон худалдах ажиллагааг зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зарчмыг уялдуулан хэрэгжүүлнэ.

### 2.6. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Богд Банк нь олон нийтээс татан төвлөрүүлж буй хөрөнгөөр дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж, банкны үйл ажиллагааг өргөжүүлж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Тус ажлын хүрээнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийж, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлт болон зээл олголтын үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн.

*Хүснэгт 6 Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө*

| № | Хөрөнгө оруулалтын төрөл (сая төгрөг) | 2021 | 2022 | 2023 | Нийт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Технологийн хөрөнгө оруулалт | 2,540 | 7,303 | 2,858 | **12,700** | **40%** |
| 2 | Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлт | 1,905 | 3,810 | 3,810 | **9,525** | **30%** |
| 3 | Борлуулалтын сувгийн хөгжүүлэлт, сайжруулалт | 2,778 | 3,523 | 3,224 | **9,525** | **30%** |
| | **Нийт** | **7,223** | **14,636** | **9,891** | **31,750** | **100%** |

## ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 3.1. Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал

Монгол Улс нэг хүнд ногдох ДНБ-ээр Дэлхийд 112-р байранд Азид 27-р байранд ордог.[2] Нэг хүнд ногдох ДНБ дэлхийн дундаж 11,000 доллар байдаг бол хөгжиж буй орнуудын дундаж 5,700 доллар байдаг.[3] Харин Монгол улсын хувьд 4,167 доллар байна.

Дэлхий нийтээр КОВИД-19 цар тахлын дэгдэлт үргэлжилж байгаа ч хүмүүс хоорондоо зай барих, хөдөлгөөнийг хязгаарлах, хөл хорио тогтоох зэрэг арга хэмжээ нь хүний эрүүл мэндэд үзүүлж болох хор хөнөөлийг хязгаарлах боломж, цаг хугацааг тодорхой хэмжээнд Монгол Улсад олгосон. Эдгээр арга хэмжээг цаг алдалгүй авсан нь нэг талаас цар тахлыг тогтоон барихад чухал үүрэг гүйцэтгэсэн ч нөгөө талдаа эдийн засагт мэдэгдэхүйц хүндрэл учруулсан. Ялангуяа, дотоод халдвар тархсантай холбоотойгоор 2020 оны 11 сарын дунд үеэс хэрэгжүүлж эхэлсэн хатуу хөл хорионы арга хэмжээ нь эдийн засагт мэдэгдэхүйц хүндрэл учруулсан.

Монгол Улсын эдийн засагт КОВИД-19 цар тахал багагүй сөрөг нөлөө үзүүлж, цар хүрээ нь өргөн байсан. 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын эдийн засаг 5.3 хувиар агшсан нь 1990-ээд оноос хойших эдийн засгийн хамгийн том агшилт байсан юм.

[2] *www.tradingeconomics.com*
[3] *United Nations, World Economics Situation and Prospects*

### 3.1.1. Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Дотоодын Нийт Бүтээгдэхүүн

Монгол Улсын үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2021 оны энхий хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 19.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 их наяд төгрөгөөр буюу 16.0 хувийн өсөлт үзүүлжээ. Үүнд голлон нөлөөлсөн хүчин зүйлс нь уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 1.5 их наяд төгрөг буюу 44.1 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 525.6 тэрбум төгрөг буюу 33.6 хувиар өссөн байна.

ДНБ-ий салбарын бүтцийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар авч үзвэл үйлчилгээ 39.5 хувь, уул уурхай, олборлолт 24.9 хувь, хөдөө аж ахуй 14.3 хувь, аж үйлдвэр, барилга 10.7 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 10.6 хувийг тус тус эзэлж байна.

2020 оны эхний хагас жилд төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр нийт хэрэглээ өссөн үзүүлэлттэй байсан бол 2021 оны эхний хагас жилд цар тахалтай холбоотойгоор хэрэглээ буурсан ба өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь хөрөнгө оруулалт, тэр дундаа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт байсан.

*График 1 Монгол Улсын ДНБ (тэрбум төгрөг)*

*Эх сурвалж:* УСХ

Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2020 оны 12 сарын эцэст 24.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.3 их наяд төгрөгөөр буюу 16 хувиар өсөхөд валютын хадгаламж 33.2 хувь, төгрөгийн хадгаламж 20.1 хувиар өссөн нь нөлөөлжээ. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2020 оны 12 сарын эцэст 991.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 4.6 хувиар буюу 43.8 тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 10.5 хувиар буюу 94.1 тэрбум төгрөгөөр өсөж байсан.

2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр мөнгөний нийлүүлэлт 27.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.2 (29.2%) их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд валютын харилцах 1.9.6 (5.1%) тэрбум төгрөгөөр, төгрөгийн харилцах 2.1 (74.2%) их наяд төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 3.8 (34.8%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*График 2 Мөнгөний нийлүүлэлт (тэрбум төгрөг)*

*Эх сурвалж:* YCX

## Төлбөрийн тэнцэл

Манай улсын төлбөрийн тэнцэл нь алдагдалтай гардаг байсан хэдий ч дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ өссөнөөр 2017 оноос эхлээд ашигтай гарч эхэлсэн. Дэлхийн эдийн засаг, худалдааны түнш орнуудын эдийн засгийн сэргэлт төлбөрийн тэнцэлд мөн эерэг нөлөө үзүүлж байна.

Мөнгө, санхүүгийн болон төсвийн бодлогын арга хэмжээнээс гадна санхүүгийн болон худалдааны хамтын ажиллагаа идэвхтэй өрнүүлж буй түнш, олон улсын байгууллагуудын дэмжлэг, бодлогын арга хэмжээний үр дүнд төлбөрийн тэнцэл нэгдүгээр улиралд 170.4 сая ам. доллар буюу ДНБ-ний 1.3 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 520.6 сая ам. доллароор нэмэгдсэн үзүүлэлт юм.

*График 3 Монгол Улсын төлбөрийн тэнцэл (сая доллар)*

*Эх сурвалж:* YCX

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 - 5903858

СЗХ
БҮРТГЭВ
БҮРТГЭВ-03

Урсгал дансны алдагдал 207.4 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурав. Мөн ГШХО-ын орох урсгал болон гадаад зээлийн ашиглалт өмнөх оны мөн үеэс нэмэгдэж, санхүүгийн тэнцэл 408.4 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байсан нь төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлжээ. Энэ онд түүхий эдийн үнэ өндөр байгаа нь төлбөрийн тэнцэлд эерэг нөлөөтэй ч дотоодод вирус тархсан нь улс хоорондын ачаа тээврийг хязгаарлаж, улмаар экспорт удаашрах эрсдэлийг үүсгэж байна.

Үйлчилгээний худалдааны орлого 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 354.4 сая ам. доллар, зарлага 822.1 сая ам. доллар болж, орлого өмнөх оны мөн үеэс 27.1 сая ам. долларoор өсөж, зарлага 215.5 сая ам. долларoор буурсан байна.

Хөрөнгийн данс 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 63.6 сая ам. долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 12.4 сая ам. долларoор өссөн байна. Харин хөрөнгийн дансны ашиг 2021 оны 6 дугаар сард 7.0 сая ам. доллар болж, өмнөх сараас 8.2 сая америк долларoор буурчээ.

Санхүүгийн дансны тэнцэл 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 768.6 сая ам. долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 349.4 сая ам. долларoор өсжээ. Харин санхүүгийн дансны ашиг 2021 оны 6 дугаар сард 68.9 сая ам. доллар болж, өмнөх сараас 60.9 сая ам. долларoор буурчээ.

## Инфляц

*График 4 Монгол Улсын инфляцын түвшин*

*Эх сурвалж: Монголбанк*

2019 онд инфляцын дундаж түвшин 5.2 хувь болж өссөн бол 2020 онд цар тахал, олон удаагийн хөл хорионы улмаас Төв банкны зорилтот түвшин болох 8 хувиас харьцангуй доогуур үзүүлэлттэй буюу 2.3 хувь болж буурсан. Энэ нь иргэдийн худалдан авах чадвар буурсан, тээврийн болон амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний салбар, бусад салбарын үнийн бууралт, зогсолтоос шалтгаалсан.

2021 оны эхний 4 дүгээр сараас огцом өсөж 8 дугаар сарын байдлаар 8.9 хувь хүрээд байна. Төв банкны дүгнэлтээр энэ нь эрэлт болон нийлүүлэлтийн хүчин зүйлс, зардлын шалтгаантай ба ханшийн нөлөө, импортын инфляц, шатахууны хомсдол, хүнсний барааны үнийн индексийн огцом өсөлт зэргээс үүдэлтэй. Азийн хөгжлийн банкны төсөөллөөр инфляц 2022 онд мөн өндөр байх хэвээр байна.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

### 3.1.2. Монгол Улсын мөнгөний бодлого

УИХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг хэлэлцүүлж баталсан. Монголбанк мөнгөний бодлогыг 3 хүрээнд нийт 9 зорилтын дагуу хэрэгжүүлнэ. Үүнд:

- Мөнгөний бодлогын хүрээнд инфляцыг 6 хувь (+/-2)-ийн орчимд тогтворжуулах, макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэх, төв банкны ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхээр олон нийтийг мэдээллээр ханган ажиллах;

- Санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд Мөчлөг сөрсөн арга хэрэгслийг ашиглан банкны салбарт учирч болзошгүй сөрөг нөлөөг бууруулж, банкны эрсдэл даах чадварыг хадгалах, банкны хяналт шалгалт, зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэх;

- Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжиж, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх, Төв банкны суурь бүртгэлийн болон дотоод удирдлагын цогц системийг нэвтрүүлж, бүртгэл, удирдлага, хяналт, тайлагналд олон улсын туршлагыг нэвтрүүлэх, иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх гэсэн зорилтуудыг тавьжээ.

Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ 1) ирээдүйд чиглэсэн, 2) зах зээлийн зарчимд суурилсан, 3) эрэлтийн гаралтай инфляцыг зохистой түвшинд хадгалах стратегийг баримтална хэмээн баталсан байна.

2020 оны 3 сараас эхлэн Монголбанк бодлогын хүүгээ 3 удаа нийлбэр дүнгээр 5 нэгж хувиар бууруулж түүхэн доод үзүүлэлт болох 6 хувьд хүргэжээ. Мөн 2021 оны 6 дугаар сарын 23-ны Мөнгөний бодлогын хорооны хоёрдугаар улирлын ээлжит хурлаар 6 хувьд хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн нь зах зээлийн хүүг бууруулж дотоод эрэлтийг дунд хугацаанд тэтгэхээр зорьсонтой холбоотой юм. Банкуудад илүүдэл нөөцөө зээл болгон гаргаж эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих сэдэл өгөх үүднээс Монголбанк төв банкны богино хугацаат үнэт цаасаас хүртэх өгөөжийг харьцангуй бууруулжээ.

2021 онд баримтлах үндсэн чиглэлийг 1) мөнгөний бодлогын хүрээнд, 2) санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд, 3) санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд нийт 8 зорилт тавьж ажиллаж байна.

Төв банкнаас Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засагт учирч буй хүндрэл, сөрөг нөлөөллийг бууруулах, үүсэж болзошгүй эрсдлээс сэргийлэхийн тулд макро эдийн засгийн бодлогуудыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн ба макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Эдийн засгийг дэмжих 10 их наяд төгрөгийн хөтөлбөрийн хүрээнд 3 хувийн хүүтэй зээл болон 9 хувийн репо санхүүжилтийн нөлөөгөөр нийт зээл өсөж байгаа ч зээлийн багцын чанар муудаж байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 6 дугаар сарын эцэст 1.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 182.7 (18.1%) тэрбум төгрөгөөр өссөн

СЗХ
БУРТГЭВ-03
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БУРТГЭВ-03

байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2021 оны 6 дугаар сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 37.1 (1.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

### 3.1.3. Монгол Улсын төсвийн бодлого

Цар тахлаас үүдэн эдийн засгийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж төсвийн орлого тасарсан, нөгөө талдаа туслалцаа дэмжлэгтэй холбоотойгоор зардал өссөн нь 2020 онд төсөв ихээхэн хэмжээний алдагдалтай гарахад нөлөөлөв. 2020 онд төсвийн нийт орлого жилийн 13 хувиар буурсан нь эрдэс баялгийн олборлолтоос олох орлого унасан, хэрэглээ буурсан, орлого тасарсан, татварын хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой байв. Татварын орлого жилийн 12.8 хувиар, татварын бус орлого жилийн 12.6 хувиар тус тус буурчээ. Цар тахлаас үүдэн дэмжлэг туслалцаа үзүүлэх, уул уурхайн орлого буурахтай зэрэгцэн татварын орлогын 61 хувийг бүрдүүлдэг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар жилийн 15.8 хувиар, нийгмийн даатгалын шимтгэл 19.6 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татвар 11.2 хувиар тус тус буурчээ. Түүнчлэн, цар тахлыг хумих зорилгоор авсан арга хэмжээ ажлын байр, орлогод нөлөөлснөөр хүн амын орлогын албан татвар жилийн 7.2 хувиар буурчээ.[4]

### 3.1.4. Монгол Улсын гадаад худалдаа

2021 оны эхний 8 сарын байдлаар Монгол Улс дэлхийн 144 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.1 тэрбум доллар, үүнээс экспорт 5.6 тэрбум ам.доллар, импорт 4.5 тэрбум ам.доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 27.3 хувь буюу 2.2 тэрбум ам.доллар, экспорт 25.6 хувь буюу 1.1 тэрбум ам.долларoop, импорт 29.6 хувь буюу 1.0 тэрбум ам.долларoop өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 1.2 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн тус үеэс 127.2 сая ам.долларaар өсжээ.

*График 5 Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 8 сарын гүйцэтгэлээр (тэрбум доллар)*

*Эх сурвалж: Монголбанк*

Экспорт 2021 оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум ам.долларoop өсөхөд төмрийн хүдэр, баяжмалын экспорт 365.5 сая америк доллар, зэсийн баяжмалын экспорт 982 сая ам.доллар, нүүрсний экспорт 140 сая ам.долларoop нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Мөн оны эхний 8 сарын байдлаар дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн

[4] Дэлхийн Банк

СЭХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

үнэ өссөнтэй холбоотой экспортын орлого нэмэгдсэн. Тухайлбал, зэсийн баяжмалын экспорт 2021 оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс биет хэмжээгээр 1.6 хувиар буурсан хэдий ч нийт үнийн дүн 97.1 хувиар өссөн дүн юм.

Боловсруулсан болон хагас боловсруулсан алтны экспорт 2021 оны эхний 8 сарын байдлаар 5.76 тонн болж өмнөх оны мөн үеийн экспортоос 71 хувиар буурч 338.3 сая ам.долларт хүрсэн. Төмрийн хүдэр, баяжмал, цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ ялимгүй хэмжээгээр буурсан хэдий ч ханшийн өсөлтийн нөлөөгөөр нийт үнийн дүн өссөн байна.

2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал зэсийн хүдэр, баяжмалын экспорт 97.1 хувиар өсөж 2 тэрбум ам.доллар, чулуун нүүрсний экспорт 11 хувиар өсөж 1.3 тэрбум ам.доллар, боловсруулаагүй нефть 230 хувиар өсөж 219 сая ам.доллар, төмрийн хүдэр, баяжмал 91 хувиар өсч, 768 сая доллар, цайрын хүдрийн экспорт 24 хувиар өсөж 131 сая ам.доллар болж нийт экспортын 90 хувийг эрдэс уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна.

*График 6 Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн 8 сарын гүйцэтгэлээр (сая доллар)*




*Эх сурвалж: УСХ, Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал*

Энэ оны эхний 8 сарын гүйцэтгэлээр Монгол Улс дэлхийн 56 оронд бараа экспортолсноос БНХАУ-д 89.5 хувь, Швейцарт 4.2 хувь, БНСУ-д 2.2 хувь, ОХУ-д 1.3 хувь, Сингапурт 1.2 хувь, ногдсон ба энэ нь нийт экспортын 98.4 хувийг эзэлж байна.

Дотоод дахь халдварын тархалт буурахгүй байгаа хэдий ч ачаа тээвэрлэлт, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг бууруулахгүй байх нь эдийн засгийн эргэлтийг хэвийн байлгахад чухал үүрэгтэй учир хилийн боомтууд дахь халдвар хамгааллын горимыг сайжруулж экспортыг хэвийн горимд явуулах үйл ажиллагаа үргэлжилсээр байна. БНХАУ-ын эдийн засаг, цар тахалтай холбоотой нөхцөл байдал сайжирч, уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт тогтвортой байгаа тул хил орчмын халдварын тархалтыг бууруулбал төлөвлөсөн нийлүүлэлтийг хийх боломжтой юм.

Энэ оны эхний 8 сарын хугацаанд нийт 4.4 тэрбум долларын бараа, түүхий эд импортолсон нь өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 1 тэрбум доллараар буюу 30 хувиар өссөн үзүүлэлт юм. Импортын бүтээгдэхүүний 15 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 31 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 43 хувийг машин тоног төхөөрөмж, барилгын материал зэрэг

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 ... 03358

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHAN
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн тус тус эзэлжээ. Монгол Улс дэлхийн 144 орноос бараа импортолсноос БНХАУ 39.4 хувь, ОХУ 27 хувь, Япон 6.6 хувь, БНСУ 4.3 хувь, ХБНГУ 3.4 хувь, АНУ 2.9 хувийг тус тус эзэлсэн нь, нийт импортын 83.3 хувийг бүрдүүлжээ.

Импортын барааны тээвэрлэлт хил дээр саатсан нь дотоод дахь хэрэгцээг бүрэн хангахад хүндрэл учруулж байгаа бөгөөд түүнчлэн хилээр хугацаандаа нэвтэрч чадаагүй бараа бүтээгдэхүүний хадгалалтын зардал нэмэгдэж дэлхийн зах зээл дээрх нефтийн үнэ өсөлтийн нөлөөтэйгөөр шатахууны үнэ өссөн нь цаашид импортын бараа бүтээгдэхүүний үнийг өсгөх хандлагатай байна.

*График 7 Төгрөгийн доллартай харьцах ханш, 2020*

*Эх сурвалж: Монголбанк*

2020 оны эцсийн байдлаар төгрөгийн америк доллартай харьцах ханш 2,849.89 төгрөгт хүрч оны эхнээс 4.2 хувиар суларсан бол 2021 оны 9 сарын байдлаар оны эхнээс 0.02 хувиар чангарч 2849.22 төгрөгт хүрчээ.

### 3.1.5. Монгол Улсын эдийн засгийн төлөв

Олон улсын санхүүгийн байгууллагууд дэлхийн эдийн засаг 2021 онд 5.6-6 хувь, бүс нутгаар нь авч үзвэл Америкийн Нэгдсэн Улс 6.8 хувь, Европын улсууд 4.2 хувь, Хөгжиж буй орнууд 6 хувь, БНХАУ 8.5 хувийн өсөлттэй байх төсөөллийг гаргасан. Дэлхийн санхүүгийн зах зээл, эдийн засгийн сэргэлтэд хөгжингүй орнуудын КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж буй бодлогын дэмжлэг болон вакцинжуулалтын идэвх ихээхэн нөлөөлж байна.

Монгол Улсын гадаад худалдааны гол түнш орон болох БНХАУ-н эдийн засаг 2021 онд 8.5 хувийн өсөх хүлээлттэй, экспортын голлох түүхий эдийн үнэ өсөлттэй байгаа зэрэг гадаад худалдаанд нөлөөлөх эерэг нөлөөллүүд байгаа хэдий ч боомтууд дээрх халдварын тархалт, бараа бүтээгдэхүүн тээвэрлэлт саатсан, Хятадын тал халдварын тархалттай холбоотой хязгаарлалт тавих зэрэг хүндрэлүүд экспортын төлөвлөсөн нийлүүлэлтийг хийхэд хүндрэл учруулсан. Одоо хийгдэж буй дэд бүтцийн бүтээн байгуулалт болон халдвар хамгааллын горимыг сайжруулбал цаашид экспортын голлох бүтээгдэхүүн болох уул уурхайн түүхий эдийг төлөвлөсөн хэмжээнд нийлүүлэх боломж нээгдэх юм.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТЕ8896 5903858

Монгол Улсын эдийн засаг 2020 оны 1 дүгээр улиралд 10.7 хувиар агшсан бол үүнээс хойш "V" хэлбэрийн сэргэлтийг үзүүлж 2021 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар, 2-р улиралд 6.3 хувиар өссөн байна. Энэхүү сэргэлтэд эрдэс түүхий эдийн үнийн өсөлт, экспортын эрэлт, уул уурхайн олборлолт, тээвэр, боловсруулах үйлдвэрийн салбарын идэвхжил, эдийн засгийн өсөлтийг дэмжих төсөв, мөнгөний бодлогын арга хэмжээ нөлөөлсөн байна.[5] Эхний 2 улирлын гүйцэтгэлээр эдийн засгийн өсөлт нь уул уурхайн салбар давамгайлсан өсөлт байсан бол уул уурхайн бус салбар эхний улиралд 11 хувиар агшсан ба вакцинжуулалтын идэвхжил, хөл хорио сулруулалт, Засгийн газар болон Монгол банкнаас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд цаашид уул уурхайн бус салбарууд 2022 оны эцэс хүртэл өсөж 2023 онд тогтворжих төлөвтэй байна.

Уул уурхайн салбарын хувьд Оюу толгой компанийн зэс болон алтны агууламжийн хэмжээ цаашид багасах төлөвтэй байгаа ч далд уурхайн бүтээн байгуулалт эхэлбэл уул уурхайн салбар цаашид өсөх төлөвтэй байна.

Дэлхийн банкны гаргасан тооцоогоор Монгол Улсын эдийн засаг нь 2020 онд 5.3 хувиар буурсан ч 2021 онд 4.5 хувиар өсөх төсөөллийг гаргасан ба. 2021 оноос 2022 оны төсөөлөл нь КОВИД- 19 цар тахлын нөхцөл байдал, БНХАУ-ын сэргэлтийн хурд далайц, экспортын өсөлт, хөрөнгө оруулалтын орчин, дотоод зээлийн өсөлт, бодлогын арга хэмжээний нөлөө зэрэг хүчин зүйлээс хамаарна. Азийн Хөгжлийн Банкны тодорхойлсноор 2021 онд ДНБ 4.8 хувиар алгуур өсөн, 2022 онд 5.7 хувиар өсөхөөр төсөөллийг гаргажээ. 2021 оны өсөлтөд нийтийн эрүүл мэндийн эрсдэл, КОВИД-19 цар тахлын нөлөө бүрэн арилахгүйгээс дотоод эрэлт огцом сэргэхгүй, бизнесийн итгэл эрс сайжрахгүй гэж үзэж байна.

*Хүснэгт 7 Монгол Улсын эдийн засгийн төсөөлөл, хувиар*

| Дэлхийн банк | 2020Г | 2021Т | 2022Т | 2023Т |
|---|---|---|---|---|
| ДНБ өсөлт | -5.3% | 4.5% | 5.2% | 7.1% |
| Инфляци | 2.3% | 6.5% | 7.0% | 8.5% |
| Урсгал дансны алдагдал (ДНБ-д эзлэх хувь) | -4.3% | -8.9% | -10.7% | -10.3% |
| Төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувь) | -9.5% | -2.6% | -1.5% | -1.3% |
| ЗГ-ын өрийн үлдэгдэл (ДНБ-д эзлэх хувь) | 78.4% | 76.9% | 71.7% | 67.6% |
| ГШХО (ДНБ-д эзлэх хувь) | 12.4% | 14.0% | 14.8% | 10.5% |
| **Азийн Хөгжлийн Банк** | **2020Г** | **2021Т** | **2022Т** | **2023Т** |
| ДНБ өсөлт | -5.3% | 4.6% | 6.0% | - |
| Инфляци (12 сарын дундаж) | 3.7% | 6.9% | 8.5% | - |
| Урсгал дансны алдагдал (ДНБ-д эзлэх хувь) | -4.3% | -8.3% | -10.7% | - |
| **ОУВС** | **2020Г** | **2021Т** | **2022Т** | **2023Т** |
| ДНБ өсөлт | -5.3% | 5% | 7.5% | 5% |
| Урсгал дансны алдагдал (ДНБ-д эзлэх хувь) | -4.3% | -11.8% | -13.8% | -7.4% |

[5] Монголбанк, 2021

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
ГОЛЫН ХӨРӨНГИЙН
GOLIAN STOCK EXCHA
2021 - 11 - 03
БҮРТГЭВ-03

## 3.2. Монгол Улсын зээлжих зэрэглэл

Зээлжих зэрэглэл тогтоогч Мүүдис агентлаг (Moody's) Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2021 оны 3 сарын 16-ны өдөр "B3", Фитч (Fitch) агентлаг 2021 оны 5-р сарын 25-ны өдөр "B" ангилалд тус тус хэвээр үлдээж, Мүүдис агентлаг төлөвийг "сөрөг"-өөс "тогтвортой" болгож ахиулсан. Цар тахал дэлхий нийтээр эрчимжиж байсан 2020 оны 5 сард манай улсын зээлжих зэрэглэлийн төлөвийг "сөрөг" болгож бууруулснаас хойш 10 сарын дараа ийнхүү Мүүдис агентлаг эргэн "тогтвортой " төвшинд шилжүүлэв.

Энэхүү шийдвэр нь манай улсын хөрвөх чадварын эрсдэл, гадаад дарамтууд цар тахлын өмнөх үеэс тогтворжсон гэж шинжээчид үзсэн ба үүнд Монгол Улсын гадаад валютын албан нөөцийн хэмжээ нэмэгдэж, богино хугацаат өр төлбөрийн дарамт буурсны зэрэгцээ экспортын хамгийн том зах зээл болох БНХАУ-ын эдийн засаг сэргэснээр уул уурхайн салбарын экспорт сайжирсан, нийт хүн амын вакцинжуулалтын төвшин өндөр байгаа, ЗГ-аас иргэд, ААН дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж байгаа зэрэг нөлөөлжээ.

Фитч агентлаг 2021 оны Монгол Улсын төсвийн алдагдал ДНБ-ын 5.3 хувь болж өмнөх оны 9.5 хувиас буурна гэж тооцоолсон бөгөөд ЗГ бизнесүүд болон иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл, тусламж болон татварын хөнгөлөлт үзүүлж байгаа нь урт хугацаанд аажмаар үр дүнгээ өгнө хэмээн үзсэн. ЗГ-ын өрийг 2021 оны эцсийн байдлаар 2 хувиар буурч 74 хувь болно хэмээн тооцоолсон бөгөөд дунд хугацааны тогтвортой өсөлтийн хэтийн төлөв болон цар тахлын өмнөх төсвийн орлогын түүх дээр суурилж үзвэл төсвийн бодлогын тогтворжилт цаашид хэвийн явагдана хэмээн дүгнэсэн байна.

Монгол Улсын гадаад өр 2021 оны 2 дугээр улирлын эцэст 32.9 тэрбум долларт хүрсэн ба 8.4 тэрбум долларыг Засгийн газрын өр, 2.2 тэрбум долларыг Төв банкны өр, 1.6 тэрбум долларыг Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагын өр, 8.6 тэрбум долларыг бусад салбарууд, 12 тэрбум долларыг шууд хөрөнгө оруулалт буюу компани хоорондын зээллэг тус тус эзэлж байна. 2021-2024 оны хооронд нийт 14 тэрбум долларын төлбөр хийгдэхээр хүлээгдэж байна байгаа бөгөөд Засгийн Газраас эдгээр өр төлбөрийн эдийн засагт үзүүлэх нөлөөг багасгах үүднээс дахин санхүүжилттэй хослуулан төлөх стратегийг баримталж байна.

Гадаад валютын улсын нийт албан нөөц нь 2021 оны 7 сарын байдлаар 4.5 тэрбум долларт хүрсэн ба 2021 оны эцсээр валютын нөөц 5 тэрбум долларт хүрнэ гэж шинжээчид дүгнэж байна. 2021 оны 4-р сард нийт гадаад валютын нөөцийн хэмжээ 4.89 тэрбум долларт хүрч хамгийн өндөр төвшинд хүрсэн нь 9.5 сарын импортын хэрэгцээг хангах нөөц юм. Нөөц нэмэгдэхэд Монгол банкны үнэт металл худалдан авалт түүхэн дээд хэмжээнд буюу 23 тоннд хүрсэн, Монгол банкнаас сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүд үр дүнгээ өгсөн зэрэг нь голлон нөлөөллөө гэж Монгол банкнаас тайлбарлаж байна.

2020 онд Монгол банк Хятадын Ардын банктай байгуулсан төгрөг-юанийн своп хэлцлийг дахин 3 жилээр сунгах тохиролцоонд хүрсэн болон Худалдаа хөгжлийн банк өөрийн олон улсын зах зээлд гаргасан 500 сая долларын бондыг 5 сард амжилттай төлсөн зэрэг нь валютын нөөцийн болон ханшийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлсөн юм.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
5903858

# ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## 4.1. Санхүүгийн салбарын мэдээлэл

### 4.1.1. Санхүүгийн салбарын өнөөгийн байдал

Монгол Улсын санхүүгийн салбарын бүтэц нь банкны салбар давамгайлсан байдаг ба 2021 оны II улирлын байдлаар 11 арилжааны банк, 536 банк бус санхүүгийн байгууллага, 234 хадгаламж зээлийн хоршоо, даатгалын зах зээлд 15 даатгалын компани, 56 даатгалын зуучлагч, 26 даатгалын хохирол үнэлэгч компани үйл ажиллагаа явуулж байна. Үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 3.8 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт 578 компани үйл ажиллагаа явуулж байгаагаас 312 нь хувьцаат компани байна.

*График 8 ДНБ-д салбаруудын эзлэх хувь хэмжээ*

*Эх сурвалж: УСХ, ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, салбараар*

Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар үйлдвэрийн аргаар бодсон Дотоодын Нийт Бүтээгдэхүүн өмнөх оноос 0.86 хувиар агшин 36.95 их наяд төгрөгт хүрсэн. ДНБ-ний 4.97 хувийг (1.83 их наяд төгрөг) санхүү, даатгалын салбар бүрдүүлж байна. Санхүү даатгалын салбар нь өмнөх онтой харьцуулахад 1.86 хувиар өссөнөөр ДНБ-д эзлэх хувь нь 0.13 хувиар өссөн.

### 4.1.2. Санхүүгийн салбарын бүтэц

2020 оны жилийн эцсээр санхүүгийн салбарын нийт хөрөнгө 42.4 их наяд төгрөг байна. Банкны салбарын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өсч 36.7 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь санхүүгийн зах зээлийн 86.6 хувийг эзэлж байна. Банкнаас бусад санхүүгийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ 13 хувиар өсч 5.7 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт хөрөнгийн хэмжээгээр санхүүгийн зах зээлийн 13.4 хувийг эзэлж байна.

СЗХ
БҮРТГЭВ-03

*Хүснэгт 8 Санхүүгийн дэд салбаруудын нийт салбарт эзлэх хувь хэмжээ*

| Үзүүлэлт (тэрбум төгрөг) | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | | 2021 II | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | % | Дүн | % | Дүн | % | Дүн | % | Дүн | % |
| Банк | 25,048 | 87.3% | 29,842 | 87.9% | 32,478 | 87.1% | 36,685 | 87.1% | 40,077 | 86.1% |
| ХЗЗ | 2,436 | 8.5% | 2,508 | 7.4% | 2,690 | 7.2% | 3,027 | 7.2% | 3,804 | 8.2% |
| ББСБ | 969 | 3.4% | 1,285 | 3.8% | 1,739 | 4.7% | 2,007 | 4.8% | 2,263 | 4.9% |
| Даатгал | 245 | 0.9% | 332 | 1.0% | 366 | 1.0% | 382 | 0.9% | 429 | 0.9% |
| ХЗХ | 153 | 0.5% | 200 | 0.6% | 223 | 0.6% | 256 | 0.6% | 270 | 0.6% |
| **Бүгд** | **28,699** | **100%** | **33,967** | **100%** | **37,273** | **100%** | **42,101** | **100%** | **46,573** | **100%** |

*Эх сурвалж: УСХ*

*График 9 Санхүүгийн дэд салбаруудын нийт салбарт эзлэх хувь, активаар 2020 он*




*Эх сурвалж: Монголбанк, УСХ, СЗХ*

2021 оны 2-р улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар өсч 2.3 их наяд төгрөгт хүрсэн. ББСБ-ын зээлийн багц өмнөх оны үеэс 20.2 хувиар буюу 264.6 тэрбум төгрөгөөр, 2017 оны 2 дугаар улирлаас 183.3 хувиар буюу 1.0 их наяд төгрөгөөр өссөн дүнтэй байна. Зээлийн үлдэгдлийн 87.4 хувийг хэвийн, 2.9 хувийг хугацаа хэтэрсэн, 9.7 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурсан бол хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ 2.0 нэгж хувиар буурсан. Хадгаламж, зээлийн хоршоодын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар өсч 270.5 тэрбум төгрөгт, нийт зээлийн үлдэгдэл 13.2 хувиар өсч 181.8 тэрбум төгрөгт хүрчээ. ХЗХ-дын нийт зээлийн багцын 93.6 хувийг хэвийн, 3.7 хувийг чанаргүй, 2.7 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус бүрдүүлж байна.

*Хүснэгт 9 Банкнаас бусад санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд 2021 оны 2 дугаар улирлын байдлаар*

| Үзүүлэлтүүд (тэрбум төгрөг) | ББСБ | ХЗХ | Даатгал |
|---|---|---|---|
| Актив | 2,263.0 | 270.5 | 428.9 |
| Өр төлбөр | 709.5 | 214.6 | |
| Эзэмшигчдийн өмч | 1,553.4 | 55.9 | |
| Зээлийн өрийн үлдэгдэл | 1,571.9 | 181.8 | - |
| Чанаргүй зээл | 152.5 | 6.9 | - |
| Тайлант үеийн ашиг | 220.0 | 5.2 | 17.1 |
| Даатгалын хураамжийн орлого | - | - | 111.1 |
| Даатгалын нөхөн төлбөр | - | - | 29.0 |

*Эх сурвалж: СЗХ*

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 2021 оны 2-р улирлын байдлаар 428.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар өссөн байна. Даатгалын хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ буюу даатгалын гүнзгийрүүлэлтийн түвшин 0.58 хувь байна. Монгол Улсын даатгалын салбарын зээлийн гүнзгийрүүлэлтийн түвшинг олон улстай харьцуулахад маш доогуур үзүүлэлттэй бөгөөд 2019 оны байдлаар дэвшилтэт зах зээлтэй улс орнуудын даатгалын дундаж гүнзгийрүүлэлтийн түвшин 9.6 хувь байсан бол шинээр гарч ирж буй зах зээлтэй улс орнуудын даатгалын дундаж гүнзгийрэлтийн түвшин 3.3 хувьтай байсан байна.

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52.1 хувиар өсч 3.8 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэхүү дүнг ДНБ-тэй харьцуулахад 3.1 хувьтай тэнцэж байна.

*График 10 Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)*

*Эх сурвалж: СЗХ*

2021 оны 2 дугаар улирлын байдлаар Хөрөнгийн зах зээл дээр 646.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжаа хийгдэн өмнөх оны мөн үеэс 22 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үнэт цаасны арилжааны 80.0 хувийг хувьцаа, 0.9 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 0.6 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 18.5 хувийг хувьцааны арилжаа тус тус эзэлж байна.

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн бүтэц, тогтолцоо нь хөгжлийнхөө эхэн үед явж байгаа бөгөөд банкны салбар давамгайлсан бүтэцтэй байна. Санхүүгийн салбарын цаашдын төлөв нь КОВИД-19 цар тахлын дараа үеийн Монгол Улсын эдийн засаг алгуурхан сэргэх төлөвийг даган хөгжих, ард иргэдийн санхүү, хөрөнгийн зах зээлийн мэдлэг сайжрах, техник технологийн хөгжил зэргээс шалтгаалан хурдацтайгаар өсөх төлөвтэй байна.

СЗХ
БҮРТГЭВ-03
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*График 11 Санхүүгийн хөгжлийн индекс, 2018*

*Эх сурвалж:* ОУВС

ОУВС-аас гаргадаг улс орнуудын санхүүгийн хөгжлийн индексээс харахад 2018 оны байдлаар Монгол улс 0.4 байсан бөгөөд энэ нь Ази номхон далайн орнууд /0.36/, бүх улсууд /0.33/-с өндөр үзүүлэлт юм. Хөгжингүй орнуудын санхүүгийн хөгжлийн индексийн дундаж 0.64 байна.

*Хүснэгт 10 Монгол Улс болон өндөр, дунд орлоготой орнуудын санхүүгийн гүнзгийрэлт*

| Үзүүлэлт | Монгол | Дунд орлоготой орнууд | Өндөр орлоготой орнууд |
|---|---|---|---|
| Санхүүгийн гүнзгийрэлт | | | |
| Хувийн секторт олгосон дотоодын зээл/ДНБ | 54.6 (63-р байр) | 107.4 | 147.6 |
| Хадгаламж/ДНБ | 23.7 | 29.9 | 22.3 |

| Үзүүлэлт | Оноо | Байр | Хамгийн сайн |
|---|---|---|---|
| Жижиг дунд үйлдвэрийн санхүүжилт | 32.2/100 | 124-р байр | 74.9 (Финланд) |
| Хувиараа хөрөнгө босгох боломж | 19.6/100 | 124-р байр | 70.6 (АНУ) |
| Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ/ДНБ | 7.0/100 | 99-р байр | 100 |
| Даатгалын төлбөр/ДНБ | 7.2/100 | 122-р байр | 100 |

*Эх сурвалж: Дэлхийн банк, Өрсөлдөх чадварын тайлан 2019*

Дэлхийн зах зээл дээр хөгжсөн орнуудын жишгийг даган санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, ард иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, техник технологийн дэвшилтэт нээлтүүдийг бүтээгдэхүүн үйлчилгээ үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, төр засаг, зохицуулагч байгууллагуудын шийдвэр гаргалт, хууль тогтоомжийн тэнцвэртэй, хүртээмжтэй байдал зэргийг хангах нь санхүүгийн зах зээлийн цаашдын хөгжлийн төлөвт нөлөөлөх юм.

### 4.1.3. Банкны салбар

Монгол Улсад 1990 онд нийгэм, улс төр, эдийн засгийн шинэчлэл хийгдсэнээр "Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм", 1991 онд "Банкны хууль" батлагдсан зэрэг үйл явдал нь 2 шатлалт банкны тогтолцооны үндэс суурь тавигдах эхлэл болсон. Үүнээс хойш нийт 31 банкнаас 17 банк нь 1996 оноос 2009 оны хооронд болсон

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 - 5903858

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

гурван удаагийн хямралын улмаас дампуурах, бусад банктай нэгдэх, татан буугдах зэргээр үйл ажиллагаагаа зогсоосон. 2020 онд 2 арилжааны банк үйл ажиллагаагаа зогсоосон байна. Арилжааны банкууд Монгол Улсын сүүлийн 20 жилийн санхүүгийн захыг тодорхойлсоор ирсэн ба банкны хадгаламж, зээлийн захууд нь сегментчлэгдсэн байдаг нь үүнд ихээхэн нөлөөлдөг. [6]

## 4.2. Банкны салбарын мэдээлэл

2021 оны 2-р улирлын байдлаар 12 арилжааны банкууд 15,868 ажилчид, 1,391 салбараар дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс төрийн өмчийн нэг банк /Төрийн банк/ байна. Банкны салбар санхүүгийн салбарын 93.3 хувийг бүрдүүлж буй нь бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт бөгөөд иргэд, аж ахуй нэгжүүдийн зээлийн эх үүсвэрт арилжааны банкууд томоохон байр суурийг эзэлж байна. Арилжааны банкуудын хувьцаа эзэмшигчдийн бүтцийн дийлэнх хувийг цөөн тооны хөрөнгө оруулагчид бүрдүүлж байна. Монголбанкны тодорхойлсноор банкны салбарт нөлөө бүхий банкуудад Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Төрийн банк орж байгаа бөгөөд эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж байна.

### 4.2.1. Банкны салбарын өнөөгийн байдал

Монголбанкны зүгээс КОВИД-19 цар тахлын иргэд, бизнесүүдэд үзүүлж буй хүндрэлийг зөөллөх үүднээс дунд хугацааны тогтвортой байдалд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2020 оны байдлаар нийт хадгаламжийн дансны тоо 3 сая ширхэгт, нийт зээлдэгчдийн тоо 0.9 сая ширхэгт хүрсэн байна. Монголбанкнаас бодлогын хүүг 2020 оны 3 ба 4 сард нийт 2 нэгж хувиар бууруулж, төв банкны хүүгийн коридорыг 1 нэгж хувиар нарийсгасан. Үргэлжлүүлэн цар тахлын нөлөөгөөр бодлогын хүүг 9 болон 11 сард тус тус дахин бууруулсан бөгөөд түүхэнд байгаагүй доод хэмжээ буюу 6 хувьд хүрсэн байна. Мөнгөний бодлогын хорооны тогтоолоор хүүгийн коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй байхаар өөрчилсөн байна.

*График 12 Монголбанкны бодлогын хүү, хүүгийн коридор*

*Эх сурвалж: Монголбанк*

[6] *Эх сурвалж: Монголбанк*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТҮБ8966 ₪ 5903858

СЗХ
2021 . 11 . 03 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ...
MONGOLIAN STOCK EXCHA...
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Хүүгийн коридор нарийссанаас банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүгийн бодлогын хүүнээс хазайх абсолют хазайлт 0.21 нэгж хувь болон буурсан. Мөн эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчдийн хэрэглээний зээлийн хугацааг 12 сараар, ипотекийн зээлийн хугацааг 6 сараар сунгах шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

Банкны салбарын нийт хөрөнгө 2021 оны 2-р улирлын байдлаар 40.1 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.7 их наяд төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн байна. Салбарын хөрөнгийн 46.2 хувийг аж ахуй нэгж, иргэдэд олгосон зээл, 20.9 хувийг төв банкны үнэт цаас, 11.1 хувийг банкуудын нөөц бүрдүүлж байна. Банкуудын өөрийн хөрөнгө 2020 оны байдлаар 3.75 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2 хувиар өссөн. Банкуудын нөөц өмнөх оны мөн үеэс 34.2 хувиар буурсан. Нийт зээлийн үлдэгдэл 5 хувиар бууран 17 их наяд төгрөгт хүрсэн. Нийт зээлийн бууралтад хэрэглээний зээлийн бууралт 89 хувийг эзэлж байгаа бөгөөд төрөөс тэтгэврийн зээлийг тэглэсэн нь үүнд нөлөөлсөн байна. Цар тахалтай холбоотой банкуудын активын бүтцийн өөрчлөлт, зээлийн агшилт нь мөн нийт зээлийн бууралтад нөлөөлсөн байна. Нийт пассивын дүн 2.4 хувиар өсч 33.6 их наяд төгрөгт хүрсэн ба нийт пассивын 66.7 хувийг харилцах болон хадгаламжийн дүн бүрдүүлж байна. Нийт хадгаламжийн дүн өмнөх оны мөн үеэс 28.9 хувиар өссөн бол нийт харилцахын дүн 4.4 хувиар буурсан байна. Банкуудын өөрийн хөрөнгө нь нийт активын 8.3 хувийг бүрдүүлж байна.

*Хүснэгт 11 Банкны салбарын үндсэн үзүүлэлт*

| Үзүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021Q2 |
|---|---|---|---|---|---|---|
| **Салбарын тоо** | 1,491 | 1,511 | 1,512 | 1,413 | 1,402 | 1,391 |
| **Арилжааны банкуудын тоо** | 14 | 14 | 14 | 14 | 12 | 12 |
| **Картын тоо** | 3,953,98 | 3,844,63 | 4,291,15 | 3,748,02 | 4,077,89 | 4,127,03 |
| **Идэвхтэй ашиглагдаж буй картын** | 1,468,37 | 1,716,22 | 1,585,94 | 1,899,50 | 1,863,29 | 1,985,11 |

*Эх сурвалж: Монголбанк*

*Хүснэгт 12 Салбарын санхүүгийн үзүүлэлт*

| Үзүүлэлт (тэрбум төгрөг) | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021Q |
|---|---|---|---|---|---|---|
| **Өөрийн хөрөнгө** | 2,936 | 3,150 | 3,260 | 3,031 | 3,059 | 3,171 |
| **Банкны нөөц** | 2,925 | 3,386 | 4,507 | 6,178 | 4,063 | 3,569 |
| **Тухайн оны ашиг, Алдагдал** | 176 | 249 | -97 | 33 | 265 | 322322 |
| **Дотоодын зээл (цэвэр)** | 11,883 | 12,948 | 16,000 | 16,794 | 15,813 | |
| **Харилцах, Хадгаламж** | 10,921 | 13,486 | 17,508 | 18,806 | 22,434 | 20,648 |
| **Пассив** | 22,402 | 25,623 | 29,793 | 32,829 | 33,627 | 36,905 |
| **Нийт хөрөнгө** | 25,338 | 28,773 | 33,053 | 35,859 | 36,685 | 40,077 |

*Эх сурвалж: Монголбанк*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БУРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*График 13 Арилжааны банкуудын эзлэх хувь, нийт активаар*




Нийт активын хэмжээгээр банкны салбарын 35 хувийг Хаан банк, 22 хувийг Худалдаа Хөгжлийн банк, 19 хувийг Голомт банк, 10 хувийг Төрийн банк болон 8 хувийг Хас банк эзэлж байна.

Монголбанкнаас арилжааны банкуудыг ТОМ, ДУНД, ЖИЖИГ гэсэн 3 ангилалд хуваажж байна.

*Эх сурвалж: Монголбанк, Банкуудын тайлан*

*Хүснэгт 13 Арилжааны банкны ангилал*

| ТОМ (>5 их наяд) | ДУНД (1-5 их наяд төгрөг) | ЖИЖИГ (<1 их наяд төгрөг) |
|---|---|---|
| **Худалдаа Хөгжлийн банк, Хаан банк, Голомт банк** | Хас банк, Төрийн банк, Капитрон банк | Чингис Хаан банк, Үндэсний Хөрөнгө Оруулалтын банк, Ариг банк, Тээвэр Хөгжлийн банк, Богд банк |

*Эх сурвалж: Монголбанк*

*График 14 Арилжааны банкуудын гол үзүүлэлтүүд, 2021.Q2 (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Монголбанк, Банкуудын тайлан*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
БҮРТГЭВ-03

*График 15 Арилжааны банкуудын ашгийн үзүүлэлт, 2021.Q2 (сая төгрөг)*

*Эх сурвалж: Монголбанк, арилжааны банкуудын санхүүгийн тайлан*

*График 16 Банкуудын зээл, хадгаламжийн хүү, хувиар*

*Эх сурвалж: Монголбанк*

Арилжааны банкуудын зээл, хадгаламжийн хүү 2019 онд 5.6 хувийн зөрүүтэй байсан бол 2020 онд 5.2 хувь болж, 2021 оны 7 сарын байдлаар 7.02 хувь болсон байна.

*График 17 Хөрвөх чадварын харьцаа*

*Эх сурвалж: Монголын Банкны Холбоо*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТЕ8966 5903858

Системийн нөлөө бүхий таван банк нь хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийг ханган ажиллаж байна. Төрийн банкны хөрвөх чадварын харьцаа ялимгүй буурсан бол зээлийн олголт буурсантай холбоотойгоор бүх банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

### 4.2.2. Зээлийн мэдээлэл

Монгол Улсын банкны салбарын зээлийн багцын хувьд чанаргүй, хугацаа хэтэрсэн зээл хуримтлагдсан байдалтай байна. 2021 оны 2-р улиралын байдлаар банкны салбарын зээлийн үлдэгдэл өмнөх оны жилийн эцсын үеэс 11.34 хувиар өсөн 18.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт хөрөнгийн 49 хувийг бүрдүүлж байна. Банкуудын шинээр олгосон зээл 2021 оны эхний хагас жилийн байдлаар 43.4 хувиар өссөн ба Зээлийн жигнэсэн дундаж хүү 2020 оны сүүлээс эхлэн буурч байгаа нь аж ахуйн нэгжүүдийн ерийн дарамт буурахад зохих дэмжлэг болж байна. 2020 оны байдлаар банкны зээлийн 100 төгрөг тутмын 60 төгрөг нь хэвийн, 40 төгрөг нь асуудалтай буюу хугацаа хэтэрсэн, чанаргүй, цар тахлын нөлөөтэй зээлүүд байна[7].

*График 18 Зээлийн үлдэгдэл (сая төгрөг)*




*Эх сурвалж: Монголбанк*

Банкуудын нийт зээлийн 80.3 хувийг хэвийн зээл (2019 оноос 10 хувийн бууралт), 6.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл (2019 оноос 55 хувийн өсөлт), 9.91 хувийг чанаргүй зээл (2019 оноос 10 хувийн өсөлт) бүрдүүлж байна. Зээлийн эрсдэлийн сан нь өмнөх оноос 13.8 хувиар өсч нийт зээлийн үлдэгдлийн 9.6 хувийг бүрдүүлж байна.

*График 19 Зээлийн бүтэц, зээлдэгчээр, хувиар*

*Эх сурвалж: Монголбанк*

[7] *Эх сурвалж: Монголын банкны холбоо, 2020*

2021 оны 2-р улирлын байдлаар нийт зээлийн 49.16 хувийг иргэдэд олгосон зээл (2020 оноос 7.9 хувийн бууралт), 48.0 хувийг хувийн байгууллагад олгосон зээл (2019 оноос 6.6 хувийн бууралт), 2.0 хувийг улсын байгууллагад олгосон зээл (2019 оноос 490 хувийн өсөлт) бүрдүүлж байна. Нийт зээлийн үлдэгдлийн 16.6 хувийг цалин, тэтгэврийн зээл, 16.1 хувийг бөөний болон жижиглэнгийн, 13.4 хувийг үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны, 10.3 хувийг уул уурхай олборлолтын зээлүүд тус тус бүрдүүлж байна.

*График 20 Чанаргүй зээлийн хувь, зээлдэгчээр*




*Эх сурвалж: Монголбанк*

2020 онд уул уурхайн салбарын болон үл хөдлөх хөрөнгө, ипотекийн зээлээс бусад салбарын зээл агшсан байна. Банкны салбарын чанаргүй зээлийн эрсдэл хуримтлагдсан хэвээр байгаа ба КОВИД-19 цар тахлын нөлөө, бизнесүүдийн тогтворгүй үйл ажиллагаа, болон аж ахуй нэгжүүд үйл ажиллагаагаа зогсоосон зэрэг хүчин зүйлс нь хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлтөд нөлөөлсөн. 2020 оны байдлаар чанаргүй зээлийн харьцаа 10.7 хувь, анхаарал хандуулах зээл 9.6 хувьтай байна. Иргэдийн чанаргүй зээл 149.6 тэрбум төгрөгөөр буюу 61.2 хувиар өссөн нь нийт чанаргүй зээлийг өмнөх оноос 25.6 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн байна.

*График 21 Чанаргүй зээлийн хувь, зээлийн төрлөөр*




*Эх сурвалж: Монголбанк*

Чанаргүй зээлийн 22.5 хувийг уул уурхай, 22 хувийг боловсруулах үйлдвэр, 16.6 хувийг барилгын салбарын чанаргүй зээл бүрдүүлсэн бөгөөд энэ нь системийн дунджаас өндөр үзүүлэлт байна.

*График 22 Банкны салбарын эх үүсвэрийн мэдээлэл*

*Эх сурвалж: Монголбанк*

2020 оны байдлаар банкны салбарын татан төвлөрүүлсэн эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өсч 32.8 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд эх үүсвэрийн өсөлтийн 90 гаруй хувийг харилцах, хадгаламжийн өсөлт эзэлсэн байна. Арилжааны банкуудын хадгаламж 2020 оны байдлаар 28.6 хувиар өссөн бөгөөд үүнд гадаад валютын ханшийн өсөлтөөс шалтгаалсан валютын хадгаламжийн өсөлт, КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр харилцах дансны үлдэгдэлд хүү төлөхийг зогсоосонтой холбоотой харилцах данснаас хадгаламжийн данс руу шилжих хөдөлгөөн, бодлогын хүүг үе шаттайгаар бууруулсан зэрэг нь нөлөөлсөн байж болзошгүй.

*График 23 Банкны цэвэр ашиг (тэрбум төгрөг)*

*Эх сурвалж: Монголбанк*

Банкны салбарын цэвэр ашгийн хэмжээ 2020 онд 38.81 тэрбум төгрөг байсан бол 2021 оны 2-р улиралд 29.4 тэрбум төгрөг болж буурсан байна. Цэвэр ашгийн хэмжээ болон активын өгөөж буурахад КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр зээлийн өсөлт, хөрөнгө оруулалт буурсан нь нөлөөлсөн байна.

*График 24 Банкны салбарын орлого, зардлын бүтэц*

*Эх сурвалж: Монголбанк*

2020 онд банкны салбарын нийт орлого 5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүний 83.6 хувийг хүүгийн орлого, 16.4 хувийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Хүүгийн орлогын 72.2 хувийг зээлийн хүүгийн орлого, 25.7 хувийг үнэт цаасны хүүгийн орлого, 2.1 хувийг харилцах, хадгаламжид төлөгдсөн хүүгийн орлого бүрдүүлж байна. Нийт зардал 5 их наяд гарсан бөгөөд үүний 62.9 хувийг хүүгийн, 37.1 хувийг хүүгийн бус зардал бүрдүүлж байгаагаас хүүгийн зардлын 64.971.5 хувийг харилцах, хадгаламжийн хүүгийн зардал, 11.5 хувийг зээл, үнэт цаасны хүүгийн зардал, 23.6 хувийг бусад хүүгийн зардал бүрдүүлсэн байна.

Банкны салбарын эрсдэл даах чадварыг харуулдаг үзүүлэлтийг авч үзэхэд 2020 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 15.6 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс 3.6 нэгж хувиар өндөр байна.

Системийн нөлөө бүхий банкнуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт 2019 онтой харьцуулахад ялимгүй өссөн үзүүлэлттэй байна. Банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлтийг ханган ажиллаж байна.

СЭХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*График 25 Банкны зээлийн хугацаа хэтрэлт*




*Эх сурвалж: Монголын Банкны Холбоо*

Монгол Улсын хувьд 2020 оны байдлаар 1.3 их наяд төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн багцын 79 хувь нь бизнесийн хугацаа хэтэрсэн зээл байна. 2020 оны 7 сараас эхлэн эдийн засаг идэвхэжсэнтэй холбоотой иргэдийн зээлийн хугацаа хэтрэлт буурч байсан боловч 11 сараас эхлэн огцом өссөн байна. [8]

*Хүснэгт 14 2018-2021 оныг хамарсан хугацааны жилийн дундаж хүүгийн түвшин*

| Жилийн дундаж хүүгийн түвшин | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| Төгрөгийн харилцах дансны жигнэсэн дундаж хүү | 3.08% | 3.28% | 3.02% | 0.00% |
| Валютын харилцах дансны жигнэсэн дундаж хүү | 1.54% | 1.54% | 1.16% | 0.00% |
| Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү | 10.33% | 11.02% | 8.99% | 6.00% |
| Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү | 10.26% | 11.08% | 8.84% | 6.20% |
| Зээлийн сар бүрийн үлдэгдэлд жигнэсэн төгрөгийн | 17.71% | 17.00% | 16.93% | 16.41% |
| Зээлийн сар бүрийн үлдэгдэлд жигнэсэн валютын | 10.82% | 10.63% | 10.40% | 10.04% |
| Активын дундаж хүү | 12.28% | 12.43% | 11.29% | 9.66% |
| Эх үүсвэрийн дундаж хүү | 10.26% | 11.08% | 8.84% | 6.20% |
| Харилцах дансны дундаж хүү | 2.31% | 2.41% | 2.09% | 0.00% |

*Эх сурвалж: Монголбанк, БДО Аудит ХХК шинжилгээ*

2020 оны 6 сараас эхлэн арилжааны банкууд харилцагчийн төгрөгийн болон валютын харилцах дансны үлдэгдэлд хүү төлөхийг зогсоосон байна. Мөн Монголбанкны бодлогын хүүг 6 хувьд хүргэсний нөлөөгөөр бүх хүүгийн түвшин буурсан хандлагатай байна. 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар активын дундаж хүү 9.7 хувь байгаа бол харилцахаас бусад эх үүсвэрийн дундаж хүү 6.2 хувь, хүүгийн зөрүү 3.5 хувь орчимд байна.

2020 онд банкны тухай хуульд нэмэлтээр системийн ач холбогдолтой банкууд 2022 оны 6 сараас өмнө нээлттэй Хувьцаат компани болох, 2023 оны 12 сараас өмнө нэг хувьцаа эзэмшигчид ногдох хувь хэмжээ 20 хувиас хэтрэхгүй байх өөрчлөлтүүдийг оруулан баталсан. Банкны салбарын хөгжил болон нээлттэй компани болох хүрээнд Монгол Улсын хөрөнгө оруулалт, бизнесийн орчин сайжирсан байх нь чухал юм. Хөрөнгө оруулалтын

[8] *Монголын Банкны Холбоо, 2020 оны 4 дүгээр улирлын тайлан*

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 - 5903858

СЭХ 2021 . 11 . 10
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

орчин сайжирснаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, банкны салбарын өөрийн хөрөнгийг сайжрах, засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, ил тод байдал, тайлагнал сайжрах зэрэг эерэг үр дагавартай.

### 4.2.3. Банкны салбарын ирээдүйн төлөв

Банкны салбарын цаашдын төлөв нь Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал болон экспортын эрэлт, Хятад Улсын эдийн засгаас шууд хамааралтай байдаг ба түүхий эд, үнэт металлын эрэлт ихсэх нь банкны салбарт эерэгээр нөлөөлөх боломжтой. Банкны салбарын зээлийн хүү буурч, зээл олголт идэвхжиж эхэлсэн. 2020 оны туршид бодлогын хүүг 5 нэгж хувиар бууруулан 6 хувьд хүргэж, банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийг 2.5 нэгж хувиар бууруулах замаар эх үүсвэр чөлөөлж, репо санхүүжилтийг дэмжсэнээр зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд төгрөгийн зээлийн дундаж хүү 2020 оны 9 сараас хойш буурсаар 2021 оны 4 сард 15 хувь хүрсэн байна. Энэхүү бодлогын хүүгийн нөлөө болон хөтөлбөрийн зээлийн нөлөөгөөр зээлийн жигнэсэн дундаж хүү 1-2 хувиар буурах төлөвтэй байна. Засгийн газар 2021 оны 2 сарын 17-ны өдөр зээлийн хүүгийн татаас олгох, зээлд батлан даалт гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-г баталж, мөнгө хэвлэхгүйгээр эдийн засгаа эрчимжүүлэх шийдвэрийг гаргасан. Энэхүү 10 их наядын цогц төлөвлөгөөнд жижиг дунд үйлдвэрлэл, стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, Монголбанкны репо санхүүжилтийг 2 дахин нэмэгдүүлэх, ХАА-н үйлдвэрлэл, малчдыг дэмжих зэрэгт голлон анхаарах юм. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд банкуудын зээл олголт өсч эхэлсэн бөгөөд 2021 оны 5 сарын 24-ний байдлаар 1.01 их наяд төгрөгийн Ажлын байр дэмжих зээл, 412.3 тэрбум төгрөгийн репо санхүүжилт, 295.1 гаруй тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосон байна. Банкны салбарын зээл 4 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 3 хувиар өссөн бөгөөд 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд банкуудын зээл цаашид өсөх төлөвтэй байна.[9] Иргэдийн зээлийн хувьд эрэлт багатай байгаа ба цаашид иргэдийн зээлийн чанар муудах эрсдэл байна. Монголбанкны зүгээс инфляцыг 6 (+/-2) хувьд байлгах, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг мөнгөний бодлогын дунд хугацааны зорилттой нийцтэй байлгах бодлогыг баримтлах төлөвтэй байна. Монголбанкнаас дараах төсөөллийг гаргасан байна.

*Зураг 1 Монголбанкны макро эдийн засгийн үзүүлэлтийн төсөөлөл*




*Эх сурвалж: Монголбанк*

[9] *Эх сурвалж: Монголбанк, 2021*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 5003858

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Тэтгэмжийн орлогын нөлөөг хасвал өрхийн орлого 2.6 хувиар буурахаар байна. 2021 оны 7 сард зээлийн ангилал хуучин хэвэндээ ороход санхүүгийн салбарт зээлийн эрсдэл үүсэхээр хүлээгдэж байна.

## 4.3. Өрсөлдөгчийн судалгаа

2021 оны 08 сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсын банкны салбарт нийт 11 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байгаа ба эдгээрээс 10 нь хувийн өмчийн, 1 нь төрийн өмчийн банк байна. Банкны тухай хуульд заасны дагуу "банкны системд нөлөө бүхий банк" гэж банкны хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал зэрэг шалгуурыг нэгэн зэрэг баримтлан банкны тогтолцоонд нөлөөтэй гэж Монголбанкнаас тогтоосон банкийг хэлдэг.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж нь банкуудын санхүүгийн тайлан юм.

Системийн нөлөө бүхий 5 банкны 2021 оны 06 сарын 30-наарх санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

*Хүснэгт 15 Системийн нөлөө бүхий 5 банкны 2021 оны 06 сарын 30-наарх санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд*

| Үзүүлэлтүүд (тэрбум төгрөг) | Хаан банк | ХХБ банк | Голомт банк | Хас банк | Төрийн банк |
|---|---|---|---|---|---|
| **Санхүүгийн үзүүлэлт** | | | | | |
| Нийт хөрөнгө | 13,895.9 | 8,591.1 | 7,818.3 | 3,413.1 | 3,926.9 |
| Нийт зээл (цэвэр дүнгээр) | 6,094.9 | 4,166.9 | 3,129.5 | 1,513.3 | 2,078.9 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 10,851.1 | 5,433.5 | 5,482.5 | 2,213.8 | 3,083.9 |
| Нийт өр төлбөр | 12,639.2 | 7,511.1 | 7,235.9 | 3,111.8 | 3,549.7 |
| Нийт өөрийн хөрөнгө | 1,256.8 | 1,079.9 | 582.4 | 301.3 | 377.2 |
| Тайлант хугацааны ашиг | 131.6 | 62.4 | 9.3 | 24.6 | 29.4 |
| **Харьцаа үзүүлэлт** | | | | | |
| Хөрөнгийн өгөөж ROA* | 0.9% | 0.7% | 0.1% | 0.7% | 0.7% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж ROE** | 10.5% | 5.8% | 1.6% | 8.2% | 7.8% |

*ROA* - 2021 оны хагас жилийн цэвэр ашгийг 2021 оны хагас жилийн байдлаарх нийт хөрөнгөд харьцуулав.*

*ROE** - 2021 оны хагас жилийн цэвэр ашгийг 2021 оны хагас жилийн байдлаарх өөрийн хөрөнгөд харьцуулав.*

*Эх сурвалж: Банкуудын санхүүгийн тайлан, 2021 оны хагас жил*

2021 оны хагас жилийн эцсийн байдлаар банкны системийн нийт хөрөнгө 40.1 их наяд төгрөг, цэвэр зээлийн багц 19.6 их наяд төгрөг, нийт өр төлбөр 36.9 их наяд төгрөг, нийт өөрийн хөрөнгө 3.2 их наяд төгрөгт тус тус хүрсэн байна.

Системийн нөлөө бүхий 5 том арилжааны банк нь системийн нийт хөрөнгийн 94 хувийг, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны 87 хувийг, нийт өр төлбөрийн 92 хувийг, цэвэр ашгийн 80 хувийг бүрдүүлдэг.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

54-Системийн нөлөө бүхий 5 банкны нийт хөрөнгийн дундаж өгөөж 0.6 хувь, өөрийн хөрөнгийн дундаж өгөөж 6.8 хувь байна.

### 4.3.1. Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр суурь

Үнэт цаас гаргагч нь арилжааны банкны салбарын отгон банк бөгөөд 2014 оноос банкны үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Богино хугацаанд тогтвортой өсөлт үзүүлж байгаа шинэлэг банк юм. 2019 оноос цахим банкны үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагчийн тоо, зах зээлд эзлэх байр суурыа нэмэгдүүлэхэд төвлөрч, амжилттай ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь системийн жижиг банкны ангилалд хамаардаг. Активын хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээ, харилцагчдын тоогоор ойролцоо арилжааны банкуудтай санхүүгийн үзүүлэлтийг харьцуулан доорх хүснэгтэд харууллаа.

*Хүснэгт 16 Богд Банкны активын хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээ, харилцагчдын тоогоор ойролцоо арилжааны банкуудын санхүүгийн үзүүлэлтүүд, 2021 оны хагас жил*

| Үзүүлэлтүүд (тэрбум төгрөг) | Капитрон банк | Тээвэр хөгжлийн банк | Богд банк |
|---|---|---|---|
| **Санхүүгийн үзүүлэлт** | | | |
| Нийт хөрөнгө | 1,104.4 | 414.6 | 270.4 |
| Нийт зээл (цэвэр дүнгээр) | 578.8 | 257.4 | 125.5 |
| Чанаргүй зээл | 41.8 | 12.5 | 5.7 |
| Зээлийн эрсдлийн сан | 28.4 | 15.2 | 2.7 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 767.9 | 141.7 | 124.0 |
| Нийт өр төлбөр | 982.7 | 298.8 | 202.1 |
| Нийт өөрийн хөрөнгө | 121.7 | 115.8 | 68.3 |
| Тайлант хугацааны ашиг | 9.3 | 6.7 | 6.9 |
| **Харьцаа үзүүлэлт** | | | |
| Хөрөнгийн өгөөж ROA* | 1.14% | 2.4% | 4.3% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж ROE** | 10.4% | 10.0% | 17.3% |
| Эрсдэлийн сангийн хүрэлцээ*** | 4.9% | 5.9% | 2.1% |
| Чанаргүй зээлийн харьцаа**** | 7.2% | 4.8% | 4.5% |

*ROA* - Trailing twelve months- аргыг ашиглан 2021 оны 6 сарын 30-ны өдрөөрх жилийн өгөөжийг тооцов.*
*ROE** - Trailing twelve months- аргыг ашиглан 2021 оны 6 сарын 30-ны өдрөөрх жилийн өгөөжийг тооцов.*
*Эрсдэлийн сангийн хүрэлцээ*** - Нийт эрсдэлийн санг нийт зээлийн багцад харьцуулав.*
*Чанаргүй зээлийн харьцаа**** - Нийт чанаргүй зээлийг нийт зээлийн багцад харьцуулав.*

*Эх сурвалж: Банкуудын санхүүгийн тайлан, 2021 оны хагас жил*

Нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжөөр харьцуулж үзэхэд Богд Банкны ашигт ажиллагаа өндөр, үр ашигт байдал сайн байгааг харуулж байна. Капитрон банкны хувьд чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлтээр банкны салбарын дундаж үзүүлэлтээс харьцангуй өндөр буюу их эрсдэлтэй байгаа бол Богд Банкны хувьд чанаргүй зээлийн хэмжээ бага, эрсдэлийн түвшин бага байна.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг нийт хөрөнгөд харьцуулахад системийн нөлөө бүхий банкуудын дундаж 45.1 хувь байсан бол Капитрон банк, Тээвэр хөгжлийн банк, Богд

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 .11. 10
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

банкуудын дундаж үзүүлэлт 46.4 хувь байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ 10 хувийг эзэлж байсан бол дээрх 4 банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ 25 хувь байна. Богд Банкны хувьд өөрийн хөрөнгийн хүрэлцээ 34.9 хувь байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн хүрэлцээ өндөр байгааг илтгэж байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг дараах хүснэгтэд харьцуулав:

*Хүснэгт 17 Зохистой харьцаа үзүүлэлтүүд*

| Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд | Байвал зохих | Капитрон банк | Тээвэр хөгжлийн банк |
|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа | >9% | 13.3% | 37.5% |
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа | >12% | 13.7% | 37.5% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт | >25% | 40.5% | 28.5% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) | < - / +15% | 10.0% | -9.4% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт) | < - / +30% | 11.1% | -9.4% |

*Эх сурвалж: Банкуудын вебсайт*

Богд Банк нь Монголбанкнаас тавигддаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган ажиллаж байгаа бөгөөд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаагаар салбартаа тэргүүлж байна.

### 4.3.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээний харьцуулалт

**Харилцах, хадгаламж**

Банкууд иргэд, аж ахуй нэгж байгууллагаас харилцах, хугацаагүй хадгаламж болон хугацаатай хадгаламжийн дансаараа дамжуулан хөрөнгийн илүүдэлтэй хэсгээс эх үүсвэр татан төвлөрүүлж хөрөнгийн дутагдалтай талд зээлдүүлэх байдлаар банкны үйл ажиллагааг эрхэлж байна. 2021 оны хагас жилийн эцсийн байдлаар банкны салбарт нийт хадгаламжийн хэмжээ 18.6 их наяд төгрөг байна. Нийт хадгаламжийн 22.7 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Банкууд дээр хадгаламжийн хүү жилийн 1 - 2 хувийн зөрүүтэй байна.

**Зээлийн бүтээгдэхүүн**

2021 оны хагас жилийн эцсийн байдлаар банкуудын зээлийн үлдэгдэл 19.6 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс хувийн байгууллагын зээл 9.1 их наяд төгрөг, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 9.3 их наяд төгрөг байна. Чанаргүй зээлийн багц 1.9 их наяд төгрөгт хүрч нийт зээлийн багцын 5 хувийг эзэлж байна.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТЕ8966 - 5903858

*Хүснэгт 18 Богд Банк болон түүнтэй активын хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээ, харилцагчдын тоогоор ойролцоо арилжааны банкуудын зээлийн бүтээгдэхүүний харьцуулалт*

| Зээлийн бүтээгдэхүүний төрөл | Капитрон банк | Тээвэр хөгжлийн банк | Богд банк |
|---|---|---|---|
| **Бизнесийн зээл** | | | |
| Хөрөнгө оруулалтын зээл | Тийм | Тийм | Тийм |
| Эргэлтийн хөрөнгийн зээл | Тийм | Тийм | Тийм |
| Зээлийн шугам | Тийм | Тийм | Тийм |
| Худалдааны зээл | - | - | Тийм |
| Тоног төхөөрөмжийн зээл | Тийм | - | - |
| Жижиг дунд үйлдвэрлэлийн зээл | Тийм | Тийм | - |
| ББСБ зээл | - | Тийм | - |
| Шуурхай зээл | Тийм | - | - |
| Пос-ын орлого барьцаалсан зээл | Тийм | - | Тийм |
| Репо санхүүжилт | Тийм | Тийм | Тийм |
| Төслийн зээл | Тийм | Тийм | Тийм |
| **Хэрэглээний зээл** | | | |
| Цалингийн зээл | Тийм | Тийм | Тийм |
| Тэтгэврийн зээл | Тийм | Тийм | |
| Хадгаламж барьцаалсан зээл | Тийм | Тийм | Тийм |
| Автомашины зээл | Тийм | Тийм | Тийм |
| Өрхийн зээл | Тийм | Тийм | Тийм |
| Малчны зээл | Тийм | - | - |
| Сургалтын зээл | - | - | - |
| Үл хөдлөх барьцаалсан зээл | Тийм | Тийм | - |
| Хэрэглээний худалдан авалтын зээл | Тийм | - | Тийм |
| **Орон сууцны зээл** | | | |
| 8% хүүтэй орон сууцны зээл | Тийм | Тийм | Тийм |
| Амины орон сууц худалдан авах, барих зээл | Тийм | Тийм | Тийм |
| Хашаа байшин барих, худалдан авах зээл | Тийм | - | Тийм |
| Дулаан зогсоолын зээл | Тийм | - | - |
| Банкны эх үүсвэрээр олгох орон сууцны зээл | Тийм | Тийм | Тийм |
| Эко орон сууц, хувийн сууцны зээл | - | Тийм | Тийм |

*Эх сурвалж: Банкуудын вебсайт*

Банкуудын зээлийн бүтээгдэхүүнийг харьцуулж үзэхэд бизнес, хэрэглээ, орон сууцны зээл гэсэн үндсэн 3 төрөлд хуваагдан 14-22 нэр төрлийн зээлийг олгон зээлийн багцаа нэмэгдүүлж ажиллаж байна.

Мөнгөний бодлогын хорооноос иргэдэд олгох зээлийн дээд хугацааг хамгийн ихдээ 30 сар, иргэдийн хэрэглээний зээлийн өр орлогын харьцааг 60 хувь байхаар тогтоосон. Энэхүү шийдвэр нь ипотекээс бусад иргэдийн зээлд хамааралтай. Иргэд татварын дараах орлогынхоо хамгийн ихдээ 70 хувийг зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрт төлөх боломжтой болсон. Энэхүү шийдвэрүүд нь банкны секторт хэрэглээний зээлийн огцом өсөлтийг сааруулж өгсөн.

СЗХ
2021 -11- 10
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

# ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## 5.1. Аудитын дүгнэлт

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК нь 2020 оны 9 сарын 28-ний өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан EYMA/LOE-20/AC/MD/DB/26 тоот Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Богд Банк ХХК-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж, дүгнэлт гаргасан байна.

Хараат бус аудитын дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 сарын 31 өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартуудын (СТОУС) дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК нь энэхүү ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэсэн ба Нягтлан бодогчийн ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Банкнаас хараат бус байх бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Хараат бус аудиторууд нь гаргасан дүгнэлтийн хүрээнд олж авсан аудитын нотолгоог хангалттай, зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Бусад зүйл**

Банкны 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн тайланг Гроут Финанс Аудит ХХК аудитор Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартуудын (СТОУС) дагуу аудитлаж, 2020 оны 4 сарын 8-ны өдөр тэдгээр санхүүгийн тайланд өөрчлөгдөөгүй дүгнэлт өгсөн.

*Дэлгэрэнгүй аудитын дүгнэлтийг Хавсралт-с харна уу.*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 а 5903858

СЗХ 2021 11 10 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021 -11- 03 БҮРТГЭВ-03

## 5.2. Санхүүгийн байдлын тайлан

*Хүснэгт 19 Санхүүгийн байдлын тайлан*

| Санхүүгийн байдлын тайлан (сая төгрөг) | 2018.12.31* | 2019.12.31 | 2020.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | |
| Бэлэн мөнгө ба Монгол банк дахь харилцах | 7,442 | 99,684 | 53,555 | -46% |
| Банк, банк бус санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 17,006 | 30,977 | 37,530 | 21% |
| Бусаад худалдан авах нөхцөлтэй үнэт цаас | 19,994 | - | - | 0% |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 71,991 | - | - | 0% |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт | - | 24,412 | 20,090 | -18% |
| Дериватив | 6 | - | - | 0% |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 53,501 | 83,708 | 101,263 | 21% |
| Бусад хөрөнгө | 4,374 | 2,904 | 3,126 | 8% |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 3,852 | 3,754 | 3,590 | -4% |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө | - | - | 344 | 100% |
| Үндсэн хөрөнгө | 1,900 | 2,395 | 2,326 | -3% |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | - | 2,693 | 2,270 | -16% |
| Биет бус хөрөнгө | 898 | 804 | 807 | 0% |
| **Нийт хөрөнгө** | **180,964** | **251,331** | **224,901** | **-11%** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | | | |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 31,106 | 89,623 | 27,049 | -70% |
| Бусаад худалдах нөхцөлтэй хэлцэл | 22,986 | - | 25,049 | 100% |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 38,828 | 94,741 | 100,674 | 6% |
| Дериватив | - | 6 | - | -100% |
| Бусад эх үүсвэр | 29,749 | 9,263 | 7,465 | -19% |
| Баталгаа | 1,784 | - | - | 0% |
| Бусад өр төлбөр | 4,610 | 674 | 935 | 39% |
| Түрээсийн өр төлбөр | - | 2,545 | 2,293 | -10% |
| Татварын өр төлбөр | - | 12 | 136 | 1,033% |
| **Нийт өр төлбөр** | **129,063** | **196,864** | **163,601** | **-17%** |
| Хувьцаат капитал | 50,000 | 50,000 | 50,000 | 0% |
| Эздийн өмчийн бусад хэсэг | - | (243) | 1,041 | -528% |
| Хуримтлагдсан ашиг | 1,901 | 4,710 | 10,259 | 118% |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **51,901** | **54,467** | **61,300** | **13%** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **180,964** | **251,331** | **224,901** | **-11%** |

* *2018 оны санхүүгийн байдлын тайлан нь СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу бэлтгэж аудитлагдсан.*

БОГД БАНК ХХК БОГД БАНК BOGD BANK УЛААНБААТАР ХОТ ТТБ8966 - 5

СЭХ
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

## 5.2.1. Санхүүгийн байдлын тайлангийн бүтэц

*Хүснэгт 20 Санхүүгийн байдлын тайлангийн бүтэц*

| Санхүүгийн байдлын тайлан | 2018.12.31* | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Бэлэн мөнгө ба Монгол банк дахь харилцах | 4% | 40% | 24% |
| Банк, банк бус санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 9% | 12% | 17% |
| Бусаан худалдан авах нөнцөлтэй үнэт цаас | 11% | 0% | 0% |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 40% | 0% | 0% |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт | 0% | 10% | 9% |
| Дериватив | 0% | 0% | 0% |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 30% | 33% | 45% |
| Бусад хөрөнгө | 2% | 1% | 1% |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 2% | 1% | 2% |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө | 0% | 0% | 0% |
| Үндсэн хөрөнгө | 1% | 1% | 1% |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 0% | 1% | 1% |
| Биет бус хөрөнгө | 0% | 0% | 0% |
| **Нийт хөрөнгө** | **100%** | **100%** | **100%** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | | |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 17% | 36% | 12% |
| Бусаан худалдах нөхцөлтэй хэлцэл | 13% | 0% | 11% |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 21% | 38% | 45% |
| Дериватив | 0% | 0% | 0% |
| Бусад эх үүсвэр | 16% | 4% | 3% |
| Баталгаа | 1% | 0% | 0% |
| Бусад өр төлбөр | 3% | 0% | 0% |
| Түрээсийн өр төлбөр | 0% | 1% | 1% |
| Татварын өр төлбөр | 0% | 0% | 0% |
| **Нийт өр төлбөр** | **71%** | **78%** | **73%** |
| Хувьцаат капитал | 28% | 20% | 22% |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 0% | 0% | **0%** |
| Хуримтлагдсан ашиг | 1% | 2% | 5% |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **29%** | **22%** | **27%** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **100%** | **100%** | **100%** |

* *2018 оны санхүүгийн байдлын тайлан нь СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу бэлтгэж аудитлагдсан.*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 - 5903858

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

### 5.2.2. Санхүүгийн байдлын тайлангийн голлох үзүүлэлтүүд

**Нийт хөрөнгө**

*График 26 Богд Банкны нийт хөрөнгө (тэрбум төгрөг)*

2020 онд Богд Банкны нийт актив өмнөх онтой харьцуулахад 11 хувиар буурч 224.9 тэрбум төгрөг болжээ. Нийт хөрөнгийн бууралтад банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрээс 34.5 тэрбум төгрөгийг төлсөн нь нөлөөлсөн. 2020 оны байдлаар нийт активын 27 хувийг эздийн өмч, 73 хувийг өр төлбөр бүрдүүлж байна.

**Татан төвлөрүүлсэн хөрөнгө**

*График 27 Богд Банкны татан төвлөрүүлсэн хөрөнгө (тэрбум төгрөг)*

Богд Банкны нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 17 хувь буюу 33.39 тэрбум төгрөгөөр буурч 160.24 тэрбум төгрөг болжээ. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн бууралтад банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрээс 34.5 тэрбум төгрөгийг төлсөн нь нөлөөлсөн. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 63 хувийг буюу 100.67 тэрбум төгрөгийг харилцагчаас татсан эх үүсвэр, 37 хувийг буюу 59.56 тэрбум төгрөгийг бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрүүд тус тус бүрдүүлж байна.

**Зээлийн багц**

*График 28 Богд Банкны зээлийн багц (тэрбум төгрөг)*

Богд Банкны нийт зээлийн багц өнгөрсөн оноос 21 хувь буюу 17.6 тэрбум төгрөгөөр өсч 101.26 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2020 оны эцсийн байдлаар нийт зээлийн багцын 96 хувийг төгрөгийн зээл, 4 хувийг валютаар олгосон зээл эзэлж байгаа нь зээлийн багц дахь гадаад валютын эрсдэл бага байгааг харуулж байна. Зээлийн багцын 23 хувь нь иргэдийн зээл, 77 хувь нь байгууллагад олгосон

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
5903858

СЭХ
БҮРТГЭВ
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

зээлийн багцаас бүрдэж байсан бөгөөд энэ нь Банкны зээлийн бодлого байгууллагын зээл дээр төвлөрч ажилласныг харуулж байна. 2020 онд Богд Банкны нийт зээлийн багцын 1.9 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.1 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад хугацаа хэтэрсэн зээл 2.84 тэрбум төгрөгөөр буурч, чанаргүй зээл 2.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

## Өөрийн хөрөнгө

*График 29 Богд Банкны өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)*

Өөрийн хөрөнгийн хэмжээ 61.30 тэрбум төгрөгт хүрсэн нь 2019 оноос 6.83 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд үүнд Богд Банкны ашигт ажиллагаа нэмэгдэж 10.26 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан нь нөлөөлсөн. Банкны ашигт ажиллагаа сайжирсан нь өөрийн хөрөнгийн чадавхыг нэмэгдүүлж, 2020 оны жилийн эцсийн байдлаар банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа 46.24 хувь (Зохистой харьцаа >9 хувь), өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 46.24 хувь (Зохистой харьцаа >12 хувь) болж өссөн байна.

## Бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж

*График 30 Богд Банкны бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж (тэрбум төгрөг)*




Богд Банкны банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж 21 хувь буюу 6.55 тэрбум төгрөгөөр өсч 37.53 тэрбум төгрөг болжээ. Нийт харилцах, хадгаламжийн 98 хувийг дотоодын банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж, 2 хувийг гадаадын банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж эзэлж байна. 2020 оны эцсийн байдлаар банк санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламжийн хэмжээ 25.2 тэрбум төгрөг байна.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 ... 5703838
ЭМ АЙ СИ СИ УЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2021 -11- 03 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021 -11- 03 БҮРТГЭВ-03

### Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах, хадгаламж

*График 31 Богд Банкны бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах (тэрбум төгрөг)*

Богд Банкны бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах, хадгаламж 45 хувь буюу 37.65 тэрбум төгрөгөөр буурч 46.23 тэрбум төгрөг болжээ. Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах дансны бууралтад Монголбанк дахь харилцах 32.32 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн. 2020 оны жилийн эцсийн байдлаар Банкны заавал байлгах нөөцийн хэмжээ төгрөгөөр 4.70 тэрбум төгрөг ба гадаад валютаар 2.64 тэрбум төгрөг байна.

## 5.3. Орлогын тайлангийн үзүүлэлтүүд

*Хүснэгт 21 Орлогын тайлан*

| Орлогын тайлан (сая төгрөг) | 2018* | 2019 | 2020 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| Хүүгийн орлого | 10,132 | 21,055 | 24,497 | 3,442 | 16% |
| Хүүгийн зардал | (4,119) | (11,057) | (11,885) | (828) | 7% |
| **Хүүгийн цэвэр орлого** | **6,013** | **9,998** | **12,612** | **2,614** | **26%** |
| Шимтгэл, хураамжийн орлого | 626 | 1,071 | 1,594 | 523 | 49% |
| Шимтгэл, хураамжийн зардал | (292) | (368) | (402) | (34) | 9% |
| **Шимтгэл, хураамжийн цэвэр орлого** | **334** | **703** | **1,192** | **489** | **69%** |
| Арилжааны цэвэр орлого | 128 | 298 | 521 | 223 | 75% |
| Бусад орлого | 583 | 92 | 481 | 389 | 424% |
| **Үйл ажиллагааны нийт орлого** | **7,058** | **11,091** | **14,806** | **3,715** | **34%** |
| Хүлээгдэж буй зээлийн алдагдал | - | (1,272) | (806) | 466 | -37% |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын цэвэр алдагдал | (291) | - | - | - | 0% |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **6,767** | **9,819** | **14,000** | **4,181** | **43%** |
| Үйл ажиллагааны зардал | (4,498) | (6,932) | (7,789) | (857) | 12% |
| **Татварын өмнөх ашиг** | **2,269** | **2,887** | **6,211** | **3,324** | **115%** |
| Татварын зардал | (82) | (317) | (594) | (277) | 87% |
| **Татварын дараах цэвэр ашиг** | **2,187** | **2,570** | **5,617** | **3,047** | **119%** |

**2018 оны орлогын тайлан нь СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас батлагдсан заавар, журмын дагуу бэлтгэж аудитлагдсан.*

БОГД БАНК BOGD BANK УЛААНБААТАР ХОТ ТТД 5903858

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

### 5.3.1. Орлогын тайлангийн бүтцийн шинжилгээ

**Үйл ажиллагааны орлого**

*График 32 Богд Банкны үйл ажиллагааны орлого (тэрбум төгрөг)*

Богд Банкны үйл ажиллагааны орлого өмнөх жилийн мөн үеэс 34 хувь буюу 3.72 тэрбум төгрөгөөр өсч 14.81 тэрбум төгрөг болжээ. Үйл ажиллагааны орлогын өсөлтөд харилцагчдын тоо нэмэгдэж цэвэр хүүгийн орлого нэмэгдсэн нь нөлөөлсөн. 2020 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны орлогын 85 хувь буюу 12.61 тэрбум төгрөгийг цэвэр хүүгийн орлого, 15 хувь буюу 2.19 тэрбум төгрөгийг хураамж ба шимтгэл, арилжааны цэвэр орлого болон үйл ажиллагааны бусад орлого эзэлж байна.

**Үйл ажиллагааны зардал**

*График 33 Богд Банкны үйл ажиллагааны зардал (тэрбум төгрөг)*

Богд Банкны үйл ажиллагааны зардал 12.4 хувь буюу 0.86 тэрбум төгрөгөөр өсч 7.79 тэрбум төгрөг болжээ. Үйл ажиллагааны зардлын өсөлт нь Богд Банкны харилцагчдын тоо өсч, үйл ажиллагааны хамрах хүрээ тэлж цалингийн зардал, мэргэжлийн үйлчилгээний төлбөр болон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны орлогын 38 хувь буюу 3.01 тэрбум төгрөгийг цалингийн зардал, 19 хувь буюу 1.58 тэрбум төгрөгийг мэргэжлийн үйлчилгээний төлбөр, 41 хувь буюу 3.2 тэрбум төгрөгийг бусад үйл ажиллагааны зардал эзэлж байна.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 -11- 10
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHA
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

**Ашигт ажиллагаа**

*График 34 Богд Банкны ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)*

2020 онд Богд Банкны цэвэр ашиг өмнөх оноос 119 хувь буюу 3.05 тэрбум төгрөгөөр өсч 5.62 тэрбум төгрөг болжээ. Цэвэр ашгийн өсөлт нь үнэт цаас гаргагчийн зээлийн багц өсч хүүгийн орлого нэмэгдсэнтэй холбоотой байна. Хүү болон түүнтэй адилтгах орлогод харьцуулсан цэвэр ашиг 23 хувьтай байна.

## 5.4. Мөнгөн урсгалын тайлан

**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал**

2020 оны байдлаар Богд Банкны үйл ажиллагааны гарах мөнгөн урсгал 32.24 тэрбум төгрөг байсан бөгөөд энэхүү өсөлт нь бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламжийн төлбөртэй холбоотой байна.

*Хүснэгт 22 Мөнгөн гүйлгээний тайлан*

| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ (сая төгрөг) | 2018* | 2019 | 2020 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| Татварын өмнөх цэвэр ашиг | 2,187 | 2,887 | 6,211 | 3,324 | 115% |
| *Мөнгөн бус тохируулгууд:* | | | | | |
| Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт борлуулсны олз | - | - | (891) | (891) | 100% |
| Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт борлуулсны гарз | - | 128 | 395 | 267 | 209% |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлыг тайланд бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт | - | - | (15) | (15) | 100% |
| Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын цэвэр алдагдал | 291 | - | - | - | 0% |
| Түрээсийн өр төлбөрийн үнийн хөнгөлөлтийн олз | - | - | (39) | (39) | 100% |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө борлуулсны гарз, цэвэр | - | - | 16 | 16 | 100% |
| Үндсэн хөрөнгө борлуулсны гарз | - | 3 | 1 | (2) | -67% |

БОГД БАНК
BOGD BANK
УПАЛНЕРТАР ХОТ
ТТБ8960 5903858

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн зардал | - | 1,272 | 806 | (466) | -37% |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 236 | 350 | 610 | 260 | 74% |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн элэгдэл | 99 | 99 | 163 | 64 | 65% |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга | 185 | 186 | 186 | - | 0% |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга | - | 304 | 424 | 120 | 39% |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | - | - | 12 | 12 | 100% |
| Данснаас хассан үндсэн хөрөнгө | 5 | - | - | - | 0% |
| Зээлээр авсан эх үүсвэрийн хүүгийн зардал | - | 149 | 273 | 124 | 83% |
| Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал | - | 364 | 395 | 31 | 9% |
| Хүүгийн орлого | (10,132) | - | - | - | 0% |
| Хүүгийн зардал | 4,120 | - | - | - | 0% |
| Орлогын албан татварын зардал | 82 | - | - | - | 0% |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн бодис бус олз | - | (37) | 360 | 397 | -1,073% |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг** | **(2,927)** | **5,705** | **8,907** | **3,202** | **56%** |
| Эргэлтийн хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтүүд | (17,929) | 3,177 | (40,012) | (43,189) | -1,359% |
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **(20,856)** | **8,882** | **(31,105)** | **(39,987)** | **-450%** |
| Орлогын татварын төлөлт | (82) | (305) | (469) | (164) | 54% |
| Хүлээн авсан хүү | 8,968 | - | - | - | 0% |
| Төлсөн хүү | (3,670) | - | - | - | 0% |
| Түрээсийн өр төлбөрийн хүүгийн төлөлт | - | (364) | (395) | (31) | 9% |
| Зээлээр авсан эх үүсвэрт төлсөн хүү | - | (27) | (267) | (240) | 889% |
| **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(15,640)** | **8,186** | **(32,236)** | **(40,422)** | **-494%** |

**2018 оны орлогын тайлан нь СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас батлагдсан загвар, журмын дагуу бэлтгэж аудитлагдсан.*

**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн урсгал**

Богд Банкны хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны орох мөнгөн урсгал нь 2020 оны байдлаар 5.19 тэрбум төгрөг байсан бөгөөд санхүүгийн хөрөнгө оруулалтын худалдан авалттай холбоотой байна.

*Хүснэгт 23 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тайлан*

| Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ (сая төгрөг) | 2018* | 2019 | 2020 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| Санхүүгийн хөрөнгө оруулалтын худалдан авалт | - | (82,905) | (62,683) | 20,222 | -24% |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулснаас орсон мөнгө | - | 76,968 | 68,267 | (8,701) | -11% |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө борлуулснаас орсон мөнгө | - | - | 350 | 350 | 100% |

СЗХ
2021 11 10
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHAN
2021 11 03
БҮРТГЭВ-03

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Худалдан авсан хөрөнгө оруулалтын үнэт цаас | (547,341) | - | - | - | 0% |
| Эргэн төлөгдсөн хөрөнгө оруулалтын үнэт цаас | 482,874 | - | - | - | 0% |
| Үндсэн хөрөнгө борлуулснаас орсон мөнгө | - | 77 | 0.4 | (77) | -99% |
| Үндсэн хөрөнгө худалдан авалт | (810) | (1,031) | (554) | 477 | -46% |
| Биет бус хөрөнгө худалдан авалт | (674) | (732) | (189) | 543 | -74% |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(65,951)** | **(7,623)** | **5,191** | **12,814** | **168%** |

**2018 оны орлогын тайлан нь СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу бэлтгэж аудитлагдсан.*

## Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал

Богд Банкны санхүүгийн үйл ажиллагааны гарах мөнгөн урсгал нь 2020 оны байдлаар 2.33 тэрбум төгрөг байсан ба зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлттэй холбоотой байна.

*Хүснэгт 24 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тайлан*

| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ (сая төгрөг) | 2018* | 2019 | 2020 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| Зээлийн эх үүсвэрийн санхүүжилт | - | 9,036 | 5,973 | (3,063) | -34% |
| Зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт | - | - | (8,086) | (8,086) | 100% |
| Татсан эх үүсвэр | 29,749 | - | - | - | 0% |
| Хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалт | 21,259 | - | - | - | 0% |
| Түрээсийн ер төлбөрийн үндсэн төлбөрийн төлөлт | - | (185) | (214) | (29) | 16% |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **51,008** | **8,851** | **(2,327)** | **(11,178)** | **-126%** |

**2018 оны орлогын тайлан нь СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу бэлтгэж аудитлагдсан.*

## Мөнгөн хөрөнгийн цэвэр хөдөлгөөн

2020 оны байдлаар үнэт цаас гаргагч нь 29.37 тэрбум төгрөгийн цэвэр гарах урсгалтай байсан бөгөөд Богд Банкны бусад банк санхүүгийн харилцах, хадгаламжийн төлбөртэй холбоотой байна.

*Хүснэгт 25 Мөнгөн хөрөнгийн цэвэр хөдөлгөөн*

| Мөнгөн хөрөнгийн цэвэр хөдөлгөөн (сая төгрөг) | 2018* | 2019 | 2020 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| Мөнгөн хөрөнгийн цэвэр хөдөлгөөн | (30,610) | 9,413 | (29,372) | (38,785) | -412% |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 49,765 | 93,627 | 103,041 | 9,414 | 10% |
| **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **19,155** | **103,041** | **73,669** | **(29,372)** | **-29%** |

**2018 оны орлогын тайлан нь СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу бэлтгэж аудитлагдсан.*

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 ▲ 5903358

СЗХ
2021 -11- 03
БҮРТГЭВ-03
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

## 5.5. Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Монгол Улсын Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2 дахь заалтуудад заасан шаардлагыг банк үйл ажиллагаандаа хэрхэн биелүүлж байгааг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 5 сарын 23-ны өдрийн А-138 дугаар тушаалаар шинэчлэн батлсан "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу Монголбанкнаас хянаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нь банкны үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой байдаг. Богд Банк нь зохистой харьцааны үзүүлэлтийг ханган ажиллаж байна.

*Хүснэгт 26 Богд Банкны зохистой шалгуур үзүүлэлт*

| Үзүүлэлт | Байвал зохих | 2018 | 2019 | 2020 | Өрсөлдөгчийн дундаж* |
|---|---|---|---|---|---|
| I зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа | >9% | 57.38% | 41.89% | 46.24% | 27.33% |
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа | >12% | 62.19% | 41.89% | 46.24% | 27.73% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт | >20% | 88.00% | 54.00% | 58.82% | 46.36% |
| Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт) | <+/-30% | 9.00% | 8.90% | 1.04% | 9.05% |

**Өрсөлдөгч гэдэгт Богд Банктай харьцуулалт хийхээр сонгож авсан банкнууд болох Кредит банк, Тээвэр Хөгжлийн банк, Капитрон банк багтаж байгаа бөгөөд өрсөлдөгчийн дунджийн мэдээллийг дээрх банкнуудын 2020 оны аудитлагдсан тайлангийн мэдээллээс тооцоолж гаргасан болно.*

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг Монголбанк 9 хувиас илүү байхыг шаарддаг бол Богд Банк 17.5 хувиас илүүд барихыг зорьдог ба 2020 онд өмнөх онтой харьцуулахад 10.38 хувиар өсч 46.24 хувь болсон байна. Энэхүү үзүүлэлт нь салбарын дунджаас 1.69 дахин их байгаа ба Богд Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ сайн байгааг илтгэж байна. Үнэт цаас гаргагч нь хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөгүй байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь Монголбанкнаас тогтоосон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу 20 хувиас өндөр байхыг шаарддаг бол үнэт цаас гаргагч нь дотооддоо 32.5 хувиас илүү байх шалгуурыг тавьдаг. 2020 оны эцсээр тус харьцаа нь 58.82 хувь байсан бөгөөд энэ нь салбарын дунджаас 1.27 дахин өндөр буюу Богд Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайн байгааг илтгэж байна.

Нийт гадаад валютын позиц нь Монголбанкнаас тогтоосон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу 30 хувиас бага байх шаардлагатай бол үнэт цаас гаргагч нь дотооддоо 19 хувиас бага байх шалгуурыг тавьдаг. 2020 оны эцэст нийт гадаад валютын нээлттэй позиц өөрийн хөрөнгийн 1.04 хувийг бүрдүүлж байгаа ба дээрх үзүүлэлт нь салбарын дунджаас 8.7 дахин бага байна. Харин нэгж валютын өөрийн хөрөнгөнд эзлэх хувийг Монголбанкнаас 15 хувиар хязгаарладаг бол Богд Банк дотооддоо нэгж валютын нээлттэй позицыг өөрийн хөрөнгийн 6.5 хувиас хэтрүүлэхгүй

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

байх бодлого барьж байна. 2020 оны эцэст нэгж гадаад валютын өөрийн хөрөнгөнд эзлэх хувь 0.41 хувь байсан бөгөөд салбарын дунджаас 17.68 дахин бага байна. Дээрх үзүүлэлтүүд нь Богд Банкны гадаад валютын ханшийн эрсдэл бага байгааг харуулж байна.

## 5.6. Харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

*Хүснэгт 27 Харьцаа үзүүлэлтийн шинжилгээ*

| Үзүүлэлт | 2018* | 2019 | 2020 | Өрсөлдөгчийн дундаж** | Салбарын дундаж *** |
|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны маржин | 61.54% | 49.26% | 54.65% | 42.40% | 27.10% |
| Цэвэр ашгийн маржин | 19.07% | 11.41% | 20.73% | 8.95% | 6.13% |
| Боловсон хүчний зардал/Нийт орлого | 15.06% | 11.77% | 11.11% | 13.57% | 9.71% |
| Үйл ажиллагааны зардал/Нийт орлого | 39.21% | 30.79% | 28.75% | 26.00% | 24.10% |
| Нийт актив/Өөрийн хөрөнгө | 3.49 | 4.61 | 3.67 | 6.33 | 11.99 |
| Зээл/Татан төвлөрүүлсэн хөрөнгө | 43.61% | 43.23% | 63.20% | 65.00% | 52.91% |
| Зээлийн эрсдэлийн сангийн зардал/Нийт актив | 0.16% | 0.42% | 0.40% | 1.22% | 2.35% |

**2018 оны Богд Банкны санхүүгийн тайлан нь СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас батлагдсан заавар, журмын дагуу бэлтгэгдсэн.*

***Өрсөлдөгч гэдэгт Богд Банктай харьцуулалт хийхээр сонгож авсан банкнууд болох Кредит банк, Төрийн Хөгжлийн банк, Капитрон банк багтаж байгаа ба өрсөлдөгчийн дунджийн мэдээллийг дээрх банкнуудын 2020 оны аудитлагдсан тайлангийн мэдээллээс тооцоолж гаргасан болно.*

***Салбар гэдэгт Монгол Улсын арилжааны банкнуудын 2020 оны аудитлагдсан тайлангийн мэдээллээс тооцоолж гаргасан болно.*

### Ашигт ажиллагаа

2020 онд үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөж өнгөрсөн оноос 2 дахин өсч 2.36 хувь болон 9.70 хувь болсон ба дээрх үзүүлэлт нь салбарын дунджаас өндөр байна. Үүнээс харахад Богд Банк нь салбарын бусад банкуудтай харьцуулахад өөрийн хөрөнгийг илүү үр ашигтай ашиглаж байна.

Үйл ажиллагааны зардлыг нийт орлогод харьцуулсан үзүүлэлт нь өнгөрсөн оноос 2.04 хувиар буурч 28.75 хувь болсон ба энэхүү үзүүлэлт нь салбарын дунджаас 2.75 хувиар өндөр байгаа хэдий ч Богд Банкны ашигт ажиллагаа салбарын дунджаас илүү байна. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн маржин өмнөх оноос 81.68 хувиар өсч 20.73 хувь болсон байна. Энэхүү үзүүлэлт нь салбарын үзүүлэлтээс 2.3 дахин их байгаа ба Богд Банкны ашигт ажиллагаа нь салбарын банкуудтай харьцуулахад сайн байна.

### Зээлийн үзүүлэлтүүд

2020 онд Үнэт цаас гаргагчийн зээлийг татан төвлөрүүлсэн хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт 43.23 хувиас өсч 63.20 хувь болсон бөгөөд Богд Банкны зээлийн багц өнгөрсөн оноос 21 хувь буюу 17.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 101.26 тэрбум төгрөгт хүрсэн нь нөлөөлсөн байна. 2020 онд зээлийн багц хэдий өссөн ч зээлийн эрсдэлийн сангийн зардлыг нийт активд харьцуулсан үзүүлэлт 0.4 хувь буюу өмнөх оны үзүүлэлттэй ойролцоо байгаа ба салбарын дунджаас 3 дахин бага байна. Үүнээс харахад Богд Банкны зээлийн багцын чанар сайн байна.

БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТҮБ8966 - 5903858

СЗХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

# ЗУРГАА. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨӨЛӨЛ, ЗАРЦУУЛАЛТ

## 6.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны бодлого

### 6.1.1. Харилцах хадгаламжийн үйлчилгээ

Богд Банк нь ирэх жилүүдэд өргөн цар хүрээтэйгээр ажиллан данс эзэмшигчийн тоог нэмэгдүүлэх ба харилцагчийг идэвхжүүлэх, сэдэлжүүлэхэд төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тухайлбал:

- Зах зээл дээр өөрийн брэнд бүхий БАГЦ-ын үйлчилгээг нэвтрүүлнэ;
- Иргэд болон байгууллагад зориулсан уян хатан нөхцөл бүхий хугацаат хадгаламж, урамшуулалт хадгаламжийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлнэ;
- Өсвөр насны хуулийн хүрээнд хагас чадамжтай гэж тодорхойлогддог 13-с дээших насны хүүхдүүдэд зориулсан ХҮҮХДИЙН харилцах данс болон хадгаламжийн бүтээгдэхүүнийг шинэчлэн Rebranding хийнэ;
- Хүүхдийн мөнгө болон тэтгэврийн үйлчилгээг банкаар дамжуулан гүйцэтгэнэ;
- Хуримтлал дэмжих тусгайлсан үйлчилгээг бий болгоно;
- Цалингийн багц үйлчилгээг нэвтрүүлнэ;
- Харилцагчдад зориулсан B-point (харилцагчдын байнгын урамшууллын) хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### 6.1.2. Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ

Богд Банкны зээлийн бүтээгдэхүүний бодлогын хувьд шинээр зах зээлд бүтээгдэхүүн гаргахаас гадна банкны уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээг богино хугацаанд, бага зардлаар, түргэн шуурхай түгээхэд чиглэн ажиллана. Түүнчлэн борлуулалтын ажилтанд бүтээгдэхүүний журам заавар, энгийн хялбар байхад чиглэгдэнэ. Банк нь зээлийн үйл ажиллагааны хувьд дараах чиглэлийн хүрээнд ажиллана:

- Зээлдэгчийн эрсдэлийг үнэлэх Кредит Скоринг системийг нэвтрүүлэх;
- DMS буюу цахим бичиг баримтын Докмайн систем нэвтрүүлэх;
- SME зээлүүдийг богино хугацаанд харьцаа үзүүлэлтэд үндэслэн шийдвэрлэх аргачлалыг боловсруулах;
- Онлайн зээлийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэн, өрсөлдөх чадварыг сайжруулах;
- Тусгайлсан эрсдэл бага бүхий салбарт зориулсан үйлдвэрлэлийн зээл, нийлүүлэлтийн гинжин хэлхээний санхүүжилт, авлага барьцаалсан зээл гэх мэт шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх;
- Зээлийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, түргэсгэх ажлын хэсэг байгуулан зээл судлах, шийдвэрлэх, олгох бүхий л үйл ажиллагааг сайжруулах;
- Зээлийн хүүгийн үнийн бодлогыг шинэчлэх;
- Төслийн зээлийн үйл ажиллагааг дэмжин ажиллахад тус тус чиглэгдэнэ.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

### 6.1.3. Цахим и-сувгаар борлуулах бүтээгдэхүүн, үйлчилгээ

Богд Банкны нийт харилцагчдын 80-с дээш хувь нь онлайнаар буюу цахим сувгаар дамжин харилцагч болсон бөгөөд сүүлийн 1 жилийн хугацаанд цахимаар хийгдэж буй гүйлгээний тоо болон дүн 3 дахин өссөн. Банк нь цахим сувгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлт сайжруулалт дээр цаашид илүү анхааран ажиллах бөгөөд ирэх жилүүдэд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Онлайн зээлийг Мобайл болон Интернет банк, бусад цахим сувгуудаар дамжуулан борлуулах;
- Иргэдэд зориулсан хэрэглээний болон бизнесийн зээлийн хүсэлтийг цахим сувгаар хүлээн авах, шийдвэрлэх;
- Эх үүсвэрийн бүх төрлийн данс, картын захиалгыг зайнаас авдаг байх ажлыг шат дараалалтайгаар дотоод болон гадаадын хэрэглэгчдэд хүргэх;
- Валют арилжааг хэрэглэгч онлайнаар хийдэг байх;
- Цахим сувгаар хийх гүйлгээний лимитийн хүсэлтийг харилцагч зайнаас гаргах, зайнаас өөрчлөлтийг оруулдаг байх;
- Бүх картуудыг цахим хэлбэрт оруулан бүртгэж, цахим картаар төлбөр тооцоо хийх боломжийг тус тус бүрдүүлэн ажиллана.

## 6.2. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө

Богд Банк нь ирэх жилүүдэд Иргэд болон Жижиг дунд бизнес эрхлэгч гэсэн үндсэн 2 харилцагчийн сегментийн хүрээнд үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө гарган ажиллаж байна.

**Иргэдийн бизнес:**

Банк нь иргэдэд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээгээ хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн байх зарчмын хүрээнд ажиллаж ирсэн. Ирэх жил банкны үйлчилгээгээ харилцагчийн амьдралын хэв маяг, хүсэл сонирхол, бодит хэрэгцээнд тулгуурласан байх гэсэн үндсэн зарчмын хүрээнд хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Богд Банк нь иргэдийн сегментийн хүрээнд дараах стратеги, бодлогыг барьж ажиллана. Үүнд:

*Харилцагчийн тоог нэмэгдүүлэх*

Банкны харилцагчийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд банкны хувьд бүх насны харилцагчид өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэн ажилладаг. Иймээс харилцагчийн суурь баазыг нэмэгдүүлэх тал дээр онцгой ач холбогдол өгөн ажиллах бөгөөд шинээр харилцагч татах чиглэлээр маркетингийн хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

*Flagship тусгайлсан бүтээгдэхүүнийг санал болгох*

Богд Банк нь өрсөлдөгч нараас ялгарах бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл, боломжийг нэмэгдүүлж, өөрийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгон, зах зээлд таниулах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Тус чиглэлийн хүрээнд Монголын арилжааны банкны салбарт анх удаагаа харилцагч нарт чиглэсэн урамшууллын хөтөлбөрийг нэвтрүүлэх, шимтгэл

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

хураамж болон харилцагчийн амьдралын хэв маягийг илтгэсэн Багцын үйлчилгээ гэх мэт шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг гаргахаар ажиллаж байна.

*Цахим борлуулалтыг идэвхжүүлэх*

Банк нь цөөн тооны салбараар чанартай цогц үйлчилгээг үзүүлэх бодлогоо цаашид хэрэгжүүлэн ажиллах бөгөөд улмаар өөрийн Мобайл болон интернет банкны сувгаар банкны бүх төрлийн борлуулалтыг идэвхжүүлэх төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Банкны болон бусад хамтран ажиллагч байгууллагуудын үйлчилгээг тус сувгаараа дамжуулан харилцагчдадаа санал болгоно.

*Зөв үр дүнтэй маркетинг ба байнгын урамшуулал хөнгөлөлт*

Банк нь өөрийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах арга хэмжээг идэвхтэй бөгөөд далайцтай хийхээр төлөвлөж байна. Мөн харилцагчдыг татах, тогтоон барихын тулд харилцагчийн сегмент, үр ашиг болон тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулсан төрөл бүрийн урамшуулал хөнгөлөлтийн арга хэмжээ, өдөрлөгийг зохион байгуулна.

*Багц, бөөний борлуулалт болон борлуулалтын шинэ сувгийг нэмэх*

Банк нь өөрийн бүх төрлийн борлуулалтын сувгаар дамжуулан харилцагч нартаа бүтээгдэхүүн үйлчилгээгээ үзүүлэхээс гадна зах зээл дээр танигдсан, туршлагатай нэр хүнд бүхий байгууллагатай хамтрах эсхүл бусад технологийн шийдлээр дамжуулан банкны үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд зорин ажиллана.

**Жижиг дунд бизнес:**

Жижиг дунд бизнес эрхлэгчдийн хувьд хөлөө олсон, бизнес тогтворжсон байгууллагууд зах зээлд харьцангуй цөөн тул эдгээр харилцагчдыг татахын тулд арилжааны банкууд ихэвчлэн хямд хүүгийн бодлого барьж ажиллаж байна. Мөн нөгөө талдаа ерсөлдөөний улмаас харилцагчийн хүссэн санхүүжилтийг түргэн шуурхай шийдвэрлэх нь авч хэрэгжүүлэх шаардлагатай чухал стратеги болоод байна. Богд Банк нь бизнес эрхлэгчдийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, борлуулалтын орлого зэрэгт суурилсан эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалт, зээлийн шугам гэх мэтээр ялгаатай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон ажиллаж байгаа ба цаашид зөвхөн банкны үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээ төдийгүй санхүүгийн зөвлөгөө, дэвшилтэт технологийн шийдлээр боловсруулагдсан бусад үйлчилгээг хөгжүүлэхээр төлөвлөж байна. Бизнесийн байгууллагуудын үндсэн бизнесийг дэмжихийн зэрэгцээ, тэдгээрийн ажиллагсдын санхүүгийн хэрэгцээг шийдвэрлэх, өрхийн төсвийн зарцуулалт, өрийн дарамт болон санхүүгийн хэрэглэгчийн хамгаалах банкны тухай ойлголтыг өгч ажилласнаар нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн, ил тод нээлттэй хамтран ажиллах үүд хаалга болно. Банк тус бизнесийн хүрээнд дараах бодлого стратегийг баримтлан ажиллана. Үүнд:

*Үндэсний үйлдвэрлэл, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих*

Банк нь ирэх жилүүдэд эдийн засгийн нөхцөл байдал болон банкны ерөнхий бодлоготой уялдуулан жижиг дунд бизнес эрхлэгч, тэр дундаа үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллана. Энэхүү чиглэлээр авлага барьцаалсан санхүүжилт, нийлүүлэлтийн гинжин хэлхээний санхүүжилт гэх мэт мөнгөн урсгалд суурилсан шинэлэг тусгайлсан

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТГ58966 - 5903858

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх бөгөөд эдийн засгийн нөхцөл, тухайн салбарын онцлогт тохируулан илүү таатай нөхцөлөөр зээлийн үйлчилгээг санал болгоно.

*Төслийн зээлийн эх үүсвэртэй зээлийг харилцагчдадаа олгох*

Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлэх аливаа төсөл хөтөлбөрт банк нь идэвхтэй оролцох бөгөөд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бусад олон улсын болон дотоодын хувийн байгууллагуудтай хамтран шинэ төслийн зээлийг харилцагчдадаа олгох тал дээр анхаарч ажиллана. Мөн зээлээс гадна бизнес эрхлэгчдийг дэмждэг, мэдлэг олгодог байгууллагуудтай хамтран харилцагчдынхаа санхүүгийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

*Зээлийг хурдтай шийдвэрлэх*

Зээлийн хүсэлт хүлээн авах, судлах, шийдвэрлэх, олгох, эргэн хянах, төлүүлэх үйл ажиллагааг цогцоор нь авч үзэн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

*Цогц бүтээгдэхүүн шийдэл санал болгох*

Харилцагчид дан ганц зээл буюу санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж өгснөөс гадна тухайн харилцагчийн борлуулалт, үйл ажиллагааг дэмжсэн шийдэл бүхий цогц үйлчилгээг санал болгоно.

**Банкны уламжлалт бус бүтээгдэхүүн үйлчилгээ**

Банк нь банкны уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээг илүү боловсронгуй болгон харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэлэг, хурдан, ойлгомжтой амар хялбар байлган хөгжүүлэлт, сайжруулалтыг тогтмол хийж ажиллана. Банкны хувьд тухайн харилцагчаас нэг удаад ашиг олохоос илүү урт хугацаанд буюу насан туршид нь хамт байж бүтээгдэхүүн үйлчилгээгээ үзүүлэхийг эрмэлзэх бөгөөд улмаар тухайн харилцагчийн нас, орлого, онцлог, хэрэгцээнд тулгуурлан төрөл бүрийн шийдлийг санал болгоно.

Тухайлбал банк нь ирэх жилүүдэд хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа өргөжин тэлж байгаатай холбоотойгоор доорх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

- Хөрөнгө оруулалтын сан,
- Хувийн тэтгэврийн сан,
- Брокер болон
- Кастодиан банк

Мөн Банк нь даатгалын зуучлалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөлтэй бөгөөд мэргэжлийн санхүүгийн үзүүлэлт сайтай даатгагч нартай хамтран харилцагч нартаа шаардлагатай даатгалын үйлчилгээг зуучлан хүргэж байна. Богд Банк нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээр мэргэшсэн тусгайлсан чиг үүрэг бүхий компани байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Банк нь хадгаламж гэсэн банкны уламжлалт сэтгэлгээг халж харилцагчийнхаа хүсэл сонирхолд нийцсэн зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд нийцүүлэн чанартай хүргэхээр зорин ажиллах болно.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

## 6.3. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төлөвлөгөө

### 6.3.1. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл

Богд Банкны 2021 оноос 2025 он хүртэлх 5 жилийн төлөвлөгөө дараах байдалтай байна.

*Хүснэгт 28 Богд Банкны 5 жилийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл* [10]

| Балансын зүйл (сая төгрөг) | 2020Г | 2021Т | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т |
|---|---|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 53,555 | 92,210 | 111,154 | 117,126 | 213,523 | 272,916 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | 37,530 | 19,847 | 45,129 | 66,110 | 72,661 | 79,364 |
| Хөрөнгө оруулалт | 20,090 | 37,729 | 85,788 | 133,228 | 186,673 | 243,094 |
| Зээл (цэвэр дүнгээр) | 101,263 | 248,592 | 400,211 | 651,348 | 957,902 | 1,239,867 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 579 | 1,100 | 1,240 | 1,397 | 1,574 | 1,773 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 4,817 | 5,164 | 14,930 | 20,407 | 25,645 | 32,227 |
| Үндсэн хөрөнгө | 2,326 | 4,133 | 4,657 | 5,248 | 5,913 | 6,663 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 3,590 | 3,425 | 4,030 | 4,541 | 5,117 | 5,766 |
| Борлуулах зориулалттай хөрөнгө | 344 | - | - | - | - | - |
| Биет бус хөрөнгө | 807 | 1,879 | 2,117 | 2,385 | 2,688 | 3,029 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **224,901** | **414,080** | **669,256** | **1,001,788** | **1,471,695** | **1,884,699** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | | | | |
| Харилцах | 19,714 | 63,659 | 87,020 | 110,060 | 146,705 | 180,634 |
| Хадгаламж | 80,960 | 168,389 | 379,245 | 607,184 | 953,426 | 1,209,175 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 34,514 | 38,854 | 43,782 | 77,128 | 109,966 | 156,785 |
| Бусад эх үүсвэр | 25,049 | 38,285 | 43,141 | 75,999 | 108,356 | 154,490 |
| Бусад өр төлбөр | 935 | 1,488 | 1,609 | 1,629 | 1,648 | 1,668 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 2,429 | 1,533 | 1,658 | 1,678 | 1,698 | 1,719 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **163,601** | **312,208** | **556,455** | **873,678** | **1,321,800** | **1,704,471** |
| **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | | | | | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 50,000 | 100,000 | 100,000 | 100,000 | 100,000 | 100,000 |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | 10,259 | 1,007 | 11,827 | 27,013 | 48,658 | 78,835 |
| Бусад өөрийн хөрөнгө | 1,041 | 864 | 974 | 1,098 | 1,237 | 1,394 |
| **НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **61,301** | **101,872** | **112,801** | **128,111** | **149,895** | **180,228** |
| **ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **224,901** | **414,080** | **669,256** | **1,001,788** | **1,471,695** | **1,884,699** |

[10] *Богд Банкны бизнес төлөвлөгөө*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТӨ8966 № 5903838

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHAN
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

### 6.3.2. Орлогын тайлангийн төсөөлөл

Богд Банк нь орлого тайлангийн хувьд 5 жилийн хугацаанд дараах байдлаар төлөвлөсөн байна:

*Хүснэгт 29 Богд Банкны 5 жилийн орлогын тайлангийн төсөөлөл* [11]

| Орлого, зардлын зүйл (сая | 2020Г | 2021Т | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т |
|---|---|---|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 24,497 | 32,821 | 55,779 | 86,813 | 129,785 | 177,060 |
| Хүүгийн зардал | 11,885 | 15,726 | 28,890 | 47,689 | 73,326 | 101,155 |
| Хүүгийн цэвэр орлого | 12,612 | 17,095 | 26,889 | 39,124 | 56,459 | 75,905 |
| Эрсдэлийн сангийн зардал | 806 | 2,083 | 6,402 | 10,516 | 17,492 | 25,778 |
| Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого | 11,806 | 15,012 | 20,487 | 28,608 | 38,967 | 50,127 |
| Бусад орлого | 2,194 | 5,358 | 7,543 | 12,066 | 18,281 | 25,073 |
| Бусад зардал | 7,789 | 9,286 | 14,993 | 21,824 | 29,796 | 36,384 |
| **Татварын өмнөх ашиг, алдагдал** | **6,211** | **11,084** | **13,038** | **18,850** | **27,452** | **38,817** |
| Орлогын татварын зардал | 594 | 1,736 | 2,218 | 3,664 | 5,807 | 8,640 |
| **Татварын дараах ашиг, алдагдал** | **5,617** | **9,348** | **10,820** | **15,186** | **21,645** | **30,177** |
| Бусад орлого | - | - | - | - | - | - |
| **Тайлант хугацааны нийт** | **5,617** | **9,348** | **10,820** | **15,186** | **21,645** | **30,177** |

### 6.3.3. Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувийн төсөөлөл

Богд Банк нь дээрх бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлсний үр дүнд зах зээлд эзлэх хувийг дараах зорилтот хүрэхээр төсөөлсөн байна.

*График 35 Богд Банкны зах зээлд эзлэх зорилтот хувь*

## 6.4. Үнэт цаас гаргагчийн суваг хуваарилалтын стратеги

Богд Банк нь цахим сувгаар харилцагчийн цаг хугацааг хэмнэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг гарган үнэ цэнэ бий болгох тал дээр түлхүү ажиллах хэдий ч банкны үйлчилгээг илүү хүртээмжтэй байлгах зорилгоор банкны биет салбар нэгжийнхээ тоог шат дараатай нэмэгдүүлнэ. Банкны салбар нэгж нь цомхон бүтэцтэй, энгийн нүсэр бус байх гэсэн суурь зарчмыг хадгална. Банк нь энэхүү зарчмын хүрээнд хүн амын төвлөрөл, харилцагчдын

[11] *Богд Банкны бизнес төлөвлөгөө*

СЗХ 2021 .11.ар 19 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021 -11- 03 БҮРТГЭВ-03

хүсэл шаардлага, зах зээлийн онцлог зэргийг үнэлсний үндсэн дээр шинэ салбар нэгж байгуулан ажиллаж байна.

Богд Банк нь 2021 онд Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт хотуудад нийт 6 салбар нээж, 2022 онд Монгол орны 21 аймагт өөрсдийн нэгж, төлөөллөө байгуулахаар төлөвлөсөн.

Банк нь үйлчилгээнийхээ хүртээмжийг нэмэгдүүлэн салбар байгуулахдаа дан ганц өөрийн хөрөнгө оруулалтаар хийхээс илүүтэй бусад мэргэжлийн ёс зүйтэй байгууллагуудтай стратегийн түвшинд хамтран санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэхээр зорин ажиллаж байна. Энэхүү зорилтын хүрээнд банк нь Монгол Шуудан ХК, Даатгалын компаниуд гэх мэт стратегийн ач холбогдох бүхий мэргэжлийн байгууллагуудтай хамтран тэдгээрийн салбар нэгжээр дамжуулан банкны үйлчилгээ үзүүлэн ажиллана.

## 6.5. Үнэт цаас гаргагчийн маркетингийн төлөвлөгөө стратеги

Богд Банк нь арилжааны банкны үзүүлдэг зээл, хадгаламж, карт гэх мэт бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байгаагаас гадна бусад банкинд нэвтрүүлээгүй өөрсдийн бренд бүтээгдэхүүнийг зах зээлд гаргаад байна. Тухайлбал "B-point" /Би пойнт/ харилцагчдын байнгын урамшууллын үйлчилгээ, "Багцын үйлчилгээ" буюу харилцагчийн төлбөр тооцоо, амьдралын хэв маягт таарсан нэмэлт үйлчилгээ, Prime /Прайм/ кредит карт болон онлайн хадгаламж, зээлийн үйлчилгээг дурдаж болох юм. Бусдаас ялгаатай байх нь маркетингийн том хөшүүрэг бөгөөд Банк бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлах замаар Банкны нэр хүндийг олон нийтэд улам таниулахаар зорин ажиллаж байна.

Банк нь үйл ажиллагаагаа таниулах ажлын хүрээнд харилцагчдынхаа сонирхол, хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч, зөв оновчтой медиа хэрэгслийг ашиглан мэдээ мэдээллээ түгээнэ. Банк нь мэдээллээ түгээхдээ дан ганц өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээг таниулахаас гадна өөрийн болон бусад хамтрагч байгууллагуудын медиа хэрэгслээр дамжуулан иргэдэд санхүүгийн зөвлөгөө, бусад хэрэгцээт мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэж байна. Цаашид Богд Банк нь харилцагчдадаа илүү ойлгомжтой энгийнээр хүргэхээр зурган болон видео контентуудыг боловсруулан түгээхээр төлөвлөж байна.

Богд Банк нь технологийн шинэ эрин үед уламжлалт маркетингаас илүү дижитал буюу сошиал маркетингийг илүү ашиглаж байгаа бөгөөд иргэдийн хамгийн их ашигладаг хандалт ихтэй сошиал платформууд болох Facebook, Twitter, Instagram, Youtube, LinkedIn дээр албан ёсны хуудас үүсгэн, эдгээр платформ болон www.bogdbank.com цахим хуудсаар дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээ, цаг үеийн мэдээг тухай бүр хүргэж байна.

Банк нь нийгмийн хариуцлагын эрхэмлэгч байгууллагын хувьд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, соёл урлаг болон спортын баг тамирчдыг бүх талаар дэмжин ажиллана. Богд Банк нь жилийн тайлангаа олон нийтэд нээлттэй тайлагнадаг, салбартаа байгууллагын засаглалаар манлайлан ажиллахыг зорьж байна.

Ирэх жилүүдэд Богд Банк нь зах зээлд өөрийн онцлог давуу тал бүхий бүтээгдэхүүн үйлчилгээгээр олон нийтэд танигдах ажлуудыг түлхүү төлөвлөж байна:

БОГД БАНК ХХК БОГД БАНК BOGD BANK УЛААНБААТАР ХОТ ТТӨ8966 5903858

СЭХ
2021 -11- 10
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANG
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

- Бүтээгдэхүүний үйлчилгээний олон нийтийн сүлжээнд байршуулах сурталчилгаа, мэдээ, мэдээллийг хөдөлгөөнт, дуут хэлбэрээр боловсруулах;
- Банкны имижийг сурталчилсан рекламыг түгээх;
- Бүтээгдэхүүний үйлчилгээний зааварчилгааг шинэ технологид суурилсан, өөрмөц төрхтэйгөөр гаргах;
- Банкны онцлох мэдээ мэдээллийг тогтмол нийтэд ил тод мэдээлэх;
- Банкны харилцагч нэг бүрд хүрсэн шууд маркетингийг автоматжуулан хүргэх;
- Томоохон нэр хүнд бүхий контент ивээн тэтгэх.

Банк нь өөрийн болон бусад хамтран ажиллагч байгууллагуудаар систем, тэдгээрийн өгөгдлийн сан дээр дүн шинжилгээ хийж тухайн харилцагчийн зан төлөв, худалдан авалт хийх хэв маяг болон сонирхол дээр үндэслэн бүтээгдэхүүн үйлчилгээний хөнгөлөлт урамшуулал үзүүлэх, шууд маркетингийн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх бөгөөд үүнтэй холбоотойгоор банкны мобайл платформ, интернет банк болон цахим хуудас дээр мэдэгдлийн шинэлэг хэрэгслүүдийг ашиглахаар төлөвлөсөн.

## 6.6. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Богд Банк нь олон нийтээс татан төвлөрүүлж буй хөрөнгөөр дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж, банкны үйл ажиллагааг өргөжүүлж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Тус ажлын хүрээнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийж, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлт болон зээл олголтын үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн.

*Хүснэгт 30 Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө*

| № | Хөрөнгө оруулалтын төрөл (сая төгрөг) | 2021 | 2022 | 2023 | Нийт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Технологийн хөрөнгө оруулалт | 2,540 | 7,303 | 2,858 | **12,700** | **40%** |
| 2 | Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлт | 1,905 | 3,810 | 3,810 | **9,525** | **30%** |
| 3 | Борлуулалтын сувгийн хөгжүүлэлт, сайжруулалт | 2,778 | 3,523 | 3,224 | **9,525** | **30%** |
| | **Нийт** | **7,223** | **14,636** | **9,891** | **31,750** | **100%** |

### 6.6.1. Технологийн хөрөнгө оруулалт

Үнэт цаас гаргагч нь ирэх жилүүдэд өөрийн хөрөнгийн хэмжээ, харилцагчийн бааз суурь болон үнэлгээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд техник, технологийн шийдэл, боломжийг ашиглахаар төлөвлөсөн. Богд Банк нь технологид 12.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр ирэх 5 жилд харилцагчийн тоог 12 дахин нэмэгдүүлж, зээлийн багцыг 1.2 их наяд төгрөгт хүргэн, зорилтот зах зээлийн 7 хувийг эзлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Банк нь технологийн хөрөнгө оруулалтын хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 - 11 - 03
БҮРТГЭВ-03

*Хүснэгт 31 Үнэт цаас гаргагчийн технологийн хөрөнгө оруулалтын задаргаа*

| Хөрөнгө оруулалтын задаргаа | Үнийн дүн (сая төгрөг) | Хувь (%) |
|---|---|---|
| Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ | 6,350 | 50% |
| Систем сайжруулалт, хөгжүүлэлт | 4,191 | 33% |
| Уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах, сайжруулах | 2,159 | 17% |
| **Нийт** | **12,700** | **100%** |

*Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ*

Үнэт цаас гаргагч нь орчин үеийн шинэлэг систем, серверт шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийж, системийн аюулгүй байдлын хамгаалалт дээр онцгойлон анхаарч ажиллахаар төлөвлөсөн.

Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд Богд Банк нь одоо ашиглаж буй салбарын болон АТМ төхөөрөмжийн сүлжээний холболтыг сайжруулан, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөр тооцоо буюу цахим гүйлгээтэй холбоотой бүтээгдэхүүнүүд болох зарлага болон орлого хүлээн авдаг АТМ, ПОС буюу карт хүлээн авагч төхөөрөмжүүд, КИОСК гэх мэт төхөөрөмжүүдэд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Дээрх ажлын үр дүнд харилцагчдад хүргэх үйлчилгээг улам чанаржуулж, дэд бүтцийг өргөжүүлэн сайжруулах юм. Банкны алсын хараа, эрхэм зорилгыг хангах, стратегийн дунд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бусад банкуудаас үйлчилгээний хурд, технологийн хоцрогдолгүйгээр ажиллах нь зах зээлийг тэлэх, зорилтод түвшинд хүрэхэд өндөр ач холбогдолтой юм.

*Хүснэгт 32 АТМ, КИОСК, ПОС-ын худалдан авалтын төлөвлөгөө*

| Худалдан авалтын төрөл | 2021 | 2022 | 2023 | Нийт |
|---|---|---|---|---|
| АТМ худалдан авалт | 3 | 15 | 10 | 28 |
| КИОСК худалдан авалт | 1 | 49 | 20 | 70 |
| ПОС худалдан авалт | 1,000 | 2,500 | 1,500 | 5,000 |

*Систем сайжруулалт, хөгжүүлэлт*

Банкны бизнес нь харилцагчийн итгэлцэл дээр оршин тогтнодог. Систем сайжруулалт, хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтын үр дүнд Богд Банк нь системийн аюулгүй байдалд онцгойлон анхаарч шаардлагатай сайжруулалт, хөгжүүлэлтийг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Банк нь системийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж, сайжруулах зорилгын хүрээнд харилцагчдын өдөр тутмын амьдралд үнэ цэнэ, найдвартай байдлыг улам баталгаажуулах, банкны үндсэн системүүдийн хөгжүүлэлтийг амжилттай хийж, мэдээлэл технологийн ажилтнуудын сургалт хөгжил, техник, технологи, дата төвийн сайжруулалт, шинэчлэлтийг тасралтгүй хөгжүүлэх зорилготойгоор ажиллаж байна.

Систем сайжруулалт, хөгжүүлэлтийн хүрээнд Үнэт цаас гаргагч нь серверийн шинэчлэл, программын эрх, системийн аюулгүй байдлыг сайжруулах, дэд бүтцийг өргөжүүлж ачаалал даах чадварыг нэмэгдүүлэх ажлуудыг хийхээр төлөвлөсөн. Дээрх хөрөнгө оруулалтын үр дүнд харилцагчдын хүсэл, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хүргэж, зах зээлээ 10 дахин нэмэгдүүлэх боломжтой болох юм.

СЗХ
2021 .11 сар
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээг цахимжуулах, сайжруулах*

Дэлхий нийтээрээ банкууд цахим хэлбэрт шилжиж, цахимаар үйлчлэх хандлагатай байна. Энэхүү шилжилт манай улсад хурдацтай явагдаж байгаа нь банкуудад маш том боломжийг бий болгож байна. Дээрх шинэчлэлийн хүрээнд банкуудын харилцагчдад найдвартай, хурдтай үйлчилгээг хүргэх олон салбар нэгж, хүний нөөц, үйл ажиллагааны тогтмол зардлууд хэмнэгдэж, томоохон банкуудтай адил түвшинд өрсөлдөх боломжтой болох юм.

Богд Банк нь технологийн салбарт хөрөнгө оруулалт хийж, харилцагч болон банкны цаг хугацаа, зардлыг хэмнэсэн цахим үйлчилгээг хөгжүүлэхэд анхааран ажиллана. Дээрх ажлын үр дүнд уламжлалт банкны үйл ажиллагааны зардлыг багасгаж, ашгийн түвшинг өсгөж, үйлчилгээ үзүүлэх хугацааг 3-6 дахин хурдасгаж, харилцагчдын тоог жилд дунджаар 50 хувиар нэмэгдүүлнэ.

### 6.6.2. Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлт

Богд Банк нь харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бүтээгдэхүүн үйлчилгээгээ ямагт сайжруулан хөгжүүлэн ажиллах бөгөөд улмаар шаардлагатай хөгжүүлэлт судалгаанд татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулна. Банк нь орчин үеийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, бусдаас ялгаатай байдлаар харилцагчийн хөрөнгө, цаг хугацааг хэмнэсэн давуу талтай бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхийг эрмэлзэхээс гадна уламжлалт банкны үйлчилгээг цахимжуулах, сайжруулахтай холбоотой хөрөнгө оруулалтыг хийж ажиллана.

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 30 хувь буюу 9.5 тэрбум төгрөгийг бүтээгдэхүүн үйлчилгээнд зарцуулах ба үүнээс 75 хувийг онлайн зээлийн багцад, үлдсэн 25 хувийг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахад зарцуулахаар төлөвлөсөн.

*Хүснэгт 33 Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлтийн төлөвлөгөө*

| Зарцуулалтын төрөл | Үнийн дүн (сая төгрөг) | Хувь (%) |
|---|---|---|
| Зээлийн багц | 7,144 | 75% |
| Бусад шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ | 2,381 | 25% |
| **Нийт** | **9,525** | **100%** |

*Зээлийн багц*

Богд Банк нь орлого олдог актив буюу зээлийн бүтээгдэхүүнд 7.14 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байгаа бөгөөд зээлийг онлайн сувгаар олгож, харилцагчийн цаг хугацааг хэмнэсэн өгөөж өндөр бүтээгдэхүүнд зарцуулна. Дээрх хөрөнгө оруулалтын үр дүнд хамтран ажиллагч байгууллагуудын хүрээ өргөсөж, харилцагчид үзүүлэх үйлчилгээний хурд нэмэгдэж, зээлийн багц болон харилцагчдын тоо нэмэгдэх ач холбогдолтой юм.

*Хүснэгт 34 Зээлийн багцын хөрөнгө оруулалтын задаргаа*

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

| Зарцуулалтын төрөл | Үнийн дүн (сая төгрөг) | Хувь (%) | Бий болох давуу талууд |
|---|---|---|---|
| Онлайн цалингийн зээл | 3,400 | 48% | -Хамтрагч байгууллагуудын тоо нэмэгдэнэ |
| Онлайн хэрэглээний зээл | 1,580 | 22% | - Харилцагчдын тоо нэмэгдэнэ |
| Онлайн бизнесийн зээл | 1,120 | 16% | - Банкны бусад бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт нэмэгдэнэ |
| Кредит карт | 1,044 | 15% | - Зээлийн багц нэмэгдэнэ<br>- Харилцагчид үзүүлэх үйлчилгээний хурд нэмэгдэнэ |

*Бусад шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ*

Богд Банк нь зээлийн бүтээгдэхүүнээс гадна бусад шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнд 2.25 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. Үнэт цаас гаргагч нь Багцын үйлчилгээ болон B-point үйлчилгээг улам сайжруулан, шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж, харилцагчдын тоог нэмэгдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газар болон Монгол улсаас олгож буй тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Богд Банк нь ONE-STOP буюу нэг цэгийн үйлчилгээг үзүүлэхийг баримтлан ажиллах тул зах зээл дээрх эрэлт хэрэгцээтэй, харилцагчдын хүсэл сонирхолд нийцсэн үйлчилгээг боломжит хэмжээнд нэвтрүүлэхийг зорин ажиллах бөгөөд энэ чиглэлээр мэргэшсэн, зах зээлд танигдсан байгууллагуудтай хамтран ажиллах, тэдгээрийг санхүүжүүлэх, хөрөнгө оруулах эсхүл шинээр үүсгэх зэргээр тухайн үйлчилгээг харилцагчдадаа хүргэнэ. Тухайлбал Банк нь ирэх жилүүдэд хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөтэй байна. Үүнд:

- хөрөнгө оруулалтын сан;
- хувийн тэтгэврийн сан;
- брокер;
- кастодиан банк.

### 6.6.3. Борлуулалтын сувгийн хөгжүүлэлт, сайжруулалт

*График 36 Харилцагчийн тоо*




Богд Банк нь анх 2015 онд 15 харилцагчтайгаар үндсэн үйл ажиллагаагаа явуулж байсан бол өнгөрсөн 2 жилийн хугацаанд харилцагчийн тоо 3 дахин нэмэгдэж, 2020 оны эцсээр 29,925 харилцагчтай болсон байна. Үнэт цаас гаргагч нь өөрийн интернет банк болон мобайл банкны шинэчлэлтийг 2019 онд хийснээр цахим сувгаар борлуулж буй харилцах, хадгаламж, зээлийн үйлчилгээ авах харилцагчдын тоо огцом нэмэгдсэн. 2021 оны эхний хагас жилийн байдлаар Багцын үйлчилгээ болон B-point урамшууллын

СЗХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHAN
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

хөтөлбөр зах зээлд нэвтрүүлсэн даруйд харилцагчийн тоо оны сүүлээс 73.9 хувь буюу 22,117 харилцагчаар нэмэгдэн нийт харилцагчийн тоо 52,042-д хүрсэн. Нийт харилцагчдын 80 хувь нь дижитал салбар буюу цахим сувгаар дамжуулан харилцагч болсон байна.

Банк нь ирэх жилүүдэд харилцагчийн бааз суурийг нэмэгдүүлэх тал дээр онцгой ач холбогдол өгч ажиллах бөгөөд харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ болон санхүүгийн цогц шийдлийг санал болгохдоо орчин үеийн дэвшилтэд техник, технологийг ашиглан богино хугацаанд түргэн шуурхай найдвартай үйлчилгээ үзүүлэхийг эрмэлзэж ажиллах ба харилцагчдын тоог нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжин тэлэхтэй холбоотойгоор борлуулалтын сувгийн хүртээмж, сайжруулалт, хөгжүүлэлтэд нийт татан төвлөрүүлж буй хөрөнгийн 30 хувь буюу 9 орчим тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн.

*Харилцагчдын бааз суурь нэмэгдүүлэх*

*График 37 Харилцагчдын тоон төсөөлөл*




Банк нь ирэх жилүүдэд харилцагчдын тоог өмнөх жилээс 50-с багагүй хувиар нэмэгдүүлэн 2025 он гэхэд Монгол Улсын нийт хүн амын 25-30 хувийг банкныхаа харилцагч болгохоор зорин ажиллаж байна. Үүний хүрээнд дижитал банк хариуцсан нэгж байгуулан шаардлагатай программ хангамжид хөрөнгө оруулж, "харилцагч–бүтээгдэхүүн–суваг" зарчмын дагуу нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллахаар төлөвлөж байна.

*Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж*

Богд Банк нь цахим сувгаар харилцагчийн цаг хугацааг хэмнэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг гарган үнэ цэнэ бий болгох тал дээр түлхүү ажиллах хэдий ч банкны үйлчилгээг илүү хүртээмжтэй байлгах зорилгоор банкны биет салбар нэгжийнхээ тоог шат дараатай нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Үнэт цаас гаргагч нь банкны салбар нэгжийг цомхон бүтэцтэй, энгийн нүсэр бус байх гэсэн суурь зарчмыг хадгалан ажиллана. Банк нь энэхүү зарчмын хүрээнд хүн амын төвлөрөл, харилцагчдийн хүсэл шаардлага, зах зээлийн онцлог зэргийг үнэлсний үндсэн дээр шинэ салбар нэгж байгуулах төлөвлөгөөтэй байна.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТӨ8966 ▲ 5903858

СЗХ БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*График 38 Салбарын тоо*




Богд Банк нь 2021 онд багтаан Улаанбаатар хот болон Дархан хотуудад нийт 6 өөрийн салбараа нээх төлөвлөгөөтэй байгаа ба 2022 онд Монгол орны 21 аймагт өөрсдийн нэгж, төлөөллөө байгуулахаар төлөвлөж байна. Үнэт цаас гаргагч нь үйлчилгээнийхээ хүртээмжийг нэмэгдүүлэн салбар байгуулахдаа дан ганц өөрийн хөрөнгө оруулалтаар хийхээс илүүтэй бусад мэргэжлийн ёс зүйтэй байгууллагуудтай стратегийн түвшинд хамтран санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэхээр зорин ажиллаж байна. Богд Банк нь хамтын ажиллагааны хүрээнд Монгол Шуудан ХК, Даатгалын салбар болон бусад мэргэжлийн байгууллагуудын салбар нэгжээр дамжуулан банкны үйлчилгээ буюу харилцах, хадгаламж, картын төлбөр тооцооны үйлчилгээ болон зээлийн үйлчилгээг үзүүлнэ.

*Хүснэгт 35 Шинээр байгуулах салбар, нэгжийн төсөөлөл*

| Салбар, нэгжийн байршил | 2021 | 2022 | 2023 | Нийт |
|---|---|---|---|---|
| Улаанбаатар | 4 | 11 | 5 | **20** |
| Express | 1 | 20 | 10 | **31** |
| Орон нутаг | 1 | 19 | 0 | **20** |
| **Нийт** | **6** | **50** | **15** | **71** |

Банк нь Монгол Шуудан ХК-ийн салбарууд, Бодь Даатгал ХК-ийн салбаруудаар дамжуулан өөрийн үйлчилгээг үзүүлснээр салбар байгуулах зардал 3-5 дахин буурах боломжтой бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд банкны зүгээс салбар нэгжээ нээхдээ шаардлагатай хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээг хийснээр богино хугацаанд тухайн зах зээлд нэвтрэн үйл ажиллагаагаа эхлүүлэх давуу талтай болно. Богд Банк нь стратегийн түншлэлд урт хугацааны харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллах ба харилцагчийн үйлчилгээний нэгдсэн стандарт, сургалт үйлчилгээ чанар дээр анхаарч ажиллахаар зорьж байна.

# ДОЛОО. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

## 7.1. Үнэт цаас гаргагчийн үнэлгээний дүгнэлт

Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2021Y/VAL-001 тоот дугаартай Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээний дагуу БДО Аудит ХХК хийж гүйцэтгэсэн. Үнэлгээг хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалахаас өмнө болон арилжаалсны дараах байдлаар хийсэн бөгөөд үнэлгээний дүгнэлтийг гаргахдаа үнэлгээний өртийн хандлага

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 - 5903858

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHANG
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

болон орлогын хандлагын хосолмол загвар болох Илүүдэл Ашгийн арга[12] (ихэвчлэн "Нэмэгдэл Эдийн Засгийн Үнэ Цэн-ийн загвар" буюу EVA Model гэж нэрлэгддэг)-ыг ашигласан.

Банкны 100 хувийн өмчийн зах зээлийн үнэ цэнийн үнэлгээ нь хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалахаас өмнөх байдлаар 105,925 сая - 127,119 сая төгрөг байх үндэслэлтэй байна гэж үнэлгээний байгууллага дүгнэсэн байна.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалтыг үндэслэн Богд Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргаж буй нэгж хувьцааны анхдагч зах зээлд олон нийтэд санал болгох үнийг 2,540 төгрөг байхаар шийдвэрлэж, 2021 оны 10 сарын 25-ны өдрийн 21/17 тоот тогтоолоор баталгаажуулсан байна.

**Үнэлгээнд ашигласан арга аргачлал**

Богд банкны бизнесийг үнэлэхдээ орлогын хандлагаас Илүүдэл өгөөжийн арга болон Ногдол ашиг хорогдуулах загвар, зах зээлийн хандлагаас жишиг компанийн арга зүйг сонгон ашигласан.

Бизнесийн 100 хувийн эзэмшигчийн өмчийн зах зээлийн үнэ цэнийн дүгнэлтийг өртгийн ба орлогын хандлагын аргын хосолмол арга болох Илүүдэл ашгийн аргыг ашиглан тооцсон. Энэхүү үнэлгээнд зах зээлийн хандлагын зах зээлийн үржүүлэгчийн арга болон Орлогын хандлагын Ногдол ашиг хорогдуулах загваруудыг Үнэлгээний дүгнэлт гаргасан Илүүдэл ашгийн аргын үр дүнгийн дээд, доод интервалыг шалгах зорилгоор авч үзсэн байна.

**Зах зээлийн хандлага**

Жишиг компанийн арга зүйг ашиглахдаа банкны салбарт хамгийн түгээмэл ашиглагддаг P/E буюу "Үнэ/ашиг" болон P/B буюу "Үнэ/Дансны үнэ" үржүүлэгчийг авч ашигласан байна.

Зах зээлийн хандлагын хүрээнд үнэлгээний дээд ба доод утгын интервалыг тооцохдоо гадаадын болон дотоодын зах зээл дэх банк, санхүүгийн байгууллагуудын мэдээлэлд суурилсан. Гадаадын зах зээл дэх банкнууд нь үйл ажиллагааны хувьд тогтворжиж, өсөлт тогтмол хэмжээнд хүрсэн гэдэг утгаараа үнэлгээний доод утгыг илэрхийлнэ гэж үзсэн бол дотоодын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдаж буй санхүүгийн байгууллагуудын үзүүлэлт нь Богд Банкны өсөлтийн өөдрөг хувилбарыг илэрхийлэх боломжтой гэж дүгнэсэн.

*Хүснэгт 36 МХБ-ийн Санхүүгийн салбарын жишиг компанийн үржүүлэгчийн мэдээлэл*

| Тикер | RoE | P/B | P/E |
|---|---|---|---|
| ADB | 17.9% | 6.12x | 34.08x |
| INV | 21.7% | 4.34x | 19.93x |

[12] *Бизнесийн нэгжийн бий болгох ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнд үндэслэдэг үнэлгээний арга юм.*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ 96 - 5903858

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

| | | | |
|---|---|---|---|
| LEND | 12.8% | 1.95x | 15.24x |
| Богд банкны өмчийн өгөөжийн хувьд суурилан тохируулсан үржүүлэгч | 9.7% | 2.44x | 18.84x |

Монголын Хөрөнгийн Бирж дээр санхүүгийн салбарт 3 банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа идэвхтэй арилжаалагдаж байгаа нь банкны салбартай хамгийн төстэй нь юм. Үнэлгээний компани нь ББСБ-ын үржүүлэгчийг Өмчийн өгөөжийн хувьтай уялдуулан регрессийн хүчин зүйлийн шинжилгээ хийх замаар Богд Банканд тохирох үнэлгээний үржүүлэгчийг тодорхойлсон.

Жишиг компанийн арга зүйн доод утгыг тодорхойлохдоо дараах гадаад банкнуудын Үнэ-Ашгийн харьцаа ба Үнэ- Дансны үнийн харьцааг судалж доод утгын инвервалыг тооцоолсон байна.

*Хүснэгт 37 Гадаадын жишиг нээлттэй банкны үржүүлэгчийн мэдээлэл*

| Нээлттэй банкны нэр | Ашгийн маржин | ROE | P/B | P/E |
|---|---|---|---|---|
| Vestjysk Bank (VJBA.CO) | 34% | 9% | 0.81x | 8.44x |
| Bank of Jiujiang (SEHK:6190) | 32% | 15% | 1.13x | 9.75x |
| Cadence Bancorp (CADE) | 26% | 9% | 1.68x | 21.78x |
| Cadence Bancorp (CADE) | 29% | 10% | 1.47x | 20.26x |
| SunTrust Bank (STI) | 30% | 13% | 1.28x | 10.72x |
| TD Bank Group (TD) | 31% | 17% | 1.84x | 11.43x |
| Wells Fargo (WFC) | 34% | 17% | 1.49x | 9.49x |
| Доод | | | 0.81x | 8.44x |
| Дээд | | | 1.84x | 21.78x |
| Голч дүн | | | 1.47x | 10.72x |
| Дундаж | | | 1.39x | 13.12x |
| **25% Quartile** | | | **1.21x** | **9.62x** |
| **75% Quartile** | | | **1.59x** | **15.85x** |

Жишиг компанийн аргаар тооцсон үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэн "Үнэ/Дансны үнэ" үржүүлэгчийг ашиглан тооцоолсон өмчийн 100%-ийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэн нь 119,500–163,300 сая төгрөг, "Үнэ/ашиг" үржүүлэгчийг ашиглан тооцоолсон өмчийн 100%-ийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэн нь 105,800–180,500 сая төгрөг байгаа нь Үнэлгээний дүгнэлт гаргасан Илүүдэл ашгийн аргын үр дүнг дэмжиж байна.

**Орлогын хандлагын арга**

Банк, санхүүгийн байгууллагын мөнгөн урсгалыг тооцохдоо үнэлгээний практикт ихэвчлэн ногдол ашиг хорогдуулах загвар, илүүдэл өгөөжийн загвар буюу Residual Earnings Method (зарим тохиолдолд Economic Value Added Method гэж нэрлэдэг) ба Өмчийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргыг ашигладаг.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
БҮРТГЭВ-03

Банкны онцлог, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн бүтэц зэргээс шалтгаалан ногдол ашиг хорогдуулах загвар болон Илүүдэл ашгийн загварыг ашиглах нь зохистой гэж үзсэн учир үнэлгээнд Хорогдуулсан мөнгөн урсгалын аргаас Илүүдэл ашгийн загвар, Ногдол ашиг хорогдуулах загварыг авч ашигласан.

Мөнгөн урсгалын төсөөлөл нь Банкны удирдлагаас БДО Аудит ХХК-д ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн. Хорогдуулах хүүг өөдрөг болон гутранги төсөөллийн хүрээнд МХБ-ийн ТОП-20 индексийн түүхэн урт хугацааны өгөөжид суурилсан өмчийн эрсдэлийн нэмэгдэл болон төгрөгийн эрсдэлгүй хүүний шинжилгээнд суурилан гаргасан Капитал Хөрөнгийн Үнэлгээний Загвараар буюу өмчийн өртгөөр тооцсон бөгөөд БДО Аудит ХХК-ийн шинжилгээгээр өмчийн өртөг өөдрөг төсөөллөөр 16 хувь, гутранги төсөөллөөр 17.5 хувь байна.

Орлогын хандлагын үр дүнгээс дүгнэхэд Үнэт цаас гаргагчийн үнэлгээний өдрийн байдлаар явагдаж байгаа одоогийн бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэн нь хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалахаас өмнөх байдлаар хяналт тавих эрх мэдэлтэй хувь оролцооны сууриар 138,826 сая төгрөгөөс 166,605 сая төгрөгийн хооронд, хяналтын эрх мэдэлгүйн хөнгөлөлтийг хассаны дараах байдлаар 105,925 сая төгрөгөөс 127,119 сая төгрөгийн хооронд байна гэж БДО-Аудит ХХК дүгнэсэн байна.

**Үнэлгээний загварын үндсэн орц, төсөөллийн тухай**

Нийт орлого

- Прогнозын хугацааны туршид эдийн засгийн анхдагч орчин таатай уур амьсгалтай байж, банкны зээлийн бүтээгдэхүүний эрэлт тогтвортой хадгалагдана гэж таамагласан. Таамагласан хугацааны туршид банкны нийт орлого дунджаар 39 хувь өсөх гэж таамагласан.
- Хүүгийн орлого нь 2020 онд жилийн дундаж орлого авчрах активын 10.9 хувьтай тэнцүү байсан ба прогнозын хугацааны туршид энэ түвшинд хадгалагдана гэж төсөөлсөн.
- Таамагласан хугацааны туршид олгох зээлийн нийт хөрөнгөд эзлэх хувь дунджаар 59 хувь байна гэж таамагласан.

*График 39 Орлогын төсөөлөл (сая төгрөг)*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

*Эх сурвалж: Бизнесийн төлөвлөгөө*

**Ашигт ажиллагаа**

- Банкны цэвэр ашгийн маржин сүүлийн гурван жилийн хугацаанд дунджаар 17 хувь байсан бол таамаглалын хугацааны дундаж цэвэр ашгийн маржин 17 хувь байна.

*График 40 Ашигт ажиллагаа (зүүн тэнхлэгт - хувь, баруун тэнхлэгт - сая төгрөг)*

*Эх сурвалж: Бизнесийн төлөвлөгөө*

## 7.2. Хөрөнгө оруулалтын өгөөж

Банкны өөрийн хөрөнгийн өгөөж нь 2021 онд 11.5 хувь, 2022 онд 10.8 хувь болох тооцололтой байгаа ба цаашид өссөөр 2027 онд 16.9 хувь байх төсөөлөлтэй байна. Харин

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

нийт хөрөнгийн өгөөж нь 2021 оноос 2027 оны хооронд дунджаар 1.8 хувь болох төлөвтэй байна.

*График 41 Хөрөнгийн эргэц, өгөөж*




Банкны дупонт шинжилгээ болон харьцаа үзүүлэлтийн шинжилгээнээс харахад банкны орлого, цэвэр ашгийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд хөрөнгийн эргэц мөн өссөн үзүүлэлттэй байна.

Богд Банк нь 2023 он хүртэл шинээр 71 салбар нэгжийг нээн 2023 оны байдлаар 381,100 харилцагчтай болох төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд Банкны салбар нэгжийн тоо болон харилцагчдын тоо нэмэгдсэнээр банкны нийт орлого 2027 он хүртэл дунджаар 39 хувиар өсөх төлөвтэй байна.

*Хүснэгт 38 Ашигт ажиллагааны шинжилгээ*

| Ашигт ажиллагаа– DuPont шинжилгээ | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөрөнгийн эргэц (Орлого / Хөрөнгийн дундаж) | 0.10x | 0.11x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x |
| x Ашигт ажиллагаа (Цэвэр ашиг / Орлого) | 11.60% | 21.0% | 24.5% | 17.1% | 5.4% | 14.6% | 14.9% | 15.3% | 16.3% |
| = Хөрөнгийн өгөөж (ROA) | 1.2% | 2.4% | 2.9% | 2.0% | 1.8% | 1.8% | 1.8% | 1.8% | 2.0% |
| x Хөшүүрэг (Хөрөнгийн дундаж / Өмчийн дундаж) | 4.06x | 4.11x | 3.92x | 5.05x | 6.94x | 8.90x | 10.17x | 9.54x | 8.59x |
| = Өмчийн өгөөж (ROE(дундаж)) | 4.8% | 9.7% | 11.5% | 10.1% | 12.6% | 15.6% | 18.3% | 17.6% | 16.8% |
| Хугацааны эхний өмчийн өгөөж (ROE1) | 4.95% | 10.31% | 15.25% | 10.62% | 13.46% | 16.90% | 20.13% | 19.28% | 18.40% |

*Хүснэгт 39 Санхүүгийн үзүүлэлтийн харьцуулсан шинжилгээ*

| | Банкны салбарын дундаж | | | Богд банк | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
| Өмчийн өгөөж (ROE) | 6.2% | 7.2% | 7.5% | 11.5% | 10.1% | 12.6% | 15.6% | 18.3% | 17.6% | 16.9% |
| Хөрөнгийн өгөөж (ROA) | 0.7% | 0.9% | 1.0% | 2.93% | 2.0% | 1.8% | 1.8% | 1.8% | 1.8% | 2.0% |
| Цэвэр ашгийн маржин | 3.5% | 7.6% | 9.1% | 24.5% | 17.1% | 15.4% | 14.6% | 14.9% | 15.3% | 16.3% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөрөнгийн эргэц | 10.3x | 10.8x | 10.0x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x |
| Хөшүүрэг | 13x | 11.8x | 15.2x | 3.9x | 5.1x | 6.9x | 8.9x | 10.2x | 9.5x | 8.6x |

Дупонт шинжилгээ нь эздийн өмчийн өгөөжийг (ROE) гурван хүчин зүйлээр задалж, уг санхүүгийн үзүүлэлт тус бүрээр ашигт ажиллагааны сул тал болон давуу талуудыг харуулдаг санхүүгийн хэрэглэгдэхүүн юм. ROE нь цэвэр ашгийг өмчид харьцуулж тооцдог санхүүгийн үр ашгийн үзүүлэлт бөгөөд хамгийн энгийнээр эздийн өмчийн өгөөжийн урт хугацааны дундаж үзүүлэлт нь 14% буюу түүнээс дээш байх нь өгөөж өндөр байгааг илтгэх бөгөөд 10 хувиас бага байх нь хангалтгүй үзүүлэлт юм. Богд банкны хувьд ирэх 7 жилд дунджаар 14.6%-н эздийн өмчийн өгөөжтэй байх тооцоотой байгаа ба энэ нь салбарын дунджаас харьцангуй өндөр байгаа нь компанийн ашигт ажиллгааны түвшинг илтгэж байна.

Эздийн өмчийн өгөөж= Цэвэр ашгийн маржин* Нийт хөрөнгийн эргэц* Санхүүгийн хөшүүрэг

Нийт хөрөнгийн эргэцээр хэмжигддэг хөрөнгийн үр ашигт хэрэглээ нь тухайн жилийн орлогыг дундаж ашигт харьцуулсан үзүүлэлт ба уг үзүүлэлт нь бизнесийн салбараас хамаарч ялгаатай байдаг байна. Богд Банкны ирээдүйн 7 жилийн тооцооллын хувьд нийт хөрөнгийн эргэц нь дунджаар 0.12x байх тооцоотой байгаа нь мөн салбарын дунджаас өндөр буюу хөрөнгийн үр ашигт хэрэглээтэй байгааг харуулж байна.

Санхүүгийн хөшүүрэг буюу өмчийн үржүүлэгч нь компани нийт хөрөнгөө санхүүжүүлэх зорилгоор хэр хэмжээний эх үүсвэр татсаныг шууд бус аргаар хэмжих үзүүлэлт юм. Уг үзүүлэлтийг нийт хөрөнгийг нийт өмчид харьцуулж олдог ба хөшүүрэг бага байх нь компанийг өрсөлдөгчидтэй нь харьцуулахад сул талтай болгодог бол хэт их хөшүүрэгтэй байх нь компанийн санхүүгийн эрсдэлийг нэмэгдүүлдэг. Богд банкны хувьд хөшүүргийн хэмжээ салбарын дунджаас доогуур байгаа нь нэгдүгээрт санхүүгийн эрсдэл бага байгааг илтгэх ба цаашлаад хөшүүргийг нэмэгдүүлэх замаар үйл ажиллгаагаа тэлэх боломж бийг харуулж байна.

Ирээдүйд Банкны цэвэр ашиг өсөх нь хөрөнгө оруулагчдад ногдол ашиг тараах нөхцөлийг бүрдүүлж байгаа ба энэхүү шийдвэрийг үнэт цаас гаргагчийн ТУЗ тогтооно.

Ийнхүү хөрөнгө оруулагч нар Компанийн орлого ашгийн өсөлтөөс үүдэлтэй ханшийн зөрүүнээс болон ногдол ашгийн орлогоор ирээдүйд өгөөж авах боломжтой байна.

# НАЙМ. ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ АРГАЧЛАЛ

## 8.1. Хувьцааг анхдагч зах зээлд арилжаалах аргачлал

Үнэт цаас гаргагч нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг МХБ-тэй Анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах гэрээ байгуулан явуулах ба үнэт цаасыг МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 4 дүгээр бүлэгт заасан "ТОГТООСОН ҮНИЙН АРГА"-ыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Тогтоосон үнийн аргаар хийх арилжаа нь МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.1.3 хэсэгт зааснаар үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнээр санал болгон арилжих үйл ажиллагааг хэлэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнийг дараах байдлаар тогтоосон байна.

*Хүснэгт 40 Хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнэ*

| Хөрөнгө оруулагчид | Нэмж гаргах хувьцаанаас санал болгох | Санал болгох хувьцааны тоо | Санал болгох үнэ (төгрөг) | Татан төвлөрүүлэх хөрөнгө |
|---|---|---|---|---|
| **Стратегийн** | 70% | 8,750,000 | ₮2,540 | 22,225,000,000 |
| **Олон нийт** | 30% | 3,750,000 | ₮2,540 | 9,525,000,000 |
| **Нийт** | **100%** | **12,500,000** | | **31,750,000,000** |

**Стратегийн хөрөнгө оруулагч**

Стратегийн хөрөнгө оруулагч гэдэг нь Биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.4 дэх хэсэгт тодорхойлсон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, анхдагч зах зээлийн арилжаанд нийт худалдан авалт нь 500 сая төгрөгнөөс доошгүй дүнтэй байх бөгөөд үнэт цаасаа 6-аас доошгүй сарын хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагчийг ойлгоно. Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээнээс нийт захиалгын хэмжээ давсан тохиолдолд стратегийн хөрөнгө оруулагч бүрийн захиалгыг хувь тэнцүүлэх аргачлалд оруулалгүйгээр шууд биелүүлэн тооцно.

Хэрэв стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга нь санал болгож буй нэмж гаргах хувьцааны 70 хувиас хэтэрвэл стратегийн хөрөнгө оруулагчдын хувьцааны захиалгыг цаг хугацааны дарааллаар биелүүлж, 70 хувиас хэтэрсэн захиалгыг олон нийтэд санал болгож буй 30 хувийн хувьцаанаас хуваарилалт хийнэ.

Стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд тогтоосон үнийн аргаар санал болгох хувьцааны үнэ нь 2,540 төгрөг байна. Тогтоосон үнэ (өгөөж)-өөр санал болгох арилжаа – Үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнээр санал болгон арилжих үйл ажиллагаа бөгөөд МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны 3.1.3 хэсэгт заасан байдаг.

Харилцагч худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнээр өгөх бөгөөд энэ аргыг ашиглах үед үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй. Нийт харилцагчдад тэнцүү хуваарилах хөрөнгийн суурь хэмжээг тогтоож болно. Нийт худалдан авах захиалгын тоо ширхэг нийт санал болгосон үнэт цаасны тоо ширхгээс илүү гарсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглан үнэт цаасны хуваарилалтыг хийнэ. Хувь тэнцүүлэх коэффициентийг олохдоо:

K=C1/C2
K – Хувь тэнцүүлэх коэффициент
C1 – Арилжихаар санал болгож буй нийт үнэт цаасны тоо
C2 – Худалдан авах захиалгад багтсан нийт үнэт цаасны тоо

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 ... 5903858

Худалдан авах захиалга тус бүрийг хувь тэнцүүлэх коэффициентээр үржүүлж, харилцагч бүрт оногдох үнэт цаасны тоог гаргана. Хувь тэнцүүлэх коэффициентоор үржүүлж гарсан тооны бутархай орон нь 0.5-аас дээш бол 1 бүхэл нэгжид, 0.5-аас доош бол 0 нэгжид шилжүүлэн тооцно. Бутархай оронг бүхэл тоонд шилжүүлсний дараа хуваарилалт хийгдсэн нийт хувьцааны тоо арилжихаар санал болгож буй үнэт цаасны тооноос илүү гарсан тохиолдолд хамгийн олон ширхэг хувьцаа авах захиалга өгсөн харилцагчдын үнэт цаасны тооноос тус бүр нэг ширхгийг хасах зарчмаар арилжихаар санал болгож буй тоотой тэнцүүлнэ. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн нөхцлийн дагуу нэг харилцагчийн үнэт цаас худалдан авах захиалгын мөнгөн дүнгийн дээд хэмжээг заасан хязгаарлалтыг тогтоож болно.

## 8.2. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь

Үнэт цаас гаргагч нь дараах хуваарийн дагуу үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна.

*Зураг 2 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь*

### 8.2.1. СЗХ, Биржээс үнэт цаасыг бүртгэх шийдвэр

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг Бирж болон СЗХ-нд нэгэн зэрэг гаргах бөгөөд уг арилжаа эрхлэх зохицуулагч байгууллагуудад үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл авснаар олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно. Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх хүсэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд гаргах бөгөөд тус зөвшөөрөл олгогдсоноор анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авахад бэлэн болно. Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дуссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. Хороо нь тайланг хүлээн авч арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвд өмчлөх эрхийн бүртгэл хийх болон хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох албан бичгийг ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.

### 8.2.2. Олон нийтэд танилцуулах

Үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргах Бирж болон СЗХ-ны зөвшөөрөл гарсны дараа олон нийтэд санал болгох тухай мэдээлэх, танилцуулах үйл ажиллагааг эхлүүлнэ.

### 8.2.3. Анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл

Захиалгын бүртгэлийн эхлэх болон дуусах хугацааг Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь СЗХ-ны шийдвэр гарсны дараа Биржтэй хамтран тогтооно. Андеррайтер нь УЦК-иудад арилжааны талаар зааварчилга, мэдээлэл өгөх ба УЦК-иуд захиалгыг биржийн программд шивж оруулна. Захиалга бүртгэлийн хугацаанд стратегийн хөрөнгө оруулагчдаас болон олон нийтээс захиалга авах сан нь тусдаа байна.

### 8.2.4. Захиалга биелүүлэх

Анхдагч зах зээлийн захиалга хаагдсанаар хувьцаа худалдан авах захиалгын дүнг нэгтгэн андеррайтераас ирүүлсэн хүсэлт болон үнэт цаасны танилцуулгад тусгасан хуваарилалтын зарчмын дагуу Бирж гүйцэтгэнэ.

### 8.2.5. Төлбөр тооцоо

Арилжааны журмын дагуу арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Хөрөнгө оруулагч нь Биржид бүртгэлтэй үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэж, өөрийн үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу хувьцаа худалдан авах мөнгөн хөрөнгө байршуулах ба өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалга өгнө.

### 8.2.6. Хувьцаа худалдан авах захиалга өгөх заавар

1. Үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээх
2. Өөрийн хүссэн банкаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх өөрийн нэр дээрх дансандаа хувьцаа худалдан авах мөнгөө байршуулна

| | |
|---|---|
| Хүлээн авагчийн банк: | Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв |
| Хүлээн авагчийн нэр: | Овог, нэр |
| Дансны дугаар: | 12 орон бүхий үнэт цаасны дансны дугаар (УЦК-иас лавлах) |
| Үнийн дүн: | Хувьцааны үнэ+шимтгэл |
| Гүйлгээний утга: | Хувьцааны мөнгө (Овог, нэр, регистрийн дугаар) |

3. Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хувьцаа худалдан авах захиалга өгнө
4. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдсанаар хөрөнгө оруулагчийн нэр дээр хувьцаа шилжинэ

## 8.3. Үнэт цаасны хоёрдогч арилжааны төлөвлөгөө

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар "хоёрдогч зах зээл" гэж үнэт цаасны анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасыг дахин арилжихтай холбогдсон харилцааг хэлдэг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд арилжсан тухай тайланг ажлын гурван өдөрт багтаан хянах ба зөрчил гараагүй, үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон гэж үзсэн тохиолдолд үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгоно.

ҮЦТХТ болон Бирж нь уг зөвшөөрлийг хүлээн авснаар үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

## 8.4. Хувьцаатай холбоотой шимтгэл ба орлогын албан татвар

**Хувьцааны арилжааны шимтгэл**

Хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанитай хийсэн гэрээнд заасны дагуу хувьцааны арилжааны шимтгэл төлөх үүрэгтэй. Үнэт цаас борлуулсан орлогын албан татварыг арилжаанд оролцсон хувь хүн, хуулийн этгээд жилийн эцэст нэг удаа доор дурдсаны дагуу төлөхөөр зохицуулагдсан байна. Үүнд:

**Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар**

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасан "хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого" болон 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан "ногдол ашгийн орлого"-д тус хуулийн 17-р зүйлд зааснаар 10 хувийн татвар ногдуулна гэж заасан байна.

**Хувь хүний орлогын албан татвар**

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан "ногдол ашгийн орлого", 10 дугаар зүйлийн 10.1.4-т заасан "Хувьцаа, үнэт цаас борлуулсан орлого"-д тус хуулийн 21.2.4-т зааснаар 10 хувийн татвар ногдуулна гэж заасан байна.

СЭХ
2021.11.10
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

# ЕС. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

## 9.1. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь 2014 оноос хойш банкны салбарын хамгийн отгон нь болж, богино хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж Монголын зах зээлд өөрсдийн гэсэн байр суурыа эзлэн, орчин үеийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, олон нийтэд танигдсан шинэ зууны банк болохоор зорин ажиллаж байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Богд Банк нь Монгол Улс даяар нийт 11 салбар нэгжтэй, 172 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

### 9.1.1. Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга

*Хүснэгт 41 Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга*

| Агуулга |
|---|
| **Байгуулагдсан огноо**<br>2014 |
| **Үйл ажиллагааны чиглэл**<br>- Зээлийн үйл ажиллагаа;<br>- Төлбөр тооцооны үйлчилгээ;<br>- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;<br>- Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах үйл ажиллагаа;<br>- Мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа;<br>- Гадаад төлбөр тооцоо хийх;<br>- Зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах;<br>- Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;<br>- Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа;<br>- Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа;<br>**Бизнесийн зарчим**<br>- Шилдэг удирдлага, авьяас чадвар<br>- Санхүүгийн салбарын гүнзгий туршлага<br>- Санхүүгийн салбарын урт хугацааны гүйцэтгэл<br>- Бүс нутгийн онцлог шинж чанартай франчайзинг |
| **Салбар нэгжийн тоо**<br>11 |
| **Ажилтны тоо**<br>172 |
| **Гүйцэтгэх захирал**<br>Ганбаатар овогтой Саруул |
| **Хувьцаа эзэмшигчид**<br>Бодь капитал ХХК - 91.32%<br>Богд Капитал Инвестмент ХХК - 8.68% |

### 9.1.2. Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал

Үнэт цаас гаргагч нь 2014 онд үүсгэн байгуулагдсанаас хойш дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ЭМ АЙ СИ СИ УЦК ХХК

СЗХ
2021 11 10
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Зураг 3 Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал*




### 9.1.3. Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл

Дэлхийн нийт улс орны зээлжих чадвар болон томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудад санхүүгийн зэрэглэл тогтоогч Мүүдис Олон Улсын үнэлгээний агентлаг нь 2021 оны 3 сарын 22-ны өдөр Богд Банкны суурь үнэлгээг B3, харилцагчийн эрсдэлийн зэрэглэл B2/NP болон Хэтийн төлөв байдлыг "тогтвортой" гэж үзсэн. Дээрх үнэлгээ нь дотоодын томоохон банкуудын үнэлгээтэй эн зэрэгцэхүйц үнэлгээ бөгөөд Монгол Улсын Засгийн Газрын зээлжих зэрэглэлтэй ижил түвшний үнэлгээ юм. Богд Банкны зээлжих зэрэглэл нь санхүүгийн болон зохистой харьцааны үзүүлэлтүүд эерэг, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар өндөр түвшинд тогтвортой, гадаад зах зээлээс валютын эх үүсвэр татан төвлөрүүлэх байнгын чадавх тогтвортой хадгалагдаж байгаатай холбоотой байна.

*Хүснэгт 42 Богд Банкны зээлжих зэрэглэл*

| Төлөв байдал | Тогтвортой |
|---|---|
| Татан төвлөрүүлсэн хөрөнгө - Дотоодын валютаар | B2/NP |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгө - Гадаадын валютаар | B3/NP |
| Банкны хадгаламж | B3 |
| Банкны хадгаламж | B3/NP |
| Зээлийн суурь үнэлгээ | B3 |
| Тохируулгын дараах зээлийн суурь үнэлгээ | B3 |
| Харилцагчийн эрсдэлийн үнэлгээ | B2(cr)/NP(cr) |

*Эх сурвалж: Moody's Investors Service*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТД 8766 5903858

СЗХ 2021.11.10 БҮРТГЭВ-03
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-11-03 БҮРТГЭВ-03

### 9.1.4. Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээ

1924 онд Монгол Улсад банкны систем анхлан үүсгэн байгуулагдсанаас хойш 70 жилийн хугацаанд улсын банкны системээр явж ирсэн ба нэг банкны институцтэй, түүгээрээ дамжуулан арилжааны төлбөр тооцоо, зээл, мөнгөний бодлого хэрэгжүүлдэг байв. 1991 онд Банкны тухай хууль батлагдаж, хоёр шатлалт банкны системтэй болсноор төв банк болон арилжааны банк бий болж, хувийн банкуудын үйл ажиллагааны зах зээл шинээр бүрэлдэн бий болсон.

Арилжааны банк нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээд юм. Монгол улсад 2021 оны байдлаар 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэсэн өдрийн байдлаар Богд Банк нь МБ болон СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэйгөөр мөнгөн хөрөнгийн хадгаламж, зээлийн үйлчилгээ, гадаад болон дотоод төлбөр тооцоо, гадаад валют арилжаа, цахим банкны үйлчилгээ (интернет банк, мобайл банк), даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг иргэд болон байгууллагын харилцагчдадаа санал болгон үзүүлж байна.

**Иргэдийн банк**

*График 42 Богд Банкны иргэдийн банкны дансны мэдээлэл*

Иргэдийн банк нь банк санхүүгийн салбар цахим банк руу шилжиж буй энэ цаг үетэй хөл нийлүүлэхийн тулд цахим борлуулалтын сувгуудыг хөгжүүлж, харилцагчдад тусгайлан зориулж бий болгох дижитал банкны үйлчилгээг үзүүлэх суурийг тавих зорилго бүхий багийг бүрдүүлэн ажиллаж байна. 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Богд Банкны иргэдийн банк нь нийт 23,933 харилцагчтай байна.

Богд Банк нь иргэдэд дараах төрлийн үйлчилгээнүүдийг үзүүлж байна:

- Харилцах/ Хадгаламж
- Зээл

БОГД БАНК BOGD BANK УЛААНБААТАР ХОТ ТТБ8966 - 5903858

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

- Гадаад төлбөр тооцоо
- B-point, багцын үйлчилгээ
- Даатгалын зуучлалын үйлчилгээ

## B-point харилцагчдад зориулсан банкны салбарын анхны лояалти үйлчилгээ

*Зураг 4 Богд Банкны лояалти үйлчилгээ*

Банк нь Монгол дахь банкны салбарын анхдагч урамшууллын үйлчилгээ буюу B-point-ийг үйлчилгээндээ нэвтрүүлсэн бөгөөд тус онооны систем нь Богд Банкнаас гаргаж буй харилцагчаа урамшуулах, урт хугацааны түншлэлийг бий болгох зорилго бүхий банкны лояалти үйлчилгээ юм. Харилцагч нь банкны бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглаж оноо цуглуулан, цуглуулсан оноогоороо банкны үйлчилгээг шууд болон хөнгөлөлттэйгөөр авах боломжтой. Мөн энэхүү урамшууллын оноогоороо Банкны өөрийн болон түүний хамтран ажиллагч байгууллагад хөнгөлөлттэй нөхцөлөөр тодорхой үйлчилгээ авах боломжтой.

## Багцын үйлчилгээ

*Зураг 5 Богд Банкны багцын үйлчилгээ*

Багцын үйлчилгээг сонгосон харилцагч нь өөрийн амьдралын хэв маяг, хэрэглээнд тааруулан өдөр тутмын банкны гүйлгээ, төлбөр тооцооны үйлчилгээг илүү таатай уян хатан нөхцөлөөр авах боломжтойгоос гадна Банк болон хамтран ажиллагч байгууллагуудаас хөнгөлөлттэй үнээр бараа бүтээгдэхүүн үйлчилгээ авах боломжтой юм. Package буюу багцын эрхийг авснаар харилцагч сар бүр суурь хураамж төлж карт үнэгүй захиалах, тодорхой тооны шилжүүлэг болон зарлагын гүйлгээний шимтгэлээс чөлөөлөгдөн, мөн бусад дурдсан үйлчилгээг үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр авах боломжтой болох юм. Өдөр тутмынхаа хэрэглээнд нийцүүлэн Мастер (Master) and Прайм (Prime) багцаас сонголтоо хийж багцын хэрэглэгч болсноор Банкнаас суутгадаг картын үйлчилгээний жилийн хураамж төлөхгүй бөгөөд бүх банкны ATM, банк хоорондын онлайн болон бусад гүйлгээ гэх мэт үйлчилгээнүүд нь шимтгэлгүй болох юм.

## Даатгалын зуучлалын үйлчилгээ

Богд Банк нь бүх төрлийн хэрэгцээг нэг цэгээс хангах зорилгоор, эрсдэлийн удирдлагын оновчтой шийдэл болох даатгалын зуучлалын үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Үнэт цаас гаргагч нь аливаа нэг даатгалын компаниас хамааралгүй ба хамтран ажиллах даатгалын компаниудаа сонгохдоо, нийт даатгалын салбарт судалгаа хийсний үндсэн дээр, тэдгээрийн санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл, санхүүгийн чадавх,

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

үйлчилгээний чанарыг харгалзан үздэг тул даатгуулагчдын ажлыг хөнгөвчилж, найдваргүй даатгагчаар даатгуулах эрсдэлийг бууруулдаг. Даатгалын үйлчилгээг банкаар дамжуулан авснаар нэмэлт шимтгэл, хураамж төлдөггүйгээс гадна, даатгалын компанийн нийтэд санал болгосон нөхцөлөөс илүү хямд хураамжаар даатгуулах боломжтой юм.

**Байгууллагын банк**

2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Богд Банкны байгууллагын банк нь нийт 691 аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлж байна.

*График 43 Богд Банкны байгууллагын банкны дансны мэдээлэл*

Богд Банк нь байгууллагуудад дараах төрлийн үйлчилгээнүүдийг үзүүлж байна:

- Харилцах
- Хадгаламж
- Зээл
- Дотоод баталгаа
- Байгууллагын төлбөрийн карт
- Гадаад төлбөр тооцоо

**Дотоод баталгаа**

Бизнесийн харилцаанд орох явцад ажил, үүрэг гүйцэтгэгч тал тодорхой гэрээний нөхцөлүүдийг биелүүлэх үүрэгтэй байдаг ба үүргээ биелүүлж чадаагүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч тал гүйцэтгэгч талаас төлбөр, алданги нэхэмжлэх эрхтэй байдаг бөгөөд банк гүйцэтгэгчийн өмнөөс баталгаа гаргаснаар гэрээнд тусгагдсан нөхцөлийн дагуу гүйцэтгүүлэгчид төлбөр төлөх үүрэг хүлээдэг. Тус үйлчилгээ нь байгууллагад аливаа зарлагдсан тендерт оролцож, ажил гүйцэтгэх, бэлтгэн нийлүүлэх боломжийг нээж, бизнесийн цар хүрээ өргөжин тэлэхэд чухал ач холбогдолтой юм.

**Аккредитивийн үйлчилгээ**

Банк нь худалдагч, худалдан авагчийн хоорондох ашиг сонирхлын зөрчлийг зохицуулж, төлбөр төлөхгүй болон бараа нийлүүлэхгүй байх эрсдэлийг бууруулах зорилготой аккредитивийн үйлчилгээг үзүүлдэг.

**Байгууллагын төлбөрийн карт**

БОГД БАНК ХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 - 5903858

СЗХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Банк нь байгууллагуудад цалингийн карт болон бизнес картын үйлчилгээг үзүүлдэг. Бизнесийн картын үйлчилгээ нь байгууллагын төлбөр тооцоог хөнгөвчлөх, санхүүгийн хэрэгцээг хянахад зориулагдсан үйлчилгээ бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд байгууллагын ажилтнууд давуу тал бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг авах болон асуудлыг түргэн, шуурхай, шийдвэрлүүлэх боломжтой юм.

**ПОС-ийн үйлчилгээ**

Богд Банк нь карт уншигч ПОС төхөөрөмжийг бизнесийн үйл ажиллагаанд зориулан санал болгодог ба тус төхөөрөмж нь Visa, UnionPay, төгрөгийн гэх зэрэг олон улсын болон дотоодын бүх картуудыг хүлээн авах боломжтой.

**Үнэт цаас гаргагчийн харилцах, хадгаламжийн үйлчилгээ**

**Богд Банкны иргэдийн харилцах, хадгаламж**

Богд Банкны иргэдийн банкны дансны тоог үйлчилгээний төрлөөр дараах хүснэгтээс харна уу.

*Хүснэгт 43 Богд Банкны иргэдийн харилцах, хадгаламжийн дансны тоо бүтээгдэхүүний төрлөөр*

| Иргэдийн харилцах, хадгаламжийн тоо | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|
| Харилцах | 6,966 | 11,014 | 23,324 |
| Хадгаламж | 19 | 653 | 1,871 |

Богд Банк нь иргэдэд дараах төрлийн харилцах, хадгаламжийн үйлчилгээнүүдийг үзүүлж байна:

*Хүснэгт 44 Богд Банкны иргэдийн банкны харилцах, хадгаламжийн үйлчилгээний төрлүүд*

| Харилцах | Хадгаламж |
|---|---|
| - Энгийн харилцах<br>- ЭСКРОУ данс<br>- Хүүхдийн нэрийн данс | - Хугацаатай хадгаламж<br>- Хугацаагүй хадгаламж<br>- Хүүхдийн хадгаламж<br>- Урьдчилсан хүүт хугацаатай хадгаламж<br>- Онлайн хадгаламж |

Үнэт цаас бэлтгэх үеийн байдлаар Банкны иргэдэд үзүүлж буй харилцах, хугацаагүй хадгаламжийн үйлчилгээ нь хүүгүй ба хугацаатай хадгаламжийн хувьд хугацаа болон нөхцөлөөс хамааран төгрөгийн жилийн хүү 5.20%-10.70%, валютын жилийн хүү 1.60%-3.30% байна.

Богд Банкны иргэдийн харилцах, хадгаламж 2020 онд өмнөх онтой харьцуулахад 76 хувиар буюу 19.5 тэрбум төгрөгөөр өсч 45.1 тэрбум төгрөг болсон байна. Өсөлт нь 2020 онд харилцагчдын тоо 2 дахин өссөнтэй холбоотой ба үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар иргэдийн банкны эх үүсвэр, харилцах, хадгаламжийн үйлчилгээ дараах бүтэцтэй байна:

*Хүснэгт 45 Богд Банкны иргэдийн харилцах, хадгаламжийн мэдээлэл СТОУС-ын дагуу*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТЕЛ: 66 - 5903858

СЭХ
2021 -11- 03
БҮРТГЭВ-03
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

| Иргэдийн харилцах, хадгаламж (сая төгрөг) | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|
| Хугацаат хадгаламж | 173 | 20,878 | 39,259 |
| Харилцах данс | 14,458 | 5,455 | 3,663 |
| Хугацаагүй хадгаламж | 4 | 260 | 2,130 |
| **Нийт** | **14,635** | **25,593** | **45,052** |

## Богд Банкны байгууллагуудын харилцах, хадгаламж

Байгууллагын банкны дансны тоог үйлчилгээний төрлөөр дараах хүснэгтээс харна уу.

*Хүснэгт 46 Богд Банкны байгууллагын харилцах, хадгаламжийн дансны тоо бүтээгдэхүүний төрлөөр*

| Байгууллагын харилцах, хадгаламжийн тоо | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|
| Харилцах | 424 | 594 | 934 |
| Хадгаламж | - | 5 | 21 |
| Банк, СБ-аас татсан харилцах, хадгаламж | 69 | 100 | 134 |

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Богд Банк нь байгууллагуудад дараах харилцах, хадгаламжийн үйлчилгээг үзүүлж байна:

*Хүснэгт 47 Богд Банкны байгууллагуудад үзүүлж буй хадгаламж, харилцах үйлчилгээний төрлүүд*

| Харилцах | Хадгаламж |
|---|---|
| - Энгийн харилцах<br>- Шаталсан хүүт харилцах данс<br>- Хүүхдийн нэрийн данс | - Хугацаатай хадгаламж<br>- Хугацаагүй хадгаламж |

Үнэт цаас бэлтгэх үеийн байдлаар Банкны байгууллагын харилцах, хугацаагүй хадгаламжийн үйлчилгээ нь хүүгүй ба хугацаатай хадгаламжийн хувьд хугацаа болон нөхцөлөөс хамааран төгрөгийн жилийн хүү 5.20%-10.60%, валютын жилийн хүү 1.40%-3.30% байна.

Богд Банкны байгууллагын харилцах, хадгаламж 2020 онд өмнөх оноос 18.4 хувиар буюу 12.53 тэрбум төгрөгөөр буурч 55.62 тэрбум төгрөг болсон байна. Бууралт нь КОВИД-19 цар тахлын аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлсэн сөрөг нөлөөтэй холбоотой байна.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар байгууллагын банкны эх үүсвэр, харилцах, хадгаламжийн үйлчилгээ дараах бүтэцтэй байна:

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
ЭК АЙ СИ СИ ҮЦК ХХК

СЗХ 2021.11.10 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-11-03 БҮРТГЭВ-03

*Хүснэгт 48 Богд Банкны байгууллагын харилцах, хадгаламжийн мэдээлэл СТОУС-ын дагуу*

| Байгууллагын харилцах, хадгаламж (сая төгрөг) | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|
| Хугацаат хадгаламж | 6,550 | 7,630 | 13,964 |
| Харилцах данс | 18,024 | 59,907 | 16,051 |
| Баталгааны эх үүсвэр | 1,784 | 611 | 4,252 |
| Хугацаагүй хадгаламж | - | - | 21,355 |
| **Нийт** | **26,358** | **68,148** | **55,622** |

**Үнэт цаас гаргагчийн зээлийн үйлчилгээ**

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 11 сарын 6-ны өдрийн А-175 тоот тушаалаар Богд Банканд Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан "Зээл, төлбөр тооцооны үйлчилгээ, гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгосон.

**Үнэт цаас гаргагчийн Бизнесийн банкны газрын үйл ажиллагаа**

Үнэт цаас гаргагчийн Бизнесийн банкны газар нь зээлийн үйл ажиллагааг хариуцаж ажилладаг. Чадварлаг, мэргэшсэн харилцааны менежерүүд Богд Банкны харилцагчдад зээлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажилладаг. Зээлийн үйлчилгээг Улаанбаатар хотын 11 салбар нэгжээр дамжуулан Банкны 29,000 гаруй иргэд болон байгууллагуудад хүргэн ажиллаж байна.

Зээлийн бүтээгдэхүүн нь зах зээлээс хамааарч иргэдийн зээл болон байгууллагын зээл гэж ангилдаг. Иргэдийн зээл нь иргэд, хувь хүмүүсийн санхүүгийн хэрэгцээг хангах, дэмжих зорилгоор олгох зээл юм. Байгууллагын зээл нь бизнес эрхлэгч, аж ахуй нэгж байгууллагын бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тэдний бизнесийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөтгөх, техник технологи болон тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх үйл ажиллагааны ашиг орлого, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор үндсэн хөрөнгө бэлтгэх, өргөтгөх, хөрөнгө оруулалт хийх, тоног төхөөрөмж шинэчлэх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан олгогдох зээл юм.

Байгууллагуудад зориулж бизнесийн зээл болон хөрөнгө оруулалтын зээлийг олгон ажилладаг бол иргэдэд зориулж цалингийн зээл, хэрэглээний зээл, орон сууцны зээл, шуурхай зээл болон кредит картын зээлийн үйлчилгээг үзүүлдэг.

*Хүснэгт 49 Богд Банкны зээлийн үйлчилгээний төрлүүд*

| Иргэд | Байгууллага |
|---|---|
| - Хэрэглээний зээл<br>- Орон сууцны зээл<br>- Бизнесийн зээл<br>- Төслийн зээл | - Эргэлтийн хөрөнгийн зээл<br>- Хөрөнгө оруулалтын зээл<br>- Зээлийн шугам<br>- Худалдааны зээл<br>- ПОС-н орлого барьцаалсан зээл<br>- РЕПО санхүүжилтийн төслийн зээл |

Богд Банкны байгууллагын зээлийн үйлчилгээний хүү хугацаа болон нөхцөлөөс хамааран төгрөгийн зээлийн жилийн хүү 10.50%-26.40%, валютын зээлийн жилийн хүү 12.10%-

БОГД БАНК ХХК БОГД БАНК BOGD BANK УЛААНБААТАР ХОТ ТТБ8966 УЛААНБААТАР

24.00% бөгөөд иргэдэд үзүүлж буй зээлийн үйлчилгээний хүү хугацаа болон нөхцөлөөс хамааран төгрөгийн зээлийн жилийн хүү 20.40%-28.80%, валютын зээлийн жилийн хүү 13.20%-22.80% байна.

Банкны зээлийн дансны тоог сегментээр дараах хүснэгтээс харна уу.

*Хүснэгт 50 Богд Банкны зээлийн дансны тоо сегментээр*

| Зээлийн дансны тоо | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|
| **Иргэд** | 286 | 1,708 | 2,094 |
| **Байгууллага** | 26 | 55 | 72 |

Богд Банкны сүүлийн 3 жилийн зээлийн багцыг үйл ажиллагааны сегментээр хураангуйлан доорх хүснэгтээс харна уу.

*Хүснэгт 51 Богд Банкны зээлийн багц үйл ажиллагааны сегментээр*

| Зээлийн багц үйл ажиллагааны сегментээр | 2019.01.01* | | 2019.12.31 | | 2020.12.31 | |
|---|---|---|---|---|---|---|
| | сая төг | % | сая төг | % | сая төг | % |
| Бизнесийн зээл | 48,147 | 88.5% | 69,445 | 81.8% | 75,019 | 72.6% |
| Орон сууцны зээл | 897 | 1.7% | 2,685 | 3.2% | 7,498 | 7.3% |
| Хэрэглээний зээл | 5,335 | 9.8% | 7,587 | 8.9% | 14,570 | 14.1% |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх* | - | 0.0% | 5,197 | 6.1% | 6,288 | 6.1% |
| **Нийт** | **54,380** | **100.0%** | **84,915** | **100.0%** | **103,375** | **100.0%** |

**Богд Банк нь 2019 оноос эхлэн Засгийн газраас хэрэгжүүлж буй орон сууцны хөнгөлөлттэй зээлийг иргэдэд олгож эхэлсэн. 2019 оны 1 сарын 1-нээс СТОУС 9-ийг нягтлан бодох бүртгэлдээ нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор МИК-д шилжүүлэх харилцагчдад олгосон орон сууцны ипотекийн зээлийн багцыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгөд ангилсан.*

Богд Банкны нийт зээлийн багц өнгөрсөн оноос 22 хувь буюу 18.5 тэрбум төгрөгөөр өсч 103.4 тэрбум төгрөгт хүрсэн. 2019 онд нийт активын 34 хувийг зээлийн багц эзэлж байсан бол 2020 онд нийт активын 46 хувь болж өссөн байна. 2019 онд нийт зээлийн багцын 2.4 хувийг чанаргүй зээлийн багц, 2020 онд нийт зээлийн багцын 5 хувийг чанаргүй зээлийн багц тус тус эзэлж байгаа нь салбарын дундаж үзүүлэлт болох 10.7 хувиас харьцангуй бага байгааг харуулж байна. [13]

2020 оны 12 сарын 31-ний Банкны харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны барьцааг дараах байдлаар харуулав:

*Хүснэгт 52 Богд Банкны зээлийн барьцаа хөрөнгийн мэдээлэл*

| Зээлийн барьцаа хөрөнгө ба сайжруулалт (сая төгрөг) | Дансны үнэ | Барьцааны дүн | Эрсдэлд өртөх дүн |
|---|---|---|---|
| Бизнесийн зээл | 75,019 | 140,722 | (65,702) |
| Хэрэглээний зээл | 14,570 | 24,991 | (10,421) |
| Орон сууцны зээл | 13,786 | 22,134 | (8,348) |
| **Нийт** | **103,375** | **187,847** | **(84,472)** |

[13] *Эх сурвалж: МБ-ны Арилжааны банкуудын тайлан тэнцэл*

СЗХ
2021 -11- 03
БҮРТГЭВ-03
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANG
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

## Бизнесийн зээл

Бизнесийн зээлийг хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх, эх үүсвэр барьцаалсан зээл болон шугамын зээлүүдийг байгууллагын харилцагчдад төгрөг болон доллараар олгодог. Банкны бизнесийн зээлийн багц 2019 онд 44 хувь буюу 21.3 тэрбум төгрөг, 2020 онд 8 хувь буюу 5.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Богд Банк нь зээлийн бодлогын дагуу барьцаа хөрөнгө байршуулдаг ба 2020 оны байдлаар бизнесийн зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ 140.7 тэрбум төгрөг бөгөөд барьцаа хөрөнгийн хүрэлцээ 188 хувь байна.

## Хэрэглээний зээл

Хэрэглээний зээл нь цалингийн зээл, автомашины зээл, кредит картын зээл, хадгаламж барьцаалсан зээл, шуурхай зээлээс бүрддэг. Банкны хэрэглээний зээлийн багц 2019 онд 42 хувь буюу 2.3 тэрбум төгрөг, 2020 онд 92 хувь буюу 7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Цалингийн зээл болон кредит картын зээлээс бусад зээлүүдэд барьцаа хөрөнгө байршуулдаг ба 2020 оны байдлаар хэрэглээний зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ 25 тэрбум төгрөг бөгөөд барьцаа хөрөнгийн хүрэлцээ 172 хувь байна.

## Орон сууцны зээл

Орон сууцны зээл нь банкны өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэн олгосон орон сууцны зээл, хувийн сууц, хашаа байшин барих болон худалдан авах зээлээс бүрддэг. Орон сууцны зээлийн багц 2019 онд 199 хувь буюу 1.8 тэрбум төгрөг, 2020 онд 179 хувь буюу 4.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. 2020 оны байдлаар орон сууцны зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ 22.1 тэрбум төгрөг бөгөөд барьцаа хөрөнгийн хүрэлцээ 161 хувь байна.

## Орон сууцны хөнгөлөлттэй зээл

Засгийн газраас хэрэгжүүлдэг орон сууцны ипотекийн санхүүжилтийн хүрээнд Банк нь Монголбанкнаас орон сууцны ипотекийн зээлийн санхүүжүүлэх эх үүсвэрийг авдаг ба энэ санхүүжилтийн эх үүсвэрээр харилцагчдад орон сууцны ипотекийн зээлийг 2019 оноос эхлэн олгож эхэлсэн. Орон сууцны ипотекийн зээлийн хүү Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 10 сарын 1-ний А-392 дугаар тушаалаар 8 хувиас 6 хувь болж буурсан. 2019 оны байдлаар 5.2 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байсан бол 2020 онд 21 хувь буюу 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 6.3 тэрбум төгрөгт хүрсэн.

Богд Банкны зээл валютаар дараах байдалтай илэрхийлэгдсэн байна:

*Хүснэгт 53 Богд Банкны зээл валютаар*

| Богд Банкны зээл валютаар (сая төгрөг) | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Төгрөгийн зээл | 76,127 | 97,070 |
| Долларын зээл | 7,581 | 4,193 |
| **Нийт** | **83,708** | **101,263** |

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 ▲ 5903956

СЗХ
2021 оны 11 сар 19 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANG
2021 - 11 - 03
БҮРТГЭВ-03

2019 онд Банкны нийт зээлийн багцын 91 хувийг төгрөгийн зээл, 9 хувийг долларын зээл бүрдүүлж байсан бол 2020 онд 96 хувийг төгрөгийн зээл, 4 хувийг долларын зээл бүрдүүлж байна. 2020 онд ам долларын төгрөгтэй харьцах ханш 4.2 хувиар чангарсан ба гадаад валютаас хамаарах зээлийн эрсдэл бага байна.

## Зээлийн төвлөрөл

Ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, эсвэл ижил газар зүйн бүсэд болон эдийн засгийн тухайлсан нэг салбарт бизнес эрхэлдэг харилцагчдын үйл ажиллагаанд улс төр, эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал төвлөрөл нь бий болдог. Банкны гүйцэтгэлийг өсөлттэй тодорхой нэг эдийн засгийн салбар болон газарзүйн бүсээс хир хамааралтай байгааг төвлөрөл нь илэрхийлдэг.

Эрсдэлийн хэт төвлөрлөөс зайлсхийх үүднээс Банк өөрийн бодлого болон журмаараа багцын эрсдэлийг тараан байршуулах замаар зохицуулж өгдөг. Тус зохицуулалтад дурдагдсанаар зээлийн төвлөрлийн эрсдэлийг Банк хянаж удирддаг байна. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт заасны дагуу Монголбанк нь МБ-ны Ерөнхийлөгчийн 2019 оны 5 сарын 23-ны өдрийн А-138 дугаар тушаалаар "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ыг шинэчлэн батлан бөгөөд банкуудад дараах стандарт хязгаарлалтуудыг тогтоож, биелүүлэхийг үүрэг болгосон. Үүнд:

(i) Нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд олгох нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн нийлбэр дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй.

(ii) Банк холбогдох этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн дүн нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас тус тус хэтрэхгүй. Банкны тухай хуулийн дээрх шаардлагын дагуу Банк нь зээлийн өргөдлийг нарийн судалж, эрсдэлийн түвшинд суурилсан хүүгийн хувь хэмжээг тогтоож, төвлөрлийн эрсдэлийг удирдах үүднээс нэг зээлдэгч, эдийн засгийн салбар зэрэг үзүүлэлтээр зээлийн багцад лимит тогтоож, түүнд хяналт тавих зэргээр зээлийн эрсдэлийг хянаж удирддаг.

Доорх хүснэгтэд 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Богд Банкны зээлийн багц дахь 10 том зээлдэгчийн зээлийн үлдэгдэл, СТОУС-ын дагуух шатлал, эрсдэлийн сангийн мэдээллийг хураангуйлав:

*Хүснэгт 54 Богд Банкны зээлийн багцын 10 том зээлдэгчийн мэдээлэл*

| Зээлдэгч (сая төгрөг) | Салбар | Нийт зээлийн дүн | Нийт зээлийн багцад эзлэх хувь | Зээлийн шатлал | Эрсдэлийн сан |
|---|---|---|---|---|---|
| Зээлдэгч 1 | Барилга | 11,084 | 11.24% | 1 | 49.13 |
| Зээлдэгч 2 | Боловсрол | 9,800 | 9.94% | 2 | 64.45 |
| Зээлдэгч 3 | Үл хөдлөх | 8,000 | 8.11% | 1 | - |
| Зээлдэгч 4 | Худалдаа | 6,891 | 6.99% | 2 | 4.97 |
| Зээлдэгч 5 | Барилга | 6,257 | 6.34% | 1 | 5.41 |
| Зээлдэгч 6 | Худалдаа | 4,509 | 4.64% | 1 | - |

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
5903858

102

СЗХ
2021 оны 10 сар 10 өдөр
КҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Зээлдэгч 7 | Худалдаа | 3,965 | 4.02% | 1 | 2.76 |
| Зээлдэгч 8 | Санхүү, даатгал | 3,050 | 3.09% | 1 | 0.45 |
| Зээлдэгч 9 | Үл хөдлөх | 2,781 | 2.82% | 1 | 0.57 |
| Зээлдэгч 10 | Санхүү, даатгал | 2,100 | 2.13% | 1 | 0.77 |

## Зээлийн багц салбараар

Монгол Улсын Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 сарын 31-ний өдрийн 319, А/160 дугаар "Эдийн засгийн бүх үйл ажиллагааны салбарын ангиллыг шинэчлэн батлах" тухай хамтарсан тушаалаар Банк өөрийн нийт зээлдэгчдийг дараах салбарт ангилсан.

*Хүснэгт 55 Богд Банкны зээлийн багц салбараар*

| Зээлийн багц салбараар | 2019.01.01 | | 2019.12.31 | | 2020.12.31 | |
|---|---|---|---|---|---|---|
| | сая төг | % | сая төг | % | сая төг | % |
| Барилга | 15,749 | 28.96% | 16,409 | 19.32% | 20,244 | 19.58% |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 12,269 | 22.56% | 22,788 | 26.84% | 19,550 | 18.91% |
| Бөөний болон жижиглэнгийн худалдаа | 8,804 | 16.19% | 15,531 | 18.29% | 17,926 | 17.34% |
| Цахилгаан эрчим хүч ба шатахуун | 2,629 | 4.83% | 7,587 | 8.93% | 14,570 | 14.09% |
| Боловсрол | - | 0.00% | 10,040 | 11.82% | 11,582 | 11.20% |
| Санхүү болон даатгалын үйл ажиллагаа | 6,457 | 11.87% | 1,175 | 1.38% | 7,201 | 6.97% |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ | 4 | 0.01% | 3,094 | 3.64% | 3,094 | 2.99% |
| Бусад үйлчилгээ | 17 | 0.03% | 1,397 | 1.64% | 1,991 | 1.93% |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 6,531 | 12.01% | 2,643 | 3.11% | 1,827 | 1.77% |
| Эрүүл мэндийн үйлчилгээ | - | 0.00% | 63 | 0.07% | 1,184 | 1.15% |
| Боловсруулах үйлдвэрлэл | - | 0.00% | 1,154 | 1.36% | 1,324 | 1.28% |
| Урлаг үзвэр, тоглоом наадам | - | 0.00% | 1,164 | 1.37% | 1,101 | 1.07% |
| Зочид буудал, байр сууц, хоолны үйлчилгээ | 650 | 1.20% | 712 | 0.84% | 825 | 0.80% |
| Мэдээлэл холбоо | - | 0.00% | 1,159 | 1.37% | 832 | 0.81% |
| ХАА, ойн аж ахуй, ан агнуур | - | 0.00% | - | 0.00% | 52 | 0.05% |
| Хэрэглээ | - | 0.00% | - | 0.00% | 73 | 0.07% |
| Бусад | 1,270 | 2.34% | - | 0.00% | - | 0.00% |
| **Нийт зээлийн багц** | **54,380** | **100%** | **84,915** | **100.00%** | **103,375** | **100.00%** |

## Зээлийн хэмжээ тархцаар

Доорх хүснэгтэд Богд Банкны зээлийн үлдэгдлийн хэмжээгээр зээлдэгчдийн тоо, нийт зээлийн багцад эзлэх хувийг харууллаа.

*Хүснэгт 56 Богд Банкны зээлийн хэмжээ тархцаар*

| Зээлийн хэмжээ | 2020.12.31 | | |
|---|---|---|---|
| | Зээлийн үлдэгдэл (төгрөг) | Зээлийн дансны тоо | Зээлийн багцад эзлэх хувь |
| 100,000 хүртэлх | 6,392,844 | 98 | 0.01% |
| 100,001-1,000,000 | 148,988,460 | 519 | 0.15% |
| 1,000,001-10,000,000 | 3,872,415,941 | 762 | 3.93% |

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 оны 10 сар
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

| | | | |
|---|---|---|---|
| 10,000,001-50,000,000 | 11,967,978,131 | 565 | 12.13% |
| 50,000,001-100,000,000 | 8,933,731,430 | 127 | 9.06% |
| 100,000,001-500,000,000 | 11,165,615,455 | 57 | 11.32% |
| 500,000,001-1,000,000,000 | 17,316,659,913 | 24 | 17.56% |
| 1,000,000,001 дээш | 45,221,729,047 | 14 | 45.85% |
| **Нийт** | **98,633,511,221** | **2,166** | **100.00%** |

## Зээлийн багцын чанар

Богд Банкны нийт зээлийн үлдэгдэл болон хорогдуулсан өртгөөр зээлийн багцад байгуулсан эрсдэлийн сангийн хураангуйг доорх хүснэгтэд харуулав:

*Хүснэгт 57 Богд Банкны зээлийн эрсдэлийн сан*

| Зээлийн эрсдэлийн сан | 2019.01.01 | | 2019.12.31 | | 2020.12.31 | |
|---|---|---|---|---|---|---|
| | сая төг | % | сая төг | % | сая төг | % |
| Бизнесийн зээл | 48,147 | 88.5% | 69,445 | 87.1% | 75,019 | 77.3% |
| Орон сууцны зээл | 897 | 1.7% | 2,685 | 3.4% | 7,498 | 7.7% |
| Хэрэглээний зээл | 5,335 | 9.8% | 7,587 | 9.5% | 14,570 | 15.0% |
| **Нийт** | 54,379 | 100% | 79,717 | 100% | 97,087 | 100% |
| Үнэ цэнийн бууралтын сан | (152) | -0.3% | (1,207) | -1.4% | (2,112) | -2.1% |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх харилцагчдад олгосон зээл | **54,227** | **100.0%** | **78,510** | **93.8%** | **94,975** | **93.8%** |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх | - | 0.0% | 5,197 | 6.2% | 6,288 | 6.2% |
| Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | **54,227** | **100.0%** | **83,707** | **100.0%** | **101,263** | **100.0%** |

Банк "санхүүгийн хэрэглүүр" ангилалд хамаарах зээлийн үүрэг болон санхүүгийн баталгаа, бодит үнэ цэнийн өөрчлөлт ашиг, алдагдлын тайланд бүртгэгдээгүй бусад өрийн хэрэглүүр болон бүх зээлд зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын сан бүртгэсэн. СТОУС 9-н дагуу өмчийн хэрэглүүр нь үнэ цэнийн бууралтад орохгүй. Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал нь хөрөнгийн ашиглалтын нийт хугацаанд үүсэх зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Хэрэв анх бүртгэснээс хойш алдагдал нь мэдэгдэхүйц хэмжээгээр өсөөгүй бол алдагдал нь 12 сарын хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА аргын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэглүүрийн чанаргүйдлийн магадлалын үр дүнгээр ЗҮЦХА-г илэрхийлнэ.

2019 болон 2020 оны зээлийн багцыг чанараар нь хураангуйлж доорх хүснэгтэд харуулав:

*Хүснэгт 58 Богд Банкны зээлийн багцын чанар 2019 оны байдлаар*

| Зээлийн төрөл (сая төгрөг) | Шатлал 1 | Шатлал 2 | Шатлал 3 | Нийт |
|---|---|---|---|---|
| Бизнесийн зээл | 63,482 | 4,235 | 1,728 | **69,445** |
| Орон сууцны зээл | 2,473 | - | 212 | **2,685** |
| Хэрэглээний зээл | 7,473 | 28 | 86 | **7,587** |
| **Нийт** | **73,428** | **4,263** | **2,026** | **79,718** |

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 оны 10 дугаар
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Хүснэгт 59 Богд Банкны зээлийн багцын чанар 2020 оны байдлаар*

| Зээлийн төрөл (сая төгрөг) | Шатлал 1 | Шатлал 2 | Шатлал 3 | Нийт |
|---|---|---|---|---|
| Бизнесийн зээл | 44,007 | 26,954 | 4,058 | **75,019** |
| Орон сууцны зээл | 5,026 | 1,927 | 546 | **7,498** |
| Хэрэглээний зээл | 11,349 | 2,624 | 596 | **14,570** |
| **Нийт** | **60,382** | **31,505** | **5,200** | **97,087** |

Банк нь 2019 оны 1 сарын 1-нээс эхлэн СТОУС 9-г нэвтрүүлсэн. СТОУС 9-н шаардлагын дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанд зээлийн эрсдэлийн сан байгуулдаг бөгөөд зээлийг чанараар нь Шатлал 1, Шатлал 2, Шатлал 3 гэж ангилдаг.

**Шатлал 1** - Эргэн төлөлт хугацаандаа хийгдэж байгаа буюу хэвийн ангилалтай активыг хамруулна. Үндсэн зээл, хүүгийн хугацаа хэтэрсэн хоног иргэний хувьд 15 хоног, аж ахуй нэгжийн хувьд 30 хоногоос ихгүй.

**Шатлал 2** - Хугацаа хэтэрсэн буюу анхаарал хандуулах ангилалд байгаа активыг хамруулна. Үндсэн зээл, хүүгийн хугацаа хэтэрсэн хоног 90 хоногоос хэтрэхгүй.

**Шатлал 3** - Чанаргүй буюу хэвийн бус, эргэлзээтэй, муу ангилалд байгаа активыг хамруулна. Үндсэн зээл, хүүгийн хугацаа хэтэрсэн хоног 91-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн.

Доорх хүснэгтэд жилийн эцсийн ангилал болон Банкны дотоод зээлийн үнэлгээний систем дээр үндэслэсэн зээлийн чанар болон ЗҮЦХА-г агуулсан зээлийн эрсдэлийн хамгийн их хэмжээг харуулав.

*Хүснэгт 60 Богд Банкны зээлийн дансны үнэ болон ЗҮЦХА 2019 оны байдлаар*

| Зээлийн дансны үнэ болон ЗҮЦХА (сая төгрөг) | Бизнесийн зээл | Орон сууцны зээл | Хэрэглээний зээл | Нийт |
|---|---|---|---|---|
| 2019.01.01-нээрх дансны үнэ | 48,147 | 897 | 5,335 | 54,380 |
| Нэмэгдсэн | 47,929 | 2,006 | 6,892 | 56,827 |
| Хасагдсан | (27,040) | (219) | (4,640) | (31,899) |
| Валютын ханш болон бусад тохируулга | 409 | - | - | 409 |
| **2019.12.31-нээрх дансны үнэ** | **69,445** | **2,685** | **7,587** | **79,718** |
| 2019.01.01-нээрх ЗҮЦХА-н сан | 123 | 1 | 27 | 152 |
| Нэмэгдсэн | 520 | 7 | 74 | 601 |
| Хасагдсан | (92) | (0.1) | (18) | (110) |
| Шатлал хоорондын шилжилтийн ЗҮЦХА -д үзүүлэх нөлөөлөл | 454 | 69 | 42 | 564 |
| Тайлант жилд байгуулсан | 882 | 76 | 97 | 1,055 |
| **2019.12.31-нээрх ЗҮЦХА-н сан** | **1,006** | **77** | **125** | **1,207** |

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 . 11 . 19
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 - 11 - 03
БҮРТГЭВ-03

*Хүснэгт 61 Богд Банкны зээлийн дансны үнэ болон ЗҮЦХА 2020 оны байдлаар*

| Зээлийн дансны үнэ болон ЗҮЦХА (сая төгрөг) | Бизнесийн зээл | Орон сууцны зээл | Хэрэглээ-ний зээл | Нийт |
|---|---|---|---|---|
| 2020.01.01-нээрх дансны дүн | 69,445 | 2,685 | 7,587 | 79,718 |
| Нэмэгдсэн | 27,890 | 5,251 | 10,534 | 43,674 |
| Хасагдсан | (22,562) | (438) | (3,551) | (26,551) |
| Валютын ханш болон бусад тохируулга | 246 | - | - | 246 |
| **2020.12.31-нээрх дансны үнэ** | **75,019** | **7,498** | **14,567** | **97,087** |
| 2020.01.01-нээрх ЗҮЦХА-н сан | 1,006 | 77 | 125 | 1,207 |
| Нэмэгдсэн | 63 | 262 | 524 | 850 |
| Хасагдсан | (210) | (3) | (59) | (272) |
| Шатлал хоорондын шилжилтийн ЗҮЦХА-д үзүүлэх нөлөөлөл | 234 | 85 | 8 | 327 |
| Тайлант жилд байгуулсан | 87 | 345 | 473 | 905 |
| **2020.12.31-нээрх ЗҮЦХА-н сан** | **1,093** | **422** | **598** | **2,112** |

**Цахим банкны үйлчилгээ**

Дэлхий дахинаа эрчээ авч хөгжиж байгаа Финтек нь уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээг илүү хялбар түргэн шуурхай болгох, санхүүгийн үйлчилгээний зардлыг бууруулж, үйлчилгээний шимтгэл, хураамжийг багасгах зэрэг олон давуу талыг харилцагчдад олгодог. Үүний хүрээнд Богд Банк нь BOGD MOBILE аппликейшн хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэхүү аппликейшн нь харилцагч салбарт ирж үйлчлүүлэх цагийг хэмнэх олон төрлийн үйлчилгээг гар утаснаасаа авч болох боломжийг бүрдүүлсэн олон давуу талтай өргөн хэрэглээ бүхий дэвшилтэт бүтээгдэхүүн юм. Одоогоор Үнэт цаас гаргагчийн нийт харилцагчдын 75 хүртэлх хувь нь интэрнэт банкны байнгын хэрэглэгч бөгөөд 57 хүртэлх хувь нь онлайнаар бүртгүүлсэн харилцагчид байгаа нь цахим үйлчилгээ хэрэглэгчдийн дунд эрэлттэй байгааг харуулж байна.

Зарим давуу талуудаас дурдвал:

- Харилцагч нь BOGD MOBILE аппликейшнаар дамжуулан данс нээлгэх, карт захиалах зэрэг бүхий л үйлчилгээг авах боломжтой;
- Харилцагч зардлын гүйлгээгээ хянах боломжтой бөгөөд ПОС машинаар үйлчлүүлснээр илүү дэлгэрэнгүй зардлаа төрөлжүүлж графикаар харах боломжтой;
- Харилцагч нь онлайнаар Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл болон Богд Банкны цуглуулсан дата дээр үндэслэн 3 төрлийн Скоринг үнэлгээ хийлгэн барьцаа хөрөнгө шаардахгүйгээр 50,000-1,000,000 төгрөг хүртэлх дүнгээр ШУУРХАЙ ЗЭЭЛ авах боломжтой юм.

**Үнэт цаас гаргагчийн гадаад, төлбөр тооцооны үйлчилгээ**

Богд Банк нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын болон дотоод бодлого, хууль, журмыг баримтлан ажилладаг. Банк нь байгуулагдсан цагаасаа эхлэн Олон Улсад нэр хүнд бүхий банкуудтай корреспондент харилцаа үүсгэж SWIFT сүлжээгээр дамжуулан гадаад төлбөр тооцоог дэлхийн бүх улс руу түргэн шуурхай,

СЗХ
ирсэн 2021 оны 11 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ...
MONGOLIAN STOCK EXCHANG...
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

найдвартай гүйцэтгэн ажиллаж байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар үнэт цаас гаргагч нь 7 гадаадын нэр хүндтэй банкуудтай корреспондент харилцаатай байгаа ба USD, CNY, EUR, RUB, JPY, HKD зэрэг 7 валютын 17 ностро данстайгаар харилцагчдын гүйлгээг хийж гүйцэтгэж байна.

*Хүснэгт 62 Богд Банкны харилцагч банкны жагсаалт*

| № | Хамтрагч банкны нэр | Хамтран ажиллаж эхэлсэн он | Төлбөр тооцоо хийх валют |
|---|---|---|---|
| 1 | Өвөр Монголын Банк, БНХАУ | 2017 | USD, CNY |
| 2 | Шанхай Пудонг Хөгжлийн Банк, БНХАУ | 2018 | CNY |
| 3 | Күүкмин Банк, БНСУ | 2016 | USD, KRW, HKD |
| 4 | Хөдөө Аж Ахуйн Банк, БНХАУ | 2016 | CNY |
| 5 | ВТБ Банк, ОХУ | 2018 | USD, RUB |
| 6 | Баошанг Банк, БНХАУ | 2018 | USD, EUR, CNY |
| 7 | Транскапитал Банк, ОХУ | 2019 | USD, RUB, EUR, JPY, GBP, CNY |
| 8 | Хуйшан Банк, БНХАУ | 2020 | CNY |
| 9 | Росэксим Банк, ОХУ | 2019 | USD, RUB, EUR |

**Үнэт цаас гаргагчийн валютын арилжаа**

Банк нь уян хатан валютын ханшийн бодлого баримталж өөрийн харилцагчдынхаа валютын хэрэгцээг салбар нэгжүүд, мобайл банк, интернет банк болон шууд хэлцлээр дамжуулан тогтмол хангаж, валютын арилжааны дотоод зах зээлд эзлэх байр суурыа нэмэгдүүлэн ажиллаж байна. Банк нь харилцагч байгууллагуудад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах своп болон форвард хэлцлүүдийг санал болгодог.

### 9.1.5. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны бодлого

Үнэт цаас гаргагч нь өөрсдийн бусдаас ялгарах бүтээгдэхүүн үйлчилгээг бүх төрлийн харилцагчдад санал болгон, харилцагчийн бааз суурыа нэмэгдүүлэх, одоо байгаа харилцагчдадаа сэтгэл ханамжийг бий болгон тогтоон барьж үлдэх, бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхдээ дэлхийн стандартад нийцсэн, дотоод болон гадаадын иргэдэд зориулсан, техник технологийн дэвшилтэт шийдлийг ашиглан, хэрэглэгчийн цаг хугацааг хэмнэхэд чиглэсэн байхаар зорин ажиллаж байна. Богд Банк нь ирэх жилүүдэд Иргэд болон Жижиг дунд бизнес эрхлэгч гэсэн үндсэн 2 харилцагчийн сегментийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн.

**Иргэдийн бизнес**

Банкны иргэдэд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээ нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн байх гэсэн зарчмын хүрээнд боловсруулагдаж ирсэн. Цаашдаа банкны үйлчилгээ нь харилцагчийн амьдралын хэв маяг, хүсэл сонирхол, бодит хэрэгцээнд тулгуурласан байх гэсэн үндсэн зарчмын хүрээнд хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 11 10
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANG
2021 - 11 - 03
БҮРТГЭВ-03

## Жижиг дунд бизнес

Бизнесийн үйл ажиллагаа нь тогтворжсон жижиг дунд бизнес эрхлэгч байгууллагууд зах зээлд харьцангуй цөөн тул эдгээр харилцагчдыг татахын тулд арилжааны банкууд ихэвчлэн хямд хүүгийн бодлого барьж ажиллаж байна. Мөн нөгөө талдаа өрсөлдөөний улмаас харилцагчийн хүссэн санхүүжилтийг түргэн шуурхай шийдвэрлэх нь авч хэрэгжүүлэх шаардлагатай чухал стратеги болоод байна. Бизнес эрхлэгчдийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, борлуулалтын орлого зэрэгт суурилсан эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалт, зээлийн шугам гэх мэтээр ялгаатай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон ажиллаж байгаа ба цаашид зөвхөн банкны үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээ төдийгүй санхүүгийн зөвлөгөө, дэвшилтэт технологийн шийдлээр боловсруулагдсан бусад үйлчилгээг хөгжүүлэхээр төлөвлөж байна.

### Зээлтэй холбоотой бодлого, зээлийн үйл ажиллагааны журам

Банк нь аливаа зээлийг судалж эхлэхээс өмнө үнийн дүнгээс хамааран Гүйцэтгэх захирал эсвэл ТУЗ-ийн гишүүдээс зээл судлах зөвшөөрөл авч, зээл хүсэгч бүрт зээлдэгчийн үнэлгээг хийдэг. Зээлдэгчийг үнэлэх үйл явцыг зээлдэгчийн онцлогт тохируулан зээлийн бодлого, зээлийн үйл ажиллагааны журамтай уялдуулан гүйцэтгэдэг.

Монголын арилжааны банкууд Олон Улсын Санхүүгийн Корпорацийн тусламжтайгаар 2009 онд Зээлийн Мэдээллийн Санг иргэн, аж ахуй нэгжийн санхүүгийн хариуцлагыг нэмэгдүүлж зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, Банк, санхүүгийн байгууллагын зээлийн судалгааны зардлыг бууруулах зорилгоор байгуулсан. Зээлийн мэдээллийн сан нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас Зээлийн мэдээллийн тухай хуулийн дагуу нийлүүлсэн зээлдэгчийн зээлийн мэдээлэл болон бусад төлбөрийн мэдээллийг агуулж буй Монголбанкны зээлийн мэдээллийн нэгдсэн сан юм. Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 10 сарын 20-ны өдөр баталсан "Зээлийн мэдээллийн тухай" хуульд заасны дагуу зээлийн мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагааг Монголбанк тусгай зөвшөөрөлтэйгөөр зээмшдэг. "Зээлийн мэдээллийн тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, санхүүгийн түрээсийн компани /лизинг/, төрийн байгууллага нь иргэн, аж ахуй нэгжээс зөвшөөрөл авсан эсэхээс үл хамааран Монголбанкны мэдээллийн санд зээлийн мэдээллийг тогтмол өгдөг. Монголбанкнаас арилжааны банкууд тухайн зээлдэгчийн зээлийн түүхийн талаарх сүүлийн 6 жилийн мэдээллийг авч зээлдэгчийн үнэлгээг хийхдээ ашиглаж байна.

## Зээлийн хороод

Богд Банканд 3 түвшний зээлийн хороод байна. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл, Зээлийн хороо, Зээлийн дэд хороо нь зээл олгох, зээл төлөх болон зээлийн үйл ажиллагаатай холбогдон гарах асуудлын талаар хэлэлцэн шийдвэр гаргана. Зээлийн хороо нь зээлийн бүтээгдэхүүний дээд доод хэмжээ, зээлийн хугацаа, зээлийн үнийн бодлогыг тодорхойлох, зээлийн бодлого, бүтээгдэхүүний журамд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хариуцан ажилладаг. Зээлийн дэд хорооны үйл ажиллагаа, шийдвэр гаргах зарчим нь Зээлийн дэд хорооны ажиллах журмаар, Зээлийн хорооны үйл ажиллагаа, шийдвэр гаргах зарчим нь зээлийн хорооны ажиллах журмаар зохицуулагддаг.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 11 10
2021-11-03
БҮРТГЭВ-03

Банкны Зээлийн хороо нь Гүйцэтгэх захирлаар даргалуулсан нийт 5 гишүүнтэй бөгөөд эрсдэлийн нэгдсэн удирдлагын хариуцсан дэд захирал, зээлийн удирдлага хариуцсан дэд захирал, бизнес банк хариуцсан дэд захирал болон үйл ажиллагаа хариуцсан дэд захирлаас бүрддэг. Тус хороо нь эрхийн хүрээнд зээлийн хүсэлт, зээлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, сар бүрийн эрсдэлийн сангийн таамаглал, зайны хяналтын тайланг хэлэлцэх, зээлийн үйл ажиллагаатай холбоотой заавар, журмыг хэлэлцэх батлах чиг үүрэгтэй ажилладаг. Зээлийн хороо нь 100 сая төгрөгөөс дээш дүнтэй зээлийн хүсэлтийг хэлэлцэн баталдаг. Түүнчлэн, одоогийн мөрдөгдөж буй бодлого журмын дагуу 3 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй зээлийн хүсэлтийг мөн ТУЗ-д танилцуулан батлуулдаг байна.

Зээлийн дэд хороо нь зээлийн хэлтсийн захирлаар даргалуулсан нийт 3 гишүүнтэй бөгөөд эрсдэлийн нэгдсэн удирдлага хариуцсан дэд захирал, бизнесийн банк хариуцсан дэд захирлаас бүрдэнэ. Тус хороо нь эрхийн хүрээнд зээлийн хүсэлт, зээлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, зээлтэй холбоотой заавар журам, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэн Зээлийн хороонд уламжлах чиг үүрэгтэй. Зээлийн дэд хороо нь орон нутгийн салбар болон зээлийн нэгжүүдийн зээлийн хорооны зээл батлах эрхээс давсан буюу 100 сая төгрөг хүртэлх зээлийн хүсэлтийг хэлэлцэн баталдаг.

## Зээл олгох процесс

Зээл олгохоос өмнө Банк боломжит зээл хүсэгчийн эрсдэл, зээлийн судалгааг дараах тоон болон чанарын хүчин зүйлүүдэд үндэслэн хийдэг. Үүнд:

- Зээл хүсэгчийн үйл ажиллагааны салбар, холбогдох эдийн засгийн хүчин зүйлс
- Зээл авах зорилго, зээл эргэн төлөх чадвар
- Хөрөнгө оруулалтын зээлийн хувьд суурь төслийн үр ашигт байдал болон төсөл хэрэгжих боломж
- Зээлдэгчийн зээлийн түүх
- Холбогдох баримт бичгийн баталгаажуулалт
- Зээлийн ерөнхий болон тусгай нөхцөлүүд
- Барьцаа хөрөнгийн хүрэлцээ, баталгаа, батлан даалт зэрэг гол үзүүлэлтүүд.

Зээлийн хороодын шийдвэр гаргах эрхийн хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 63 Зээлийн хороодын шийдвэр гаргах эрхийн хэмжээ*

| № | Хороо | Шийдвэр гаргах эрхийн хэмжээ |
|---|---|---|
| 1 | Төлөөлөн удирдах зөвлөл | 3,000,000,001 /гурван тэрбум нэг/ төгрөгөөс дээш дүнтэй зээл батлах, зээлийн нөхцөл өөрчлөх |
| 2 | Зээлийн хороо | 100,000,001 /зуун сая нэг/ төгрөгөөс 3,000,000,000 /гурван тэрбум/ төгрөг хүртэлх хэмжээний зээл батлах, зээлийн нөхцөл өөрчлөх |
| 3 | Зээлийн дэд хороо | Журмын дагуу олгогдох 100,000,000 /зуун сая/ төгрөг хүртэлх бүх төрлийн зээл |

## Барьцаа хөрөнгийн бодлого

Банк хуулийн дагуу зээлдэгчийн өмчлөлд байгаа газар эзэмших, өмчлөх эрх, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, хөрөнгийн эрх, тусгай зөвшөөрөл /лиценз/, хувьцаа, үнэт цаас, мөн зээлийн бүтээгдэхүүний төрлөөс хамаарч зээлдэгчийн ирээдүйн үйл ажиллагаанаас

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

олох орлого, үр шим, банкнаас хүлээн зөвшөөрч болох бусад эд хөрөнгийг зээлд барьцаална.

Зээлийн барьцаа хөрөнгө нь зах зээлийн үнэлгээг тогтоох боломжтой, түргэн борлогдох чанартай, өмчлөх эрх шилжүүлэхэд хялбар, хуулийн холбогдох хугацаа дуусаагүй /хүчинтэй/, хөшүүргийн үнэ цэнтэй, хууль эрх зүйн хувьд маргаангүй байх шаардлагатай.

Барьцаа хөрөнгийн үнэлгээ ба олгож болох зээлийн дээд хэмжээнд дараах харьцааг мөрддөг.

*Хүснэгт 64 Зээлийн дээд хэмжээнд мөрдөх харьцаа*

| Барьцааны зүйл | Барьцааны үнэлгээнд эзлэх зээлийн дээд хэмжээ |
|---|---|
| Үйлдвэрлэлийн зориулалттай барилга | 60% |
| Үйлчилгээний зориулалттай барилга | 70% |
| Орон сууц /амины орон сууц, хувийн сууц/ | 70% |
| Хадгаламж түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгө | 85% |
| Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл | 50% |
| Газар өмчлөх, эзэмших эрх | 50% |
| Хөрөнгийн хоёрдогч зах зээлд арилжаалагдаж буй хувьцаа | 50% |
| Бараа, бэлэн бүтээгдэхүүн | 50% |
| Санхүүгийн түрээсийн тоног төхөөрөмж | 50% |
| Тоног төхөөрөмж, машин механизм | 50% |
| Тээврийн хэрэгсэл | 50% |
| Туслах барьцаа | 0% |

Барьцаа хөрөнгийн үнэлгээг барьцааны төрлөөс хамааруулан зах зээлийн үнэ, үлдэх өртөг болон экспертийн дүгнэлтээр тодорхойлно.

## Зээлийн тандалт

Зээл олгосны дараах тандалт судалгааны хүрээнд Банк нь дараах төрлийн хяналтуудыг тавьж ажилладаг.

- Зээлийн зарцуулалтыг хянах;
- Зээл, хүүгийн эргэн төлөлтийг хянах;
- Санхүүгийн тайлангийн хяналт;
- Газар дээрх хяналт зэргийг хийж гүйцэтгэн холбогдох хороонд танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажилладаг. Мөн зээлдэгчийн санхүүгийн болон зах зээлийн нөхцөл байдлыг үнэлэх, зээлийн барьцаа хөрөнгийн чанар болон хүрэлцээтэй байдлыг үнэлэх замаар зээлдэгчийн эрсдэлийг тодорхойлж, тасралтгүй бууруулж ажилладаг.

Зээлдэгчийн эргэн хяналт хийхдээ харилцах дансны хуулга, санхүүгийн тайлан, зээлдэгчийн ирүүлсэн болон Банкны олж авсан зээлдэгчийн бизнесийн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг үндэслэн эргэн хяналтын тайлан бичиж холбогдох хороонд танилцуулдаг.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
5903858

СЗХ
БҮРТГЭВ
№ 31
ОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
ONGOLIAN STOCK EXCHAN
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

**Депозит бүтээгдэхүүний журам**

Үнэт цаас гаргагч нь үндэсний болон гадаад валютаар депозит бүтээгдэхүүний данс нээлгэн, мөнгөн хөрөнгөө хадгалуулах, захиран зарцуулах, түүнтэй холбоотой үйл ажиллагаанд 2020 оны 12 сарын 27-ны өдөр батлагдсан Депозит бүтээгдэхүүний журмын дагаж мөрддөг. Тус журмын дагуу дараах бодлого, журмыг мөрдлөг болгодог:

- Харилцагчийг таньж мэдэх, харилцагчийн хувийн хэргийн бүрдүүлбэр, мэдээллийг шинэчлэх ажиллагаатай холбогдох үйл ажиллагаанд Харилцагч таньж мэдэх журам болон холбогдох бусад зааврыг;
- Депозит бүтээгдэхүүнтэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээг гүйцэтгэхдээ Теллерийн системийн багц журам болон бусад холбогдох зааврыг;
- Депозит бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн журам болон Богд Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг;
- Банкны цахим үйлчилгээнд бүртгүүлэх, данс нээх, бусад цахим үйлчилгээ авахтай холбоотой үйл ажиллагааг Цахим банкны үйлчилгээний журмаар;
- Төлбөрийн картын данстай холбогдон үүсэх харилцааг Төлбөрийн картын журмаар тус тус зохицуулж байна.

**Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн удирдлагын бодлого, журам**

Богд Банкны Актив, пассивын бодлого нь эрсдэлийн зохистой түвшинд хамгийн их ашиг олохуйц актив, пассивын оновчтой багц бүрдүүлэх, хүү тогтоох, эргэн төлөгдөх хугацааг уялдуулах замаар оновчтой актив, пассивын удирдлагыг хэрэгжүүлэх зорилготой.

Үнэт цаас гаргагчийн Хөрөнгө зохицуулалт, хөрөнгө оруулалтын банкны хэлтэс нь Банкны актив, пассивын бодлого, эрсдэлийн удирдлагын стратеги, бодлогуудыг хэрэгжүүлэн, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, нөөцийн үзүүлэлт, шаардлагуудыг ханган хадгалахын зэрэгцээ эх үүсвэрийг хамгийн оновчтой байдлаар байршуулах замаар банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг. Тус хэлтэс нь нөөцийн удирдлагын болон санхүүгийн чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

- Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, нөөцийн үзүүлэлтүүдийг тогтоосон журмын дагуу хангаж ажиллах;
- Монголбанк, бусад банканд байршуулсан мөнгөн хөрөнгө болон ностро данснуудын хэмжээнд өдөр тутмын хяналт тавьж, төлбөр тооцооны шаардлагатай нийцүүлэн удирдах;
- Олон улсын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох чиглэлээр ажиллах, зөвлөгөө өгөх, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- Гадаад, дотоодын харилцагч санхүүгийн байгууллагуудтай хамтран хамтарсан санхүүжилтийн үйл ажиллагааг зохион байгуулах;
- Актив ашиглалтыг сайжруулах, банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх үүднээс сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг гадаад, дотоодын банк санхүүгийн зах зээлд үр ашигтайгаар байршуулах;
- Банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх үүднээс нөөцийн үзүүлэлт, арилжааны бодлого, эрсдэлийн удирдлагын стратеги болон тогтоосон лимит, хязгаарлалтын

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
5903858

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 11 03
БҮРТГЭВ-03

хүрээнд банкны валют, үнэт металл, үнэт цаасны арилжааны үйл ажиллагааг харилцагчийн болон банкны нэрийн өмнөөс гадаад, дотоод зах зээл дээр гүйцэтгэх.

Үнэт цаас гаргагч нь Актив, пассивын бодлогын дагуу эрсдэл багатай, өгөөж өндөртэй үнэт цаасанд хөрөнгө оруулдаг бөгөөд Төв банкны үнэт цаас, Засгийн газар, хувийн байгууллагуудын гаргасан бондыг эзэмшдэг. Богд Банкны эзэмшиж буй хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг дараах хүснэгтээс харна уу.

*Хүснэгт 65 Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй үнэт цаасны мэдээлэл СТОУС-ын дагуу*

| Богд Банкны эзэмшиж буй үнэт цаас (сая төгрөг) | 2019.01.01 | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|---|
| Засгийн газрын бонд | 13,391 | 5,109 | 10,315 |
| Төв банкны үнэт цаас | 56,512 | 43,264 | 44,330 |
| Компанийн бонд | 2,509 | 10,399 | - |
| Бодь даатгал ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт | - | 1,485 | - |
| МИК үнэт цаас | - | - | 1,332 |
| Бодь цамхаг ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт | - | - | 3,300 |
| МХБ дээрх компаниудын хувьцаа | - | - | 217 |
| **Нийт** | **72,412** | **60,257** | **59,494** |

**Үнэт цаас гаргагчийн дотоод аудитын бодлого**

Богд Банкны дотоод аудитын үйл ажиллагааг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо болон Дотоод аудитын газар хариуцдаг. Дотоод аудитын үйл ажиллагааны журам нь дотоод аудитын үйл явц, аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, мэдээлэх, зөвлөмж өгөх, эргэн хянахтай холбогдон үүсэх бүхий л харилцааг зохицуулдаг.

**Аудитын хороо** нь үйл ажиллагаагаа ТУЗ-д шууд тайлагнадаг ба санхүүгийн тайлангийн үйл явц, дотоод хяналтын систем болон санхүүгийн эрсдэлийн менежмент, аудитын үйл явц, комплайнс буюу хуулийн нийцлийг хянахад дэмжлэг үзүүлэн ажилладаг.

ТУЗ, Дотоод аудитын хороо нь дотоод аудитын үйл ажиллагаанд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг:

- Дотоод аудитын олон улсын стандарт, шилдэг туршлага, арга члалыг нэвтрүүлэхэд бүх төрлийн боломжоор хангаж дэмжлэг үзүүлэх;
- Дотоод аудитын газрын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, төсвийг баталж, үйл ажиллагааг нь чиглүүлэх;
- Дотоод аудитын газрын захирал, аудиторуудыг томилж, чөлөөлөх;
- Дотоод аудитын газрын хүний нөөцийг мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд бодлогын түвшинд дэмжих.

**Дотоод аудитын газар** нь банкны үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг бие даасан, бодитойгоор үзүүлдэг. Тус газар нь өөрийн үндсэн чиг үүргийн хүрээнд Банкны Удирдлагын хороо, холбогдох бусад хороод, газар, хэлтэс, нэгжийн удирдлагуудад засаглал, эрсдэлийн удирдлага,

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 .11. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 31
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHAN
2021 11 03
БҮРТГЭВ-03

дотоод хяналтын талаар зөвлөгөө өгч, баталгаажуулах үйлчилгээ үзүүлж, холбогдох аудитын тайланг мэдээлж ажилладаг. Тус газар нь ТУЗ, Аудитын хороонд үйл ажиллагаагаа тайлагнах ба аудитлагдсан нэгж, үйл ажиллагаатай холбоотой тайланг Гүйцэтгэх удирдлагад мэдээлж, шаардлагатай сайжруулалтын ажлуудыг цаг тухайд нь хийлгэдэг.

Дотоод аудитын газар нь дотоод аудитын зорилгыг биелүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг:

- Банкны дотоод хяналт болон удирдлагын түвшинд ажиглагдаж байгаа эрсдэлд үндэслэсэн аудитын жилийн уян хатан төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Банкны бүх ажилтнуудын хийж байгаа үйлдэл нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм, журам, стандарт, Банкны бодлого, журам, зааварт нийцэж байгаа эсэхэд аудит хийх;
- Аудитын тайлангаар дамжуулан банкны дотоод хяналтын системийн байнгын үйл ажиллагааг сайжруулахад зөвлөмж, дэмжлэгээр хангах;
- Аудитын олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа тогтмол ашиглахыг эрмэлзэх;
- Аудитын үйл ажиллагааны нэгдсэн үр дүнг Банкны ТУЗ, аудитын хороонд тогтмол давтамжтайгаар тайлагнах.

Богд Банк нь аудитын цар хүрээг тэлэх, үр ашгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2020 онд дотоод аудитын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж, ажилтнуудын үр чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч, чанарын баталгаажуулалт, сайжруулалтын хөтөлбөрийн хүрээнд дотоод үнэлгээг анх удаа хийсэн. Мөн дотоод аудитын уламжлалт арга барилыг орчин үеийн шинэлэг аргачлалаар баяжуулж, Дотоод Аудиторуудын олон улсын институт /IIA Global/-аас гаргадаг Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ /Internaltional Practice Framework/-г үйл ажиллагаандаа жишиг болгон ажиллаж байна.

**Үнэт цаас гаргагчийн техник технологийн хүрээнд баримталж буй бодлого**

**Мэдээлэл технологи**

Богд Банк нь техник технологийн хөгжлийг ашиглаж харилцагч, үйлчлүүлэгчдэдээ шинэ санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх зорилготой ажилладаг. Тэр дундаа мэдээллийн технологийн сүүлийн үеийн цогц шийдлүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, тэдэнтэй уялдах, гар ажиллагаа шаардсан ажлуудыг хялбаршуулж эрсдэлээс хамгаалах төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Үнэт цаас гаргагч нь мэдээлэл технологийг өөрийн үйл ажиллагаа, үйлчилгээг шуурхай, тасралтгүй, эрсдэлгүй явуулах зорилгоор батлагдсан Богд Банкны Мэдээллийн Технологийн үйл ажиллагааны журмыг үйл ажиллагаандаа дагаж мөрддөг. Богд Банк нь харилцагчдынхаа мэдээллийн аюулгүй байдлыг эрсдэлийн удирдлагад тулгуурлан хянаж, сүүлийн үеийн технологиудын тусламжтайгаар бизнес болон хувь хүний нууцыг хамгаалан бизнесийн нэр хүндийг өсгөн ажиллахыг эрхэмлэн ажиллаж байна.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ6966 - 5903858



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч нь өөрсдийн Дата нөөц төвтэй бөгөөд энэ нь байгалийн гамшиг зэрэг давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлд харилцагчдадаа тасралтгүй үйл ажиллагааг хүргэх үндсэн түлхүүр болж өгдөг. Мөн Дархан хотод шинэ нөөц төвтэй болохоор бэлтгэл ханган ажиллаж байна.

Богд Банк нь санхүүгийн салбарт техник технологийн дэвшлийг нэвтрүүлэхээр зорин ажилладаг. Банк нь дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэх хиймэл оюун ухаан болон блокчэйн технологи ашиглаж банк санхүүгийн AI боловсон хүчин бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна. Ухаалаг банкны дараагийн шатны хүрээнд Үнэт цаас гаргагч нь нийтлэг бус ВИП үйлчилгээ болон call center буюу дуудлагын төвийн үйлчилгээг харилцагчдадаа хүргэхээр төлөвлөж байгаа бөгөөд хэрэглэгчдийн мэдээлэлд суурилсан зөвхөн тухайн харилцагчид зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Богд Банк нь техник технологийн хүчин чадлаа жил бүр өсгөх төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна.

**Мэдээллийн аюулгүй байдал**

Богд Банк нь дэлхийн тэргүүлэгч үйлдвэрлэгч Импервагийн Веб Аппликейшн файрволл (firewall) худалдан авч, тохируулан гадаад сүлжээний системүүдийг хиймэл оюун ухааны тусламжтай нэмэгдүүлсэн. Зайнаас ажиллах нөхцөл байдалд тохируулан дотоод, гадаад сүлжээний хамгаалагдсан шийдэл нэвтрүүлж, онцгой нөхцөл байдлын үед банкны үйл ажиллагааг явуулах боломжоор хангасан. Bogd Mobile шинэ системийн хамгаалалтын давхар шийдэл нэвтрүүлэн, төхөөрөмж сүлжээний түвшинд цахим халдлагаас харилцагчаа хамгаалах шийдэл нэвтрүүлсэн байна.

Богд Банк нь мэдээллийн технологийн хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна:

- Олон Улсын түвшинд хүрсэн, Дэлхийн санхүүгийн байгууллагын стандартыг хангасан банкны үндсэн бүртгэлийн шинэ систем нэвтрүүлэх;
- санхүүгийн болон дотоод үйл ажиллагааны явц, үр дүн, хандлага, таамаглалыг шууд үзүүлэх программыг удирдлагуудын хүрээнд ашиглалтад оруулах;
- аюулгүй байдал, хамгаалалтын үйлчилгээг сайжруулах;
- теллерийн автоматжуулалт.

**Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн бодлого**

Банкны хүний нөөцийн бодлого нь банкны стратегийн бодлого, зорилтуудыг хангахад хүний нөөцийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулах, банкны ажилтнуудыг хөдөлмөрийн бүтээмжтэй зөв зохистой үнэлэн дүгнэх холбогдох арга хэмжээг авах замаар хөдөлмөрийн бүтээмжийг өндөр түвшинд байлгах, банктай хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, тэдгээрийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, сургалт, хөдөлмөрийн аливаа асуудал, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналтын үйл явцыг тодорхой болгох харилцааг зохицуулдаг байна.

Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримталж байна. Үүнд:

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ68966 ₪ 5903358

СЗХ
2021 . 11 сар 10
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ...
ONGOLIAN STOCK EXCHAN...
2021 - 11 - 03
БҮРТГЭВ-03

- Богд Банкны эрхэм зорилго, стратегийн зорилтуудыг хангахуйц хүний нөөцийг бүрдүүлэх
- Сургалт үйл ажиллагааг байнгын буюу тасралтгүй явуулах
- Банкны хүний нөөцийн бодлогуудын хэрэгжилтийг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц
- Хянагдахуйц бөгөөд урт хугацаанд тогтвортой хэрэгжихүйц
- Ёс суртахууны хэм хэмжээнд нийцсэн, шударга байх
- Итгэл хүлээлгэх, шаардлагатай эрх мэдлийг хуваарилах.

Богд Банк нь ажилтны сургалтын хөтөлбөрөө жил бүр шинэчлэн баталж, ажилтнуудаа мэргэжлийн болоод хувь хүний хөгжлийн хувьд өсөж дэвжих боломжоор тогтмол хангаж ажилладаг. Банк нь Бодь даатгал ХК-тай хамтран ажиллагсдаа эрүүл мэндийн даатгалд хамруулах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулдаг.

Үнэт цаас гаргагч нь Хөдөлмөрийн тухай хууль болон нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах, ажлын байраар хангах ажлыг хэрэгжүүлэн ажилладаг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Богд Банканд хөгжлийн бэрхшээлтэй 3 ажилтан ажиллаж байна.

Богд Банк нь 2021 оноос эхлэн ажилчдадаа банкны хувьцаа эзэмшүүлэх ESOP хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн ба хөтөлбөрийн хүрээнд жил бүрийн нэмэгдэл цалин, үр дүнгийн урамшууллыг Банкны энгийн хувьцаагаар олгох ба 2021 онд энгийн хувьцааныхаа 1 хүртэлх хувийг ажилчдадаа эзэмшүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Банкны ажилчид ажил үүргээ гүйцэтгэхдээ ИТГЭЛ гэж товчлон илэрхийлэгдэх үнэт зүйлсийг ямагт мөрдөж ажилладаг.

*Зураг 6 Банкны ажилчдын үнэт зүйлс*




Үнэт цаас бэлтгэх үеийн байдлаар Банк нь нийт 172 ажилтантай үйл ажиллагаагаа эрхлэн ажиллаж байгаа ба үүнээс 61 хувийг эмэгтэй ажилтан, 39 хувийг эрэгтэй ажилтан тус тус эзэлж байна. Мөн нийт 13 удирдах албан тушаалтай ажилчдаас 31 хувийг эмэгтэй ажилтан, 69 хувийг эрэгтэй ажилтан эзэлж байна.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТГ68966 - 5903858

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHAN
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Банкны нийт ажилтнуудын 13 хувь нь гадаадын нэр бүхий их дээд сургуульд бакалавр болон магистрын зэрэг хамгаалсан, Англи хэлний мэргэжлийн өндөр ур чадвар бүхий ажилтнуудаас бүрдэж байна.

*Зураг 7 Богд Банкны хүний нөөцийн голлох үзүүлэлтүүд*

| Эмэгтэй | Эрэгтэй | Банкинд ажилласан туршлагатай | Гадаадад их, дээд сургууль төгссөн | Магистрын зэрэг хамгаалсан |
|---|---|---|---|---|
| 61% | 39% | 60% | 13% | 20% |

## 9.2. Хамтын ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд сүүлийн үеийн техник технологи, шинэ стандартыг анхлан нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулалт, байгууллага, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан илүү уян хатан нөхцөлөөр санал болгохоор зорьж ажилладаг. Түүнчлэн, гадаад харилцаагаа өргөжүүлэх, худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг идэвхжүүлэх үүднээс олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг ба тэдгээрээс дурдвал:

**Дотоод харилцаа**

Богд Банк нь үйл ажиллагаагаа явуулахдаа төрийн болон хувийн хэвшлийн томоохон байгууллагуудтай хамтран ажилладаг. Мөн харилцагчдадаа түргэн шуурхай, найдвартай бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхийн тулд мэргэжлийн, нэр хүнд бүхий байгууллагуудтай урт хугацааны түншлэл тогтоон стратегийн хүрээнд хамтран ажиллаж байна.

Тухайлбал Банк нь Үндэсний дата төвтэй ХУР, ДАН гэх мэт шинэлэг харилцагчийн цаг зав хэмнэсэн, найдвартай байдлыг бий болгосон үйлчилгээг үзүүлэхийн тулд мэдээлэл солилцох болон нөөц төвөө байршуулан ажиллаж байна. Иргэдэд урт хугацаатай бага хүүтэй орон сууцны зээлийн санхүүжилт олгох, ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэхийн тулд зээлийн багц худалдах, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр Монголын Ипотекийн Корпораци болон Монголбанктай нягт хамтран ажиллаж байна. Мөн Монголбанктай зохицуулагч байгууллагын хүрээнд хяналт шалгалт, тайлан мэдээг цаг тухай бүр нь хүргэн ажиллахын сацуу Жижиг Дунд Үйлдвэр эрхлэгч болон Иргэдийн бизнесийн эргэлтэд шаардлагатай санхүүжилтийн хөтөлбөрийг дэмжин ажилладаг билээ. Төрийн байгууллагууд болох Татварын ерөнхий газартай хуулийн этгээд, иргэдийн татварын төлөлт, орлого төвлөрүүлэх чиглэлээр, Улсын бүртгэлийн ерөнхий газартай улсын тэмдэгтийн хураамж төлөх, ажилтнуудын цалин тавих, цалингийн зээл олгох, Нийгмийн даатгалын ерөнхий газартай өндөр настны тэтгэвэр тэтгэмж болон нийгмийн даатгалын орлого төвлөрүүлэлтийн чиглэлээр тус тус хамтран ажиллаж байна. Банк нь харилцагчдад таатай үнэ цэнэ авчрах бүх л төрлийн хамтын ажиллагааг дэмжин

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
5903858

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

ажилладаг бөгөөд цаашид ч энэ чиглэлээр дотоодын төдийгүй гаднын байгууллагуудтай хамтрах болно.

**Гадаад харилцаа**

Богд Банк нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн гадаад харилцаагаа өргөжүүлэх, худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг идэвхжүүлэх шат дараалсан арга хэмжээг авч байгаа.

Банк нь Олон улсын Хөрөнгө Оруулалтын банк, Росэксим, Транскапитал, Күүкмин зэрэг гаднын мэргэжлийн банкуудтай корреспондент харилцаа тогтоон харилцагчдадаа гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх боломж олгож байгаагаас гадна худалдааны санхүүжилт болон аккредитивийн үйлчилгээ үзүүлж байна.

**Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк /ІІВ/**

Богд Банк нь гадны томоохон байгууллагуудтай хамтарч ажиллаж, Монгол Улс дахь бизнес эрхлэгчдээ дэмжих зорилгоор Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банкнаас худалдааны санхүүжилтийн эх үүсвэр авах шугам батлуулж хамтран ажиллахаар болсон. Уг хамтын ажиллагааг эхлүүлснээр Европын улсууд руу харилцагчдынхаа аккредитивыг шууд хэлбэрээр санхүүжүүлэх, дамжуулах, дунд болон урт хугацаатай хямд эх үүсвэрийг татан төвлөрүүлэх, олон улсын бизнесийн харилцааг дэмжих зэрэг боломжууд нэмэгдэж байгаа бөгөөд Монгол Улсын гадаад худалдааг дэмжихэд чухал нөлөө үзүүлэх юм.

Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк нь олон улсын хамтын ажиллагааны гэрээний дагуу 1971 онд байгуулагдан, хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллаж буй хөрөнгө оруулалтын банк бөгөөд өөрийн гишүүн орнуудын эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлэх төслүүдийг дунд болон урт хугацааны санхүүжилт, эх үүсвэр байршуулах зорилготой, хөрөнгө оруулалтын чиглэлээр 50 жил ажиллаж буй мэргэшсэн байгууллага юм.

**Росэксим**

Оросын Холбооны Улсын томоохон банк болох Росэксимбанктай корреспондент харилцаа тогтоож, худалдааны санхүүжилтийн эх үүсвэр авах шугам батлуулсан байна. Ингэснээр харилцагч болон хамтран ажиллагч байгууллагууд уг эх үүсвэрийн шугамыг ашиглан худалдааны санхүүжилт буюу баталгаа, аккредитивийн үйлчилгээг илүү таатай нөхцөлөөр авах, гадаад гуйвуулгыг илүү хурдан түргэн шуурхай гүйцэтгэх боломжтой юм.

Росэксимбанк нь 1994 онд үүсэн байгуулагдсан ОХУ-ын Засгийн газрын тусгай агентлаг банк бөгөөд Оросын компаниудын экспорт импортыг дэмжих зорилготой ажилладаг байгууллага юм. Тус байгууллагатай хамтран ажилласнаар Монгол Улсын экспорт импортын харилцааг дэмжин, эдийн засаг болон нийгэмд эерэг нөлөө авч ирнэ гэж төлөвлөж байгаа юм.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8766 5903858

СЭХ
2021 оны 11 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01
ИТГЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨГЖЛИЙН БАНК
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

## 9.3. Нийгмийн хариуцлага

Богд Банк нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээс гадна гадаад, дотоодын төслийн зээлийн хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг үр ашгийг нэмэгдүүлэн ажилласаар байна. Банк нь тогтвортой хөгжил, хариуцлагатай үйл ажиллагааг дэмжин ажилладаг.

"Тогтвортой хөгжил" гэдэг нь өнөө үеийн хэрэгцээг хангахдаа ирээдүй үеийн хэрэгцээг хязгаарлахгүй байх явдал бөгөөд эдийн засгийг хөгжүүлэхээс гадна байгалийн нөөцийг үр ашигтайгаар зарцуулж, эрүүл мэнд, нийгмийн асуудлуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. Богд Банк нь "Тогтвортой санхүүжилтийн бодлого"-ыг 2015 оноос хойш хэрэгжүүлэн ажиллаж байсан бөгөөд 2021 оноос уг бодлогыг "Тогтвортой хөгжлийн бодлого" болгон өөрчилснөөр зөвхөн санхүүжилт бус банкны бүх шатны үйл ажиллагааг хамруулан тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Банк нь тогтвортой санхүүжилтийн хүрээнд дараах байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн. Үүнд, агаарын бохирдол болон хөрсний бохирдлыг бууруулах зорилготой Эко Яармаг орон сууцны төсөл, экологийн тэнцвэртэй байдлыг хамгаалах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр зохион байгуулдаг Мод тарих аян, автомашины хөдөлгүүрээс үүдэлтэй агаарын бохирдлын эсрэг зохион бүтээсэн Монголын хамгийн анхны цахилгаан Мон-30 нэртэй автобусны төсөл, Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооноос зохион байгуулдаг "Харж баясахын жаргал" нэртэй өдөрлөгийн ивээн тэтгэгч, өсвөр үеийн хүүхдүүдэд багаас нь санхүүгийн боловсрол олгож мөнгөтэй зөв зүйтэй харьцах соёл хүмүүжлийг олгох зорилгоор жил бүр Их Засаг Олон Улсын Их Сургууль, Ерөнхий боловсролын Монте роза дунд сургууль, Орхон аймгийн ЕБС-ийн 14 дүгээр сургууль, 15 дугаар сургууль, Орос 19 дугаар сургуультай хамтран оюутан, сурагчдад хувийн санхүүгийн боловсролын чиглэлээр лекц хичээлийг хөтөлбөр хуваарийн дагуу тогтмол ордог байна.

Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэж буй зарим ажлуудаас дурдвал:

**ЭКО-ЯАРМАГ Амины орон сууцны төсөл**

*Зураг 8 Амины орон сууцны зураг*

Тус амины орон сууцны төсөл нь агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилготой Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдийг хямд өртөгтэй, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаанаар халдаг, цэвэр ус болон бохирын шийдлийг байгальд ээлтэй эко системээр шийдвэрлэсэн ашигтай талбай ихтэй амины орон сууцны загвараар өөрийн эзэмшлийн газар дээр бариулах боломжтой орон сууцжуулах зорилготой төсөл хөтөлбөр юм. Уг төслийн хүрээнд эхний ээлжийн Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн бөгөөд банкны зүгээс бага хүүтэй урт хугацаатай бөгөөд гол нь өрхийн орлогод тулгуурласан санхүүгийн хүндрэл үүсэхгүйгээр өргөн төлөх нөхцөлтэй санхүүжилтээр хамтран ажилласан.

БОГД БАНК ХХК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТЕ8966 ж 5903858

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHAN
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Орон сууцны хувьд цэвэр ашигтай талбай 49-50 м.кв талбайтай 1 том зочны өрөө, 2 унтлагын өрөө, 1 ариун цэврийн өрөөтэй бөгөөд дундаж ам бүлтэй буюу 3-5 хүн амьдрахад нэн тохиромжтой талбайтай юм. Хөрсний бохирдлыг шийдвэрлэх гол зорилгын хүрээнд бүрэн вакуум септик танк бүхий бохирын систем суурилуулсан нь лагийг 3-5 жилд нэг удаа соруулж ашиглах учир 100 хувь хөрсний бохирдлыг арилгах давуу талтай. Мөн халаалт болон халуун хүйтэн усны системд АТМОР ХХК-ны эко эрчим хүчний хэмнэлттэй шийдлийг ашигласан нь хорт утаа ялгаруулахгүй учир бүрэн эко амины орон сууц болсон юм.

**“Эрдэм” төв, “Манай гэр” Хүүхэд асрамжийн төв**

*Зураг 9 Хүүхэд асрамжийн төв “Эрдэм” төв, “Манай гэр” Хүүхэд асрамжийн төв*

Богд Банк нь нийгмийн сайн сайхан үйлсийн төлөө олон үйлсэд хамтран ажиллахыг зорьдог бөгөөд тэр дундаас хамгийн эрхэм чухал болсон хүүхдүүдийн төлөө хийж буй үйлсэд түлхүү оролцохыг зорьдог байна. Энэ зорилгынхоо хүрээнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хүүхэд асрах төвүүдтэй хамтран ажиллаж эхлээд байна. Тус төвүүд нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэргүй, улсаас ямар нэгэн дэмжлэг авдаггүй бөгөөд үйл ажиллагааны зардал санхүүг зөвхөн өөрсдийн сайн дурын үндсэн дээр гэр бүр хамаатан садны хүрээнд өөрсдийн хүчин чадлаар шийдвэрлэж яваа сайхан сэтгэл хамт олон учраас Богд Банкны хамт олон хамтран ажиллаж эхлээд байна. “Эрдэм” төв, “Манай гэр” нь олон хүүхдүүдийг хүлээн авч амьдрах, сурч боловсрох зэрэг таатай орчин нөхцөлийг бүрдүүлэн гадаад дотоодын их сургуулиудад амжилттай суралцуулж ажил амьдралын гарааг эхлүүлж өгдөг төвүүд юм. Үнэт цаас гаргагч нь Эх үрсийн баяр бүрээр тус төвүүдээр зочлон, хүүхдүүдтэй уулзаж тэдний хүсэл мөрөөдлийн талаар ярилцан урам зориг хайрлахын зэрэгцээ хүүхдүүд өөрсдийн сурсан дуу бүжиг шүлгээ уншиж бяцхан хэмжээний урлагийн тоглолт үзүүлдэг сайхан уламжлалтай юм.

**Өсвөр насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох сургалтууд**

*Зураг 10 Сургалтын зураг*

Богд Банк нь хүүхдүүд рүү чиглэсэн хэд хэдэн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд жил бүр өсвөр насны болон сургуулиа төгсөөд амьдралд хөл тавин өөрийн санхүүгээ удирдах гэж байгаа ерөнхий боловсролын төгсөх ангийн хүүхдүүд болон дунд анги, бага ангийн сурагч нарт зориулан банк, мөнгөний зохистой харьцаа хэрэглээний талаарх хүмүүжлийг суулгах үүднээс танин мэдэхүйн сургалт хичээлийг тогтмол ордог байна. Хамтран ажилладаг сургуулиудаас дурдвал Их Засаг Олон Улсын Их Сургууль, Ерөнхий боловсролын Монте роза дунд сургууль, Орхон аймгийн ЕБС-ийн 14 дүгээр сургууль, 15 дугаар сургууль, Орос 19 дугаар сургуультай хамтран оюутан, сурагчдад хувийн санхүүгийн боловсролын чиглэлээр лекц хичээлийг хөтөлбөр хуваарийн дагуу хамтран ажиллаж байна. Цаашид улам өргөжин хамтран ажиллах сургуулиудын тоог нэмэгдүүлэхийг зорьж байна.

БОГД БАНК ХХК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ 66 5903858

СЗХ БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2021-11-03 БҮРТГЭВ-03

**Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр**

*Зураг 11 Мод тарих үндэсний өдөр*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" хэмээн зарласан билээ. Богд Банк нь нийгмийн хариуцлагын хүрээнд экологийн тэнцвэртэй байдлыг хамгаалах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" жил бүр гачуурт тосгоны Дэнгийд мод, бут сөөг тарьдаг уламжлалтай юм.

Мод тарих арга хэмжээнд банкны ажилтнууд идэвхтэй оролцож, ирээдүйд Богд Банкны нэрэмжит төгөлийг байгуулснаар Улаанбаатар хотын ногоон бүсийн ой бүхий талбайг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулахыг зорьж байна.

**КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажил**

Богд Банк нь дараах ажлуудыг нийгмийн хариуцлагын хүрээнд КОВИД-19 цар тахлаас урьдчилан авч хэрэгжүүлсэн байна:

- Цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд Богд Банк нь Улсын Онцгой Комиссын үйл ажиллагаанд дэмжлэг болгон 2020 онд Банкны зүгээс 20 сая төгрөгийн мөнгөн хандивыг олгон хамтран ажилласан.
- Богд Банкны Захиргаа, хүний нөөцийн хэлтэс нь ажиллагсадаа өөрийн хүсэлтийн дагуу Синофарм болон Спутник вакцинд хамруулаад байгаа бөгөөд зөвхөн ажилтан гэлтгүй тэдгээрийн гэр бүлийн гишүүд мөн Богд банкны харилцагчдыг тус тус вакцинжуулсан байна.

**Богд Банкны нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлууд**

- Богд Банк нь ажилтнуудаа даатгалд хамруулсан байдаг бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулиар хүлээсэн үүрэг, мөн нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар ханган ажиллуулдаг байна.
- Үнэт цаас гаргагч нь Бодь Даатгал ХК-тай хамтран ажиллагсдаа эрүүл мэндийн даатгалд хамруулах урьдчилан сэргийлэх ажлыг 2020 оноос хойш хэрэгжүүлж байна.
- Богд Банк нь хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсдыг ажиллуулах ажлын байраар хангах ажлыг хэрэгжүүлэн ажилладаг. Одоогоор Богд Банканд хөгжлийн бэрхшээлтэй 3 ажилтан ажиллаж байна.

## 9.4. Үнэт цаас гаргагчийн байгаль орчин, нийгэм болон засаглалын үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь ESG шалгуур буюу Байгаль орчин, нийгэм болон засаглалын шалгуурын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. ESG шалгуур нь өөр хоорондоо уялдаа

БОГД БАНК ХХК БОГД БАНК BOGD BANK УЛААНБААТАР ХОТ

холбоотой байгаль орчин /environment/, нийгэм /society/ болон засаглал /governance/ гэх ойлголтуудаас бүрддэг.

- "E" буюу байгаль орчин гэсэн шалгуур нь компанийн байгаль орчинтой хэрхэн харилцаж буйг;
- "S" буюу нийгэм гэсэн шалгуур нь компанийн нийгэмдээ үзүүлэх үр нөлөө, нийгмийн олон төрлийн бүлэгтэй харилцах харилцааг;
- "G" буюу засаглал нь тухайн компанийн дотоод тогтолцоо болон хууль журамд хэрхэн нийцэж ажилладаг, хяналтын систем, ажилчидтайгаа хэрхэн харилцдаг зэргийг тус тус харуулдаг.

Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Богд Банк нь өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан уур амьсгалын тэнцвэрт хүрэхэд шаардагдаж буй эдийн засгийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхээс гадна дотоод үйл ажиллагаагаа байгаль, нийгэмд ээлтэй болгохоор зорин ажиллаж байна. Банкны баримталж буй стратегийн үндсэн чиглэл нь тогтвортой бизнесийн үйл ажиллагааг явуулах, нийгэм, байгаль орчны асуудлуудад анхаарал хандуулах, тогтвортой, сэтгэл ханамжтай ажлын байрыг бий болгох юм.

Богд Банк нь ногоон санхүүжилтийг дэмждэг эко банкны хувьд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Зээлийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шинжээчийн үнэлгээ хийдэг.
- Тогтвортой хөгжлийн цогц сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт борлуулалтын болон төв албаны ажиллагсдаа тогтвортой хөгжил, ногоон санхүүжилт, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ чиглэлээр сургалт зохион байгуулдаг.
- Ногоон зээлийн хөгжүүлэлт, тайлагналыг хэрэгжүүлэн ажилладаг.
- "Жендерийн тэгш байдлын бодлого"-ыг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд ажлын байранд жендерийн эрх тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлснээр ажилтан бүр банкны үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох, байгууллагын үр ашиг болон хөгжлийн бодлогод тэнцүү ашиг хүртэх боломж улам нээлттэй болсон.
- Ногоон зээлийн бүтээгдэхүүн, төслийн зээл болон бусад нийгэм эдийн засагт эерэг нөлөөтэй төсөл хөтөлбөрийг дэмжин оролцдог.

### 9.4.1. Байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа

**Богд Банк нь Уур амьсгалын ногоон сангийн үйл ажиллагааны хүрээнд Монголын ногоон санхүүгийн корпорацийн үүсгэн байгуулагчдын нэг болсон**

Богд Банк нь ногоон зээл, тогтвортой санхүүжилтийн бодлогыг дэмжин ажилладаг бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 5 сарын 6-ны өдрийн 21/09 өдрийн тоот шийдвэрээр "Монголын Ногоон Санхүүгийн Корпораци"-ийн төсөлд хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн.

Уур амьсгалын ногоон сан нь анх 2015 онд НҮБ-ын дэргэд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор байгуулагдсан Олон улсын санхүүжүүлэгч байгууллага бөгөөд энэхүү төсөлд хамрагдах зорилгоор Монголын

СЭХ
2021 .11.10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Банкны Холбоо болон Засгийн Газрын зүгээс "Монголын Ногоон Санхүүгийн Корпораци"-г байгуулах төслийг 2016 онд эхлүүлсэн. Энэхүү төсөл нь Олон улсын байгууллага, Засгийн газар болон Арилжааны банкуудын хөрөнгө оруулалттай байгууллага бөгөөд эрчим хүчний хэмнэлт, байгаль орчны чиглэлээр хөнгөлөлттэй төслийн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Шинээр байгуулагдаж буй Монгол Ногоон санхүүжилтийн корпораци нь дараах чиглэлээр санхүүжилт олгоно. Үүнд:

- Нийт санхүүжилтийн 20 хувийг ногоон хэрэглээний зээлд;
- нийт санхүүжилтийн 20 хувийг ногоон орон сууцны зээлд;
- Нийт санхүүжилтийн 60 хувийг ногоон бизнесийн зээлд тус тус зарцуулахаар төлөвлөсөн.

**Богд Банк нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны хүрээнд Эко-Яармаг амины орон сууцны төслийг санхүүжүүлсэн**

Эко Яармаг төсөл нь агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилготой Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдийг хямд өртөгтэй, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаанаар халдаг, цэвэр ус болон бохирын шийдлийг байгальд ээлтэй эко системээр шийдвэрлэсэн ашигтай талбай ихтэй амины орон сууцны загвараар өөрийн эзэмшлийн газар дээр бариулах боломжтой орон сууцжуулах зорилготой төсөл хөтөлбөр юм. Уг төслийн хүрээнд Богд банкнаас бага хүүтэй урт хугацаатай уян хатан төлбөрийн нөхцөлтэй санхүүжилтээр хамтран ажилласан.

**Богд Банк нь байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд жил бүр мод тарих арга хэмжээнд идэвхтэй оролцдог**

Богд Банк нь нийгмийн хариуцлагын хүрээнд экологийн тэнцвэртэй байдлыг хамгаалах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" жил бүр гачуурт тосгоны Дэнгийд мод, бут сөөг таридаг уламжлалтай.

**Богд Банк нь тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтэд онцгой ач холбогдол өгөн ажилладаг**

2019 оны 12 сард Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Хадгаламжийн Даатгалын Корпорациас хамтарсан тушаал гаргаж "Монгол Улсын Ногоон Таксономи"-ийг баталсан. Ногоон Таксономи нь байгаль орчин, нийгэмд ээлтэй ногоон үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид Ногоон Таксономийг ашиглан ногоон зээл, төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлох боломжтой болсон. Богд Банк нь энэхүү үзүүлэлт, стандартыг үндэслэн Ногоон зээлийн бүтээгдэхүүнийг гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Банк нь тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтэд онцгой ач холбогдол өгөн ажиллаж байгаа бөгөөд 2021 онд уг үйл ажиллагааг хариуцсан тусгайлсан нэгж болох Эко банкны албыг байгуулсан бөгөөд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна:

БОГД БАНК ХХК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
2021-11-03
БҮРТГЭВ-03

- Банкны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн менежмент Банканд хог хаягдлыг ангилах дотоод системийг нэвтрүүлж мөн эрчим хүч, усны хэрэглээг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Ногоон зээлийн хөгжүүлэлт, тайлагнал Ногоон зээлийн багцыг нэмэгдүүлж, Монгол Улсын Ногоон Таксономийн дагуу Монголбанканд тайлагнах;
- Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо, Монголбанк, Олон Улсын Санхүүгийн Корпорациас хэрэгжүүлсэн Тогтвортой Санхүүжилтийн үнэлгээг хийлгэж үнэлгээгээ ахиулах;
- НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр Санхүүгийн Санаачилгаас гаргасан "Хариуцлагатай Банкны Зарчмууд"-ыг хэрэгжүүлэгч банкуудын нэг болох;
- Ногоон зээлийн бүтээгдэхүүнийг гаргах, энэ чиглэлээр 2-3 бүтээгдэхүүнтэй болох гэх мэт олон ажлын төлөвлөн ажиллаж байна.

### 9.4.2. Нийгэмтэй холбоотой үйл ажиллагаа

**Богд Банк нь дараах үйл ажиллагааг нийгмийн үзүүлэлтийн хүрээнд авч хэрэгжүүлдэг байна.**

- Үнэт цаас гаргагч нь нийгмийн хариуцлагын хүрээнд бүх ажиллагсдадаа гэнэтийн ослын даатгалд хамруулсан;
- Хөдөлмөрийн тухай хуулиар хүлээсэн үүрэг, мөн нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар ханган ажиллуулдаг. Одоогоор Богд Банканд хөгжлийн бэрхшээлтэй 3 ажилтан ажиллаж байна.
- Богд Банкны Захиргаа, хүний нөөцийн хэлтэс нь ажиллагсдадаа өөрийн хүсэлтийн дагуу Синофарм болон Спутник вакцинд хамруулаад байгаа бөгөөд зөвхөн ажилтан гэлтгүй тэдгээрийн гэр бүлийн гишүүд мөн Богд банкны харилцагчдыг тус тус вакцинжуулсан байна.
- Богд Банк нь жендэрийн эрх тэгш байдлыг дэмжин ажилладаг. Үнэт цаас гаргагчийн нийт ажилтнуудын 61 хувийг эмэгтэй ажилтан, 39 хувийг эрэгтэй ажилтан тус тус эзэлж байна.

### 9.4.3. Засаглалтай холбоотой үйл ажиллагаа

Богд Банк нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн иргэдийн, олон нийтийн банк болох зорилт тавин ажиллаж ирсэн. Үнэт цаас гаргагч нь Монголын хамгийн анхны олон нийтэд нээлттэй хувьцаат банк болох ажлыг эхлүүлээд байна. Нээлттэй банк болсноор хувьцаа эзэмшлийн төвлөрөл буурч, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Банкны толгой компани болон зэргэлдээ компаниуд нь харилцан хараат бус нэгдмэл хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах зарчмыг баримталдаг. Толгой компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь Банкны нэгдлийн хэмжээнд зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор ерөнхий стратеги боловсруулж, салбар компаниудад зохистой засаглалын оновчтой бүтцийг нэвтрүүлж, толгой болон охин компаниудад зориулсан дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлдэг. Богд Банк болон түүний нэгдэлд хамаарагдах охин, хараат компаниудын хооронд хийгдсэн гэрээ хэлцэл нь ТУЗ-өөс баталсан бодлогын дагуу хараат бус байдлаар хийгддэг.

БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 • 5903858

СЗХ
ХҮРТГЭВ
2021 -11- 03
ХҮРТГЭВ-03

Богд Банкны ТУЗ нь Банканд зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд Компанийн тухай болон Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах засаглалын бодлогыг барьж ажилладаг:

- Банкны Гүйцэтгэх удирдлагад хяналт тавих, ажлын үр дүнгийн тайланг улиралд нэгээс доошгүй удаа авч хэлэлцэх, хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах;
- Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон нэгдмэл сонирхолтой этгээдийн эрх ашгийг хамгаалах;
- Банкны бодлого, стратеги, эрсдэл даах сонирхлыг тодорхойлж, үр ашигтай шийдвэр гаргах;
- Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, банкны бүтцийн өөрчлөлт зэрэг гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;
- ТУЗ-өөс Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээн дээрх үүрэг, хариуцлага, үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах тогтолцоог бүрэн тусгаж, гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэх;
- Гүйцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, урт хугацааны хэтийн зорилго, стратеги төлөвлөгөө, ёс зүйн хэм хэмжээ болон гэрээнд заасан үүргийн биелэлт зэрэгтэй уялдуулан шийдвэрлэх;
- Хууль тогтоомж болон банкны дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай, үнэнч шударгаар гүйцэтгэж, чандлан сахих;
- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас банкны өмнө хүлээсэн үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд саад тотгор үзүүлэх үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;
- Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад заасан шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж, хөндлөнгийн аудит хийлгэх;
- Банкны дотоод аудитын асуудал эрхэлсэн нэгжээс хийсэн шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг цаг тухайд нь авч хэлэлцэн, зохистой засаглал болон дотоод хяналтын тогтолцоог сайжруулах талаар Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцох.

# АРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ТУЗ, УДИРДЛАГА БОЛОН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН МЭДЭЭЛЭЛ

## 10.1. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн хувьцааны 91.32 хувийг Бодь Капитал ХХК, 8.68 хувийг Богд Капитал Инвестмент ХХК тус тус эзэмшдэг болно. Богд Банкны Гүйцэтгэх захирлаар Г.Саруул 2014 оны 11 сарын 17-ноос хойш томилогдон ажиллаж байна.

Банк нь 2020 оны 8 сарын 19-ны өдөр эцсийн өмчлөгч 1 иргэний мэдээллийг улсын бүртгэлд зохих ёсоор бүртгүүлсэн байх бөгөөд Л.Болд хувьцаа эзэмшигчийг эцсийн өмчлөгчөөр хуулийн этгээдийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэсэн байна.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 - 5903858

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар хувьцаа эзэмшлийн хувьд дараах бүтэцтэй бөгөөд тус бүр Банкны тухай хуулийн 3.1.12-т тодорхойлсон "нөлөө бүхий хувьцаа эзэмшигч"[14] юм.

*Зураг 12 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц*

### 10.1.1. Бодь капитал ХХК-ийн тухай

*Хүснэгт 66 Бодь капитал ХХК-ийн мэдээлэл*

| | |
|---|---|
| **Компанийн нэр:** | Бодь капитал ХХК |
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9011114092 |
| **Регистрийн дугаар:** | 5166586 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Гадаад худалдаа |
| **Хаяг:** | Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бодь Цамхаг, 4-р давхар |

Бодь Капитал ХХК нь 2007 оны 9 сарын 20-ны өдөр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр гадаад худалдаа, бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой байгуулагдсан. Тус компани нь байгуулагдсан хугацаанаасаа хойш үйл ажиллагаа явуулж ирсэн ба гүйцэтгэх захирлаар Л.Болдхуяг ажиллаж байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Бодь капитал ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

*Хүснэгт 67 Бодь капитал ХХК-ийн хувьцаа эзэмшигчид*

| Хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо | Нэрлэсэн үнэ (мянган төгрөг) | Эзэмшлийн хувь (%) |
|---|---|---|---|
| Л.Болд | 2,102 | 33,634,102 | 73.65% |
| Л.Болдхуяг | 752 | 12,032,752 | 26.35% |
| **Нийт** | **2,854** | **45,666,854** | **100.00%** |

[14] Банкны "нөлөө бүхий хувьцаа эзэмшигч" гэж банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг данган болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд, тэдгээрийн эцсийн өмчлөгч хүн, эсхүл банкны бодлого, шийдвэр болон удирдлагад нөлөөлөхүйц хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч хүнийг хэлнэ.

СЗХ
БҮРТГЭВ
№ 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

### 10.1.2. Богд Капитал Инвестмент ХХК-ийн тухай

*Хүснэгт 68 Богд Капитал Инвестмент ХХК-ийн мэдээлэл*

| | |
|---|---|
| **Компанийн нэр:** | Богд Капитал Инвестмент ХХК |
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9011713073 |
| **Регистрийн дугаар:** | 6250262 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Гадаад худалдаа |
| **Хаяг:** | Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бодь Цамхаг, 4-р давхар |

Богд Капитал Инвестмент ХХК нь 2017 оны 11 сарын 27-ны өдөр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр гадаад худалдаа, бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой байгуулагдсан. Тус компани нь байгуулагдсан цагаасаа хойш үйл ажиллагаа явуулж ирсэн ба гүйцэтгэх захирлаар Б.Билэгт ажиллаж байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Богд Капитал Инвестмент ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

*Хүснэгт 69 Богд Капитал Инвестмент ХХК-ийн хувьцаа эзэмшигчид*

| Хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо | Нэрлэсэн үнэ (мянган төгрөг) | Эзэмшлийн хувь (%) |
|---|---|---|---|
| Л.Болдхуяг | 2,193,000 | 2,193,000 | 51.00% |
| П.Ганбаатар | 2,107,000 | 2,107,000 | 49.00% |
| **Нийт** | **4,300,000** | **4,300,000** | **100.00%** |

## 10.2. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл

### 10.2.1. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар

Үнэт цаас гаргагчийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн дүрмээр Богд Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 50 тэрбум төгрөг байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Богд Банкны хувьцаа эзэмшигчид нь Бодь Капитал ХХК, Богд Капитал Инвестмент ХХК гэсэн хоёр хуулийн этгээд байна.

*Хүснэгт 70 Богд Банкны үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаарх хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ*

| № | Хувьцаа эзэмшигч иргэн болон хуулийн этгээдийн нэр | Гаргасан хувьцаа | | | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Ширхэг | Нэрлэсэн үнэ | Нийт дүн (мянган төгрөг) | |
| 1 | Бодь Капитал ХХК | 45,661,000 | 1,000 | 45,661,000 | 91.32% |
| 2 | Богд Капитал Инвестмент ХХК | 4,339,000 | 1,000 | 4,339,000 | 8.68% |
| **Нийт** | | **50,000,000** | | **50,000,000** | **100.00%** |

БОГД БАНК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 .11.10
БҮРТГЭВ
№ 01
ҮНДЭСНИЙ ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

### 10.2.2. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө олон нийтэд хувьцаагаа санал болгосны дараах байдлаар

Үнэт цаас гаргагч нь нэмж үнэт цаас гаргахаас өмнө 50,000,000 ширхэг зарласан хувьцаатай, нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000,000 ширхэг гаргасан энгийн хувьцааатай, 50 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Богд Банк нь нийт хувьцааны 20.0 хувийг нийт санал болгосноор нийт 62,500,000 ширхэг гаргасан энгийн хувьцаатай болно.

*Хүснэгт 71 IPO дараах Богд Банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц*

| № | Хувьцаа эзэмшигч иргэн болон хуулийн этгээдийн нэр | Гаргасан хувьцаа | | | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Ширхэг | Нэрлэсэн үнэ | Нийт дүн (мянган төгрөг) | |
| 1 | Бодь капитал ХХК | 45,661,000 | 1,000 | 45,661,000 | 73.06% |
| 2 | Богд Капитал Инвестмент ХХК | 4,339,000 | 1,000 | 4,339,000 | 6.94% |
| 3 | Олон нийтэд | 12,500,000 | 1,000 | 12,500,000 | 20.00% |
| | **Нийт** | **62,500,000** | | **62,500,000** | **100.00%** |

## 10.3. Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээд

### 10.3.1. Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн мэдээлэл

Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад "Холбогдох этгээд"-д банкны нэгдлийн оролцогч, банк, банкны нэгдлийн оролцогчийн хувьцааны тав ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувь хүн, хуулийн этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд, хувьцааных нь тав болон түүнээс дээш хувийг банк эзэмшдэг хуулийн этгээд, хувьцааных тав болон түүнээс дээш хувийг банкны эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд эзэмшдэг хуулийн этгээд, банк, банкны нэгдлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд, банкны эрхлэх үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг банктай нэгдмэл сонирхолтой этгээд, эрх бүхий албан тушаалтныхнь чиг үүргийг банкны эрх бүхий албан тушаалтан давхар гүйцэтгэдэг хуулийн этгээд, банкны саналын эрхтэй хувьцааны арав болон түүнээс дээш хувийг эрх бүхий албан тушаалтан нь эзэмшдэг хуулийн этгээд, нэгдмэл сонирхолтой бусад хувь хүн, хуулийн этгээд, Монголбанкнаас холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд зэрэг орно.

Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдэд хамаарах хуулийн этгээдүүдийн мэдээллийг доорх жагсаалтаар оруулаа. Үүнд:

*Хүснэгт 72 Холбогдох этгээдийн ерөнхий мэдээлэл*

| № | Холбогдох этгээдийн мэдээлэл | Регистрийн дугаар |
|---|---|---|
| 1 | Бодь Капитал ХХК | 5166586 |
| 2 | Богд Капитал Инвестмент ХХК | 6250262 |
| 3 | Бодь Даатгал ХХК | 2088606 |

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 ... 3003838
127
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
БҮРТГЭВ-03

| | | |
|---|---|---|
| 4 | Бодь ХХК | 2089904 |
| 5 | Бодь Цамхаг ХХК | 2789752 |
| 6 | Бодь Системс ХХК | 5854717 |
| 7 | Бодь инвест ҮЦК ХХК | 5781574 |
| 8 | Бодь партнерс ХХК | 5883814 |
| 9 | Би Би Солюшн ХХК | 6029582 |
| 10 | Бодь констракшн ХХК | 5884306 |
| 11 | Хаан поло клуб ГҮТББ | 8004811 |
| 12 | Эйч Ди Ди Жи ХХК | 5537746 |
| 13 | Герман секьюрити технолоожис ХХК | 6275648 |
| 14 | Конэтсвисс ХХК | 5513944 |
| 15 | Тауэр телевиз ХХК | 5817978 |
| 16 | Дайчи эйжинси ХХК | 6396909 |
| 17 | Ардчилсан хүчний холбоо ГҮТББ | 8018146 |
| 18 | Богдгрупп ХХК | 5903904 |
| 19 | Герман-Монголын Бизнес Эрхлэгчдийн Холбоо ТББ | 1014765 |
| 20 | Монгол-Солонгосын эдийн засгийн форум ТББ | 8142467 |
| 21 | Монгол ойрх дорнодын эдийн засгийн хамтын ажиллагааны чуулган НҮТББ | 8179239 |
| 22 | Монгол-Хятадын санхүү эдийн засгийн хамтын ажиллагааны чуулган ГҮТББ | 8231109 |
| 23 | Монголын ардчилалын үнэт зүйлс сан | 8165564 |
| 24 | Монголын кино телевизийн продюсеруудын нийгэмлэг НҮТББ | 8244375 |
| 25 | Монголын хөрөнгийн зах зээлийн зөвлөл ГҮТББ | 8177139 |
| 26 | Хан уул дэвшил сан | 8192553 |
| 27 | Шинэ монголын төлөө санаачилга НҮТББ | 8231958 |
| 28 | Дексонпатнерс ХХК | 5313643 |
| 31 | С.Лувсанвандан сан | 8201579 |
| 32 | СОСНТМ ХХК | 5313643 |
| 32 | Эм жи вүүд ХХК | 2676869 |

## 10.3.2. Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдэд олгосон зээлийн мэдээлэл

*Хүснэгт 73 Холбогдох этгээдэд олгосон зээлийн мэдээлэл*

| Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд) | 2018 | | 2019 | | 2020 | |
|---|---|---|---|---|---|---|
| | Үлдэгдэл дүн | Өөрийн хөрөнгөд эзлэх хувь (%) | Үлдэгдэл дүн (сая төгрөг) | Өөрийн хөрөнгөд эзлэх хувь | Үлдэгдэл дүн (сая төгрөг) | Өөрийн хөрөнгөд эзлэх хувь (%) |
| **Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтгах тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)** | | | | | | |
| Банкны хувьцаа эзэмшигч | 500.00 | 0.96% | - | 0.00% | 1,737.11 | 2.83% |
| Банкны эрх бүхий албан тушаалтан | 286.67 | 0.55% | 138.92 | 0.25% | 236.20 | 0.38% |
| Банкны бусад холбогдох этгээд | 1,990.15 | 3.83% | 2,636.34 | 4.81% | 2,800.00 | 4.56% |
| **Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй** | | | | | | |

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 5903858

СЗХ
БҮРТГЭЛ
БҮРТГЭВ-03
2021 -11- 03

| адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй) | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Банкны нийт хувьцаа эзэмшигч | 500.00 | 0.96% | - | 0.00% | 1,737.11 | 2.83% |
| Банкны эрх бүхий албан тушаалтан | 364.34 | 0.70% | 328.01 | 0.60% | 541.62 | 0.88% |
| Банкны эрх бүхий албан тушаалтан | 2,478.01 | 4.77% | 5,579.99 | 10.19% | 5,814.36 | 9.46% |

## 10.4. Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

### 10.4.1. Үнэт цаас эзэмшигчийн эрх,үүрэг

**Үнэт цаас эзэмшигчийн эрх**

Үнэт цаас эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу энгийн хувьцаа эзэмшигчийн хувьд дараах эрх эдлэхээс гадна өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжих, захиран зарцуулах, компанийн дүрэмд заасан бусад эрхийг эдэлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах, шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар Компанийн ТУЗ-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;
- Компани татан буугдах үед Компанийн тухай хуульд заасан журмын дагуу Компанийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг хуваалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- Хувьцаат Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах;

Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлд зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, шинэчлэн найруулсан, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийсэн гэх зэрэг тохиолдлуудад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр Компанийн дүрэмд заасан үндэслэл, журмаар өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй.

**Үнэт цаас эзэмшигчийн үүрэг**

Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 . 11 . сар 10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-11-03
БҮРТГЭВ-03

- Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдэх байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтлөх этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх үүрэг хүлээнэ;
- Хувьцаа эзэмшигч нь компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, компанийн ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийхийг хориглоно;
- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг.

### 10.4.2. Үнэт цаас гаргагчийн үүрэг

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу дараах нийтлэг үүрэгтэй байна. Үүнд:

- Үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэн гаргах;
- Үнэт цаасны арилжаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд СЗХ-нд хүргэх, нийтэд мэдээлэх;
- Компанийн тухай хуульд зааснаас доошгүй тооны хараат бус гишүүнтэй байх;
- Тохиромжтой этгээдийг эрх бүхий албан тушаалтнаар томилох буюу сонгох;
- Үнэт цаасны танилцуулгад заасан төслийн хэрэгжилт өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх;
- Хагас жилийн болон СЗХ-нд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд СЗХ болон Биржид хүргүүлэх;
- Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг СЗХ-ноос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх.

### 10.4.3. Үнэт цаас гаргагч болон эзэмшигчийн хариуцлага

Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Компани болон Үнэт цаас эзэмшигч нь дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ;
- Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй;
- Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ;
- Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна;
- Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

БОГД БАНК
BOGD BANK
5903858

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

## 10.5. Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого

Богд Банкны ногдол ашгийн бодлогын баримт бичиг нь 2021 оны 5 сарын 20-ны 21/57 тоот Ногдол ашгийн журам батлах тухай ТУЗ-ийн тогтоолын дагуу Компанийн тухай хууль, дүрэм болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн боловсруулагдсан байна.

"Богд Банк" ХХК-ийн ногдол ашгийн журам нь ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргах, хуваарилах ногдол ашгийн хэмжээ, хуваарилах нөхцөл журмыг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Банк нь Банкны тухай хуулийн 47 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь заалт, Ногдол ашгийн журмын 3 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна. Хэрэв хуваарилах бол нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татвар төлсний дараах цэвэр ашгийн хэмжээ, банкны богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тогтооно. Банкны ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Хэрэв Банк нь тухайн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байгаа үндэслэл, шалтгаан, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар хэсэгтээ тусгасан байна. Ногдол ашгийн журмыг хавсралтаас харна уу.

## 10.6. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, компанийн засаглал

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн байгууллага, нэгжийн бүтэц зохион байгуулалт дараах байдалтай байна:

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
MCC

СЗХ
2021 .11. 10
БҮРТГЭЛ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Зураг 13 Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт*

**БОГД БАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**



### 10.6.1. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Эрсдэлийн Удирдлага, Аудит, Урамшуулал, Хүний нөөцийн гэх дөрвөн хорооны үйл ажиллагааг хариуцан удирддаг. ТУЗ нь энэхүү үүргээ Богд Банкны стратеги төлөвлөгөө, удирдлагын бодлого, жилийн төсөв, чухал шийдвэр, хэлцлийг хянах, хэлэлцэх, батлах, түүнчлэн үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй удирдах албан тушаалтнуудад хяналт тавих замаар биелүүлэхийг зорьж ажилладаг. Мөн түүнчлэн, банкны удирдлага, зохион байгуулалтын ерөнхий бүтэц захиргааны зардлын хэмжээг тогтоох, гүйцэтгэх захирлыг Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр томилох, түүнийг ажлаас түдгэлзүүлэх, чөлөөлөх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, олгох цалин шагнал урамшуулал, үүрэг хариуцлагын хэмжээг тогтоох, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ХЭХ-аар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох, банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж батлуулах зэрэг эрхтэй.

Банк болон ТУЗ-ийн гишүүн хоорондын харилцааг Иргэний хуулийг удирдлага болгон, гэрээгээр зохицуулдаг ба тус гэрээнд Банкны нэрийн өмнөөс, түүнийг төлөөлөн ХЭХ-аас итгэмжлэгдэн томилогдсон этгээд гарын үсэг зурна.

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтад тусгагдсан шаардлагыг хангасан хувь хүн байх ба ТУЗ-ийн гишүүн нь өрсөлдөгч

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

компанийн хувь нийлүүлэгч, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, ажилтан байж болохгүй.

Үнэт цаас гаргах үеийн байдлаар Богд Банкны ТУЗ нь 4 ердийн болон 2 хараат бус гишүүдээс бүрдсэн нийт 6 гишүүн байна. ТУЗ-ийн гишүүд нь Банкны тухай хуулийн 32, 33 дугаар зүйл болон Монголбанкнаас тавигдсан шалгуурыг хангасан байна. ТУЗ-ийн 6 гишүүн нь санхүүгийн мэргэжилтэй бөгөөд банк, санхүүгийн салбарт хамгийн багадаа 15 жил ажилласан туршлагатай байна. ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүнээр ажилладаг. ТУЗ-ийн гишүүд бүрийн бүрэн эрхийн хугацаа дараагийн жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд гишүүдийг улируулан сонгож болохоор зохицуулсан байна.

ТУЗ нь үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар дараах бүрэлдэхүүнтэй байна.

*Хүснэгт 74 Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл*

| № | Нэр | Харьяал | Эрхэлж байгаа ажил | Томилогдсон | Төлөв |
|---|---|---|---|---|---|
| 1 | Л.Болдхуяг | Монгол | Богд Банкны ТУЗ-ийн дарга | 2014.10.31 | Ердийн |
| 2 | Г.Саруул | Монгол | ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал | 2014.10.31 | Ердийн |
| 3 | Жан Торстен | Герман | ТУЗ-ийн гишүүн | 2018.12.31 | Ердийн |
| 4 | Эллиот Рован Аукланд | Их Британи | ОУ-ын Х/О Банкны Бизнес төлөвлөлт, санхүүгийн загварчлалын албаны дарга | 2021.02.15 | Ердийн |
| 5 | Ж.Нарантуяа | Монгол | ОУ-ын Санхүүгийн Корпорацийн зөвлөх | 2014.10.31 | Хараат |
| 6 | Д.Моломжамц | Монгол | ОУ-ын Хөрөнгө Оруулалтын Банкны зөвлөх | 2018.05.09 | Хараат бус |
| 7 | Р.Нямцэрэн | Монгол | Богд Банкны ахлах хуульч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | 2020.03.02 | Нарийн бичгийн |

СЭХ
БҮРТГЭЛ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Зураг 14 ТУЗ-ийн дарга Лувсанвандан Болдхуяг*

**Лувсанвандан БОЛДХУЯГ**
*ТУЗ-ийн дарга, Бодь группийн үүсгэн байгуулагч*

**Мэргэжил:** Эдийн засагч

**Боловсрол:** 1974-1984 онд Монгол Улс, Улаанбаатар хот, Бүрэн дунд боловсрол
1984-1985 онд Монгол Улсын Их Сургуулийн Герман хэлний анги
1985-1986 онд Унгар, Карл Марксын Их сургууль, түүх судлаач
1986-1991 онд Герман, Гумбольдтын Их сургууль, түүх судлаач
1991-1995 онд Герман улсын өмч хувьчлалын газарт судалгаа шинжилгээний ажил, их сургуулийн дадлага

**Ажилласан туршлага:** 1995 оноос Герман улс дахь Монголиа Хаус Файненшиал Сервисес компанийн захирал, 1996-2000 оны хооронд Голомт Банкны ТУЗ-ийн дарга, Бодь Интернэшнл группийн Ерөнхийлөгч, 2000 оноос Бодь Интернэшл компанийн Ерөнхий захирал, Бодь Даатгал компанийн ерөнхийлөгч, Голомт Банкны ТУЗ-ийн гишүүн, СОС Интернэшнл Медика Монголиа эмнэлгийн удирдах зөвлөлийн гишүүн, Доктор. Профессор Лувсанвандан сангийн тэргүүн, Монголын Бизнес Эдийн засгийн дээд сургуулийн хүндэт доктор, Монголын гандболын холбооны дэд ерөнхийлөгч, Монголын Үйлдвэрлэгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн ,2005 оноос Бодь Группын ерөнхийлөгч, Шведийн Вант улс дахь Өргөмжит Ерөнхий Консул, 2004-2007 оны хооронд Голомт банкны ТУЗ-ийн дарга, 2009 онд Бодь Даатгал ХХК-ийн Ерөнхийлөгч, Бодь Группын Ерөнхий захирал, Шведийн Вант улсын Өргөмжит Ерөнхий Консул, Монголын Поло Холбооны Ерөнхийлөгч, Хаан Поло Клубыг үүсгэн байгуулагч, 2011 онд Бодь Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Шведийн Вант улсын Өргөмжит Ерөнхий Консул, 2014 онд Бодь Группын ерөнхийлөгч, Лувсанвандан сангийн тэргүүн, Лувсанвандан Арт Галерейг үүсгэн байгуулагч

**Компанийн засаглалын сургалт** КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2014 оны 9 сарын 6-нд гэрчилгээ авсан.
**Гэрчилгээний дугаар:** 1030022

*Зураг 15 Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн Ганбаатар Саруул*

**Ганбаатар САРУУЛ**
*Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн*

**Мэргэжил:** Эдийн засагч

**Боловсрол:** 1999-2003 онд АНУ, Лоёола их сургууль, эдийн засагч

**Ажилласан туршлага:** АМП Фьючерс компанийн Ази, Орос, ТУХН-ийн орнуудыг хариуцсан Газрын захирал, 2010 оноос Сангийн яамны зөвлөх, 2011 оноос Монголын Хөрөнгийн Биржийн Тэргүүн дэд захирал, валютын захын үүсмэл хэрэгслүүд хариуцсан Ахлах трейдер, Розентал Коллинс групп болон Мобиум Ипотекийн группд Ахлах банкир, Бодь группийн Гүйцэтгэх захирал, Бодь даатгал ХХК-ийн ТУЗ-ийн дарга

**Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байдал:** КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2014 оны 9 сарын 6-нд гэрчилгээ авсан.
**Гэрчилгээний дугаар:** 1030021

*Зураг 16 ТУЗ-ийн гишүүн Жан Торстэн Дазер*

**ЖАН ТОРСТЭН Дазер**
*ТУЗ-ийн гишүүн*

**Мэргэжил:** Санхүү эдийн засгийн магистр, эдийн засагч

**Боловсрол:** 1981-1983 онд Герман, Хамбургын Их сургууль, Эдийн засгийн бакалавр
1983-1985 онд Швейцар, Ст.Галлены коллеж, Санхүү эдийн засгийн магистр

**Ажилласан туршлага:** Швейцар Улсын Солюшн Партнерс Глобал ХК үүсгэн байгуулагч, Таск Мерчант Капитал ХХК гүйцэтгэх захирал, Бизнесийн шинжилгээ Стратегийн Свисс партнерс ХК хөрөнгө оруулалтын банкны удирдах зөвлөлийн гишүүн, Жэй Пи Морган партнер, Швейцар Улсын дижитал үйлчилгээний Глобра компаний ТУЗ-ийн гишүүн, Герсон Лехрман Группийн шинжээч, Бодмер капитал ХК удирдах зөвлөлийн гишүүн

**Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байдал:** КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2021 оны 4 сарын 23-нд гэрчилгээ авсан.
**Гэрчилгээний дугаар:** 0521119

СЗХ
2021 он 11 сар 10
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Зураг 17 ТУЗ-ийн гишүүн Эллиот Рован Аукланд*

**ЭЛЛИОТ РОВАН Аукланд**
*ТУЗ-ийн гишүүн*

**Мэргэжил:** CIMA, Санхүүгийн удирдлага

**Боловсрол:** 1996-2004 онд Их Британи Улс, Оксфордын Их сургууль, Эдийн засгийн бакалавр

**Ажилласан туршлага:** 2006-2015 оны хооронд Ти Эйч Си Партнерс-т шинжээч, 2015-2017 оны хооронд Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкны Зөвлөх, Хөрөнгө оруулагчдын харилцаа, үнэлгээ, Бүтцийн санхүүгийн албаны дарга, 2017-одоог хүртэл Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкны Бизнесийн төлөвлөлт, санхүүгийн загварчлалын албаны дарга

**Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байдал:** КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2021 оны 4 сарын 23-нд гэрчилгээ авсан.
**Гэрчилгээний дугаар:** 0521120

*Зураг 18 ТУЗ-ийн хараат бус гишүүн Жамбалсүрэн Нарантуяа*

**Жамбалсүрэн НАРАНТУЯА**
*ТУЗ-ийн хараат бус гишүүн*

**Мэргэжил:** Эдийн засагч, хуульч

**Боловсрол:** 1978-1983 онд ОХУ, Кубанийн Улсын Их Сургууль, эрх зүйч

**Ажилласан туршлага:** 1983-1989 оны хооронд Улсын дээд шүүхийн зааварлагч, 1989-1990 оны хооронд Сүхбаатар Дүүргийн шүүхийн шүүгч, 1991-1992 оны хооронд Улсын бага хурлын зөвлөх, 1992-1998 оны хооронд УИХ-ын Тамгын газарт зөвлөх, ахлах зөвлөх, 1998-2008 оны хооронд УИХ-ын Тамгын газарт Нэгдүгээр нарийн бичиг, 2009-2010 оны хооронд УИХ-ын даргын зөвлөх, 2010-одоог хүртэл Олон Улсын Санхүүгийн Корпорацид Хуулийн зөвлөх

**Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байдал:** КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2020 оны 9 сарын 26-нд гэрчилгээ авсан.
**Гэрчилгээний дугаар:** 0521088

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 • 5903858

СЗХ
2021 -10- 10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Зураг 19 ТУЗ-ийн хараат бус гишүүн Дэмчигжав Моломжамц*

**Дэмчигжав МОЛОМЖАМЦ**
*ТУЗ-ийн хараат бус гишүүн*

**Мэргэжил:** Эдийн засагч, Доктор профессор

**Боловсрол:** 1970-1975 онд ОХУ, Санхүү эдийн засгийн бакалавр, Улс арлын аж ахуйн дээд сургууль
1985-1987 онд ОХУ, Эдийн засгийн дэд доктор, Санхүү эдийн засгийн сургууль
1997-1999 онд ОХУ, Эдийн засгийн доктор цол, Санхүү эдийн засгийн сургууль

**Ажилласан туршлага:** 1975-1990 оны хооронд Сангийн яаманд Монгол Улсын Сангийн сайд, Төсвийн газрын дарга, Валютын газрын дарга, 1990-1992 оны хооронд Монгол Улсын Засгийн газарт Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, 1992-1996 оны хооронд Монгол Банкны Ерөнхийлөгч, 1997-2001 оны хооронд Эдийн Засаг Хамтын Ажиллагааны Олон улсын байгууллагад Орлогч дарга, 2012-2016 оны хооронд Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банканд Орлогч дарга

**Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байдал:** КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2020 оны 9 сарын 26-нд гэрчилгээ авсан.
**Гэрчилгээний дугаар:** 0521091

*Зураг 20 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ренчинхорлоо Нямцэрэн*

**Ренчинхорлоо НЯМЦЭРЭН**
*ТУЗ-ийн нарийн бичгийн дарга*

**Мэргэжил:** Эрх зүйч

**Боловсрол:** 2007-2012 онд МУИС-Хууль зүйн сургууль, эрх зүйч бакалавр
2012-2015 онд МУИС-Хууль зүйн сургууль, эрх зүйч магистр

**Ажилласан туршлага:** 2012-2014 оны хооронд Сар шинэ интернэшнл ББСБ хуульч ахлах хуульч, 2014-2019 онд Аригбанк ХХК-нд хуулийн зөвлөх, 2019 оноос одоог хүртэл Богд Банкны Үйл ажиллагааны газар, хуулийн албанд ахлах хуульч, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

**Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байдал:** КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2020 оны 9 сарын 26-нд гэрчилгээ авсан.
**Гэрчилгээний дугаар:** 0521078

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТЕ8966 ... 5923558

МИСС

СЭХ
2021 оны 10 дугаар сарын 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

### 10.6.2. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод

ТУЗ нь урьдчилсан хэлэлцүүлэг хийх, зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд хамгийн чухал асуудлуудыг хэлэлцэх түр эсвэл байнгын хороод байгуулна.

Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ нь дараах хороодыг байгуулсан байна.

- Цалин хөлс, нэр дэвших хороо
- Эрсдэлийн удирдлагын хороо
- Аудитын хороо
- Хүний нөөцийн хороо

ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Аудитын болон Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнд заавал орж ажиллахаар зохицуулагдсан байна.

Хорооны хурлыг хорооны дарга, хорооны гишүүн, мөн Банкны ТУЗ-ийн шийдвэрийн дагуу хуралдуулдаг. Асуудал хэлэлцэх хорооны хэлэлцүүлгийн дүнг хуралд оролцсон бүх гишүүдийн гарын үсэг зурж бичгээр гаргасан шийдвэрт тусгаж, ТУЗ-ийн даргад танилцуулах ба Хорооны гаргасан саналуудыг зөвлөмж гэж авч үздэг. Бусад асуудлуудыг хороодын тусгай дотоод журмын дагуу зохицуулдаг байна.

**Аудитын хороо**

Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлангийн үйл явц, дотоод хяналтын систем болон санхүүгийн эрсдэлийн менежмент, аудитын үйл явц, комплайнс буюу хуулийн нийцлийн асуудлыг хянах үйл явцыг холбогдох хууль тогтоомж, Банкны дотоод дүрэм, журмын дагуу хянахад ТУЗ-д дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Энэхүү хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Моломжамц нар ажиллаж байна.

**Урамшууллын асуудал эрхэлсэн хороо**

Урамшууллын хороо нь Банкинд мөрдөгдөж буй цалин урамшууллын бодлогын хэрэгжилт, гүйцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний биелэлт, ёс зүйн хэм хэмжээ болон банкны урт хугацааны ашигт ажиллагаатай уялдуулсэн эсэхэд хяналт тавих, ТУЗ, гүйцэтгэх удирдлагад олгох цалин урамшууллын хэмжээг тодорхойлж, ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг идэвхжүүлэх үүрэгтэй.

Тус хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Моломжамц, гишүүдээр ТУЗ-ийн дарга Д.Болдхуяг, ТУЗ-ийн гишүүн Торстен Дазер нар байна.

**Эрсдэлийн удирдлагын хороо**

Эрсдэлийн удирдлагын хороо нь Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, хянах замаар Банкны хүлээж болзошгүй

БОГД БАНК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 . 11 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 11- 03
БҮРТГЭВ-03

хохирлыг бууруулах, эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгон хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Моломжамц, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Саруул нар ажиллаж байна. ТУЗ нь Үнэт цаас гаргагчийн үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмыг батлах ба гүйцэтгэх удирдлагын банкны үйл ажиллагаанд мөрдүүлэх, зохион байгуулах ажлын хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.

**Хүний нөөцийн хороо**

Хүний нөөцийн хороо нь ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, ажлын гүйцэтгэлийн тайланг хувьцаа эзэмшигчдэд жил бүр, ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын гүйцэтгэл, хурлын ирц, хуралд оролцсон байдлын талаар ТУЗ-д тус тус тайлагнах, ТУЗ-ийн гишүүнийг томилох, үүрэг ажлаас чөлөөлөх асуудлыг ХЭХ-д оруулах, гүйцэтгэх удирдлагад багтан ажиллах албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх этгээдийг ТУЗ-д танилцуулах, гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэл болон гэрээний биелэлтийг дүгнэж ТУЗ-д танилцуулах зэрэг үүрэгтэй ажилладаг. Хүний нөөцийн хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг болон ТУЗ-ийн гишүүн Г.Саруул нар ажиллаж байна.

### 10.6.3. Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс сонгосон гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь Богд Банкны дүрэм болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бөгөөд банкны эрх бүхий төлөөлөгч байна. Банкны гүйцэтгэх удирдлагын баг нь салбартаа удаан ажилласан, хариуцсан чиг үүрэг болон менежментийн ур чадварын хувьд мэргэшсэн, мэргэжлийн хамт олноос бүрдсэн. Үнэт цаасны танилцуулага бэлтгэх үеийн байдлаар Богд Банкны гүйцэтгэх удирдлагын баг нь дараах бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

*Хүснэгт 75 Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг*

| № | Овог нэр | Албан Тушаал | Томилогдсон Огноо |
|---|---|---|---|
| 1 | Г.Саруул | ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал | 2014.10.31 |
| 2 | Д.Төрмандах | Ерөнхий аудитор | 2019.07.18 |
| 3 | Б.Билэгт | Үйл ажиллагаа хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч | 2018.08.08 |
| 4 | С.Оргодол | Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч | 2020.12.16 |
| 5 | Б.Баярмаа | Бизнес хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч | 2021.08.23 |
| 6 | А.Энхжаргал | Санхүү хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч | 2016.01.06 |
| 7 | М.Алтанзүрх | Мэдээллийн технологи хариуцсан дэд захирал | 2016.12.28 |
| 8 | С.Отгонжаргал | Зээл хариуцсан дэд захирал | 2016.06.13 |
| 9 | Ч.Банчин | Бизнес хөгжил хариуцсан дэд захирал | 2019.06.21 |
| 10 | М.Алтанбагана | Иргэдийн банк хариуцсан дэд захирал | 2019.03.25 |
| 11 | Х.Анхсүрэн | Байгууллагын банк хариуцсан дэд захирал | 2021.09.01 |
| 12 | Ц.Уянга | Цахим банк, Харилцагчийн үйлчилгээ хариуцсан дэд захирал | 2021.09.01 |
| 13 | Э.Ган-Эрдэнэ | Хөрөнгө зохицуулалт, хөрөнгө оруулалтын банкны газрын захирал | 2020.10.06 |
| 14 | Б.Сэргэлэн | Хүний нөөцийн газрын захирал | 2020.02.19 |

БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТТ98246 5903858

СЭХ
2021 11 10
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Зураг 21 Дорж Төрмандах*

**Дорж ТӨРМАНДАХ**
*Ерөнхий Аудитор*

**Мэргэжил:** Санхүүгийн менежмент

**Боловсрол:** 2007-2011 онд, СЭЗИС, Санхүүгийн менежмент

**Ажилласан туршлага:** Банк, санхүүгийн салбарт 2011 оноос хойш эрсдэлийн удирдлага, дотоод аудитын үйл ажиллагааны чиглэлээр ажилласан туршлагатай

*Зураг 22 Болдхуяг Билэгт*

**Болдхуяг БИЛЭГТ**
*Үйл ажиллагаа хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч*

**Мэргэжил:** Бизнесийн Санхүү

**Боловсрол:** 2013-2015 онд Швейцар, Европын Холбооны бизнесийн сургууль, Бизнесийн удирдлага, Бизнесийн санхүү

**Ажилласан туршлага:** 2016 оноос Богд Банканд Санхүүгийн шинжээч, Үйл ажиллагааны газрын захирал, Тэргүүн дэд захирал

*Зураг 23 Санжаасүрэн Оргодол*

**Санжаасүрэн ОРГОДОЛ**
*Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч*

**Мэргэжил:** Хууль эрх зүй, Эдийн засаг, Олон улсын банк санхүүгийн хууль

**Боловсрол:** 1987-1992 онд МУИС-Хуулийн сургууль, Хууль эрх зүй
2001-2002 онд АНУ, Колорадо мужийн Эдийн засгийн дээд сургууль, Эдийн засгийн бакалавр
2002-2003 онд АНУ, Бостоны Их сургууль, ОУ-ын банк, санхүүгийн хуулийн мастер,

**Ажилласан туршлага:** 1992-1996 оны хооронд Эрчим хүч, геологи, уул уурхайн яаманд Хуулийн зөвлөх, Сайдын зөвлөлийн нарийн бичгийн дарга, 1996-1997 оны хооронд Худалдаа Хөгжлийн Банканд Хуулийн зөвлөх, Тамгын газрын захирал, 2004-2006 оны хооронд Дэлхийн Банкны Монгол Улс дахь Суурин Төлөөлөгчийн газарт Дэд бүтцийн мэргэжилтэн, 2006-2008 оны хооронд Олон Улсын Санхүүгийн Корпорацад Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, Суурин төлөөлөгч, 2008-2009 оны хооронд Монгол шуудан банканд ТУЗ-ийн дарга, 2009-2020 оны хооронд Худалдаа Хөгжлийн Банканд Гүйцэтгэх захирлын орлогч, 2010-2020 онуудад Банк Санхүүгийн Академид

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 • 5903858

СЭХ
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHAN
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

ТУЗ-ийн гишүүн, дарга, 2013-2015 оны хооронд Монголын Орон Сууцны Санхүүжилтийн Корпорацад ТУЗ-ийн дарга, 2011 оноос Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд Арбитрч, 2020 оноос Богд Банканд Эрсдэлийн нэгдсэн удирдлага хариуцсан дэд захирал

*Зураг 24 Баярбаатар Баярмаа*

**Баярбаатар БАЯРМАА**
*Бизнес хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч*

**Мэргэжил:** Банкны эдийн засаг, Эрх зүйч

**Боловсрол:** 1992-1997 онд, МУИС-ЭЗС, Банкны эдийн засаг
2006-2009 онд, МУИС-ХЗС, Эрх зүйч

**Ажилласан туршлага:** 2007-2021 оны хооронд Худалдаа хөгжлийн банканд Сувгийн хэлтсийн захирал, Иргэдийн банкны газрын захирал, Гүйцэтгэх захирлын орлогчоор ажилласан туршлагатай

*Зураг 25 Ангиа Энхжаргал*

**Ангиа ЭНХЖАРГАЛ**
*Санхүү хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч*

**Мэргэжил:** Банкны эдийн засагч, Бизнесийн удирдлага

**Боловсрол:** 2001-2005 онд МУИС-ХҮДС, Банкны эдийн засгийн бакалавр
2008-2010 онд Удирдлагын академи, Бизнесийн удирдлага магистр

**Ажилласан туршлага:** 2005-2015 онд Капитал Банканд нягтлан бодогч, Ахлах нягтлан бодогч, Санхүүгийн ахлах мэргэжилтэн, Санхүү, хөрөнгийн удирдлагын газрын захирал

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ЭМ АЙ СИ СИ ҮЦК ХХК
ТТГ-4-8719
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 . 11 . 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Зураг 26 Мөнхням Алтанзүрх*

**Мөнхням АЛТАНЗҮРХ**
*Мэдээллийн технологи хариуцсан дэд захирал*

**Мэргэжил:** Компьютерийн программ хангамж, Компьютерийн ухааны магистр

**Боловсрол:** 1998-2002 онд ШУТИС-КТМС, Компьютерийн программ хангамж
2004-2005 онд ШУТИС-КТМС, Компьютерийн ухааны магистр

**Ажилласан туршлага:** 2002-2006 онд ШУТИС-КТМС-д багш, 2009-2016 Төр болон хувийн хэвшилд Мэдээллийн технологийн газрын дарга

*Зураг 27 Сэнгэравдан Отгонжаргал*

**Сэнгэравдан ОТГОНЖАРГАЛ**
*Зээл хариуцсан дэд захирал*

**Мэргэжил:** Банкны эдийн засагч, санхүүч

**Боловсрол:** 1999-2003 онд СЭЗИС, Банк санхүүгийн бакалавр

**Ажилласан туршлага:** 2003-2016 оны хооронд Хас Банканд нягтлан бодогч, зээлийн эдийн засагч, Зээлийн Удирдлагын Газарт эрсдэлийн менежер, ахлах мэргэжилтэн, хэлтсийн захирал, Өмчийн харилцааны хэлтсийн захирал

*Зураг 28 Чойноо Банчин*

**Чойноо БАНЧИН**
*Бизнес хөгжил хариуцсан дэд захирал*

**Мэргэжил:** Бизнесийн удирдлага

**Боловсрол:** 2008-2012 онд Их Британи, Лондонгийн худалдааны их сургууль, Бизнесийн удирдлага

**Ажилласан туршлага:** 2013-2017 оны хооронд Хас Банканд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ахлах мэргэжилтэн, 2017-2019 оны хооронд Бизнес хөгжлийн газрын ахлах менежер, 2019 оноос Богд Банканд Бизнес хөгжил хариуцсан дэд захирал

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
5903858

СЗХ
2021 оны 11 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHAN
2021-11-03
БҮРТГЭВ-03

*Зураг 29 Мөнхжаргал Алтанбагана*

**Мөнхжаргал АЛТАНБАГАНА**
*Иргэдийн банк хариуцсан дэд захирал*

**Мэргэжил:** Санхүүгийн менежмент

**Боловсрол:** 2006-2010 онд ШУТИС-КТМС, Санхүүгийн менежмент

**Ажилласан туршлага:** 2009-2017 оны хооронд Хаан Банканд эдийн засагч, Ахлах харилцааны менежер, Зээлийн газарт бүс хариуцсан мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан. 2017 оноос Богд Банканд зээлийн газрын ахлах мэргэжилтэн, Салбар тооцооны төвийн захирал, Сувгийн удирдлагын хэлтсийн захирал, Иргэдийн банк хариуцсан дэд захирал

*Зураг 30 Хүрэлбаатар Анхсүрэн*

**Хүрэлбаатар АНХСҮРЭН**
*Байгууллагын банк хариуцсан дэд захирал*

**Мэргэжил:** Банк, санхүү

**Боловсрол:** 2015-2016 онд, МУИС-ЭЗС , Банк, санхүүгийн магистр

**Ажилласан туршлага:** 2015-2021 оны хооронд Худалдаа хөгжлийн банканд Салбарын захирал, Салбарын захирал орлох менежер, Сувгийн газрын захирал

*Зураг 31 Цэрэндоржийн Уянга*

**Цэрэндорж УЯНГА**
*Цахим банк, Харилцагчийн үйлчилгээ хариуцсан дэд захирал*

**Мэргэжил:** Санхүү зээлийн эдийн засаг

**Боловсрол:** 2001-2006 онд, ОХУ-д Кемеровын их сургууль, Санхүү зээлийн эдийн засаг

**Ажилласан туршлага:** 2006-2021 оны хооронд Борлуулалт, харилцагчийн үйлчилгээний хэлтсийн менежер, Ахлах менежер, Хэлтсийн захирал, Газрын захирал

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 ₪ 5903858

СЗХ
2021 оны 11 сар 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Зураг 32 Эрдэнэ-Очир Ган-Эрдэнэ*

**Эрдэнэ-Очир ГАН-ЭРДЭНЭ**
*Хөрөнгө зохицуулалт, хөрөнгө оруулалтын банкны газрын захирал*

**Мэргэжил:** Эдийн засаг-Математик загварчлал

**Боловсрол:** 2007-2011 онд МУИС, Эдийн засгийн математик загварчлал

**Ажилласан туршлага:** 2011-2015 оны хооронд Голомт Банкны Нөөцийн удирдлагын газарт дилерээр ажиллаж байсан. 2015-2017 оны хооронд Богд Банкны Хөрөнгө зохицуулалт, хөрөнгө оруулалтын банкны хэлтэст ахлах дилер, 2017 оноос одоог хүртэл Богд Банкны Хөрөнгө зохицуулалт, хөрөнгө оруулалтын банкны газрын захирал

*Зураг 33 Буян-Очир Сэргэлэн*

**Буян-Очир СЭРГЭЛЭН**
*Хүний нөөцийн газрын захирал*

**Мэргэжил:** Эдийн засаг

**Боловсрол:** 1994-1997 онд, МУИС, Орчуулагч
2001-2003 онд, СЭЗДС, Эдийн засаг

**Ажилласан туршлага:** 1998-2000 онд Монгол банканд Ерөнхийлөгчийн нарийн бичиг, 2002-2009 онд Анод банканд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, 2011-2014 онд Гэд Хилл ХХК-д Хүний нөөцийн менежер, 2014-2015 онд Моннис интернэшнлд Ерөнхий менежерээр ажиллаж байсан. 2016 оноос Богд банканд Харилцааны менежер, Хүний нөөцийн менежер, Хүний нөөцийн газрын захирлаар ажиллаж байгаа.

### 10.6.4. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны хороод

Үйл ажиллагааны хороод нь Зээл, Эрсдэл, Удирдлага, Актив, Пассив болон Бизнес Хөгжлийн Хороодоос бүрддэг.

**Зээлийн Хороо** нь Богд Банкны зээлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ТУЗ-аас олгосон эрхийн хүрээнд зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив олгох, үл хөдлөх хөрөнгө шилжүүлэн авах, олгосон зээлийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт тавих, улмаар зээлийн багцын чанар, ашигт ажиллагааг хангаж ажилладаг.

**Эрсдэлийн Хороо** нь Богд Банкны эрсдэлийн удирдлагын бодлогод нийцүүлэн банк өөрт учирч буй зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, хөрвөх чадварын эрсдэлүүдийг үр дүнтэй удирдан хянах, эрсдэлийг таних, хэмжих, эрсдэлийн шалгуур,

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТГЁ8966 - 5903858

хязгаар, загвар, модель болон аргачлалыг тодорхойлох, эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлдэг.

**Удирдлагын Хороо** нь Богд Банкны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны болон нэгжүүдийн бизнес төлөвлөгөө, бүх төрлийн стратеги, урт болон дунд хугацааны зорилтууд, хөрөнгө оруулалтын бодлого болон түүнтэй холбогдох тайлан, санал, санаачилгатай танилцан, тэдгээрийн биелэлтэд хяналт тавин ажилладаг.

**Актив, Пассивын Хороо** нь Богд Банкны актив, пассивын бодлого, журмаар тогтоосон стандартуудын биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж, хөрвөх чадвар, хүү, ханшийн стратегийн талаар богино, дунд, урт хугацааны зорилтын талаар хэлэлцэж, ашигт ажиллагаа, төлбөрийн чадварын үзүүлэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүү, хугацаа, хөрөнгө, зах зээлийн болоод санхүүгийн байдлын судалгаа хийж ажилладаг.

**Бүтээгдэхүүн Хөгжлийн Хороо** нь Богд Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ, програм ашиглалт, төлбөрийн карт, цахим бизнес, мэдээллийн технологитой холбоотой нэвтрүүлэх, сайжруулах, өөрчлөх, хөгжүүлэх, шаардлагатай тохиолдолд зах зээлээс татан авах, маркетингийн үйл ажиллагаа, олон нийттэй харилцах бодлого, чиглэлтэй холбоотой асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх үүрэгтэй ажилладаг.

**10.6.5. Үнэт цаас гаргагчийн газар, хэлтсүүд**

Үнэт цаас гаргагч нь 8 газар, 1 хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг ба чиг үүрэг нь дараах байдалтай байна.

**Дотоод аудитын газар** нь Банкны үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг бие даасан, хараат бус, бодитойгоор үзүүлэн ажилладаг.

**Үйл ажиллагааны газар** нь Монгол Улсын Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм журам зааврын хүрээнд Банкны үйл ажиллагааны хэвийн тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн захиргааны, хууль зүйн, хүний нөөцийн, аж ахуйн үйлчилгээний бодлого, удирдлагаар ханган ажилладаг.

**Бизнес банкны газар** нь Банкны сувгийн удирдлагын бодлогыг оновчтой хэрэгжүүлэх, борлуулалт болон харилцагчийн тоон төлөвлөгөө биелүүлэх үүрэгтэй ажилладаг.

**Бизнес хөгжлийн газар** нь шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах, боловсруулах, хөгжүүлэх, үүнийг технологийн өндөр шийдэл, цахим сувгуудаар дамжуулан харилцагчдад хүргэх, борлуулах, банкны депозитыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах замаар Банкны бизнес хөгжлийг өрсөлдөхүйц түвшинд хүргэх, банкны ашиг орлогыг нэмэгдүүлэхээр ажилладаг.

**Эрсдэлийн нэгдсэн удирдлагын газар** нь Банкны ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгөд сөргөөр нөлөөлөхүйц банкны үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй төлөвлөгдсөн болон төлөвлөгдөөгүй үр дагавар түүнд нөлөөлөх хэмжих боломжтой болон боломжгүй нөхцөлийг урьдчилан таамаглах банкны эрсдэлийн түвшин хэмжээг тодорхойлон, түүнээс урьдчилан сэргийлэх бодлого арга замыг боловсруулж, эрсдэлийн нөлөөллийг удирдах замаар банкны үйл ажиллагааны тогтвортой байдлыг ханган ажилладаг.

**Санхүүгийн удирдлагын газар** нь хэрэглэгчийг санхүүгийн бодит үнэн зөв мэдээллээр хангах банкны санхүүгийн зорилго, зорилтуудыг тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулах хөрөнгө өр төлбөрийн зохистой харьцаог холбогдох газар хэлтэс хамтран хэрэгжүүлж системийн хэмжээний нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодорхойлж, санхүү бүртгэлтэй холбоотой батлагдсан журам, зааврын хүрээнд хэрэгжилтийг хангуулах банкны гадаад дотоод төлбөр тооцоо гүйцэтгэх бүтээгдэхүүн үйлчилгээ хөрөнгө оруулалтын үр өгөөж, үнийн бодлогыг тодорхойлоход хяналт тавин ажилладаг.

**Мэдээллийн технологийн газар** нь Мэдээллийн технологийн дэд бүтцийг хэвийн найдвартай ажиллагаа, түүний төлөвлөлт, хөгжүүлэлтийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ба мэдээллийн аюулгүй байдлын зохистой хэм хэмжээнд тогтворжуулах үүсэж болон эрсдэлээс сэргийлэх холбогдох мэдлэгийг олгох зорилготой.

**Зээлийн удирдлагын газар** нь зээлийн бодлого үйл ажиллагааны чиглэлээр тодорхойлох зээлийн судалгаа шинжилгээ хийх тайлан мэдээ хөтлөх шинэ бүтээгдэхүүн судлах боловсруулах нэвтрүүлэх удирдлага болон холбогдох нэгжийг шаардлагатай зээлийн мэдээ тайлангаар ханган ажилладаг.

**Хөрөнгө зохицуулалт, Хөрөнгө оруулалтын банкны хэлтэс** нь Банкны актив пассивын бодлого эрсдэлийн удирдлагын стратеги бодлогуудыг хэрэгжүүлэн банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нөөцийн үзүүлэлт шаардлагуудыг хангах хадгалахын зэрэгцээ эх үүсвэрийг хамгийн оновчтой байдлаар байршуулах замаар банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх үүрэгтэй ажилладаг.

### 10.6.6. Үнэт цаас гаргагчийн ёс зүй

Үнэт цаас гаргагч нь Богд Банкны Ёс зүйн дүрмийг Гүйцэтгэх захирлын 2015 оны 6 сарын 8-ний өдрийн 15/078 тоот тушаалаар баталсан. Энэхүү ёс зүйн дүрэм нь Банк болон Банкны ажилтан үйл ажиллагаа явуулахдаа мөрдөх ёс зүй, зан үйлийг зохицуулдаг.

Богд Банкны ёс зүй дүрэмд дараах зүйлс хамаардаг байна:

- Банк болон удирдах ажилтнаас баримтлах ёс зүйн шаардлагад Банк харилцагчтай, төрийн байгууллагатай, нийгмийн бусад талуудтай харилцахад болон өөрийн ажилтнуудтай харилцахад баримтлах ёс зүйн хэм хэмжээ;
- Банкны ажилтны ёс зүйн шаардлага болох үүрэгт ажлаа үнэнч шударгаар гүйцэтгэх, биеэ зохистой авч явах, мэдээллийн нууцыг хадгалах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, банкны хөрөнгийг хамгаалах, санхүүгийн сахилга баттай байх зэрэг шаардлагууд;
- Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх арга болон ашиг сонирхлын зөрчил мэдэгдэх, тайлагнах тухай.

### 10.6.7. Компанийн Засаглалын Кодекс

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны 2014 оны 5 сарын 7-ны өдрийн 162 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан Компанийн Засаглалын Кодекс болон Монголбанкны

СЗХ
2021 оны 11 сарын 0 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Ерөнхийлөгчийн 2014 оны 9 сарын 30-ны өдрийн А-151 тоот тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмыг дагаж мөрддөг. Компанийн Засаглалын Кодекст Хувьцаа эзэмшигчдийн эрх, мэргэжлийн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмших хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал, дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчмууд багтдаг. Банк нь Дүрэмдээ банкны зохистой засаглалын зарчмуудыг бүрэн тусгаж өгсөн байдаг ба мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 сарын 30-ны өдрийн А-151 тоот тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам болон түүгийг хэрэглэх зөвлөмжийн дагуу "Богд Банкны зохистой засаглалын бодлого"-ыг ТУЗ-ийн тогтоолоороо батлан хэрэгжүүлж ажиллаж байна. Тус бодлогын хүрээнд банкны ТУЗ болон Гүйцэтгэх шатны удирдлагын үйл ажиллагааг банкны хувь нийлүүлэгчид болон харилцагч, хадгаламж эзэмшигчдийн болон бусад сонирхол нэгтэй этгээдийн эрх ашигт нийцүүлэх, банкны ил тод байдлыг сайжруулах зэрэг банкны зохистой засаглалд ач холбогдол бүхий арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Банк дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоожийг удирдлага болгодог. Мөн Банкны зохистой засаглалын тайланг тайлант жилийн байдлаар тогтоосон хугацаанд Монголбанкинд тухай бүр хүргүүлж, хариу үнэлгээ, зөвлөмжийн хүрээнд тодорхой арга хэмжээг авч ажилладаг.

Банкны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журамд заасны дагуу банк зохистой засаглалыг хэрэгжүүлэх бөгөөд ТУЗ-ийн дэргэд дэд хороодтой байгаа. Тухайлбал:

- Эрсдэлийн удирдлагын хороо
- Аудитын хороо
- Урамшууллын хороо
- Хүний нөөцийн хороо

Богд Банкны хувьд ирэх жилүүдэд Эрсдэлийн удирдлага болон Аудитын хорооны тогтолцоог сайжруулах, түүний удирдлага, ажиллах хүрээ, шийдвэр гаргах эрх хэмжээ, үүрэг дээр ихээхэн анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороодыг мэдээллээр хангах, шийдвэр гаргахад нь дэмжин ажиллахад чиглэнэ. Банкны хороодын журмын эрх үүргийг нарийвчлан гаргаж, үйл ажиллагаандаа мөрдөх, дотоод хяналтын болон үйл ажиллагааны тогтолцоог сайжруулахад чиглэсэн арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

Банкны дүрэм, дотоод журам, явуулж буй үйл ажиллагаа нь Компанийн тухай хууль болон СЗХ-ны баталсан Компанийн Засаглалын Кодекст нийцүүлэн ажиллаж байгаа эсэх талаар хуулийн зөвлөх компанийн дүгнэлт гарсан болно. Дэлгэрэнгүй мэдээллийг хууль зүйн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлангаас үзнэ үү.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 5903858

СЗХ
2021 оны 10 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

# АРВАН НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮРТГЭЛ БОЛОН ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭРТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

## 11.1. Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл

### 11.1.1. Үнэт цаас гаргагчийн бүртгэл

Богд Банк нь Улсын бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу 2014 оны 11 сарын 6-ны өдөр үүсгэн байгуулагдсан ба Банкны тухай хуулийг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 12 сарын 17-ны өдрийн А-199 тоот тушаалаар "Богд Банк" оноосон нэр бүхий банк байгуулах зөвшөөрлийг олгосноор үйл ажиллагаа эхэлсэн байна.

*Хүснэгт 76 Үнэт цаас гаргагчийн бүртгэл*

| Үнэт цаас гаргагч | Богд Банк |
|---|---|
| **Байгуулагдсан огноо** | 2014 оны 11 сарын 6-ны өдөр |
| **Улсын бүртгэлд бүртгэгдсэн байдал** | 2014 оны 11 сарын 17-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байх бөгөөд 9016001020 тоот улсын бүртгэлийн дугаар, 5903858 тоот регистрийн дугаартайгаар үйл ажиллагаагаа эрхэлж байгаа хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| **Монголбанкны тусгай зөвшөөрөл** | - Зээлийн үйл ажиллагаа;<br>- Төлбөр тооцооны үйлчилгээ;<br>- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;<br>- Гадаад төлбөр тооцоо (энгийн)<br>- Гадаад төлбөр тооцоо<br>- Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах (3-аас дээш жилийн хугацаатай 150 сая ам.доллараас доошгүй гадаад эх үүсвэрийг татан төвлөрүүлэх, дотоодын зах зээлд ашиглах хязгаарлалттай)<br>- Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах үйл ажиллагаа;<br>- Мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа;<br>- Мөнгөн хадгаламж (зөвхөн гадаад зах зээлээс эх үүсвэр татах нөхцөлтэй)<br>- Гадаад төлбөр тооцоо хийх, эрхлэх үйл ажиллагаа;<br>- Зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдан авах, эрхлэх үйл ажиллагаа;<br>- Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах, эрхлэх үйл ажиллагаа; |
| **СЗХ-ны тусгай зөвшөөрөл** | - Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх; |
| **Улсын бүртгэлд бүртгэгдсэн болон шуудангийн хаяг** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, Таван өндөр төв, 1 давхар |
| **Утас** | +976 7013 9999 |
| **И-мэйл** | info@bogdbank.com |
| **Цахим хуудас** | www.bogdbank.com |

### 11.1.2. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй эд хөрөнгийн мэдээлэл

**Үнэт цаас гаргагчийн үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл**

Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалтын зорилгоор эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө нь 2017 оны 12 сард худалдан авсан оффисийн барилгаас бүрдэж байна. Тус хөрөнгийн 86

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 5903858

СЭХ
2021 оны 11 сарын 0 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 - 11 - 03
БҮРТГЭВ-03

м2 талбайг Үнэт цаас гаргагч нь салбарын үйл ажиллагаанд ашиглаж байгаа ба үлдсэн хэсгийн түрээслэх зорилгоор эзэмшдэг. 2018 оны 6 сард Богд Банк нь тус барилгад түрээслэгч олох үүднээс Үнэт цаас гаргагчийн дээд шатны хувьцаа эзэмшигчтэй холбоотой менежментийн компанитай гэрээ байгуулсан. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Богд Банк нь дараах үл хөдлөх хөрөнгийг эзэмшиж байна. Үүнд:

*Хүснэгт 77 Үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл*

| № | Үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл | Байршил |
|---|---|---|
| 1 | Богд Банкны Баруун 4 замд байрлах салбар 1,060 м2 оффистийн барилга нь Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, Таван өндөр төв, 1 давхар |

## Үнэт цаас гаргагчийн барааны тэмдгийн мэдээлэл

Богд Банк нь дор дурдсан барааны тэмдгүүдийг Монгол Улсын Оюуны өмчийн газарт бүртгүүлж, хамгаалуулсан байна. Үүнд:

*Хүснэгт 78 Үнэт цаас гаргагчийн барааны тэмдгийн мэдээлэл*

| № | Улсын бүртгэлийн дугаар | Анхдагч огноо | Барааны тэмдэг | Хүчинтэй байх хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | 14826 | 2015.01.29 | БОГД БАНК | 2025.01.29 |
| 2 | 14462 | 2015.02.11 | БОГД БАНК | 2025.02.11 |
| 3 | 23073 | 2020.08.04 | PRIME | 2030.08.04 |

## Үнэт цаас гаргагчийн түрээсийн хөрөнгийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаанд ашигладаг салбаруудын оффисийн талбайг түрээслэх гэрээтэй. Эдгээр түрээсийн гэрээнүүд нь дунджаар таван жилийн хугацаатай байна. Богд Банкны түрээсийн гэрээний дагуу хүлээсэн үүрэг нь түрээслүүлэгчийн өмчлөх эрхээр баталгаажсан болно. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Богд Банк нь дараах үл хөдлөх хөрөнгийг түрээсэлж байна. Үүнд:

*Хүснэгт 79 Түрээсийн хөрөнгийн мэдээлэл*

| № | Түрээсийн хөрөнгийн мэдээлэл | Байршил |
|---|---|---|
| 1 | Дунжингарав салбар, 110 м2 бүхий оффисын зориулалттай талбай | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Нийслэл өргөн чөлөө, Эс Март худалдаа үйлчилгээний төв, 1 давхар /Дунжингарав худалдааны төвийн замын урд байрлалтай/ |
| 2 | Бодь цамхаг салбар, 1-р давхрын 110 м2, 3-р давхрын 9.6 м2, 4-р давхрын 545 м2, 11-р давхрын 275.6 м2 оффисын талбай болон 4 ширхэг автомашины зогсоол | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг, 1 давхар |
| 3 | Гэгээнтэн тооцооны касс, 15 м2 бүхий үйлчилгээний зориулалттай талбай | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Зайсангийн гудамж, Гэгээнтэн цогцолбор, 1 давхар |
| 4 | Мишээл салбар, 136.65 м2 бүхий үйлчилгээний талбай | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Мишээл барилгын их дэлгүүр, 1 давхар |

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТӨ 8966 5903558

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

| | | |
|---|---|---|
| 5 | Соманг салбар, 184 м2 бүхийн оффисын талбай | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороолол, 13 хороолол, Соманг төв, 1 давхар |
| 6 | Эрдэнэт салбар, 193.05 м2 бүхий офиссын талбай | Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уурхайчин, 3-р баг, Чандмань төв, Баруун жигүүр |
| 7 | Улаанхуаран салбар, 148 м2 бүхий үйлчилгээний талбай | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16-р хороо, 16-р хороолол, Улаанхуаран гудамж, Синема Некст худалдаа үйлчилгээний цогцолбор, 1 давхар |
| 8 | МПМ плаза салбар, 123 м2 үйлчилгээ, оффисын зориулалттай талбай | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Юнескогийн гудамж, МПМ цогцолбор барилга, 1 давхар |

## 11.2. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний, сонирхлын зөрчилтэй болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ

### 11.2.1. Бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт зааснаар "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг, мөн компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ийг их хэмжээний хэлцэлд тооцох байна. Харин компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй гэж заасан байна. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтоох ба их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшны уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

Богд Банкны 2021 оны 6 сарын 24-ний өдрийн 427 тоот дугаартай батламж бичигт дурдсанаар үнэт цаас гаргах үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь их хэмжээний хэлцэл байгуулаагүй байна.

### 11.2.2. Бусадтай байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт зааснаар "Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэдэгт сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын бағцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг хэлэх бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТӨ8966 • 5903858

СЭХ
БҮРТГЭВ
№ 91
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана.

Хуулийн фирмийн дүгнэлт болон Богд Банкны 2021 оны 6 сарын 24-ний өдрийн 427 тоот батламж албан бичигт дурдсанаар Богд Банк нь 2018-2021 онд сонирхлын зөрчилтэй хэд хэдэн хэлцлийг ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд Компанийн тухай хуульд заасан шаардлагын дагуу хэлэлцэн шийдвэрлэж байгуулсан гэж дүгнэсэн байна.

### 11.2.3. ХНХ-ийн хувь буюу түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээ, хэлцэл

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.7 дахь заалт, Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 4.3.7 дахь хэсэгт заасны дагуу Богд Банкны 2021 оны 6 сарын 24-ний 427 тоот батламж албан бичигт дурдсанаар Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл байгуулаагүй байна.

### 11.2.4. Үйл ажиллагаатай холбоотой гэрээ

Үнэт цаас гаргагчийн гадаад зээлийн эх үүсвэр

Богд Банк ХХК нь 2019 оны 7 сарын 8-ны өдөр Өвөр Монголын банкнаас жилийн 7 хувийн хүүтэй гадаад зээл авч байсан бөгөөд тус зээлийн үлдэгдэл 4,489,813 мянган төгрөгийг 2021 оны 1 сарын 8-ны өдөр бүрэн эргүүлэн төлсөн байна. Хуулийн фирмийн дүгнэлтэд дурдсанаас Үнэт цаас гаргагч нь бусад ямар нэг өр төлбөр хүлээж болзошгүй үүрэг хүлээгээгүй буюу ямар нэг зээлийн гэрээ байгуулаагүй байна.

Бизнесийн бусад гэрээ хэлцлүүд

Хуулийн фирмийн дүгнэлтэд дурдсанаар Богд Банкны хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа болон 2018 оны 1 сарын 1-ний өдрөөс 2021 оны 4 сарын 23-ны өдрийн хооронд байгуулсан, дуусгавар болсон гэрээнүүд нь зохих ёсоор байгуулагдсан буюу хуульд харшлаагүй байна гэж үзсэн байна.

## 11.3. Үнэт цаас гаргагчийн хэрэг, маргаан

Үнэт цаас гаргагчид холбогдуулан арбитр, шүүхэд гаргасан хэрэг маргаан байхгүй бөгөөд Банкны эсрэг гаргасан нэхэмжлэл, гомдол, үүсгэсэн хэрэг байхгүй байна.

Мөн Богд Банк нь гаалийн ерөнхий газар болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шүүхийн шийдвэрийн дагуу аливаа иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байна.

# АРВАН ХОЁР. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

## 12.1. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, тогтоомж

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь дараах хууль тогтоомжийн холбогдох хэсгээр зохицуулагдаж байна. Үүнд:

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8766 5903858

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Иргэний хууль
- Банкны тухай хууль
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
- Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль
- Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль
- Валютын зохицуулалтын тухай хууль
- Компанийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль
- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 сарын 30-ны өдрийн А-151 тоот тушаалаар батлагдаж, 2018 оны 8 сарын 2-ны өдөр нэмэлт орсон "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 7 сарын 3-ны өдрийн А-99 тоот тушаалаар батлагдсан "Банкны нэгжийн журам"
- Монголбанкны Ерөнхийлөгч, СЗХ-ны даргын 2021 оны 3 сарын 26-ны өдрийн А-90/85 тоот хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан "Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам" ("Түр журам")
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 3 сарын 22-ны өдрийн А-82 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам"
- СЗХ-ны 2015 оны 11 сарын 23-ны өдрийн 408 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"
- СЗХ-ны 2019 оны 1 сарын 9-ний өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан "Даатгалын багц дүрэм"
- Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 сарын 12-ны өдрийн 162 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан Компанийн засаглалын кодекс

## 12.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулагч байгууллагууд

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд дараах зохицуулагч байгууллагууд хяналт тавин ажиллаж байна. Үүнд:

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ56966 ж 5908858

СЗХ
он сар өдөр
2021 11 10
БҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

### 12.2.1. Монголбанк

Богд Банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 12 сарын 17-ны өдрийн А-199 тоот тушаалтай 27 тоот Банкны зөвшөөрлийн гэрчилгээний үндсэн дээр үйл ажиллагаагаа эрхэлж байна.

Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулиар Монголбанкны хэрэгжүүлэх эрх, үүрэг, удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд болон банканд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Монголбанк нь Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага бөгөөд дараах чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг:

- мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах;
- мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;
- банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих;
- гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;
- банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- макро зохистой бодлого хэрэгжүүлэх.

### 12.2.2. Санхүүгийн Зохицуулах Хороо

Богд Банк нь СЗХ-ны 2019 оны 12 сарын 16-ны өдрийн 382 тоот тогтоолын дагуу "даатгалын зуучлагчийн" үйл ажиллагаа эрхэлж байна.

СЗХ нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.

Даатгалын зуучлагч нь санхүүгийн нэмэлт тайланг улирал бүр гаргаж, эхний хагас жилийн болон жилийн санхүүгийн тайлангийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд цаасаар болон СЗХ-ны цахим бүртгэлд илгээх, 1 болон 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн хамт дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор цаасаар болон СЗХ-ны цахим бүртгэлд илгээх үүрэг хүлээдэг.

## 12.3. Банкны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжууд

### 12.3.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль

2001 оны 2 сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж буй Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
Т.: 8960 5903858

СЗХ
2021 . 11 . 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулдаг. Тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т банкны үйл ажиллагааны чиглэлийг заасан ба 15.2.1-т банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлнэ гэж заасан байдаг.

Үнэт цаас гаргагч нь 2014 оны 12 сарын 17-нд Банкны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан. Иймд Богд Банк нь үйл ажиллагааны чиглэлийнхээ хүрээнд тусгай зөвшөөрлийн эрхтэйгээр үйлчилгээгээ явуулдаг байна.

**12.3.2. Банкны тухай хууль**

2010 оны 1 сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр мөргдөгдөж буй Банкны тухай хуульд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 оны 1 сарын 28-ны өдөр баталснаар Монгол Улсын арилжааны банкууд хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх үүрэг хүлээсэн. Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хувьцаат компани болохтой холбоотой орсон нэмэлт өөрчлөлтүүдийг дор тусгав. Үүнд:

**Банкны үйл ажиллагаа эрхлэх хэлбэр**

Банкны системд нөлөө бүхий банкууд 2022 оны 6 сарын 30-ны дотор нээлттэй хувьцаат компани болж, тодорхой тооны хувьцаагаа нийтэд санал болгоно. Харин бусад банкны хувьд өөрийн сонголтоор нээлттэй эсвэл хаалттай компани болох юм.

**Банкны системд нөлөө бүхий банканд тооцох шалгуур**

"Системд нөлөө бүхий банк"-ийг Монголбанкнаас тогтоох бөгөөд үүнд банкны нийт хөрөнгө, нийт өр төлбөр, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, үндсэн үйл ажиллагаа, харилцагчдын тоо, санхүүгийн тогтолцоон дахь хамаарал зэргийг харгалзан үзнэ.

**Банкны хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасны эзэмшлийн хязгаар**

2023 оны 12 сарын 31-ний дотор, аливаа хувьцаа эзэмшигчийн дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээг тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхээргүй байхаар тогтоосон байна.

**ТУЗ-ийн гишүүдийн тоо**

Банкны ТУЗ нь ес ба түүнээс дээш гишүүнтэй байна. Банкны ТУЗ-ийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна. Мөн Монголбанкны зөвшөөрснөөр Банкны гүйцэтгэх удирдлага томилох шийдвэр хүчин төгөлдөр болно.

**Төлбөр барагдуулах дараалал**

Банк татан буугдсан үед төлбөр барагдуулах дарааллыг иргэд, хадгаламж эзэмшигчдийн төлбөрийн дарааллыг дээгүүрт тавьсан байна.

**Банкийг төлбөрийн чадваргүй болсон, төлбөрийн чадваргүй болох гарцаагүй нөхцөл байдал үүссэнд тооцох**

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 . 11 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03

Монголбанк доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь бүрдсэн тохиолдолд банк төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болох гарцаагүй нөхцөл байдал үүссэнд тооцно:

- Банк хадгаламж эзэмшигч, харилцагч, бусад үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болсон, эсхүл гаргаж өгөх боломжгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон;
- Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүйгээс цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;
- Банкны пассив нь активаасаа хэтэрсэн, эсхүл ердийн боломжит хугацаанд хэтрэх нь хяналт шалгалтаар тогтоогдсон.

**Банканд авах урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

Банк нь Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн, банкны тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй, эсхүл найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан бол Монголбанк банкны актив, өр төлбөрийн хэмжээ, өөрчлөлтийг хязгаарлах, эсхүл активыг төрөлжүүлэхийг даалгах зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зохицуулалт нэмсэн байна.

### 12.3.3. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

Энэхүү хууль нь 1995 оны 10 сарын 31-ний өдөр батлагдаж тухай бүрт нэмэлт, өөрчлөлт орсон ба банк, эрх бүхий хуулийн этгээдээс иргэн, хуулийн этгээдэд мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагаа үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Банк нь өдөр тутамдаа энэхүү хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх бөгөөд тус хуульд мөнгөн хадгаламжийн гэрээ, хадгалагч, хадгалуулагчийн эрх, үүрэг, мөнгөн хадгаламжийн данс, түүний төрөл, мөнгөн хадгаламжийн баталгаа, итгэмжлэлийг үндэслэн гүйлгээ хийх, мөнгөн хадгаламжийг өв залгамжлах, гэрээслэх тохиолдол, төлбөр тооцооны данс нээх, хаах, төлбөр тооцооны хэлбэр, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаа, зээлийн гэрээ, зээлийн барьцаа, зээл төлүүлэх ажиллагаа зэргийн тухай нарийвчлан заасан байдаг.

### 12.3.4. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийг 2018 оны 6 сарын 22-ны өдөр баталсан бөгөөд тус хуулиар банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор банканд хийсэн активын чанарын үнэлгээ, бусад холбогдох хяналт шалгалтын үр дүнд гарсан өөрийн хөрөнгийн дутагдлыг банкны хувьцаа эзэмшигч, бусад хөрөнгө оруулагчаар хангуулах, шаардлагатай бол төрөөс банкийг дахин хөрөнгөжүүлэх, оруулсан хөрөнгийг удирдах, төсөвт буцаан төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Банкны салбарт хийгдсэн активын чанарын үнэлгээгээр өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааг хангаагүй, системд нөлөө бүхий банкны хувьцаа эзэмшигчдэд өөрийн

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 ж 5903858

СЭХ
БҮРТГЭВ
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

хөрөнгийн дутагдлыг нэн тэргүүнд өөрийн нөөц бололцоогоор хангуулах, төрийн оролцооноос хувийн салбарын хөрөнгө оруулалтыг илүү хөхүүлэн дэмжих, тэргүүн ээлжид хувийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө босгох үйл ажиллагааг идэвхжүүлэх эрх зүйн орчинг уг хуулиар бүрдүүлсэн болно.

### 12.3.5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2013 оны 5 сарын 31-ний өдөр батлагдсан. Банк нь тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтад заасан мэдээлэх үүрэгтэй этгээд болохын хувьд харилцагчийг таньж мэдэх, тодорхой төрлийн гүйлгээнд хяналт тавих, НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу, мөн, харилцагчийн талаарх баримт материалыг таваас доошгүй жилийн хугацаанд хадгалах, сэжигтэй гүйлгээний талаар Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх зэрэг үүрэг хүлээж байна.

### 12.3.6. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

Энэхүү хууль нь 1995 оны 10 сарын 31-ний өдөр батлагдаж тухай бүрт нэмэлт, өөрчлөлт орсон ба банк, эрх бүхий хуулийн этгээдээс иргэн, хуулийн этгээдэд мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагаа үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Банк нь өдөр тутамдаа энэхүү хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх бөгөөд тус хуульд мөнгөн хадгаламжийн гэрээ, хадгалагч, хадгалуулагчийн эрх, үүрэг, мөнгөн хадгаламжийн данс, түүний төрөл, мөнгөн хадгаламжийн баталгаа, итгэмжлэлийг үндэслэн гүйлгээ хийх, мөнгөн хадгаламжийг өв залгамжлах, гэрээслэх тохиолдол, төлбөр тооцооны данс нээх, хаах, төлбөр тооцооны хэлбэр, банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн үйл ажиллагаа, зээлийн гэрээ, зээлийн барьцаа, зээл төлүүлэх ажиллагаа зэргийг тухай нарийвчлан заасан байдаг.

### 12.3.7. Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль

2013 оны 1 сарын 10-ны өдөр банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкан дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг баталсан. Тус хуулийн дагуу Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3 дахь заалтуудад заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк хадгаламж эзэмшигчийн хадгаламжийг энэ хуульд заасны дагуу хадгаламжийн даатгалд заавал даатгуулж, даатгалын хураамж төлөх үүрэг хүлээдэг.

## 12.4. Монголбанк, СЭХ-ноос баталсан үйл ажиллагаанд ач холбогдол бүхий журам, дүрмүүд

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТӨ8960 ● 5903858

СЗХ
2021 .11.03 өдөр
БУРТГЭВ
№ 01

2021 -11- 03
БУРТГЭВ-03

**12.4.1. Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам ("Түр журам")**

2021 оны 1 сарын 28-ны өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу системд нөлөө бүхий арилжааны банк нь банкийг нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуульд нийцүүлэн өөрчлөх ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, банк хувьцаагаа нийтэд болон хаалттай хүрээнд санал болгох төлөвлөгөө, нэгж хувьцааг санал болгох үнийн төсөөлөл, боломжит хөрөнгө оруулагчдын тандан судалгаа зэргийг тусгасан төлөвлөгөөг боловсруулан, 2021 оны 7 сарын 1-ний өдрийн дотор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх үүрэг хүлээсэн.

Төлөвлөгөөнд тавигдах нөхцөл шаардлагыг тоймловол:

- Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцааны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны хорин хувиас хэтрэхгүй байх тухай шаардлагын дагуу банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, нарийвчилсан төлөвлөгөө, боломжит хөрөнгө оруулагчдын талаарх мэдээлэл болон уг шаардлагыг хангасны дараагаар банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд хэрхэн өөрчлөлт орох талаар хийсэн тооцоо, мэдээлэл;
- Нийтэд санал болгон анх удаа гаргах нэгж хувьцааны үнийг тодорхойлсон үнэлгээний төсөөлөл, судалгаа;
- Зах зээлийн баттаамжийн судалгаа болон боломжит хөрөнгө оруулагчдын талаарх тандан судалгаа.

Түр журмын зарим гол агуулгыг дурдвал:

- Банк нь компанийн хэлбэрээ хувьцаат компани болгон өөрчлөх, хувьцаат болгон өөрчилсөнтэй холбоотой улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулах ажлыг 2022 оны 6 сарын 30-ны өдрийн дотор хэрэгжүүлэхээр төлөвлөгөөндөө тусгана.
- Банк нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д зааснаар Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх бөгөөд банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, төлөвлөгөө, боломжит хөрөнгө оруулагчдын талаарх мэдээллийг 2023 оны 12 сарын 31-ний өдрийн дотор хэрэгжүүлэхээр төлөвлөгөөндөө тусгана.
- СЗХ, Монголбанк нь Төлөвлөгөөг бүрэн гүйцэд хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор хянаж, банканд мэдэгдэнэ. (Түр журмын төслийн 3.1).
- Төлөвлөгөөг хэрэгжих боломж хязгаарлагдмал, үндэслэлгүй, эсвэл шаардлага хангаагүй гэж үзвэл төлөвлөгөөг шинэчилж ирүүлэхийг банкнаас шаардах (Түр журмын төслийн 3.2, 3.3).

БОГД БАНК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 ▲ 5903858

СЗХ
2021 . 11 . 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

- Банк нь тус шаардлагад заасан хугацаанд Төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, СЗХ, Монголбанканд хүргүүлэх үүрэгтэй.

**12.4.2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, шинээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, хувьцаагаа нийтэд санал болгох, банкны хувьцааг худалдах, шилжүүлэх, үүнтэй төстэй бусад хэлцэл хийх болон аливаа этгээд банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахад Монголбанкинд мэдэгдэх, зөвшөөрөл авах журам**

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11 дэх заалтад банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, шинээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, хувьцаагаа нийтэд санал болгох, банкны хувьцааг худалдах, шилжүүлэх, үүнтэй төстэй бусад хэлцэл хийх болон аливаа этгээд банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахад энэ хуулийн 36.3-т заасны дагуу тогтоосон шалгуурыг үндэслэн Монголбанкинд мэдэгдэх, зөвшөөрөл авах журмыг Монголбанк Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална гэж заасан.

Банкны үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд Монголбанкны хяналтад, харин арилжааны банк нь хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргаж, нээлттэй хувьцаат компани болсноор засаглал, тайлагнал, бүртгэлийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооны хяналтад давхар хянагдах юм.

**12.4.3. Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам**

Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг банкны хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон нэгдмэл сонирхолтой этгээдийн эрх ашигт нийцүүлэх, улмаар банкны зохистой засаглалын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 сарын 30-ны өдрийн А-151 тоот тушаалаар батлагдаж, 2018 оны 8 сарын 2-ны өдөр нэмэлт орсон "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам" батлагдсан. Тус журамд заасны дагуу банкны ТУЗ нь банканд зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд зааснаас гадна дараах үүргийг хүлээдэг:

- Банкны Гүйцэтгэх удирдлагад хяналт тавих, ажлын үр дүнгийн тайланг улиралд нэгээс доошгүй удаа авч хэлэлцэх, Хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах;
- Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон нэгдмэл сонирхолтой этгээдийн эрх ашгийг хамгаалах;
- Банкны бодлого, стратеги, эрсдэл даах сонирхлыг тодорхойлох, банканд үр ашигтай шийдвэр гаргах;
- Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо,хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, банкны бүтцийн өөрчлөлт зэрэг гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;

БОГД БАНК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 - 5903858

СЗХ
2021 -11- 03
ЕБҮТГЭВ
№ 01
2021 -11- 03

- ТУЗ-өөс Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээнд эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах тогтолцоог бүрэн тусгаж, гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэх;
- Банкны удирдлагыг сонгон шалгаруулах, тэдгээрийн залгамж халааг бэлтгэх төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөнд удирдах дээд албан тушаал бүрд тавигдах ажил мэргэжлийн шаардлага, чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хангалттай түвшинд бэлтгэхийг тодорхой тусгасан байх;
- Гүйцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, урт хугацааны хэтийн зорилго, стратеги төлөвлөгөө, ёс зүйн хэм хэмжээ болон гэрээнд заасан үүргийн биелэлт зэрэгтэй уялдуулан шийдвэрлэх;
- Хууль тогтоомж болон банкны дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай, үнэнч шударгаар гүйцэтгэж, чандлан сахих;
- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас банкны өмнө хүлээсэн үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд саад тотгор үзүүлэх үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;
- Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад заасан шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж, хөндлөнгийн аудит хийлгэх;
- Банкны дотоод аудитын асуудал эрхэлсэн нэгжээс хийсэн шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг цаг тухайд нь авч хэлэлцэн, зохистой засаглал болон дотоод хяналтын тогтолцоог сайжруулах талаар Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцох;
- Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг ур чадвараа дайчлан, хичээл зүтгэл гарган ажиллах.

### 12.4.4. Банкны нэгжийн журам

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 7 сарын 3-ны өдрийн А-99 тоот тушаалаар батлагдсан Банкны нэгжийн журамд зааснаар банкны төлөөлөгчийн газар, салбар, тооцооны төв байгуулахад Монголбанкнаас ерөнхий зөвшөөрөл олгох ба банк нь тооцооны касс байгуулах, татан буулгах асуудлыг өөрөө шийдвэрлэх эрхтэй. Монголбанкнаас банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 6 сарын хугацаанд тогтмол ханган ажилласан, Монголбанкны газар дээрх иж бүрэн шалгалтын үнэлгээгээр дунд ба түүнээс дээш үнэлгээ авсан, зөвшөөрөл хүсэх үед албадлагын арга хэмжээний хүрээнд банкны зарим үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хязгаарлах, хянагч томилох арга хэмжээ авагдаагүй буюу хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд салбар, тооцооны төв байгуулах зөвшөөрлийг банканд олгодог.

### 12.4.5. Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 6 сарын 10-ны өдрийн А-155/134 тоот тушаалаар Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам шинэчлэн батлагдсан. Тус журмын дагуу банк нь нягтлан бодох бүртгэл болон удирдлагын үйл ажиллагааны зорилгоор өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээнд нийцүүлэн активыг хэвийн, анхаарал хандуулах, чанаргүй ангилал буюу хэвийн бус, эргэлзээтэй, муу зэргээр ангилж, эрсдэлийн сан байгуулах, активын эрсдэлийн удирдлагын талаар дотооддоо баримтлах бодлого, журам, заавар, аргачлал зэргийг боловсруулан дагаж мөрдөх үүрэгтэй.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
Т: 8966 - 5903858

СЗХ
2021 оны 11 сарын 17 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

### 12.4.6. Банкны тухай хуулийн 6.2-т заасан үйл ажиллагааны зохицуулалтын журам

СЗХ-ны 2011 оны 2 сарын 23-ны өдрийн 45 дугаар тогтоолын хавсралтаар Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан үйл ажиллагааны зохицуулалтын журам батлагдсан ба тус журмын дагуу СЗХ-ноос дараах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг банканд олгоно:

- санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх
- итгэлцлийн үйлчилгээ
- даатгалын зуучлагч
- кастодиан
- факторингийн үйлчилгээ.

## 12.5. Дагаж мөрдөх бусад хууль тогтоомжууд

### 12.5.1. Компанийн тухай хууль

Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргаж, нээлттэй хувьцаат компани болсноор Компанийн тухай хуулийн хувьцаат компани болон түүний үйл ажиллагаатай холбогдох зохицуулалтуудыг дагаж мөрдөх шаардлагатай болно.

Хувьцаа эзэмшигчдийн өмчлөх эрхийн бүртгэл хийгдсэний дараагаар компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хуулийн 9 дүгээр бүлэг, СЗХ-ны холбогдох журмын дагуу зарлан хуралдуулж, нээлттэй хувьцаат компанийн дүрмийг батлан, төлөөлөн удирдах зөвлөлийг сонгон, компанийг нээлттэй хувьцаат үйл ажиллагаа эрхэлдэг компанийн хэлбэрээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлдэг.

### 12.5.2. Татварын ерөнхий хууль

Татварын ерөнхий хууль 2019 оны 3 сарын 22-ны өдөр шинэчлэгдэн найруулагдсан. Энэхүү хуулиар Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргагч нь Татварын Ерөнхий хуульд зааснаар татвар төлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх, хариуцлага хүлээх болон холбогдох харилцаанд хуулиар тогтоосон журмыг баримтлах үүрэг хүлээнэ.

### 12.5.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль нь 2019 оны 3 сарын 22-ны өдөр батлагдсан бөгөөд татварын хувь хэмжээ, аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татвар ногдуулах, ус албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 - 5903858

СЭХ
2021.11.10
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 10 хувиас 25 хувийн хооронд байх бөгөөд дараах хувь хэмжээг үндэслэн тогтоодог:

- 6 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах орлого - 10 хувь;
- Татвар ногдуулах жилийн орлого 6 тэрбум төгрөгөөс дээш бол 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод - 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.

### 12.5.4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль

2018 оны 6 сарын 21-ний өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. Тус хуульд заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд нь хуулийн этгээдийн хувийн хэрэг дахь мэдээлэлд орсон аливаа өөрчлөлтийг ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлж, бүртгүүлэх үүрэг хүлээдэг.

### 12.5.5. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор УИХ-аас 2020 оны 4 сарын 29-ний өдөр дээрх хуулийг баталсан бөгөөд тус хууль нь 2021 оны 6 сарын 30-ныг хүртэл үйлчилнэ. КОВИД-19 цар тахлын нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу цар тахлын үед Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанк, Улсын онцгой комисс болон бусад холбогдох байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг дор тоймлон авч үзэв. Ингэхдээ, аж ахуйн нэгж байгууллага, бизнес эрхлэгчдэд илүү хамааралтай гэж үзсэн арга хэмжээнүүдэд түлхүү анхаарал хандуулсан болно.

КОВИД-19 цар тахлын нөлөөллийг бууруулах тухай хуулиар Монголбанкны зүгээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

- Төгрөгийн болон банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийн тодорхой салбарыг дэмжих, банкны санхүүгийн байдлыг сайжруулах зорилгоор банканд зээл олгох Төв банк /Монголбанк/-ны тухай хууль -д заасан үйл ажиллагаа явуулж, хуульд заасан арга, хэрэгслийг ашиглах;
- Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор дотоод болон гадаадын улс, олон улсын банк, санхүүгийн байгууллага, хуулийн этгээдээс зээл болон бусад хэлцлээр гадаад валют авах, худалдан авах нөхцөлтэйгөөр дотоодын банк, санхүүгийн байгууллагад зээл олгох;
- Эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй ипотекийн зээлийн тусгай бүтээгдэхүүн гаргах;
- Барилгын салбарын зээлийн чанар муудахаас сэргийлэх, ажлын байрыг хадгалах зорилгоор Монголбанкнаас олгосон санхүүжилтийн үндсэн төлбөрийн эргэн

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 - 5903858

СЗХ
ирсэн тар
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03

төлөлтийн хэмжээгээр орон сууцны ипотекийн зээлийг үргэлжлүүлэн санхүүжүүлэх; болон

- Ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр нийт 6 хүртэлх сараар хугацааг сунгах асуудлыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

### 12.5.6. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль 2009 оны 7 сарын 9-ны өдөр батлагдсан бөгөөд тус хуулиар бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба банк, банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн хадгаламж, зээл, тэдгээртэй адилтгах аливаа үйлчилгээ, санхүүгийн үүсмэл хэрэгсэлтэй холбоотой байгуулах гэрээ, түүгээр хүлээх үүргийг гүйцэтгэхээс бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглодог.

### 12.5.7. Зээлийн мэдээллийн тухай хууль

2011 оны 10 сарын 30-ны өдөр батлагдсан Зээлийн мэдээллийн тухай хуульд зааснаар арилжааны банк нь зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч болохын хувьд дараах эрх, үүрэгтэй:

- зээлийн мэдээллийн нууцлалын аюулгүй байдал, хамгаалалтыг хангахыг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс шаардах;
- зээлийн мэдээлэлд орсон нэмэлт, өөрчлөлтийг эх сурвалжид тулгуурлан тухай бүрд нь хийж, зээлийн мэдээллийг баяжуулан боловсруулалт хийж байхыг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс шаардах;
- зээлийн мэдээллийн санд шилжүүлсэн мэдээлэлд худал, буруу ташаа нэмэлт мэдээлэл оруулахгүй байхад хяналт тавих;
- нийлүүлсэн зээлийн мэдээллийн эх сурвалжид эргэлзээтэй байдал үүссэний улмаас уг мэдээллийг тодруулах, нягтлан шалгах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зээлдэгч болон холбогдох бусад байгууллагад хүсэлт гаргаж, хамтран ажиллах.
- зээлийн мэдээллийн үнэн зөвийг нягтлан шалгаж, бодитой, тодорхой, эх сурвалжид нийцсэн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлэх;
- зээлийн мэдээллийг солилцоход энэ хуульд заасан шаардлагыг биелүүлэх;
- зээлийн мэдээллийг дутуу, алдаатай нийлүүлсэн тохиолдолд түүнийг засах, гүйцээх, нэмэлт оруулах арга хэмжээг нэн даруй авах.

## 12.6. Компанийн Засаглалын Кодекс

Компанийн Засаглалын Кодекс нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 5 сарын 7-ны өдрийн 162 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан. Мөн Энэхүү Компанийн Засаглалын Кодексг 1999 онд баталж, улмаар 2004 онд нэмэлт өөрчлөлт оруулаад байгаа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас баталсан "Компанийн засаглалын зарчим"-ыг удирдлага болгосон байна.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ6966 ⁂ 5903858
162

Компанийн Засаглалын Кодекст Хувьцаа эзэмшигчдийн эрх, мэргэжлийн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмших хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал, дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэх зарчмуудыг Компани нь өөрсдийн холбогдох журам, үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлэхийг зөвлөдөг. Компанийн засаглалын кодекс нь дараах зарчмуудаас бүрдэнэ:

**Компанийн засаглалын үр ашиг бүхий тогтолцооны үндсийг бүрдүүлэх**

Компанийн засаглалын үндсэн тогтолцоо нь эдийн засагт үзүүлэх нөлөө, зах зээлийн бүрэн бүтэн байдлыг дэмжсэн үр ашигтай, шударга байх ёстой. Энэ нь хууль дүрэмтэй нийцэж, үр дүнтэй хяналт шалгалт хийх, хэрэгжүүлэх боломжийг хангасан байна. Хянах, зохицуулах, хууль сахиулах байгууллагууд нь өөрийн эрх үүргээ шударгаар мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх эрх мэдэл, хүчин чадал нөөцөөр хангагдсан байх. Мөн тэдний шийдвэр нь цагаа олсон, ил тод, ойлгомжтой буюу тодорхой мөн нийтийн эрх ашигт нийцсэн байх ёстой бөгөөд олон улсын хамтын ажиллагааг байнга сайжруулж, хөгжүүлж байх нь зүйтэй.

**Хувьцаа эзэмшигчдийн эрх, бүх хувьцаа эзэмшигчдэд адил, тэгш хандах**

Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах болон эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлээд зогсохгүй, бүх хувьцаа эзэмшигчид ялангуяа цөөнх хувьцаа эзэмшигчдийг ялгаварлахгүй адил хандах нөхцөлийг бүрдүүлсэн байхаас гадна хувьцаа эзэмшигчид зөрчигдсөн эрхээ үр дүнтэйгээр нөхөн сэргээж авах боломжоор хангагдсан байх ёстой.

**Мэргэжлийн хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээл болон бусад зуучлагч**

Компанийн засаглалын тогтолцоо нь хөрөнгө оруулалтын гинжин хэлхээний туршид зохистой хөшүүрэг үзүүлж, үнэт цаасны зах зээлийг компанийн сайн засаглалд хувь нэмэр оруулахуйц байдлаар үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлнэ. Мэргэжлийн хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулагчдын шийдвэрт нөлөөлөх дүн шинжилгээ, зөвлөгөө өгдөг итгэмжлэгдсэн зөвлөх, шинжээч, брокер, рейтингийн буюу үнэлгээний байгууллага нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж үнэн зөв, найдвартай мэдээллийг нээлттэй хүргэж байх шаардлагатай.

**Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг**

Компанийн засаглалын тогтолцоо нь оролцогч талууд болох хувьцаа эзэмшигчид, ажилчид, зээлдүүлэгчид, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид болон бусад оролцогч талуудын эрхийг хууль тогтоомж, хамтын гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, мэдээллээр цаг алдалгүй хангаж оролцогч талуудын хоорондын идэвхтэй хамтын ажиллагааг дэмжихэд чиглэгдэнэ.

**Мэдээллийн нээлттэй, ил тод байдал**

Компанийн засаглалын тогтолцоо нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа, өмчлөл, болон засаглалтай холбоотой бүхий л мэдээллүүд нь хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргах чухал мэдээллүүд байдаг тул мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, нийтэд нээлттэй байлгах боломжоор ханган. Мэдээлэл ил тод байснаар компаниуд хөрөнгө татах болон зах зээл дээр илүү итгэлцлийг бий болгох боломжтой болдог. Мөн санхүүгийн тайланг хөндлөнгийн, мэргэжлийн аудитын байгууллагаар баталгаажуулж байх ёстой байдаг.

**ТУЗ-ийн үүрэг хариуцлага**

Компанийн засаглал нь ТУЗ-ийн зүгээс компанийн үйл ажиллагааг стратеги удирдлагаар ханган, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд байнгын зохистой хяналтыг тавьж, хараат бус, бие даасан шийдвэр гаргах, компани болон хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээх, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах боломжийг бий болгодог байна.

## 12.7. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

ҮЦЗЗтХ-ийн 6 дугаар зүйлд зааснаар *"нийтэд санал болгох"* гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу үнэт цаасаа 50-аас дээш тооны этгээдэд санал болгон худалдахаа мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэхийг хэлдэг. СЗХ нь нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны журам, заавар, дарааллыг баталдаг. Үүнээс гадна эдгээртэй нийцүүлэн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага буюу хөрөнгийн бирж нь өөрийн биржид арилжих үнэт цаасны бүртгэлийн журмыг мөн баталдаг.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7 дох заалтад зааснаар СЗХ нь дор дурдсан нөхцөлийн аль нэг нь бүрэн хангагдсан бол үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон гэж үздэг:

- үнэт цаасыг нэрлэсэн үнээр гаргаж байгаа тохиолдолд санал болгосон бүх хувьцаа худалдагдсан буюу тухайн үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийг үнэт цаас гаргагчийн холбогдох дансанд бүрэн байршуулсан;
- үнэт цаасыг нэрлэсэн үнээс дээгүүр үнээр худалдсан тохиолдолд нийтэд санал болгосон үнэт цаасны танилцуулгад заасан төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, үнэт цаас гаргагчийн холбогдох дансанд бүрэн байршуулсан;
- андеррайтер оролцсон тохиолдолд андеррайтерийн гэрээний дагуу үнэт цаасны төлбөл зохих төлбөрийг бүрэн хийсэн буюу заасан нөхцөлийг бүрдүүлсэн.

ҮЦЗЗтХ-ийн 27.3-д Банк, түүний толгой, банкны нэгдэлд орсон болон банкны хувьцааны таваас дээш хувийг эзэмшиж байгаа хуулийн этгээд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхээр Хороонд хүсэлт гаргаж байгаа тохиолдолд Банкны тухай хуульд заасан холбогдох журмыг баримтлахаар заасан байдаг.

## 12.8. Үнэт цаасны бүртгэлийн журам

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

### 12.8.1. Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам

2015 оны 11 сарын 23-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны 408 тоот Үнэт цаасны бүртгэлийн журмын зорилго нь компанийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгслийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхэд үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэх байгууллага, Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх, үүргийг тодорхойлох, хувьцаа, өрийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, бүртгэхээс татгалзах, бүртгэсэн үнэт цаасыг нийтэд танилцуулах, анхдагч зах зээлд арилжих, тайлагнах, Хорооны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү журмын дагуу Үнэт цаас гаргагч нь анх удаа нийтэд санал болгох үнэт цаас гаргах хүсэлтээ Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад нэгэн зэрэг гаргаж бүртгүүлнэ. Мөн тус журмаар, Үнэт цаас бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг, хүсэлтийг хянах, Санхүүгийн Зохицуулах Хорооны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах, үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд танилцуулах, үнэт цаасыг бүртгэлээс хасах, хүлээх хариуцлага зэргийг тусгаж өгсөн байдаг.

### 12.8.2. "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам

2018 оны 1 сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлсан "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмаар үнэт цаас гаргагчийн хувьцаа, өрийн хэрэгслийг МХБ-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, үнэт цаасыг нийтэд танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаасыг бүртгүүлэхэд тавигдах шаардлага болон бүрдүүлэх баримт бичиг нь тухайн үнэт цаасны төрөл, үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны байдал, үнэт цаасыг гаргах хэлбэрээс хамаарч өөр байна.

Мөн түүнчлэн үнэт цаас бүртгүүлэх ажиллагааны бэлтгэл, бүртгүүлэх хүсэлт хэрхэн гаргах, бүрдүүлэх баримт бичиг, үнэт цаасны танилцуулгын агуулга, хэлбэр, үйлчилгээний хөлс, бүртгэлээс хасах үндэслэл, хүлээх хариуцлага зэргийг тусгаж өгсөн байдаг.

### 12.8.3. "Монголын үнэт цаасны бирж" ХХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам

2018 оны 5 сарын 24-ний өдрийн 16 тоот тогтоолоор батлсан "Монголын үнэт цаасны бирж" ХХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмаар шинээр болон нэмж гаргах үнэт цаасыг Биржид бүртгүүлэхтэй холбоотойгоор үнэт цаас болон үнэт цаас гаргагчид тавигдах шаардлагыг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Компанийн өрийн хэрэгсэл, хадгаламжийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, варрант, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх зэрэг хувьцаанаас бусад үнэт цаас бүртгүүлэхэд энэ журамд зааснаас гадна Биржийн тогтоосон нэмэлт шаардлагыг хангасан байна.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 ★ 5903858

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
2021-11-03
БҮРТГЭВ-03

# АРВАН ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13 дахь хэсэгт заасны дагуу энэхүү үнэт цаасыг Бирж бүртгэсэн нь эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ямагт эрсдэлтэй үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Тус бүлэгт тодорхойлсон эрсдэлүүд нь зөвхөн үнэт цаасны танилцуулгыг бэлдэх үед тодорхойлсон болзошгүй эрсдэлүүд ба урьдчилан тодорхойлох боломжгүй, гэнэтийн болон эрсдэл гэж тооцоогүй үйл явдлууд нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт, ирээдүйн ашигт сөргөөр нөлөөлөх боломжтой ба энэ нь үнэт цаасны ханшид нөлөөлж, хөрөнгө оруулагч өөрийн оруулсан бүх хөрөнгө эсвэл хөрөнгийн зарим хэсгийг алдах эрсдэлтэй болохыг анхаарна уу.

## 13.1. Үнэт цаасны танилцуулгад орсон мэдээлэлтэй холбоотой эрсдэл

### 13.1.1. Статистикийн мэдээлэлтэй холбоотой эрсдэл

Тус үнэт цаасны танилцуулга нь Богд Банкны дотоод мэдээллээс гадна Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Үндэсний статистикийн хороо зэрэг зохицуулагч байгууллагуудын олон нийтэд нээлттэй статистик мэдээлэл болон бусад гуравдагч этгээдийн мэдээлэл дээр үндэслэсэн болно. Эдгээр мэдээллүүдийг үнэн, зөв гэсэн үндэслэл дээр тус үнэт цаасны танилцуулгыг бэлтгэсэн хэдий ч Богд Банк нь мэдээлэл бүрийн үнэн зөв байдал дээр хяналт, баталгаажуулалт хийгээгүй болно. Тиймээс эдийн засгийн үзүүлэлт, банк санхүүгийн салбарын үзүүлэлт зэрэг нь бүрэн бус эсхүл үнэн бус байж болзошгүй.

## 13.2. Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгохтой холбоотой эрсдэл

### 13.2.1. Хувьцааны хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэл

Хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах нь үргэлж үнийн хэлбэлзлийн эрсдэлийг дагуулж байдаг. Богд Банк нь хувьцаагаа нээлттэй зах зээл дээр арилждаг болсноор хувьцааны үнэ өсөн эсхүл хувьцаа нь идэвхтэй арилжаалагдана гэх баталгаа байхгүй. Ирээдүйд дахин хувьцаагаа олон нийтэд санал болгохгүй гэх баталгаа байхгүй ба энэ тохиолдолд хувьцааны үнэд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй.

### 13.2.2. Ногдол ашигтай холбоотой эрсдэл

Богд Банк нь ирээдүйд тогтмол ногдол ашиг хуваарилна гэх баталгаа байхгүй ба банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл нь өөрийн бүрэн эрхийн дагуу ногдол ашиг хуваарилахгүй байх эсхүл хөрөнгө оруулагчийн хүлээлтээс бага хэмжээний ногдол ашгийг хуваарилах шийдвэр гаргаж болно. Банк нь ногдол ашгийн бодлогоо үл биелүүлэх, ногдол ашиг

БОГД БАНК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ
5168966 ▲ 5903858
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
БҮРТГЭВ-03

хуваарилалт нь хөрөнгө оруулагчийн хүлээлтэд хүрэхгүй байх зэрэг нь Богд Банкны хувьцааны үнэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

## 13.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүд

### 13.3.1. Макро эдийн засгийн эрсдэл

Богд Банк нь дотоодын болон дэлхийн эдийн засгийн нөхцөл байдалд өртөмтгий байна. Тиймээс Засгийн газрын эдийн засгийн хүрээнд баримталж буй бодлого, улсын эдийн засгийн өсөлт, дэлхийн эдийн засгийн өсөлт, геополитикийн нөхцөл байдал, түүхий эдийн эрэлт, нийлүүлэлт зэрэг хүчин зүйлс нь банкны үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлнө. Эдийн засгийн агшилт, аливаа нэг салбарын болон бүс нутгийн эдийн засгийн сааралт, улс төрийн онцгой нөхцөл байдал нь банкны үйл ажиллагаа болон стратегид сөргөөр нөлөөлөх ба энэ нь материаллаг байж болзошгүй.

### 13.3.2. Банк, санхүүгийн салбарын системийн эрсдэл

Тодорхой нэг томоохон санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа доголдох, дефолт зарлах зэргээс үүдэн харилцагч талуудад гинжин сөрөг нөлөө үзүүлж, иргэдийн санхүүгийн байгууллагад итгэх итгэл алдарч улмаар санхүүгийн системийн тогтвортой байдалд аюул учрах эрсдэлийг банк, санхүүгийн салбарын системийн эрсдэлд харгалзан үзнэ. Салбарын харилцагч талуудад гинжин сөрөг нөлөө гарах нь банкны үйл ажиллагаанд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

### 13.3.3. Өрсөлдөөний эрсдэл

2020 оны эцсийн байдлаар Монгол Улсад нийт 12 банк үйл ажиллагаагаа эрхэлж байна. Үүнээс таван банкийг системийн нөлөө бүхий банк хэмээн Монголбанкнаас тодорхойлсон нь Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк, Голомт банк, Хас банк ба Төрийн банк бөгөөд эдгээр нь нийт банкны системийн 85 орчим хувийг бүрдүүлж байна. Ирээдүйд шинэ банк үүсгэн байгуулагдах, гадаадын арилжааны банк Монголд үйл ажиллагаагаа эрхлэх хууль, эрх зүйн нөхцөл бүрдэх, банк болон санхүүгийн байгууллагад хоорондоо нэгдэх зэрэг нь Богд банкны хувьд өрсөлдөөний эрсдэлийг бий болгоно. Үүнээс гадна, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар системийн нөлөө бүхий 5 банк 2022 оны 2 дугаар улирлаас өмнө нээлттэй хувьцаат компани болох шаардлагатай байгаа бол бусад 7 банк нь нээлттэй болон хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай болсон. Хэдийгээр Богд банк бусад банкуудаас түрүүлж алхан, нээлттэй хувьцаат банк болох алхмыг хамгийн эхэнд хийсэн ч өрсөлдөгч банкууд мөн нээлттэй болох нь цаашид өрсөлдөөний сул талыг үүсгэж болзошгүй.

### 13.3.4. Улс төрийн нөхцөл байдалтай холбоотой эрсдэл

Монгол улсын өнөөгийн улс төрийн тогтолцоо, хэрэгжүүлж буй бодлого, хуулийн хэрэгжилт хангалттай тогтвортой бус юм. Манай улс төрийн систем нь 1992 онд Үндсэн хууль батлагдсаны дагуу парламентын засаглалтай, УИХ-ын сонгуулийг ардчилсан

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 • 5903858

СЗХ
2021 оны 11 дэвр
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

зарчмаар явуулж эхэлсэн. УИХ нь 76 суудалтай ба одоо мөрдөгдөж буй сонгуулийн хуулиар 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг тус бүр нь нэг буюу олон мандаттайгаар 26 тойрогт хуваагдаж 76 гишүүнийг сонгодог. Монгол Улсын Ерөнхийлөгч нь УИХ-ын шийдвэрийн хэрэгжилтэд хориг тавих эрх бүхий этгээд юм. Энэ жилийн Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд 2020 онд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орсны дагуу 4 жил тутамд сонгогдог байсан нь 6 жил болж өөрчлөгдсөн тул цаашид Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх барих хугацаа 6 жил болж байна. Сүүлийн жилүүдэд УИХ-д эрх барьж буй нам, гишүүд огцрох, тухайн жилд эрх барьж буй намын хэрэгжүүлж буй хууль, бодлого нь дараах сонгуулийн жилд тогтвортой, уялдаа холбоотойгоор хэрэгжихгүй байх нөхцөл байдлууд ихээр үүсэж буй юм. Дээрх хүчин зүйлс нь манай улсын эдийн засаг, ДНБ, хөрөнгө оруулалт хийгээд банкны үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд нөлөөлдөг тул энэхүү улс төрийн тогтворгүй байдал нь банкны бизнесийн стратеги, санхүү болон үйл ажиллагаанд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

### 13.3.5. Бизнесийн эрсдэл

Богд Банкны өнөөгийн баримталж буй бизнесийн стратеги, өсөлтийн төлөвлөгөө нь банкны хувьд хамгийн оновчтой бөгөөд амжилттай байх, эсхүл эдгээр нь оновчтой байсан ч банк нь аливаа эрсдэлд өртөхгүйгээр стратеги, төлөвлөгөөгөө хэрэгжүүлнэ гэх баталгаа байхгүй. Эдгээр нь зөвхөн Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, чадавхаас гадна Монгол Улсын төдийгүй дэлхийн эдийн засаг, зах зээлийн байдлаас шалтгаална. Дээрх хүчин зүйлс нь банк стратегийн хэрэгжилтийг амжилттай гүйцэтгэх эсэхэд нөлөөлнө. Урьдчилан тодорхойлох боломжгүй, гэнэтийн гадаад болон дотоод хүчин зүйлс нь банкны бизнесийн стратегид эрсдэл үүсгэж, санхүүгийн болон үйл ажиллагааны материаллаг сөрөг нөлөө гарч болзошгүй.

### 13.3.6. Үйл ажиллагааны эрсдэл

Богд Банк нь үйл ажиллагааны эрсдэлийг бууруулахаар дотоод хяналтын зохистой бодлого, журам, процессыг бий болгосон боловч энэ нь үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн хаах баталгааг өгөхгүй. Хүний хүчин зүйлийн эрсдэл буюу ажиллагсад алдаа гаргах, үйл ажиллагааны болон дотоод хяналтын журмыг үл мөрдөх, хууль, журам, стандарт, банкны стратегид үл нийцэх үйлдэл гаргах зэрэг нь зарим тохиолдолд банкны урьдчилан сэргийлэх хяналтаас гадуур үйлдэгдэж болзошгүй ба тэдгээрийг банкны холбогдох нэгжүүд тухай бүр илрүүлэх баталгаа байхгүй тул хүний хүчин зүйлээс үүсэх эрсдэл нь банкны үйл ажиллагаа, ашигт ажиллагаа, ирээдүйн зорилтод материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

### 13.3.7. Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэгт зээлдэгч гэрээний үүргээ үл биелүүлэх, зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийг цаг хугацаанд төлөхгүй байх, зээлийн чанар муудах зэрэг эрсдэл орно. Зээлийн эрсдэлд гадаад хүчин зүйлс болох макро эдийн засгийн байдал, санхүүгийн системийн нөхцөл байдал нөлөөлөхөөс гадна дотоод хүчин зүйлс болох банкны зээлийн болон актив, пассивын бодлого нөлөөлнө. Зээлдэгч бүрийн нөлөө нь харьцангуй байх ба тухайн зээлийн хугацаа, дүнгээс шалтгаалан банкны санхүүгийн байдалд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
БҮРТГЭВ-03

санхүүгийн тайлангаар банкны нийт зээлийн багц 98.6 тэрбум төгрөг байсныг 1.9 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.1 хувийг чанаргүй зээлийн багц эзэлж байна. 2020 оны эцсээр Балансын гадуурх үүрэгт 21.1 тэрбум төгрөгийн баталгаа гаргасан ба нийт баталгааны 80 хувийг эх үүсвэргүй баталгаа, 20 хувийг эх үүсвэртэй баталгаа эзэлсэн байна. Цаашид зах зээлийн болон санхүүгийн системийн нөхцөл байдал болон банкны баримталж буй дотоод бодлого нь зээлийн эрсдэлийг хамгийн бага түвшинд барихад хүндрэл учруулахгүй гэсэн баталгаа байхгүй.

### 13.3.8. Зээлийн төвлөрлийн эрсдэл

2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайлангаар Богд банкны нийт зээлийн багц 98.6 тэрбум төгрөг байснаас нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь нь 18.04 хувь, Хувь нийлүүлэгч, банкны ажилтан, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээлийн нэг этгээдэд олгосон дүн өөрийн хөрөнгөд 4.56 хувийг, нийлбэр нь өөрийн хөрөнгөд 13.17 хувийг эзэлж байгаа нь тус бүр Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 болон 17.3 дахь заалтууд буюу Монголбанкны шалгуур үзүүлэлтийг хангаж байна. Нийт зээлийн багц 96 хувь нь төгрөгийн зээл, 4 хувь нь валютаар олгосон зээлээс бүрдэж байсан ба 38 хувь нь иргэдийн зээл, 62 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл байв. Том 40 зээлдэгч нь нийт зээлийн багцын 85 хувийг бүрдүүлж байсан бол хамгийн том зээлдэгч нь 10 хувийг бүрдүүлсэн нь зээлийн төвлөрлийн эрсдэл байгааг илэрхийлж байна.

### 13.3.9. Зээлийн барьцаа хөрөнгөтэй холбоотой эрсдэл

Богд Банк нь өөрсдийн Банкны зээлийн бодлогын дагуу зээлийн барьцаа хөрөнгийн шалгуур, үнэлгээ, гэрээ байгуулах, хяналт тавих зэрэг асуудлуудыг Иргэний хууль болон бусад холбогдох хууль, мөн өөрсдийн Зээлийн үйл ажиллагааны журмаар зохицуулж байна. Зээлийн барьцааны хөрөнгө нь үнэлгээтэй байх, зах зээлд эрэлттэй буюу түргэн борлогдох чадвартай байх, өмчлөх эрх шилжүүлэхэд амар байх, хүчинтэй байх, хөшүүргийн үнэ цэнтэй байх, хяналт тавих боломжтой байх, өмчлөх эрх зүйн маргаангүй байх зэрэг шаардлагыг хангасан байхаар зохицуулсан. Богд Банкны 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт зээл 98.6 тэрбум төгрөг, барьцаа хөрөнгийн үнэлгээ 219.4 тэрбум буюу зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) нь 45 хувь байна. Үүнийг иргэдийн болон хуулийн этгээдийн зээлээр ангилбал иргэдийн 37.3 тэрбум төгрөгийн зээлийн ЗҮХ нь 50 хувь, хуулийн этгээдийн 61.3 тэрбум төгрөгийн зээлийн ЗҮХ нь 42 хувь байна. Банкны салбарын хувьд зээлийн төрөл, зээлдэгчийн санхүүгийн чадамжаас хамааран ЗҮХ-ийн дээд хэмжээ нь 40 - 80 хувь байдаг тул Богд Банкны ЗҮХ нь бага түвшинд буюу эрсдэл багатай байна. Хэдийгээр тийм боловч, зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ нь зах зээлийн орчноос хамааран хувьсан өөрчлөгдөж байх тул ирээдүйд эдгээр барьцаа хөрөнгийн үнэлгээ нь өнөөгийн түвшинд хадгалагдана гэх баталгаа байхгүй.

### 13.3.10. Эх үүсвэрийн эрсдэл

Богд Банк нь 2020 оны эцсийн байдлаар 121.9 тэрбум төгрөгийг харилцах, хадгаламж байдлаар татан төвлөрүүлсэн бол 36.7 тэрбум төгрөгийг зээл, репо санхүүжилт, төслийн санхүүжилт зэргээр эх үүсвэр татсан байна. Нийт 121.85 тэрбум төгрөгийн харилцах, хадгаламжийн 36 хувь нь иргэдийн, 31 хувь нь хуулийн этгээдийн, 33 хувь нь банк,

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТЕ8966 - 5903858

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж байна. Иргэдээс татан төвлөрүүлсэн 43.9 тэрбум төгрөгийн 8 хувь нь харилцах, 92 хувь нь хадгаламж, хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн 37.7 тэрбум төгрөгийн 40 хувь нь харилцах, 60 хувь нь хадгаламж байна. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн дийлэнх хувийг хадгаламж бүрдүүлж байгаа нь эрсдэлийг бууруулж буй хэдий ч Топ 20 эх үүсвэрийн нийт дүн нь 85 тэрбум буюу нийт эх үүсвэрийн 70 хувьтай тэнцүү, банк санхүүгийн байгууллагаас татсан харилцах, хадгаламж нь 40 тэрбум буюу нийт эх үүсвэрийн 33 хувьтай тэнцэж байгаа нь эх үүсвэрийн төвлөрлийн эрсдэл байгааг илэрхийлж байна. Богд Банк нь өөрсдийн Актив, Пассивын удирдлагын бодлогоор эх үүсвэрийн төвлөрөл, өртөг болон тэдгээртэй холбогдох эрсдэлийг зохицуулж байна.

### 13.3.11. КОВИД-19 эрсдэл

Монгол улсад КОВИД-19 халдвар дотоодод тархсанаас хойш УИХ, Засгийн Газар болон Монголбанкнаас санхүүгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээсийг авсаар байна. Бүх нийтийн хөл хорио нь Богд Банкны үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар сөрөг нөлөө үзүүлж байгаа бол дараах шийдвэрүүдийн үр нөлөө нь Богд Банкны үйл ажиллагаа, ашигт ажиллагаанд шууд байдлаар эерэг болон сөрөг нөлөөг үзүүлж байна. Үүнд:

- Харилцагчийн зээлд нөхцөл өөрчлөлт хийх арга хэмжээг авснаар Богд Банк нь 2020 онд нийт 27.1 тэрбум төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийснээс 2020 оны 12 сарын 31-ний байдлаар 3.6 тэрбум төгрөгийн үндсэн дүнтэй нөхцөл өөрчилсөн зээл үлдсэн байна. Монголбанкны тус шийдвэр нь 2021 оны 7 сарын 1-ний өдрийг хүртэл хэрэгжих ба эдгээр 3.6 тэрбум төгрөгийн нөхцөл өөрчилсөн зээлийн хүү болон эргэн төлөлт хийгдэж эхлэх хугацаа нь 2021 оны эхний 7 сард байгаа нь банкны мөнгөн урсгалд үзүүлэх сөрөг нөлөө бага буйг илтгэж байна.
- Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл авсан иргэдийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг 2021 оны 7-р сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулах арга хэмжээний хүрээнд 2020 онд нийт 819 сая төгрөгийн ипотекийн зээлийн багцын 245 сая төгрөгийн зээлийн төлбөрийг хойшлуулсан ба үүний 51 сая төгрөгийн үндсэн дүнтэй зээлийн эргэн төлөлт 2020 онд хийгдэж эхэлсэн бол үлдсэн 194 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт болон хүүгийн төлөлт нь 2021 оны эхний улиралд хийгдэж эхэлсэн байна. Үнийн дүн болон хугацааны хувьд тус шийдвэрийн Богд Банканд үзүүлэх сөрөг нөлөө бага байна.
- Бодлогын хүүг бууруулах шийдвэрүүд нь банкны зээлийн эрэлтийг өсгөх хэдий ч харилцагч илүү өндөр өгөөж өгөх бусад санхүүгийн хэрэгсэл рүү хөрөнгөө хөрвүүлснээр татан төвлөрүүлсэн хөрөнгө буурах эрсдэлийг бий болгоно. 2020 онд нийт харилцах болон хадгаламжаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл нь өмнөх оноос 17 хувиар буурсан ба тренд цаашид ч үргэлжлэхийг үгүйсгэхгүй.
- Репо арилжаагаар урт хугацаатай санхүүжилт олгох арга хэмжээг хэрэгжүүлснээр Богд банк нь 2020 оны эцэст Монголбанкнаас 10 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг авснаар Хөгжлийн банктай 15 тэрбум төгрөгийн, 6 хувийн хүүтэй урвуу репо хэлцэлд орох боломж бүрдсэн байна.

БОГД БАНК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 11 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 31
МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОНЫ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

- Цар тахлын үед харилцах дансанд хүү тооцохгүй байх арга хэмжээг авснаар харилцагчид харилцах дансаа хадгаламжид хөрвүүлж эхэлсэн нь Богд Банкны хувьд эх үүсвэрийн өртгийг нэмэгдүүлэх эрсдэлтэй.
- Иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх талаар болон Гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй талаар шийдвэр нь Богд Банканд материаллаг нөлөөг үзүүлээгүй ба цаашид ч материаллаг сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл маш бага түвшинд байна.

### 13.3.12. Хөрвөх чадварын ба төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл

Банк нь актив, пассивын зөрүүнээс шалтгаалан хөрвөх чадварын болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлд өртөж байдаг. 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайлангаар Богд Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь 58.8 хувь байгаа нь Монголбанкны зохистой харьцаа болох 25 хувийн шалгуурыг хангаж байгаа ба Базелийн хорооны зохистой харьцааны дагуу тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR) нь 171 хувь, 30 хоног дотор хөрвөх чадварын харьцаа (LCR) нь 229 хувь байгаа нь тус бүр 100 хувийн шалгуурыг хангаж байна. Гэсэн хэдий ч актив пассивын төвлөрөл өндөр байгаа тул энэ нь цаашид Банканд хөрвөх чадварын болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл үүсгэж болзошгүй. Банк нь актив, пассивын зөрүүг тогтмол хянаж, удирддаг хэдий ч зах зээлийн эрсдэл ба санхүүгийн системийн доголдол үүсэхийг үгүйсгэхгүй ба банкны актив, пассивын удирдлагын бодлого нь цаашид тус эрсдэлээс бүрэн хамгаалах баталгааг өгөхгүй.

### 13.3.13. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл

Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ нь алдагдлыг шингээх чадварыг илэрхийлдэг. Монголбанк нь Базелийн хорооны зөвлөмжийн дагуу өөрийн хөрөнгийн доод хэмжээг тогтоож, байнга хангуулж ажилладаг. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг Монголбанк 9 хувиас илүү байхыг шаарддаг бол Богд Банк 17.5 хувиас илүүд барихыг зорьдог ба 2020 оны эцэст 46.24 хувь байв. Банк нь 2020 оны эцсээр хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөгүй байна. Цаашид банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг өнөөгийн өндөр түвшинд хадгална гэх баталгаа байхгүй.

### 13.3.14. Монголбанкны шаардлагаар хангасан байвал зохих зохистой харьцааны бусад шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд үүсч болзошгүй эрсдэл

Богд Банк нь Монголбанкны шаардлагын дагуу дээр дурдсан өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээлийн төвлөрлийн эрсдэлийн харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шалгуур үзүүлэлтүүдийг хангахаас гадна үндсэн хөрөнгийн харьцаа, гадаад валютын зохистой харьцаа зэргийг хангасан байх шаардлагатай байдаг. 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайлангийн дагуу үндсэн хөрөнгийн харьцаа нь 11 хувь байгаа нь шалгуур үзүүлэлт болох 8 хувийг хангаж байна. Оны эцэст гадаад валютын нийт нээлттэй позиц өөрийн хөрөнгийн 0.4 хувьтай тэнцүү байсан нь нэг валютын хувьд өөрийн хөрөнгийн 15 хувь, нийт валютын хувьд өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй байх Монголбанкны шаардлагыг хангаж байна.

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
7758966 • 5903358

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

### 13.3.15. Банкны зээлжих чадварын үнэлгээний эрсдэл

Богд Банкны зээлжих чадвар буюу зээлийн үүрэг хариуцлагаа биелүүлэх чадварын үнэлгээ нь эх үүсвэр татах чадамж, эх үүсвэрийн өртөг, цаашлаад банкны ашигт ажиллагаанд шууд нөлөөлнө. 2017 онд ОУВС Монголбанктай хамтран банкуудад активын чанарын үнэлгээ хийхэд Монголбанкнаас анхаарал татахуйц асуудал байхгүй гэсэн талаар Богд Банк бидэнд мэдэгдсэн. Мүүдис Олон Улсын үнэлгээний агентлаг нь 2021 оны 3 сарын 22-ны өдөр Богд Банкны суурь үнэлгээг B3, харилцагчийн эрсдэлийн зэрэглэл B2/NP болон Хэтийн төлөв байдлыг "тогтвортой" гэж үзсэн. Үнэт цаас гаргагчийн зээлжих чадварын үнэлгээ буурахгүй гэсэн баталгаа байхгүй. Зээлжих чадварын үнэлгээ хэдий хэмжээгээр буурахаас шалтгаалан нөлөө нь харьцангуй байх ба Банкны санхүүгийн байдалд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй ба нээлттэй арилжаалагдаж буй банкны хувьд хувьцааны үнэ буурах эрсдэл үүсч болзошгүй.

### 13.3.16. Нэр хүндийн эрсдэл

Санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа нь харилцагч талуудын итгэл дээр үндэслэдэг онцлогтой тул нэр хүндийн эрсдэл нь банкны харилцагч татах болон эх үүсвэр татах чадамжид шууд нөлөө үзүүлнэ. Ирээдүйд учрах гадаад болон дотоод хүчин зүйлс нь банкны нэр хүндэд нөлөөлөхгүй гэх баталгаа байхгүй. Үүсэж болзошгүй нэр хүндийн эрсдэл нь банкны санхүүгийн чадамж, үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй.

### 13.3.17. Санхүүжилтийн гэрээний хязгаарлалттай холбоотой эрсдэл

Богд банк нь 2020 оны байдлаар дотоодын төслийн санхүүжилт болон гадны банкнаас санхүүжилтийг бүрдүүлсэн ба эдгээрийн санхүүжилтийн гэрээнд аливаа хязгаарлалтын нөхцөл тусгагдаагүй байна. Ирээдүйд Богд Банкны бусдаас авах санхүүжилт нь хязгаарлалтын нөхцөлтэй байхыг үгүйсгэхгүй ба энэ тохиолдолд хязгаарлалтын нөхцөл нь банкны бизнесийн стратеги, өргөжин тэлэх явцад сөргөөр нөлөөлж болзошгүй.

### 13.3.18. Санхүүгийн хяналтын эрсдэл

Богд Банк нь санхүүгийн дотоод хяналтын процессыг ТУЗ-ийн баталсан эрсдэлийн бодлого болон Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан Хөрөнгө зохицуулалт, Хөрөнгө оруулалтын банкны хэлтсийн дүрэм, Санхүү удирдлагын хэлтсийн дүрэм, Нягтлан бодох бүртгэлийн дүрэм зэргээр зохицуулж байна. Тус бодлого, дүрмүүд нь хяналтын процесс, ажил үүрэг, эрх мэдлийн хуваарилалт, хязгаарлалт, оролцогч талуудын эрх болон үүргийг тодорхойлсон байна. Банк нь санхүүгийн хяналтыг шат дараалсан, гурвалсан, газар дээрх болон тайлангийн хяналтын хэлбэрээр хэрэгжүүлдэг хэдий ч эдгээр бодлого, дүрмүүд нь хяналт дутмагаас үүсэх эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах оновчтой бодлого мөн эсэхэд, тус бодлогын хэрэгжилт хангалттай байх эсэхэд баталгаа өгөхгүй.

### 13.3.19. Мэдээллийн технологийн эрсдэл

Банкны санхүүгийн үзүүлэлт, стратегийн зорилтуудаа хүрэх чадвар болон бизнесийн өсөлт нь мэдээлэл технологийн системийн үйл ажиллагаанаас ихээхэн хамаардаг бөгөөд

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 ▪ 5903838

мэдээлэл технологийн системийн үйл ажиллагааны доголдол, саатал нь банкны шийдвэр гаргалт болон эрсдэлийн удирдлагын үйл явцыг саатуулах, банкны бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөвт томоохон сөрөг нөлөө үзүүлэх боломжтой. Ирээдүйд банкны үйл ажиллагаа өргөжиж шинээр мэдээлэл технологийн систем нэвтрүүлснээр банкны үйл ажиллагааны хамаарал нэмэгдэж мэдээлэл технологитой холбоотой эрсдэлийг өсгөж болзошгүй.

### 13.3.20. Хүний нөөцийн эрсдэл

Богд Банкны санхүүгийн гүйцэтгэл нь удирдлагын баг болон ажиллагсдын чадвар, туршлага, нэр хүнд, ноу-хау, ёс зүй болон хамтран ажиллах чадвар, хүний нөөцийн бодлогоос хамаарна. Хамгийн чадварлаг баг хамт олныг бүрдүүлэх нь Үнэт цаас гаргагчийн дотоод бодлогоос гадна гадаад хүчин зүйлс болох өрсөлдөгчдийн санал болгож буй цалин урамшуулал, ажлын орчин, улсын дундаж цалин, амьжиргааны зардал зэргээс хамаарна. Хүний нөөцийн бодлого нь оновчтой ба Богд Банкны үйл ажиллагааг хамгийн амжилттай байлгах зохистой бодлого гэх баталгаа байхгүй.

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсанаас хойш хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бүтэц, засаглалаар үйл ажиллагаагаа явуулсан тул нээлттэй компани болох нь удирдлагын багийн хувьд сорилт үүсгэж болзошгүй. Нээлттэй банкийг удирдах туршлага дутмаг байдал нь банканд санхүүгийн болон нэр хүндийн эрсдэлийг үүсгэж болзошгүй.

### 13.3.21. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой эрсдэл

Богд Банк нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Мөнгө Угаах Терроризмыг Санхүүжүүлэх (МУТС)-тэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг баталсан байна. Монгол улсын МУТС тэмцэхтэй холбоотой хууль, журмуудын дэлгэрэнгүй мэдээлэлтэй тус үнэт цаасны танилцуулгын хууль эрх зүйн орчин хэсгээс танилцах боломжтой ба банкны МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам нь тус хуулийн 14.4-т заасан шаардлагуудыг хангасан байна. Гэсэн хэдий ч үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаандаа мөрдөж буй бодлого, журам нь аливаа МУТС эрсдэлийг бүрэн таних, тодорхойлоход хангалттай эсэхэд, мөн бодлогын хэрэгжилт бүх түвшинд хангалттай байх эсэхэд баталгаа өгөхгүй. Ирээдүйд МУТС тэмцэх тухай хуулийн зөрчил гарвал банкны хувьд нэр хүндийн болон санхүүгийн, улмаар аливаа хориг, хязгаарлалтад өртөх байдлаар үйл ажиллагаанд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

### 13.3.22. Үл даатгагдах эрсдэл

Богд Банк нь Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн дагуу харилцагчийн мөнгөн хадгаламжийг даатгалд хамруулан ажиллаж байна. Тус хуулийн 8.1-д зааснаар даатгалын тохиолдол бий болоход Хадгаламжийн даатгалын корпораци хадгаламж эзэмшигчийн тухайн банкан дахь төгрөг ба валютын нийт 20 сая хүртэл төгрөгийн хадгаламжийг нөхөн төлөхөөр зохицуулагдсан байдаг. Үнэт цаас гаргагч нь мөн өөрсдийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүдийг даатгуулсан хэдий ч эд хөрөнгийн даатгал, хариуцлагын даатгалуудад хамрагдаагүй тул банкны аливаа ажил мэргэжлийн алдаа, түүний санаатай бус үйл ажиллагааны улмаас гуравдагч этгээдэд буюу бусдад

СЗХ
2021 .11.10
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол учрахад, мөн бүх төрлийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөнд гэнэтийн тооцоологдоогүй хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсэх хохирол зэрэг нь даатгагдаагүй байна. Үл даатгагдах эрсдэл, даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ хангалтгүй байх зэрэг нь ирээдүйд дээрх тохиолдлуудад банкны санхүүгийн байдал болон үйл ажиллагаанд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

## 13.4. Үнэт цаас гаргагчийн хууль эрх зүйн эрсдэл

### 13.4.1. Хөгжиж буй орнуудын хууль эрх зүйн орчны эрсдэл

Одоогийн байдлаар Монгол Улсад хууль эрх зүйн сайжруулалт, шинэчлэлүүд банк, санхүүгийн салбарт хурдацтай явагдаж байна. Тус хэрэгжиж буй хууль эрх зүйн шинэчлэл нь банкны үйл ажиллагаа болон тэдгээрийн хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэгт нөлөө үзүүлж болзошгүй байна.

### 13.4.2. Хууль эрх зүйн эрсдэл

Монгол Улсад банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага нь голчлон дараах хууль, тогтоомж, бодлого, журмаар зохицуулагдана. Үүнд:

- Үндсэн хууль (1992)
- Иргэний хууль (2002)
- Банкны тухай хууль (2010)
- Банк эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (1995)
- Төв банк /Монголбанк/-ны тухай хууль (1996)
- Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль (2018)
- Компанийн тухай хууль (2011)
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013)
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2002)
- Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль (2009)
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005)
- Монголын Компанийн Засаглалын Кодекс, Санхүүгийн Зохицуулах Хороо (2007)
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 594 дүгээр тушаалаар батлсан "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-80 дугаар тушаалаар батлсан "Банкны зөвшөөрлийн журам"
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009), гэх мэт

Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрхэн мөрдөж байгаад Биржээс хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар үнэт цаас гаргагч, холбогдох этгээдэд шаардлага хүргүүлж, журам болон гэрээний дагуу хариуцлага ногдуулж болно.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Банк нь Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.20 дахь хэсэгт тодорхойлсон "банкны системд нөлөө бүхий банк" биш тул

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 • 5903858

СЭХ
2021 .11. 10
БҮРТГЭВ
№ .1
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн зохицуулалтад хамаарахгүй болохыг дурдах нь зүйтэй.

Богд Банк нь хэрэв Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн, банкны тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй, эсхүл найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан бол Монголбанкнаас зөрчил, дутагдлыг арилгах талаар албан шаардлага, сануулга, үүрэг, даалгавар өгөх, банкны гүйцэтгэх удирдлага хийгээд үйл ажиллагаа явуулахыг хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, түдгэлзүүлэх хүртэлх арга хэмжээг авах боломжтой.

Ирээдүйд дээр дурдагдсан хууль, дүрэм журмын хүрээнд Банкны үйл ажиллагаанд шууд нөлөөлөхүйц аливаа нэмэлт, өөрчлөлт, Банкны зүгээс хууль тогтоомжоор хүлээсэн үүрэгтэй холбоотой аливаа зөрчил гарвал Банкны хувьд нэр хүндийн болон санхүүгийн, улмаар аливаа хориг, хязгаарлалтад өртөх байдлаар үйл ажиллагаанд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

### 13.4.3. Монгол Улсын татварын хуулийн шинэчлэлтэй холбоотой эрсдэл

2019 оны 3 сарын 22-ны өдрийн Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан ба дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгэлтэй байгаа хуулийн этгээд 2021 оны 1 сарын 1-ний өдрөөс өмнө өөрийн эцсийн өмчлөгчийг батлагдсан журам, маягтын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх үүрэг хүлээсэн.

2008 оны 5 сарын 20-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн холбогдох заалт, 2017 оны 5 сарын 11-ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.19 дахь заалтын 1, 3, 4, 5 дахь хэсгийг хэрэв татвар төлөгчийн эрх зүйн байдлыг дордуулахаар бол буцаан хэрэглэх, татварын зөрчилд холбогдох шийтгэлийн хуудастай холбоотой гомдлыг татварын маргаан таслах зөвлөлд заасны дагуу хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжсэн татварын өрийг татварын алба хураах, 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс өмнө үүссэн татварын хяналт шалгалттай холбоотой татварын хөөн хэлэлцэх хугацааг тоолох, хугацааны тасалдлыг шинэчилсэн найруулсан хуульд заасны дагуу тогтоохоор тус тус зохицуулсан байна.

Ирээдүйд дээр дурдагдсан татварын хувь хэмжээ, тайлагнах, хянан шалгах эрх зүйн зохицуулалт өөрчлөгдөх тохиолдолд Банкны үйл ажиллагаанд нөлөөлөхүйц тул санхүү болон үйл ажиллагаанд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

### 13.4.4. Тусгай зөвшөөрлийн эрсдэл

Богд Банк нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дах хэсэг, Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 1 сарын 17-ний өдрийн А-199 тоот тушаалтай Банкны зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа эрхэлж байна.

БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ

Монголбанкнаас олгосон 27 тоот Банкны зөвшөөрлийн гэрчилгээ болон СЗХ-ноос олгосон ТЗ 210/68 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дагуу дараах үйл ажиллагаануудыг эрхлэх хугацаагүй зөвшөөрөлтэй байна. Үүнд:

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 11 сарын 6-ны өдрийн А-175 тоот тушаалаар зээл, төлбөр тооцооны үйлчилгээ, гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах үйл ажиллагаа;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 4 сарын 9-ний өдрийн А-69 тоот тушаалаар энгийн гадаад төлбөр тооцоо хийх, эрхлэх үйл ажиллагаа;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 5 сарын 25-ны өдрийн А-148 тоот тушаалаар гадаад төлбөр тооцоо хийх, эрхлэх үйл ажиллагаа;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 12 сарын 27-ны өдрийн А-362 тоот тушаал үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах үйл ажиллагаа; (3-аас дээш жилийн хугацаатай 150 сая доллараас доошгүй гадаад эх үүсвэрийг татан төвлөрүүлэх, дотоодын зах зээлд ашиглах хязгаарлалттай)
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 5 сарын 25-ны өдрийн А-148 тоо тушаал үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах, зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдан авах үйл ажиллагаа;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 5 сарын 5-ны өдрийн А-147 тоот тушаал зөвхөн гадаад зах зээлээс эх үүсвэр татах нөхцөлтэй мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 12 сарын 20-ны өдрийн А-337 тоот тушаал мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 12 сарын 20-ны өдрийн А-337 тоот тушаал санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 5 сарын 25-ны өдрийн А-148 тоот тушаал өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах үйл ажиллагаа
- СЗХ-ны 2019 оны 12 сарын 16-ны өдрийн 382 тоот тогтоол Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагаа;

Богд Банк нь дээрх тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ирээдүйд мөн бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах шаардлага үүсэх боломжтой. Үүнтэй холбоотойгоор тусгай зөвшөөрлийг бүртгэхээс татгалзах, хэрэв Үнэт цаас гаргагч нь Монголбанкны журам, холбогдох банкны хууль, тогтоомжийг биелүүлээгүй тохиолдолд торгууль ногдуулах, тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох нөхцөл байдал үүсэх боломжтой. Энэ нь Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах, хэтийн төлөв байдал, бизнес, санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

## 13.5. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

Банкны эрсдэлийн удирдлагын зорилго нь банкны бүхий л түвшинд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, эрсдэл үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, эрсдэлийг хэмжих, хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг оновчтой удирдах явдал юм.

СЭХ
2021 .11. 10
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Богд Банкны Эрсдэлийн нэгдсэн удирдлагын газар нь Банкны ТУЗ-ийн зүгээс үйл ажиллагааны гол чиглэлүүдийн хүрээнд баталсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хязгаарлалтууд болон эрсдэлийн бодлогын баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнаж ажилладаг. Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Базелийн хорооноос гаргасан "Банкны зохистой засаглалын зарчмууд" болон Олон Улсын стандарт зөвлөмжүүдийг удирдлага болгон эрсдэлийн гурван давхар хамгаалалтын шугам бүхий эрсдэлийн засаглалыг бэхжүүлэн, эрсдэлийн удирдлагын зохистой засаглалыг хэрэгжүүлэн ажилладаг.

"Хамгаалалтын гурван шугам" загварыг хэрэгжүүлдэг. Эрсдэлийн удирдлагын бодлого банкны бүх түвшинд хэрэгжиж, Эрсдэлийн нэгдсэн удирдлагын газар нь хараат бусаар банкны үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах, удирдах оновчтой процессыг тодорхойлж, хэрэгжүүлнэ. Харин дотоод аудитын газар нь эрсдэлийн удирдлагын бодлого болон дотоод хяналтын үр дүнтэй байдал, үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлтэд хараат бус баталгаажуулалт өгнө. Эрсдэлийн удирдлагын дээд түвшний хяналт нь ТУЗ болон түүний дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд хамаарах ба ТУЗ нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх түвшинг тодорхойлох, ЭНУГ-ын үйл ажиллагааг чиглүүлэх, үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх байдлаар хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүргийг хүлээдэг.

*Зураг 34 Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын засаглалын тогтолцоо*

**Хамгаалалтын 1-р шугам**

Бизнес, арын алба нэгжүүд - эрсдэлийг хариуцах, эрсдэлийг дотоод хяналтаараа удирдах үүрэг бүхий үйл ажиллагааны нэгжүүд;

**Хамгаалалтын 2-р шугам**

БОГД БАНК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
БҮРТГЭВ-03

Бодлого, зааврааp хангах, хяналтыг хэрэгжүүлэх нэгжүүд - хамгаалалтын 1-р шугамын нэгжүүдийн эрсдэлийг үнэлэх, үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийх, комплайнсын болон үйл ажиллагааны эрсдэл, чанарыг үнэлэх үүрэг бүхий хяналтын нэгжүүд;

**Хамгаалалтын 3-р шугам**

Дотоод аудитын нэгж - хамгаалалтын 1 болон 2-р шугам дах үйл ажиллагааны нэгжүүдээс хараат бусаар баталгаажуулах үйлчилгээ үзүүлэн, үр дүнг гүйцэтгэх удирдлагад мэдээлэх болон ТУЗ-д тайлагнах үүрэг бүхий бие даасан нэгж юм.

Богд Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн стратегитай уялдсан эрсдэлийн уян хатан, оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлд гол анхаарлаа хандуулан зохицуулагч байгууллага, ТУЗ-ийн зүгээс банкны үйл ажиллагаанд тавьж буй хязгаарлалтуудыг бүрэн ханган, ажилтнуудын ур чадвар, эрсдэлийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, эрсдэлийн соёлыг бэхжүүлэн, эрсдэлийг үнэлэх олон улсын арга аргачлал, загварыг судлан, сайжруулж, олон улсын стандартын дагуу тооцож үнэлж ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын зохистой бүтэц, оновчтой зохион байгуулалтыг хийх хүрээнд Олон улсын банкны хяналтын Базелийн хорооноос гаргасан эрсдэлийн удирдлагын зөвлөмжүүд, шинэчлэгдэн гарсан олон улсын "ISO 31000:2018 Эрсдэлийн удирдлага – Зааварчилга" стандарт зэрэгт нийцүүлэхэд анхаарч ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог оновчтой бүрдүүлж, нэг банк болон нийт банкны тогтолцоонд харилцагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд зохистой засаглалын орчин чухал үүрэгтэй. Харин Базел хорооны эрсдэлийн удирдлагын зөвлөмж, шинэчилсэн стандарт нь өмнөх дэлхийн санхүүгийн хямралаар банкуудын зохистой засаглалтай холбоотой илэрсэн нийтлэг дутагдлыг харгалзан илүү боловсронгуй зарчмуудыг боловсруулсан байдаг. Мөн зохистой засаглалаас гадна үндсэн зарчмуудыг хэрэгжилтийг оновчтой байлгах үүднээс эрсдэлд суурилсан хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх болон хяналт шалгалтын арга хэмжээсийг тухай бүр авч хэрэгжүүлэхийг шаарддагаараа онцлогтой.

Иймээс эрсдэлийн удирдлагын хяналт, хэрэгжилтийг хамгийн үр дүнтэй байлгах үүднээс Богд Банк нь Төлөөлөн Удирдах Зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлага, хяналтын шат дамжлагыг тодорхойлсон эрсдэлийн удирдлагын бодлогыг баталсан ба ISO:31000 стандарт, байгууллагын эрсдэлийн удирдлагын COSO загварт нийцсэн байна.

Үнэт цаас гаргагч нь 2020 онд Монгол улаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх бодлого, журам болон харилцагч таньж мэдэх журмыг дотоодын хууль болон олон улсын зохицуулагч байгууллагын заавар, журам, зөвлөмжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, дотоод үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

## 13.6. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн бодлого болон удирдлага

Үнэт цаас гаргагч нь учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг тогтмол авч хэрэгжүүлдэг. Үүнд:

- Банкны бүхий л түвшинд эрсдэлд суурилсан хяналт, тогтолцоог бүрдүүлж, эрсдэлд суурилсан шийдвэрийг гаргаж ажилладаг бөгөөд Эрсдэлийн нэгдсэн удирдлага

хариуцсан захирал Банкны Зээлийн хороод, Удирдлагын хороо, Актив пассивын хороо, Бүтээгдэхүүн хөгжлийн хороонд саналын эрхтэй оролцдог.
- Банкны эрсдэл даах чадварын хүрээнд эрсдэлийн аппетитийг тодорхойлон зохистой харьцаа, банкны дагаж мөрдөх хязгаарлалтуудыг тогтмол давтамжтай хянаж, тайлагнаж ажилладаг.
- Эрсдэлийн аппетитийн хүрээнд зээл, зах зээл, хөрвөх чадвар, үйл ажиллагааны эрсдэлүүдийн хүлээн зөвшөөрөх түвшинд хязгаар тогтоож, холбогдох газар нэгжүүд мөрдөж ажилладаг.
- Банкны үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр системийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, шинээр үүсч буй эрсдэлийн урьдчилан тодорхойлон тэдгээрийг судлах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх бүрт холбогдох эрсдэлийг тодорхойлон үнэлж, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах удирдах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлдэг.
- Банкны эрсдэлийн соёлыг бэхжүүлэхтэй холбоотой ажилтнууд, салбар, газар нэгжүүдийг үйл ажиллагаа, эрсдэлийн тухай мэдлэг мэдээллээр хангаж, холбогдох сургалтыг тогтмол зохион байгуулдаг.

Богд Банк нь технологид суурилсан банк болох зорилгын хүрээнд дата анализ, технологид суурилсан эрсдэлийн удирдлагын шинэ арга аргачлалыг нэвтрүүлэх, үйл ажиллагааг автоматжуулах улмаар эрсдэлийн удирдлагыг сайжруулах, олон улсын банкны эрсдэлийн удирдлагын сайн туршлагуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагыг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэх нь ашигт ажиллагаа болон урт хугацааны тогтвортой өсөлтийг дэмжих бөгөөд даатгалыг аливаа эрсдэлийг бууруулах, шилжүүлэх арга замуудын нэг хэрэгсэл болгон ашигладаг. Ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эрүүл мэндийн даатгалд хамруулж байгаа нь улмаар ажилтнуудын сэтгэл ханамж, ажилтны эрүүл мэндээс шалтгаалсан банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дам бууруулах нөлөөтэй.

Богд Банк нь өдөр тутамдаа дараах эрсдэлүүдийг хянаж, зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллаж байна:

- Зах зээлийн эрсдэл
- Зээлийн эрсдэл
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар ба хөрвөх чадварын эрсдэл
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээний
- Санхүүгийн хяналтын эрсдэл
- Бусад санхүүгийн эрсдэл
- Үйл ажиллагааны эрсдэл
- Хүний нөөцийн эрсдэл
- Хуулийн болон комплайнсын эрсдэл
- Нэр хүндийн эрсдэл
- Мэдээллийн технологийн эрсдэл
- Цахим эрсдэл
- Бизнесийн эрсдэл
- Инновацийн эрсдэл
- Харилцагч талын эрсдэл

- Байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл
- Дампуурлын эрсдэл

**Зээлийн эрсдэлийн удирдлага**

Зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Зээлийн болон, Эрсдэлийн удирдлагын газрууд нь зээлийн эрсдэл, зээлийн багцын эрсдэл хариуцсан үйл ажиллагаа явуулдаг. Тус нэгжүүд нь Монголбанкны зүгээс зээлийн эрсдэлийн чиглэлээр банкуудад тавьж буй хязгаарлалтуудыг хангаж ажиллахаас гадна ТУЗ-ийн зүгээс зээлийн төвлөрлийн эрсдэлийг бууруулах хүрээнд зээлийн дүнгийн хязгаарлалт, нэг зээлдэгч болон нийт зээлдэгчийн хязгаарлалт, бүтээгдэхүүний түвшинд тавих хязгаарлалтын харьцаа үзүүлэлтийг тус тус тогтоож, харьцаа үзүүлэлтээ тайлант хугацаанд хангаж ажилласан эсэхэд хяналт тавьдаг.

Зээлийн үйл ажиллагааны хүрээнд зээлдэгч зээлийн үүргээ биелүүлэхтэй холбоотой зээлдэгчийн төлбөрийн чадвар болон барьцаа хөрөнгийн үнэ цэнийн бууралт бүхий үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор орон сууцны зээл, автомашины зээл болон барьцаа хөрөнгийн төрлөөс хамааруулан заавал даатгалд хамруулах бодлого баримталдаг.

**Зах зээлийн эрсдэлийн удирдлага**

Зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Богд Банк нь үндсэн үйл ажиллагаа, актив, пассивын үнэ цэнэд нөлөөлөх гадаад валютын ханшийн хөдөлгөөн, хүүгийн түвшний өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийг авч үздэг бөгөөд дотоод болон гадаадын макро эдийн засаг, улс төрийн нөхцөл байдалд орж буй өөрчлөлт, банканд үзүүлэх нөлөөллийг үнэлж, эрсдэлээс сэргийлэх чиглэлд холбогдох газар нэгж, гүйцэтгэх удирдлагыг дараах мэдээллээр хангадаг.

- Хөрөнгө зохицуулалтын газар болон гүйцэтгэх удирдлагыг Базелийн хорооны зөвлөмжийн дагуу бодсон валютын ханшийн өөрчлөлтөөс хүлээж болох хамгийн их алдагдлын мэдээллээр;
- Холбогдох газар нэгжийг Актив, пассивын төвлөрөл, хүүгийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, гадаад валютын эрсдэл болон бусад эрсдэлийн мэдээллээр;
- Удирдлагыг Банкны үйл ажиллагаанд нөлөөлөх МУ-ын макро эдийн засгийн үзүүлэлтүүд тэдгээрийн чиг хандлагын судалгаа, холбогдох эрсдэлийн мэдээллээр.

**Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага**

Богд Банк нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх чадварыг илэрхийлсэн Монголбанкны чадварын зохистой харьцаа, заавал байлгах нөөцийн шаардлага зэргийг авч үздэг бөгөөд Банкны хөрвөх чадварын эрсдэлийг мөнгөн урсгалын тайлан GAP шинжилгээ, Базелийн стандартын дагуу LCR, NSFR харьцаа үзүүлэлтээр хэмжиж тайлагнадаг. Банк нь тайлант хугацаанд зохицуулагч байгууллагаас тавьж буй шаардлага, харьцаа үзүүлэлтийн хангаж ажилладаг ба дотооддоо "Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын бодлого"-ын баримт бичгийг мөрдөж, хөрвөх чадварын эрсдэлийг эрт илрүүлэх, тэргүүлэгч индикаторуудыг тодорхойлон, хэмжиж-хянах, тухайн

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

нөхцөл байдалд тулгуурласан оновчтой арга хэмжээг хэрэгжүүлэх замаар эрсдэлийг удирдан ажилладаг.

**Үйл ажиллагаа, комплайнсын эрсдэлийн удирдлага**

Богд Банк нь дотоодын болон олон улсын зохицуулагч байгууллагын заавар, журам, зөвлөмжид нийцсэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх бодлого, журам болон харилцагч таньж мэдэх журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Банк нь нийт ажилтнуудыг дээрх чиглэлийн сургалт, зөвлөмжөөр хангадаг.

Богд Банк нь үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс бүх түвшинд хамгаалалтын гурван шугамын загварын дагуу хяналтыг хэрэгжүүлж, давхар болон дараалсан хяналтын системийг сайжруулах, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын чиглэлээрх ажилтан бүрийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлд ажилладаг. Банк нь цаашид нэгдсэн эрсдэлийн үнэлгээ, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа бөгөөд дээрх ажлын үр дүнд ирээдүйд учрах аюулын үр нөлөөг таньж мэдэх, оновчтой удирдах, үйл ажиллагааны аль хэсэгт илүү өндөр эрсдэл учрахыг тааамглах боломжтой болох юм.

# АРВАН ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

## 13.7. Андеррайтер

*Хүснэгт 80 Эм Ай Си Си ҮЦК ХХК-ийн танилцуулга*

| MICC | **Эм Ай Си Си ҮЦК ХХК** |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9011472094 |
| **Регистрийн дугаар** | 5011558 |
| **Үйл ажиллагааны чиглэл** | Андеррайтер, брокер, дилер |
| **Хаяг** | Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Баруун Сэлбийн гудамж, ЖЖ тауэр, 7 давхар |
| **Утас** | +976-7011 2023 |
| **Веб хуудас** | www.micc.mn |
| **Цахим шуудан** | contact@micc.mn |

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

### 13.7.1. Андеррайтерийн компанийн танилцуулга

Эм Ай Си Си ҮЦК ХХК нь хувьцааны болон зээлийн санхүүжилт, мөн IPO болон компанийн нэгдэх, худалдан авахад зуучлах хэлцлүүдийг амжилттай хэрэгжүүлсэн туршлагатай. Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдэд, мөн Монгол улсад хөрөнгө оруулалт хийх сонирхолтой гадаадын томоохон корпорациудад зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшсэн.

Андеррайтерийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн анхдагч компани бөгөөд андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд Монголын томоохон компаниудад дотоод гадаадын зах зээлээс санхүүжилт босгох түүнтэй уялдан гарах санхүүгийн болон эрх зүйн асуудлуудыг мэргэжлийн түвшинд чанартай амжилттай гүйцэтгэн, ажлын арвин туршлага хуримтлуулж чадсан юм. Эм Ай Си Си ҮЦК ХХК нь IPO, IPO-ийн өмнөх санхүүжилт, бондын санхүүжилтээрх туршлагаараа тэргүүлдэг. Хөрөнгийн зах зээл дээр нийт 20 гаруй тооны хэлцлийг гүйцэтгэж 3.2 их наяд төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж, зөвлөх үйлчилгээг үзүүлжээ.

IPO туршлага: 2020 онд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д дотоодын анхдагч зах зээл дээр гаргасан төр, иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж буй хувьцааг Монголын хөрөнгийн биржийн олон нийтэд нээлттэй компанийн бүртгэлд бүртгүүлэх, цаашлаад гадаадын хөрөнгийн бирж дээр бүртгүүлэх боломжуудыг судалж, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн болно.

2010-2015 онуудад Монголын уул уурхайн компаниуд гадаадын бирж дээр эрчимтэй IPO хийж байна. Гадаадын бирж дээр байгаа компаниудын хувьцааг авах, ялангуяа монгол компаниудын хувьцааг худалдан авч эзэмших сонирхол Монголын хөрөнгө оруулагчдад ихээр бий болоод байна. Улс орны эдийн засгийн өсөлт, нэн ялангуяа уул уурхайн салбарын үсрэнгүй хөгжил, Монголын Хөрөнгийн зах зээлийг сонирхох гадаадын хөрөнгө оруулагчийн сонирхол дээр тулгуурлан Олон улсын томоохон биржүүд дээр хэд хэдэн IPO амжилттай гүйцэтгэжээ. (ASX, HKEX, TSXV).

Андеррайтер нь Харанга Ресурс ХК, Монголиан Майнинг корпораци ХК, Хүннү Коал ХХК, Алтан Рио ХК, Эрдэнэ Ресурс, Кара Минералс зэрэг компаниудын IPO болон IPO-ийн өмнөх санхүүжилт Монгол дахь албан ёсны борлуулагчаар ажилласнаар, дотоодын иргэд хөрөнгө оруулагчид 17 сая ам.долларын хөрөнгө оруулалт эдгээр компаниудад хийжээ.

2010 оны эхээр Эрдэнэс Тавантолгойн хувьцааг иргэдэд олгох ажил хөрөнгийн зах зээлд ид өрнөж байсан. MICC Эрдэнэс Монгол төрийн өмчит компанид дэлхийн хамгийн том ашиглагдаагүй нүүрсний орд болох Таван Толгойг эзэмших Эрдэнэс Тавантолгой компанийн хувьцааг хуваарилах ажилд санхүүгийн зөвлөгөө өгч, Монгол Улсын иргэд Эрдэнэс Тавантолгойн хувиас хишиг хүртэх боломжийг олгон ХК байгуулах, хувьцааны нэрлэсэн үнийг тогтоох, хувьцааны тоо ширхэг, ангиллыг тодорхойлоход зөвлөхөөр ажилласан туршлагатай.

**Тусгай зөвшөөрөл**

Эм Ай Си Си ҮЦК ХХК нь 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрээр 169 дугаар тогтоолоор брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан ба улмаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 353 тоот тогтоолоор брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай

БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 . 11 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар, 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 501 тоот тогтоолоор 3 жилийн хугацаагаар тус тус сунгасажээ. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 307 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 жил, 2012 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр 3 жилийн хугацаагаар сунгав. 2013 оны 05 сарын 24-ний өдөр "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийг шинэчлэн найруулж УИХ-аас баталсан бөгөөд үүнтэй холбоотой холбогдох журмууд шинэчлэгдэж андеррайтерийн тусгай зөвшөөрөл хугацаагүй олгогддог болсон.

### 13.7.2. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үнэт цаас гаргагч нь Эм Ай Си Си ҮЦК ХХК-тай 2021 оны 9 сарын 18-ны өдөр 21/25 тоот "Богд Банк Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа олон нийтэд худалдахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ", 2021 оны 9 сарын 17-ны өдөр Ард Секюритиз ҮЦК болон Эм Ай Си Си ҮЦК ХХК-тай "Эрх үүрэг шилжүүлэх тухай санамж бичиг"-ийг тус тус байгуулан, Үнэт цаас гаргагчийн хувьцааг нийтэд санал болгох ажлыг зохион байгуулах андеррайтерийн үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн Бүртгэлийн журам, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэхээр харилцан тохиролцжээ.

Гэрээний хүрээнд андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн олон нийтэд анх удаагаа хувьцаагаа худалдах буюу IPO хийх, хувьцаагаа анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн нууцыг хадгалах, задруулахгүй байх, задруулсан тохиолдолд хариуцлага хүлээхээр тусгасан.

Гэрээнд тусгагдсан гол нөхцлүүд:

- Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгох ажиллагааг гүйцэтгэж, шаардлагатай бүх төрлийн зөвлөгөө, дэмжлэгээр хангах;
- Хөрөнгө оруулагч нартай хийх уулзалтуудыг богино хугацаанд амжилттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- Хувьцааг анх удаа олон нийтэд арилжаалахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн холбогдох багийнхантай хамтран маркетингийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Мөн институциональ хөрөнгө оруулагч нарт зориулан роудшоу хийх;
- Зохих хууль дүрмийн дагуу Банкны хувьцааг борлуулах, хөрөнгө оруулагчдыг ихээр хамруулан татахтай холбоотойгоор андеррайтер, брокеруудын синдикат байгуулж ажиллах

Санамж бичгийн хүрээнд Эм Ай Си Си ҮЦК ХХК нь Үнэт цаас гаргагчийн Ард секюритиз ХХК-тай байгуулсан 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Дугаар 21/07 "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-нд заасан эрх, үүргүүдийг 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөр хүлээж авч, хувьцааг олон нийтэд санал болгон худалдах (IPO) ажиллагаанд андеррайтераар үргэлжлүүлэн андеррайтерийн үйлчилгээний гэрээг шинээр байгуулан ажиллахаар болсон байна.

## 13.8. Хараат бус аудитын компани

*Хүснэгт 81 Хараат бус аудитын фирмийн танилцуулга*

БОГД БАНК
БОЭД БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТҮБ8966 ⁂ 5903858

| | |
|---|---|
| | **Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК** |
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9019015029 |
| **Регистрийн дугаар** | 2665247 |
| **Үйл ажиллагааны чиглэл** | Аудитын үйл ажиллагаа, татварын үйлчилгээ, бизнесийн зөвлөгөө, баталгаажуулах, зөвлөх үйлчилгээ |
| **Хаяг** | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж 21, Найман Зовхис, 200 тоот |
| **Утас** | +976-11 314 032 |
| **Веб хуудас** | www.ey.com/en_mn |
| **Цахим шуудан** | info@mn.ey.com |

### 13.8.1. Хараат бус аудитын компанийн танилцуулга

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК нь дэлхийн 150 оронд 300,000 гаруй ажилтантай Эрнст энд Янг Глобал сүлжээний бүрэн эрхт гишүүн бөгөөд Монгол Улсын Сангийн яамнаас аудит, татвар болон зөвлөгөө өгөх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авч 1999 оноос хойш үйл ажиллагаа явуулж байна. Тус аудитын фирм нь Монгол Улс болон дэлхийн бусад орнуудаас хуримтлуулсан туршлага, нөөц боломжид тулгуурлаж Монгол Улсын бизнес, эдийн засгийн хөгжлийг дэмжин ажилладаг. Эрнст энд Янг Монголия Аудитын ажилчид нь мэргэжлийн өндөр түвшин, баялаг туршлага бүхий дотоод болон гадаадын мэргэжилтнүүдээс бүрддэг бөгөөд үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

### 13.8.2. Хараат бус аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК нь 2020 оны 9 сарын 28-ны өдөр Үнэт цаас гаргагчтай EYMA/LOE-20/AC/MD/DB/26 тоот Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан байна. Тус аудитын үйлчилгээ гэрээний хүрээнд Богд Банк ХХК-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангуудыг багтаасан санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлангуудтай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж, аудиторын тайлан гаргах болон мөн хураангуй санхүүгийн тайланд дүгнэлт гаргах үйлчилгээг үнэт цаас гаргагчид үзүүлэхээр тусгасан байна.

Гэрээний хүрээнд Аудитын компани нь аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн хувьд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргах, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг хүлээн ажиллах үүрэг хүлээсэн байна.

Гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагч нь Аудитын компанид энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээллийг, бичиг баримт болон материалуудын баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх, холбогдох бичиг баримт нь алдаатай эсхүл бүрдэл дутуу, шаардлага хангахгүй нөхцөлд аудитын фирмийн тавьсан шаардлагын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, бодитой мэдээллээр хангах, шаардлагатай бичиг баримтыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулах үүрэг хүлээсэн байна.

## 13.9. Хуулийн зөвлөх фирм

*Хүснэгт 82 Хуулийн зөвлөх фирмийн танилцуулга*

| | **Өмгөөллийн Ди Би энд Жи Ти Эс ХХН** |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9022003045 |
| **Регистрийн дугаар** | 6387942 |
| **Үйл ажиллагааны чиглэл** | Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх |
| **Хаяг** | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-24, Парк Плэйс, 7 давхар, 705 тоот |
| **Утас** | +976 11 331 020, +976 11 332 020, +976 7013 1020 |
| **Веб хуудас** | www.dblaw.mn |
| **Цахим шуудан** | info@dblaw.mn |

### 13.9.1. Хуулийн фирмийн танилцуулга

Өмгөөллийн Ди Би энд Жи Ти Эс ХХН (хуучнаар Жи Ти Эс Адвокатс ХХН) нь 20-иод жил үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын анхны хувийн хуулийн фирмүүдийн нэг бөгөөд 2019 онд шинэчлэгдэн зохион байгуулагдсан билээ. Тус нөхөрлөлийн бүрэлдэхүүнд Монгол Улсад болон гадаадын олон оронд хууль, эрх зүйн анхан болон ахисан шатны боловсрол, мэдлэг эзэмшсэн хуульчид мэргэжлийн өндөр түвшинд ажиллан, хууль эрх зүйн зөвлөгөөг үзүүлдэг чадвартай хуульч, эрх зүйчид ажилладаг томоохон хуулийн фирмүүдийн нэг бөгөөд олон жилийн туршид хуримтлуулсан туршлага болон нөу-хау-

ийг хуваалцан дараа үеийн хуульчдыг бэлтгэн ажиллаж байна. Ди Би энд Жи Ти Эс ХХН нь банк санхүү, хөрөнгийн зах зээл, уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, олон улсын санхүү болон худалдаа, барилга байгууламж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, компани нэгдэн, нийлэх болон худалдан авах, маргаан шийдвэрлэх, хөдөлмөр болон татварын төлөвлөлт зэрэг чухал салбаруудыг хамарсан хууль зүйн зөвлөгөөний цогц үйлчилгээ үзүүлдэг. Түүнчлэн 2007 оноос Монгол Улсын болон Сингапур, Хонг Конг, Торонто, Лондонгийн хөрөнгийн биржүүдэд анхлан болон нэмж хувьцаа гаргах, өрийн бичиг гаргах арилжааны банк болон уул уурхайн томоохон компаниудын хэлцэл дээр хуулийн зөвлөхөөр тасралтгүй ажиллаж ирсэн туршлагатай. Тус хуулийн фирм нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 12 сарын 1-ний өдөр 336 тоот тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлөө шинэчлэн авч ажиллаж байна.

### 13.9.2. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Ди Би энд Жи Ти Эс ХХН нь 2021 оны 2 сарын 17-ны өдөр 21/11 тоот Хууль зүйн үйлчилгээ үйлчилгээ үзүүлэх гэрээг Үнэт цаас гаргагчтай байгуулсан байна. Тус гэрээний хүрээнд хуулийн компани 2021 онд Банкны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Үнэт цаас гаргагчийн хувьцаагаа анхлан нийтэд санал болгон арилжих үйл ажиллагаанд Андеррайтерийн багийн зүгээс хийх хуулийн дүн шинжилгээний ажилд туслах, энэ талаар Богд Банканд шаардлагатай тохиолдолд тайлан бэлдэх; үнэт цаасны танилцуулга боловсруулах, нээлттэй арилжих хувьцаа гаргах зөвшөөрлийг Монголбанкнаас авах, Санхүүгийн Зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэхэд туслах, Богд Банк хувьцаат компани болохтой холбогдуулан компанийн засаглалын өөрчлөлтийн талаар зөвлөх, холбоотой гэрээ, хэлцлийг хянах, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 1 сарын 10-ны өдрийн 19 тоот тогтоолоор баталсан журмын 3.6 дах хэсэгт заасан агуулга бүхий хууль зүйн дүгнэлт гаргах үйлчилгээг үнэт цаас гаргагчид үзүүлэхээр тусгасан байна.

Гэрээний хүрээнд Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн хувьд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон эрх бүхий байгууллагуудаас баталсан холбогдох журмын дагуу хууль зүйн дүгнэлт гаргахдаа үйлчлүүлэгчээс ирүүлсэн баримт бичгийг бүрэн судалж, холбогдох хууль, тогтоомжид нийцэж байгаа асуудлаар хөндлөнгийн дүн шинжилгээ хийн, төрийн байгууллагуудаас лавлагаа, тодорхойлолт авах, бусад мэргэжлийн байгууллагуудтай харилцан, хамтран ажиллах бөгөөд үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгыг хянаж тэдгээрт тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг баталгаажуулах, хүүлийн дүгнэлт гаргах үүрэг хүлээсэн байна.

Гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагч нь хуулийн фирмд энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээллийг, бичиг баримт болон материалуудын баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх, холбогдох бичиг баримт нь алдаатай эсхүл бүрдэл дутуу, шаардлага хангахгүй нөхцөлд, хуулийн компанийн тавьсан шаардлагын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, бодитой мэдээллээр хангах, шаардлагатай бичиг баримтыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулах үүрэг хүлээсэн байна.

## 13.10. Үнэлгээний компани

| | |
|---|---|
| | **БДО Аудит ХХК** |
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9018001010 |
| **Регистрийн дугаар** | 2546442 |
| **Үйл ажиллагааны чиглэл** | Аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээ |
| **Хаяг** | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны Зам-62, Юнескогийн Гудамж, Юнион Бюлдинг, Б Блок, 15-р давхар, 1502 тоот |
| **Утас** | +976 7740 4040 |
| **Веб хуудас** | www.bdo.mn |
| **Цахим шуудан** | info@bdo.mn |

### 13.10.1. Үнэлгээний компанийн танилцуулга

БДО нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. Тус компани нь дэлхийн 154 оронд өөрийн 1,400 салбар оффисоор дамжуулан 64,300 гаруй ажилчидтай үйл ажиллагаа явуулж байна. БДО-ийн Монгол дахь оффис 2012 оны 12 сард БДО Монгол Нэртэйгээр Монгол улсын аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай Итгэлт Аудит ХХК-ийн суурин дээр үүсгэн байгуулагдсан. БДО Монгол нь Улаанбаатар хотод байрладаг бөгөөд зөвлөх үйлчилгээний БДО Консалтинг ХХК, аудит ба баталгаажуулах үйлчилгээний БДО Аудит ХХК болон татварын цогц үйлчилгээний БДО Такс ТМЗ ХХК нэрийн дор 2 партнер, 50 орчим ажилчидтай үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь уул уурхай, үйлдвэрлэл, санхүү, техник технологи гэх мэт Монгол Улсын гол салбаруудад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлдэг.

### 13.10.2. Үнэлгээний үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

БДО Аудит ХХК нь 2021 оны 3 сарын 2-ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2021Y/VAL-001 тоот Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх үзүүлэх гэрээг байгуулсан байна. Тус гэрээний хүрээнд Олон Улсын Үнэлгээний Стандарт, Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шаардлагын дагуу үнэт цаасны зах зээл дээр шинээр хувьцаа гаргах үйл ажиллагаанд зориулан Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн 2020 оны 12 сарын 31-ний хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх, тайлан гаргахаар тусгасан байна.

Гэрээний хүрээнд Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчид хөрөнгийн болон бизнесийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн хувьд эрх бүхий байгууллагуудаас баталсан холбогдох журам, стандартын дагуу Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн бизнесийн

үнэлгээ, газар эзэмших, ашиглах эрх болон үл хөдлөх хөрөнгийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх бодит үнэ цэнэ тодорхойлох хөрөнгийн үнэлгээ хийх, тэдгээрт тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг баталгаажуулах, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг хүлээн ажиллах, үйлчлүүлэгчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх, холбогдох ажиллагаа хийх бүрд тэмдэглэл хөтлөх, ажлын явцын үр дүн, гарч болох эрсдэл, нөхцөл байдлын талаар шуурхай мэдээлэл өгөх, гэрээт ажлыг гүйцэтгэх явцад аливаа байдлаар сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон тохиолдолд даруй мэдэгдэх, үйлчлүүлэгчийн эрх, ашиг хууль ёсны сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх үүрэг хүлээсэн байна.

Гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагч нь Үнэлгээний компанид гэрээт ажилтай холбоотой Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, удирдлагын дотоод мэдээлэл зэрэг бүхий л мэдээлэл, шаардлагатай нэмэлт баримт, материалыг шаардсан тухай бүрт бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах бүх талын дэмжлэг үзүүлэх, үнэлгээний байгууллагыг өөрийн байранд нэвтрэх, уулзалт хийх, дүгнэлт гаргахад шаардлагатай холбогдох мэдээллийг авах, шалгах ажлыг гүйцэтгэх орчноор хангах, тухайн мэдээлэл, баримтыг хариуцсан ажилтнуудыг томилж ажиллуулах, мэдээ, материал, түүний агуулгыг тодорхойлоход туслах зэрэг ажлыг үнэн зөв, цаг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардлагатай бусад ажлын зохион байгуулах үүргүүд тус тус багтсан байна.

ХАВСРАЛТ

СЭХ
2021 ТҮР 10
БҮРТГЭ
МОНГОЛ ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



MICC

# АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
Андеррайтер, Брокер, Дилерийн
“ЭМ АЙ СИ СИ ҮЦК” ХХК

Улаанбаатар хот

2021 он

ӨМНӨХ ҮГ

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 ▲ 5903858



ЭМ АЙ СИ СИ ҮЦК ХХК
УЛААНБААТАР

СЭХ
2021 оны 10 дугаар сар
БҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03
БҮРТГЭВ-03



Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.3 "Үнэт цаас гаргагч нь энэ хуулийн 5.1.1-д заасан үнэт цаасыг нийтэд санал болгохдоо андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдтэй гэрээ байгуулна", мөн хуулийн 41.1-д андеррайтерийн үйл ажиллагааг тодорхойлохдоо "Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдаж авах зэрэг ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ" гэж, түүнчлэн, Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 12-р сарын 30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.1-д "Хүсэлт гаргагч нь Биржийн бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл шатанд хуульд заасны дагуу түсгай зөвшөөрөлтэй андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй гэрээ байгуулан, бүртгүүлэх ажиллагааны бэлтгэлийн хангана" гэж тус тусын үндэслэв.

Үнэт цаас гаргагч Богд банкинд андеррайтерийн үйлчилгээ үзүүлж буй "Эм Ай Си Си ҮЦК" ХХК 2021 оны 09 сарын 18-ны өдөр "БОГД БАНК МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ДЭЭР ХУВЬЦААГАА ОЛОН НИЙТЭД ХУДАЛДАХАД АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ" дугаар 21/25 тоот гэрээг байгуулсан бөгөөд гэрээний дагуу үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай танилцаж, судалгааг явуулсны үндсэн дээр болон харааг бүс хөндлөнгийн байгууллагуудын дүгнэлт, тайланд үндэслэн, холбогдох хууль, журмын дагуу энэхүү үнэт цаасны танилцуулгыг боловсруулж, андеррайтерийн дүгнэлтийг гаргалаа.

"Эм Ай Си Си ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргагчтай нэгдмэл сонирхолын зөрчилгүй бөгөөд үнэт цаасны танилцуулга болон энэхүү дүгнэлтийг боловсруулахдаа Санхүүгийн зохицуулах хороноос хүлээн зөвшөөрсөн эрх бүхий харааг бүс аудитор "Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК", харааг бүс үнэлгээчин "БДО Монгол ХХК "болон харааг бүс хуулийн фирм "Өмгөөллийн Ди Би энд Жи Ти Эс ХХН"-ийн гаргасан ажлын тайлан дүгнэлт, мэдээлэлд үндэслэв. Түүнчлэн олон улсын санхүүгийн байгууллагууд болох ОУВС, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк болон Монгол Банк, Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан олон нийтэд ил түгээгдсэн зах зээлийн тоон мэдээ, мэдээлэл, баримтыг шүүж, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын хөгжил, бодлого, хууль эрх зүйн орчин зэрэг макро болон микро орчинг судалж, үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаатай танилцаж, Банкны ажилтнууд болон удирдлагатай уулзаж ярилцах, Банкны дүнд хугацааны бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлан, гэрээ болон бусад бичиг баримтууд зэрэг үнэт цаас гаргагчаас албан ёсны тайлан, төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдийг ашиглаж мэргэжлийн ёс зүйг баримтлан, хуулийн хүрээнд ажиллалаа.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

ЭМ АЙ СИ СИ ҮЦК ХХК
5011558
191
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
ОН 2021 сар. 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

MICC

*Андеррайтерийн дүгнэлт*

## Агуулга

Нэг. Банкны салбарын нөхцөл байдлын тухай, үнэт цаас гаргагчийн өнөөгийн байдал, ирээдүйн өсөлт ..... 4

1.1 Банкны салбарын нөхцөл байдлын тухай ..... 4

1.2 Үнэт цаас гаргагчийн түүх, өнөөгийн үйл ажиллагаа ..... 5

1.3 Үнэт цаас гаргагчийн Стратеги, ирээдүйн өсөлт ..... 6

Хоёр. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын тухай ..... 7

2.1 Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц ..... 7

2.2 Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ..... 7

2.3 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод ..... 8

2.4 Үнэт цаас гаргагчийн Удирдлагын баг ..... 9

Гурав. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтүүд ..... 10

3.1 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан ..... 10

3.2 Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан ..... 11

3.3 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээний үзүүлэлтүүд ..... 12

Дөрөв. Санал болгож буй үнэт цаасны танилцуулга ..... 14

4.1 Санал болгож буй үнэт цаасны мэдээлэл ..... 14

4.2 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийн талаар ..... 14

4.3 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах талаар ..... 15

4.4 Үнэт цаасны хөрдөгч зах зээлийн арилжааны төлөвлөгөө ..... 17

4.5 Хувьцаатай холбоотой шимтгэл ба орлогын албан татвар ..... 18

4.6 Үнэт цаасаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт ..... 18

4.7 Үнэт цаас худалдан авахад анхаарах зүйлс ..... 18



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 5903358

ЭМ АЙ СИ СИ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 11 03
БҮРТГЭВ
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

## Нэг. Банкны салбарын нөхцөл байдлын тухай, үнэт цаас гаргагчийн өнөөгийн байдал, ирээдүйн өсөлт

### 1.1 Банкны салбарын нөхцөл байдлын тухай

1.1.1 Банкны систем дэх цар тахлын нөлөө

*Ковид-19* цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан Засгийн газраас авсан арга хэмжээний хүрээнд хил хааж, хорио цээрийн дэглэм тогтоосноос импортын бараа бүтээгдэхүүний татан авалт саатах, экспортын үйл ажиллагаа зогсонги байдалд орох, бөөний болон жижиглэн худалдааны нийлүүлэлт буурах, хүнсний бус худалдааны салбар, тээвэр, түрээс, үйлчилгээний салбарын орлого тасалдах болсон. Үүнтэй холбоотойгоор зээлдэгчдэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг ханган ажиллах зорилтын хүрээнд Монголбанкнаас зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх зэрэг зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд 2021.06.30-ны өдрийн байдлаар банкуудын нийт 237,083 зээлдэгчийн 7.35 их наяд төгрөгийн зээл Ковид-19-т өртсөн байгаагаас 68 хувь буюу 185,671 зээлдэгчийн нийт 5.2 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийжээ. Ковид-19-т өртсөн болон бүтэц өөрчилсөн зээлийн дүн 2020 онд эрчимтэй нэмэгдэж байсан бол 2021 оны эхнээс харьцангуй тогтворжих хандлагатай боллоо.

Банкны салбарын нийт актив 2020 оны байдлаар 34,310.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 941.8 тэрбум төгрөгөөр буюу 3 хувиар өссөн байна. Банкнуудын өөрийн хөрөнгө 2020 оны байдлаар 3,754.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2 хувиар өссөн. Банкны системийн зээлийн өрийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар задлан харвал энэ оны 6 дугаар сарын байдлаар үүл үүрхайн салбарын 41 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн 39 хувь, худалдааны салбарын 30 хувь, барилгын салбарын 45 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбарын 48 хувь, бусад салбарын 37 хувь нь Ковид-19-т өртсөн үзүүлэлттэй байгаагаас эдгээр салбарын зээлийн 50-80 хувьд бүтцийн өөрчлөлт хийгдсэн байна.

**Ковид-19-т өртсөн зээл эдийн засгийн салбараар**

| № | Зээлийн төрлөөр Тэрбум ₮ | Нийт зээл | Ковид19-т өртсөн | Өртсөн % | Бүтэц өөрчилсөн дүн | Бүтэц өөрчилсөн/ Ковид өртсөн зээл |
|---|---|---|---|---|---|---|
| | Нийт зээл | 19,159 | 7,359 | 38% | 5,214 | 71% |
| 1 | Үүл үүрхай | 1,790 | 734 | 41% | 559 | 76% |
| 2 | Боловсруулах | 1,581 | 621 | 39% | 311 | 50% |
| 3 | Худалдаа | 3,926 | 1,172 | 30% | 697 | 59% |
| 4 | Барилга | 1,606 | 730 | 45% | 432 | 59% |
| 5 | Үл Хөдлөх Хөрөнгө | 2,587 | 1,237 | 48% | 935 | 76% |
| 6 | Бусад | 7,669 | 2,865 | 37% | 2,280 | 80% |

*Эх сурвалж:* Монголбанк, Банкуудаас ирүүлсэн мэдээлэл



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ЗИЙ АЙ СИ СИ ҮЦК ХХК
MICC
193

СЭХ
2021 -11- 03
БУРТГЭВ-03

1.1.2 Банкны салбарын зарим гол үзүүлэлтүүд

*Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар*

Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны үзүүлэлт 2021 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 5.2 нэгж хувиар өсөж, 45.8 хувь байна. Түс үзүүлэлт нь Монголбанкнаас тогтоосон доод хязгаараас 20.8 нэгж хувиар өндөр юм.

*Ашигт ажиллагаа*

Банкны салбар 2021 оны 6 дугаар сарын байдлаар 71.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байгаа нь өмнөх оны мөн үеэс 132 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн дүн юм. Ингэснээр ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн болон активын өгөөж 6 дугаар сарын байдлаар харгалзан 4.1 болон 0.4 хувьд хүрсэн байна. Банкны салбарын чанартүй зээлийн хэмжээ 2021 оны 6 дугаар сарын байдлаар нэмэгдэж, эрсдэлийн сангийн зардал өссөн нь ашигт ажиллагаа огцом буурахад нөлөөлжээ.

*Банкны салбарын эх үүсвэрийн долларжилт*

Банкны системийн гадаадаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн нь 2.7 их наяд төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 414 тэрбум төгрөгөөр /13.3 хувиар/ нэмэгдсэн байна. Банкны салбарт гадаад валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн буурах нь салбарын эмзэг байдлыг бууруулдаг боловч, нөгөө талаас гадны хөрөнгө оруулалт буурах эрсдэлийг үүсгэдэг. Энэхүү эрсдэлийг бууруулахын тулд макро зохистой бодлогын арга хэрэгслийг ашиглах, гадаад валютын өр төлбөр, гадаад валютын позицид хязгаарлалт тавих зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Банк нь гадаад валютын нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцааг нийт валютын хувьд +/-30 хувийн дотор түс түс барьж байх шаардлагатай байдаг бөгөөд тайлант хугацаанд энэ үзүүлэлт -8.0 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

*Банкны системийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт*

Банкны салбарын эрсдэл даах чадварыг харуулдаг үзүүлэлтийг авч үзэхэд 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 13.1 хувь, нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 15.8 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдээс харгалзан 4.1 ба 3.8 нэгжээр түс түс өндөр байна.

## 1.2 Үнэт цаас гаргагчийн түүх, өнөөгийн үйл ажиллагаа

Богд Банк ХХК нь 2014 оноос Монголбанкаас олгосон 27 тоот Банкны зөвшөөрлийн гэрчилгээ болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон Т3-210/68 тоот тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа эхлүүлж Монгол улсын санхүүгийн зах зээлд олон улсын шилдэг стандарт, туршлагыг нэвтрүүлж, шинэ үеийн хандлага болоомж, технологийн дэвшлийг ашиглан банк, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэ цэнийг бий болгож, харилцагч олон нийтэд танигдсан шинэ зүүны банк болон ажиллаж байна.

Банк нь иргэдийн болон байгууллагуудад зориулсан банкны үйлчилгээ үзүүлэхээс гадна нийт харилцагчиддаа цахим банкны үйлчилгээ, картын үйлчилгээг санал болгон ажиллаж байна. Иргэдийн банкны үйлчилгээ нь харилцах, хадгаламж, зээл, гадаад төлбөр тооцоо, даатгалын зуучлал, багцын үйлчилгээ болон лояалти зэрэг үйлчилгээнүүдээс бүрддэг бол байгууллагын банкны үйлчилгээ нь байгууллагуудын харилцах, хадгаламж, зээл, баталгаа, төлбөрийн карт болон гадаад төлбөр тооцооны үйлчилгээнүүдээс түс түс бүрдэж байна. Үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдээс дурьдвал:



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТЕ8966 - 5903858
ЭМ АМ СИ СИ ҮЦК ХХК
УЛААНБААТАР

СЭХ
2021 11 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2021 11 03
БҮРТГЭВ-03



- Зээлийн үйл ажиллагаа;
- Төлбөр тооцооны үйлчилгээ;
- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
- Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах үйл ажиллагаа;
- Менгөн хадгаламжийн үйл ажиллагаа;
- Гадаад төлбөр тооцоо хийх;
- Зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах;
- Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
- Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа;
- Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа тус тус багтана.

Олон улсын үнэлгээний "Мүүдиз" байгууллага (www.moodys.com) нь дэлхийн нийт улс орны зээлжих чадвар болон томоохон өр акүйн нэгж, байгууллагуудад санхүүгийн зэрэглэл тогтоогч бөгөөд 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Богд банкны төлөө байдлын хувьд тогтвортой, татан төвлөрүүлсэн дотоодын валютын хөрөнгөөр B2/NP, татан төвлөрүүлсэн гадаад валютын хөрөнгөөр B3/NP, Банкны хадгаламж B3/NP, зээлийн сүүрь үнэлгээ B3, тохируулгын дараах зээлийн сүүрь үнэлгээ B3, харилцагчийн эрсдэлийн үнэлгээ B2(cr)/NP(cr) гэж тус тус үнэлсэн байна (*Эх сурвалж: Moody's Investors Service*). Энэ үнэлгээ нь дотоодын томоохон банкуудын үнэлгээтэй эн зэрэгцэхүйц үнэлгээ бөгөөд Монгол Улсын Засгийн Газрын зээлжих зэрэглэлтэй ижил түвшний үнэлгээ юм.

### 1.3 Үнэт цаас гаргагчийн Стратеги, ирээдүйн өсөлт

Банк нь богино хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэн төлж Монголын зах зээлд өөрсдийн байр сүүрийг бий болгон, орчин үеийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, харилцагч олон түмэндээ танигдсан шинэ зүүны банк болохоор зорин ажиллаж байна. Энэхүү зорилтын хүрээнд Банк нь 2021 онд олон ниитэд өөрсдийн хувьцаагаа санал болгон салбартаа анхдагч, түүчээлэгч болохоор төлөвлөсөн байгаа бөгөөд өөрсдийн бүсдаас ялгарах бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдад санал болгох, харилцагчийн бааз сүүрийг нэмэгдүүлэх, одоо байгаа харилцагчдадаа сэтгэл ханамжийг бий болгон тогтоон барьж үлдэх, бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхдээ дэлхийн стандартад нийцсэн, дотоод болон гадаадын иргэдэд зориулсан, техник технологийн дэвшилтэт шийдлийг ашиглан, хэрэглэгчийн цаг хугацааг хэмнэхэд чиглэсэн байхаар зорьж ажиллана.

Богд Банк нь Иргэд болон Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулан үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын дараах төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

*Иргэдийн бизнест* зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээгээ хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн байх зарчмын хүрээнд ажиллаж ирсэн ба банкны үйлчилгээгээ харилцагчийн амьдралын хэв маяг, хүсэл сонирхол, бодит хэрэгцээнд улам ойртуулсан, түүнд тулгуурласан байх зарчмын хүрээнд хөгжүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд харилцагчийн тоог нэмэгдүүлэх, Flagship түсгайлсан бүтээгдэхүүнийг санал болгох, цахим борлуулалтыг идэвхжүүлэх, зөө үр дүнтэй маркетинг ба байнгын урамшуулал хөнгөлөлт үзүүлэх, багц, бөөний борлуулалт болон борлуулалтын шинэ сувгийг нэмэх технологийн шийдлээр дамжуулан банкны үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд зорин ажиллаж байна.

*Жижиг дунд бизнес эрхлэгчдийн хувьд* Богд Банк нь бизнес эрхлэгчдийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, борлуулалтын орлого зэрэгт суурилсан эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалт, зээлийн шугам гэх мэтээр ялгаатай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон ажиллаж



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
7708966, 5903858
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
БҮРТГЭВ-03



байгаа ба цаашид зөвхөн банкны үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээ төдийгүй санхүүгийн зөвлөгөө, дэвшилтэт технологийн шийдлээр боловсруулагдсан бусад үйлчилгээг хөгжүүлэхээр төлөвлөж байна. Банк нь ирэх жилүүдэд эдийн засгийн нөхцөл байдал болон банкны ерөнхий бодлоготой уялдуулан авлага барьцаалсан санхүүжилт, нийлүүлэлтийн гинжин хэлхээний санхүүжилт гэх мэт мөнгөн урсгалд суурилсан шинэлэг түсгайлсан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлнэ.

Төслийн зээлийн эх үүсвэртэй зээлийг Засгийн газар, Монголбанк, Олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтарч олгоно.
Зээлийг хурдтай шийдвэрлэх, цогц бүтээгдэхүүний шийдэл гэх мэт харилцагчийн борлуулалт, үйл ажиллагааг дэмжсэн шийдэл бүхий цогц үйлчилгээг санал болгоно.
Банкны уламжлалт бус бүтээгдэхүүн үйлчилгээг илүү боловсронгуй болгон харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэлэг, хурдан, ойлгомжтой амар хялбар байлган хөгжүүлэлт, сайжруулалтыг тогтмол хийж харилцагчаас нэг удаад ашиг олохоос илүү урт хугацаанд бүюү насан туршид нь хамт байж бүтээгдэхүүн үйлчилгээгээ үзүүлэхийг эрмэлзэж харилцагчийн онцлог, хэрэгцээнд тулгуурлан тухайлсан шийдлийг санал болгоно.
Тухайлбал банк нь ирэх жилүүдэд хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа өргөжин тэлж байгаатай холбоотойгоор

- хөрөнгө оруулалтын сан,
- хувийн тэтгэврийн сан,
- брокер болон кастодиан банкны үйл ажиллагааг ойрын хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

## Хоёр. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын тухай

### 2.1 Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

2021 оны 09 сарын 20-ны байдлаар үнэт цаас гаргагчийн хувьцааны 91.32 хувийг Бодь Капитал ХХК, 8.68 хувийг Богд Капитал Инвестмент ХХК тус тус эзэмшдэг болно. Богд Банкны Гүйцэтгэх захирлаар Г.Сарүүл 2014 оны 11 сарын 17-ноос хойш томилогдон ажиллаж байна. Банк нь 2020 оны 8 сарын 19-ны өдөр эцсийн өмчлөгч 1 иргэний мэдээллийг үлсын бүртгэлд зохих ёсоор бүртгүүлсэн байх бөгөөд Л.Болд хувьцаа эзэмшигчийг эцсийн өмчлөгчөөр хүүлийн этгээдийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэсэн байна.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар хувьцаа эзэмшлийн хувьд дараах бүтэцтэй бөгөөд тус бүр Банкны тухай хуулийн 3.1.12-т тодорхойлсон “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” юм.

### 2.2 Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл

Үнэт цаас гаргах үеийн байдлаар Богд Банкны ТУЗ нь 4 ердийн болон 2 хараат бус гишүүдээс бүрдсэн нийт 6 гишүүн байна. ТУЗ-ийн гишүүд нь Банкны тухай хуулийн 32, 33 дугаар зүйл болон Монголбанкнаас тавигдсан шалгуурыг хангасан байна. ТУЗ-ийн 6 гишүүн нь санхүүгийн мэргэжилтэй бөгөөд банк, санхүүгийн салбарт хамгийн багадаа 15 жил ажилласан туршлагатай байна. ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүнээр ажилладаг. ТУЗ-ийн гишүүд бүрийн бүрэн эрхийн хугацаа дараагийн жилийн хувьцаа эзэмшигчдийн эзлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд гишүүдийг улирүүлан сонгож болохоор зохицуулсан байна.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
-11- 03
БУМ-ТГЭВ-03

MICC



*Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл*

| № | Нэр | Харьяалал | Эрхэлж байгаа ажил | Томилогдсон | Төлөв |
|---|---|---|---|---|---|
| 1 | Л.Болдхүяг | Монгол | Богд Банкны ТУЗ-ийн дарга | 2014.10.31 | Ердийн |
| 2 | Г.Саруул | Монгол | ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал | 2014.10.31 | Ердийн |
| 3 | Жан Торстен | Герман | ТУЗ-ийн гишүүн | 2018.12.31 | Ердийн |
| 4 | Эллиот Розан Аукланд | Их Британи | ОУ-ын Хөрөнгө Оруулалтын Банкны Бизнес төлөвлөлт, санхүүгийн загвар члалын албаны дарга | 2021.02.15 | Ердийн |
| 5 | Ж.Нарантуяа | Монгол | ОУ-ын Санхүүгийн Корпорацийн зөвлөх | 2014.10.31 | Хараат |
| 6 | Д.Моломжамц | Монгол | ОУ-ын Хөрөнгө Оруулалтын Банкны зөвлөх | 2018.05.09 | Хараат бус |
| 7 | Р.Нямцэрэн | Монгол | Богд Банкны ахлах хуульч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | 2020.03.02 | Нарийн бичгийн дарга |

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан, банк санхүүгийн салбарт олон жил ажилласан туршлагатай, мэргэшсэн, хоорондын нэгдмэл сонирхолгүй, бие даан шийдвэр гаргах чадвартай, компанийн сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэн Банкны тогтвортой хөгжлийг ханган ажиллах бүрэн боломжтой бөгөөд МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 10.5.1, 10.5.6, 10.5.7, заалтуудыг тус тус хангаж байна.

### 2.3 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод

Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ нь дараах хороодыг байгуулсан байна.

Аудитын хороо

Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлангийн үйл явц, дотоод хяналтын систем болон санхүүгийн эрсдэлийн менежмент, аудитын үйл явц, комплайнс буюу хуулийн нийцлийн асуудлыг хянах үйл явцыг холбогдох хууль тогтоомж, Банкны дотоод дүрэм, журмын дагуу хянахад ТУЗ-д дэмжлэг үзүүлэн ажилладаг. Хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхүяг, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Моломжамц нар ажиллаж байна.

Урамшууллын асуудал эрхэлсэн хороо

Урамшууллын хороо нь Банкинд мөрдөгдөж буй цалин урамшууллын бодлогын хэрэгжилт, гүйцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний биелэлт, ёс зүйн хэм хэмжээ болон банкны урт хугацааны ашигт ажиллагаатай уялдуулсан эсэхэд хяналт тавих, ТУЗ, гүйцэтгэх удирдлагад олгох цалин урамшууллын хэмжээг тодорхойлж, ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг идэвхжүүлэх үүрэгтэй. Түс хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Моломжамц, гишүүдээр ТУЗ-ийн дарга Д.Болдхүяг, ТУЗ-ийн гишүүн Торстен Дазер нар байна.

Эрсдэлийн удирдлагын хороо

Эрсдэлийн удирдлагын хороо нь Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, хянах замаар Банкны хүлээж болзошгүй хохирлыг бууруулах, эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгон хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Моломжамц, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхүяг, ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Саруул нар ажиллаж байна. ТУЗ нь Үнэт цаас гаргагчийн үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмыг батлах ба гүйцэтгэх



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 5903858
ЗМ АЙ СИ СИ ҮЦК ХХК
197
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 оны 10 сарын 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

үдирдлагын банкны үйл ажиллагаанд мөрдүүлэх, зохион байгуулах ажлын хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.

Хүний нөөцийн хороо

Хүний нөөцийн хороо нь ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, ажлын гүйцэтгэлийн тайланг хувьцаа эзэмшигчдэд жил бүр, ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын гүйцэтгэл, хүрлын ирц, хуралд оролцсон байдлын талаар ТУЗ-д тус тус тайлагнах, ТУЗ-ийн гишүүнийг томилох, үүрэг ажлаас чөлөөлөх асуудлыг ХЭХ-д оруулах, гүйцэтгэх удирдлагад багтан ажиллах албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх эгтгэдийг ТУЗ-д танилцуулах, гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэл болон гэрээний биелэлтийг дүгнэж ТУЗ-д танилцуулах зэрэг үүрэгтэй ажилладаг. Хүний нөөцийн хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхүяг болон ТУЗ-ийн гишүүн Г.Саруул нар ажиллаж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Аудитын болон Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнд заавал орж ажиллахаар зохицуулагдсан байна. Хорооны хурлыг хорооны дарга, хорооны гишүүн, мөн Банкны ТУЗ-ийн шийдвэрийн дагуу хуралдуулдаг. Асуудал хэлэлцэх хорооны хэлэлцүүлгийн дүнг хуралд оролцсон бүх гишүүдийн гарын үсэг зурж бичгээр тэргасан шийдвэрт тусгаж, ТУЗ-ийн даргад танилцуулах ба Хорооны гаргасан саналуудыг зөвлөмж гэж авч үздэг. Бусад асуудлуудыг хороодын тусгай дотоод журмын дагуу зохицуулдаг байна.

### 2.4 Үнэт цаас гаргагчийн Удирдлагын баг

Банкны гүйцэтгэх удирдлагын баг нь салбартаа удаан ажилласан, хариуцсан чиг үүрэг болон менежментийн ур чадварын хувьд мэргэшсэн, мэргэжлийн хамт олноос бүрдсэн. Үнэт цаасны танилцуулага бэлтгэх үеийн байдлаар Богд Банкны гүйцэтгэх удирдлагын баг нь дараах бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

*Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг*

| № | Овог нэр | Албан Тушаал | Томилогдсон Огноо |
|---|---|---|---|
| 1 | Г.Саруул | ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал | 2014.10.31 |
| 2 | Д.Термандах | Ерөнхий аудитор | 2019.07.18 |
| 3 | Б.Билэгт | Үйл ажиллагаа хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч | 2018.08.08 |
| 4 | С.Оргодол | Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч | 2020.12.16 |
| 5 | Б.Баярмаа | Бизнес хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч | 2021.08.23 |
| 6 | А.Энхжаргал | Санхүү хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч | 2016.01.06 |
| 7 | М.Алтанзүрх | Мэдээллийн технологи хариуцсан дэд захирал | 2016.12.28 |
| 8 | С.Оттонжаргал | Зээл хариуцсан дэд захирал | 2016.06.13 |
| 9 | Ч.Банчин | Бизнес хөгжил хариуцсан дэд захирал | 2019.06.21 |
| 10 | М.Алтанбагана | Иргэдийн банк хариуцсан дэд захирал | 2019.03.25 |
| 11 | Х.Анхсүрэн | Байгууллагын банк хариуцсан дэд захирал | 2021.09.01 |
| 12 | Ц.Уянга | Цахим банк, Харилцагчийн үйлчилгээ хариуцсан дэд захирал | 2021.09.01 |
| 13 | Э.Ган-Эрдэнэ | Хөрөнгө зохицуулалт, хөрөнгө оруулалтын банкны газрын | 2020.10.06 |
| 14 | Б.Сэргэлэн | Хүний нөөцийн газрын захирал | 2020.02.19 |



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 ₪ 5903858

## Гурав. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтүүд

### 3.1 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан

2020 оны санхүүгийн байдлын тайланд тусгагдсан 91,085,024 мянган төгрөгийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд 2,220,704 мянган төгрөгийн касс дахь бэлэн мөнгө, 51,334,605 мянган төгрөгийн банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө, 37,529,715 мянган төгрөгийн банк, бусад санхүүгийн байгууллагууд дахь харилцах, хадгаламж багтана.

*Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан*

| *Мянган төгрөгөөр* | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 7,441,602 | 99,684,347 | 53,555,309 |
| Банк болон бусад санхүүгийн байгууллагууд дахь харилцах, хадгаламж | 17,006,309 | 30,976,830 | 37,529,715 |
| Бүдаан худалдан авах нөхцөлтэй үнэт цаас | 19,993,976 | | |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 71,990,892 | 24,412,396 | 20,089,647 |
| Дериватив | 5,951 | | |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 53,501,467 | 83,707,974 | 101,262,996 |
| Бусад хөрөнгө | 4,374,101 | 2,904,183 | 3,126,470 |
| Үндсэн хөрөнгө | 1,899,605 | 2,394,691 | 2,326,444 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай ҮХХ | 3,852,421 | 3,753,641 | 3,590,107 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 0 | 2,693,246 | 2,269,534 |
| Биет бус хөрөнгө | 989,098 | 804,106 | 807,055 |
| Борлуулах зориулалттай ҮХХ | | | 344,090 |
| ***Нийт хөрөнгө*** | **180,964,422** | **251,331,414** | **224,901,367** |
| **Эздийн өмч ба өр төлбөр** | | | |
| **Өр төлбөр** | | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 38,827,592 | 94,740,800 | 100,674,527 |
| Банкнаас байршуулсан харилцах, хадгаламж | 31,106,211 | 89,623,237 | 27,048,795 |
| Бүдаан худалдах нөхцөлтэй хэлцэл | 22,986,145 | | 25,048,873 |
| Бусад эх үүсвэр | 29,748,968 | 9,263,050 | 7,464,732 |
| Баталгаа | 1,784,013 | | |
| Бусад өр төлбөр | 4,610,247 | 3,231,713 | 3,363,889 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | | | |
| Дериватив | | 5,653 | |
| ***Нийт өр төлбөр*** | **129,063,176** | **196,864,453** | **163,600,816** |
| **Эздийн өмч** | | | |
| Хувьцаат капитал | 50,000,000 | 50,000,000 | 50,000,000 |
| Хуримтлагдсан ашиг | 1,901,246 | 4,466,961 | 11,300,551 |
| ***Эздийн өмчийн дүн*** | **51,901,246** | **54,466,961** | **61,300,551** |
| **Нийт эздийн өмч ба өр төлбөр** | **180,964,422** | **251,331,414** | **224,901,367** |

*Эх сурвалж: 2018 оны санхүүгийн үзүүлэлтийг KPMG, 2019 ба 2020 оны санхүүгийн үзүүлэлтийг Ernst & Young багалгаажуулсан аудитын тайлан*

2020 оны санхүүгийн байдлын тайланд 101,262,996 мянган төгрөгийн харилцагчдад олгосон нийт зээлийн дансанд дахь зээлийн 92,905,738 мянган төгрөг нь хэвийн, 1,880,175 мянган төгрөг нь хугацаа хэтэрсэн, 1,675,566 мянган төгрөг нь хэвийн бус, 283,546 мянган төгрөг нь эргэлзээтэй, 1,888,486 мянган төгрөг нь муу зээлийн ангилалд байна. Харилцагчдад олгосон зээлийн үлдэгдэл нийт хөрөнгийн 45 хувийг эзэлж байна. 25,048,873 мянган төгрөгийн бүдаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаасны 14,992,608 мянган төгрөгийн үнэт цаас нь Хөгжлийн банкны, үлдсэн нь Монголбанкны үнэт цаас байна. 2020 оны байдлаар харилцагчдын харилцах,

СЗХ
БҮРТГЭВ
2021 -11- 03
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03



хадгаламжийн дансанд дахь үлдэгдэл 100,674,527 мянган төгрөг байгаагаас Засгийн Газрын хадгаламж 23,776,846 мянган төгрөг, байгууллагын хадгаламж 31,845,429 мянган төгрөг, иргэдийн хадгаламж 45,052,252 мянган төгрөг байна. Нийт хөрөнгийн 17 хувийг эзэмшигчдийн өмч, 45 хувийг харилцагчдын харилцах, хадгаламжийн үлдэгдэл тус тус эзэлж байна. Богд банкны нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11 хувиар буурсан бол өөрийн хөрөнгө нь 2019 онд өмнөх оноос 5%-иар, 2020 онд 13%-иар өссөн байна.

### 3.2 Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан

Үнэт цаас гаргагч нь 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 224.9 тэрбум төгрөгийн нийт хөрөнгө, 61.3 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, цэвэр ашгийн үзүүлэлт үүсгэн байгуулагдсан цагаас хойш тогтмол өссөн бөгөөд 2020 оны эцэст 5.6 тэрбум төгрөгт хүрсэн нь /119 хувиар өссөн/ өмнөх жилийн үзүүлэлтээс ойролцоогоор 2 дахин өссөн үзүүлэлт юм. Эдийн засгийн нөхцөл байдал хүнд байсан хэдий ч үнэт цаас гаргагч нь удирдлагын оновчтой менежментийн үр дүнд ашгийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн байна. Өөрийн хөрөнгийн өгөөж 11.1% болж нэмэгдсэн нь байна.

*Аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан*

| *Мянган төгрөгөөр* | 2018 | 2019 | 2020 | өсөлт |
|---|---|---|---|---|
| **Хүүгийн орлого** | **10,132,377** | **21,054,710** | **24,497,420** | **16%** |
| Монголбанкинд байршуулсан хөрөнгийн | 169,762 | 386,237 | 414,883 | 7% |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн | 2,185,496 | 2,069,803 | 2,238,341 | 8% |
| Үнэт цаасны | 3,081,044 | 5,734,923 | 5,255,516 | -8% |
| Зээлийн | 4,696,075 | 12,863,747 | 16,588,680 | 29% |
| **Хүүгийн бус орлого** | **4,542,689** | **1,589,157** | **2,990,810** | **88%** |
| Арилжааны орлого | 3,420,279 | 425,800 | 916,006 | 115% |
| Хураамж, шимтгэлийн орлого | 626,070 | 1,071,574 | 1,593,908 | 49% |
| Бусад хүүгийн бус орлого | 496,340 | 91,783 | 480,896 | 424% |
| **Нийт орлого** | **14,675,066** | **22,643,867** | **27,488,230** | **21%** |
| **Хүүгийн зардал** | **4,119,502** | **11,056,797** | **11,885,143** | **7%** |
| Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүү | 4,027,013 | 3,511,933 | 2,344,164 | -33% |
| Харилцагчид төлсөн хүү | 26,360 | 3,889,622 | 6,166,917 | 59% |
| Бүцаан худалдан авах гэрээний | 58,928 | 3,142,531 | 2,706,446 | -14% |
| Бусад эх үүсвэрийн | 7,201 | 149,071 | 272,997 | 83% |
| Бусад хүүгийн зардал | - | 363,640 | 394,619 | 9% |
| **Хүүгийн бус зардал** | 7,977,405 | 7,428,157 | 8,585,674 | 16% |
| Арилжааны зардал | 3,211,969 | 128,087 | 394,630 | 208% |
| Хураамж, шимтгэлийн зардал | 292,231 | 368,063 | 401,875 | 9% |
| Үйл ажиллагааны бусад зардал | 4,473,205 | 6,932,007 | 7,789,169 | 12% |
| **Нийт зардал** | **12,096,907** | **18,484,954** | **20,470,817** | **11%** |
| **Үйл ажиллагааны ашиг** | **2,578,159** | **4,158,913** | **7,017,413** | **69%** |
| Болзошгүй эрсдэлийн сан | 293,332 | 1,271,862 | 806,397 | -37% |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг** | 2,284,827 | 2,887,051 | 6,211,016 | 115% |
| Үндсэн бус зардал | 15,610 | | | |
| **Татварын өмнөх ашиг** | 2,269,217 | 2,887,051 | 6,211,016 | 115% |
| Орлогын татвар | 81,895 | 317,000 | 593,687 | 87% |
| **Цэвэр ашиг** | **2,187,322** | **2,570,051** | **5,617,329** | **119%** |

*Эх сурвалж: 2018 оны санхүүгийн үзүүлэлтийг KPMG, 2019 ба 2020 оны санхүүгийн үзүүлэлтийг Ernst & Young баталгаажуулсан аудитын тайлан*

2020 онд нийт 24.5 тэрбум төгрөгийн хүү болон түүнтэй адилтгах орлого нь өмнөх оноос 16 хувиар өссөн бөгөөд нийт орлогын 89 хувь нь хүүгийн орлого, үлдсэн хувь нь хүүгийн бус орлого байна. 2020 онд хүүгийн бус орлого 2.99 тэрбум хүрсэн нь арилжааны орлого, үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого, бусад хүүгийн бус орлогын өсөлтөөс бий болсон байна. 2020 онд



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 - 5903358
ЭМ ЭН СИ ХК ТТК ХХК
200

бизнесийн хэвийн үйл ажиллагааны зардал өмнөх онтой харьцуулахад 11%-иар өсөж 20.5 тэрбум төгрөг болсон. Энэ нь үйл ажиллагаа өргөжин тэлсэнтэй холбоотойгоор нэмэгдсэн зардлууд байна. Нийт зардлын өсөлтөд хүүгийн зардал 7 хувь, хүүгийн бус зардал 16 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. 2020 онд хүүгийн зардалд 11.9 тэрбум төгрөг төлсөн нь өмнөх оны дүнгээс 7 хувиар өссөн байна. 2019 ба 2020 онуудад үр ашгийг татварын хувь тогтмол 9% орчим байна. Нийт орлого өмнөх онтой харьцуулахад 2019 онд 54 хувь, 2020 онд 21 хувиар өссөн байна.

### 3.3 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээний үзүүлэлтүүд

***Хөрөнгө оруулалтын өгөөж***

Банкны өөрийн хөрөнгийн өгөөж нь 2021 онд 11.5 хувь, 2022 онд 10.8 хувь болох тооцололтой байгаа ба цаашид өссөөр 2027 онд 16.9 хувь байх төсөөлөлтэй байна. Харин нийт хөрөнгийн өгөөж нь 2021 оноос 2027 оны хооронд дунджаар 1.8 хувь болох төлөвтэй байна.

*Хөрөнгийн эргэц, өгөөж*

Банкны дупонт шинжилгээ болон харьцаа үзүүлэлтийн шинжилгээнээс харахад банкны орлого, цэвэр ашгийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд хөрөнгийн эргэц мөн өссөн үзүүлэлттэй байна.

Богд Банк нь 2023 он хүртэл шинээр 71 салбар нэгжийг нээн 2023 оны байдлаар 381,100 харилцагчтай болох төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд Банкны салбар нэгжийн тоо болон харилцагчдын тоо нэмэгдсэнээр банкны нийт орлого 2027 он хүртэл дунджаар 39 хувиар өсөх төлөвтэй байна.

*Ашигт ажиллагааны шинжилгээ*

| Ашигт ажиллагаа- DuPont шинжилгээ | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөрөнгийн эргэц (Орлого / Хөрөнгийн дундаж) | 0.10x | 0.11x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x |
| x Ашигт ажиллагаа (Цэвэр ашиг / Орлого) | 11.60% | 21.0% | 24.5% | 17.1% | 5.4% | 14.6% | 14.9% | 15.3% | 16.3% |
| = Хөрөнгийн өгөөж (ROA) | 1.2% | 2.4% | 2.9% | 2.0% | 1.8% | 1.8% | 1.8% | 1.8% | 2.0% |
| x Хөшүүрэг | 4.06x | 4.11x | 3.92x | 5.05x | 6.94x | 8.90x | 10.17x | 9.54x | 8.59x |

СЗХ
ирсэн өдөр 2021 11 10
БҮРТГЭВ
№ 1
БҮРТГЭВ-03



| (Хөрөнгийн дундаж / Өмчийн дундаж) | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| = Өмчийн өгөөж (ROE(дундаж)) | 4.8% | 9.7% | 11.5% | 10.1% | 12.6% | 15.6% | 18.3% | 17.6% | 16.8% |
| Хугацааны эхний өмчийн өгөөж (ROE1) | 4.95% | 10.31% | 15.25% | 10.62% | 13.46% | 16.90% | 20.13% | 19.28% | 18.40% |

*Санхүүгийн үзүүлэлтийн харьцуулсан шинжилгээ*

| | Банкны салбарын дундаж | | | Богд банк | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
| Өмчийн өгөөж (ROE) | 6.2% | 7.2% | 7.5% | 11.5% | 10.1% | 12.6% | 15.6% | 18.3% | 17.6% | 16.9% |
| Хөрөнгийн өгөөж (ROA) | 0.7% | 0.9% | 1.0% | 2.93% | 2.0% | 1.8% | 1.8% | 1.8% | 1.8% | 2.0% |
| Цэвэр ашгийн маржин | 3.5% | 7.6% | 9.1% | 24.5% | 17.1% | 15.4% | 14.6% | 14.9% | 15.3% | 16.3% |
| Хөрөнгийн эргэц | 10.3x | 10.8x | 10.0x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x | 0.12x |
| Хөшүүрэг | 13x | 11.8x | 15.2x | 3.9x | 5.1x | 6.9x | 8.9x | 10.2x | 9.5x | 8.6x |

DuPont анализ нь эздийн өмчийн өгөөжийг (ROE) гурван хүчин зүйлээр задалж, уг санхүүгийн үзүүлэлт тус бүрээр ашигт ажиллагааны сул тал болон давуу талуудыг харуулдаг санхүүгийн хэрэглэгдэхүүн юм. ROE нь цэвэр ашгийг өмчид харьцуулж тооцдог санхүүгийн үр ашгийн үзүүлэлт бөгөөд хамгийн энгийнээр эздийн өмчийн өгөөжийн урт хугацааны дундаж үзүүлэлт нь 14% буюу түүнээс дээш байх нь өгөөж өндөр байгааг илтгэх бөгөөд 10 хувиас бага байх нь хангалтгүй үзүүлэлт юм. Богд банкны хувьд ирэх 7 жилд дунджаар 14.6%-н эздийн өмчийн өгөөжтэй байх тооцоотой байгаа ба энэ нь салбарын дунджаас харьцангуй өндөр байгаа нь компанийн ашигт ажиллагааны түвшинг илтгэж байна.

Эздийн өмчийн өгөөж= Цэвэр ашгийн маржин* Нийт хөрөнгийн эргэц* Санхүүгийн хөшүүрэг

Нийт хөрөнгийн эргэцээр хэмжигддэг хөрөнгийн үр ашигт хэрэглээ нь тухайн жилийн орлогыг дундаж ашигт харьцуулсан үзүүлэлт ба үг үзүүлэлт нь бизнесийн салбараас хамаарч ялгаатай байдаг байна. Богд Банкны ирээдүйн 7 жилийн тооцооллын хувьд нийт хөрөнгийн эргэц нь дунджаар 0.12х байх тооцоотой байгаа нь мөн салбарын дунджаас өндөр буюу хөрөнгийн үр ашигт хэрэглээтэй байгааг харуулж байна.

Санхүүгийн хөшүүрэг буюу өмчийн үржүүлэгч нь компани нийт хөрөнгөө санхүүжүүлэх зорилгоор хэр хэмжээний эх үүсвэр татсаныг шүүд бүс аргаар хэмжих үзүүлэлт юм. Уг үзүүлэлтийг нийт хөрөнгийг нийт өмчид харьцуулж олдог ба хөшүүрэг бага байх нь компанийг өрсөлдөгчидтэй нь харьцуулахад сул талтай болгодог бол хэт их хөшүүрэгтэй байх нь компанийн санхүүгийн эрсдэлийг нэмэгдүүлдэг. Богд банкны хувьд хөшүүргийн хэмжээ салбарын дунджаас доогуур байгаа нь нэгдүгээрт санхүүгийн эрсдэл бага байгааг илтгэх ба цаашлаад хөшүүргийг нэмэгдүүлэх замаар үйл ажиллагаагаа тэлэх боломж бийг харуулж байна.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 ⁂ 5903858

СЭХ
өдөр
БҮРТГЭВ
БҮРТГЭВ-03



## Дөрөв. Санал болгож буй үнэт цаасны танилцуулга

### 4.1 Санал болгож буй үнэт цаасны мэдээлэл

*Үнэт цаасны хураангуй танилцуулга*

| Үнэт цаас гаргагч | Богд Банк ХХК |
|---|---|
| **Бүртгэл** | Монголын Хөрөнгийн Бирж |
| **Ангилал** | Тангилал |
| **Үнэт цаасны төрөл** | Энгийн хувьцаа |
| **Гаргасан хувьцааны тоо** | 50,000,000 ширхэг |
| **Үнэт цаасны арилжаа явуулах арга** | Олон нийтэд нээлттэй хүрээнд |
| **Нийтэд санал болгож буй хувь** | 20.00% |
| **Нэмж гаргах хувьцааны тоо** | 12,500,000 ширхэг |
| **Анхдагч зах зээлд гаргах аргачлал** | Тогтоосон үнийн үнийн арга |
| **Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох хэмжээ, санал болгох үнэ** | • 8,750,000 ширхэг (нэмж гаргах хувьцааны 70%)<br>• Санал болгох үнэ: ₮2,540 төгрөг |
| **Олон нийтэд санал болгох хэмжээ, санал болгох үнэ** | • 3,750,000 ширхэг (нэмж гаргах хувьцааны 30%)<br>• Санал болгох үнэ: ₮2,540 төгрөг |
| **Олон нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо** | 62,500,000 ширхэг |
| **Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ** | **₮31,750,000,000 төгрөг** |
| **Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт** | 1.Технологийн хөрөнгө оруулалт<br>2.Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлт<br>3. Борлуулалтын сувгийн хөгжүүлэлт, сайжруулалт |
| **Андеррайтер** | ЭМ АЙ СИ СИ УЦК ХХК / MICC |

### 4.2 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийн талаар

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр

Банкны хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу Үнэт цаас гаргагч нь 2021 оны 4 сарын 1-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 21/06 тоот шийдвэрээр Банкийг өөрчлөн байгуулах тухай хуралдан, Банкны тухай хуулийн 28 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйл болон Үнэт цаас гаргагчийн Удирдлагын хорооны 2021 оны 1 сарын 14-ны өдрийн 21/03 тоот хурлаас гарсан шийдвэр, Компанийн дүрмийн 7.1, 7.3.2, 7.3.4, 7.3.8, 13.1, 13.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Богд Банкны 20 хувьтай тэнцэх энгийн хувьцааг шинээр нэмж гарган, нийтэд нээлттэй арилжих замаар Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулсан саналыг зөвшөөрч, үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбогдох үйлчилгээ үзүүлэх компаниудыг сонгон хамтран ажиллахаар шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Үнэт цаас гаргагч нь 2021 оны 2 сарын 2-ны өдрийн ТУЗ-ийн 21/06 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан, Банкийг өөрчлөн байгуулах тухай асуудлыг хэлэлцэхээр хуралдан, Банкны тухай хуулийн 28.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 18.1 дэх хэсэг болон Үнэт цаас гаргагчийн Удирдлагын хорооны 2021 оны 1 сарын 14-ний өдрийн 21/03 тоот хурлаас гарсан шийдвэр, Компанийн дүрмийн 7.3.2, 7.3.4, 7.3.8, 8.12.5, 8.12.6, 13.1, 13.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Богд Банкийг өөрчлөн байгуулах, энгийн хувьцааг шинээр нэмж гарган Биржээр



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УДААНБААТАР ХОТ
5903858

СЭХ
2021.11.10 ӨДӨР
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

дамжуулан нийтэд нээлттэй арилжих замаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, улмаар хувьцаат компани болгон хэлбэрээ өөрчлөх саналыг банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлсэн байна.

### 4.3 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах талаар

***Хувьцааг анхдагч зах зээлд арилжаалах аргачлал***

Үнэт цаас гаргагч нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг МХБ-тэй Анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах гэрээ байгуулан явуулах ба үнэт цаасыг МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 4 дүгээр бүлэгт заасан "ТОГТООСОН ҮНИЙН АРГА"-ыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална.

Тогтоосон үнийн аргаар хийх арилжаа нь МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.1.3 хэсэгт зааснаар үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнээр санал болгон арилжих үйл ажиллагааг хэлэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнийг дараах байдлаар тогтоосон байна.

*Хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнэ*

| Хөрөнгө оруулагчид | Нэмж гаргах хувьцаанаас санал болгох хувь | Санал болгох хувьцааны тоо | Санал болгох үнэ (төгрөг) | Татан төвлөрүүлэх хөрөнгө (төгрөг) |
|---|---|---|---|---|
| **Стратегийн** | 70% | 8,750,000 | ₮2,540 | 22,225,000,000 |
| **Олон нийт** | 30% | 3,750,000 | ₮2,540 | 9,525,000,000 |
| **Нийт** | **100%** | **12,500,000** | | **31,750,000,000** |

**Стратегийн хөрөнгө оруулагч**

Стратегийн хөрөнгө оруулагч гэдэг нь Биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.4 дэх хэсэгт тодорхойлсон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, анхдагч зах зээлийн арилжаанд нийт худалдан авалт нь 500 сая төгрөгнөөс доошгүй дүнтэй байх бөгөөд үнэт цаасаа 6-аас доошгүй сарын хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагчийг ойлгоно. Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээнээс нийт захиалгын хэмжээ давсан тохиолдолд стратегийн хөрөнгө оруулагч бүрийн захиалгыг хувь тэнцүүлэх аргачлалд оруулалгүйгээр шууд биелүүлэн тооцно.

Хэрэв стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга нь санал болгож буй нэмж гаргах хувьцааны 70 хувиас хэтэрвэл стратегийн хөрөнгө оруулагчдын хувьцааны захиалгыг цаг хугацааны дараалаар биелүүлж, 70 хувиас давсан захиалгыг олон нийтэд санал болгож буй 30 хувийн хувьцаанаас хуваарилалт хийнэ.

Стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд тогтоосон үнийн аргаар санал болгох хувьцааны үнэ нь 2,540 төгрөг байна.

Тогтоосон үнэ (өгөөж)-ээр санал болгох арилжаа - Үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнээр санал болгон арилжих үйл ажиллагаа бөгөөд МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.1.3 хэсэгт заасан байдаг.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
58966 • 5903659
ЗХ АЙ СИ СИ ҮНЭ ХХК
MICC
ТТГ № 6719
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
БҮРТГЭВ-03



Харилцагч худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнээр өгөх бөгөөд энэ аргыг ашиглах үед үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй. Нийт харилцагчдад тэнцүү хуваарилах хөрөнгийн суурь хэмжээг тогтоож болно. Нийт худалдан авах захиалгын тоо ширхэг нийт санал болгосон үнэт цаасны тоо ширхгээс илүү гарсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглан үнэт цаасны хуваарилалтыг хийнэ. Хувь тэнцүүлэх коэффициентийг олохдоо:

K = C1/C2

K- Хувь тэнцүүлэх коэффициент

C1 - Арилжихаар санал болгож буй нийт үнэт цаасны тоо

C2 - Худалдан авах захиалгад багтсан нийт үнэт цаасны тоо

Худалдан авах захиалга тус бүрийг хувь тэнцүүлэх коэффициентээр үржүүлж, харилцагч бүрт оногдох үнэт цаасны тоог гаргана. Хувь тэнцүүлэх коэффициентоор үржүүлж гарсан тооны бутархай орон нь 0.5-аас дээш бол 1 бүхэл нэгжид, 0.5-аас доош бол 0 нэгжид шилжүүлэн тооцно. Бутархай оронг бүхэл тоонд шилжүүлсний дараа хуваарилалт хийгдсэн нийт хувьцааны тоо арилжихаар санал болгож буй үнэт цаасны тооноос илүү гарсан тохиолдолд хамгийн олон ширхэг хувьцаа авах захиалга өгсөн харилцагчдын үнэт цаасны тооноос тус бүр нэг ширхгийг хасах зарчмаар арилжихаар санал болгож буй тоотой тэнцүүлнэ. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн нөхцлийн дагуу нэг харилцагчийн үнэт цаас худалдан авах захиалгын мөнгөн дүнгийн дээд хэмжээг заасан хязгаарлалтыг тогтоож болно.
Үнэт цаасны танилцуулгад анхдагч зах зээлд хувьцааг байршуулах асуудлыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

***Хувьцаа арилжаалах зөвшөөрөл авах***

Банк нь Андеррайтераар компаниар дамжуулан МХБ болон СЭХ-д үнэт цаасаа бүртгүүлэх тухай хүсэлт гаргана. үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл авснаар олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно. Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх хүсэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд гаргах бөгөөд тус зөвшөөрөл олгогдсоноор анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авахад бэлэн болно. Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дуссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг СЭХ-нд хүргүүлнэ. Хороо нь тайланг хүлээн авч арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвд өмчлөх эрхийн бүртгэл хийх болон хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох албан бичгийг ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.

***Хувьцааг арилжих нөхцөл***

- Банкны энгийн хувьцааг МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын гуравдугаар зүйлд заасны дагуу ***Тогтоосон үнийн аргаар*** санал болгон арилжина.
- Хувьцааны захиалгын тоо (захиалгын гэрээ) хэтэрснээс үүдэн тогтоосон босго дүнгээр захиалгыг биелүүлэх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдол бүрд босго үнийн дүнг 25 хүртэлх хувиар бууруулан шинэчлэн тогтоож болно. Ингэхдээ үнэт цаас гаргагч болон андеррайтер нь МХБ-тэй зөвшилцөнө.
- Захиалгын бүртгэлийн эхлэх болон дуусах хугацааг Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь СЭХ-ны шийдвэр гарсны дараа Биржтэй хамтран тогтооно.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 , 5903858

СЗХ
2021 -11- 10 өдөр
БҮРТГЭВ

2021 -11- 03
БҮРТГЭВ-03



- Андеррайтер нь ҮЦК-иудад арилжааны талаар зааварчилга, мэдээлэл өгөх бә ҮЦК-иуд захиалгыг биржийн программд шивж оруулна.
- Захиалга бүртгэлийн хугацаанд стратегийн хөрөнгө оруулагчдаас болон олон нийтээс захиалга авах сан нь түсдаа байна.
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан үг нөхцөл байдал, журмын зохицуулалтыг танилцуулаагүй, бичгээр мэдэгдэл авааагүйгээс харилцагчдад учирсан хохирлыг үнэт цаас гаргагч болон андеррайтер хариуцахгүй.

***Хувьцааг олон нийтэд танилцуулах***

- Банктай хамтарч маркетингийн стратеги боловсруулж, Үнэт цаасны танилцуулга болон танилцуулгын хураангуйг боломжит хөрөнгө оруулагчдад танилцуулах.
- Roadshow: Үнэт цаасны танилцуулга (roadshow) зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, боломжит хөрөнгө оруулагчидтай уулзаж, танилцуулах.
- Санал болгож буй хувьцаатай холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх.

***Захиалга хүлээн авах, биелүүлэх***

- СЗХ-ны зөвшөөрлийн дагуу МХБ-тэй хамтран захиалга хүлээн авч эхлэх болон хаах хугацааг тогтоох,
- ҮЦК-иудад арилжааны талаарх зааварчилгаа, мэдээлэл өгөх,
- ҮЦК-иуд худалдан авах захиалгыг биржийн программд шивэх,
- Сонгосон аргачлалын дагуу хувьцаа худалдан авах захиалгыг СЗХ-ноос зөвшөөрөл авснаар биелүүлэх.

***Хувьцаа худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагчид:***

- МХБ-д бүртгэлтэй ҮЦК-иудаас сонгож, үнэт цаасны данс нээлгэнэ,
- Үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу хувьцаа худалдан авахад шаардагдах мөнгөө брокерын үйлчилгээний шимтгэлийн хамтаар байршуулна.

*Гүйлгээний зааварт*

| | |
|---|---|
| Хүлээн авагчийн банк: | Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК |
| Хүлээн авагчийн нэр: | Овог, нэр |
| Дансны дугаар: | 12 орон бүхий үнэт цаасны дансны дугаар (ҮЦК-иас авлах) |
| Үнийн дүн: | Хувьцааны үнэ+шимтгэл |
| Гүйлгээний утга: | Хувьцааны мөнгө (Овог, нэр, регистрийн дугаар) |

- Сонгон үйлчлүүлж буй үнэт цаасны компанидаа хувьцаа худалдан авах захиалгаа өгөх, гэрээ байгуулах.
- Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдсанаар хөрөнгө оруулагчийн нэр дээр хувьцаа шилжинэ.

### 4.4 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлөвлөгөө

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар "хоёрдогч зах зээл" гэж үнэт цаасны анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасыг дахин арилжихтай холбогдсон харилцааг хэлдэг. Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг Хороонд хүргүүлнэ. Хороо үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд



БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

арилжсан тухай тайланг ажлын гурван өдөрт багтаан хянах бөгөөд зөрчил гарвагүй, үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон гэж үзсэн тохиолдолд үнэт цаасны хөрөнгө зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгоно. УЦТХТ болон Бирж нь үг зөвшөөрлийг хүлээн авснаар үнэт цаасны хөрөнгө зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

### 4.5 Хувьцаатай холбоотой шимтгэл ба орлогын албан татвар

***Хувьцааны арилжааны шимтгэл***

Хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанитай хийсэн гэрээнд заасны дагуу хувьцааны арилжааны шимтгэл төлөх үүрэгтэй. Үнэт цаас борлуулсан орлогын албан татварыг арилжаанд оролцсон хувь хүн, хуулийн этгээд жилийн эцэст нэг удаа доор дурдсаны дагуу төлөхөөр зохицуулагдсан байна. Үүнд:

***Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар***

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасан "хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого" болон 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан "ногдол ашгийн орлого"-д тус хуулийн 17-р зүйлд зааснаар 10 хувийн татвар ногдуулна гэж заасан байна.

***Хувь хүний орлогын албан татвар***

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан "ногдол ашгийн орлого", 10 дугаар зүйлийн 10.1.4-т заасан "Хувьцаа, үнэт цаас борлуулсан орлого"-д тус хуулийн 21.2.4-т зааснаар 10 хувийн татвар ногдуулна гэж заасан байна.

### 4.6 Үнэт цаасаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Богд Банк нь олон нийтээс татан төвлөрүүлж буй хөрөнгөөр дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж, банкны үйл ажиллагааг өргөжүүлж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Түс ажлын хүрээнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийж, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлт болон зээл олголтын үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн.

*Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө*

| № | Хөрөнгө оруулалтын төрөл (сая төгрөг) | 2021 | 2022 | 2023 | Нийт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Технологийн хөрөнгө оруулалт | 2,540 | 7,303 | 2,858 | **12,700** | **40%** |
| 2 | Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлт | 1,905 | 3,810 | 3,810 | **9,525** | **30%** |
| 3 | Борлуулалтын сувгийн хөгжүүлэлт, сайжруулалт | 2,778 | 3,523 | 3,224 | **9,525** | **30%** |
| **Нийт** | | **7,223** | **14,636** | **9,891** | **31,750** | **100%** |

*Эх сурвалж: Богд банк*

### 4.7 Үнэт цаас худалдан авахад анхаарах зүйлс

Үнэт цаас гаргагч нь 2014 оноос арилжааны банкны үйл ажиллагаагаа эхлүүлэн богино хугацаанд тогтвортой өсөлт үзүүлж байгаа технологид суурилсан шинийг санаачлагч, олон үлсын жишиг нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн Монгол Улсын санхүүгийн зах зээл дээр тогтвортой

өсөлттэй тэргүүлэгч банк болж ирэх таван жилийн хугацаанд банкны салбарын нөлөө бүхий банк болохоор зорин ажиллаж буй шинэлэг банк юм. Энэхүү зорилгодоо хүрэхдээ өөрсдийн бүсдаас ялгарах бүтээгдэхүүн үйлчилгээг дэлхийн стандартад нийцүүлэн бүх төрлийн харилцагчдад санал болгон, харилцагчийн баяз сууриа нэмэгдүүлэх, одоо байгаа харилцагчдадаа сэтгэл ханамжийг бий болгож байна. Хөрөнгө оруулагч та үнэт цаасны танилцуулгаас үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, өмнөх жилүүдийн амжилт, ололт болон цаашдын хөрөнгө оруулалт, стратеги болон санхүүгийн төлөвлөгөөний тухай илүү дэлгэрэнгүй мэдээллүүдтэй танилцах боломжтой.

Банк нь Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд бүртгэгдэж олон нийтээс хөрөнгө оруулалт татаж байгаа ба хувьцааны бүртгэлийн I ангилалд бүртгүүлэх үнэт цаасны шалгүүр үзүүлэлтүүдийг хангасан байх журмын зохицуулалттай.

Иймд хөрөнгө оруулагч нь эдгээр нөхцөл байдлыг анхаарч, үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээлэл, компани болон хөрөнгө оруулагчдад учирч болзошгүй эрсдэлийн талаар сайтар судалж үнэт цаас гаргагчийн санал болгож байгаа хувьцааг худалдан авах шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

## ДҮГНЭЛТ

"Эм Ай Си Си ҮЦК" ХХК нь андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийсэн шинжилгээ, судалгаа, үнэт цаас гаргахтай холбогдуулан бусад мэргэжлийн байгууллагуудын хийсэн тайлан дүгнэлтүүдэд үндэслэн Богд Банкны хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой гэж үзэн энэхүү дүгнэлтийг гаргаж байна.

Үнэт цаас гаргагч нь Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 оны 1 сарын 28-ны өдрийн УИХ-аас хэлэлцэн батлсны дагуу хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах, салбарын засаглалыг ахиулж, илүү ил тод, нээлттэй болгох, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлж банкны хувьцаа эзэмшил, удирдлагын төвлөрсөн байдлаас үүдэлтэй эрсдлийг бууруулж, банкны хувьцааны эзэмшил, мэдээллийн хүртээмжээр дамжуулан олон нийтийн хяналтыг бий болгох, банкны хяналт шалгалтын бие даасан байдлыг нэмэгдүүлэх үүднээс 2021 онд олон нийтэд өөрийн хувьцаагаа санал болгон салбартаа бүсдыг хошуучлан манлайлж анхдагч, түүчээлэгч банк болж өөрсдийн бүсдаас ялгарах бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдад санал болгон, санхүүгийн хувьд тэлж, харилцагчийн баяз сууриа нэмэгдүүлж одоо байгаа харилцагчиддаа сэтгэл ханамжийг илүү бий болгох, бүтээгдэхүүн үйлчилгээг технологид суурилсан дэлхийн стандартад нийцсэн санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлсэн санхүүгийн институци болохоор зорин ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь өөрийн хэлбэрийг өөрчлөн хувьцаат компани болсноор хувьцаагаа олон нийтэд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан санал болгож байгаа нь өдөөс өдөрт хувьсан өөрчлөгдөж буй технологийн ертөнцөд, банк-санхүүгийн салбарт технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр уламжлалт банкны бизнесээ өргөжүүлэн тэлж бий болох бодит өгөөжийг хувьцаа эзэмшигчид, нийт харилцагч үйлчлүүлэгчидтэйгээ хуваалцан, хамт хүртэх боломжийг бүрдүүлж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13 дахь хэсэгт тусгаснаар нийтэд санал болгон гаргах үнэт цаас, түүний танилцуулгыг бүртгэсэн, нийтэд санал болгох болон үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах зөвшөөрөл олгосныг тухайн үнэт цаасанд өгч байгаа баталгаа гэж үзэхгүй бөгөөд үнэт цаасыг худалдан авсны улмаас хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг



СЗХ
2021 -11- 03
208

СЗХ
2021 11 10
БҮРТГЭВ
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



бүртгэсэн байгууллага хариуцахгүй, эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй.

Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ямагт эрсдэлтэй үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажилласааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна. Мөн гарч болзошгүй эрсдэлүүдийг нь зөвхөн үнэт цаасны танилцуулгыг бэлдэх үед тодорхойлсон болзошгүй эрсдэлүүд бөгөөд урьдчилан тодорхойлох боломжгүй гэнэтийн нийгэм улс төр, гадаад дотоод зах зээлийн мэдээ мэдээлэл, үйл явдлууд нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт, ирээдүйн ашигт сөргөөр нөлөөлж болзошгүй ба энэ нь үнэт цаасны ханшид нөлөөлж, хөрөнгө оруулагч өөрийн оруулсан бүх хөрөнгө эсвэл хөрөнгийн зарим хэсгийг алдах эрсдэлтэй болохыг анхаарна уу.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 ₪ 5903858

СЗХ
2021 .11 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2021 11 03
БҮРТГЭСЭН

## ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН ДҮГНЭЛТ

BDO

Нууцлалын гэрээгээр хатуу хязгаарлагдсан

# БОГД БАНК ХХК

**2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх**

**Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний тайлан**

**БДО Аудит Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани**

*Манчөл үлсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

*Энэхүү тайлан нь Хавсралт А-д заасан Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл болон Үйлчлүүлэгчийн зөвшөөрөл хэлэлцээрийн дагуу бэлтгэгдсэн болно. Тины хэрэгцээнээс өөр зорилгоор хэвлэмэл болон цахим хэлбэрээр хуулбарлах нь хүчин төвөлөөр болно.*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
БАТАР ХХК

ЭМ АЙ СИ СИ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

Монгол улс, Улаанбаатар хот
СБД-1, ЮНЕСКО-гийн гудамж
Нарны зам-62, Юнион Билдинг
В блок, 15-р давхар, 1502 тоот

**Богд банк ХХК**
Монгол Улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3,
Улаанбаатар 15160, Монгол улс
Бодь цамхаг, 1 давхар

БОГД БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.САРУУЛ ТАНАА:

Огноо: 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдөр

Хүндэт ноён,

Бидний хооронд 2021 оны 03 дугаар сарын 02-нд байгуулсан Хөрөнгийн болон Бизнесийн үнэлгээ хийх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-нд заасны дагуу бид Богд банк ХХК (цаашид "Богд банк" гэх)-ийн захиалгаар тус компанийн банкны үйл ажиллагааг хамарсан бизнес (цаашид "Бизнес" гэх)-ийн өмчийн 100 хувийн хувь оролцоог үнэлж, бизнесийн үнэлгээний тайлан бэлтгэлээ.

Богд банк нь үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргахтай холбоотой шийдвэр гаргах зорилгоор бизнесийн өмчийн 100 хувийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэн тодорхойлох үнэлгээ (цаашид "Үнэлгээ" гэх) хийхийг биднээс хүссэн.

Үнэлгээний олон улсын стандартын УОУС 200 ***Бизнес ба Бизнесийн хувь оролцоо***-ын 20.3(г)-д заасны дагуу бидний энэхүү тайлангаар тайлагнасан үнэ цэн нь "өмчийн бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэн" болно.

Энэхүү тайлан нь 2020 оны 12 дугаар сарын 31 ("Үнэлгээний өдөр")-ны байдлаар бизнесийн үнэлгээний үр дүнг нэгтгэсэн болно. Үнэлгээний зорилго нь харааг бүс экспертийн журмаар банкны эрхэлж буй бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэнийг тооцоход оршино.

Үнэлгээний хураангуй дүгнэлтэд бидний ашигласан үнэлгээний хандлага, арга зүйн тайлбар, үнэлгээний шинжилгээ хийхэд авч үзсэн хүчин зүйлс багтсан. Бид мөн ашигласан мэдээллийн эх сурвалжийг аливаа хязгаарлалтын хамтаар энэхүү тайлангийн Хавсралт А-Л-д жагсаасан. Хавсралт А-Л-д дурдсан мэдээлэл, тооцоолол, үнэлгээний хязгаарлалтын нөхцөл нь үг тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Энэхүү тайланд тусгагдсан бизнестэй холбогдох шинжилгээ нь банкны удирдлагаас өгсөн мэдээлэлд үндэслэсэн. Бизнесийн үнэ цэнийг мэргэжлийн шүүн тунгаалт (шийдэл) ашиглан тооцсон тул бусад үнэлгээчид үүнтэй ижил үр дүнг гаргахгүй байж болно гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Банкнаас бидэнд өгсөн мэдээлэл ба өөрсдийн ашигласан төсөөллүүдэд суурилан бид энэхүү тайланд тооцоолсон үнэ цэн нь үл үндэслэлтэй гэж үзэж байна.

Энэ үнэлгээнд материаллаг үр нөлөөтэй аливаа мэдээллийг бид олж мэдсэн нөхцөлд холбогдох нэмэлт мэдээллийг түүгээс өөрсдийн үнэлгээний дүгнэлтээ шинэчлэн найруулах эрхтэй болохыг ийм үүрэг хүлээхгүй.

Хэрэв танд аливаа тайлбар эсвэл дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай бол Г.Баянменхтай +976 9111 4040, bayanmunkh@bdo.mn гэсэн хаягаар, эсвэл Д.Алтансүх +976 8888 1614, altansukh@bdo.mn хаягаар холбоо барина уу.

Таныг хүндэтгэсэн,

Гомбын БАЯНМЕНХ
Удирдах партнер
Тэргүүлэх үнэлгээчин
БДО Аудит ХХК

Даланбаярын АЛТАНСҮХ
Гүйцэтгэх захирал
МНБ, CGMA
БДО Аудит ХХК

## Тодорхойлолт, товчилсон үгийн тайлбар

| Товчилсон үг | Утга |
|---|---|
| БДО Монгол/Бид | БДО Аудит Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани; Улсын бүртгэлийн 2546442 регистрийн дугаартай, аудит, үнэлгээний зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж |
| Бизнес төлөвлөгөө | Удирдлагын боловсруулсан банкны ирээдүйн бизнес төлөвлөгөө |
| Богд банк /Компани/ Үйлчлүүлэгч | Богд банк Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани; Улсын бүртгэлийн 5903858 регистрийн дугаартай, зээл, төлбөр тооцоо, гадаад валютын арилжаа, хадгалах, хадгалуулах, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгж |
| ККҮЗ | Капитал хөрөнгө үнэлгээний загвар |
| Хөрөнгийн хандлага | Бизнесийн нэгжийн хөрөнгийн тохируулсан цэвэр үнэ цэнд суурилсан үнэлгээний өртгийн хандлага |
| ХМУ | Хорогдуулсан мөнгөн урсгал |
| НАХ | Ногдол ашиг хорогдуулах загвар нь прогнозын хугацааны жил бүрийн ногдол ашгийг өмчийн өртгийг ашиглан хорогдуулах замаар банкны өмчийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолдог арга |
| Илүүдэл өмчийн мөнгөн урсгалыг хорогдуулах арга | Илүүдэл өмчийн мөнгөн урсгалыг хорогдуулах арга нь илүүдэл ашгийн аргатай төстэй болович илүүдэл ашгийн оронд өмчид хамаарах нийт мөнгөн урсгалаас өмчийн өртгийг хассан дүнг хорогдуулан тооцно. |
| Хяналтгүй хувь оролцооны хөнгөлөлт | Хувьцаа эзэмшигч нь компанид хяналт хэрэгжүүлэх эрх мэдэлгүйгээс болж компанид өөрийн эзэмшиж буй хувьцаат хяналт тавих эрх мэдэлтэй хувьцаа эзэмшигчийнхтэй адил үнэар зарж чадахгүй байхад зориулсан хөнгөлөлт. |
| Гэрээ | 2021 оны 3-р сарын 2-ны өдөр БДО Монгол болон Богд банк ХХК-ийн хооронд байгуулсан бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ |
| Өмчийн үнэ цэн | Бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэн юм. |
| ӨХЧМУ загвар | Өмчид хамаарах чөлөөт мөнгөн урсгалын загвар буюу банкны өмчийн эздэд хамаарах мөнгөн урсгалыг өмчийн өртгөөр хорогдуулан тооцох замаар банкны бодит үнэ цэнийг тооцоолдог арга |
| Урьдчилан харах боломжтой ирээдүй | Үйлчлүүлэгчийн бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхээр таамагласан прогнозын хугацаа |

| Товчилсон үг | Утга |
|---|---|
| СЗХ | Санхүүгийн Зохицуулах хороо |
| ЖКАЗ | Жишиг компанийн арга зүй |
| ЖААЗ | Жишиг арилжааны арга зүй |
| КЖДӨ | Капиталын жинлэсэн дундаж өртөг |
| Орлогын хандлага | Бизнесийн нэгжийн бий болгох ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнд үндэслэдэг үнэлгээний арга |
| ҮОУС | Үнэлгээний олон улсын стандартын консулаас бэлтгэн толилуулдаг Үнэлгээний олон улсын стандарт |
| Удирдлага | Богд банк ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Саруул, банкны гүйцэтгэх удирдлагын баг |
| Зах зээлийн хандлага | Зах зээлийн өгөгдлөөс үүссэн үнэлгээний үржүүлэгч, өмнөх арилжааны харьцуулалтад үндэслэдэг үнэлгээний хандлага |
| МБХ | Монголын Банкны Холбоо |
| МХБ | Монголын Хөрөнгийн Бирж |
| Жишиг компани | Тайлангийн Хавсралт Г-д тодорхойлсон нээлттэй компаниуд |
| Петер Линчийн БҮЦ-ийн дүрэм | Peter Lynch Fair Value Rule хэмээн нэрлэгддэг энэ дүрэм нь Өсөлтийн дээд хязгаар нь Үнэ/Ашиг үржүүлэгчээр хязгаарлагдана гэсэн дүрэмд суурилан Өмчийн бодит үнэ цэнийг тооцдог хялбар дүрэм. |
| Үлдэгдэл ашиг хорогдуулах загвар | Банк, санхүүгийн байгууллага гэх мэт өөрийн хөрөнгөд минимум шаардлагатай тавигддаг салбарт илүү тохирох арга гэж үздэг. Энэ аргын танигдсан нэршил нь EVA арга юм. Энэ аргын үед хэрэглэгдэх илүүдэл ашгийг ирээдүйн жил бүрийн цэвэр ашгаас өмчийн өртгийг хасаж тодорхойлно. |
| Үнэлгээний өдөр | 2020 оны 12 дугаар сарын 31 |
| Үнэлгээний баг | Хавсралт К-д тодорхойлсон БДО Монголын үнэлгээний зөвлөх үйлчилгээний баг |
| Фврд | Форвард |

Хүүдэс 8 | Богд банк ХХК-ийн бизнесийн ба хөрөнгийн үнэлгээний тайлан



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
СЗХ 2021 11 10
БҮРТГЭВ-03

## Тайлангийн агуулга


1. Хураангуй үр дүн ..... 7
2. Үндсэн мэдээлэл ..... 11
   2.1 Захиалагч ба үйлчлүүлэгчийн мэдээлэл ..... 12
   2.2 Зориулагдсан хэрэглээ ..... 12
   2.3 Үнэлгээний даалгавар ..... 12
   2.4 Мэргэшсэн үнэлгээчид ..... 12
   2.5 Түсгай зохицуулалт ..... 12
   2.6 Үнэ цэнийн суурь ..... 13
   2.7 Үндсэн төсөөллүүд ..... 14
   2.8 Түсгай төсөөллүүд ..... 15
   2.9 УОУС-аас гажих нөхцөл ..... 15
   2.10 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал ..... 15
3. Салбарын тойм ..... 16
   3.1 Макро эдийн засаг ..... 17
   3.2 Хөрөнгийн зах зээл ..... 20
   3.3 Хөрш орнуудын банкны сектор ..... 21
   3.4 Монгол улсын банкны секторын онцлог ба өнөөгийн байдал ..... 21
   3.4 Ковид-19-ийн нөлөө ба эдийн засгийн цаашдын төлөв ..... 27
4. Бизнесийн үндсэн мэдээлэл ..... 30
   4.1 Бизнесийн үндсэн мэдээлэл ..... 31
   4.2 Орлого бий болгогч нэгж ..... 31
   4.3 Хөрөнгийн үндсэн мэдээлэл ..... 32
5. Санхүүгийн мэдээлэл ..... 34
   5.1 Түүхэн санхүүгийн байдлын тайлан ..... 35
   5.2 Түүхэн орлогын дэлгэрэнгүй тайлан ..... 36
   5.3 Үнэлгээний өдрийн болон үнэлгээний өдрийн дараагийн байдлаарх санхүүгийн үзүүлэлт ..... 37
6. Үнэлгээний шинжилгээ ..... 38
   6.1 Үнэлгээний арга хандлага ..... 39
   6.2 Санхүүгийн төсөөлөл ..... 41
   6.3 Зах зээлийн шинжилгээ ..... 44
   6.4 Хөрөнгийн үнэлгээний шинжилгээ ..... 46
7. Бизнесийн үнэлгээний үр дүн ..... 49
   Орлогын хандлага: Үлдэгдэл ашиг хорогдуулах загвар – МХБ-ийн санхүүгийн секторын бетагаар хөшүүрэгдсэн гутранги төсөөлөл 50
   Орлогын хандлага: Үлдэгдэл ашиг хорогдуулах загвар – МХБ-ийн санхүүгийн секторын бетагаар хөшүүрэгдсэн өөдрөг төсөөлөл .. 51
   Орлогын хандлага: Ногдол Ашиг Хорогдуулах Загвар – МХБ-ийн санхүүгийн секторын бетагаар хөшүүрэгдсэн гутранги төсөөлөл 52
   Орлогын хандлага: Ногдол Ашиг Хорогдуулах Загвар – МХБ-ийн санхүүгийн секторын бетагаар хөшүүрэгдсэн өөдрөг төсөөлөл .. 53
   Орлогын хандлага: Аргуудын үр дүнгийн дүгнэлт ..... 54
   Зах зээлийн хандлага: Жишиг Компанийн Арга Зүй ..... 55
   Өртгийн хандлага: Тохируулга хийсэн цэвэр өөрийн хөрөнгийн арга ..... 56
8. Хөрөнгийн үнэлгээний үр дүн ..... 57
Хавсралт ..... 59

## Тайлангийн агуулга


Хавсралт А. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл ..... 60
Хавсралт Б. Үнэлгээний нийтлэг хандлагууд ..... 61
Хавсралт В. Капиталын жигнэсэн дундаж өртөг ба өмчийн өртөг 63
Хавсралт Г. Жишиг компанийн мэдээлэл ..... 65
Хавсралт Д. Мөнгөн урсгалын төсөөлөл ..... 73
Хавсралт Е. Хорогдуулах хувийн тооцоолол ..... 75
Хавсралт Ж. Хөрөнгийн үнэлгээний дэлгэрэнгүй тооцоолол ..... 80
Хавсралт З. Мэдээллийн эх сурвалж ..... 82
Хавсралт И. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл ..... 83
Хавсралт К. Үнэлгээний баг ..... 84
Хавсралт Л. Үнэлгээчний тусгай зөвшөөрөл ..... 87




БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТӨ8960 - 5909858
5011558
ЗӨВАЙ СИ СИ ҮНЭ ХХК
214
БОГД БАНК
Сэх
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
ЕУРТЭВ-03

## Хүснэгтийн Жагсаалт


*Хүснэгт 1. Бизнесийн үнэлгээний үр дүнгийн хураангуй-IPO гаргасны дараа* ..... 7
*Хүснэгт 2. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, оны эцсийн байдлаар* ..... 17
*Хүснэгт 3. Төгрөгийн гадаад валюттай харьцах Монголбанкны нэрлэсэн, дундаж ханш* ..... 18
*Хүснэгт 4. Төгрөгийн гадаад валюттай харьцах Монголбанкны нэрлэсэн, дундаж ханшийн сүүлийн 12 жилийн статистик* ..... 18
*Хүснэгт 5. 2006 -2020 оны 12 сарын 31 болон 2021 оны 03 сарын 31-нээрх МХБ-ийн Топ-20-ын индекс, хугацааны эцсээрх жил бүрийн индексийн өсөлтийн хувь* ..... 20
*Хүснэгт 6. Банкны салбарын орлого, зардлын дундаж харьцаа* ..... 26
*Хүснэгт 7. Банкны салбарын өсөлтийн хувь* ..... 26
*Хүснэгт 8. 2018-2021 оныг хамарсан хугацааны банкны жилийн дундаж хүүгийн түвшин* ..... 29
*Хүснэгт 9. Богд банк ХХК-ийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн баримт бичиг* ..... 33
*Хүснэгт 10. Богд банк ХХК-ийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгөд хийсэн биет хэмжилтийн үр дүн* ..... 33
*Хүснэгт 11. Аудитлагдсан түүхэн санхүүгийн байдлын тайлан (мян.төг)* ..... 35
*Хүснэгт 12. Аудитлагдсан түүхэн орлогын дэлгэрэнгүй тайлан (мян.төг)* ..... 36
*Хүснэгт 13. Үнэлгээний өдрийн ойролцоо хугацааны санхүүгийн гол үзүүлэлт (сая төг)* ..... 37
*Хүснэгт 14. МХБ-ийн Санхүүгийн салбарын жишиг компанийн үржүүлэгчийн мэдээлэл* ..... 45
*Хүснэгт 15. Гадаадын жишиг нээлттэй банкны үржүүлэгчийн мэдээлэл* ..... 45
*Хүснэгт 16. Гадаад жишиг банкнуудын арилжааны үржүүлэгчийн мэдээлэл* ..... 46
*Хүснэгт 17. Харилцагчдад олгосон зээл* ..... 47
*Хүснэгт 18. Санхүүгийн хөрөнгө оруулалт* ..... 48
*Хүснэгт 19. Илүүдэл ашгийн загвараар тооцсон үнэлгээний үр дүн – МХБ-ын салбарын бетагаар хөшүүрэгдсэн гүтранги төсөөлөл* ..... 50
*Хүснэгт 20. Илүүдэл ашгийн загвараар тооцсон үнэлгээний үр дүн – МХБ-ын салбарын бетагаар хөшүүрэгдсэн Өөдрөг төсөөлөл* ..... 51
*Хүснэгт 21. НАХ загвараар тооцсон үнэлгээний үр дүн – МХБ-ын салбарын бетагаар хөшүүрэгдсэн гүтранги төсөөлөл* ..... 52
*Хүснэгт 22. НАХ загвараар тооцсон үнэлгээний үр дүн – МХБ-ын салбарын бетагаар хөшүүрэгдсэн өөдрөг төсөөлөл* ..... 53
*Хүснэгт 23. Орлогын хандлагын аргуудын үнэлгээний үр дүн* ..... 54
*Хүснэгт 24. Жишиг компанийн аргаар тооцсон үнэлгээний үр дүн* . 55
*Хүснэгт 25. Петр Линчийн Бодит Үнэ Цэнийн дүрмээр тооцсон үнэлгээний үр дүн* ..... 55
*Хүснэгт 26. Тохируулга хийсэн цэвэр өрийн хөрөнгийн аргын үнэлгээний үр дүн* ..... 56
*Хүснэгт 27. Хөрөнгийн үнэлгээний үр дүнгийн хураангуй* ..... 58
*Хүснэгт 28. Жишиг компанийн танилцуулга – Бета тооцоололд ашигласан жишиг* ..... 65
*Хүснэгт 29. Жишиг компанийн танилцуулга – Дотоод санхүүгийн байгууллагууд* ..... 68
*Хүснэгт 30. Жишиг компанийн танилцуулга – Гадаад банкнууд* ..... 69
*Хүснэгт 31. Жишиг компанийн бетагийн мэдээлэл* ..... 70
*Хүснэгт 32. МХБ-д бүртгэлтэй жишиг компанийн бетагийн мэдээлэл* ..... 71
*Хүснэгт 33. Орлогын тайлангийн төсөөлөл – Таамагласан ирэх долоон жил* ..... 73
*Хүснэгт 34. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл – Таамагласан ирэх долоон жил* ..... 73
*Хүснэгт 35. Хорогдуулах хүүгийн тооцоолол* ..... 75




БОГД БАНК ХХК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
215
СЭХ
2021 оны 10 дугаар сарын 01
ХҮРТГЭВ
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
ХҮРТГЭВ-03

## Хүснэгтийн Жагсаалт


*Хүснэгт 36. Нэрлэсэн хорогдуулах хүүг Бодит хорогдуулах хүүд хөрвүүлэлт* ..... 75
*Хүснэгт 37. Үлдэгдэл ашиг хорогдуулах загвар – Гүтранги төсөөлөл* ..... 76
*Хүснэгт 38. Үлдэгдэл ашиг хорогдуулах загвар – Өөдрөг төсөөлөл* 77
*Хүснэгт 39. Ногдол ашиг хорогдуулах загвар – Гүтранги төсөөлөл*78
*Хүснэгт 40. Ногдол ашиг хорогдуулах загвар – Өөдрөг төсөөлөл* ... 79
*Хүснэгт 41. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үр дүн (сая төгрөгөөр)* ..... 80
*Хүснэгт 42. Тээврийн хэрэгслийн үнэлгээний үр дүн (сая төгрөгөөр)* ..... 81
*Хүснэгт 43. Бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний үр дүн (сая төгрөгөөр)* ..... 81


## Зургийн жагсаалт


*Зураг 1. Олон нийтэд хувьцаагаа санал болгосны дараах төсөөллөөр Богд банкны бизнесийн өмчид хамаарах үнэлгээний үр дүнгийн дүрслэл (төгрөгөөр)* ..... 8
*Зураг 2. Орлогын хандлагын Үлдэгдэл өгөөжийн аргаар тооцоолсон 100%-ийн өмчид хамаарах үнэлгээний үр дүнгийн IPO гаргахын өмнөх ба гаргасны дараах үеийн өмчийн үнэ цэнийн интервал* ..... 9
*Зураг 3. ДНБ (их наяд төгрөгөөр)* ..... 17
*Зураг 4. Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл* ..... 19
*Зураг 5. Зах зээлд эзлэх хувийн жингээр, 2020 оны байдлаар* ..... 22
*Зураг 6. Санхүүгийн хөгжлийн индекс* ..... 22
*Зураг 7. Арилжааны банкнуудын өврийн хөрөнгө (тэрбум төгрөгөөр)* ..... 24
*Зураг 8. Арилжааны банкнуудын цэвэр ашиг (тэрбум төгрөгөөр)* . 24
*Зураг 9. Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл, чанаргүй зээл (тэрбум төгрөгөөр)* ..... 24
*Зураг 10. Чанаргүй зээлийн хувь, 2020 он* ..... 25
*Зураг 11. Өврийн хөрөнгийн харьцаа үзүүлэлт* ..... 25
*Зураг 12. Хөрвөх чадварын харьцаа* ..... 25
*Зураг 13. Банкны зээлийн хугацаа хэтрэлт* ..... 28
*Зураг 14. Хувьцаа эзэмшилтийн бүтэц* ..... 31
*Зураг 15. Түүхэн орлогын задаргаа, мянган төгрөг* ..... 31
*Зураг 16. Орлогын төсөөлөл, сая төгрөгөөр* ..... 41
*Зураг 17. Зээл ба нийт хөрөнгийн үзүүлэлт, сая төгрөгөөр* ..... 42
*Зураг 18. Үндсэн зардлуудын төсөөлөл, сая төгрөгөөр* ..... 42
*Зураг 19. Ашигт ажиллагаа (зүүн тэнхлэгт хувиар, баруун тэнхлэгт сая төгрөгөөр)* ..... 43
*Зураг 20. Дотоодын жишиг компанийн Хаёрдогч зах зээл дэх арилжааны үнэ* ..... 44





БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
Т15899 • 5903653
СЭХ
2021 -11- 03
Үнэт цаасны танилцуулга

## 1. Хураангуй үр дүн

**Богд банкны бизнес дэх өмчийн 100%-ийн хувь оролцооны тооцоолсон зах зээлийн үнэ цэнийн дүгнэлт гаргасан үндэслэл**

- Бизнесийн 100%-ийн эзэмшигчийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо бид орлогын хандлагыг авч үзсэн. Энэхүү үнэлгээнд зах зээлийн хандлагын зах зээлийн үржүүлэгчийн арга болон Орлогын хандлагын Ногдол ашиг хорогдуулах загваруудыг Үнэлгээний дүгнэлт гаргасан Илүүдэл ашгийн аргын үр дүнгийн дээд, доод интервалыг шалгах зорилгоор авч үзсэн.
- Эзэмшигчийн өмчийн 100%-ийн хувь оролцооны тооцоолсон зах зээлийн үнэ цэн нь аливаа хяналтгүйн хөнгөлөлтөөр тохируулга хийгдээгүй, хяналттай хувь оролцоонд хамаарах үнэ цэн болно.
- Банк анх үдаа хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах замаар олон нийтэд санал болгосон хувьцаанаас худалдан авсан хөрөнгө оруулагчийн эзэгээс банкны удирдлагад төлөвлөл хэрэгжүүлэх эрх мэдлийн хүчин чадлаас хамааран хяналтгүй хувь оролцоонд ногдох хөнгөлөлтийг тооцох замаар тодорхой хяналтгүй хувь оролцооны үнэ цэнийг тооцоолно. Иймхүү тооцоолсон хяналтгүй хувь оролцоонд хамаарах нэгж хувьцааны үнэ цэн нь хяналттай хувь оролцоо эзэмшигчийн нэгж хувьцааны үнэ цэнээс өөрөөр тогтоогдож болно.
- Түүнчлэн, банк хувьцаагаа олон нийтэд санал болгох арга хэлбэр, хувь хэмжээ, таниулалд зэргээс хамааран тухайн олон нийтэд санал болгож буй өмчийн хяналтгүй хувь оролцоонд ногдох хөнгөлөлтийн дүн нь 23.7% орчимд байх магадлалтай.

**Үнэлгээчний Дүгнэлт**

Үнэлгээний өдрийн байдлаар, бизнес төлөвлөгөөний зорилтыг хангасан тохиолдолд Богд Банкны 100%-ийн өмчийн тооцоолсон зах зээлийн үнэ цэн нь:

- ***IPO гаргахаас өмнөх байдлаар*** ***хяналттай хувь оролцоонд суурилсан шинжилгээгээр 138,826-166,605 сая төгрөг, хяналтгүй хувь оролцоонд суурилсан шинжилгээгээр 105,925-127,119 сая төгрөг,***
- ***IPO гаргасны дараах байдлаар*** ***хяналттай хувь оролцоонд суурилсан шинжилгээгээр 139,703-167,906 сая төгрөг, хяналтгүй хувь оролцоонд суурилсан шинжилгээгээр 106,593-128,112 сая төгрөг*** тус тус байх үндэслэлтэй байна.

*Хүснэгт 1. Бизнесийн үнэлгээний үр дүнгийн хураангуй-IPO гаргасны дараа*

| *Мөнгөн дүн нь сая төгрөгөөр* | Параметрүүд | |
|---|---|---|
| *Хорогдуулах хувь* | Гүтранги | Өөдрөг |
| Эрсдэлгүй хүүгийн түвшин | 8.50% | 8.50% |
| Өмчийн эрсдэлийн нэмэгдэл | 10.10% | 8.50% |
| Хөшүүрэггүй бета | 0.38 | 0.38 |
| Дахин хөшүүрэгдсэн бета | 1.18 | 1.18 |
| Компанийн тусгайлсан эрсдэлийн нэмэгдэл | 4.00% | 4.00% |
| **Өмчийн өртөг** | **24.4%** | **22.60%** |
| **Өмчийн бодит өртөг** | **17.5%** | **16.0%** |
| Урт хугацааны өсөлт | 5% | 5% |
| Прогнозын хугацааны жилийн дундаж өсөлт | 23x | 23x |
| Хүлээгдэж буй инфляц | 6% | 6% |
| Хяналтгүй хувь оролцооны хөнгөлөлт | 23.7% | 23.7% |
| 2020 оны жилийн цэвэр ашиг | 5,617 | 5,617 |
| 2020/12/31-нээрх өмчийн дансны үнэ | 61,309 | 61,309 |
| 2021/12/31-нээрх өмчийн дансны форвард үнэ | 101,872 | 101,872 |
| IPO-ийн өмнөх байдлаар Үнэлгээний дүгнэлт | | |
| **100%-ийн хяналтгүй хувь оролцоонд хамаарах өмчийн зах зээлийн тооцоолсон үнэ цэн** | **105,925** | **127,119** |
| **100%-ийн хяналттай хувь оролцоонд хамаарах өмчийн зах зээлийн тооцоолсон үнэ цэн** | **138,826** | **166,605** |
| IPO-ийн дараах байдлаар Үнэлгээний дүгнэлт | | |
| **100%-ийн хяналтгүй хувь оролцоонд хамаарах өмчийн зах зээлийн тооцоолсон үнэ цэн** | **106,593** | **128,112** |
| **100%-ийн хяналттай хувь оролцоонд хамаарах өмчийн зах зээлийн тооцоолсон үнэ цэн** | **139,703** | **167,906** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



Үнэт цаасны танилцуулга

## Богд банкны бизнес дэх өмчийн 100%-ийн хяналтай хувь оролцооны тооцоолсон зах зээлийн үнэ цэний дэд ба доод интервалын тайлбар

- Үнэлгээчдийн тооцоолсон үнэ цэнийн дүгнэлтийн дээд ба доод утгыг Зураг 1-д үзүүлсэн.

*Зураг 1. Олон нийтэд хувьцаагаа санал болгосны дараах төсөвлөвөр Богд банкны бизнесийн өмчид хамаарах үнэлгээний үр дүнгийн дүрслэл (төгрөгөөр)*




*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

### *Зах зээлийн хандлагын дээд ба доод хязгаар тогтоосон үндэслэл*

- Зах зээлийн хандлагын доод хязгаарыг 18.84х гэсэн Үнэ/ашиг үржүүлэгч ба Богд банкны 2020 оны жилийн цэвэр ашигт суурилан тооцоолсон. Зах зээлийн Үнэ/ашиг үржүүлэгчийг 2020 оны гүйцэтгэлээр МХБ дээр хувьцаа нь нэалттэй арилжаалагдаж буй гурван банк бүс санхүүгийн байгууллагын Үнэ/Ашиг үржүүлэгч ба Өмчийн өгөөжийн хамаарлын шинжилгээнд суурилан Богд банкны Өмчийн өгөөжид шилжүүлэн тооцоолсон. Иймд энэхүү үржүүлэгч нь үнэлгээний өдрөөрх Богд банкны онцлогийг тусган харуулсан.
- Зах зээлийн хандлагын дээд хязгаарыг 19.93х гэсэн Үнэ/ашиг үржүүлэгч ба Богд банкны 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх таамагласан цэвэр ашигт суурилан тооцоолсон. Зах зээлийн Үнэ/ашиг үржүүлэгчийг 2020 оны гүйцэтгэлээр МХБ дээр хувьцаа нь нэалттэй арилжаалагдаж буй Инвескор ББСБ ХК-ийн Үнэ/Ашиг үржүүлэгчийг ашиглан тооцоолсон. Инвескор ББСБ нь Өмчийн дүн болон цэвэр ашгийн хэмжээний хувьд Богд банктай хамгийн ойролцоо байсан учраас үржүүлэгчийн дээд хязгаарыг сонгоход тохиромжтой гэж үзсэн.

### *Орлогын хандлагын дээд ба доод хязгаар тогтоосон үндэслэл*

- Орлогын хандлагын доод хязгаарыг 17.5%-ийн өмчийн бодит өртөөр хорогдуулан тооцсон Үлдэгдэл ашгийн аргын үр дүнгээр сонгосон. 17.5%-ийн өмчийн бодит өртгийг тооцохдоо ижил хэмжээтэй гадаадын жижиг жишиг банкнуудын хөшүүрэгүй бетаг Богд банкны Өр/Өмчийн харьцаагаар тохируулан хөшүүрэгдсэн бетад суурилсан.
- Орлогын хандлагын дээд хязгаарыг 16%-ийн өмчийн бодит өртөөр хорогдуулан тооцсон нэгдэл ашгийн аргын үр дүнгээр сонгосон. 16%-ийн өмчийн бодит өртгийг МХБ дээр хувьцаа нь нэалттэй арилжаалагддаг гурван ББСБ-ын хөшүүрэгүй бетаг Богд банкны Өр/Өмчийн харьцаагаар тохируулан хөшүүрэгдсэн бетад, өмчийн эрсдэлийн нэмэгдлийг 2008-2021 онуудын МХБ-ийн ТОП-20 индексийн жил бүрийн дундажид суурилсан. Энэ үр дүнг үнэлгээний дүгнэлтэд сонгоогүй үндэслэл нь Богдбанк нэгдэл ашиг хуваарилахаар төлөвлөөгүйтэй холбоотой.

### *Үнэлгээний дүгнэлтийн дээд ба доод хязгаар тогтоосон үндэслэл*

- Дүгнэлтийн доод хязгаарыг тогтоохдоо Петр Линчийн Бодит Үнэ цэн(Peter Lynch Fair Value)-ийн аргаар тооцоолсон үнэлгээний шинжилгээ ба өөдрөг төсөөллийн үнэлгээнээс 23.7%-ийн хяналтгүйн хөнгөлөлт тооцсон үр дүнгийн аль багаар сонгосон. Петр Линчийн Бодит Үнэ цэнийн аргыг өндөр өсөлттэй, ашгийн өсөлтийн хурд нь тогтворжоогүй бизнест ашигладаг ба өсөлтийг түүхэн таван жилийн эсхүл тодорхой прогнозын хугацааны өмчийн дансны үнийн дундаж өсөлтийн шинжилгээнд суурилдаг. Бид энэ аргад ашиглах өсөлтийн хувийг 2021-2027 оны Богд банкны төсөөлсөн Өмчийн дансны үнийн CAGR болох 23% болон 2020 оны жилийн цэвэр ашигт суурилан тооцоолсон. Дэлгэрэнгүйг Хүснэгт 27-гоос дэлгэрүүлнэ үү.
- Дүгнэлтийн дээд хязгаарыг тогтоохдоо 16%-ийн өмчийн бодит өртөөр хорогдуулан тооцсон Үлдэгдэл ашгийн аргын үр дүнгээр сонгосон. 16%-ийн өмчийн бодит өртгийг МХБ дээр хувьцаа нь нэалттэй арилжаалагддаг гурван ББСБ-ын хөшүүрэгүй бетаг Богд банкны татварын дараах Өр/Өмчийн харьцаагаар тохируулан хөшүүрэгдсэн бетад суурилсан.
- Дүгнэлтийн дээд хязгаар нь хяналттай хувь оролцоонд хамаарах өмчийн 100%-ийн үнэ цэнийг төлөөлөх бол доод хязгаар нь хяналтгүй хувь оролцоонд хамаарах өмчийн 100%-ийн үнэ цэн рүү ойртоно.



БОГД БАНК ХХК
ТТБ/ДАА-5903869
УЛААНБААТАР ХОТ
BOGD BANK
БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БУРТГЭВ-03

**Үнэт цаасны зах зээлд анх удаа үнэт цаас гаргахын өмнөх ба дараах үеийн Өмчийн дээд үнэ цэний интервал**

*Зураг 2. Орлогын хандлагын Үлдэгдэл өгөөжийн аргаар тооцоолсон 100%-ийн өмчид хамаарах үнэлгээний үр дүнгийн IPO гаргахын өмнөх ба гаргасны дараах үеийн өмчийн үнэ цэнийн интервал*

| Хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргахаас өмнөх бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэн | Хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргасны дараах бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэн |
|---|---|

***Одоогийн үнэлгээний интервал-Үлдэгдэл өгөөжийн арга***

| | |
|---|---|
| 23.7%-ийн хөнгөлөлтийн дараах 100% хяналтгүй хувь оролцоо | 127,120 сая төгрөг |
| 100% хяналттай хувь оролцооны үнэ цэн | 166,605 сая төгрөг |

***Одоогийн үнэлгээний үржүүлэгч***

| | Үнэ/Дансны үнэ | Үнэ/Ашиг |
|---|---|---|
| Хяналтын бус хувь оролцооны | 2.07x | 22.63x |
| Хяналттай хувь оролцооны | 2.72x | 29.66x |

***Февраль 2021 үржүүлэгч***

| | Февр Үнэ/Дансны үнэ | Февр Үнэ/Ашиг |
|---|---|---|
| Хяналтын бус хувь оролцооны | 1.57x | 15.19x |
| Хяналтай хувь оролцооны | 2.06x | 19.91x |

***IPO-ийн дараах үнэлгээний интервал-Үлдэгдэл өгөөжийн арга***

| | |
|---|---|
| 23.7% -ийн хөнгөлөлтийн дараах 100% хяналтгүй хувь оролцоо | 128,112 сая төгрөг |
| 100% хяналттай хувь оролцооны үнэ цэн | 167,906 сая төгрөг |

***IPO-ийн дараах үнэлгээний үржүүлэгч***

| | Үнэ/Дансны үнэ | Үнэ/Ашиг |
|---|---|---|
| Хяналтын бус хувь оролцооны | 2.09x | 22.81x |
| Хяналтын хувь оролцооны | 2.74x | 29.89x |

***Февраль 2021 үржүүлэгч***

| | Февр Үнэ/Дансны үнэ | Февр Үнэ/Ашиг |
|---|---|---|
| Хяналтын бус хувь оролцооны | 1.26x | 13.71x |
| Хяналтын хувь оролцооны | 1.65x | 17.96x |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

**Цөөнх бүюу саналын эрхгүй хувь оролцоог олон нийтэд анх удаа санал болгоход зориулсан хорогдуулга бүюу хөнгөлөлт**

- Хүснэгт 1-д харуулсан үнэлгээний үр дүнгийн интервал нь банкны нийт хувьцаа эзэмшигчдэд хамаарах 100%-ийн өмчийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэнийн доод ба дээд интервалыг одрогийн буюу банкийг удирдах хяналтын эрх мэдэлтэй хувь оролцооны шинжилгээнд суурилан тодорхойлсон үнэ цэн юм. Энэхүү интервалд багтсан үр дүнг банкны нийт гаргасан хувьцааны тоонд хуваавал банканд хяналт тавих замаар үнэ цэнийг өсгөх эсхүл бууруулах эрх мэдэлтэй хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааны тооцоолсон зах зээлийн үнэ цэн гарна.

- Харин банканд хяналт тавих эрх мэдэлгүй эсхүл гаргасан аливаа шийдвэрт нөлөө үзүүлэхээргүй саналын эрхтэй хувь оролцоог эзэмшиж буй нэгж хувьцааны үнэ цэн нь хяналттай хувь оролцооны үнэ цэнээс ямагт дорогуур тогтоогддог.

- ***Бидний шинжилгээгээр, Богд банк ХХК-ийн олон нийтэд санал болгох хувьцааны үнэ цэн нь 10-30 хувийг олон нийтэд санал болгох тохиолдолд, хяналтгүй хувь оролцоо эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааны үнэ цэн нь хяналттай хувь оролцоо эзэмшигчдийн нэгж хувьцааны үнэ цэнээс 10%-24%-иар доогуур тогтоогдох магадлалтай. Иймд хяналтгүй хувь оролцооны байр сууринаас авч үзвэл банкны өмчийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэн нь доод үнэ цэн рүү ойрхон тогтоогдох ба энэ нь нээлттэй зах зээлд чөлөөтэй арилжаалагдах үнэ цэнтэй ойролцоо байх магадлалтай.***



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
УПАА-ЭБ-03
УПАА-ЭБ-03
219

**Түсад нь хөрөнгийн үнэлгээний тайлан бэлтгээгүй тухай мэдэгдэл**

- Бид банктай байгуулсан гэрээний хүрээнд, банкны бүх хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайланд тусгагдсан үнэ нь тухайн хөрөнгө, өр төлбөрийн бүлгийн бодит үнэ цэнээс материаллаг илүү эсхүл дутуу илэрхийлэгдсэн үр нөлөөгөөр нийт бизнест хамаарах үнэ цэнийг материаллаг дүнгээр илүү эсхүл дутуу илэрхийлэхэд хүргэх нөлөөтэй эсэхийг шинжилсэн.
- Харав шинжилгээний үр дүнгээр ийм үр нөлөө үзүүлэхээр материаллаг хэмжээний зөрүүтэй хөрөнгийн бүлгийн хувьд түсад нь хөрөнгийн үнэлгээний тайлан бэлтгэх үүрэг хүлээсэн.
- Гэвч бидний шинжилгээний үр дүнгээр банкны тодорхой хөрөнгө ба өр төлбөрийн бүлгүүдийн хувьд банкны бизнесээс түсдаа мөнгө бий болгогч хөрөнгө, өр төлбөрийн бүлэг байхгүй байна.
- Мөн бидний тодорхойлсон банкны бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах өмчийн хувь ароцооны тооцоолсон зах зээлийн үнэ цэнийг материаллагаар илүү эсхүл дутуу илэрхийлахад хүргэх нөлөө үзүүлэхээр хөрөнгө, өр төлбөрийн бүлэг байхгүй байна.

Иймд энэхүү бизнесийн үнэлгээний тайлангаас түсад нь хөрөнгийн үнэлгээний тайлан бэлтгэх шаардлагагүй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Банкны үнэлгээний өдрөөрх хөрөнгө, өр төлбөрийн бүлэгт хийсэн үнэлгээний шинжилгээ Эрдэнийн хандлагын Тохируулсан цэвэр хөрөнгийн аргын шинжилгээ хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Хүүдэл 10 | Богд банк ХХК-ийн бизнес, хөрөнгийн үнэлгээний тайлан

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ5393 • 5903858
220
БОГД БАНК
Сэх
2021 -11- 10
БҮРТГ
№ 1
Унэт цаасны танилцуулга -11- 03
БҮРТГЭБ-03

СЭХ
БҮРТГЭВ
№ 1
2021 11 10
-11- 03
БҮРТГЭВ-03

Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.

## 2. Үндсэн мэдээлэл

Хүндис 11 | Богд банк ХХК-ийн бизнес, хөрөнгийн үнэлгээний тайлан

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8946 ► 5903858

### 2.1 Захиалагч ба үйлчлүүлэгчийн мэдээлэл

- Богд банк ХХК нь энэхүү тайлангаар тайлагнаж буй үнэлгээний объектын тооцоолсон зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох даалгаврыг захиалсан захиалагч бөгөөд үйлчлүүлэгч мөн болно.
- Богд банк ХХК нь Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын Талбай, Бодь цамхаг, 1-р давхарт байрладаг.

### 2.2 Зориулагдсан хэрэглээ

- Энэхүү үнэлгээний тайланг Богд банкны хувьцаат анх удаа олон нийтэд санал болгох зориулалтаар хэрэглэнэ.
- Энэ зориулалтын хүрээнд дараах талууд өөр өөрсдийн шийдвэр гаргалтын зориулалтаар хэрэглэхэд зориулагдсан. Үүнд:
  - (i) Богд банкны одоогийн хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах зөвлөл, банкны удирдлагаас сонгогдсон Хөрөнгө оруулалтын компани нь олон нийтэд санал болгох хувьцааны тоо болон нэгж хувьцааны үнийн баримжаа тогтоох зорилгоор хэрэглэнэ.
  - (ii) Санхүүгийн зохицуулах хороо нь Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын шийдвэр гарах зорилгоор хэрэглэнэ.
  - (iii) Монголын Хөрөнгийн Бирж нь үнэт цаасыг олон нийтэд анх удаа худалдахыг зөвшөөрөх тухай шийдвэр гаргах зорилгоор хэрэглэнэ.
  - (iv) Ирээдүйн хөрөнгө оруулагчид түс банкнаас анх удаа санал болгож буй хувьцаанд хөрөнгө оруулах эсэх тухай шийдвэр гаргах зориулалтаар хэрэглэж болно.
- Энэхүү үнэлгээний тайланд тусгагдсан үнэлгээний тооцоолол нь Санхүүгийн тайлагналын болон аливаа зарга, маргаанд зориулсан шийдвэр гаргах зориулалтаар хэрэглэхэд зориулагдаагүй болно.

### 2.3 Үнэлгээний даалгавар

- Үйлчлүүлэгч нь өөрийн бизнесийн болон хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг харат бус байр суринаас мэргэжлийн түвшинд гаргаж тайлагнахыг биднээс хүссэн. Үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу бид үнэлгээний даалгаврыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:
  - Богд Банкны бизнесийн бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах 100%-ийн өмчийн хувь оролцооны тооцоолсон зах зээлийн үнэ цэн тодорхойлох;
  - Шаардлагатай тохиолдолд, Богд Банкны тодорхой хөрөнгийн бүлгийн тооцоолсон зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох ажил багтана.

### 2.4 Мэргэшсэн үнэлгээчид

- БДО-Аудит ХХК (бусад үлсүүдын БДО-ийн пүүсүүдээс ялган таних зорилгоор цаашид "БДО Монгол" хэмээн нэрлэнэ) нь захиалагчийн хүсэлтээр Богд Банк-ны бизнесийн үнэлгээг гүйцэтгэгч харат бус мэргэжлийн байгууллага болно. Бид өөрийн компанид ажилладаг тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн үнэлгээчид болон үнэлгээний мэргэжилтнүүдэд суурилан хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэхээс гадна үнэлгээний бүс үйлчлүүлэгчдэд аудитын болон бусад зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг, БДО олон улсын сүлжээний Монгол улс дахь гишүүн компани юм.
- Үнэлгээний багийг БДО Монгол-ын үнэлгээ хариуцсан захирал (БДО-ийн дүрмээр партнер хэмээн нэрлэдэг) ноён Г.Баянмөнх удирдан чиглүүлсэн. Үнэлгээний багийн гишүүдийн талаарх мэдээллийг Хавсралт К-аас харна уу. Энэ үнэлгээний ажилд тооцооллын болон шинжилгээний аливаа нарийн төвөгтэй нөхцөл байдал үүсэх магадлал бага гэж таамагласан учраас үнэлгээний ажилд аливаа хөндлөнгийн туслалцаа авааүй.
- Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу БДО Монгол нь энэ үнэлгээний тайланд хариуцлага хүлээх бөгөөд мэргэжлийн хариуцлагаа Номин даатгал ХХК-иар даатгуулсан. Мөн түүнчлэн манай мэргэшсэн үнэлгээчид нь өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа Номин даатгал ХХК-иар даатгуулсан болно. Даатгалын гарчилгээний хуулбарыг Хавсралт Л-ээс харна уу.
- БДО Монгол болон үнэлгээнд оролцсон үнэлгээчид, мөн үнэлгээний туслах ажилтнууд нь Богд банк-нд энэхүү үнэлгээний үйлчилгээнээс өөр үйлчилгээ үзүүлдэггүй, хувьцаа эзэмшдэггүй, үнэлгээний үр дүнд нөлөөлөх аливаа ашиг сонирхлын зөрчилгүй болно. (Үнэлгээний багийн ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг Хавсралт И-ээс үзнэ үү.)

### 2.5 Тусгай зохицуулалт

- Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтээс гаргасан Ёс зүйн дүрмийн дагуу бид өөрсдийн үнэлгээний тайланд тусгагдсан үнэ цэнийн талаарх дүгнэлтийг Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Ёс Зүйн Хороо болон бусад эрх бүхий зохицуулагч байгууллагын шаардлагаар хамгаалах эрхтэй.
- Үнэлгээний үйлчлүүлэгч болох Богд банк нь арилжааны банкны үйл ажиллагаа эрхлэх дараах тусгай зөвшөөрөлтэй:



БОГД БАНК
Улаанбаатар хот
ТТЗ8966 5903858
222
СЭХ 2021 -11- 10 өдөр ХҮРГЭВ
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
MSE-IPO-2021-0003

- Монголбанкны ерөнхийлөгчийн 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А-148 тоот тушаалаар олгогдсон (а) өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах, (б) гадаад төлбөр тооцооны нэмэлт зөвшөөрөл, (в) үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах, (г) зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл
- Монголбанкны ерөнхийлөгчийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А-337 тоот тушаалаар олгогдсон "2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн мөнгөн хадгаламж болон санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх нэмэлт зөвшөөрөл"

### 2.6 Үнэ цэнийн суурь

- Бид энэхүү тайланг бэлтгэхдээ Үнэлгээний олон улсын стандартын консул (УОУСК)-ын батлан толилуулдаг Үнэлгээний олон улсын стандарт (УОУС)-ыг даган мөрдсөн. Энэхүү үнэлгээний хүрээнд зах зээлийн үнэ цэнийн суурийг ашигласан бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно.

- Зах зээлийн үнэ цэн гэдэг нь УОУС 104-ийн 30.1-р мөрөнд тодорхойлсны дагуу *"зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хооронд хэлцэлд харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж үнэлгээний өдрөөр тооцогдсон дүн"*-г хэлнэ. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтыг дараах үзэл баримтлалын дагуу ашиглана:

  - **"Тооцогдсон дүн"** – харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийн төлөө төлөх мөнгөөр илэрхийлэгдэх үнэ юм. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу зах зээлийн үнэ цэн нь тухайн зах зээлээс үл үндэслэлтэйгээр олж авч болох, үнэлгээний өдрөөрх хамгийн их магадлалтай үнэ байдаг. Энэ нь борлуулагчийн үл үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнэ ба худалдан авагчийн үл үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн давуу талтай үнэ байна. Харин **ерөнхий санхүүжилт**, борлуулалт ба буцаан түрээслэх тохиролцоо, борлуулалттай холбоотойгоор хэн нэгнээс олгосон тусгай төлбөр, хөнгөлөлт гэх мэт тусгай нөхцөл буюу заалтаар, эсвэл эвдэхэн тодорхой нэг өмчлөгч буюу худалдан авагчид хамаарах үнэ цэнийн ямар нэг элементээр нэмэгдүүлэх буюу бууруулах байдлаар тооцоолсон үнийг энэхүү тооцоололд тусгайлан хамруулдаггүй.
  - **"Хөрөнгө, болон өр төлбөрийг арилжвал зохино"** – гэдэг нь хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэн бол урьдчилан тодорхойлсон дүн эсвэл бодит борлуулалтын үнэ биш, харин тооцоолсон дүн байх нөхцөлийг илэрхийлнэ. Энэ нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын бүх элементүүдийг үнэлгээний өдрөөр хангах үг ажил гүйлгээний үнэ байдаг.
  - **"Үнэлгээний өдрөөр"** – гэдэг нь тухайн үнэ цэн үг өдрийн байдлаар гэх мэт тусгай цаг хугацаатай байхыг шаарддаг. Зах зээл ба зах зээлийн нөхцөл байдал нь өөрчлөгдөж болох учраас үг тооцоолсон үнэ цэн нь өөр нэг хугацаанд бүрүү эсвэл тохиромжгүй байж болох юм. Үнэлгээний дүн нь өөр бусад дүрын өдрийн биш, харин үнэлгээний тэр өдрийн байдлаарх зах зээлийн төлөв байдал бэ нөхцөлүүдийг тусган илэрхийлдэг.
  - **"Бэлэн байгаа худалдан авагч"** – гэдэг нь худалдан авах сэдэл сонирхилгатай боловч тийм албан үүрэг хүлээгээгүй талыг илэрхийлнэ. Уг худалдан авагч нь ямар ч хамаагүй үнээр худалдан авахаар хэт хүссэн эсвэл худалдан авна гэж урьдчилан тодорхойлогдсон этгээдийн аль нь ч биш юм. Мөн худалдан авагч нь оршин байгаа гэдгийг батлан харуулж эсвэл урьдчилан баримжаалж чадахгүй тийм төсөөллийг буюу таамаглалын зах зээлтэй холбоотойгоор биш, харин одоогийн зах зээлийн бодит байдал болон одоогийн зах зээлийн хүлээлтийн дагуу худалдан авах этгээд байдаг. Уг төсөөлсөн худалдан авагч нь зах зээлээр шаардахаас илүү өндөр үнийг төлөхгүй. Одоогийн азаж нь "тухайн зах зээл"-ийг бүрдүүлэгчдийн нэг болдог.
  - **"Бэлэн байгаа борлуулагч"** – нь ямар ч хамаагүй үнээр борлуулахаар хэт хүссэн буюу албадлагын дагуу борлуулагч эсвэл одоогийн зах зээлийг үл үндэслэлтэйгээр харгалзан үзэхгүйгээр үнэ тогтоож буй этгээдийн аль нь ч биш юм. Бэлэн байгаа борлуулагч нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа нээлттэй зах зээлээс олж авах хамгийн сайн үнэ бүхий зах зээлийн нөхцөлөөр хөрөнгийг борлуулах садал санаачилгатай байдаг, гэхдээ уг сайн үнэ нь хэд ч байж болох юм. Бэлэн байгаа борлуулагч бол таамагласан өзэн бөгөөд жинхэнэ бодит өзний үнэн бодит нөхцөл байдал нь энэхүү хэлэлцүүлгийн хэсэг болохгүй.
  - **"Хамааралгүй талуудын ажил гүйлгээ"** нь жишээлбэл, толгой ба охин компаниуд эсвэл газрын өзэн ба хөлслөгч гэх мэт үнийг зах зээлийн шинж, агуулгагүй болгох буюу нэмэгдүүлж болох тийм тухайлсан буюу тусгай харилцан хамааралтай биш байх талуудын хооронд ажил гүйлгээ юм. Зах зээлийн үнэ цэнээр тооцогдох ажил гүйлгээ нь тус бүрдээ харааг бусаар үйл ажиллагаа явуулж бүй холбоогүй талуудын хооронд хийгдэнэ гэж урьдчилан таамагладаг.
  - **"Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа"** – гэдэг нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу үл үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнээр борлуулахад нөлөө үзүүлэхийн түлд тухайн хөрөнгийг хамгийн тохиромжтой арга замаар зах зээлд гарган танилцуулахыг хэлнэ. Борлуулагчийн хандан нөөтгэх



БОГД БАНК
Сэх
2021 -11- 03
Үнэт цаасны танилцуулга
223

зах зээлээс хамгийн сайн үнийг олж авахад борлуулалтын арга нь хамгийн тохиромжтой гэж үздэг. Зах зээлд гарган танилуулах хугацаа нь тодорхой тогтсон байдаггүй бөгөөд хөрөнгийн төрөл, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран өөр өөр байдаг. Цорын ганц шалтгаар нь зах зээлд оролцогчдын зохих тоон хэгийн анхааралд үг хөрөнгийг хандуулах боломж олгох хангалттай хугацаатай байх ёстой.

- **"Талууд түг бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй"** – гэдэг нь тухайн хөрөнгийн төрөл ба шинж чанар, түүний бодит болон боломжит ашиглалт, зах зээлийн төлөв байдлын талаар үг бүлэн байгаа худалдан авагч болон бэлэн байгаа борлуулагчийн аль алинд үнэлгээний өдрийн байдлаар үл үндэслэлтайгээр мэдээлсэн байна гэсэн үрьдчилсан нөхцөлийг илэрхийлнэ. Талууд түс бүр нь үг ажил гүйлгээ дэх өөрийн хэтийн байр суурины хувьд хамгийн тааламжтай байх үнийг олохын тулд тухайн мэдлэгийг бодол төлөвлөгөөтэйгөөр ашиглана гэж урьдчилан тооцолдог. Хожмын нөгөө өдрийн урьдчилан харах боломжгүй үр ашгийг биш, харин тухайн үнэлгээний өдрөөрх зах зээлийн байдлыг лавлагаа болгосноор "бодол төлөвлөгөө"-г үнэлдэг. Жишээлбэл, борлуулагч нь зах зээлийн үнэ буурсан үед хөрөнгийг зах зээлийн өмнөх үнээс бага үнээр борлуулах нь тааваал бодол төлөвлөөгүй байна гэсэн үг биш юм. Иймэ тохиолдолд энэ нь үнэ өөрчлөгдсөн зах зээл дэх өөр арилжааны хувьд зөв байх бөгөөд бодол төлөвлөгөөтэй худалдан авагч буюу борлуулагч нь тухайн үед багын боломжтой байгаа зах зээлийн хамгийн сайн мэдээллийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

- **"Албан шахалт шаардлагагүй"** – гэдэг нь тал түс бүр үг ажил гүйлгээг хийх сэдэл санаачилгатай боловч түүнийг гүйцэтгүүлэхээр аль ч талыг хүчлэгүй буюу хэт албадан шахаагүй байхыг илэрхийлнэ.

- Үнэлгээний тайланд ашигласан орц мэдээлэл болон эцсийн үр дүнг үнэлгээний тайлангийн түршид тусгайлан зааснаас бусад үүүлэлтийн хувьд монгол төгрөгөөр, сая төгрөгийн нарийвчлалтайгаар ашиглана. Үнэлгээний валют нь Монгол улсын үндэсний мөнгөн тамдэт болох төгрөг болно.

### 2.7 Үндсэн төсөөллүүд

- Бид дараах төсөөллүүдэд үндэслэн компанийн эмчийн 100%-ийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэнийг тооцсон бөгөөд анд дурдсан төсөөллүүд нь үнэлгээний өдрөөр оршин байгаа бодит байдалтай нийцэх буюу нийцэж болох төсөөлсөн төлөв байдлыг илэрхийлнэ. Үүнд:

- Богд Банк нь ирээдүйн урьдчилан харах боломжтой хугацаанд (тодорхойлсон прогнозын хугацаанд) өөрийн банкны бизнесээ тасралтгүй үргэлжлүүлэх үйл ажиллагааны төсөөлөл бариимтална.
- Богд Банкны тасралтгүй ажиллагаа эсвэл бизнесийн үндсэн чиглэлд ирээдүйн урьдчилан харах боломжтой хугацаанд мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй гэж төсөөлсөн.
- Мөнгөн урсгалын төсөөлөл нь Богд Банкнаас бидэнд ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг тус банкны болон арилжааны банкны салбарын түүхэн хандлагаар нормалжуулсан. Хэвийн түвшинд хүртэл нормалжуулсан бизнес төлөвлөгөөнд багтсан мэдээллийн агуулга, тооцоолол нь үнэн зөв, бодитой гэж төсөөлсөн.
- Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд багтсан аливаа тооцоолол нь бизнесийн үйл ажиллагааны хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалтад үндэслэсэн. Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд байгуулагын нөөц ашиглалтыг боломжит хамгийн дээд түвшин[1]-д тодорхойлсон бөгөөд эдгээр тооцоолол нь үдирдлагын хамгийн сайн мэдлэг, туршлага дээр үндэслэн бэлтгэгдсэн гэж төсөөлсөн. Дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд ашигласан төсөөллийг Үнэлгээний шинжилгээ хэсгээс дэлгэрүүлнэ үү.
- Банкны үйлчилгээний ертөгц материаллаг үр нөлөөтэй хөдөлмөрийн орцын өсөлт, боловсон хүчний суралт, ажил олгогчоос ажилтанд олгох нийгмийн халамжийн төлөвлөгөө байхгүй. Мөн түүнчлэн боловсон хүчний мэргэжлийн ур чадварын дутагдал, мэргэжлийн ёс зүйн доголдлоос үүсэх аливаа зарга, маргаан үүсэхгүй гэж төсөөлсөн.
- Засгийн газрын бодлого, зохицуулалтын гэнэтийн өөрчлөлт Богд Банкны бизнесийн үйл ажиллагаа (загвар) болон банкны үйл ажиллагаа эрхлэх тустай зөвшөөрөлд мэдэгдэхүйц нөлөөлөхгүй.
- Богд Банкны бизнесийн үйл ажиллагаа нь Монгол улсын татварын хуулиар зохицуулагдах бөгөөд 2020 оноос мөрдөгдсөн татварын шинэчлэгдсэн зохицуулалтаар үргэлжлэн зохицуулагдана.
- Богд Банкны санхүүгийн тайланд тусгагдсан бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас бусад тодруулагүй хөрөнгө/өр төлбөр эсвэл хэвийн бус үүрэг харилцлага, үнэлгээний өдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй шүүхийн зарга маргаан зэрэг үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөөтэй аливаа болзошгүй зүйл байхгүй.
- Банкны салбарт мэдэгдэхүйц нөлөөлөх байгалийн гамшиг, цаг үурын тааруй нөхцөл ирээдүйн урьдчилан харах боломжтой хугацааны туршид үүсэхгүй.

[1] *Энэ үнэ цэнийн урьдчилсан нөхцөл "Хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт" гэсэн нэллэгтэлт ашиглалтаар ойлгоно. Хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт гэдэг нь арилжаанд хэтийн төлөвөөс авч үзсэн, тухайн хөрөнгийн хувьд хамгийн өндөр үнэ цэнийг бий болгох ашиглалт юм.*



БОГД БАНК
БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТТЕ3966 • 5903358
224
БОГД БАНК
ҮНЭТ ЦААСЫН ТАНИЛЦУУЛГА
СЭХ
2021 -11- 03
2021 -11- 10
ҮЦТГЭБ-03

### 2.8 Түсгай төсөөллүүд

- Төсөөлсөн төлөв байдал нь үналгээний өдрөөр оршин байгаа бодит байдлаас ялгаатай байх тохиолдолд үүнийг "түсгай төсөөлөл" гэж нэрлэдэг гэж УОУС 104.200.4-д заасан. Энэ хүрээнд хамаарах түсгай төсөөлөлд банкны дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд ашигласан дараах төлөв байдлыг хамруулан ашигласан. Үүнд:
  - Бусад орлогын төсөөлөл: энэхүү орлогын суурь хөрөнгийг банкны эргэлтийн хөрөнгө болон бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нийлбэрээр сонгосон ба бусад орлого нь өнгөрсөн жилүүд болон 2020 оны гүйцэтгэлээр суурь хөрөнгийн дүнгийн 0.5%-тай тэнцүү байсан бол арилжааны банкнуудын хувьд дунджаар мөн 0.5%-тай тэнцүү байсан. Харин түс банктай ойролцоо хэмжээтэй банкны ангилалд хамаарах зарим банкны хувьд энэ хувийн жин 1.23%, салбарынхаа хувьд системийн 5 банкны ангиллын зарим банкны хувьд 0.7% байсан. Иймд банкны удирдлагын баталсан бизнес төлөвлөгөөнд суурь хөрөнгийн 0.8%-1%-ийг ашиглан тооцоолсон бусад орлогын төсөөллийг түсгай төсөөлөл гэж үзсэн.
  - Банкны хувьцааг олон нийтэд саналболгохоос өмнө хэрэгжиж дуусахаар хүлээгдэж буй банкны хувьцаанд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-иас оруулах нэмэлт хөрөнгө оруулалт нь үнэлгээний өдрийн байдлаар зохицуулагч байгууллагын зөвшөөрөл хараахан авааагүй байсан учраас түсгай төсөөлөл гэж үзсэн.
  - Үналгээний өдөр нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байсан ба энэ өдрийн дараа 2021 оны 03 дугаар сарын 31-нээрх улирлын санхүүгийн тайлан оролцогч талуудад танилцуулагдсан. Иймд үнэлгээний өдрийн дараа 2021 оны 03 дугаар сарын 31-нээр тохиолдсон тодорхой үйл явдал, ажил гүйлгээний нөлөөг үнэлгээний өдрөөрх үр дүнд тусган харуулахын тулд үнэлгээний үр дүнд суурилсан форвард үржүүлэгчид энэхүү үнэлгээний өдрийн дараагийн үр дүн нөлөөлсөн.
- Зээлийн хүүг нэг оронтой тоонд шилжүүлэх үндэсний зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд банкны зээлийн хүү буурах хүлээлттэйгээр санхүүгийн төсөөллүүдийг бэлтгэсэн. Үүнтэй холбоотойгоор эх үүсвэрийн өртөг мөн дагаж буурна гэж төсөөлснийг түсгай төсөөлөл гэж үзсэн.

### 2.9 УОУС-аас гажих нөхцөл

- Монгол улсын хөрөнгийн зах зээл дээр үнэлэгдэж буй банктай яг ижил жишиг нээлттэй банк байхгүй байсан учраас жишиг компаниар МХБ дээр хувьцаа нь нээлттэй арилжаалагддаг банк бус санхүүгийн байгууллагууд болон гадаад улсын ижил хэмжээтэй банкнуудыг сонгосон нь УОУС-д заасан жишиг компани сонгох сонголтоос бага зэрэг гажих нөхцөл үүсгэнэ.

### 2.10 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал

- Үналгээний тайлан нь Монгол болон Англи хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд Монгол хэлнээс өөр хэлээр энэ тайланг орчуулах эрх зөвхөн БДО Монгол-д байна. Бид энэхүү үнэлгээний тайланг хэвлэмэл хэлбэрээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ. Гарын үсэг зурж, тамга дарсан хэвлэмэл болон цахим тайлангууд аль аль нь адил хүчин төгөлдөр болно.
- Англи ба монгол хэл дээрх тайланд зөрүү гарсан тохиолдолд монгол хэл дээр бэлтгэгдсэн тайланг үндсэн тайлан гэж үзнэ.
- Үнэлгээний тайланг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь үналгээний зорилгоос өөр зорилгоор хувилж, эсвэл бүрэн/хэсэгчлэн иш татаж ашиглахыг хориглоно.



БОГД БАНК
ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ
СЭХ
2021-11-10
ХҮЛЭЭН АВСАН
№ 1
Үнэт цаасны танилцуулга
2021-11-03
MONGOLIAN STOCK EXCHANGE
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 5903059
225

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

## 3. Салбарын тойм



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга - 03
БУРТГЭВ-03
226

### 3.1 Макро эдийн засаг

- Үндэсний Статистикийн Хорооны цахим хуудсанд мэдээлснээр Дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2020 онд урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 37.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 322.3 (0.9%) тэрбум төгрөгөөр, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 18.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.0 (5.3%) их наяд төгрөгөөр түс түс буурлаа. [2]

- ДНБ, 2020 онд 5.3 хувиар буурсны (-2.0) пункт нь үүл уурхай, олборлолтын салбарт, (-3.0) пункт нь үйлчилгээний салбарт, тухайлбал (-1.5) пункт нь тээвэр, мэдээлэл холбооны салбарт, (-1.3) пункт нь бөөний, жижиглэн худалдааны салбарт, харин (-1.1) пункт нь бүтээгдэхүүний цэвэр татварт түс түс нөгдөж байна.

*Зураг 3. ДНБ (их наяд төгрөгөөр)*

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

- Хэрэглээний үнийн үлсын индекс 2020 оны 12 дугаар сарын байдлаар жилийн 2.3 хувь байна. Жилийн инфляцыг авч үзвэл 2.2 нэгж хувийг хүнсний барааны бүлэг, 0.2 нэгж хувийг хүнсээс бусад барааны үнийн өсөлт бүрдүүлж байна.

- Монголбанкны зүгээс 2020 оны инфляцын зорилтот түвшин 8 хувь, харин 2021 оноос дүнд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулах зорилт тавьсан.

- М2 Мөнгөний нийлүүлэлт 2020 оны 12 дугаар сарын эцэст 24.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.3 их наяд төгрөгөөр буюу 16.0%-аар өсөхөд валютын хадгаламж 33.2%, төгрөгийн хадгаламж 20.1%-аар өссөн нь нөлөөлжээ. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2020 оны 12 дугаар сарын эцэст 991.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 43.8 (4.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 94.1 (10.5%) тэрбум төгрөгөөр өсжээ.

- Төгрөгийн хадгаламж 2020 оны 12 дугаар сарын эцэст 13.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 909.4 (7.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 2.2 (20.1%) их наяд төгрөгөөр өсжээ. Валютын хадгаламж 4.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 125.9 (2.6%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оноос 1.2 (33.2%) их наяд төгрөгөөр өсжээ.

*Хүснэгт 2. Мөнгөний зорим үндсэн үзүүлэлт, оны эцсийн байдлаар*

| Тэрбум төгрөгөөр | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|
| Мөнгөний нийлүүлэлт, М2 | 15,861.2 | 19,474.8 | 20,833.8 | 24,173.9 |
| *Жилийн өөрчлөлт, %* | 30.5% | 22.8% | 7.0% | 16.0% |
| Төгрөгийн хадгаламж | 8,622.0 | 10,156.3 | 11,119.7 | 13,357.1 |
| *Жилийн өөрчлөлт, %* | 48.9% | 17.8% | 9.5% | 20.1% |
| Валютын хадгаламж | 2,531.9 | 3,019.5 | 3,483.7 | 4,641.1 |
| *Жилийн өөрчлөлт, %* | -9.2% | 19.3% | 15.4% | 33.2% |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 205.7 (1.2%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оноос 889.2 (4.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.7 (50.6%) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

- Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын эцэст 13.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 118.8 (0.9%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оноос 1.5 (9.8%) их наяд төгрөгөөр буурчээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 80.9 хувийг зээлж, өмнөх оны мөн үеэс 4.4 пунктээр буурсан байна.
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 90.0 (7.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 445.4 (54.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.4 хувийг зээлж, өмнөх оноос 2.8 пунктээр өссөн байна.

[2] *Монгол улсын нийгэм эдийн засгийн байдал 2020-1, Үндэсний Статистикийн Хороо*



БОГД БАНК BOGD BANK УЛААНБААТАР ХОТ 7758966 • 5903358
227
БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
СЭХ
БУРТГЭВ-03

- Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 12 дугаар сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 3.1 (0.2%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оноос 184.5 (10.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.7 хувийг эзэлж, өмнөх оноос 1.6 пунктээр өссөн байна.

- Иргэдэд олгосон хугацаандаа байгаа 7.9 тэрбум төгрөгийн зээлийн 9.8 хувь нь 1 жилийн, 59.9 хувь нь 1-5 хүртэлх жилийн, 30.3 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай байна.

- Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 2020 оны 12 дугаар сарын байдлаар 8.4 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 3.7 хувь байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар бууруч шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүү 8.8 хувь, хугацаагүй хадгаламжийн хүү 5.4 хувь байна.

- Шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 14.8 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 9.8 хувь болж, шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 2.1 нэгж хувиар буурсан үзүүлэлттай байна. Иргэдэд 622.1 тэрбум төгрөгийн зээл олгосноос 50.8 хувь нь 2 жил хүртэлх хугацаатай байна.

*Хүснэгт 3. Төгрөгийн гадаад валюттай харьцах Монголбанкны нэрлэсэн, дундаж ханш*

| Төгрөг | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|
| Америк доллар | 2,433.5 | 2,637.4 | 2,727.3 | 2,849.6 |
| *Жилийн өөрчлөлт, %* | -2.0% | 8.4% | 3.4% | 4.5% |
| Евро | 2,879.4 | 3,002.4 | 3,030.5 | 3,466.2 |
| *Жилийн өөрчлөлт, %* | 9.9% | 4.3% | 0.9% | 14.4% |
| Юань | 369.0 | 383.0 | 388.8 | 435.6 |
| *Жилийн өөрчлөлт, %* | 2.9% | 3.8% | 1.5% | 12.1% |
| Рубль | 41.5 | 39.2 | 43.4 | 38.4 |
| *Жилийн өөрчлөлт, %* | 3.8% | -5.7% | 10.8% | -11.4% |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

- Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш 2020 оны 12 дугаар сард 2849.55 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар суларч, өмнөх сараас 0.02 хувиар чангарсан байна.

- Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2020 оны 12 дугаар сард 435.64 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар, өмнөх сараас 1.0 хувиар, төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2020 оны 12 дугаар сард 38.42 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар чангарч, өмнөх сараас 3.8 хувиар түс тус суларсан байна.

- Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 10.4 их наяд төгрөг, үүнээс нийт танцвэржүүлсэн орлого, тусламж нь 9.4 их наяд төгрөг байна. Нийт зарлага, аргаж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 14.0 их наяд төгрөг болж, танцвэржүүлсэн нийт танцал 4.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан байна.

- Монгол Улс 2020 онд нийт 146 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум америк доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум америк доллар, импорт 5.3 тэрбум америк доллар боллоо.

- Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 876.9 (6.4%) сая америк доллар, үүнээс экспорт 43.3 (0.6%) сая америк доллароор, импорт 833.6 (13.6%) сая америк доллароор түс түс буурчээ.

*Хүснэгт 4. Төгрөгийн гадаад валюттай харьцах Монголбанкны нэрлэсэн, дундаж ханшийн сүүлийн 12 жилийн статистик*

| *Он* | *Хаалтын ханш* | *Ханш өсөлт* | *Дундаж ханш* | *Ханш өсөлт* |
|---|---|---|---|---|
| 2010 | 1,256.47 | | 1,234.08 | |
| 2011 | 1,396.37 | 11.1% | 1,265.52 | 2.5% |
| 2012 | 1,392.10 | -0.3% | 1,359.24 | 7.4% |
| 2013 | 1,659.34 | 19.2% | 2,045.61 | 50.5% |
| 2014 | 1,888.44 | 13.8% | 1,817.94 | -11.1% |
| 2015 | 1,995.51 | 5.7% | 1,970.31 | 8.4% |
| 2016 | 2,489.53 | 24.8% | 2,145.53 | 8.9% |
| 2017 | 2,427.13 | -2.5% | 2,439.78 | 13.7% |
| 2018 | 2,643.69 | 8.9% | 2,467.05 | 1.1% |
| 2019 | 2,734.33 | 3.4% | 2,663.54 | 8.0% |
| 2020 | 2,849.89 | 4.2% | 2,813.29 | 5.6% |
| 2021 оны 1-р улирал | 2,849.81 | 0.0% | 2,849.73 | 1.3% |
| **CAGR** | | **7.1%** | | **7.2%** |
| **Хэвийн дундаж** | | **2.8%** | | **5.4%** |

*Эх сурвалж: Монголбанк, БДО Монгол шинжилгээ*



БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТТЗ 9966 - 5903698
228
БОГД БАНК
СЭХ
2021 -11- 10
БУРТГЭВ
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БУРТГЭВ-03

- Хүснэгт 4-д харуулсан судалгаанаас харахад 2010 оноос 2021 3-р сарын 31-ний дүүстал хугацаанд ам долларын тогтвортэй харьцах ханш дунджаар жил бүр 7%-ийн үналттай байсан байна. Үүнээс 10%-иас давсан хэт хэлбэлзлийг хассаны дараах жил бүрийн хэвийн дундаж ханшийн үналт нь 2.8%-5.4% орчимд хэлбэлзээж байна.

*Зураг 4. Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл*

*Эх сурвалж: www.bloombergtv.mn*

- Монгол улсын эдийн засаг 2021 онд 6.1% өсөх гэж Монгол банк төсөөлж байгаа бол ОУВС 2021 оны 4 дүгээр сарын шинэчилсэн төсөөллөөрөө 5.0%, АХБ 4.8%, Дэлхийн банк 6.1%, Фитч агентлаг 6.1% өсөх гэсэн таамаглал дэвшүүлсэн талаар Блүүмберг мэдээлсэн байна.



БОГД БАНК ХХК
УПАА:БАЯТАР ХОТ
Тел/Фах: 5903858
БОГД БАНК ХХК
БОГД БАНК
229
БОГД БАНК
СЭХ
ӨМ
Бүртгэв
Үнэт Цаасны Танилцуулга
2021-11-03
БҮРТГЭВ-03
BDO

### 3.2 Хөрөнгийн зах зээл

- Үнэт цаасны арилжаагаар 2020 онд 53.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн нь өмнөх оноос 107.6 (66.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Харин 2020 оны 12 дугаар сард 14.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 99.9 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 9.6 (3 дахин их) тэрбум төгрөгөөр, арилжсан үнэт цаас 72.1 (3.6 дахин их) сая ширхэгээр тус тус өссөн байна.

- Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2020 оны 12 дугаар сард 18,126.1 нэгж болж, өмнөх сараас 584.8 нэгжээр өсөж, өмнөх оны мөн үеэс 828.8 нэгжээр буурсан бол 2020 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 17,732.0 нэгжээр өсөж, 34,635.7 нэгжид хүрсэн байна. Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2020 оны 12 дугаар сарын эцэст 3.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 429.7 (16.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 336.3 (12.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол 2020 оны 1-р улиралтай харьцуулахад 48.5 хувиар өсөж, 3.6 их наяд төгрөгт хүрсэн байна. 2021 оны 1-р улирлын хүрсэн түвшин нь 2020 оны жилийн эцсийн дотоодын нийт бүтээгдэхүүний дүнтэй харьцуулахад 10%-тай тэнцэх үзүүлэлт болж байгаа талаар Санхүүгийн Зохицуулах Хороо тайланд тэмдэглэсэн байна.

- Зэргэлдэх хүснэгтэд харуулсанчлан, 2006-2020 оныг хамарсан хугацааны жил бүрийн эцсээрх Топ-20-ын хаалтын хэлшийн жилийн дундаж үнийн өсөлтийн өгөөж 16.2%, 2006 оны 12 сарын 31-нээс 2021 оны 03 сарын 31-нийг хамарсан хугацааны эцсээрх үе бүрийн дундажид суурилсан жилийн үнийн өсөлт(CAGR)-ийн өгөөж 19.4% байна.

- Мөн зэргэлдэх хүснэгтэд харуулсанчлан, ТОП-20 индексийн 2007 оныг 2006 оноой харьцуулсан гипер өсөлтийг хассаны дараах 2008-2021 онуудын жилийн дундаж индексийн өсөлтийн өгөөж 17% байна.

- Испанийн IESE Бизнесийн сургуулийн санхүүгийн проф. Павло Фернандез 2021 оны долоохийн 88 оронд ашиглагдсан Зах зээлийн эрсдэлийн шагнал ба эрсдэлгүй хүүгийн түвшин судалгаа хийсэн тайлангаа 2021 оны 6-р сарын 7-нд нийтлүүлжээ. Энэ судалгаанд Монгол улсын Зах зээлийн төгрөгийн эрсдэлийн шагналыг 10.1%, Эрсдэлгүй төгрөгийн хүүгийн дундаж хувийг 8.5%[3] байсан гэж тусгасан байсан нь бидний дээрх судалгаатай нийцтэй байна.

*Хүснэгт 5. 2006 -2020 оны 12 сарын 31 болон 2021 оны 03 сарын 31-нээрх МХБ-ийн Топ-20-ын индекс, хугацааны эцсээрх жил бүрийн индексийн өсөлтийн хувь*

| он | Хаалтын индекс | Жилийн өсөлт |
|---|---|---|
| 2006 | 2,030.81 | |
| 2007 | 10,256.13 | 405% |
| 2008 | 5,583.22 | -46% |
| 2009 | 6,189.91 | 11% |
| 2010 | 14,759.81 | 138% |
| 2011 | 21,687.57 | 47% |
| 2012 | 17,714.51 | -18% |
| 2013 | 16,301.81 | -8% |
| 2014 | 14,854.24 | -9% |
| 2015 | 12,897.59 | -13% |
| 2016 | 12,456.06 | -3% |
| 2017 | 20,736.93 | 66% |
| 2018 | 21,466.76 | 4% |
| 2019 | 19,621.86 | -9% |
| 2020 | 19,285.80 | -2% |
| 2021.03 | 34,635.65 | 80% |
| CAGR 2006-2020 | | 16.2% |
| CAGR 2006-2021 | | 19.4% |
| 15 жилийн дундаж өсөлт | | 12.2% |
| 16 жилийн дундаж өсөлт | | 42.9% |
| 2008-2021 онуудын дундаж | | 17.0% |

*Эх сурвалж: Монголбанк, БДО Монгол шинжилгээ*

[3] *Survey: Market Risk Premium and Risk-Free Rate used for 88 countries in 2021, Pablo Fernandez. Professor of Finance. IESE Business School, fernandezpa@iese.edu*



БОГД БАНК ХХК УЛААНБААТАР ХОТ Т/Д 8966 • 5903858
БОГД БАНК ХХК
230
БОГД БАНК
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА 03
БУРТГЭВ-03
MONGOLIAN STOCK EXCHANGE

### 3.3 Хөрш орнуудын банкны сектор

**ОХУ-ын банкны сектор**

- ОХУ-ын банкны систем нь 2 шатлалтай бүтэцтэй бөгөөд 1988 онд анхны арилжааны банкнууд үүссэн байна. ОХУ-ын банкны салбарт Сбербанк, ВТБ банк, Газпромбанкууд нийт активын хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байна.
- Оросын Төв банкны 2020 оны тайланд дурдсанаар банкнуудын нийт активын ДНБ-д харьцуулсан харьцаа 90 орчим хувьтай байна. Мөн банкны секторын нийт актив 2020 онд өмнөх оноос 12.5%-аар өссөн байна. Банкны секторын цэвэр ашиг 2020 онд өмнөх оноос 6.2%-аар буурсан үзүүлэлттэй байна.
- ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам 2020 онд Оросын эдийн засаг 3,9%-иар буурах ч гэлээ 2021 онд 3,3%, 2022 онд 3%, 2022 онд 4% түс түс өсөн гэсэн тооцоо хийсэн байна. Мөн ОХУ-ын Төв банк жижиг, дунд бизнесүүдэд хүүгүй, Засгийн газрын батлан даалттай зээл олгохыг дэмжсэн байна.

**БНХАУ-ын банкны сектор**

- 1978 оноос өмнө Хятад улсад зөвхөн нэг төлөлцөөт банкны систем үйлчилж Хятадын Ардын Банк дангаараа Төв болон арилжааны банкны үүргийг хамтад нь гүйцэтгэдэг байсан. Тухайн үед Хятад улсын нийт санхүүгийн 93% нь түс банкны мэдэлд байсан.
- Банкны салбарын шинэчлэл хийх анхны алхам бол томоохон арилжааны банкнуудыг байгуулах явдал байсан. Нэг шатлалт банкны системээс эхлэлтэй энэхүү шинэчлэл нь 1984 онд 2 шатлалт системийг бий болгож, улмаар санхүүгийн олон төрлийн үйлчилгээний үр дүнд санхүүгийн байгууллагыг төрөлжүүлсэн төдийгүй гүйцэтгэлийн үзүүлэлтийн тоог ч нэмэгдүүлж чадсан.
- 2003 онд Хятад улс дэлхийн худалдаанд байгууллагад нэгдэж санхүүгийн салбараа тэлэхийн тулд банкны салбарт суурь шинэчлэл хийсэн.
- Банкнуудыг нэлттэй хувьцаат компани болгож үр ашгийг сайжруулахын тулд Засгийн газраас дараах арга хэмжээг авсан байна. Үүнд: хөрөнгө босгох, санхүүжилт босгохын тулд бага эрэмбэтэй бонд гаргахыг хуваан зөвшөөрөх, чанаргүй зээлийг Хөрөнгийн Удирдлагын Корпорацаар дамжуулан шилжүүлэх, гадаадын стратегийн хөрөнгө оруулагч нарыг оруулж ирэх явдал байсан.
- 1980 оныг хүртэл дэлхийн банкны секторт АНУ-ын банкнууд дангаараа тэргүүлж дэлхийн банкны чиг хандлага болон хөгжлийг тодорхойлж байсан бол сүүлийн жилүүдэд Хятадын банкнууд тэргүүлэх болсон байна.
- 2020 оны байдлаар Хятадын 4 том банк болох Industrial Commerical bank of China, China construction bank, Agricultural bank of China, Bank of China банкнууд нийт хөрөнгийн хэмжээгээр дэлхийн банкны салбарыг тэргүүлж байна.

**Монгол улсын банкны секторын онцлог ба өнөөгийн байдал**

- Монгол Улсад 2020 оны жилийн эцсийн байдлаар 1 хөгжлийн банк, 12 арилжааны банк, 532 ББСБ, 254 хадгаламж зээлийн хоршоо, 16 даатгалын компани, 53 үнэт цаасны компани үйл ажиллагаа явуулж нийт санхүүгийн салбарын 93 орчим хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байна.
- 2020 оны байдлаар нийт 12 арилжааны банк үйл ажиллагаагаа явуулж байгаагаас төрийн өмчийн /Төрийн банк/ нэг банк байна. Эдгээр банкны 1400 гаруй салбар, нэгжээр дамжуулан Монгол Улсын бүх аймаг, хот, сум, сүүрин газруудад үйлчилж байгаа бөгөөд тэдгээрт 16 мянга гаруй ажиллагсад ажиллаж манай улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд банкны үйлчилгээг хүргэж байна.
- Монгол Улсын санхүүгийн зах зээлд 2008 оноос эхлэн гадаадын банк төлөөлөгчийн газраа байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар түүгай шалгууруыг хангасан олон улсад нэр хүнд бүхий 5 гадаадын банкны төлөөлөгчийн газар үйл ажиллагаа эрхэлж байна. Арилжааны банкнуудын хувьцааны дийлэнх хувийг цөөн тооны хөрөнгө оруулагчид эзэмшиж байна.
- Банкны салбарын санхүүгийн зах зээлд эзлэх хувь нь харьцангуй өндөр (2019 оны эхний хагасын байдлаар 90 орчим хувь) бөгөөд үүнээс шалтгаалан иргэд болон хувийн салбар санхүүжилтийн хэрэгцээгээ банкны зээлээр голлон бүрдүүлж байна.
- 2020 оны байдлаар банкны салбарт нийт 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор банкны системд нөлөө бүхий банкнуудад Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Төрийн банк гэсэн 5 банк багтаж байна. Эдгээр банкнууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж байна.

- Банкнуудыг нийт активын хэмжээгээр нь харьцуулж үзвэл нийт зах зээлийн 33%-ийг ХААН банк, 22%-ийг Хүдалдаа хөгжлийн банк, 20%-ийг Голомт банк, 9%-ийг Төрийн банк, 9%-ийг Хас банк, үлдсэн хувийг бусад банкнууд эзэлж байна.

*Зураг 5. Зах зээлд эзлэх хувийн жингээр, 2020 оны байдлаар*




*Эх сурвалж: МБХ*

- Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоолсноор Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжил нь тухайн бүс нутаг дахь ойролцоо түвшний улс орнуудтай харьцуулахад харьцангуй сайн байна гэж дүгнэсэн байна.

*Зураг 6. Санхүүгийн хөгжлийн индекс*

*Эх сурвалж: ОУВС, Дэлхийн эдийн засгийн форумын санхүүгийн хөгжлийн индекс (2017), Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоолол*

**Хүүль, эрхзүйн орчин**

- Монгол Улсын банкны салбар нь Төв банк болон арилжааны банк гэсэн шатлалтай бөгөөд 1990 онд "Аж ахуйн банк байгуулах болох түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм", 1991 онд "Банкны хууль" батлагдсанаар Монгол улсын 2 шатлалт банкны тогтолцооны хөрс суурь тавигджээ.

- Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь Монгол Улсын Төв Банк буюу Монгол банк юм. Төв банк нь төрөөс үүсгэн байгуулсан ашгийн төлөө бус хуулийн этгээд бөгөөд үйл ажиллагаа нь "Төв банк /Монголбанк/-ны тухай хуулиар зохицуулагддаг.

- Арилжааны банк нь ашгийн төлөө санхүүгийн байгууллага бөгөөд үйл ажиллагаа нь "Банкны тухай" хуулиар зохицуулагддаг.

- Банкны салбарын үйл ажиллагааг зохицуулахад "Төв банк /Монголбанк/-ны тухай, "Банкны тухай", Эрдэнэсийн сангийн тухай, "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай", "Зээлийн мэдээллийн тухай", "Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай", "Банк, арх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай", "Валютын зохицуулалтын тухай" зэрэг хууль, тогтоомж, заавар журмууд үйлчилж байна.



БОГД БАНК
BOGD BANK
Улаанбаатар хот
ТТБ3966 № 5903658
Богд банк ХХК
232
БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БУРТГЭВ-03

- УИХ-аас 2021 оны 1 дүгээр сарын 29-нд "Банкны тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд дараах хэд хэдэн томоохон өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:
  - Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байна.
  - "Банкны системд нөлөө бүхий банк" гэж банкны хөрөнгө, ер төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал зэрэг шалгүүрыг нэгэн зэрэг баримтлан банкны тогтолцоонд нөлөөтэй гэж Монголбанкнаас тогтоосон банкийг хэлнэ.
  - Банкны системд нөлөө бүхий банк нэмэлтэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат компанийн хэлбэртэй байна.
  - Банк үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш нэг жилийн хугацаанд банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид зээл олгохыг хориглоно.
  - Банк үүсгэн байгуулах, банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах, банкны хувьцааг эзэмшихэд зөвшөөрөл олгох, банкны хувьцаа эзэмших хязгаарлалтыг тооцох, тогтоох харилцаг энэ хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Монголбанкны журмаар зохицуулна.

- Монголбанк доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь бүрдсэн тохиолдолд банк төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болох гарцаагүй нөхцөл байдал үүссэнд тооцно. Үүнд:
  - Банк хадгаламж эзэмшигч, харилцагч, бусад үүртийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болсон, эсхүл гаргаж өгөх боломжгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон;
  - Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүйгээс цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;
  - Банкны пассив нь активаасаа хэтэрсэн, эсхүл ердийн боломжит хугацаанд хэтрэх нь хяналт шалгалтаар тогтоогдсон.

- Банкны төлөөлөн удирдах зөвлөл ес ба түүнээс дээш гишүүнтэй байна. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

- Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний хангалтын өөрчлөлт, банкны төлбөрийн чадвар, банкны систем дэх нөлөө, эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Монголбанк тогтооно гэсэн байна.

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А-276 тоот тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс 100.0 (зуун) тэрбум төгрөг болгож тогтоох шийдвэрийг гаргасан.

- Монголбанкнаас 2020-2023 онд хэрэгжүүлэх "Банкны салбарыг чадавхжуулах дунд хугацааны хөтөлбөр"-ийг боловсруулан батлуулсан байна. Уг хөтөлбөрт 4 үндсэн зорилт тусгагдсан бөгөөд "Банк, санхүүгийн салбарын хууль эрхзүйн шинэтгэл, Банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, Хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг Базелийн стандарттай нийцүүлэн сайжруулах" зэрэг ажлуудыг хийхээр тусгасан байна.

**Монгол улсын банкны салбарын өнөөгийн байдал**

- Монголбанкны зүгээс Ковид-19-ийн иргэд, бизнесүүдэд үзүүлж буй хүндрэлийг зөөллөх үүднээс дунд хугацааны тогтвортой байдалд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ингэхдээ бодлогын хүүг 2020 оны 3 ба 4-р сард нийт 2 нэгж хувиар бууруулж, төв банкны хүүгийн коридорыг 1 нэгж хувиар нарийсгасан. Үргэлжлүүлэн цар тахлын нөлөөгөөр бодлогын хүүг 9 болон 11-р сард тус тус дахин бууруулсан. Мөн эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчдийн хэрэглээний зээлийн хугацааг 12 сараар, ипотекийн зээлийн хугацааг 6 сараар сунгах шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

- Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлд Төв банк инфляцыг 2021-2023 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулах зорилтыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

- Ковид-19 цар тахлын нөлөөнд өртсөн зээлүүдийн 53.7%-ийг том аж ахуйн нэгжүүдийн, 36.9 %-ийг иргэдийн, 8.4%-ийг жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн зээл тус тус бүрдүүлсэн байна.

- Банкны салбарын нийт актив 2020 оны байдлаар 34,310.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 941.8 тэрбум төгрөгөөр бүтэн 3 хувиар өссөн байна. Банкнуудын өөрийн хөрөнгө 2020 оны байдлаар 3,754.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2 хувиар өссөн.



БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТТӨ8966-5903958
БОГД БАНК
BOGD BANK
233
БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

*Зураг 7. Арилжааны банкнуудын өөрийн хөрөнгө (тэрбум төгрөгөөр)*

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Банкны салбарын ашиг 2020 оны байдлаар 247.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3 хувиар бууран байна. Уг дүнд ХААН, Худалдаа Хөгжлийн болон Голомт банкны ашгийн бүрэлт голлон нөлөөлсөн байна. Харин тайлант онд Үндэсний хөрөнгө оруулалтын болон Хас банкны цэвэр ашиг ихээхэн өссөн үзүүлэлттэй байна.

*Зураг 8. Арилжааны банкнуудын цэвэр ашиг (тэрбум төгрөгөөр)*




*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Нийт дотоодын зээлийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2020 оны байдлаар 16,418.9 тэрбум төгрөг болж өссөн. Чанаргүй зээлийн хэмжээ мөн өсөж 1,682.4 тэрбум төгрөг бүюу 17 орчим хувиар өссөн бөгөөд энэ нь нийт зээлийн 10 орчим хувийг зээлж байна.

*Зураг 9. Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл, чанаргүй зээл (тэрбум төгрөгөөр)*




*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамнаас хамтран гаргасан "Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан 2020"-д дурдсанаар Ковид-19 цар тахлаас шалтгаалан зээл олголт болон эргэн төлөлтүүд тасалдан хойшлогдох, Ковид-19-т өртсөн зарим зээлдэгчийн хувьд цаашид, үйл ажиллагаа явуулах боломжгүй болох бүюу эрсдэлийн сангийн зардлыг нэмэгдүүлэх зэрэг хувилбаруудаар банкны системд стресс тестийн шинжилгээ хийхэд үр дүнд нь банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт алдагдахаргүй байна. Банкнуудын ашиг ажиллагаа бүурч, алдагдалтай ажиллах, зээл олголт багасаж, санхүүгийн салбар болон бодит сектор хоорондын харилцан уялдаа бүурч, улмаар эдийн засгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дүн гарсан байна.

- 2020 оны байдлаар банкны зээлийн 100 төгрөг тутмын 60 төгрөг нь хэвийн, 40 төгрөг нь асуудалтай бүлэг хугацаа, хэтэрсэн, чанаргүй, цар тахлын нөлөөтэй байна. [4]

*Зураг 10. Чанаргүй зээлийн хувь, 2020 он*




Системийн хэмжээнд:

- 17.2 их наяд ₮ зээл байна.
- 2 их наяд ₮ чанаргүй зээл
- 1.3 их наяд ₮ хугацаа хэтэрсэн зээл
- 3.7 их наяд ₮ цар тахлын нөлөөнд өртсөн.

*Эх сурвалж: Монголын Банкны Холбоо*

- Ашигт ажиллагааны үзүүлэлт болох активын өгөөж 6 дугаар сарын байдлаар -0.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 пунктаар буурчээ. Тайлант хугацаанд сангийн зардал өссөн нь ашигт ажиллагаа огцом буурахад нөлөөлсөн байна.
- Банкны салбарын арсдэл даах чадварыг харуулдаг үзүүлэлтийг авч үзэхэд 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 15.6 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгүүр үзүүлэлтээс 3.6 нэгж хувиар өндөр байна.
- Системийн нөлөө бүхий банкнуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт 2019 оныхтой харьцуулахад ялимгүй өссөн үзүүлэлттэй байна.[5] Банкнууд өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлтийг ханган ажиллаж байна.

*Зураг 11. Өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлт*

*Эх сурвалж: Монголын Банкны Холбоо*

- Системийн нөлөө бүхий таван банк нь хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийг мөн ханган ажиллаж байна.[6] Төрийн банкны хөрвөх чадварын харьцаа ялимгүй буурсан бол зээлийн алдагдал буурсантай холбоотойгоор бүх банкнуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

*Зураг 12. Хөрвөх чадварын харьцаа*




*Эх сурвалж: Монголын Банкны Холбоо*

[4] *Монголын Банкны Холбоо, 2020 оны 4-р улирлын тойлан*

[5] *Монголын Банкны Холбоо, 2020 оны 4-р улирлын тойлан*

[6] *Монголын Банкны Холбоо, 2020 оны 4-р улирлын тойлан*



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
ҮЦТГЭБ-03

- Мүүдис агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг **"B3"** хэвээр үлдээж, төлөвийг **"сөрөг"** байснаас **"Тогтвортой"** болгож сайжруулснаа 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр зарлалаа. Түс байгууллагын дүгнэлтээр Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал Ковид-19 цар тахлын нөлөөгөөр буурч байсан ч тогтворжиж эхэлсэн гэж үзсэн байна.

*Хүснэгт 6. Банкны салбарын орлого, зардлын дундаж харьцаа*

| Цэвэр хүүгийн түвшин | 2019 | 2020 |
|---|---|---|
| Хүүгийн орлого/Эргэлтийн активын харьцаа | 11.3% | 10.2% |
| *Хүүгийн зардал/Татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн харьцаа* | 8.2% | 7.2% |
| **Цэвэр зөрүү** | **3.1%** | **3.0%** |
| **Бусад орлого ба ерөнхий удирдлагын зардлын түвшин** | **2019** | **2020** |
| *Бусад орлого/эргэлтийн хөрөнгө болон татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нийлбэрийн дундаж харьцаа* | 0.49% | 0.51% |
| *Ер.үй-ын зардал/эргэлтийн хөрөнгө болон татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нийлбэрийн дундаж харьцаа* | *1.27%* | *1.21%* |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Дээрх Хүснэгтэд үзүүлсэн Банкны салбарын орлого, зардлын дундаж харьцааны шинжилгээг Монгол улсын системийн таван банк болон Капитрок, Кредит, Тээвэр хөгжил, Богд банкнуудын сүүлийн гурван жилийн санхүүгийн үзүүлэлтийн дунджид суурилан хийсэн. Судалгаанд ашигласан эргэлтийн активт мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалт, зээлийн цэвэр үлдэгдлийг, татан төвлөрүүлсэн эх үүсвэрт харилцагчийн харилцах, хадгаламж болон бусад банк санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн үлдэгдлийг тус тус багтаасан ба харьцааг гаргахдаа эргэлтийн актив, пассивын жилийн дундажид суурилсан.

- Судалгаанаас харахад банкнууд эргэлтийн активаас жил бүр дунджаар 10-11%-ийн өгөөж хүртэж байгаа бол бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэртээ 7-8%-ийн хүү төлж, актив пассивын өгөөжийн зөрүүнээс ойролцоогоор 3%-ийн цэвэр өгөөж хүртэж байна

- Банкнууд ашиглаж байгаа эргэлтийн актив болон пассиваас хүртэж байгаа шимтгэлийн болон арилжааны өгөөж нь дунджаар 0.5%-ийн нэмэлт өгөөж хүртэж байна. Энэ үзүүлэлт ХААН банкны хувьд 2019 онд 0.79%, 2020 онд 0.74% байгаа нь системдээ хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Харин Богд банкны хувьд 2020 онд 0.59% байгаа нь системдээ хоёр дахь өндөр хувь хэмжээ болж байна.

- Судалгаанд хамрагдсан 9 арилжааны банкны жилийн нийт орлого нь 2018 онд 3,113.7 тэрбум төгрөг байсан бол 2019 онд 3,603.8 тэрбум төгрөг, 2020 онд 3,619.1 тэрбум төгрөгт хүрчээ. Эндээс харахад банкны салбарын олж буй нийт орлого 2019 онд 2018 онтой харьцуулахад 15.7%-иар өссөн бол 2020 онд 2019 онтой харьцуулахад өмнөх жилийн өсөлтөөс саарч 0.4%-ийн өсөлт үзүүлсэн нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр тайлбарлагдаж байна.

- Арилжааны банкнуудын нийт орлогын бүтцэд хүүгийн орлогын эзлэх хувийн жин 2019 онд өмнөх оноос 0.7%-иар, 2020 онд өмнөх оноос 1.1%-иар буурч, бусад орлого мөн хэмжээгээр нэмэгдэж шилжжээ. Энэ нь зээлийн хүү буурууллах хөтөлбөрийн нөлөө болон цахим шилжилтийн нөлөөгөөр тайлбарлагдаж байна. Бусад орлогоос хамгийн өндөр өгөөжийг ХААН банк хүртэж байна.

- Үйл ажиллагааны зардлыг эргэлтийн актив, пассивын нийлбэрт харьцуулсан харьцаа дунджаар 2019 онд 1.27%, 2020 онд 1.21% байгаа нь актив, пассивын хэмжээ нэмэгдэх тусам үйл ажиллагааны зардлын суурь хөрөнгөд эзлэх хувийн жин буурах хандлагатай байгааг харуулж байна.

*Хүснэгт 7. Банкны салбарын өсөлтийн хувь*

| Өсөлтийн хувь | 2019 | 2020 |
|---|---|---|
| Хүүгийн орлого | 14.9% | -0.8% |
| Бусад орлого | 26.7% | 14.5% |
| Хүүгийн зардал | 15.2% | -1.8% |
| Үйл ажиллагааны зардал | 18.0% | 5.3% |
| Цэвэр ашиг | 9.1% | -13.5% |
| Эргэлтийн актив | 10.3% | 10.5% |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгө | 11.9% | 11.1% |
| Эздийн өмч | 1.2% | 19.6% |
| Нийт хөрөнгө | 11.1% | 8.2% |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Дээрх Хүснэгтэд судалгаанд хамрагдсан 9 арилжааны банкны нийлбэрт суурилсан холбогдох орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн сүүлийн 2 жилийн өсөлтийн хувийг харуулсан.

- 9 арилжааны банкны нийлбэраар 2020 онд банкнуудын өөрийн хөрөнгө 20%-ийн өсөлттэй байна.

- Эхдээс харахад 2020 онд хөрөнгө, өр төлбөр, эх үүсвэрийн өсөлт хэвийн байхад арилжааны банкны салбарын орлого, зардлын өсөлтийн хурд саарсан нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр харилцах дансны үлдэгдэлд хүү төлөхийг зогсоосон, бодлогын хүүг үе шаттайгаар бууруулсан зэрэг Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөө банкны салбарт нөлөөлснийг харуулж байна.

- Түүнчлэн арилжааны банкнүүдын гол өсөлтийг бүсад орлогын өсөлт зэрэгцэж байгаа дүр зураг харагдаж байгаа нь арилжааны банкнуудад технологийн нөлөө болон хөрөнгө оруулалтын орлого нэмэгдэж байгаа нь нөлөөлсөн байх магадлалтайг харуулж байна.

### 3.4 Ковид-19-ийн нөлөө ба эдийн засгийн цаашдын төлөв

- Дэлхийн эдийн засаг 2021 онд 4 хувиар төлөх боломжтой бөгөөд вакцинжуулалт болон хөрөнгө оруулалт эдийн засгийн сэргэлтэд чухал үүрэгтэй хэмээн 2021 оны 1-р сард гаргасан "Дэлхийн эдийн засгийн төлөв" тайландаа Дэлхийн Банк онцолжээ.[7]

- Харин 2022 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 3.8 хувь болж саарахаар байгаа нь цар тахлын эдийн засагт нөлөөлөх урт хугацааны сөрөг үр дагаврүүдтэй холбоотой байна.

- Дэлхийн эдийн засаг 2020 онд 4.3 хувиар агшиж, цаашид эргэн сэргэх төлөвтэй байгаа ч цар тахлын нөлөөгөөр өмнөлөл, нас баралт үлэмж хэмжээгээр нэмэгдсэнээс гадна сая сая хүн ядууралд өртөж, эдийн засгийн идэвхжил, орлогын сэргэлт багагүй хугацаа шаардахаар байна. Иймд Ковид-19 цар тахлын тархалтыг бүрэн хяналтад авах, вакцины өргөн хүрээнд шуурхай нэвтрүүлэх нь богино хугацаанд бодлогын нэн тэргүүний чиглэлд тооцогдож байна. Мөн эдийн засгийн сэргэлтийг бодитойгоор дэмжихийн тулд засгийн газрын ерийг нэмэгдүүлэхийг урьтал болголгүй, харин хөрөнгө оруулалтын өгөөжийг дахин өргөлтэд оруулах тааламжтай хөшүүргийг бий болгох замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад анхаарах шаардлагатай хэмээн дүгнэжээ.

- АНУ-ын ДНБ 2020 онд 3.6 хувиар агшаад байсан бол 2021 онд 3.5 хувиар өсөх, еврогийн бүсийн үйлдвэрлэл 2020 онд 7.4 хувиар буураад байсан бол ана онд 3.6 хувиар өсөн хэмээн үзжээ. 2020 онд 5.3 хувиар агшаад байсан Японы улсын эдийн засаг ч мөн 2021 онд 2.5 хувиар төлөх төсөөллийг дэвшүүлсэн байна.
- Хөгжиж буй орнууд (БНХАУ-ыг оруулснаар)-ын эдийн засаг 2020 онд 2.6 хувиар агшсан бол 2021 онд 5 хувиар өсөн хэмээн үзжээ. Өнгөрөгч онд 2 хувийн өсөлттэй байсан БНХАУ-ын эдийн засаг ана онд 7.9 хувийн өсөлттэй байх төсөөллийг боловсруулсан байна. Харин БНХАУ-аас бусад хөгжиж буй орнуудын хувьд эдийн засаг нь 2020 онд 5 хувиар агшсан бол 2021 онд 3.4 хувиар өсөх төсөөлөлтэй байна. Бага орлоготой эдийн засгуудын хувьд 2020 онд 0.9 хувиар агшсан бол 2021 онд 3.3 хувиар төлөх хэмээн үзсэн байна.
- Азийн Хөгжлийн Банкнаас (АХБ) нийтлэн гаргадаг Азийн Хөгжлийн Цаашдын Төлөв – 2020 судалгааны хүрээнд Монгол улсын эдийн засгийн ирээдүйн өсөлтийг 2020 оны 6 сарын байдлаар таамаглахдаа 2020 онд 1.9 хувийн уналттай, 2021 онд 4.7 хувийн өсөлттэй байна гэж таамаглаж байсан бол 2020 оны 9-р сард шинэчлэгдсэн төсөөллөөр 2020 онд 2 хувийн уналттай, 2021 онд 5.1 хувийн өсөлттэй байна гэж шинэчлэн таамагласан байна.[8]

- Ковид-19-ийн үед болон цар тахлын дараах үеүдэд санхүүгийн үйлчилгээний салбарын үүрэг оролцоо асар их байна. Санхүүгийн үйлчилгээний салбарын тэсвэр хатуужил, түүний тасралтгүй үйл ажиллагаа нь улс орнуудын засгийн газар болон бизнесүүдэд ихээхэн тусламж дэмжлэг болох нь гарцаагүй. Финтек болон дижитал хэлбэрт шилжих нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд зайлшгүй шаардлага болоод байгаа тул кибер хандлагаас урьдчилан сэргийлэх ажуулгүй байдлыг хангаж ажиллах дээр анхаарах шаардлагатай.

- Дэлхий нийтээр төв банкнууд бодлогын хүүгээ түүхэн бага түвшинд хүргэж замаар мөнгө зээлийн дэмжлэгийг идэвхжүүлж, нэлттэй зэхэн үйл ажиллагаа эрхлэх замаар нөөц нийлүүлж банкны системийн дарамтыг бууруулахаар ажиллаж байна.

- Хөгжиж буй орнуудын төв банкнууд бодлогын хүүг бууруулах арга хэмжээг авч эхэлсэн бөгөөд эдгээр арга хэмжээ нь итгэлийг сэргээх замаар системд үүссэн сөрөг шокийг хязгаарлахад зэргээ нөлөөлж байгаа билээ. Үүний сацуу хад хэдэн төв банк своп хэлцлийн үндсэн дээр зээлийн сувгийн механизмуудыг ашиглан ам.долларын нөөц нийлүүлж байна.

- Төв банкнууд 2008-2009 оны арга хэмжээг, тухайлбал компанийн бонд зэрэг эрсдэлтэй активыг худалдаж авах арга хэмжээг авав. Төв банкнууд ийнхүү "эцсийн худалдан авагч"-ийн үүрэг гүйцэтгэснээр ерөнхий аж ахуй, компаниудын хувьд зээлийн олдцыг хэвийн байлгахыг зорьж байгаа билээ.

- Төв банкнууд зээллэг, активын худалдан авалтаар дамжуулан 6 их наяд ам.долларын нөөц нийлүүлэхээ мэдэгдэж байгаа нь хөрөнгө оруулагчдын итгэлцэлд эерэгээр нөлөөлж байна. Ингэснээр зарим зах дээр үүссэн хүндрэлүүд байдал намжиж, эрсдэлтэй активуудын үнэ тогтворжих хандлага ажиглагдаж буй хэдий ч зах зээлд

[7] *World Economic Outlook, Jan 2021*

[8] *Asian Development Outlook Supplement, Sep 2020*

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 ★ 5993458

238

БОГД БАНК
СЭХ
2021 -11- 03

Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03

нэхэхэн хэмжээний тодорхойгүй байдал хадгалагдсаар байгаа тедийгүй санхүүгийн эрсдэлийн захын нөхцөл байдал 2020 оны эхэн үетэй харьцуулахад чангарлаа.

- Цар тахал хүчээ авснаас хойш эрсдэлтэй активын үнэ 2008-2009 онтой харьцуулахад 50 гаруй хувиар унажээ. Хөрөнгийн биржүүд дээр үнийн бууралт доод цэгтээ хүрч, 30 ба түүнээс илүү хувиар унасан байна. Зээлийн спредүүд ялангуяа зээлжих зэрэглэл доогуур компанидын хувьд огцом нэмэгдэв. Түүнчлэн богино хугацаат санхүүжилтийн томоохон эзэмшигчид, үүний дотор ам.долларын эрэлт хэндрэл, бэрхшээл ажиглагдаж, үүссэн савлагаа нь үнэ огцом өсөхөд нөлөөлж байна. Хүү маш бага түвшинд байгаа нь цаашид эмзэг байдлыг нэмэгдүүлж байгаа ба үүнтэй зэрэгцэн санхүүгийн захын нөхцөл байдал үргэлжлэн чангарч эдийн засгийн уналт гүнзгий тедийгүй, удаан хугацаанд үргэлжлэх эрсдэлийг дагуулж байна.
- Далхийн санхүүгийн зах хямралд өртөхөд юуны түрүүнд хөгжиж буй орнуудаас хөрөнгө гадагшлах зүй тогтол энэ удаа ч ажиглагдаж ДНБ-ий 0.4 хувьтай тэнцэх буюу 100 орчим тэрбум ам.долларын багцын хөрөнгө оруулалт гадагшилсан нь түүнээ байгаагүй өндөр үзүүлэлт болсон байна.
- Мөн өөрийн хөрөнгийн нөөцийн шаардлагыг сулруулах, хуримтлагдсан нөөц хөрөнгийг чөлөөлөх зэрэг макро зохистой бодлогын арга хэмжээг түгээмэл авч хэрэгжүүлж байна.
- Зарим улс орнууд хувьцаа эзэмшигчдэд тараах ногдол ашгийг хязгаарлаж, ирээдүйд учирч болзошгүй алдагдлыг шингээхэд шаардлагатай нөөц хөрөнгийг бүрдүүлэх чиглэлийг эрх бүхий бэйгуүллагуудын зүгээс банк, санхүүгийн байгуүллагуудад өгсөн байна.
- Мөн зээлийн аргэн төлөлтөө хийх боломжгүй болсон зээлдэгчдийн зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй, хэвээр хадгалах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.
- Банкнуудад тавигдах хөрвөх чадварын болон зээвэл байлгах нөөцийн шаардлагыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Мөн зарим оронд банк, санхүүгийн байгуүллагуудад хязгаарлагдмал нөөц хөрөнгөө зээл олгох, хүндрэлд орсон зээлдэгчдийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулах боломжийг олгох зэрэгцэн комплаенсын зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

*Зураг 13. Банкны зээлийн хугацаа хэтрэлт*



*Эх сурвалж: Монголын Банкны Холбоо*

- Монгол улсын хувьд 2020 оны байдлаар 1.3 их наяд төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн багцын 79 хувь нь бизнесийн хугацаа хэтэрсэн зээл байна. 2020 оны 7-р сараас эхлэн эдийн засаг идэвхжсэнтэй холбоотой иргэдийн зээлийн хугацаа хэтрэлт буурч байсан боловч 11 сараас эхлэн огцом өссөн байна. [9]
- Бодлогын хүүгийн нөлөө 2021 онд зээлийн жигнэсэн дундаж хүүг 1-2 пунктээр бүүлгах нөлөө үзүүлсэн. 2021 оны 7-р сард зээлийн ангилал хуучин хэвээндээ ороход санхүүгийн салбарт зээлийн эрсдэл үүсэхээр хүлээгдэж байна.
- 2021 оны 03 сарын 31-ний байдлаар 17,636.4 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагийн 14,333.2 тэрбум төгрөг (81%) нь хэвийн зээл, 1,282.5 тэрбум төгрөг (7%) нь хугацаа хэтэрсэн зээл, 2,020.7 тэрбум төгрөг (11%)нь чанаргүй зээл байна.

[9] *Монголын Банкны Холбоо, 2020 оны 4-р улирлын тайлан*

*Хүснэгт 8. 2018-2021 оны хамарсан хугацааны банкны жилийн дундаж хүүгийн түвшин*

| | 2018 | 2019 | 2020 | 2021 Q1 |
|---|---|---|---|---|
| Төгрөгийн харилцах дансны жинлэсэн дундаж хүү | 3.08% | 3.28% | 3.02% | 0.00% |
| Валютын харилцах дансны жинлэсэн дундаж хүү | 1.54% | 1.54% | 1.16% | 0.00% |
| Төв банкны үнэт цаасны жинлэсэн дундаж хүү | 10.33% | 11.02% | 8.99% | 6.00% |
| Банк хоорондын зах хын жинлэсэн дундаж хүү | 10.26% | 11.08% | 8.84% | 6.20% |
| Зээлийн сар бүрийн үлдэгдэлд жинлэсэн төгрөгийн зээлийн дундаж хүүгийн жилийн дундаж | 17.71% | 17.00% | 16.93% | 16.41% |
| Зээлийн сар бүрийн үлдэгдэлд жинлэсэн валютын зээлийн дундаж хүүгийн жилийн дундаж | 10.82% | 10.63% | 10.40% | 10.04% |
| Активын дундаж хүү | 12.28% | 12.43% | 11.29% | 9.66% |
| Эх үүсвэрийн дундаж хүү | 10.26% | 11.08% | 8.84% | 6.20% |
| Харилцах дансны дундаж хүү | 2.31% | 2.41% | 2.09% | 0.00% |

*Эх сурвалж: Монголбанк, БДО Монгол шинжилгээ*

- Монгол банкнаас сар бүр гаргадаг статистик мэдээнээс тооцоолсон жилийн дундаж хүүгийн түвшин Хүснэгт 6-д харуулав. Хүснэгтээс харахад, 2020 оны 6-р сараас эхлэн харилцагчийн төгрөгийн болон валютын харилцах дансны үлдэгдэлд арилжааны банкнууд хүү төлөхийг зогсоосон байна.
- Түүнчлэн Монголбанкны бодлогын хүүг үе шаттайгаар бууруулсны нөлөөгөөр бүх хүүгийн түвшин буурсан хандлагатай байна.
- 2021 оны 1-р улирлын байдлаар активын дундаж хүү 9.7% байгаа бол харилцахаас бусад эх үүсвэрийн дундаж хүү 6.2%, хүүгийн зөрүү 3.5% орчимд байна.



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
239

СЭХ
2021 оны 11 дэвр
БҮРТГЭВ

-11- 03
БҮРТГЭВ-03



## 4. Бизнесийн үндсэн мэдээлэл



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТЬ5366 а 5903858

### 4.1 Бизнесийн үндсэн мэдээлэл

- "Богд банк" ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд зээл, төлбөр тооцооны үйлчилгээ, гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах, гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа архлах, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах, эвхэн гадаад зах зээлээс эх үүсвэр татах нехцөлтэйгөөр монгон хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлүүдийг авсан.
- Компани нь хоёр хувьцаа эзэмшигчтэй бөгөөд Бодь капитал ХХК хувьцааны 91.32%-ийг эзэмшиж, үлдсэн 8.68%-ийг Богд капитал инвестмент ХХК эзэмшиж байна.

*Зураг 14. Хувьцаа эзэмшилтийн бүтэц*




*Эх сурвалж: Үйлчлүүлэгчийн компанийн дүрэм*

### 4.2 Орлого бий болгогч нэгж

- Богд банкны бизнесийн үндсэн сегмент нь хэрэглээний, бизнесийн болон орон сууцны зээлийн үйл ажиллагаа юм. 2019 оноос эхлэн бүтээгдэхүүний багцад цахим зээлийг шинээр нэвтрүүлснээр финтех түлгуурласан зээлийн болон бусад үйлчилгээг түлхүү үзүүлж эхэлсэн. BogdMobile апп нь хүссэн газраасаа харилцагчаар бүртгүүлж банкны бүтээгдэхүүн үйлчилгээг цогцоор нь авах боломжийг бүрдүүлсэн.

*Зураг 15. Түүхэн орлогын задаргаа, мянган төгрөг*

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



БОГД БАНК ХҮРГЭВ
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
ХҮРГЭВ-03
241

### 4.3 Хөрөнгийн үндсэн мэдээлэл

- Бид Богд банк ХХК-ийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл болон бусад үндсэн хөрөнгөд холбогдох шинжилгээ, биет үзлэгийг хийн хөрөнгийн үнэ цэнийг тооцоолсон. Хөрөнгийн мэдээллийг биет үзлэгийн тэмдэглэлийн хамт доор харууллаа.

*Биет үзлэгийн тэмдэглэл*

- Биет үзлэгийн явцад үйлчлүүлэгчээс бидэнд ирүүлсэн хөрөнгийн жагсаалт болон өнгөрсөн жилийн аудитын тайланд тусгагдсан мэдээ, мэдээлэл, газар дээрх үзлэг, хэмжилтэд үндэслэн доорх биет хөрөнгүүдэд үзлэг хийсэн. Үүнд:

  - Барилга:
    - Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хүүлийн гудамж, 4/2-р байр А блок хаягт байрлах контор, үйлчилгээний зориулалттай, 1060 м2 талбайтай, 590720 дугаартай гэрчилгээтэй, Y-2203015748 тоот үлсын бүртгэлийн дугаартай, 2017 оны 12 дугаар сарын 27-нд Богд банк ХХК-д олгогдсон үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээтэй;
  - Тээврийн хэрэгсэл:
    - 00-54 УНМ улсын дугаартай, 2017 онд үйлдвэрлэсэн LEXUS-570 маркийн суудлын автомашин,
    - 00-71 УБС улсын дугаартай, 2014 онд үйлдвэрлэсэн MAYBACH S600 маркийн суудлын автомашин,
    - 87-08 УБЯ улсын дугаартай, 1961 онд үйлдвэрлэсэн, ГАЗ-13 Чайка маркийн суудлын автомашин,
    - 64-25 УББ улсын дугаартай, 2013 онд үйлдвэрлэсэн, ALPHARD маркийн суудлын автомашин,
    - 30-71 УБЕ улсын дугаартай, 2013 онд үйлдвэрлэсэн, CAMRY маркийн суудлын автомашин,
    - 60-46 УНО улсын дугаартай, 2010 онд үйлдвэрлэсэн, TOYOTA PRIUS-30 маркийн суудлын автомашин,
    - 60-43 УНР улсын дугаартай, 2011 онд үйлдвэрлэсэн, TOYOTA PRIUS-30 маркийн суудлын автомашин,
    - 11-83 УНЗ улсын дугаартай, 2010 онд үйлдвэрлэсэн, SONATA-7 маркийн суудлын автомашин
  - Конторын зориулалттай тоног төхөөрөмж, тооцоолох техник, тавилга эд хогшил
- Үзлэгийн явцад Богд банк ХХК-ийг төлөөлсөн төлөөлөгч хамт байлцсан.

### Үнэлгээний зүйлийн өмчлөх эрхийн мэдээлэл

*Хүснэгт 9. Богд банк ХХК-ийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн баримт бичиг*

| Объектын хаяг, нэр | ҮХХ-ийн өмчлөгчийн нэр, Регистрийн дугаар | ҮХХ-ийн гэрчилгээний дугаар | Эрхийн үлсын бүртгэлд бүртгэгдсэн огноо, дугаар | | Гэрчилгээгээр талбайн хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, 4/2-р байр, А блок хаягт байрлах контор, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө | Богд банк ХХК Регистрийн дугаар: 5903858 | У-2203015748 | 590720 | 2017/12/27 | 1,060 м.кв |

### Үл хөдлөх хөрөнгийн хэмжилт

*Хүснэгт 10. Богд банк ХХК-ийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгөд хийсэн биет хэмжилтийн үр дүн*

| *Объектын хаяг, нэр* | *Ашиглалтад орсон он* | *Гэрчилгээгээрх талбайн хэмжээ /м2/* | *Суурь* | *Хана* | *Хучилт* | Хаалга, Цонх | *Барилгын цэвэр талбайн хэмжээ /м2/* |
|---|---|---|---|---|---|---|---|
| Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, 4/2-р байр А блок хаягт байрлах контор, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 2008 | 1,060.00 | Цутгамал төмөр бетон | Угсармал төмөр бетон | Цутгамал бетон | Вакум | 1,140.70 |
| **Нийт** | | **1,060.00** | | | | | **1,140.70** |



БОГД БАНК
2021 -11- 10 өдөр
СЭХ
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
243

## 5. Санхүүгийн мэдээлэл

## 5.1 Түүхэн санхүүгийн байдлын тайлан

*Хүснэгт 11. Аудитлагдсан[1] түүхэн санхүүгийн байдлын тайлан (мян.төг)*

| Дүнгийн эхлэлээр | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Бэлэн мөнгө бөгөөд Монголбанк дахь харилцах | 7,441,602 | 99,684,347 | 53,556,309 |
| Банк болон бусад санхүүгийн байгууллагууд дахь харилцах, хадгаламж | 17,006,309 | 30,976,830 | 37,529,715 |
| Бусдаар худалдан авах нөхцөлтэй үнэт цаас | 19,993,576 | | |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 71,930,892 | 24,412,306 | 20,089,647 |
| Дериватив | 5,951 | | |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 53,501,467 | 83,707,974 | 101,262,996 |
| Бусад хөрөнгө | 4,374,101 | 7,904,183 | 3,126,470 |
| Үндсэн хөрөнгө | 1,899,605 | 2,394,691 | 2,326,444 |
| Хөрөнгө оруулалтын зорилгоотой УХХ | 3,852,421 | 3,753,641 | 3,550,107 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 0 | 2,693,246 | 2,269,534 |
| Биет бус хөрөнгө | 989,098 | 804,106 | 807,055 |
| Борлуулах зорилгоотой УХХ | | | 344,090 |
| ***Нийт хөрөнгө*** | **180,964,422** | **251,331,414** | **224,901,367** |
| **Өрийн өмч ба өр төлбөр** | | | |
| **Өр төлбөр** | | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 38,827,592 | 94,740,800 | 100,674,527 |
| Банкнаас байршуулсан харилцах, хадгаламж | 31,106,221 | 89,623,237 | 27,048,795 |
| Бусдаар худалдах нөхцөлтэй хөрөнгө | 22,986,145 | | 25,048,873 |
| Бусад эх үүсвэр | 29,748,968 | 9,263,050 | 7,464,732 |
| Батлагаа | 3,484,013 | | |
| Бусад өр төлбөр | 4,610,247 | 3,231,718 | 3,368,889 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | | | |
| Дериватив | | 5,653 | |
| ***Нийт өр төлбөр*** | **129,063,176** | **196,864,458** | **163,600,816** |
| **Өөрийн өмч** | | | |
| Хувьцаат капитал | 50,000,000 | 50,000,000 | 50,000,000 |
| Хуримтлагдсан ашиг | 1,901,246 | 4,466,961 | 11,300,551 |
| ***Өөрийн өмчийн дүн*** | **51,901,246** | **54,466,961** | **61,300,551** |
| ***Нийт өөрийн өмч ба өр төлбөр*** | **180,964,422** | **251,331,414** | **224,901,367** |

*Эх сурвалж: Богд банкны аудитлагдсан санхүүгийн тайлан*

- Бид үйлчлүүлэгчийн бэлтгэсэн түүхэн санхүүгийн байдлын тайланд шинжилгээ хийж, дараах зүйлсийг илрүүлсэн. Үүнд:
  - 2020 оны санхүүгийн байдлын тайланд тусгагдсан 91,085,024 мянган төгрөгийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд 2,220,704 мянган төгрөгийн касс дахь бэлэн мөнгө, 51,334,605 мянган төгрөгийн банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө, 37,529,715 мянган төгрөгийн банк, бусад санхүүгийн байгууллагууд дахь харилцах, хадгаламж багтана.
  - 2020 оны санхүүгийн байдлын тайланд толилуулагдсан 101,262,996 мянган төгрөгийн харилцагчдад олгосон нийт зээлийн дансанд дахь зээлийн 92,905,738 мянган төгрөг нь хэвийн, 1,880,175 мянган төгрөг нь хугацаа хэтэрсэн, 1,675,566 мянган төгрөг нь хэвийн бус, 283,546 мянган төгрөг нь эргэлзээтэй, 1,888,486 мянган төгрөг нь муу зээлийн ангилалд байна. Харилцагчдад олгосон зээлийн үлдэгдэл нийт хөрөнгийн 45 хувийг эзэлж байна.
  - 2020 оны түүхэн санхүүгийн байдлын тайланд тусгагдсан 25,048,873 мянган төгрөгийн бүцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаасны 14,992,608 мянган төгрөгийн үнэт цаас нь Хөгжлийн банкны, үлдсэн нь Монголбанкны үнэт цаас байна.
  - 2020 оны байдлаар харилцагчдын харилцах, хадгаламжийн дансанд дахь үлдэгдэл 100,674,527 мянган төгрөг байгаагаас Засгийн Газрын хадгаламж 23,776,846 мянган төгрөг, байгууллагын хадгаламж 31,845,429 мянган төгрөг, иргадийн хадгаламж 45,052,252 мянган төгрөг байна.
  - Нийт хөрөнгийн 17 хувийг эзэмшигчдийн өмч, 45 хувийг харилцагчдын харилцах, хадгаламжийн үлдэгдэл тус тус эзэлж байна.
  - Богд банкны нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11 хувиар буурсан бол өөрийн хөрөнгө нь 2019 онд өмнөх оноос 5%-иар, 2020 онд 13%-иар өссөн байна.

[1] *2018 оны санхүүгийн үзүүлэлтийг KPMG, 2019 ба 2020 оны санхүүгийн үзүүлэлтийг ЕҮ баталгаажуулсан аудитын тайлангаас ашигласан.*



БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 – 5903359
245
БОГД БАНК
БОГД БАНК ХХК
СЗХ
2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр
БҮРТГЭВ
№ 01
Үнэт цаасны танилцуулга - 11- 03
БҮРТГЭВ-03

## 5.2 Түүхэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*Хүснэгт 12. Аудитлагдсан түүхэн орлогын дэлгэрэнгүй тайлан (мян.төг)*

| Үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 | өсөлт |
|---|---|---|---|---|
| **Хүүгийн орлого** | **18,132,377** | **21,054,710** | **24,497,420** | **16%** |
| Монголбанкинд байршуулсан хөрөнгийн | 159,762 | 386,237 | 414,893 | 7% |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн | 7,185,496 | 2,069,803 | 2,238,341 | 8% |
| Үнэт цаасны | 3,061,044 | 5,734,923 | 5,255,516 | -8% |
| Зээлийн | 4,696,075 | 12,863,747 | 16,588,680 | 29% |
| **Хүүгийн бус орлого** | **4,542,689** | **1,589,157** | **2,990,810** | **88%** |
| Арилжааны орлого | 3,420,279 | 425,800 | 916,006 | 115% |
| Хураамж, шимтгэлийн орлого | 626,070 | 1,071,574 | 1,583,908 | 48% |
| Бусад хүүгийн бус орлого | 496,340 | 91,783 | 480,896 | 424% |
| **Нийт орлого** | **14,675,066** | **22,643,867** | **27,488,230** | **21%** |
| **Хүүгийн зардал** | **4,119,502** | **11,056,797** | **11,885,143** | **7%** |
| Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүү | 4,027,013 | 3,511,933 | 2,344,164 | -33% |
| Харилцагчид төлсөн хүү | 26,360 | 3,889,627 | 6,166,917 | 59% |
| Бондоор хөрөнгөдөн оруулсан | 58,928 | 3,142,531 | 2,706,446 | -14% |
| Бусад эх үүсвэрийн | 7,201 | 149,071 | 272,997 | 83% |
| Бусад хүүгийн зардал | - | 363,640 | 394,619 | 9% |
| **Хүүгийн бус зардал** | **7,977,405** | **7,428,157** | **8,585,674** | **16%** |
| Арилжааны зардал | 3,211,969 | 128,087 | 394,630 | 208% |
| Хураамж, шимтгэлийн зардал | 292,231 | 368,063 | 401,875 | 9% |
| Үйл ажиллагааны бусад зардал | 4,473,205 | 6,932,007 | 7,789,169 | 12% |
| **Нийт зардал** | **12,096,907** | **18,484,954** | **20,470,817** | **11%** |
| **Үйл ажиллагааны ашиг** | **2,578,159** | **4,158,913** | **7,017,413** | **69%** |
| Болзошгүй эрсдэлийн сан | **293,332** | 1,271,862 | 806,397 | -37% |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг** | **2,284,827** | **2,887,051** | **6,211,016** | **115%** |
| Үндсэн бус зардал | 15,610 | | | |
| **Татварын өмнөх ашиг** | **2,269,217** | **2,887,051** | **6,211,016** | **115%** |
| Орлогын татвар | 81,895 | 317,000 | 593,687 | 87% |
| **Цэвэр ашиг** | **2,187,322** | **2,570,051** | **5,617,329** | **119%** |

*Эх сурвалж: Богд банкны аудит хийгдсэн санхүүгийн тайлан*

- Бид үйлчлүүлэгчийн түүхэн орлогын дэлгэрэнгүй тайланд шинжилгээ хийж, дараах зүйлсийг илрүүлсэн. Үүнд:
  - 2020 онд нийт 24,497,420 мянган төгрөгийн хүү болон түүнтэй адилтгах орлого хэрэгжсэн нь өмнөх оноос 16 хувиар өссөн байна. Нийт орлогын 89 хувь нь хүүгийн орлого, үлдсэн хувь нь хүүгийн бус орлого байна. 2020 онд хүүгийн бус орлого 2,990,810 мянгад хүрсэн нь ариллжааны орлого, үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого, бусад хүүгийн бус орлогын өсөлтөөс бий болсон байна.
  - 2020 онд бизнесийн хавийн үйл ажиллагааны зардал өмнөх онтой харьцуулахад 11%-иар өсөж 20,470,817 мянган төгрөг болсон. Энэ нь үйл ажиллагаа өргөжин тэлсэнтэй холбоотой нэмэгдсэн зардлууд байна.
  - Нийт зардлын өсөлтөд хүүгийн зардал 7 хувь, хүүгийн бус зардал 16 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. 2020 онд хүүгийн зардалд 11,885,143 мянган төгрөг төлсөн нь өмнөх оны дүнгээс 7 хувиар өссөн байна.
  - 2019 ба 2020 онуудад үр ашигт татварын хувь тогтмол 9% орчим байна.
  - Нийт борлуулалт өмнөх онтой харьцуулахад 2019 онд 54 хувь, 2020 онд 21 хувиар өссөн байна.
  - Цэвэр ашгийн үзүүлэлт өмнөх онтой харьцуулахад 2019 онд 17 хувь, 2020 онд 119 хувиар өссөн байна.



БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
246
БОГД БАНК
ЕНӨТ ҮЦК
СЭХ
2021 -11- 03
Үнэт цаасны танилцуулга

### 5.3 Үнэлгээний өдрийн болон үнэлгээний өдрийн дараагийн байдлаарх санхүүгийн үзүүлэлт

*Хүснэгт 13. Үнэлгээний өдрийн ойролцоо хугацаны санхүүгийн гол үзүүлэлт (сая төг)*

| Санхүүгийн суурь үзүүлэлтүүд | Аудит хийгдсэн | Аудит хийгдээгүй |
|---|---|---|
| сая төгрөгөөр | 12/31/2020 | 3/31/2021* |
| Өмчийн дүн | 61,301 | 66,909 |
| Харилцагчийн харилцах, хадгаламж, дансны өглөгөөс бусад хүүтэй өр | 59,562 | 62,775 |
| **Нийт капитал** | **120,863** | **129,684** |
| *Өр/Капитал* | *49.3%* | *48.4%* |
| *Өмч/Капитал* | *50.7%* | *51.6%* |
| *Өр/Өмч* | *97.2%* | *93.8%* |
| Сүүлийн 12 сарын хугацааны: | | |
| Хүүгийн орлого | 24,497 | 24,442 |
| Хүүгийн зардал | 11,885 | 11,611 |
| **Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]** | **12,612** | **12,831** |
| Эрсдэлийн сангийн зардал | 806 | 529 |
| **Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]** | **11,806** | **12,302** |
| Бусад орлого | 2,194 | 5,757 |
| Бусад зардал | 7,789 | 7,182 |
| **Татварын өмнөх ашиг, алдагдал [(5+6-7)]** | **6,211** | **10,877** |
| Орлогын татварын зардал | 594 | 1,819 |
| **Татварын дараах ашиг, алдагдал [(8-9)]** | **5,617** | **9,058** |
| *Татварын хувь* | *9.6%* | *16.7%* |
| ХТӨА буюу EBIT | 10,629 | 15,170 |
| Татварын дараах өрийн хүүгийн зардлын өмнөх ашиг буюу NOPAT | 10,035 | 13,351 |
| Өмчийн өгөөж буюу RoE | 9.2% | 13.5% |
| Капиталын өгөөж буюу ROCE | 8.3% | 10.3% |

**Аудитлагдаагүй санхүүгийн мэдээлэл*

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Бид үйлчлүүлэгчийн үнэлгээний өдрийн байдлаарх санхүүгийн мэдээлэлд шинжилгээ хийж дараах зүйлсийг онцолсон. Үүнд:

  - Үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгч нь 61,301 сая төгрөгийн эзэмшигчийн өмчтэй, харин үнэлгээнд ашигласан форвард өмчийн дүн нь 2021 оны 03 сарын 31-ний өдрөөрх 66,909 сая төгрөгийн дансны үнэ бүхий өмчийн дүн дээр АСН-ээс оруулахаар хүлээгдэж буй 11,400 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын нийлбэрээс бүрдэж байсан.

  - Харин харилцагчийн харилцах, хадгаламж, дансны өглөгөөс бусад хүүтэй өрийн нийт хэмжээ үнэлгээний өдрийн байдлаар 59,562 сая төгрөг, 2021 оны 03 сарын 31-ний байдлаар 62,775 сая төгрөг байна. Үйлчлүүлэгчийн нийт капиталын хэмжээ үнэлгээний өдрийн байдлаар 120,863 сая төгрөг, 2021 оны 03 сарын 31-ээр 129,684 сая төгрөг байна.

  - Ингэснээр өр ба нийт капиталын харьцаа 48.4%, өмч ба нийт капиталын харьцаа 51.6%, өр ба өмчийн харьцаа 93.8% байна. Энэ нь 2020 оны сүүлийн үзүүлэлтээс бага зэрэг доогуур үзүүлэлт юм.

  - 2021 оны 03 сарын 31-ээрх сүүлийн 12 сарын хүүгийн цэвэр орлогын дүн 12,831 сая төгрөг, татварын дараах ашгийн хэмжээ 9,058 сая төгрөг буюу өмнөх оны үзүүлэлтээс 61% өссөн үзүүлэлттэй байна.

  - Үнэлгээний өдрийн дараагийн хугацааны санхүүгийн мэдээлэл нь аудитлагдаагүй санхүүгийн тайланд суурилсан болохыг анхаарна уу.



БОГД БАНК
СЭЗХ
2021 -04- 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-03
247

## 6. Үнэлгээний шинжилгээ



БОГД БАНК
ИПОТЕК МОРЗ
Он 2021 оны 11 сарын 09-ний өдөр №01
Сэх
Унэт цаасны танилцуулга
БОГД БАНК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8964 5903358
248

### 6.1 Үнэлгээний арга хандлага

- Бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнийг үнэлэхдээ бид дараах зүйлсийг нэгтгэн авч үзсэн. Үүнд:
  - Банкны үйл ажиллагааг хамарсан бизнесийн зах зээлийн үнэ цэн.
- Богд банкны үндсэн бизнесийн чиглэл нь арилжааны банкны үйл ажиллагаа бөгөөд энэ бизнесийн чиглэлээс өөр аливаа үйл ажиллагаа, түүнээс бий болсон материаллаг орлого түүнтэй тайлант хугацаанд үүсээгүй болно.
- Богд банкны бизнесийг үнэлэхдээ бид дараах төсөөлөлд үндэслэн орлогын хандлагаас Өмчид хамаарах чөлөөт мөнгөн урсгалын арга, Илүүдэл өгөөжийн арга болон Ногдол ашиг хорогдуулах загвар, зах зээлийн хандлагаас жишиг компанийн арга зүйг сонгон ашигласан. Бизнес ба бизнесийн хувь оролцооны үнэлгээнд ашигладаг нийтлэг хандлагуудын хураангуй тайлбарыг Хавсралт Б-ээс дэлгэрүүлэн үз.
  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь УОУС 105 *Үнэлгээний хандлагууд ба аргууд*, догол мөр 40.2 буюу 40.3-ын шалгүүрыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд орлогын хандлагыг тогтмол хэрэглэдэг. Мөн түүнчлэн, компани нь урьдчилан харах боломжтой ирээдүйд бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх төсөөлөл баримталдаг. Иймээс тасралтгүй хугацаанд үг бизнесийн бий болгож чадах эдийн засгийн өгөөж буюу мөнгөн урсгалд үндэслэн ХМУ-ний загвар ажиллах боломжтой.
  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь УОУС 105 *Үнэлгээний хандлагууд ба аргууд*, догол мөр 20.2 буюу 20.3-ын шалгүүрыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд зах зээлийн хандлагыг ихэвчлэн ашигладаг. Зах зээлийн хандлага нь бизнесийн хувьд хамгийн бодитой, үл үндэслэлтэй үнэ цэнийн дүгнэлт гаргах боломж олгодог. Учир нь энэ аргын үед бизнесийн үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа, ижил буюу жиших боломжтой бизнесийн орц мэдээлэлд үндэслэдэг. Банкны секторын уламжлалт эрсдэлээс (зохицуулалтын нөлөө, системийн эрсдэл) шалтгаалан дан ганц ХМУ загвар ашиглан үнэ цэн тооцох нь хангалттүй бөгөөд хураалцаагүй гэж бид үзсэн. Иймээс сүүлийн жилүүдэд банкны секторт хийгдсэн бодит арилжаа, нэлттэй жишиг компаниудын зах зээлийн үнэ цэнийг шинжлэх замаар үнэлгээний өдрийн байдлаар зах зээлийн арилжааны ханшийг тогтоосон. Хавсралт Г-д зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээнд ашиглагдсан жишиг компаниудын мэдээллийг хураангуй танилцуулгыг тусгасан.
- Орлогын ба зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээний үр дүн хоорондоо нийцүгй байж болно. Энэ нь үнэлгээний хандлагуудын дотоод шинж чанараас ихээхэн хамаарна.

***Зах зээлийн хандлага: Жишиг компанийн арга зүй (ЖКАЗ) ба жишиг арилжааны арга зүй (ЖААЗ)***

- Бизнес дэх өмчийн хувь оролцоог үнэлэхдээ зах зээлийн хандлага нь үнэлж буй бизнесийн санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, түүхэн ба хүлээгдэж буй санхүүгийн гүйцэтгэлийг нэлттэй компаниуд болон (1) ижил буюу төстэй бизнесийн шүгамд үйл ажиллагаа явуулдаг (2) эдийн засгийн, байгаль орчны, улс төрийн эрсдэлд адилхан өртдөг, (3) хөрөнгө оруулагчийн дараагийн сонголт байх боломжтой компаниудын зах зээлийн үнэлгээ болон эдгээр компанийн бодит арилжаатай харьцуулдаг.
- Дээрх хоёр арга зүйг дараах байдлаар тодорхойлдог:
  - ЖКАЗ: Энэ арга зүй нь нэлттэй чөлөөт зах зээлд идэвхтэй арилжаалагддаг, бизнесийн ижил шүгамд үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны зах зээлийн үнээс тооцсон зах зээлийн үржүүлэгчийг ашигладаг. Үнэлж буй бизнесийн санхүүгийн гүйцэтгэлийг илтгэх хэмжүүрт тохирох үржүүлэгчийг сонгосноор арилжаалагдахуйц цөөнхийн сонирхлоор үнэ цэн тодорхой болдог.
  - ЖААЗ: Энэ арга зүйг мөн "арилжааны арга" эсвэл "нэгдэл ба худалдан авалтын арга" гэж нэрлэдэг. Жишиг арилжаагаар зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо ижил бизнесийн шүгамд үйл ажиллагаа явуулдаг компаниудын хяналтын эрхтэй буюу их дүнтэй арилжаанаас үүссэн үржүүлэгч ашигладаг. Ингэснээр арилжаалагдахуйц хяналтын эрхтэй сонирхлоор зах зээлийн үнэ цэн тодорхой болдог.
- Бид өөрсдийн дотоод мэдээллийн сан болон албан ёсны талбартэй мэдээллийн эх сурвалжид үндэслэн үнэлгээний шинжилгээнд ЖКАЗ-г авч үзсэн.



БОГД БАНК
БҮРТГЭВ
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-03
УЛААНБААТАР ХОТ
249

***Зах зээлийн хандлага: Тохиромжтой үржүүлэгч***

*Үнэ/Өмчийн дансны үнэ (Price/Book value of Equity)-ийн үржүүлэгч*

- Компанийн зах зээлийн үнэлгээ ба өөрийн хөрөнгийн дансны үнэ цэнийн хоорондын харьцааг хөрөнгө их шаарддаг бизнесүүдэд өргөн ашигладаг бол үнийн гүйцэтгэлийн гол хөдөлгөгч хүчин зүйл нь ирээдүйн өсөлт (жишээлбэл, технологи) болдог салбар дахь бизнесийн хувьд энэ нь тийм ч тохиромжтой биш үржүүлэгч юм. Үнэ/Дансны үнийн үржүүлэгч нь төлбөрийн чадвар, хөрөнгийн шаардлага, өөрийн хөрөнгийн хүрэлцээ зэрэгт анхаарал хандуулдаг тул санхүүгийн байгууллагуудад хамгийн тохиромжтой үржүүлэгчдийн нэг гэж үздэг.

*Үнэ/Өмчийн биет дансны үнэ(Price/Tangible Book value of Equity)-ийн үржүүлэгч*

- Энэ үржүүлэгчийг тодорхойлохдоо өмнөх Үнэ/Өмчийн дансны үнэ үржүүлэгчид ашигласан Өмчийн дансны үнээс бүх биет бус хөрөнгийн үнэ цэнийг хассаны дараах өмчийн дансны үнэ цэнээр хэмжигддэг. Маш олон үнэлгээний мэргэжилтнүүд хөрвөх чадваргүй биет бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэлээс үүдэлтэй байж болзошгүй хазайлтын үгүйг арилгаж, илүү консерватив дүр зургийг харуулах зорилгоор энэ үржүүлэгчийг энгийн Үнэ/ Дансны үнэ-ээс илүү их ашиглахыг зөвлөдөг. Учир нь төлбөрийн чадваргүй болох тохиолдолд, биет бус хөрөнгийн үнэ цэнэ нь тэг хүртэл амархан унаж болзошгүй тул тэдгээрийн хөндлөнгийн нөлөөг арилгах үржүүлэгчийг ашиглах нь зүйтэй гэж үздэг оршино.

*Үнэ/Форвард Өмчийн дансны үнэ(Price/Forward Book value of Equity)-ийн үржүүлэгч*

- Энэ үржүүлэгчийг тодорхойлохдоо өмнөх Үнэ/Өмчийн дансны үнэ үржүүлэгчид ашигласан Өмчийн дансны үнийн оронд прогнозын 1 дэх юм уу өмчийн дансны үнэ цэнээр хэмжигддэг. Маш олон үнэлгээний мэргэжилтнүүд Өмчийн дансны үнийг ашигладаг. Учир нь зохицуулагч байгууллагаас Өмчийн дансны үнийг нэмэгдүүлэх шаардлага тавигдах тохиолдолд энэ үзүүлэлт хамгийн тохиромжтой үржүүлэгч гэж үздэг.

*Үнэ/Хөрөнгө, хадгаламж(Price/Deposits) үржүүлэгч*

- Арилжааны банкнуудын ихэнхэд сайн тохирох үржүүлэгчийг Үнэ/Хөрөнгө, хадгаламж үржүүлэгч гэж үздэг. Учир нь арилжааны банк нь хөрөнгө оруулагчийн хөрөнгө, хадгаламжийг татан төвлөрүүлэх замаар үндсэн бизнесээ явуулдаг. Арилжааны банкнуудын хөрөнгө, хадгаламж нь зөвхөн хүүгийн орлого олохоод тодорхой шимтгэл, хураамжийн орлого олохоод ашиглагддаг гол ах үүсвэр юм.

*Үнэ/Ашиг(Price/Earnings) үржүүлэгч*

- Компанийн зах зээлийн үнэлгээг үнэлгээний өдрөөрх сүүлийн 12 сарын хугацаат хамарсан жилийн цэвэр ашигт харьцуулсан үржүүлэгч. Энэ үржүүлэгч нь ашгаараа хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаат харуулдаг бөгөөд түгээмэл ашиглагддаг үржүүлэгч юм. Зарим өсөлт ихтэй бизнесийн хувьд ашгийн үзүүлэлтийг Форвард ашгаар сонгох нь тустэймэл байдаг.

*(Үнэ/Ашиг) /Өсөлт үржүүлэгч*

- Үнэ/Ашиг үржүүлэгчийг Өсөлтөд харьцуулсан харьцаа нь өсөлт өндертэй бизнесийн үнэлгээнд тохиромжтой үнэлгээний арга юм. Энэ аргын хувьд хэт өндөр өсөлтийг хязгаарласан онолууд байдгийн хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь Петер Линчийн Бодит Үнэ Цэн(Peter Lynch Fair Value)-ийн дүрэм юм. Петер Линчийн Бодит үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлно:

  Peter Lynch FV= PEG*Earnings Growth Rate*Earnings

  Энд:

  PEG нь Үнэ/Ашиг ба Өсөлтийн харьцаа
  Earnings Growth Rate нь Цэвэр ашгийн өсөлт
  Earnings жилийн цэвэр ашиг

- Петр Линчийн дүрмээр, өсөлтийн хувийн дээд хэмжээ нь Үнэ/Ашиг харьцаатай тэнцүү байна гэж үздэг оршино. Иймд аливаа өндөр өсөлттэй бизнесийн өмчийн үнэ цэн нь цэвэр ашгийг өсөлтөөр үржүүлснээс хэтрэхгүй байна.



БОГД БАНК
СЭХ
2021, 11р 10 өдөр
БҮРТГЭВ
№ 71
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БҮРТГЭВ-03
БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
591 558
250

- Өсөлтийг хөмжихдөө, Банкнаас бусад бизнест ХТЭХӨА-ийн дараалсан таван жилийн дунджаар, харин банк, санхүүгийн байгууллагад дараалсан таван жилийн өмчийн дансны үнийн өсөлтийн дунджаар сонгохыг зөвлөдөг.

***Орлогын хандлага: ХМУ-ын загвар***

- Ирээдүйн мөнгөн урсгалын цэвэр өнөөгийн үнэ цэний шинжилгээ буюу ХМУ-ын загвар нь ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн нь бизнесийн үнэ цэнийг нягтлэх гэсэн үзэл баримтлалд суурилдаг. Энэ арга зүйг ашиглахын тулд ирээдүйн мөнгөн урсгалын хүлээгдэж буй дүнг капиталын жинлэсэн дундаж өртөөр хорогдуулдаг. Харин мөнгөн урсгалын төсөөлөл нь шууд өмч рүү чиглэсэн бол өмчийн өртгийг хорогдуулах хүү болгон ашигладаг. ҮЖДӨ-ийн бүрэлдэхүүн болох өмчийн капиталын өртгийг сайжруулсан Капитал хөрөнгө үнэлгээний загвар (ҮХҮЗ) ашиглан тооцно.

- Банк, санхүүгийн байгууллагын мөнгөн урсгалыг тооцохдоо үнэлгээний практикт нэвтэрсэн ногдол ашиг хорогдуулах загвар, илүүдэл өгөөжийн загвар буюу Residual Earnings Method (зарим тохиолдолд Economic Value Added Method гэж нэрлэдэг) ба ӨХЧМУ аргыг ашигладаг. Энэхүү загваруудыг дараах байдлаар тодорхойлно:

  - **Ногдол ашиг хорогдуулах загвар:** Банк, санхүүгийн байгууллагын үнэлгээнд хамгийн өргөн ашиглагддаг загвар бөгөөд санхүүгийн байгууллагын үнэ цэнийг тооцохдоо ирээдүйн ногдол ашгийг өмчийн өртөөр хорогдуулдаг загвар юм.

  - **Илүүдэл ашгийн ба илүүдэл өгөөжийн загвар:** Энэ загвар нь санхүүгийн байгууллагын үнэ цэн нь өмчийн хөрөнгө оруулагчид зохих өртөөр өгөөж хүртсэний дараа үлдэх илүүдэл үнэ цэнээр тайлбарлагддаг гэж үздэг.

  - **Өмчид ногдох чөлөөт мөнгөн урсгалын загвар:** Хувьцаа эзэмшигчдэд хамаарах ирээдүйн чөлөөт мөнгөн урсгалуудыг өмчийн өртгөөр хорогдуулах замаар бизнесийн үнэ цэнийг тооцдог загвар бөгөөд бизнесийн үнэлгээний практикт өргөн ашиглагддаг ч банкны салбарт тийм ч түгээмэл биш.

- Банкны онцлог, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн бүтэц зэргээс шалтгаалан ногдол ашиг хорогдуулах загвар болон Илүүдэл ашгийн загварыг ашиглах нь зохистой гэж үзэлгээний баг дүгнасэн тул үнэлгээнд ХМУ-ын аргаас Илүүдэл ашгийн загвар, НАХ загварыг авч шинжилсэн.

- Хорогдуулсан мөнгөн урсгалын тооцоололтой холбогдох адийн засгийн болон салбарын ирээдүйн төлөв байдлыг зайлшгүй харгалзан үздэг. Бид Богд банкны бизнесийн орчинд үчирч болзошгүй аливаа эрсдэл, боломжийг шинжлэхийн тулд гадаад болон дотоод орчны эрсдэлийг онилсон салбарын судалгаа бэлтгэсэн. Дотоод орчны эрсдэлд салбарын өрсөлдөөн, нийлүүлэлтийн болон эрэлтийн шок, салбарт шинээр нэвтрэх болон гарах зардал, орлуулах бүтээгдэхүүний нөлөө зэргийг харгалзан үзсэн бол гадаад орчны эрсдэлд макро эдийн засгийн орчин, технологийн өөрчлөлт, хүн ам зүйн нөлөө, эрх зүйн орчин, нийгмийн нөлөөг бастаан судалсан.

### 6.2 Санхүүгийн төсөөлөл

- Богд банкны дунд хугацааны санхүүгийн төсөөлөл нь үдирдлагын сайн засаглалын түвшинд боловсруулсан Банкны санхүүгийн загварт үндэслэсэн бөгөөд ҮОУС 105 *Үнэлгээний хандлагууд ба аргууд*, 10.7-р дагол мөрний дагуу үнэлгээний орц мэдээлэл үнэлгээний зорилгод тохирохмжтой эсэхийг нягталсан.

*Нийт орлого*

- Прогнозын хугацааны туршид эдийн засгийн анхдагч орчин таатай уур амьсгалтай байж, банкны зээлийн бүтээгдэхүүний эрэлт тогтвортой хадгалагдана гэж таамагласан. Таамагласан хугацааны туршид банкны нийт орлого дундаар 39% өсөх гэж таамагласан.

*Зураг 16. Орлогын төсөөлөл, сая төгрөгөөр*




*Эх сурвалж: Бизнесийн төлөвлөгөө*

- Хүүгийн орлого нь 2020 онд жилийн дундаж орлого авчрах активын 10.9%-тай тэнцүү байсан ба прогнозын хугацааны туршид энэ түвшинд хадгалагдана гэж төсөөлсөн.

- Таамагласан хугацааны туршид олгох зээлийн нийт хөрөнгөд эзлэх хувь дундаажаар 59% байна гэж таамагласан.



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БУРТЭВ-03
251

*Зураг 17. Зээл ба нийт хөрөнгийн үзүүлэлт, сая төгрөгөөр*




*Эх сурвалж: Банкны бизнесийн төлөвлөгөө*

*Зураг 18. Үндсэн зардлуудын төсөөлөл, сая төгрөгөөр*




*Эх сурвалж: Банкны бизнесийн төлөвлөгөө*

### *Хариуцах, хадгаламжийн хүүгийн болон бусад зардал*

- Хүүгийн зардлын бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрт хамаарах хувь нь түүхэн жилүүдэд дунджаар бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн 6.7%-6.9%-тай тэнцүү байсан ба прогнозын хугацааны туршид 6.7% байна гэж төсөөлсөн.
- Зээлийн эрсдэлийн зардал нь түүхэн дунджаар зээлийн дундаж үлдэгдлийн 1.2% орчимд байсан ба прогнозын хугацааны туршид нийт олгосон зээлийн дундаж үлдэгдлийн 1.2%-2%-тай тэнцэхээр тооцсон. Харин элэгдэл хорогдлын зардлын хувьд тооцсон хугацааны туршид аажмаар өсөх хандлагатай бөгөөд, үндсэн ба биет бус хөрөнгийн 11-23%-тай тэнцэх төсөөлөлтэй байна.

### *Татвар ба төлбөр, хураамж*

- Мөнгөн урсгалын төсөөлөлд багтсан татвар ба төлбөр, хураамжийн тооцоолол нь Монгол улсын татварын хууль, тогтоомжийн дагуу балансгадсан. Үндсэн татвар ба төлбөр, хураамж нь орлогын албан татвар болно.
- Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын шинэ хуульд заасны дагуу 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.

### *Ашигт ажиллагаа*

- Банкны цэвэр ашгийн маржин сүүлийн гурван жилийн хугацаанд дунджаар 17% байсан бол таамаглалын хугацааны дундаж цэвэр ашгийн маржин 17% байна.



БОГД БАНК ХХК УЛААНБААТАР ХОТ ТТЕВ366 5903869
БОГД БАНК
252
БОГД БАНК
СЭЗХ
2021 04 16 өдөр
№ 01
Үнэт цаасны танилцуулга- 03

*Зураг 19. Ашигт ажиллагаа (эүүн тэнхлэгт хувиар, баруун тэнхлэгт сая төгрөгөөр)*

*Эх сурвалж: Банкны бизнесийн төлөвлөгөө*

*Мөнгөн урсгал таамагласан хугацаа*

- Бизнесийн үнэлгээний практикт мөнгөн урсгалыг ихэвчлэн хугацааны хөрөөс гурван мөчлөгтэй тооцдог. Богд банкны санхүүгийн төсөөллийг бид (1) ТЖ21-ТЖ27 он хүртэлх жилүүд, (2) 2027 оноос цаашид хязгааргүй хугацаа[11] -гаар мөнгөн урсгалыг таамагласан.

[11] Үнэлгээний практикт 50 жилээс дээш хугацаа хязгааргүй хугацаа гэж тайлбарладаг. Энэ нь тасралтгүй бүтээгдэхүүн дискрет мөнгөн урсгалын тооцоолол 50-иас дээш үеэр тооцохоо тасралтгүй буюу хязгааргүй хугацаанд тооцсон мөнгөн урсгалын үр дүнтэй материаллаг зөрүүгүй болдогтой холбоотой.



Богд банк ХХК
Улаанбаатар хот
Үнэт цаасны танилцуулга
253

### 6.3 Зах зээлийн шинжилгээ

- Бид жишиг компанийн арга зүйг ашиглахдаа банкны салбарт хамгийн түгээмэл ашиглагддаг P/E болон P/B үржүүлэгчийг авч ашигласан.
- Зах зээлийн хандлагын хүрээнд үнэлгээний дээд ба доод үтгын интервалыг тооцоходоо гадаадын болон дотоодын зах зээл дэх банк, санхүүгийн байгууллагуудын мэдээлэлд суурилсан. Гадаадын зах зээл дэх банкнууд нь үйл ажиллагааны хувьд тогтворжиж, өсөлт тогтмол хэмжээнд хүрсэн гадаг үтгаараа үнэлгээний доод үтгыг илэрхийлэх гэж үзсэн бол дотоодын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдаж буй санхүүгийн байгууллагуудын үзүүлэлт нь Богд Банкны өсөлтийн өөдрөг хувилбарыг илэрхийлэх боломжтой гэж дүгнэсэн. Дотоодын санхүүгийн байгууллагын шинжилгээнд Монгол улсын банк бус санхүүгийн секторт нээлттэй арилжаалагдаг ЛэндМН ББСБ, Ард Кредит ББСБ болон Инвескор ББСБ-ын хувьцааны арилжаанд шинжилгээ хийж холбогдох үржүүлэгчийг тодорхойлсон.




*Зураг 20. Дотоодын жишиг компанийн Хөрдгач зах зээл дэх арилжааны үнэ*







**Хүүдас 44** | Богд банк ХХК-ийн бизнес, хөрөнгийн үнэлгээний тайлан

- МХБ дээр санхүүгийн салбарт 3 банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа идэвхтэй арилжаалагдаж байгаа нь банкны салбартай хамгийн төстэй нь юм. Бид адгээр ББСБ-ын үржүүлэгчийг Өмчийн өгөөжийн хувьтай уялдуулан регрессийн хүчин зүйлийн шинжилгээ хийх замаар Богд банканд тохирох үнэлгээний үржүүлэгчийг тодорхойлсон.

*Хүснэгт 14. МХБ-ийн Санхүүгийн салбарын жишиг компанийн үржүүлэгчийн мэдээлэл*

| МХБ-ийн таних тэмдэг | RoE | P/B | P/E |
|---|---|---|---|
| ADB | 17.9% | 6.12x | 34.08x |
| INV | 21.7% | 4.34x | 19.93x |
| LEND | 12.8% | 1.95x | 15.24x |
| Богд банкны өмчийн өгөөжийн хувьд суурилан тохируулсан үржүүлэгч | 9.7% | 2.44x | 18.84x |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Хүснэгт 14-д харуулсан гурван ББСБ-ын өөрийн хөрөнгийн өсөлтийг CAGR-т суурилан тооцож үзэхэд ЛэндМН ББСБ ХК-ийн өөрийн хөрөнгийн 2017-2020 оны дундаж CAGR 31%, Ард Кредит ББСБ ХК-ийнх 32%, Инвескор ББСБ ХК-ийнх 56% байжээ.

- Энэхүү өсөлтийн үзүүлэлтэд суурилан өсөлттэй компанийн үнэлгээнд ашиглагддаг үржүүлэгч болох PEG харьцааг тооцож үзэхэд ЛэндМН ББСБ ХК-ийн Үнэ/Ашиг ба Өсөлт харьцаа 1.4, Ард Кредит ББСБ ХК-ийнх 0.85, Инвескор ББСБ ХК-ийнх 0.55 байна. Эдгээр гурван нэалттэй хувьцаат компанийн PEG харьцааны дундаж утга 0.9, дундаж утга 0.85, 25%-ийн квартил утга 0.7, 75%-ийн квартил утга 1.13 байгаа нь Монгол улсын санхүүгийн салбарт жил тутам тогтмол өндөр өсөлттэй байгааг харуулж байна.

- Арилжааны 9 банкны хувьд, өмчийн дундаж өсөлт 2019 онд 25%, 2020 онд 20%, дунджаар жилийн 23%-ийн өсөлттэй байна. Харин системийн 5 том банкны хувьд, 2019 онд 1%-ийн бууралттай, 2020 онд 22%-ийн өсөлттэй байна. Системийн 5 банкны өмчийн дансны зэнэ 2019 онд буурахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь ХХБ-ны өмч 2019 онд 22%% Төрийн банк 2%, Голомт банк 10% буурсан нь нөлөөлжээ.

- Жишиг компанийн арга зүйн доод утгыг тодорхойлохдоо бид дараах гадаад банкнуудын Үнэ ашгийн харьцаа ба Үнэ дансны үнийн харьцааг судалсан.

*Хүснэгт 15. Гадаадын жишиг нэалттэй банкны үржүүлэгчийн мэдээлэл*

| | Profit margin | RoE | P/B | P/E |
|---|---|---|---|---|
| Vestjysk Bank | 34% | 9% | 0.81x | 8.44x |
| Bank of Jiujiang | 32% | 15% | 1.13x | 9.75x |
| Cadence Bancorp | 26% | 9% | 1.68x | 21.78x |
| Cadence Bancorp | 29% | 10% | 1.47x | 20.26x |
| SunTrust Bank | 30% | 13% | 1.28x | 10.72x |
| TD Bank Group | 31% | 17% | 1.84x | 11.43x |
| Wells Fargo | 34% | 17% | 1.49x | 9.49x |
| *Min* | | | 0.81x | 8.44x |
| *Max* | | | 1.84x | 21.78x |
| *Median* | | | 1.47x | 10.72x |
| *Average* | | | 1.39x | 13.12x |
| **25% Quartile** | | | **1.21x** | **9.62x** |
| **75% Quartile** | | | **1.59x** | **15.85x** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Бид өнгөрсөн хугацаанд Богд банктай ижил хэмжээтэй гадаадын банкуудын арилжааны P/E үржүүлэгчийг мөн шинжилсэн. Хүснэгт 16-д шинжилгээний үр дүнг харуулав.

*Хүснэгт 16. Гадаад жишиг банкнуудын арилжааны үржүүлэгчийн мэдээлэл*

| Date | Bidder company | Target company | Target subsector | P/E |
|---|---|---|---|---|
| 2020-05-20 | Bangkok Bank Public Company Limited | PT Bank Permata Tbk | Banks | 42.2x |
| 2019-12-12 | Bangkok Bank Public Company Limited; PT Astra International Tbk; Standard Chartered Bank | PT Bank Permata Tbk | Banks | 31.3x |
| 2019-12-12 | Bangkok Bank Public Company Limited | PT Bank Permata Tbk | Banks | 42.0x |
| 2016-12-02 | An Hui Wenergy Company Limited; China Merchants Bank Co., Ltd. | Huishang Bank Corporation Limited | Banks | 6.4x |
| 2013-11-25 | UBS AG, London Branch; Malayan Banking Berhad | PT Bank Maybank Indonesia Tbk | Banks | 13.3x |
| 2013-06-20 | UBS AG, London Branch; Malayan Banking Berhad | PT Bank Maybank Indonesia Tbk | Banks | 16.4x |
| 2009-09-29 | Bangkok Bank Public Company Limited; Industrial and Commercial Bank of China Limited; Morgan Stanley & Co. International plc; Deutsche Bank AG, London Branch | Industrial And Commercial Bank Of China (Thai) Public Company Limited | Banks | 24.1x |
| 2008-10-07 | Malayan Banking Berhad | PT Bank Maybank Indonesia Tbk | Banks | 59.7x |
| 2008-09-30 | Aranda Investments Pte Ltd.; Malayan Banking Berhad | PT Bank Maybank Indonesia Tbk | Banks | 12.5x |
| 2008-06-18 | United Overseas Bank Limited | PT Bank UOB Indonesia | Banks | 19.0x |
| 2008-02-23 | HDFC Bank Limited; bank muscat SAOG; ChrysCapital; Citi Venture Capital International; EIH plc; ICICI Venture Funds Management Company Limited; IAF Series 2; India Advantage Value Fund V; True North Managers LLP; Sabre Capital Worldwide Inc.; The Evolvence India Fund | Centurion Bank of Punjab Ltd | Banks | 71.1x |
| 2005-09-23 | Bangkok Bank Public Company Limited; Bangkok Life Assurance Public Company Limited | Industrial And Commercial Bank Of China (Thai) Public Company Limited | Banks | 7.1x |
| **Median** | | | | **27.7x** |
| *Min* | | | | 6.4x |
| *Max* | | | | 71.1x |
| **Applied multiples** | | | | **27.7x** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

### 6.4 Хөрөнгийн үнэлгээний шинжилгээ

*Үл хөдлөх хөрөнгө*

- Бид Богд банк ХХК-ийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгөд холбогдох шинжилгээ хийсний үндсэн дээр шинээр барьж байгуулах өртөг, түрээсийн орлого болон зах зээлийн арилжааны хангалттай буюу хүрэлцээтэй мэдээлэл цуглуулсан. Уг мэдээлэлд үндэслэн бид өртгийн хандлагын орлуулалтын өртгийн арга, орлогын хандлагын орлогын капиталжуулалтын арга, зах зээлийн хандлагын жиших ажил гүйлгээний аргыг сонгон ашигласан болно.

- Бидний үнэлж буй үл хөдлөх хөрөнгө нь Сүхбаатар дүүргийн 5-р хороонд байрладаг, 3 давхар, контор үйлчилгээний зориулалттай, 2008 онд ашиглалтад орсон бетөөд 1,2-р давхар нь төмөр бетон арагт бүтээцтэй, цутгамал бетон хучилттай, 3-р давхар нь хөөсөнцөр дулаалгатай 2 талаас нь төмөрлөсөн хавтан, сэндвич бүтээцтэй. Банк уг барилгын 1 болон 2 дугаар давхарт 119.8 м2 талбайд банкны үйл ажиллагаа явуулдаг бөгөөд бусад хэсгийг хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглаж байгаа.

- Бид үнэлэгдэж буй объектын байршил болон шинж чанар, зориулалттай нь ижил төрлийн хөрөнгийн зах зээлийг шинжилсэн. Үүний үр дүнд үнэлгээнд харьцуулалтын зорилгоор ашиглаж болох жишиг хөрөнгийн хангалттай/хүрэлцээтэй борлуулах саналыг цуглуулсан. Зах зээлийн бодит арилжааны болон жагсаалтын үнэд зохих тохируулга хийсний үндсэн дээр зах зээлийн хандлагаар тооцоолсон хөрөнгийн үнэлгээний дүнг тодорхойлсон.

- Үнэлэгдэж буй хөрөнгийн хувьд түрээсийн орлогын түүхэн мэдээлэлтэй бөгөөд уг мэдээлэл үнэлгээний шинжилгээнд ашиглахад хангалттай буюу хүрэлцээтэй гэж дүгнэсэн. Бид үл хөдлөх хөрөнгийн орлогын хандлагаарх үнэлгээнд орлогын капиталжуулалтын аргыг ашигласан бөгөөд түхайн үнэлэгдэж буй хөрөнгөтэй ижил зориулалт, байршил бүхий хөрөнгийн түрээсийн өгөөжийн судалгаанд үндэслэсэн.

*Тээврийн хэрэгсэл*

- Тээврийн хэрэгслийн үнэ цэнийг тооцохдоо бид зах зээлийн хандлагын жиших ажил гүйлгээний арга болон өртгийн хандлагын орлуулалтын өртгийн аргыг ашигласан.

- Төөрийн хэрэгслийн дансанд 8 суудлын автомашин бүртгэгдсэн байсан бөгөөд бид зах зээлийн хандлагын жишиг ажил гүйлгээний арга болон өртгийн хандлагын орлуулалтын өртгийн аргыг үнэлгээнд ашигласан.

- Зарим суудлын автомашины хувьд Монголын зах зээлд борлуулсан арилжааны мэдээлэл олдоц муутай байсан тул ижил төсөөтэй хөрөнгийн гадаад зах зээлд арилжаалагдаж буй үнийн мэдээлэлд зохих тохируулгуудыг хийж үнэлгээг гаргасан болно.

*Бусад үндсэн хөрөнгө*

- Харин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, биет бус хөрөнгө зэрэг бусад үндсэн хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийг олж баттгах үеийн зардлыг ашигласан хугацааны элэгдэл болон аливаа үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тооцоолсон.

- Банкны үйл ажиллагаанд ашиглаж буй тавилга эд хогшил, компьютер тоног төхөөрөмж болон биет бус хөрөнгүүдийг өртгийн хандлагын орлуулалтын өртгийн аргаар үнэлсэн бөгөөд ашиглалтын хугацаа дууссан, үлдэгдэл өртөгтэй хөрөнгүүдийг дахин ашиглахгүй гэж үзэж үнэлээгүй болно.

- Мөн зарим тоног төхөөрөмжүүдийг зах зээлийн хандлагын жишиг ажил гүйлгээний аргаар үнэлэхэд үнэлгээний үр дүн нь тухайн хөрөнгийн дансны үнээс материаллаг зөрүүтэй байсан тул дансны үнэ нь зах зээлийн бодит үнэ цэнийг илэрхийлж чадаж байна гэж дүгнэсэн.

- Үндсэн хөрөнгө түс бүрийн үнэлгээний далгэрэнгүй тооцооллыг Хавсралт Ж-ээс үзнэ үү.

*Борлуулах зорилалттай хөрөнгө*

- Банк 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 344,090 мянган төгрөгийн үнэтэй барилга, үл хөдлөх хөрөнгийг зарж борлуулах зорилгоор эзэмшиж байсан. Энэхүү барилгыг үнэлгээний өдрийн дараа худалдан борлуулсан байна.

*Хөрөнгө оруулалтын зорилалттай үл хөдлөх хөрөнгө/ХОЗҮХХ/*

- Банкны 2020 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайланд 3,590,107 мянган төгрөгөөр тусгагдсан үл хөдлөх хөрөнгө нь 4.27 тэрбум төгрөгийн дансны үнэтэй бодит үнэ цэнтэй байсан. Энэхүү үл хөдлөх хөрөнгийг үнэлгээний едрөөр зах зээлийн үнэ цэнээр нь хэмжсэн.

*Санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө*

- Банкны 2020 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайланд бусад санхүүгийн хөрөнгө хэмээн тайлагнасан дүн нь 762,595 мянган төгрөгийн түүхэн өртөгтэй зээлийн бус байдлаар үүссэн авлага байна. Эдгээр авлагад 183,250 мянган төгрөгийн үнэ цэнийн бууралтын нөөц тооцож, 579,345 мянган төгрөгөөр тайлагнасан нь үнэлгээний едрөөрх цэвэр боломжит үнэ цэнийг илэрхийлж байна.

- Банкны 2020 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайланд бусад санхүүгийн бус хөрөнгөөр тайлагнагдсан 2,547,125 мянган төгрөг нь урьдчилж төлсөн зардал, хэтамжийн материал болон бусад хөрөнгүүдээс бүрдэж байна. Энэхүү хөрөнгөд нийтдээ 671,698 мянган төгрөгийн зөөлөх үйлчилгээний зардал багтсан байсныг хассаны дараах үлдэгдийг хөрөнгөд хапиталжих урьдчилгааны дүнгийн үлдэгдлийг 1,875,427 мянган төгрөг хүртэл бүүрүүлж үнэлсэн.

*Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа*

- Үнэлгээний едрийн байдлаар банкны зээл, урьдчилгааны цэвэр үлдэгдэл нь 101,262 сая төгрөг байсан ба үүний 97,087 сая төгрөгийн зээл нь хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн байсан. Хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн зээлийг чанараар нь ангилж 2,112 сая төгрөгийн үнэ цэн бууралтын нөөц байгуулсан байна.

*Хүснэгт 17. Харилцагчдад олгосон зээл*

| | 2020/12/31 | Үнэ цэн бууралтын нөөц | Хорогдуулсан өртөг |
|---|---|---|---|
| Бизнесийн зээл | 75,019,174 | -1,092,775 | 73,926,399 |
| Орон сууцны зээл | 7,498,465 | -421,728 | 7,076,737 |
| Хэрэглээний зээл | 14,569,824 | -597,679 | 13,972,145 |
| **Нийт зээл** | **97,087,463** | **-2,112,182** | **94,975,281** |

*Эх сурвалж: Богд банк*

- Үнэлгээний едрийн байдлаар үлдсэн 6,287.7 сая төгрөгийн зээл нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх зээл байсан.

*Санхүүгийн хөрөнгө оруулалт*

- Үнэлгээний өдрийн байдлаар банкны санхүүгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэл нь 20,089 сая төгрөг байсан.

*Хүснэгт 18. Санхүүгийн хөрөнгө оруулалт*

| | 2020/12/31 | Тайлбар |
|---|---|---|
| Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас | 1,331,801 | Энгийн болон давуу эрхтэй хүүтэй, МИК-ийн үнэт цаас. |
| Төв банкны үнэт цаас | 4,925,825 | Үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн |
| Засгийн газрын бонд | 10,314,761 | Гадаадад гаргасан ЗГ-ын үнэт цаас |
| Хаалттай компанид оруулсан өмчийн хөрөнгө | 3,300,000 | Бодь Цамхаг ХХК-ийн 2.8 тэрбум төгрөгийн үнэтэй, 8.045%-ийн өмчийн хөрөнгө оруулалт |
| МХБ-д бүртгэлтэй компанийн хувьцаа | 217,260 | Бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн. |
| **Нийт дүн** | **20,089,647** | |

*Эх сурвалж: Богд банк*

*Санхүүгийн өр төлбөр*

- Бусад банк, санхүүгийн байгууллагын хугацаатай хадгламжийн үлдэгдэл нь 2020 оны 12 сарын 31-ний байдлаар 27,048,795 мянган төгрөг байсан. Хугацаатай хадгламж нь жилийн 1%-12.5%-ийн хүүтэй, 2-оос 31 хүртэл хоногийн хугацаатай байсан учраас дансны үнэ нь бодит үнэ цэнийг төлөөлнө. Түүнчлэн энэхүү хүү бүхий эх үүсвэр нь богино хугацаатай учраас банкны үрт хугацаат өрийн хэрэгсэлд хамаарахгүй.

- Банк нь 2020 оны 12-р сарын 31-нээр Монголбанкнаас бүцааж худалдан авах нөхцөлтэй, 2021 оны 1-р сарын 11-нд хугацаа дуусах 10,056,265 мянган төгрөгийн гэрээ байгуулсан. Гэрээний барьцаанд 10,096,000 мянган төгрөгийн дүн бүхий 2021 оны 01 сарын 18-нд хугацаа дуусах Төв банкны үнэт цаасыг барьцаалсан. Зээлийн хугацаа богино учраас дансны үнэ нь бодит үнэ цэнээс материаллаг зөрүүгүй.

- Мөн Монгол Улсын Хөгжлийн банктай төв банкны үнэт цаас бүцаан худалдан авах нөхцөлтэй, богино хугацаатай, жилийн 6%-ийн хүүтэй, 2021 оны 1-р сарын 4-нд хугацаа дуусах нийтдээ 15,000,000 мянган төгрөгийн дүн бүхий хөөр гэрээ байгуулсан. Зээлийн хугацаа богино учраас дансны үнэ нь бодит үнэ цэнээс материаллаг зөрүүгүй.

- Банкны харилцагчдаас татан төвлөрүүлсэн харилцах, хадгламжийн үнэлгээний өдрөөрх үлдэгдэл нь 100,674,527 мянган төгрөг байна. Эдгээр өр төлбөр нь банкны онцлогийн дагуу бизнес үнэлгээнд ажлын капиталын бүрэлдэхүүнд багтаж үнэлэгдэнэ.

- Банк нь БНХАУ-ын Өвөрмонголын банкнаас жилийн 7%-ийн хүүтэй, 2021 оны 1-р сарын 8-нд төлөгдөх дуусвар хугацаатай 4,489,813 мянган төгрөгтэй танцах зээлтэй байсан ба уг зээл нь хугацаандаа эргэн төлөгдсөн.

- Банк нь Монголбанк, Сангийн яамны санхүүжилттэй Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд харилцан 2021/07/31 ба 2021/8/2-нд хугацаа дуусах жилийн 1-4%-ийн хүүтэй 2,641,166 мянган төгрөг болон 243,753 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан. Эдгээр хөтөлбөрийн зээл нь богино хугацаатай учраас бизнес үнэлгээнд ажлын капиталын өөрчлөлтөөр үнэлэгдэнэ.

- Банк нь Засгийн Газрын "Ажлын байр нэмэгдүүлэх төсөл"-ийн жилийн 7%-ийн хүүтэй, 2022/7/1-нд эргэн төлөгдөх 90,000 мянган төгрөгийн эх үүсвэртэй. Энэхүү зээл нь бага дунтай учраас банкны бизнесийн үнэ цэнд материаллаг нөлөөгүй гэж бид үзсэн.



BDO

БОГД БАНК

Үнэт цаасны танилцуулга 11-03

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

258

## 7. Бизнесийн үнэлгээний үр дүн

Хүүдэс 49 | Богд банк ХХК-ийн бизнес, хөрөнгийн үнэлгээний тайлан



БОГД БАНК
Унэт цаасны танилцуулга
СЗХ
БУРТГЭВ

**Орлогын хандлага: Үлдэгдэл ашиг хорогдуулах загвар – МХБ-ийн санхүүгийн секторын бетагаар хөшүүрэгдсэн гүтранги төсөөлөл**

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ, үдирдлагаас хүлээн авсан бизнесийн төлөвлөгөөнд суурилан Богд банкны илүүдэл ашгийн өнөөгийн үнэ цэнийг тооцож, бизнесийн үнэ цэнийг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэрэгцүүлэх хүснэгтэд хураангуйлав. (Үнэлгээний тооцооллыг Хавсралт Ё-оос дэлгэрүүлнэ үү.)

- Мөнгөн урсгалын төсөөлөл нь удирдлагаас бидэнд ирүүлсэн дүнд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн.

- Бид прогнозын хугацааны түршид өмчийн өгөөжөөс давсан илүүдэл ашгийг тооцохдоо прогнозын хугацааны зорилтот өмчийн дүнг арилжааны банкны дүрмийн сангийн хэмжээг 100 тэрбум төгрөгт хүргэх банкны төлөвлөгөөнд суурилан тооцоолсон.

- Бид хорогдуулах хүүг Испанийн санхүүгийн проф. Пабло Фернандезийн дэлхийн 88 орныг хамруулан хийсэн судалгааны тайланд үндэслэн 8.5%-ийн эрсдэлгүй хүүгийн түвшин болон 10.1%-ийн Өмчийн эрсдэлийн нэмэгдлийг МХБ-ийн ижил төстэй жишиг компанийн хөшүүрэггүй Бета Богд банкны үр ашгийг татварын түвшингээр засварласан Өр/Өмч харьцаагаар дахин хөшүүрэгдэж гарсан Капитал Хөрөнгийн Үнэлгээний Загвараар буюу өмчийн өртгөөр тооцсон бөгөөд БДО Монгол-ын шинжилгээгээр өмчийн бодит өртгийн хамгийн их түвшин 17.5% байна. Мөн түүнчлэн бид дараах арга зүй, параметрүүдийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан.

  - Бизнесийн үлдэх үнэ цэн буюу яцсийн мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.
  - Урт хугацааны өсөлтийг 5%, инфляцын хүлээлтийг 6% байхаар сонгон авсан.
  - Өмчийн нэрлэсэн хүүг Фишерийн тэгшитгэл ашиглан бодит хүүд шилжүүлсэн.
  - Хорогдуулах хүүгийн үеийг дундаж үеийн аргаар тооцсон.

- Илүүдэл ашгийн загварын өөдрөг төсөөллийн үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэн **139,703 сая төгрөг** байна.

*Хүснэгт 19. Илүүдэл ашгийн загвараар тооцсон үнэлгээний үр дүн – МХБ-ын салбарын бетагаар хөшүүрэгдсэн гүтранги төсөөлөл*

| *сая төгрөгөөр* | Параметрүүд |
|---|---|
| *Хорогдуулах хувь* | |
| Эрсдэлгүй хүүгийн түвшин | 8.5% |
| Өмчийн эрсдэлийн нэмэгдэл | 10.1% |
| Хөшүүрэггүй Бета | 0.38 |
| дахин хөшүүрэгдсэн бета | 1.18 |
| Компанийн тусгайлсан эрсдэлийн нэмэгдэл | 4.0% |
| **Өмчийн нэрлэсэн өртөг** | **24.5%** |
| **Өмчийн бодит өртөг** | **17.5%** |
| Урт хугацааны өсөлт | 5% |
| 2020/12/31-ний өмчийн дүн | 61,301 |
| Прогнозын хугацааны зорилтот өмч | 101,872 |
| *Үнэлгээний дүгнэлт* | |
| **Өмчийн үнэ цэн-100 хяналтай хувь оролцоонд хамаарах** | **139,703** |
| **Хяналтгүйн хөнгөлөлт** | **-23.7%** |
| **Өмчийн үнэ цэн-100% хяналтгүй хувь оролцоонд хамаарах** | **106,593** |

*Мэдрэмжийн шинжилгээ, сая төгрөгөөр*

| | 3.0% | 4.0% | 5.0% | 6.0% | 7.0% |
|---|---|---|---|---|---|
| 15.5% | 183,566 | 193,340 | 205,171 | 219,786 | 238,299 |
| 16.5% | 144,985 | 150,822 | 157,674 | 165,831 | 175,706 |
| 17.5% | 129,796 | 134,382 | 139,703 | 145,948 | 153,384 |
| 18.5% | 116,630 | 120,265 | 124,438 | 129,278 | 134,961 |
| 19.5% | 105,116 | 108,016 | 111,316 | 115,106 | 119,501 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БУРТГЭВ-03
260

**Орлогын хандлага: Үлдэгдэл ашиг хорогдуулах загвар – МХБ-ийн санхүүгийн секторын бетагаар хөшүүрэгдсэн өөдрөг төсөөлөл**

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ, удирдлагаас хүлээн авсан бизнесийн төлөвлөгөөнд суурилан Богд банкны илүүдэл ашгийн өнөөгийн үнэ цэнийг тооцож, бизнесийн үнэ цэнийг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэрэлдэх хүснэгтэд хураангуйлав. (Үнэлгээний тооцооллыг Хавсралт Ё-оос дэлгэрүүлнэ үү.)

- Мөнгөн урсгалын төсөөлөл нь удирдлагаас бидэнд ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн.

- Бид прогнозын хугацааны туршид өмчийн өгөөжөөс давсан илүүдэл ашгийг тооцохдоо прогнозын хугацааны эцэлтэт өмчийн дүнг арилжааны банкны дүрмийн сангийн хэмжээг 100 тэрбум төгрөгт хүргэх банкны төлөвлөгөөнд суурилан тооцоолсон.

- Бид хорогдуулах хүүг Испанийн санхүүгийн проф. Пабло Фернандезийн дэлхийн 88 орныг хамруулан хийсэн судалгааны тайланд үндэслэн 8.5%-ийн эрсдэлгүй хүүгийн түвшингээр, Өмчийн эрсдэлийн нэмэгдлийг МХБ-ийн ТОП-20 индексийн 2008-2021 оны дундаж өсөлт болох 17%-иас эрсдэлгүй хүүг хассан дүнгээр сонгож, сонгосон өмчийн эрсдэлийн нэмэгдлийг МХБ-д бүртгэлтэй жишиг гүрвэн ББСБ-ын хөшүүрэггүй бетаны жинлэсэн дундаж утгыг Богдбанкны татварын үр ашигт хувиар засварласан Өр/Өмч харьцаагаар дахин хөшүүрэгдэж гарсан бетагаар тохируулсан Капитал Хөрөнгийн Үнэлгээний Загвараар буюу өмчийн өртөөр тооцсон бөгөөд БДО Монгол-ын шинжилгээгээр өмчийн бодит өртгийн хамгийн бага түвшин 16% байна. Мөн түүнчлэн бид дараах арга зүй, параметрүүдийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан.

  - Бизнесийн үлдэх үнэ цэн буюу эцсийн мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.
  - Урт хугацааны өсөлтийг 5%, инфляцын хүлээлтийг 6% байхаар сонгон авсан.
  - Өмчийн нэрлэсэн хүүг Фишерийн тэгшитгэл ашиглан бодит хүүнд шилжүүлсэн.
  - Хорогдуулах хүүгийн үеийг дундаж үеийн аргаар тооцсон.

- Илүүдэл ашгийн загварын өөдрөг төсөөллийн үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэн **167,906 сая төгрөг** байна.

*Хүснэгт 20. Илүүдэл ашгийн загвараар тооцсон үнэлгээний үр дүн – МХБ-ын салбарын бетагаар хөшүүрэгдсэн Өөдрөг төсөөлөл*

| *сая төгрөгөөр* | Параметрүүд |
|---|---|
| *Хорогдуулах хувь* | |
| Эрсдэлгүй хүүгийн түвшин | 8.5% |
| Өмчийн эрсдэлийн нэмэгдэл | 8.5% |
| Хөшүүрэггүй Бета | 0.38 |
| дахин хөшүүрэгдсэн бета | 1.18 |
| Компанийн тусгайлсан эрсдэлийн нэмэгдэл | 4.0% |
| **Өмчийн нэрлэсэн өртөг** | **22.6%** |
| **Өмчийн бодит өртөг** | **16.0%** |
| Урт хугацааны өсөлт | 5% |
| 2020/12/31-ний өмчийн дүн | 61,301 |
| Прогнозын хугацааны эцэлтэт өмч | 101,872 |
| *Үнэлгээний дүгнэлт* | |
| **Өмчийн үнэ цэн-100 хяналтгүй хувь оролцоонд хамаарах** | **167,906** |
| **Хяналтгүйн хөнгөлөлт** | **-23.7%** |
| **Өмчийн үнэ цэн-100% хяналтгүй хувь оролцоонд хамаарах** | **128,112** |

*Мэдрэмжийн шинжилгээ, сая төгрөгөөр*

| | 3.0% | 4.0% | 5.0% | 6.0% | 7.0% |
|---|---|---|---|---|---|
| 14.0% | 222,936 | 237,903 | 256,611 | 280,664 | 312,735 |
| 15.0% | 172,680 | 181,230 | 191,490 | 204,030 | 219,706 |
| 16.0% | 153,485 | 160,095 | 167,966 | 177,280 | 188,737 |
| 17.0% | 137,110 | 142,278 | 148,308 | 155,433 | 163,984 |
| 18.0% | 122,985 | 127,064 | 131,771 | 137,262 | 143,751 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

**Орлогын хандлага: Ногдол Ашиг Хорогдуулах Загвар – МХБ-ийн санхүүгийн секторын бетагаар хөшүүрэгдсэн гүтранги төсөөлөл**

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ, удирдлагаас хүлээн авсан бизнесийн төлөвлөгөөнд суурилан Ногдол Ашиг Хорогдуулах загвараар Богд Банкны өнөөгийн үнэ цэнийг тооцож, бизнесийн үнэ цэнийг тодорхойлсон. Ингэхдээ бид банк нь дүрмийн санг 100 тэрбум төгрөг хүргэх минимум шаардлагыг хангах хүртэл хугацаанд олсон бүх ашгийг дүрмийн санд шилжүүлэх ба энэ шаардлагыг хангасны дараагийн тайлант жилээс эхлэн өөрийн олж бүй ашгийг 100% хувьцаа эзэмшигчдэд хуваарилна гэсэн төсөөлөлд суурилан холбогдох үнэлгээний тооцооллыг хийсэн. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав. (Үнэлгээний тооцооллыг Хавсралт Ё-оос дэлгэрүүлнэ үү.) Гэвч банкны өнөөгийн төсөөллөөр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг 100% хуваарилах эсэх шийдвэр гаргагүй учраас энэ артын үр дүнг үнэлгээний дүгнэлтэд ашиглаагүй.

- Мөнгөн урсгалын төсөөлөл нь удирдлагаас бидэнд ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн. Өөдрөг төсөөллийн хүрээнд бодит хорогдуулах хүү болох 17.5%-ийг тооцохдоо Илүүдэл ашгийн загварт ашигласантай адил төсөөллийг хэрэглэсэн. Мөн түүнчлэн бид дараах арга зүй, параметрүүдийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан.

  - Бизнесийн үлдэх үнэ цэн буюу эцсийн мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.
  - Урт хугацааны өсөлтийг 5% байхаар сонгон авсан.
  - Ногдол ашиг төлөлтийг 2022 оны жилийн ашгаас эхлэн жил бүрийн дараагийн тайлант жилд 100% төлөх гэж таамагласан.
  - Хорогдуулах хүүгийн үеийг дундаж үеийн аргаар тооцсон.

- Ногдол ашиг хорогдуулах загварын өөдрөг төсөөллийн үр дүнгээс дүгнэхэд үйлчлүүлэгчийн үнэлгээний өдрийн байдлаар явагдаж байгаа одоогийн бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэн **153,270 сая төгрөг** байна.

*Хүснэгт 21. НАХ загвараар тооцсон үнэлгээний үр дүн – МХБ-ын салбарын бетагаар хөшүүрэгдсэн гүтранги төсөөлөл*

| Сая төгрөгөөр | Параметрүүд |
|---|---|
| *Хорогдуулах хувь* | |
| Эрсдэлгүй хүүгийн түвшин | 8.5% |
| Өмчийн эрсдэлийн намагдал | 10.1% |
| Хөшүүрэггүй Бета | 0.38 |
| Хөшүүрэгтэй Бета | 1.18 |
| Компанийн тусгайлсан эрсдэлийн нэмэгдэл | 4.0% |
| **Өмчийн нэрлэсэн өртөг** | **24.5%** |
| **Өмчийн бодит өртөг** | **17.5%** |
| Урт хугацааны өсөлт | 5% |
| *Үнэлгээний дүгнэлт* | |
| Хорогдуулсан ногдол ашгийн өнөөгийн үнэ цэнэ | 50,952 |
| Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ | 102,318 |
| **Өмчийн үнэ цэнэ** | **153,270** |

*Мэдрэмжийн шинжилгээ, сая төгрөгөөр*

| | 3.0% | 4.0% | 5.0% | 6.0% | 7.0% |
|---|---|---|---|---|---|
| 15.5% | 167,532.4 | 178,474.8 | 191,501.4 | 207,270.4 | 226,749.8 |
| 16.5% | 151,318.9 | 160,208.5 | 170,644.2 | 183,067.5 | 198,106.3 |
| 17.5% | 137,477.2 | 144,788.8 | 153,270.1 | 163,226.5 | 175,079.4 |
| 18.5% | 125,542.0 | 131,620.1 | 138,598.6 | 146,693.8 | 156,196.8 |
| 19.5% | 115,161.0 | 120,261.1 | 126,064.7 | 132,728.0 | 140,457.5 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



Үнэт цаасны танилцуулга
262

**Орлогын хандлага: Ногдол Ашиг Хорогдуулах Загвар – МХБ-ийн санхүүгийн секторын бетагаар хөшүүрэгдсэн өөдрөг төсөөлөл**

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ, үдирдлагаас хүлээн авсан бизнесийн төлөвлөгөөнд суурилан Ногдол Ашиг Хорогдуулах загвараар Богд Банкны өөрийн үнэ цэнийг тооцож, бизнесийн үнэ цэнийг тодорхойлсон. Ингэхдээ бид банк нь дүрмийн санг 100 тэрбум төгрөгт хүргэх минимум шаардлагыг хангах хүртэл хугацаанд олсон бүх ашгийг дүрмийн санд шилжүүлэх ба энэ шаардлагыг хангасны дараагийн тайлант жилээс эхлэн өөрийн олж буй ашгийг 100% хувьцаа эзэмшигчдэд хуваарилна гэсэн төсөөлөлд суурилан холбогдох үнэлгээний тооцооллыг хийсэн. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд харуулав. (Үнэлгээний тооцооллыг Хавралт Ё-оос дэлгэрүүлэв үү.) Гэвч банкны өөрийн төсөөллөөр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг 100% хуваарилах эсэх шийдвэр гаргаагүй учраас энэ аргын үр дүнг үнэлгээний дүгнэлтэд ашиглаагүй.

- Мөнгөн урсгалын төсөөлөл нь удирдлагаас бидэнд ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн. Өөдрөг төсөөллийн хүрээнд бодит хорогдуулах хүү болох 16%-ийг тооцохдоо Илүүдэл ашгийн загварт ашигласантай адил төсөөллийг хэрэглэсэн. Мөн түүнчлэн бид дараах арга зүй, параметрүүдийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан.

  - Бизнесийн үлдэх үнэ цэн бүхэл эцсийн мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.
  - Урт хугацааны өсөлтийг 5%, инфляцийн хүлээлтийг 6% байхаар сонгон авсан.
  - Ногдол ашиг төлөлтийг 2022 оны жилийн ашгаас эхлэн жил бүрийн дараагийн тайлант жилд 100% төлөө гэж таамагласан.
  - Хорогдуулах хүүний үеийг дундаж үеийн аргаар тооцсон.

- Ногдол ашиг хорогдуулах загварын өөдрөг төсөөллийн үр дүнгээс дүгнэхэд үйлчлүүлэгчийн үнэлгээний өдрийн байдлаар явагдаж байгаа одоогийн бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэн **180,577 сая төгрөг** байна.

*Хүснэгт 22. НАХ загвараар тооцсон үнэлгээний үр дүн – МХБ-ын салбарын бетагаар хөшүүрэгдсэн өөдрөг төсөөлөл*

| *сая төгрөгөөр* | Параметрүүд |
|---|---|
| *Хорогдуулах хүү* | |
| Эрсдэлгүй хүүгийн түвшин | 8.5% |
| Өмчийн эрсдэлийн нэмэгдэл | 8.5% |
| Хөшүүрэггүй Бета | 0.38 |
| Хөшүүрэгтэй Бета | 1.18 |
| Компанийн тусгайлсан эрсдэлийн нэмэгдэл | 4.0% |
| **Өмчийн нэрлэсэн өртөг** | **22.5%** |
| **Өмчийн бодит өртөг** | **16.0%** |
| Урт хугацааны өсөлт | 5% |
| *Үнэлгээний дүгнэлт* | |
| Хорогдуулсан ногдол ашгийн өөдрөгийн үнэ цэнэ | 54,180 |
| Терминал үнэ цэнийн өөдрөгийн үнэ цэнэ | 126,397 |
| **Өмчийн үнэ цэнэ** | **180,577** |

*Мэдрэмжийн шинжилгээ, сая төгрөгөөр*

| | 3.0% | 4.0% | 5.0% | 6.0% | 7.0% |
|---|---|---|---|---|---|
| 14.0% | 197,735.6 | 213,101.2 | 231,881.4 | 255,356.6 | 285,539.0 |
| 15.0% | 176,716.6 | 188,920.7 | 203,565.7 | 221,465.0 | 243,839.3 |
| 16.0% | 159,094.5 | 168,940.9 | 180,577.5 | 194,541.4 | 211,608.4 |
| 17.0% | 144,133.8 | 152,184.4 | 161,576.7 | 172,676.6 | 185,996.6 |
| 18.0% | 131,295.5 | 137,953.6 | 145,636.0 | 154,598.8 | 165,191.1 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



БОГД БАНК BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ:8944-5933
263
БОГД БАНК
ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ
Үнэт цаасны танилцуулга
2021-11-03
ХУРТЭВ-03

### Орлогын хандлага: Аргуудын үр дүнгийн дүгнэлт

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ, удирдлагаас хүлээн авсан бизнесийн төлөвлөгөөнд суурилан Орлогын хандлагын аргуудын эцсийн үр дүнд суурилан тооцоолсон үнэлгээний үр дүнг зэргэлдэх хүснэгтэд хураангуйлав. (Үнэлгээний тооцооллыг арга тус бүрийн тооцооллоос дэлгэрүүлнэ үү.)

- Мөнгөн урсгалын төсөөлөл нь удирдлагаас бидэнд ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн. Хорогдуулах хүүг өөдрөг болон гутранги төсөөллийн хүрээнд МХБ-ийн ТОП-20 индексийн түүхэн урт хугацааны өгөөжид суурилсан эмчийн эрсдэлийн нэмэгдэл болон төгрөгийн эрсдэлгүй хүүгийн шинжилгээнд суурилан гаргасан Капитал Хөрөнгийн Үнэлгээний Загвараар бүюу эмчийн өртөөр тооцсон бөгөөд БДО Монгол-ын шинжилгээгээр нэрлэсэн эмчийн өртөг өөдрөг төсөөллөөр 16.3%, гутранги төсөөллөөр 17.1% байна. Мөн түүнчлэн бид дараах арга зүй, параметрүүдийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан.

  - Бизнесийн үлдэх үнэ цэн бүюу эцсийн мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.
  - Урт хугацааны өсөлтийг 5% байхаар сонгон авсан.
  - Нөгдөл ашиг төлөлтийг дүрмийн сангийн дрод хэмжээнд тавигдах шаардлага хангасны дараагийн тайлант жилээс эхлэн 100% төлөх гэж таамагласан.
  - Хорогдуулах хүүгийн үеийг дундаж үеийн аргаар тооцсон.
  - Дүгнэлтийн дрод интервалыг ашигласан аргуудын дрод квартил утгаар, дээд интервалыг дээд квартил утгаар сонгосон.

- Орлогын хандлагын үр дүнгээс дүгнэхэд үйлчлүүлэгчийн үнэлгээний едрийн байдлаар явагдаж байгаа одоогийн бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэн нь **139,703 сая төгрөгөөс 167,906 сая төгрөгийн** хооронд байна.

- Нөгдөл ашиг хорогдуулан тооцох загварын үнэлгээний үр дүн нь Илүүдэл ашгийн загвараар тооцоолсон үнэлгээний дүгнэлтийг дэмжиж байна.

- ***Хяналтгүй хувь оролцооны нэгж хувьцаанд ногдох зах зээлийн үнэ цэн нь тооцоолсон зах зээлийн үнэ цэнээс 10%-23.7%-ийн хяналтгүйн хөнгөлөлт хассан дүн дээр харагдах магадлалтай.***

*Хүснэгт 23. Орлогын хандлагын аргуудын үнэлгээний үр дүн*

| | IPO-ийн дараах байдлаар | | IPO-ийн дараах байдлаар | |
|---|---|---|---|---|
| *сая төгрөгөөр* | Гутранги | Өөдрөг | Гутранги | Өөдрөг |
| *Хорогдуулах хувь* | | | | |
| Эрсдэлгүй хүүгийн түвшин | 8.5% | 8.5% | 8.5% | 8.5% |
| Өмчийн эрсдэлийн нэмэгдэл | 10.1% | 8.5% | 10.1% | 8.5% |
| Хөшүүрэггүй Бета | 0.38 | 0.38 | 0.38 | 0.38 |
| Компанийн тусгайлсан эрсдэлийн нэмэгдэл | 4.0% | 4.0% | 4.0% | 4.0% |
| **Өмчийн нэрлэсэн өртөг** | **17.5%** | **16.0%** | **17.5%** | **16.0%** |
| **Өмчийн бодит өртөг** | | | | |
| Урт хугацааны өсөлт | 5% | 5% | 5% | 5% |
| Урт хугацааны инфляцын хүлээлт | 6% | 6% | 6% | 6% |
| *Үнэлгээний дүгнэлт* | | | | |
| ***Илүүдэл ашгийн арга*** | ***138,826*** | ***166,605*** | ***139,703*** | ***167,906*** |
| Нөгдөл ашгийн загвар | 153,270 | 153,270 | 153,270 | 180,577 |
| **100%-ийн хяналттай хувь оролцоонд хамаарах Өмчийн үнэ цэнийн дүгнэлт** | ***138,826*** | ***166,605*** | ***139,703*** | ***167,906*** |
| **Хяналтгүйн хөнгөлөлт** | ***-23.7%*** | ***-23.7%*** | ***-23.7%*** | ***-23.7%*** |
| **100%-ийн хяналтгүй хувь оролцоонд хамаарах Өмчийн үнэ цэнийн дүгнэлт** | ***105,924*** | ***127,120*** | ***106,593*** | ***128,112*** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

**Хуудас 54** | Богд банк ХХК-ийн бизнес, көрөнгийн үнэлгээний тайлан

## Зах зээлийн хандлага: Жишиг Компанийн Арга Зүй

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үйлчлүүлэгчтэй ижил бизнесийн эрсдэл бүхий жишиг компаниудын хувьцааны үнийн мэдээллийг судлах замаар бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнийг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав. (Жишиг компанийн мэдээллийг Хавсралт Г-ээс дэлгэрүүлнэ үү.)

- Үнэлгээний баг жишиг компаниудыг сонгохдоо дараах шалгуурыг авч үзсэн.

  - Үүнд, гадаадын банкны хувьд: (1) сонгон авсан жишиг компаниуд нь үйлчлүүлэгчтэй ижил бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг; (2) хангалттай борлуулалтын хэмжээ бүхий хамгийн багадаа хоёр жилийн ариллжааны түүхтэй; ба (3) Монгол улсад болон хөрш зэргэлдээ, ижил адийн засгийн орчинд нөлөөтэй зах зээл дээр бүртгэгдсэн аж ахуйн нэгжүүд байна.

  - Дотоодын санхүүгийн байгууллагын хувьд МХБ-д нөлөөтэй ариллжаалагддаг санхүүгийн байгууллагуудын P/E болон P/B үржүүлэгчийг авч үзсэн.

- Жишиг компанийн аргаар тооцсон үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний едрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн өмчийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэн **P/B үржүүлэгчийн хувьд 119,500 – 163,300 сая төгрөг** байна. **Өөрөөр хэлбэл, зах зээлийн хандлагын үнэлгээний үр дүнгийн хязгаарын хүрээнд банкны 100%-ийн өмчийн үнэ цэн нь 119,500 сая төгрөгөөс доошгүй, 163,300 сая төгрөгөөс илүүгүй байхаар байна.**

- ***Өндөр өсөлттэй бизнесийн өмчийн үнэлгээнд үнэлгээний практикт хэрэглэгддэг Петер Линчийн Бодит үнэ цэнийн дүрмээр Богд банкны үнэлгээний едрээрх 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэн нь 129,191 сая төгрөгөөс 153,986 сая төгрөгийн хооронд байх үндэслэлтэй байна.***

- Зах зээлийн хандлага нь орлогын хандлагын үр дүнг дэмжих зорилгоор ашиглагдсан бөгөөд түүх интервалд орлогын хандлагын үр дүнгүүд багтаж байгаа нь орлогын хандлагын үнэлгээний үр дүнгийн үл үндэслэлтэй байдлыг бататгаж байна гэж үнэлгээний баг дүгнэсэн.

*Хүснэгт 24. Жишиг компанийн аргаар тооцсон үнэлгээний үр дүн*

| *Форвард P/B үржүүлэгч* | *сая төг* |
|---|---|
| Санхүүгийн үзүүлэлт- өмчийн Форвард дансны үнэ[12] | 78,309 |
| Санхүүгийн үзүүлэлт- 2021/03/31-ний өмчийн дансны үнэ | 66,909 |
| Санхүүгийн үзүүлэлт- 2020/12/31-ний өмчийн дансны үнэ | 61,301 |
| P/B Үржүүлэгч – доод | 1.95x[13] |
| P/B Үржүүлэгч – дээд[14] | 2.44x |
| Дотоод үнэ цэн – Үнэлгээний өдрийн ДУ-г доод P/B үржүүлэгчээр | 119,536 |
| Дотоод үнэ цэн- Үнэлгээний өдрийн ДУ-г дээд P/B үржүүлэгчээр | 149,574 |
| Дотоод үнэ цэн –2021/03/31-ний ДУ-г дээд P/B үржүүлэгчээр | 163,258 |
| **Өмчийн үнэ цэн – доод үнэ** | **119,500** |
| **Өмчийн үнэ цэн – дээд үнэ** | **163,300** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

*Хүснэгт 25. Петр Линчийн Бодит Үнэ Цэнийн дүрмээр тооцсон үнэлгээний үр дүн*

| | *2020 оны гүйцэтгэлээр* | *2021 оны Форвард ашгаар* |
|---|---|---|
| | *сая төг* | *сая төг* |
| 2021 оны жилийн Форвард ашиг[15] | | 9,348 |
| 2020 оны жилийн ашиг | 5,617 | |
| Прогнозын хугацааны Өмчийн төсөөлсөн өсөлт[16] | 23x | 17x |
| **Өмчийн үнэ цэн** | **129,191** | **158,916** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

[12] *Өмчийн Форвард дансны үнэ нь 2021 оны Q3 сарын 31-ний өдрийн өмчийн дансны үнэ дээр Ард Санхүүгийн Нэгдэлээс оруулах хэмжээ 11.4 тэрбум төгрөгийн нэмэгдэл дүнг илэрхийлнэ.*

[13] *Үнэ/Дансны үнийн дундаж хэмжээг нь тайлагнах ROE бүхий МХБ-д хувьцаа нь нээлттэй ариллжаалагдаж буй LEND-ийн үржүүлэгч.*

[14] *Үнэ/Ашиг нь МХБ-д хувьцаа нь нээлттэй ариллжаалагдаж буй санхүүгийн компаниудын компаратын шинжилгээнд суурилан тохируулсан үржүүлэгч.*

[15] *Форвард ашиг нь 2021 оны12 сарын 31-ийг хүртэл хугацааны жилийн татварын дараах цэвэр ашгийг илэрхийлнэ.*

[16] *Төсөөлсөн өсөлт нь 2020 оны хувьд 2020-2027 оны өмчийн өсөлтийн CAGR-т, Форвард өсөлтийн хувьд 2021-2027 оны өмчийн дансны үнийн өсөлтийн CAGR-т суурилсан.*



БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
7778896 , 5703855
265

## Өртгийн хандлага: Тохируулга хийсэн цэвэр өөрийн хөрөнгийн арга

- Өртгийн хандлагыг орлогын хандлага болон зах зээлийн хандлагын тохирох аргуудын сүүрь арга болгон хэрэглэсэн.

*Хүснэгт 26. Тохируулга хийсэн цэвэр өөрийн хөрөнгийн аргын үнэлгээний үр дүн*

| *Мянган төгрөгөөр* | *2020 он* | *Тохируулга* | *Тохируулсан дүн* |
|---|---|---|---|
| Хөрөнгө | | | |
| Мөнгөн хөрөнгө | 53,555,309 | | 53,555,309 |
| Бусад банк дахь харилцах, хадгаламж | 37,529,715 | | 37,529,715 |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 20,089,647 | | 20,089,647 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 101,262,996 | | 101,262,996 |
| Бусад хөрөнгө | 3,126,470 | -761,698 | 2,454,772 |
| Үндсэн хөрөнгө | 2,326,444 | 75,105 | 2,401,549 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай ҮХХ | 3,590,107 | 56,244 | 3,646,351 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 2,269,534 | | 2,269,534 |
| Биет бус хөрөнгө | 807,055 | -3,796 | 803,259 |
| Борлуулах зориулалттай ҮХХ | 344,090 | | 344,090 |
| **Нийт хөрөнгө** | **224,901,367** | **-544,146** | **224,357,221** |
| Эздийн өмч ба өр төлбөр | | | |
| Өр төлбөр | | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 100,674,527 | | 100,674,527 |
| Банкнаас байршуулсан харилцах, хадгаламж | 27,048,795 | | 27,048,795 |
| Бүцаан худалдах нөхцөлтэй хэлцэл | 25,048,873 | | 25,048,873 |
| Бусад эх үүсвэр | 7,464,732 | | 7,464,732 |
| Бусад өр төлбөр | 3,363,889 | | 3,363,889 |
| Нийт өр төлбөр | 163,600,816 | | 163,600,816 |
| **Цэвэр өөрийн хөрөнгө** | **61,300,551** | **-544,146** | **60,756,405** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Банкны байгууллагын хувьд харилцагч, хадгаламж эзэмшигчдээс хүү бүхий эх үүсвэр татан төвлөрүүлсэн хөрөнгийн өртөг нь банкны үйлчилгээний орлогын өртөг байдаг.
- Банкны цэвэр хөрөнгийн шинжилгээнээс харахад, банкны мөнгөн урсгалаас тусдаа мөнгөн урсгал бий болгодог материаллаг дүн бүхий хөрөнгө нь 3,646,549 мянган төгрөгийн зах зээлийн үнэ цэнтэй Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө байна. Гэвч энэхүү хөрөнгөөс бий болгох өгөөжийг орлогын хандлагын үнэлгээний тооцоололд оруулж тооцоолсон болно.
- Үнэлгээний өдрийн байдлаар банкны эзэмшилд байгаа хөрөнгө оруулалтын үнэт цаасны ирээдүйн өгөөжийг банкны цэвэр ашиг шингээж үнэлгээний тооцоолол хийсэн учраас бизнесийн үнэлгээний үр дүнд багтсан болно.
- Үнэлгээний өдрийн байдлаар банк нь үрт хугацаатай өрийн санхүүжилт ашиглаагүй байна. Иймд банкны үнэлгээнд ашигласан орлогын хандлагын аргууд нь Цэвэр хөрөнгийн аргын үр дүнг багтаасан болно.
- Бусад хөрөнгийг зардлын шинжтэй хөрөнгийг хассан хорогдуулсан өртгөөр үнэлсэн.
- Үндсэн хөрөнгийг тооцоолсон зах зээлийн үнэ цэнээр үнэлсэн.
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тооцоолсон зах зээлийн үнэ цэнээр үнэлсэн.
- Биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, үнэ цэний бууралтыг хассан орлуулах өртгөөр үнэлсэн.
- Өртгийн хандлага нь биет бус үнэ цэнийг агуулдаггүй учраас дангаар бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илэрхийлэхгүй. Иймээс учраас бизнес үнэлгээний дүгнэлтэд энэхүү аргын үр дүнг хэрэглээгүй болно.



БОГД БАНК
Сэх
Үнэт цаасны танилцуулга 2021-11-03
БУРТГЭВ-03
266

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

## 8. Хөрөнгийн үнэлгээний үр дүн



БОГД БАНК
Унэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БУРТГЭВ-03
267

### Хөрөнгийн үнэлгээний үр дүнгийн нэгтгэл

- Бид өөрсдийн хийсэн шинжилгээ, компанийн удирдлагатай хийсэн ярилцлага, аудит хийгдсэн санхүүгийн тайланд суурилан үндсэн хөрөнгийн дансны үнэ нь зах зээлийн үнэ цэнээс материаллаг зөрүүгүй буюу эдгээр хөрөнгийн бодит үнэ цэнтэй тэнцүү байна гэж дүгнэсэн.

*Хүснэгт 27. Хөрөнгийн үнэлгээний үр дүнгийн хураангуй*

| Хөрөнгийн нэр | Үнэлгээний өдрөөрх дансны үнэ<br>Сая.төг | Тооцоолсон бодит үнэ цэнэ<br>Сая.төг | Ашигласан арга, хандлага |
|---|---|---|---|
| Барилга | 3,863 | 4,062 | Зах зээлийн хандлага |
| Тээврийн хэрэгсэл | 663 | 665 | Өртгийн хандлага |
| Тоног төхөөрөмж | 938 | 939 | Өртгийн хандлага |
| Тавилга эд хогшил | 576 | 574 | Өртгийн хандлага |
| Биет бус хөрөнгө | 801 | 803 | Өртгийн хандлага |
| Бусад хөрөнгө | 162 | 162 | Өртгийн хандлага |
| **Нийт дүн** | **7,003** | **7,206** | |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга 11- 03
268

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернешнл Лимитедийн гишүүн мөн.*

## Хавсралт


**Хавсралт А. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл**
**Хавсралт Б. Үнэлгээний нийтлэг хандлагууд**
**Хавсралт В. Капиталын жигнэсэн дундаж өртөг**
**Хавсралт Г. Жишиг компанийн мэдээлэл**
**Хавсралт Д. Меңгөн үрсгалын төсөөлөл**
**Хавсралт Е. Хорогдуулах хувийн тооцоолол**
**Хавсралт Ё. Бизнес үнэлгээний дэлгэрэнгүй тооцоолол**
**Хавсралт Ж. Хөрөнгийн үнэлгээний дэлгэрэнгүй тооцоолол**
**Хавсралт З. Мэдээллийн эх сурвалж**
**Хавсралт И. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл**
**Хавсралт К. Үнэлгээний баг**
**Хавсралт Л. Үнэлгээчний тусгай зөвшөөрөл**




БОГД БАНК

Үнэт цаасны танилцуулга

269

## Хавсралт А. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл

- Энэхүү тайланд багтсан үнэ цаний дүгнэлтэй холбогдох хязгаарлах нөхцөлийг доор хураангуйлан оруулаа.
- Энэхүү үнэлгээний тайлан нь бусад үнэлгээ эсвэл судалгаатай хамт хэрэглэгдэхгүй. Үнэлгээний дүгнэлт, тайланд багтсан судалгаа, гүйцэтгэсэн горимүүд нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд адгаэрийг тусад нь салгаж хэрэглахгүй.
- Үнэлгээг зөвхөн тайланд заасан зорилго, зориулалт, этгээдүүдэд л зориулж бэлтгэсэн. БДО Монгол-оос бичгээр зөвшөөрөл авааүй тохиолдолд тайланг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хувилах, энд дурдсан мэдээлэл, тоо, дүнг ямар нэгэн өөр зорилгоор гуравдагч этгээд ашиглахыг хориглоно.
- БДО Монгол-оос өөр байгууллага, хувь хүн тайлангийн ямар нэг хэсэгт зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно. Иймэ төрлийн өөрчлөлт орсон тохиолдолд БДО Монгол ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
- Гэрээт ажилтай холбоотой ажлын баримтыг бид хадгалж үлддэг бөгөөд үнэлгээний дүгнэлтэд тайлбар авах шаардлага гарсан тохиолдолд ажлын баримттай танилцаж болно. Гэхдээ энэ үйлчилгээ үнэлгээний гэрээт ажлын захидалд тусгайлан заагаагүй тохиолдолд нэмэлт төлбөртэй байна.
- Энэхүү тайланг БДО Монгол-оос бичгээр зөвшөөрөл авалгүйгээр бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зар сурталчилгаа хийх, хэвлал мэдээллийн хэрэгсэл болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж олон нийтэд түгээх, Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо эсвэл Засгийн Газрын бусад байгууллагад санал өгөхөөс өөрөөр хувийн болон олон нийтэд мэдээлэл өгөхдөө иш татах зэргээр нийтэд дэлгэх, түгээхийг хориглоно.
- Үнэлгээний өдрөөс хойш гарсан дүгнэлтэд нөлөөлж болох аливаа үйл явдал, нөхцөл байдалд бид ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй.
- Энэхүү үнэлгээнд ашигласан зарим таамаглал эсвэл төсөөлөл нь хэрэгжихгүй байж болох ба үрьдчилан төсөөлөөгүй үйл явдал үүсэж болзошгүй. Үүнд: эдийн засгийн томоохон өөрчлөлт; зах зээлийн томоохон өөрчлөлт; татвар ба бусад хууль зүйн орчинд гарсан томоохон өөрчлөлтүүд багтана. Тиймээс төлөвлөсөн хугацаанд бодит үр дүн нь хөрөнгө оруулагчийн шаардлагаас өөр байх магадлалтай. Энэ хэлбэлзэл нь материаллаг байж болох ба үнэлгээний тайланд багтсан үнийн дүнд нөлөөлж болзошгүй.
- Ирээдүйн үйл явдалтай холбоотой төсөв/урьдчилсан таамаглал/прогноз зэрэг нь төлөвлөсөн хугацаанд хүчинтэй хэвээр байна гэсэн төсөөлөлд суурилсан боловч энэ нь биелэхгүй байж болно. Иймэ учраас төсөвлөсөн/урьдчилсан төсөөлөл нь бодит дүнтэй хэр ойрхон буух тал дээр бид ямар нэгэн дүгнэлт гаргаагүй болно.
- Удирдлагаас болон түүнээс эрх олгогдсон төлөөллөөс бидэнд өгсөн мэдээллийн үнэн зөв байдал эсвэл иж бүрэн байдалд бид ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй.
- Энэхүү ажлыг хийхтэй холбоотой гэрээгээр урьдчилан тохиролцуй эсвэл үйлчлүүлэгчийн зүгээс хүсэлт тавьж, нэмэлт төлбөр санал болгож, урьдчилсан тохиролцоо хийгээгүй л бол бид үнэлсэн хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн гэрчийн мэдүүлэг өгөх, шүүх хуралд оролцох, захиргааны үйл ажиллагаанд оролцох үүрэг хүлээхгүй.
- Энэхүү тайланг зөвхөн тайланд дурдсан зориулалтаар хэрэглэх бөгөөд тайлан нь иж бүрнээрээ байхдаа хүчинтэй байна. Тайланд эцсийн байдлаар оруулсан тооцоолсон зах зээлийн үнэ цэн нь зөвхөн үнэлгээний өдрөөр хүчинтэй байна.
- Үйлчлүүлэгчийн төлөвлөгчийн бидэнд өгсөн нягтлан бодох бүртгэлийн болон хууль эрх зүйн мэдээллийн үнэн зөв байдалтай холбоотой санал дүгнэлтийг БДО Монгол-оос гаргаагүй бөгөөд бид хөрөнгийн эзэмшлийн эрхэд ямар нэгэн дью дилижинсийн үйлчилгээ үзүүлээгүй болно.
- Зөвхөн тайланд багтсан төсөөлөл ба хязгаарлах нөхцөлүүдээр л БДО Монгол-ын гүйцэтгэсэн шинжилгээ болон дүгнэлт хязгаарлагдана.
| Өмчийн өртөг | 16.00% | 16.00% | 16.00% | 16.00% | 16.00% | 16.00% | 16.00% | 16.00% |
| Хорогдуулах үе | | 0.50 | 1.50 | 2.50 | 3.50 | 4.50 | 5.50 | 6.50 |
| Хорогдуулах хүчин зүйл | | 0.93 | 0.80 | 0.69 | 0.59 | 0.51 | 0.44 | 0.38 |
| **Илүүдэл ашгийн өнөөгийн үнэ цэнэ** | | **(427)** | **(4,386)** | **(768)** | **3,180** | **7,116** | **8,155** | **8,889** |
| **Терминал өнөөгийн үнэ цэнэ** | | | | | | | | 84,848 |
| **Илүүдэл ашгийн өнөөгийн үнэ цэнэ** | | | | | | | | 21,758 |
| Өмчийн дансны үнэ | | | | | | | | 61,301 |
| **Өмчийн 100%-ийн хяналттай хувь оролцооны үнэ цэн** | | | | | | | | **167,906** |
| **23.7%-ийн Хяналтгүйн хөнгөлөлтийн дараах Өмчийн 100%-ийн үнэ цэн** | | | | | | | | **128,112** |

Мэдрэмжийн шинжилгээ

| | 3% | 4% | 5% | 6% | 7% |
|---|---|---|---|---|---|
| 14.0% | 195,468 | 206,684 | 220,392 | 237,527 | 259,557 |
| 15.0% | 172,680 | 181,250 | 191,490 | 204,030 | 219,706 |
| 16.0% | 153,485 | 160,395 | 168,808 | 177,280 | 188,737 |
| 17.0% | 137,110 | 142,278 | 148,308 | 155,433 | 163,984 |
| 18.0% | 122,985 | 127,064 | 131,771 | 137,262 | 143,751 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
БОГД БАНК
287
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03

*Хүснэгт 39. Ногдол ашиг хорогдуулах загвар – Гүтранги төсөөлөл*

| Таамаглал | |
|---|---|
| Өмчийн өртөг ('CoE') | 17.5% |
| Байгууллагын өсөлтийн хувь ('g') | 5.0% |
| Ногдол ашиг төлөлтийн % | 100% |

Ногдол ашиг хорогдуулах загвар

| сая төгрөгөөр | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 | TV |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Цэвэр ашиг** | 5,617 | 9,348 | 10,820 | 15,186 | 21,645 | 30,177 | 34,747 | 39,624 | |
| Ногдол ашиг төлөлт | | 0% | 0% | 100% | 100% | 100% | 100% | 100% | |
| **Ногдол ашиг** | | 0 | 0 | 10,820 | 15,186 | 21,645 | 30,177 | 34,747 | |
| Хорогдуулах үе | | 0.50 | 1.50 | 2.50 | 3.50 | 4.50 | 5.50 | 6.50 | 6.50 |
| Хорогдуулах хүчин зүйл | | 0.92 | 0.79 | 0.67 | 0.57 | 0.48 | 0.41 | 0.35 | 0.35 |
| **Хорогдуулсан ногдол ашиг** | | 0 | 0 | 7,290 | 8,636 | 10,476 | 12,430 | 12,181 | 102,318 |
| Прогнозын хугацааны хорогдуулсан ногдол ашгийн өнөөгийн үнэ цэнэ | 50,952 | 32% | | | | | | | |
| Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ | 102,318 | 68% | | | | | | | |
| **Өмчийн 100%-ийн үнэ цэнэ** | **153,270** | | | | | | | | |

Мэдрэмжийн шинжилгээ

| | 3% | 4% | 5% | 6% | 7% |
|---|---|---|---|---|---|
| 15.5% | 167,532.4 | 178,474.8 | 191,501.4 | 207,270.4 | 226,749.8 |
| 16.5% | 151,318.9 | 160,208.5 | 170,644.2 | 183,067.5 | 198,106.3 |
| 17.5% | 137,477.2 | 144,788.8 | 153,270.4 | 163,226.5 | 175,079.4 |
| 18.5% | 125,542.0 | 131,620.1 | 138,598.6 | 146,693.8 | 156,196.8 |
| 19.5% | 115,161.0 | 120,261.1 | 126,064.7 | 132,728.0 | 140,457.5 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
288

*Хүснэгт 40. Ногдол ашиг хорогдуулах загвар – Өөдрөг төсөөлөл*

| Таамаглал | |
|---|---|
| Өмчийн өртөг ('CoE') | 16.0% |
| Байнгын өсөлтийн хувь ('g') | 5.0% |
| Ногдол ашиг төлөлтийн % | 100% |

Ногдол ашиг хорогдуулах загвар

| сая төгрөгөөр | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 | TV |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Цэвэр ашиг** | 5,617 | 9,348 | 10,820 | 15,186 | 21,645 | 30,177 | 34,747 | 38,624 | |
| Ногдол ашиг төлөлт | | 0% | 0% | 100% | 100% | 100% | 100% | 100% | |
| **Ногдол ашиг** | | 0 | 0 | 10,820 | 15,186 | 21,645 | 30,177 | 34,747 | |
| Хорогдуулах үе | | 0.50 | 1.50 | 2.50 | 3.50 | 4.50 | 5.50 | 6.50 | 6.50 |
| Хорогдуулах хүчин зүйл | | 0.93 | 0.80 | 0.69 | 0.59 | 0.51 | 0.44 | 0.38 | 0.38 |
| **Хорогдуулсан ногдол ашиг** | | 0 | 0 | 7,466 | 9,033 | 11,099 | 13,340 | 13,242 | 126,397 |
| Прогнозын хугацааны хорогдуулсан ногдол ашгийн өнөөгийн үнэ цэнэ | 54,180 | 30% | | | | | | | |
| Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ | 126,397 | 70% | | | | | | | |
| **Өмчийн 100%-ийн үнэ цэнэ** | **180,577** | | | | | | | | |

Мэдрэмжийн шинжилгээ

| | 3% | 4% | 5% | 6% | 7% |
|---|---|---|---|---|---|
| 14.0% | 197,735.6 | 213,101.2 | 231,881.4 | 255,356.6 | 285,539.0 |
| 15.0% | 176,716.6 | 188,920.7 | 203,565.7 | 221,465.0 | 243,839.3 |
| 16.0% | 159,094.5 | 168,940.9 | 180,377.3 | 194,541.4 | 211,608.4 |
| 17.0% | 144,133.8 | 152,184.4 | 161,576.7 | 172,676.6 | 185,996.6 |
| 18.0% | 131,295.5 | 137,953.6 | 145,636.0 | 154,598.8 | 165,191.1 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



Үнэт цаасны танилцуулга

**Хавсралт Ж. Хөрөнгийн үнэлгээний дэлгэрэнгүй тооцоолол**

*Хүснэгт 41. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үр дүн (сая төгрөгөөр)*

| Хөрөнгийн нэр | Санкүүгийн тайланд тусгасан байдал | Үнэлгээний одрийн байдлаарх дансны үнэ | ҮХХ-ын хүлээн зөвшөөрсөн анхны өртөг | Ашиглалтад оруулсан огноо | Цаашид ашиглах хугацаа | Орлогын хандлагаар тооцсон үр дүн | Зах зээлийн хандлагаар тооцсон үр дүн | Тооцоолсон бодит үнэ цэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хүүлийн тудамж, 4/2-р байр А блок хаягт байрлах контор, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө | Барилга | 313 | 349 | 2008 | 72 жил | 448 | 415 | 415 |
| | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 3,550 | 3,951 | 2008 | 72 жил | 2,838 | 3,646 | 3,646 |
| **Нийт дүн** | | **3,863** | **4,300** | | | **3,286** | **4,062** | **4,062** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

**Үнэлгээчдийн дүгнэлт:**

***Бид Богд банкны үнэлгээний өдрөөрх үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг Үнэлгээний орлогын хандлага болон зах зээлийн хандлагын тохирох аргуудаар тооцоолж, банкны нягтлан бодох бүртгэл дэх дансны үнэтэй харьцуулан шинжилсний үндэсн дээр зах зээлийн хандлага нь үнэлгээний дүгнэлтийг дэмжиж гэж үзсэн. Гэвч эцэхүү үнэ цэн нь Банкны бизнесийн үнэлгээний зүсийн үр дүнд нөлөөлөх хэмжээнд материаллаг нөлөөгүй байгаа тодорхойлсон.***



290

*Хүснэгт 42. Тээврийн хэрэгслийн үнэлгээний үр дүн (сая төгрөгөөр)*

| д/д | Хөрөнгийн нэр | Нэгж өртөг | Үнэлгээний өдрөөрх дансны үнэ | Тээврийн хэрэгслийн Улсын дугаар | Ангилал, хөдөлгүүрийн багтаамж | Үйлдвэрлэсэн он | Зах зээлийн хандлагаарх үнэ цэн | Өртгийн хандлагаарх үнэ цэн | Тооцоолсон бодит үнэ цэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | LEXUS-570 | 260 | 256 | 00-54 УНМ | B, 5663 | 2017 | 254 | 258 | 258 |
| 2 | SONATA-7 | 6 | 6 | 11-83 УНЗ | B, 2000 | 2010 | 8 | 6 | 6 |
| 3 | PRIUS-30 | 19 | 15 | 60-46 УНО | B, 1797 | 2010 | 14 | 15 | 15 |
| 4 | ALPHARD | 40 | 31 | 64-25 УББ | B, 2360 | 2013 | 33 | 31 | 31 |
| 5 | PRIUS-30 | 15 | 11 | 60-43 УНР | B, 1797 | 2011 | 13 | 11 | 11 |
| 6 | CAMRY | 26 | 23 | 30-71 УБЕ | B, 2493 | 2013 | 23 | 23 | 23 |
| 7 | ГАЗ-13 ЧАЙКА | 200 | 145 | 87-08 УБЯ | B, 5530 | 1961 | 264 | 145 | 145 |
| 8 | MAYBACH S600 | 321 | 177 | 00-71 УБС | B, 6980 | 2014 | 271 | 177 | 177 |
| | **НИЙТ** | **888** | **663** | | | | **879** | **665** | **665** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

*Хүснэгт 43. Бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний үр дүн (сая төгрөгөөр)*

| Хөрөнгийн нэр | Үнэлгээний өдрөөрх дансны үнэ | Өртгийн хандлагаарх үнэ цэн | Тооцоолсон бодит үнэ цэн |
|---|---|---|---|
| Тоног төхөөрөмж | 938 | 939 | 939 |
| Тавилга эд хогшил | 576 | 574 | 574 |
| Биет бус хөрөнгө | 801 | 803 | 803 |
| Бусад хөрөнгө | 162 | 162 | 162 |
| **Нийт дүн** | **2,477** | **2,479** | **2,479** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

**Үнэлгээчдийн дүгнэлт:**

***Бид Богд банкны үнэлгээний өдрөөрх тээврийн хэрэгсэл болон бусад үндсэн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг Үнэлгээний өртгийн хандлага болон зах зээлийн хандлагын тохирох аргуудаар тооцоолж, банкны нягтлан бодох бүртгэл дэх дансны үнэтэй харьцуулан шинжилсний үндсэн дээр дансны үнэ нь зах зээлийн үнэ цэнээсээ Банкны бизнесийн үнэлгээний зүсийн үр дүнд нөлөөлөх хэмжээнд материаллаг нөлөөгүй байгааг тодорхойлсон.***



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
291

## Хавсралт 3. Мэдээллийн эх сурвалж

- Энэхүү тайланг бэлтгэхэд ашиглагдсан мэдээллийн үндсэн эх сурвалжид дараах зүйлс хамаарна:
  - 2018-2020 оны СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн, аудитлагдсан түүхэн санхүүгийн тайлан, тэдгээртэй холбогдох тодруулгууд;
  - 2021 оны 3-р сарын 31-нээрх аудитлагдаагүй санхүүгийн мэдээлэл;
  - Компанийн түүгээ зөвшөөрөл, дүрэм болон бусад холбогдох эрх зүйн баримт бичиг;
  - 2021-2027 оны санхүүгийн болон бизнесийн төлөвлөгөө;
  - Та бүхнээс биднэд ирүүлсэн бусад мэдээлэл ба баримт.

- Бидний ашигласан бусад хөндлөнгийн мэдээллийн эх сурвалжид:
  - БДО Монгол-ын 2020-2021 онд бэлтгэсэн Банкны салбарын судалгааны тайлан
  - Үндэсний Статистикийн Хорооны нийтлэл 2020
  - МХБ-ийн цахим хуудас
  - БДО Монгол-ын банкны салбарын арилжааны дотоод мэдээлэл
  - БДО Монгол-ын IPO өгөгдлийн сан
  - BDO Global – Horizon Issue 2 | 2021
  - Bloomberg Market Data жишиг компанийн мэдээллийн сан
  - S&P Capital IQ, PitchBook арилжааны өгөгдлийн сан, жишиг компаниудын үнэлгээний параметрүүд;
  - Pratt's Stats арилжааны өгөгдлийн сан, жишиг компанийн мэдээллийн сан
  - Reuters агентлагийн жишиг компанийн мэдээллийн сан
  - Монголын Банкны Холбоо, 2020 оны 4-р улирлын тайлан
  - АХБ, ОУВС, Монголбанк, СЗХ, УСГ-аас хэвлэн нийтэлдэг мэдээллүүд.

- Бидний судалсан бусад хууль эрх зүйн бичиг баримтууд:
  - Хөрөнгийн үнэлгээний тухай хууль
  - Банкны тухай хууль
  - Компанийн тухай хууль
  - Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль
  - Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
  - Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолууд

- Үнэлгээ нь үнэлгээний өдрийн байдлаар хүчин төгөлдөр байгаа мэдээлэлд үндэслэн бэлтгэгдсэн. Бид хөндлөнгийн эх сурвалжаас авсан мэдээллээс бусад энэ тайланд багтсан эсвэл биднэд ирүүлсэн аливаа мэдээлэл, мэдээллийн эх сурвалжид хариуцлага хүлээхгүй.

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

**Хавсралт И. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл**

**Бид дараах зүйлсийг баталж байна:**

- Энэхүү тайланд багтсан мэдэгдлүүд нь үнэн зөв бөгөөд алдаагүй;
- БДО Аудит ХХК-д үйлчлүүлагчийн хөрөнгө эсвэл оролцогч этгээдүүдтэй холбоотой ямар нэгэн өөрөөгийн эсвэл ирээдүйн хувь оролцоо, ялгаварлах үзэл байхгүй болно.
- Бидний шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа авч ашигласан суурь мэдээллүүд үнэн зөв ба алдаагүй болно. Энэхүү тайланд багтсан мэдээлэл, тооцоолол, дүгнэлт буюу үнэ цэнийн талаарх дүгнэлт нь үнэн зөв, алдаагүй бөгөөд найдвартай эх үүсвэрээс авсан мэдээлэлд суурилсан. Гэсэн хэдий ч эдгээр зүйлсийн үнэн зөв байдлын талаар өндөр түвшинд баталгаа гаргахгүй.
- Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, таамаглалууд нь ажлын зорилготой нийцэх ба үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангуй бодитой тооцоолсон гэж үзэж байна.
- Тайлагнасан шинжилгээ, дүгнэлт нь тайлагнасан таамаглал ба хязгаарлах нөхцөлөөр л хязгаарлагдсан бөгөөд эдгээр нь бидний хувийн бөгөөд тусгайлан ялгаварлан авч үзээгүйгээр гаргасан мэргэжлийн шинжилгээ, шийдэл, дүгнэлт болно;
- БДО Аудит ХХК болон бидний зүгээс үнэлэгдсэн өмчид ямар нэгэн алс хэтийн хувийн ашиг сонирхол, хувь оролцоо байхгүй бөгөөд оролцсон талуудтай ямар нэгэн хувийн ашиг сонирхол байхгүй болно;
- Үнэлгээний объект буюу үнэлгдэж буй хөрөнгө нь энэ гэрээт ажилд оролцсон этгээдүүдтэй ямар нэгэн холбоогүй болно;
- Үнэлгээчид болон БДО нь Богд Банк ХХК, түүний охин болон хараат компаниудтай ашиг сонирхлын холбоогүй;
- Энэ гэрээт ажилд оролцсон манай баг урьдчилан тодорхойлсон дүнг гаргах зорилгоор ажиллаагүй болохыг баталж байна;
- Энэ гэрээт ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой бидний ажлын хөлс нь урьдчилан тодорхойлсон дүнг болон сүүлж тайлагнах эсвэл үйлчлүүлагчийн хүслийг биелүүлэх, болзолт үр дүн гаргах зэргээс хамааралгүй болно;
- Бидний хийсэн шинжилгээ, мэргэжлийн шийдэл, дүгнэлт нь Хөрөнгийн үнэлгээний тухай Монгол Улсын хууль, Үнэлгээний олон улсын стандарт, Үнэлгээчдийн ёс зүйн дүрмийн шаардлагад нийцэж байгаа болно;
- Энэхүү баталгааг энд гарын үсэг зурсан Түгээй зөвшөөрөл эзэмшигч үнэлгээчид болон БДО Аудит ХХК-ийн эрх бүхий удирдлагууд гаргаж байгаа бөгөөд энэхүү ажилд оролцсон бусад мэргэжилтнүүдэд хамаарахгүй.



БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
-11- 03
293

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

## Хавсралт К. Үнэлгээний баг

**Г. Баянмөнх**
**Үнэлгээний партнер**
БДО Монгол
Холбоо барих:
+976 9111 4040
+976 7740 4040
bayanmunkh@bdo.mn

Баянмөнх нь Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн татварын зөвлөх, мэргэшсэн үнэлгээчин бөгөөд БДО Монголын арилжааны үйлчилгээний нэгжийг удирддаг. Тэрээр бизнес өмчийн үнэлгээ, санхүүгийн дью дилижинс, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээгээр мэргэшсэн 25 жилийн туршлагатай.

Баянмөнх нь үүл үүрхай, хөдөө аж ахуй, ам үйлдвэрлэл, үл хөдлөх, төмөр зам, банк, барилга, хөнгөн болон хүнд үйлдвэр, даатгал, харилцаа холбоо зэрэг олон төрлийн салбарын үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгч байсан. 2018 онд тэрээр Мандал Даатгал ХХК, Ард Даатгал ХХК-ийг багтаасан нийт таван IPO төсөлд оролцсон бөгөөд олон тооны стратегийн хөрөнгө оруулагч татах төсөлд харааг бүс үнэлгээчнээр ажилласан.

**Ж. Энхчимэг**
**Үнэлгээчин**
БДО Аудит ХХК
Холбоо барих:
+976 8810 1043
+976 7740 4040
enkhchimeg@bdo.mn

Энхчимэг нь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн үнэлгээний чиглэлээр мэргэшсэн үнэлгээний мэргэжилтэн юм. Тэрээр 2007 онд хөрөнгийн үнэлгээ хийх түгээй зөвшөөрөл авч, 2012 онд БДО олон улсын сүлжээний Монгол дахь оффист нэгдсэн.

Энхчимэг нь Монголын Мэргэшсэн Үнэлгэчдийн Институт (CA), Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (CPA), ТМЗ-ийн нийгэмлэгийн гишүүн (CTA) юм.

**Б. Энх-Оргил**
**Шинжээч**
БДО Монгол
Холбоо барих:
+976 8013 9559
+976 7740 4040
enkh-orgil@bdo.mn

Энх-Оргил нь 2017 онд БДО-д нэгдсэн бөгөөд одоогоор БДО Монголын арилжааны үйлчилгээний нэгжид шинжээчээр ажиллаж байна. Тэрээр АНУ-ын Колорадагийн Их Сургуулиас санхүү-хөрөнгө оруулалтын чиглэлээр бакалаварын зэрэг болон эдийн засгийн минорын зэргийг авсан бөгөөд стратегийн хөрөнгө оруулалт татах зорилготой үнэлгээний үйлчилгээгээр мэргэшсэн.

2018 онд тэрээр Мандал Даатгал ХХК, Ард Даатгал ХХК-ийн IPO төсөл болон стратегийн хөрөнгө оруулагч татах хэд хэдэн төсөлд шинжээчээр ажилласан. Энх-Оргил нь CFA Level II цол горилогч юм.

**Ю. Төрменх**
**Шинжээч**
БДО Монгол
Холбоо барих:
+976 9902 5841
+976 7740 4040
turmunkh@bdo.mn

Төрменх нь аудит, дотоод аудит, зах зээлийн судалгаа, санхүүгийн загвар боловсруулсан туршлагатай.

Тэрээр АНУ-ын Hyatt Hotels Corp болон Hilton Worldwide Inc-д дотоод аудитор болон шинжээчээр ажиллаж байсан туршлагатай бөгөөд 2017 онд БДО-д нэгдсэн. Төрменх нь мөн БДО Монголын Аудит ба Баталгаажуулалтын шугамд ажилласан туршлагатай.

Төрменх нь АНУ-ын Томас Эдисоны Их Сургуульд санхүү, удирдлагын мэргэжлээр бакалаврын зэрэг эзэмшсэн.



BDO

БОГД БАНК
БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТТЕ8066 - 5903658
294
БОГД БАНК
Үнэт цаасны танилцуулга
СЭХ
2021 -11- 03

**Хавсралт К. Үнэлгээний баг (үргэлжлэл)**

**Ч. Номингэрэл**
**Түслах шинжээч**
БДО Монгол
Холбоо барих:
+976 9988 2691
+976 7740 4040
nomingerel@bdo.mn

Номингэрэл нь 2020 онд БДО-д нэгдсэн бөгөөд Петро Матад ХХК-д ажиллаж байсан туршлагатай.

Номингэрэл нь Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр бакалаврын зэрэг эзэмшсэн. Тэрээр CFA Level I цол горилогч юм.

**Б.Одгэрэл**
**Үнэлгээчин**
БДО Монгол
Холбоо барих:
+976 88037830
+976 7740 4040
odgerel@bdo.mn

Одгэрэл нь 2021 онд БДО-д нэгдсэн бөгөөд Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн татварын зөвлөх, мэргэшсэн үнэлгээчин.

Одгэрэл нь Монгол Улсын Их Сургуулийг адийн засаг-нягтлан бодогч мэргэжлээр төгссөн бөгөөд Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

Тэрээр санхүүгийн салбарт ажилласан 20 жилийн туршлагатай.



БОГД БАНК
БОГД БАНК
УЛААНБААТАР ХОТ
СЭХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
Үнэт цаасны танилцуулга
295

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
БҮРТГЭВ-03



САНГИЙН ЯАМ

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 07/2009/

Иргэний үүсгэн байгуулагч: Мунхбат

Иргэний овог нэр: Гэндэн нэртэй Баяжмөнх

Иргэний иргэншлийн дугаар: УБ62062017

Иргэний бүртгэлийн дугаар: РП17042814

Үнэлгээний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: УБ 14м8м93, Нэйсмит, 63Д, 12-р давхар, Юрисмал оффис 601-609 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2010/1/270-ын тушаал 189 тоот хавсралт

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эрхэлж суугаасан хаягаас хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 6.3 дахь хэсэг заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хэрэгжүүлэх журам батлагдах хүртэл хугацаанд мөрдөнө.

САНГИЙН САЙД С.БАЯРЦОГТ

УЛААНБААТАР ХОТ

Хавсралт Л. Үнэлгээчний тусгай зөвшөөрөл

Монгол улсын хөгжлийг дэмжих корпорацийн компанид болон БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн нөхөрлөл

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2013 оны 286 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг
2013 оны 12 сарын 20-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД Ч.УЛААН

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20 17 оны 1 дүгээр тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг
20 17 оны 1 сарын 11-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД Б.ЧОЙЖИНХҮҮ

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20 19 оны 262 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг
20 19 оны 12-р сарын 17-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
ГҮРТГЭВ
№ 01

ГҮРТГЭВ-03



САНГИЙН ЯАМ

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ**

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар 97120005З

Иргэний үнэмлэхний олгосон газар: Хэнтий

Иргэний овог, нэр: Жанцангийн очирхүү Энхчимэг

Иргэний үнэмлэхний дугаар: ЛА03539З6

Иргэний регистрийн дугаар: ТЕ:65050264

Үнэлгээний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: Дархан-уул Дархан 9-р баг 4-р гэрээлэл 4-133 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Санхүүгийн сайдын 2019/03/320-оон тоот 280 дугаар тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эзэнд сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Энэхүү үнэмлэхэнд тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг /зөвшөөрөлд заасан эзэмшүүлэгч нь зөвшөөрөлтэй холбоотой бичиг баримтыг, баталгаа, барьцаалах зүйлс шилжүүлэх үүсгэх/

САНГИЙН САЙД С.БАЯРЦОГТ

УЛААНБААТАР ХОТ

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Санхүүгийн сайдын 2017 оны 12-р сарын 01-ны өдрийн 2 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД Ч.ҮЛЗААН

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Санхүүгийн сайдын 2017 оны 4-р сарын 11-ны өдрийн 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД Б.ЧОЙЖИЛСҮРЭН

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Санхүүгийн сайдын 2020 оны 12-р сарын 01-ны өдрийн 3 жилийн хугацаагаар сунгав

САНГИЙН САЙД ЧАНТХҮЛЭГИЙН ЧАНЦАЛХҮҮ

Мөнгөн угаах, хөрөнгө, эдийн хорлуулалтыг хориглох тухай Монгол улсын хууль, Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу БДО Аудит ХХК нь Ик Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн фирм.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТГЕ8966 - 5903858

СЗХ
2021 -11- 10
БҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

Хувьцаа | Богд банк ХХК-ийн бизнес хариуцлагын үнэлгээний тайлан

САНГИЙН ЯАМ

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 141800a

Иргэний үүрэн овог: Хатуул

Иргэний өөрийн: Батбаяасүрэнгийн Оюунцэцэг

Иргэний үнэмлэхний дугаар: УЭ37803069

Иргэний бүртгэлийн дугаар: 9737803069

Үнэлгээчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17-р хороо, 1-р хороолол 73-р байр 61 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 354 дүгээр тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд түүнийг төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд түүнд хуулийн болон бусад хэлбэрээр хамгаалагдсан эрх, ашиг сонирхол хамаарахгүй болно.

САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР

УЛААНБААТАР ХОТ

Хавсралт Л. Үнэлгээчний тусгай зөвшөөрөл (үргэлжлэл)

Монгол улсын хөрөнгө оруулалтын корпорацийн комисс бөгөөс БДО Аудит ХХК-ийн Ахлах Батлагчийн Нягтлан Бодох Бүртгэлийн Институтийн гишүүнчлэлийн үнэмлэх.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20 21 оны 4 дүгээр тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20 21 оны 03 -р сарын 23-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20 .... оны .... дүгээр тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20 .... оны ....-р сарын ....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20 .... оны .... дүгээр тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20 .... оны ....-р сарын ....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД

BDO
БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ58966 • 5903658

СЭХ
2021 оны 10 сарын
БУРТГЭВ
№ 01

БОГД БАНК
ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

Үнэт цаасны танилцуулга

MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БУРТГЭВ-03

Хүчинтэй | Богд банк ХХК-д бизнес харилцагч нээлгэнэ үү.

NOMIN INSURANCE

# INSURANCE CERTIFICATE
## №020

This certificate confirms that the Third Party Liability Insurance contract is made and entered into by and between "NOMIN INSURANCE" LLC and "BDO AUDIT" LLC with following terms and conditions.

| | | |
|---|---|---|
| Type of Insurance: | THIRD PARTY LIABILITY INSURANCE | |
| Insurer: | NOMIN INSURANCE LLC | |
| Insured: | "BDO AUDIT" LLC | |
| Contract No: | ND/201-12-2-50047404 | |
| Period of insurance: | Commencement:<br>Termination: | Sep 05.2020, 00.00<br>Sep 04.2021, 00.00 |
| Insurance item | ✓ Legal liability of the Insured to its clients and customers arising out of the Insured and its employees' professional negligence, misconduct, malpractice and lack of skill. | |
| Risks | ✓ A Court or other professional supervisory authorities recognized property loss of or damage to a client, customer or third party caused by the issue of inaccurate report, the disclosure of confidential information or the incorrect consultation by the Insured.<br>✓ Monetary penalty imposed on an auditor or an audit organization by a relevant professional body or court according to applicable law due to unsatisfactory services rendered by breaching operational principles or lack of professional skills.<br>✓ The court or other professional authorities recognized property loss of or damage to clients, customers or third party caused by incorrect tax consultation. | |
| The Sum Insured: | 800,000 USD ( eight hundred thousand) | |

This certificate is issued on October 23th, 2020 by "NOMIN INSURANCE" LLC for "BDO AUDIT" LLC.

"NOMIN INSURANCE" LLC
EXECUTIVE DIRECTOR
НОМИН ДААТГАЛ
JAVKHLANTSOGT.B

7/F, Nomin United Office Building, Khan-Uul district, Chinggis Avenue 23, P.O.Box 668, Ulaanbaatar 210644, Mongolia
Tel: 976-1800-2888,75778888. E-mail: insurance@nomin.net

Хавсралт Л. Үнэлгээчний туслай зөвшөөрөл (үргэлжлэл)

Монгол улсын хэмжээнээ харилцагчдаа хамгийн богцох БДО Аудит ХХК-ийг Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитэдийн компани юм.

BDO

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТГ68966 - 5903858

ОН ХУВЬ ХИЙХ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 оны 10 сар
БҮРТГЭВ
№ 31

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

## ХУУЛИЙН КОМПАНИЙН ДҮГНЭЛТ

DB&GTS

2021.06.30 № 01/723

### ХУУЛИЙН ДҮГНЭЛТ

**Нэг. Оршил**

А. Өмгөөллийн Ди Би энд Жи Ти Эс ХХН нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 336 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтад заасан Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн билээ.

Б. Монгол Улсын хуулийн этгээд болох Богдбанк ХХК (цаашид **"Банк"** эсхүл **"Үнэт цаас гаргагч"** гэх) хувьцаагаа нийтэд анхлан нээлттэй санал болгох гэж буйтай холбогдуулан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1, 10.6, 11 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дах хэсэг, Үнэт цаасны бүртгэлийн журмын 4.2.2-т заасныг тус тус удирдлага болгон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, баримт бичиг хууль зүйн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр энэхүү Хуулийн дүгнэлтийг гаргаж байна.

В. Энэхүү Хуулийн дүгнэлтэнд хэрэглэсэн нэр томъёоны тайлбарыг **Хавсралт 1**-т тодорхойлж, Үнэт цаасны танилцуулга болон Хуулийн дүгнэлттэй холбогдох Үнэт цаас гаргагчийн Эрх бүхий албан тушаалтны батламж бичгийг **Хавсралт 2**-т, Банкны дотоод дүрэм, журмын жагсаалтыг **Хавсралт 3**-т, Хуулийн дүгнэлттэй холбогдуулан төрийн байгууллагуудаас авсан лавлагаа, тодорхойлолтын хуулбарыг **Хавсралт 4**-т тус тус дурьдсан болно.

**Хоёр. Тайлбар, мэдэгдэл**

1. Энэхүү Хуулийн дүгнэлтийг гаргахуу үг дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжид үндэслэн Банкнаас бидэнд дэлгэсэн баримт бичиг, мэдээллийн хүрээнд гаргасан болно. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагуудаас тодорхойлолт, лавлагаа авсан болно.

2. Хуулийн дүгнэлтийг хууль, тогтоомжинд тавигдсан шаардлагыг Банк хэрхэн мөрдөж, биелүүлж ажиллаж байгаа талаар харьцуулалт, шалгалт хийх замаар боловсруулсан болно. Түүнээс бус аливаа үйл явдлыг тайлбарлах зорилго агуулахгүй болно.

3. Хэндлэнгийн хуульчийн хувьд мэдэх боломжгүй, Банкнаас дэлгээгүй орхисон аливаа чухал мэдээлэл байвал тийнхүү олж мэдээгүйгээс үүдэн гарах асуудалд бид хариуцлага хүлээхгүй.

4. Бид Банкны баримт бичгүүдтэй Банкны байранд танилцаж, Банкны зөвшөөрсөн хүрээнд баримт бичгүүдийг хуулбарлан авч, тодорхой тооны баримт бичгүүдийг Банкнаас бидэнд хуулбарлан хүргүүлж, цахим шуудангаар илгээснээр тэдгээртэй танилцаж, шинжлэн судалж, зарим албан тушаалтнуудтай цахим хэлбэрээр болон биечлэн уулзсан боловч тус компанийн шийдвэр гаргах түвшний бүх хүмүүс, тэр дундаа ТУЗ-ийн бүх гишүүдтэй биечлэн уулзаагүй болно.



Өмгөөллийн Ди Би энд Жи Ти Эс ХХН
Утас: +976 1133 1020, Факс: +976 7011 5060 И-мэйл: info@dblaw.mn www.dblaw.mn
Хаяг: Монгол улс, Улаанбаатар-14251, Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө -24, Парк Плейс, 705 тоот

БОГД БАНК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 5903858

300

СЗХ
2021 оны 10 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 21

MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

5. Үнэт цаас гаргагчаас бидэнд ирүүлсэн мэдээлэл, баримт бичгийн үнэн зөвийг баталгаажуулах, нэмэлт мэдээлэл авах зорилгоор бид Үнэт цаас гаргагчийн эрхим албан тушаалтнууд, газар, хэлтсийн захирлуудтай цахим хэлбэрээр ярилцлага хийсэн.

6. ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтнуудын гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаарх мэдээллийг Цагдаагийн Ерөнхий Газраас бидэнд гаргаж өгсөгүй тул тэдгээр нь Үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны зохистой засаглалын зарчим, Компанийн засаглалын кодекст тавьсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг бид гагцхүү тэдний өөрсдийн бичгээр гаргаж өгсөн баталгаа, Монголбанк болон СЗХ-нд бүртгүүлсэн бүртгэлийн нотолгоо, Монголбанкнаас бидэнд ирүүлсэн лавлагаа мэдээлийг үндэслэн баталгаажуулсан болно.

7. Энэхүү Хуулийн дүгнэлтийг бид гагцхүү Банкнаас хувьцаагаа нийтэд анхлан нээлттэй санал болгох гэж буйтай холбогдуулан гаргаж буй бөгөөд аливаа бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

**Гурав. Хуулийн дүгнэлт**

**1. Хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн байдал**

*1.1. Хуулийн шаардлага:*

Банкны тухай хуулийн 3 дугаар бүлэгт зааснаар банкийг Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр байгуулж, Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан банкийг Монгол Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар (**"Хуулийн этгээдийн бүртгэлийн газар"**)-т бүртгүүлэх үүрэг хүлээдэг.

*1.2. Үүсэн байгуулсан байдал:*

Банк нь Бодь Капитал ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хурлын 14/05 тоот тогтоолоор хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэйгээр үүсгэн байгуулагдаж, Компанийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 2014 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр зохих ёсоор бүртгэгдсэн байна.

*1.3. Улсын бүртгэлд бүртгүүлсэн байдал:*

Банк нь Монгол Улсын хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдаж, банкны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монголбанкнаас 2014 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр А-175 тоот зөвшөөрөл авсны үндсэн дээр Банкны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн дагуу Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт 2014 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр албан ёсоор бүртгэгдсэн нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг бүрэн хангаж байна.

9016001020 тоот улсын бүртгэлийн дугаар, 5903858 тоот регистрийн дугаартай Банк нь хуулийн дагуу Монгол Улсын хуулийн этгээдийн бүртгэлд нийхүү зохих ёсоор бүртгэгдсэн нь Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 08493 тоот албан бичгээр ирүүлсэн лавлагаагаар баталгаажсан болно. Тус лавлагааны хуулбарыг энэхүү Хуулийн дүгнэлтийн *Хавсралт 4*-с харна уу.

*1.4. Улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэх эрх зүйн чадвар:*

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсдэг тул Банк нь Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн дагуу өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ53966 ᵃ 5903858

ЭН ЭС СИ СИ ТИК ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2021 .11.сар 10 өдөр ХҮРТГЭВ №
ХӨРӨНГИЙН ... STOCK EXCHANGE
2021 -11- 03
ХҮРТГЭВ-03

байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхлэх чадвартай хуулийн этгээд юм.

## 2. Үнэт цаас гаргах тухай Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн шийдвэр хууль тогтоомжид нийцсэн эсэх

*2.1. Үнэт цаас гаргах хуулийн шаардлага:*

Банкны хувьцаа эзэмшлийн хэт төвлөрлийг бууруулж өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурал Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль[1] (**"Банкны хуулийн нэмэлт, өөрчлөлт"**)-ийг, дагаж мөрдөх журмын тухай хуулийн хамт 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр хэлэлцэн батлаж, улмаар 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх байдлаар хуульчилсан. Энэ нь Төрөөс менгений бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл[2] болон Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр[3]ийн дагуу банкны салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй уялдаж байгаа юм. Банкны хуулийн нэмэлт, өөрчлөлтөд заасны дагуу банкуудыг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор хуулийн этгээдийн хувьд эвхэн хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх шаардлагыг тавьсан болно. Тодруулбал: а) Монголбанкнаас банкны системд нөлөө бүхий гаж тогтоогдсон банк энгийн хувьцаагаа нийтэд санал болгох замаар арилжиж (IPO) нээлттэй хувьцаат компанид шилжих замаар өөрчлөн байгуулагдах; бол б) бусад банкууд хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх үүрэг тус тус хүлээсэн болно.

Банкны хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Банк нь хуулийн этгээдийн хэлбэрээ хаалттай хувьцаат компани болгон өөрчлөх, нэг хувьцаа эзэмшигчийн банкинд эзэмших хувьцааны хувь хэмжээг 20 хувиас бага байлгах үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой төлөвлөгөөг батлаж 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөрт багтаан Монголбанк болон СЗХ-нд хүргүүлж, хянуулах үүрэг хүлээсэн. Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшлийн бүтцийг хуульд нийцүүлэн өөрчлөх түр журмыг Монголбанк ба СЗХ боловсруулан 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр батласан. Үүний дагуу Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болох төлөвлөгөөгөө 2021 оны 5 дугаар сард Монголбанк ба СЗХ-нд хүргүүлсэн байна.

Банкны тухай хуулийн 28 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4 дэх заалтад заасны дагуу компанийн хувьцаат нэмж гаргах, компанийн хэлбэрийг өөрчлөх бүрэн эрх нь хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд банкийг өөрчлөн байгуулж болно гэж заасан.

*2.2. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн шийдвэр:*

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2021 оны 2 дугаар сарын 2-ны өдөр энгийн хувьцаат шинээр нэмж гарган Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй арилжих замаар Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, улмаар хувьцаат компани болгон хэлбэрээ өөрчлөх саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлэхээр тогтсон байна.

Банкны энгийн хувьцааны 20 хувьтай тэнцэх хэмжээний хувьцаат шинээр нэмж гарган Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй арилжих замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, улмаар хуулийн этгээдийн хэлбэрийн хувьд хувьцаат компани болон өөрчлөгдөх тухай шийдвэрийг түүний эрх бүхий этгээдүүд буюу Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 21/06 тоот "Банкийг өөрчлөн байгуулах" тухай тогтоол, 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 21/12 тоот "Банкны нэгж хувьцаат хөрөнгийн зах зээлд санал болгох үнэлгээ тогтоох тухай"

---

[1] https://www.legalinfo.mn/additional/details/3933?lawId=108 – 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль

[2] Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс менгений бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл

[3] Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТ68966 ☎ 5903858
ЭМ АЙ СИ СИ УЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 11 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

шийдвэр тус тус гарсан. Тэдгээр тогтоол, түүнд агуулагдаж буй шийдвэр нь Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 28 дугаар зүйл, 29 дүгээр зүйл, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4, Банкны Дүрмийн 7.3.1, 7.3.3, 7.3.11, 7.3.12 дах заалтуудад тус тус нийцэж байна.

**3. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, СЭХ-ноос батлагдсан Монголын компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар мэдээлэл**

*3.1. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийг томилсон байдал:*

| № | ТУЗ-ийн гишүүний нэр | Ердийн гишүүн эсэх | Томилсон шийдвэр | Компанийн засаглалын гэрчилгээний дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Л.Болдхуяг | ТУЗ-ийн дарга | 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 14/05 тоот тогтоол | 1030022 |
| 2. | Г.Саруул | Ердийн гишүүн | 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 14/05 тоот тогтоол | 1030021 |
| 3. | Jan Thorsten Duser<br><br>(кириллээр ЖАН ТОРСТЕН Дазер) | Ердийн гишүүн | 2018 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 18/06 тоот шийдвэр | 0521119 |
| 4. | Ж.Нарантуяа | Хараат бус гишүүн | 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 14/05 тоот тогтоол | 0521088 |
| 5. | Д.Моломжамц | Хараат бус гишүүн | 2018 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 18/06 тоот шийдвэр | 0521091 |
| 6. | Elliot Rowan Auckland (кириллээр Эллиот Рован Аукланд) | Ердийн гишүүн | 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 21/03 тоот шийдвэр | 0521120 |
| 7. | Р. Нямцэрэн | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | ТУЗ-ийн 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 20/12 тоот тогтоол | 0521078 |

*3.2. ТУЗ-ийн гишүүдийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар:*

Банкны ТУЗ-ийн гишүүдийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар Үнэт цаасны танилцуулгын 6 дугаар хэсэгт дурдсан мэдээлэл нь Үнэт цаас гаргагчаас бидэнд өгсөн мэдээлэлтэй нийцсэн. ТУЗ-ийн гишүүдийн удирдах чадвар, дадлага туршлага нь Банкны



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8960 ₪ 5903858

ЭН АЙ СИ СИ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

303

СЗХ
2021 оны 11 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 1

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

тухай хуулийн шаардлага хангасан болохыг бид Монголбанкнаас ирүүлсэн лавлагаа болон Үнэт цаас гаргагчийн Эрх бүхий албан тушаалтны батламж бичгээр баталгаажуулсан болно.

*3.3. ТУЗ-ийн гишүүдэд тавигдах хууль тогтоомжийн шаардлага, тэдгээрийг хангасан байдал:*

Банк нь Монголбанк, СЗХ буюу санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагын зохицуулалтад байдаг хуулийн этгээд юм. Иймд Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд Компанийн засаглалын кодексоос илүү Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8 дах хэсэг, Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 33 дугаар зүйлийн 33.3 дах хэсэгт нарийвчилан тусгасан шаардлагуудыг хангасан байх ёстой. Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8 дах хэсэгт шаардсаны дагуу Банкны ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дах хэсэгт зааснаар банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасан шалгууруудыг хангаж байгаа эсэхийг Монголбанк шалгаж тогтоож, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилж болох эсэхийг банкинд мэдэгддэг. Иймд бид Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд нь Банкны тухай хуулийн шалгуур хангасан эсэхийг Монголбанкнаас тодруулсан. Монголбанкнаас бидэнд ирүүлсэн лавлагаагаар Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд нь Банкны тухай хуулийн шалгуур хангасны үндсэн дээр томилогдсон болохыг мэдээлсэн болно.

*3.4. ТУЗ-ийн үйл ажиллагаа хууль нийцсэн эсэх:*

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн үйл ажиллагаа, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам нь Монголбанкнаас 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам" Үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, Компанийн засаглалын кодекст тавьсан шаардлагыг хангаж байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох ТУЗ-ийн азлжит болон эзлжит бус хурлууд, тэдгээрээс гарсан шийдвэрүүд нь хуульд нийцэж байна.

**4. Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, СЗХ-ноос батлагдсан Монголын компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар мэдээлэл**

*4.1. Гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага, тэдгээрийг хангасан байдал:*

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэгт "*Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагаа удирдан зохион байгуулна*", мөн 83.2 дах хэсэгт "*Компанийн дүрэмд зүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхээр заагдаагүй бол хувь хүн хэрэгжүүлнэ*", 80 дугаар зүйлийн 80.3 дах хэсэгт "*Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд компанийн гүйцэтгэх захирал байна*" гэх тус тус заасан байна. Банкны Гүйцэтгэх захирлаар Ганбаатарын Саруулыг 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн томилсон. Хөдөлмөрийн тухай хуулийн 22 болон 25 дугаар зүйлүүдийн дагуу 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Банкны ТУЗ, түүнийг төлөөлж ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг болон Гүйцэтгэх захирал Г.Саруул нар 5 жилийн хугацаатай Хөдөлмөрийн контракт байгуулсан бөгөөд 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдөр дуусгавар болно. Хөдөлмөрийн контрактад тусгасан нөхцлүүд нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцэж байна. Бид 2018-2021 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд Банкны гүйцэтгэх захирлын гаргасан тушаал, шийдвэрүүдийг хүлээн авч танилцсан бөгөөд Банкны гүйцэтгэх захиралд олгогдсон бүрэн эрхийг хэтрүүлсэн буюу бүрэн эрхээс гадуур шийдвэрлэсэн аливаа тушаал, шийдвэр байгаагүй.

Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дах заалтад зааснаар банкны төлөөлөн удирдах зөвлөл нь Монголбанкнаас зөвшөөрсөн буюу Банкны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дах хэсэгт заасан шалгууруудыг хангасан этгээдийг гүйцэтгэх удирдлагаар



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
Т[illegible] 5903858

ЭМ ХЭ СИ СИ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

томилох эрхтэй. Иймд бид Банкны Гүйцэтгэх захирал нь Банкны тухай хуулийн шалгуур хангасан эсэхийг Монголбанкнаас тодруулсан. Монголбанкнаас бидэнд ирүүлсэн лавлагаанд Банкны Гүйцэтгэх захирал нь Банкны тухай хуулийн шалгуур хангасны үндсэн дээр ТУЗ-өөс Гүйцэтгэх захирлаар томилсон болохыг мэдэгдсэн болно.

*4.2. Үнэт цаас гаргагчийн бусад эрх бүхий албан тушаалтанд тавигдаг шаардлага, тэдгээрийг хангасан байдал:*

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт ТУЗ, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцох тухай заасан. Банкны Дүрмийн 11 дүгээр зүйлд *"Банкны эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга орууллна"* гэжээ.

Хэдийгээр Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2 дах хэсэгт компани нь өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байдаг ч Банк нь хязгаарлагдмал хариуцлагатай компани болохын хувьд санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн зэрэг нь компанийн албан ёсны шийдвэр гаргахад, гэрээ хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог, эрх үүргээ хэрэгжүүлэх явцдаа компанид буюу Банкинд хохирол учруулсан тохиолдол хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх зохицуулалттай тул эрх бүхий албан тушаалтанд тооцохгүй, дүрэмд тусгахгүй байх боломжгүй юм. Иймд бид Банкны Дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтантай холбогдох заалтыг өөрчлөн найруулж, шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг ТУЗ нэмж батлахыг зөвлөсөн болно.

Бид Банкны эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3.2 дах заалтад заасан ял шийтгэл эдэлж байгаа, гэмт хэрэгт холбогдож байсан эсэхтэй холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас лавлагаа, мэдээлэл авах боломжгүй тул энэхүү Хуулийн дүгнэлтийн *Хавсралт 2-т* хавсаргасан байдлаар эрх бүхий албан тушаалтнууд нь сүүлийн 10 жилд эрүүгийн хэрэгт шүүхээс ял шийтгэгдэж байгаагүй талаарх Эрх бүхий албан тушаалтны батламжийг хүлээж авсан болно.

**5. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд хууль тогтоомж, Компанийн засаглалын кодекст нийцэж байгаа эсэх**

Банк нь үйл ажиллагаандаа мөрдөгдөх хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн төсөл боловсруулах, санал авах, хэлэлцэх, батлах, хүчингүй болгох харилцааг зохицуулах зорилгоор "Баримт бичгийн төсөл боловсруулах журам"-ыг Гүйцэтгэх захирал 2015 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 15/076 тоот тушаалаараа батлан мөрдөж байна.

Тус журмын дагуу Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаандаа мөрдөх баримт бичгүүд нь (i) журам, (ii) дүрэм, (iii) заавар, (iv) гадаш чиглэсэн хэм хэмжээ тогтоосон тушаал буюу харилцагчийн дагаж мөрдөх журмуудаас бүрдэж байна. Үнэт цаас гаргагч нь Монголбанкны "Банкны эрх зүйн баримт бичгийг бүртгэх журам"-д заасны дагуу Монголбанкинд хүргүүлэх шаардлагатай дүрэм, журам, зааврыг тухай бүр хүргүүлж мэдээлдэг байна. Энэ Хуулийн дүгнэлтийн *Хавсралт 3-т* заасан, Банкны дотоод дүрэм, журам нь холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна.

**6. Үнэт цаас гаргагчийн бусадтай зөвлөдөгчийн хувиар байгуулсан зөвлийн гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх**

Үнэт цаас гаргагчаас өрдийн үйл ажиллаганыхаа хүрээнд байгуулсан, Үнэт цаасны танилцуулгад дурьдсан санхүүжилтийн хэлцлүүд нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжинд нийцсэн байна. Үнэт цаас гаргагч нь эдгээр хэлцлүүдээс гадна ямар нэг өр төлбөр хүлээж болзошгүй үүрэг хүлээгээгүй буюу ямар нэг зөвлийн гэрээ байгуулаагүй байна. Энэ талаар баталгаажуулж Үнэт цаас гаргагч нь *Хавсралт 2-т* заасан Эрх бүхий албан тушаалтны батламж бичгийг ирүүлсэн болно.



305

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01
2021 -11- 03 БҮРТГЭВ-СЗ

**7. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах, худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээ болон үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх**

*7.1. Даатгалын гэрээ:*

Даатгалын гэрээ нь Банкны үйл ажиллагааны хүрээнд байгуулсан бизнесийн гэрээ хэлцэлд хамаарч байсан бөгөөд бид Банкны 2018-2021 онд байгуулсан даатгалын гэрээнүүдтэй танилцсан. Тус даатгалын гэрээнүүд нь албан журмын болон сайн дурын даатгалаас бүрдэх бөгөөд аливаа хууль бус агуулгагүй, зохих ёсоор байгуулагдсан байна.

*7.2. Бизнесийн бусад гэрээ хэлцлүүд:*

Бид Банкинд хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа болон 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд байгуулсан, дуусгавар болсон гэрээнүүдтэй танилцсан ба тэдгээр нь зохих ёсоор байгуулагдсан буюу хуульд харшлаагүй байна.

**8. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний хэлцэл нь хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх**

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 болон 87.1.2 дах заалтуудад тус тус зааснаар хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл хийсэн эсвэл компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт хийсэн бол их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Хуулийн дүгнэлт гарах едрийн байдлаар Банк нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт тодорхойлсон их хэмжээний хэлцэл байгуулаагүй бөгөөд үүнийг баталгаажуулах зорилгоор бид Үнэт цаас гаргагчийн Эрх бүхий албан тушаалтны батламж бичгийг авсаныг Хуулийн дүгнэлтийн *Хавсралт 2-с* харна уу.

**9. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл нь хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх**

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт "компанийн энгийн хувьцаны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний харьяат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно. Үүнд:

(i) хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /нөгдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

(ii) хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /нөгдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

(iii) хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.



БОГД БАНК ХХК БОГД БАНК BOGD BANK УЛААНБААТАР ХОТ
ӨМ АН СИ СИ ҮЦК ХХК УЛААНБААТАР ХОТ

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт зааснаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг үг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана. Мөн түүнчлэн Компанийн засаглалын кодексийн 5.8-д ТУЗ-ийн гишүүдийн хувийн болон санхүүгийн сонирхол компанийн эрх ашгийн нэн төргүүнд тавих үүргийн хооронд сонирхлын зөрчил гарах тохиолдол байдаг тул нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл ба сонирхлын зөрчлийг зохицуулах бодлоготой байх үүрэгтэй ба төлөөлөн удирдах зөвлөлийн ёс зүйн кодексийг батлан мөрдөнө гэж заасан. Түүнчлэн, тодорхой асуудлаар шийдвэр гаргах үед төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн эсхүл хэсэг гишүүдийн хувьд дээр дурдсан сонирхлын зөрчил үүсэх байгаа бол энэ тухайгаа зөвлөлд мэдэгдэж тухайн асуудалд санал өгөхгүй байхыг зөвлөсөн.

| **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(32,235,765)** | **8,186,055** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

МССС

358

СЭХ
2021. 11. 10
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-03

**БОГД БАНК ХХК**
**2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)**

| | Тодруулга | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Санхүүгийн хөрөнгө оруулалтын худалдан авалт | | (62,682,989) | (82,904,797) |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулснаас орсон мөнгө | | 68,267,368 | 76,968,371 |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө борлуулснаас орсон мөнгө | | 350,000 | – |
| Үндсэн хөрөнгө борлуулснаас орсон мөнгө | | 400 | 76,637 |
| Үндсэн хөрөнгө худалдан авалт | 19 | (554,772) | (1,031,571) |
| Биет бус хөрөнгө худалдан авалт | 21 | (188,842) | (731,980) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **5,191,165** | **(7,623,340)** |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Зээлийн эх үүсвэрийн санхүүжилт | | 5,973,138 | 9,035,845 |
| Зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт | | (8,085,958) | – |
| Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн төлөлт | | (214,232) | (185,314) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(2,327,052)** | **8,850,531** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)** | | **(29,371,652)** | **9,413,247** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 12.1 | 103,040,769 | 93,627,522 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 12.1 | **73,669,117** | **103,040,769** |
| **ХҮҮТЭЙ ХОЛБООТОЙ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Хүүгийн төлөлт | | (10,375,803) | (5,462,115) |
| Хүлээн авсан хүүгийн орлого | | 9,474,712 | 7,477,903 |
| **МӨНГӨН БУС ҮЙЛ АЖИЛЛАГАА** | | | |
| Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөрийн нэмэгдэл | 20 | – | 1,205,275 |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс Борлуулах зориулалттай хөрөнгөд шилжүүлсэн | 18 | 344,090 | – |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнээс үүссэн өр төлбөрийн хөдөлгөөн** | | | |
| **Түрээсийн өр төлбөр** | | | |
| 1 дүгээр сарын 1 | | 2,545,505 | 1,791,945 |
| Мөнгөн бус хасагдуулга | | – | 938,874 |
| Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт | | (38,553) | – |
| Тайлант жилийн хүүгийн зардал | | 394,619 | 363,640 |
| Түрээсийн өр төлбөрийн хүүгийн төлөлт | | (394,619) | (363,640) |
| Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөр төлөлт | | (214,232) | (185,314) |
| **12 дугаар сарын 31** | | **2,292,720** | **2,545,505** |
| **Зээлээр авсан эх үүсвэр** | | | |
| 1 дүгээр сарын 1 | | 9,263,050 | – |
| Зээлэйин эх үүсвэрийн санхүүжилт | | 5,973,138 | 9,035,845 |
| Үндсэн төлбөр төлөлт | | (8,085,958) | – |
| Хүүгийн төлөлт | | (266,787) | (26,769) |
| Эргэн төлөлт, цэвэр | | **(2,379,607)** | **9,009,077** |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэл | | 308,292 | 104,902 |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ | | **308,292** | **104,902** |
| Хүүгийн өглөг | | 272,998 | 149,071 |
| **12 дугаар сарын 31** | | **7,464,732** | **9,263,050** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
MICC

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**1. Байгууллагын талаарх мэдээлэл**

Богд Банк нь Монголбанкнаас ("МБ") олгосон 27 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээг 2014 оны 12 дугаар сарын 8-ны өдрөөс хойш үзүүлж байгаа бөгөөд тайлант жил болох 2020 онд Банкны үндсэн үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт орсоогүй болно. Банк нь Монгол улсад бүртгэлтэй, түс улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны төв байрны албан ёсны хаяг нь Бодь Цамхаг, 1-р Хороо, Жигжиджавын гудамж 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот - 15160, Монгол Улс.

Банкны нийт хувьцааны 91.32%-ийг Богд Капитал ХХК, 8.68% -ийг Богд Капитал Инвестмент ХХК эзэмшдэг.

Банкны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр батлагдсан.

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

**2.1 Тайлан бэлтгэх үндэслэл ба нийцлийн мэдэгдэл**

Банкны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс батлагдсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу бэлтгэгдсэн болно.

Банк 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангаа 2018 оны 1 дүгээр сарын 1 болон 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс түс түс хэрэгжиж эхэлсэн СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр*, СТОУС 16 *Түрээс* стандартуудаас бусад НББОУСЗ-с батлаж гаргасан СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас батлагдсан заавар, журмын дагуу бэлтгэсэн болно.

Банк СТОУС 9 болон СТОУС 16-г 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр анх хэрэгжүүлж эхэлсэн. Иймээс Банкны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн анхны тайлан болно. Дэлгэрэнгүйг Тодруулга 2.5-аас харна уу.

Санхүүгийн тайлангуудыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн болон өмчийн хэрэглүүр, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө, бодит үнэ цэнээр бүртгэгдэх үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусдаар түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлангийн дүнгүүдийг Банкны үйл ажиллагааны мөнгөн нэгж болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр (төг) тайлагнаж, тодруулгад өөрөөр заагаагүй бол мянганы орноор бүхэлчилсэн болно.

**2.2 Санхүүгийн тайлангийн төлөвлуулга**

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг хэрвээ чадвараар нь эрэмбэлэн төлөвлуулдаг. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас дээш хугацаанд (урт хугацаанд) эргэн төлөгдөх эсвэл барагдуулах төлбөрийн шинжилгээг Тодруулга 32-т төлөвлуулав.

Ирээдүйн үйл явдлаас үүдэрч болзошгүй бус, хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй ба доорх бүх нөхцөл цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай үед л санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлж, цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толилуулна. Үүнд:

- Бизнесийн хэвийн үйл ажиллагаанд үед;
- Чанаргүйдсэн үед;
- Банк болон/эсвэл хамтрагч талууд төлбөрийн чадваргүй болсон эсвэл дампуурсан үед.

Мастер цэвэршүүлэлтийн нөхцөлтэй үүсмэл санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг зөвхөн чанаргүйдсэн үед биш дээрх бүх цэвэршүүлэх нөхцөл хангагдсан үед л цэвэр дүнгээр нь толилуулна.

**2.3 Шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандарт, стандартын тайлбарууд**

Банкны санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартуудыг доор үзүүлэв. Банк энэхүү стандартуудыг (хэрэв Банкинд хамаарагдах бол) хүчин төгөлдөр үйлчлэх эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

| | |
|---|---|
| СТОУС 17 | *Даатгалын гэрээ*[2] |
| НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт | *Эргэлтийн эсвэл эргэлтийн бус өр төлбөрийн ангилал*[2] |
| СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлт | *Үзэл баримтлалын хүрээний зөвлөмж*[2] |
| НББОУС 16-ийн нэмэлт өөрчлөлт | *Үндсэн хөрөнгө: Зорилгаатаар ашиглаж эхлэхээс өмнөх орлого*[1] |
| НББОУС 37-ийн нэмэлт өөрчлөлт | *Давагдашгүй гэрээ – Гэрээний үүрэг биелүүлэх зардал*[1] |
| СТОУС 1 СТОУС-ыг анхлан хэрэгжүүлэх | *Охин компани нь анхлан хэрэгжүүлэгч*[1] |
| СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр | *Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөхтэй холбоотой '10 хувь'-ийн хураамжийн тест*[1] |
| НББОУС 41 Хөдөө ах аж ахуй | *Бодит үнэ цэнийн хэмжилтэд татвар ногдуулах*[1] |



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 -11- 10
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.3 Шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандартууд, тайлбарууд (үргэлжлэл)**

[1] *2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.*
[2] *2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.*

***Жишиг хүүгийн түвшний шинэчлэл - СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 ба СТОУС 16-д орсон 2-р шатны нэмэлт өөрчлөлтүүд***

2020 оны 8-р сард НББОУСЗ-с гаргасан жишиг хүүгийн түвшний шинэчлэл - СТОУС 9, НББОУС 39, СТОУС 4, СТОУС 16-д орсон 2-р шат нэмэлт өөрчлөлтүүдийг ("ЖХТШ 2-р шат") ЖХТШ-г эрэдэлгүй хүүгээр ("ЭХТ") солиход үүсэх нягтлан бодох бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор гаргасан.

ЖХТШ 2-р шатанд олон хөнгөлөлт, нэмэлт тодруулга орж байгаа бөгөөд энэхүү хөнгөлөлт нь санхүүгийн хэрэглүүрийг ЖХТШ-с ЭХ-д шилжүүлэхэд хамаарна. ЖХТШ-ийг хийсний үр дүнд гэрээний мөнгөн урсгалыг тодорхойлох суурь зарчим өөрчлөгдсөнөөр хөвөгч хүүний түвшин өөрчлөгдөхөд практик нөлөө үзүүлэх ба санхүүгийн хэрэглүүрийн хувьд ЖХТШ-ийн үнэлгээнээс ЭХТ-д шилжих нь эдийн засгийн хувьд ижил зарчмаар хэрэгжинэ.

ЖХТШ -ийн 2-р үе шат нь хүүгийн түвшний жишиг үнэлгээг ЭХТ-ээр солих үед Банкны хейджийн харилцааг үргэлжлүүлэх боломжийг олгох түр зуурын хөнгөлөлтийг үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийг хэрэгжүүлэхийн тулд Банк хейджийн тэмдэглэгээ, хейджийн баримт бичиг нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болдог. Үүнд ЭХ-г тайлбарлах зорилгоор хейджийн эрдлийг болон хейджийн хэрэглийн тайлбарыг дахин тодорхойлох ба/эсвэл ЭХ-г харгалзан хейджийн үр дүнг үнэлэх аргад нэмэлт өөрчлөлт оруулах юм. Хейджийн баримт бичгийн шинэчлэлтийг тайлант хугацааны эцэст хийж шаардлагатай. Хейджийн үр ашгийг урвуу байдлаар үнэлэхдээ Банк бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийг тэг болгох үүднээс хейдж түс бүрээр нь сонгон авч үзэж болно. Банк нь хүүгийн эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг түсад нь тодорхойлсон тохиолдолд хейджийн зүйлийн бодит үнэ цэнэ эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг гэрээний дагуу тогтоогоогүй хейджийн эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэг гэж тодорхойлж болох бөгөөд энэ нь өргөн хэрэглэгддэг тогтсон жишиг юм. Жишээлбэл: зах зээл дээр зээл болон деривативын үнийг тогтоох жишиг хүүгийн түвшин.

Жишиг зээлийн хүүгийн түвшин харааһан тогтоогүй байгаа ЭХТ-үүдийн хувьд 24 сарын дотор ЭХТ-г таних боломжтой болно хэмээн Банкны үндэслэлтэйгээр тооцоолсон тохиолдолд энэхүү шаардлагаас чөлөөлөгдөнө. Банк нь бүлгийн зүйлийн хейджийн хувьд хэрэглийг ЭХТ-д хамаарах дэд бүлгүүдэд шилжүүлэх шаардлагатай. ЖХТШ 2-р шатыг хэрэгжүүлэхээс өмнө зовхон ЖХТШ-ээс болж цуцлагдсан бөгөөд ЖХТШ 2-р шатыг хэрэгжүүлэхэд хейджийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагыг хангасан аливаа хейджийн харилцааг анх хэрэгжүүлж эхэлсэн. Банк нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх ЖХТШ 2-р шатыг хэрэгжүүлснээс санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг үнэлж байгаа ба Банкинд материаллаг нөлөө үзүүлэх гэсэн хүлээлттүй байна.

***СТОУС 17 Даатгалын гэрээ***

2017 оны 5-р сард НББОУСЗ нь даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тайлагнал болон толилуулгын зарчмуудыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн шинэ стандарт болох СТОУС 17 Даатгалын гэрээ стандартыг батлсан. СТОУС 17 нь хүчин төгөлдөр болох хугацаанаасаа эхлэн 2005 онд батлагдсан СТОУС 4 Даатгалын гэрээ стандартыг орлоно. СТОУС 17 нь даатгалыг гаргаж буй аж ахуйн нэгжийн төрөөс үл хамааран бүх төрлийн даатгалын гэрээнд (жишээлбэл, амь насны даатгал, шууд даатгал, давхар даатгал гэх мэт) мөн түүнчлэн тодорхой онцлог бүхий санхүүгийн хэрэгсэл болон баталгаанд үйлчилнэ. Стандартын хамрах хүрээ нь цөөн хэдэн хязгаарлалттай. СТОУС 17 нь даатгалын шинж чанар бүхий банкны бүтээгдэхүүнүүдэд ямар хэрэглүүл, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд нь СТОУС 9 эсвэл СТОУС 17-ийн хүрээнд хамрагдах эсэхийг тодорхойлоход нолөөлж болохуйц нягтлан бодох бүртгэлийн шинэ шаардлагыг нэвтрүүлж байна.
Даатгалд хамрагдаг зээлийн карт ба түүнтэй адилтгах бүтээгдэхүүнүүд: эдгээр бүтээгдэхүүнийг олгогчдын ихэнх нь СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хэрэгсэл гэж үзэн одоогийн аппаратаж буй бүртгэлийн зарчмыг үргэлжлүүлэх боломжтой болно. СТОУС 17 нь даатгалын гэрээний тодорхойлолтыг хангасан зээлийн картын гэрээг (мөн түүнтэй адилтгах зээлийн эсвэл төлбөрийн нөхцөлтэй бусад гэрээг) гаргахүү аливаа нэг үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнийг тогтоохдоо тухайн үйлчлүүлэгчийн даатгалтай холбоотой эрсдлийг тусгаагүй тохиолдолд СТОУС 17-ийн хамрах хүрээнд оруулахгүй. Хэрэв даатгалын нөхцөл нь зээлийн картын гэрээний нөхцлийн нэг хэсэг болж олгогдсон тохиолдолд, олгогч нь дараах шаардлагын дагуу бүртгэнэ:

- Даатгалын бүрэлдэхүүн хэсгийг салгаж СТОУС 17-ийн дагуу бүртгэх
- Бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг холбогдох бусад стандартууд (жишээлбэл, СТОУС 9, СТОУС 15 Хэрэглэгчидтэй байгуулсан гэрээний орлого эсвэл НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө гэх мэт)-ын дагуу бүртгэнэ.

Даатгалын шинж чанарыг хангасан боловч даатгалын тохиолдол үүсэхэд гэрээний дагуу даатгуулагчийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай хэмжээгээр нөхөн төлбөрийг хязгаарласан зээлийн гэрээ: Энэ төрлийн зээлийг олгогчид – жишээ нь, нас баралтаас болон чөлөөлөгдсөн зээл - СТОУС 9 эсвэл СТОУС 17-г сонгох боломжтой. Уг сонголт нь эргэлт бүхэлдүй бөгөөд багцын түвшинд хийгдэнэ.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ЗМАЙ СИ СИ ГИК ХХК
МІСС

СЭХ
2021 .11.30
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.3 Шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандартууд, тайлбарууд (үргэлжлэл)**

***СТОУС 17 Даатгалын гэрээ (үргэлжлэл)***

СТОУС 17 нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэх эсвэл түүнээс хойшхи тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд шаардлагатай тоон үзүүлэлтүүдийг харьцуулна. Хэрэв Банк нь СТОУС 17 анх хэрэгжүүлж эхлэхээс өмнө эсвэл тухайн өдрөөс эхлэн СТОУС 9 болон СТОУС 15 стандартуудыг хэрэгжүүлж эхэлсэн тохиолдолд СТОУС 17-г хугацаанаас өмнө мөрдөж эхлэхийг зөвшөөрсөн. Банк нь одоогоор СТОУС 17 хэрэгжүүлснээр санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг үнэлж байна.

***НББОУС 1-д орсон нэмэлт өөрчлөлт: Эргэлтийн болон эргэлтийн бус ор төлбөрийн ангилал***

2020 оны 1-р сард НББОУСЗ-с НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 69-76-р хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулж ор төлбөрийг эргэлтийн болон эргэлтийн бус гэж ангилах шаардлагыг тодотгосон. Нэмэлт өөрчлөлтүүдэд:

- Төлбөр тооцоог хойшлуулах эрх гэж юу болох
- Тайлант хугацааны эцэст хойшлуулах эрхтэй байх ёстой
- Ангилал нь аж ахуйн нэгжийн хойшлуулах эрхээ хэрэгжүүлэх магадлалаас шалтгаалахгүй
- Зөвхөн хөрвөх нөхцөлтэй ор төлбөрт ачуулагдах дериватив нь өөрөө өмчийн хэрэгсэл болох тохиолдолд ор төлбөрийн хугацаа нь түүний ангилалд нөлөөлөхгүй

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд бушаан мордох нөхцөлтэй. Банк нь одоогоор эдгээр нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлснээр одоогийн практикт хэрхэн нөлөөлөх, хүчин төгөлдөр зээлийн гэрээнд дахин хэлэлцээр хийх шаардлагатай эсэхийг үнэлж байна.

***Үндсэн хөрөнгө: Зориулалтын дагуу ашиглахаас өмнөх орлого - НББОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт***

2020 оны 5-р сард НББОУС-с "Үндсэн хөрөнгө - Зориулалтын дагуу ашиглаж эхлэхээс өмнөх орлого"-г баталсан бөгөөд энэхүү өөрчлөлт нь аж ахуйн нэгж байгууллагууд үндсэн хөрөнгийн өртөгөөс тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай байршил, нөхцөл байдалд нь авчрах явцад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зарж борлуулахаас орсон орлогыг хасахыг хориглосон. Аж ахуйн нэгж тухайн бүтээгдэхүүний борлуулалтаас орсон орлого, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд гарсан өртгийг тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд бушаан мордох нөхцөлтэй. Өөрөөр хэлбэл, нэмэлт өөрчлөлтийг анх удаа хэрэгжүүлэх үед тухайн өөрчлөлт нөлөөлөх хугацаанаас хойшхи ашиглалтанд орсон үндсэн хөрөнгөд энэ өөрчлөлтийг тусгана.

***СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл - Санхүүгийн ор төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх "10 хувь" шалгуур - хураамж***

СТОУС-ыг 2018-2020 оны туршид жил бүр боловсронгуй болгох ажлын хүрээнд НББОУСЗ-с СТОУС 9-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Аж ахуйн нэгжийн бүтэц өөрчлөгдсөн санхүүгийн ор төлбөрийн нөхцөл нь гэрээний анхны нөхцлөөс үлэмж хэмжээгээр ялгаатай эсэхийг үнэлэхэд авцлагдах хураамжийг нэмэлт өөрчлөлтөөр тодотгосон. Хураамжид зөвхөн зээлдэгч ба зээлдүүлэгчийн хооронд төлсөн эсвэл хүлээн авсан төлбөр орох бөгөөд үүнд бусдын өмнөөс зээлдэгч эсвэл зээлдүүлэгчийн төлсөн бүюу авсан төлбөр багтсан болно. Аж ахуйн нэгжийн нэмэлт өөрчлөлтийг анх хэрэгжүүлсэн тайлант жилийг эхлэх үед эсвэл түүний дараа жилд бүтэц өөрчилсөн эсвэл солилцсон санхүүгийн ор төлбөрт хэрэгжүүлнэ.
Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр болно. Банк энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлж эхлэх тайлант жилд бүтэц өөрчилсөн эсвэл солилцсон санхүүгийн ор төлбөрүүдэд хэрэгжүүлэх ба Банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзсэн.

***Үзэл баримтлалын хүрээний зөвлөмж- СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлтүүд***

2020 оны 5-р сард НББОУСЗ-с СТОУС 3 Бизнесийн нэгдэл - үзэл баримтлалын хүрээний талаарх нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь 1989 онд гаргасан Санхүүгийн тайланг бэлтгэх, танилцуулах хүрээ, түүний шаардлагыг мэдэгдэхүйд өөрчлөхгүйгээр 2018 оны 3-р сард баталсан Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээний зөвлөмжөөр солих зорилготой юм.
Түүнчлэн удирдах зөвлөлөөс НББОУС 37 эсвэл СТОУТХ 21 Татвар-т хамаарах ор төлбөр ба болзошгүй ор төлбөрийн улмаас үүсч болзошгүй "2 дахь өдөр"-ийн ашиг, алдагдлаас зайлсхийх үүднээс СТОУС 3-н хүлээн зөвшөөрөх зарчимд үл хамаарах зааглыг нэмэлтээр оруулсан. Үүний зэрэгцээ Удирдах зөвлөлөөс Санхүүгийн тайлан бэлтгэх, танилцуулах тогтолцооны зөвлөмжийг орлуулснаар нөлөөлөл ертөх болзошгүй хөрөнгийн талаар СТОУС 3-т байгаа удирдамжийг тодруулж өгсөн. Нэмэлт өөрчлөлтүүд нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Нэмэлт өөрчлөлтүүд Банкинд нөлөөлөхгүй гэж үзэж байна.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
ХЭЗЭЭ ЧАР ХОТ
MICC

СЭХ
2021 -11- 10
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.3 Шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандартууд, тайлбарууд (үргэлжлэл)**

***Давагдашгүй гэрээ - Гэрээ биелүүлэх зардал - НББОУС 37-д орсон нэмэлт өөрчлөлтүүд***

2020 оны 5-р сард НББОУСЗ-өөс НББОУС 37-д нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээ нь давагдашгүй эсэхээ аллагалтай эсэхийг үнэлэхдээ аж ахуйн нэгж ямар зардлыг оруулж тооцох шаардлагатайг тодорхойлсон. Нэмэлт өөрчлөлтүүд нь "шууд хамааралтай зардлын хандлагын" хэрэгжүүлдэг. Бараа, үйлчилгээ үзүүлэх гэрээнд шууд хамааралтай зардлууд нь нэмэгдсэн өртөг болон гэрээний үйл ажиллагаатай шууд холбоотой зардлын хуваарилалтыг аль алиныг нь багтаана. Ерөнхий болон захиргааны зардал нь гэрээнд шууд хамааралгүй бөгөөд гэрээнд заасны дагуу эерэг талдаа тодорхой төлбөр тооцоогүй тохиолдолд хасагдана.
Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болно. Банк эдгээр нэмэлт өөрчлөлтийг анх оруулсан тайлангийн жилийн эхэнд бүх үүргээ биелүүлээгүй байгаа гэрээнд хэрэгжүүлнэ. Банк энэхүү нэмэлт өөрчлөлтийн үр нөлөөг үнэлж байна.

***СТОУС 1 Олон улсын санхүүгийн тайлагналын стандартыг анхлан хэрэгжүүлэх - Охин компани нь анх удаа хэрэгжүүлэгчийн хувьд***

СТОУС-ыг 2018-2020 оны туршид жил бүр боловсронгуй болгох ажлын хүрээнд НББОУСЗ-с СТОУС 1-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ нэмэлт өөрчлөлтийг СТОУС 1-ийн Д16 (а)-г охин компани нь хэрэгжүүлэхээр сонгосон тохиолдолд хамааралтай бөгөөд толгой компанийн СТОУС-д шилжсэн огноог үндэслэн толгой компанийн тайлагнасан дүнг ашиглан хөрвүүлэлтээс үүссэн хуримтлагдсан зөрүүг хэмжихийг охин компанид зөвшөөрсөн. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр болно. Нэмэлт өөрчлөлтүүд Банкинд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

***НББОУС 41 Хөдөө аж ахуй - бодит үнэ цэнийн хэмжилтэд татвар ногдуулах***

СТОУС-ыг 2018-2020 оны туршид жил бүр боловсронгуй болгох ажлын хүрээнд НББОУСЗ-с НББОУС 41 Хөдөө аж ахуй стандартад нэмэлт өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтөөр НББОУС 41-ийн 22 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжүүд НББОУС 41-ийн хүрээнд хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихдээ татвар ногдуулах мөнгөн гүйлгээг хасах шаардлагыг хассан болно. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлагналын хугацааны бодит үнэ цэнийн хэмжилтэд хэрэгжүүлж эхэлнэ. Нэмэлт өөрчлөлт нь Банкинд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол болгоогүй**

**Гадаад валютын ханшийн тэгшитгэл**

Санхүүгийн тайлангууд нь Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр толилуулагдсан. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ хийсэн өдрийн спот ханшаар үйл ажиллагааны мөнгөн тэмдэгтрүү хөрвүүлж, бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг тайлагналын өдрийн спот ханшаар дахин хөрвүүлдэг. Арилжааны бус үйл ажиллагаанаас үүссэн ханшийн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд үйл ажиллагааны бусад орлого/зардлаар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн, түүхэн өртгөөр хэмжигдэг мөнгөн бус зүйлсийг хүлээн зөвшөөрөх өдрийн спот ханшаар хөрвүүлнэ.

**Орлого хүлээн зөвшөөрөлт**

***Үр ашигт хүүгийн аргачлал***

СТОУС 9-ийн дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн бүх хөрөнгүүд, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаа ашиглан тодорхойлно. Мөн СТОУС-9-ийн дагуу бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн арга ашиглан тодорхойлно. Үр ашигт хүү гэдэг нь санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудыг хугацааных нь туршид эсвэл тохиромжтой гэж үзсэн богино хугацаанд дансны үнэ хүртэл нь дискаунтчилсан хүү юм.

Үр ашигт хүүг (цааллаад санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг) үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын хөнгөлөлт, урамшуулал, шимтгэл болон зардлыг оруулан тооцдог. Банк нь зээлийн нийт хугацааны турш тогтмол өгөөж хүртэнэ гэсэн хамгийн сайн тооцоолсон илэрхийлэх өгөөжийн хувиар хүүгийн орлогыг бүртгэдэг.

Хэрэв санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй мөнгөн урсгал нь зээлийн эрсдэлээс бусад шалтгаанаар өөрчлөгдсөн бол ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр дискаунтчилан цааллаад дансны үнийг тохируулна. Үүг өөрчлөлт нь эерэг эсвэл сөрөг залруулгаар санхүүгийн байдлын тайланд тухайн санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнэд нөлөөлж үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүгийн орлого/зардлыг нэмэгдүүлж эсвэл бууруулж болно.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
ҮЦТ-ЫНБААР ХОТ
ЗМ АВ СЕ СМ ХК ХХК
363

СЭХ
2021 оны 11 дүгээр сарын 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн төл бодлогууд (үргэлжлэл)**

**Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)**

***Хүү болон түүнтэй адилтгах орлого/зардал***

Цэвэр хүүгийн орлого болон зардлыг үр ашигт хүүгийн арга болон бусад аргыг ашиглан тооцдог. Эдгээрийг хүүгийн орлого болон зардлын аль алиныг хувьд харьцуулагдахуйц мэдээллийг харуулахын тулд орлогын тайланд тусад нь толилуулсан болно.

Банк нь зөвхөн дээр дурьдсан санхүүгийн хэрэгслүүдийн хувьд үр ашигт хүүгийн аргаар хүүгийн орлого болон зардлыг тооцоолдог.

Бусад хүүгийн орлого болон зардалд үүсмэл санхүүгийн хэрэгслийн хейдж хэлцлийн хүү болон бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэхээр хэмжигддэг бүх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн хүү (гэрээний хүүгийн хувь хэмжээгээр тооцдог хугацаандах зорилгоор зээмшиж буй хөрөнгөөс бусад) орно.

Арилжааны зорилалттай санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хүүгийн орлого болон зардал нь "Арилжааны цэвэр орлого"-д бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр хүлээн зөвшөөрөгдсөн болно.

Банк нь үнэ цэнэ буурсаи гэж үзсэнээс бусад санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар уг санхүүгийн хөрөнгийн дансны үнээс тооцдог.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурч ("Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бууралт" тодруулгын дагуу), "3-р шатлал" -д орсон тохиолдолд Банк үр ашигт хүүгийн аргыг ашиглан санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан цэвэр өртөөс хүүгийн орлогыг тооцно. Санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орохоо больсон ("Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бууралт" тодруулгын дагуу) тохиолдолд хүүгийн орлогыг дансны үнээс тооцно.

**Хураамж ба шимтгэлийн орлого**

Банк нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг төрөл бүрийн үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог.

Хураамж болон шимтгэлийн орлогыг Банк үзүүлсэн үйлчилгээний оронд хүлээн авах төлбөрийн дүнг тусгасан хэмжээгээр хүлээн зөвшөөрнө.

Гүйцэтгэлийн үүрэг, түүнчлэн тэдгээрийг биелүүлэх хугацааг гэрээ байгуулагдах үед тодорхойлно. Банкны орлого олох гэрээнд нэгэвчлэн олон гүйцэтгэлийн үүрэг байдаггүй бөгөөд эдгээрийг доорх байдлаар тайлбарласан.

Банк үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд хүлээн авах төлбөрийг нэн даруй нэхэмжилдэг. Аль эсвэл хугацааны туршид үзүүлэх үйлчилгээний гэрээний хугацааны төгсгөлд нэхэмжлэхийг гаргадаг (доор өөрөөр заагаагүй бол). Банк нь харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс өмнө үйлчилгээний хяналт нь Банкинд байдаг тул орлого хүлээн зөвшөөрөлтөд үндэсэн үүрэг гүйцэтгэгч гэж дүгнэсэн.

*Тодорхой хугацааны туршид үзүүлж байгаа үйлчилгээнүүдээс олсон хураамжийн орлого.* Тодорхой хугацааны туршид үйлчилгээ үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Эдгээр хураамжинд шимтгэлийн орлого, хөрөнгийн зохицуулалт, хамгаалалт, бусад зохицуулалт болон зөвлөгөөний хураамжууд орно.

*Гүйлгээний үйл ажиллагаанаас олсон шимтгэлийн орлого.* Хувьцаа эсвэл бусад үнэт цаас худалдан авах болон бизнес худалдан авах эсвэл зарах гэх мэт тодорхой хугацааны туршид үйлчилгээ үзүүлж олох орлогыг үндэсэн гүйлгээ хийгдэж дууссан үед хүлээн зөвшөөрнө. Шимтгэлийн бүрэлдэхүүн хэсгийн төлбөрийг гүйцэтгэлийн зохих шалгуурыг биелүүлсний дараа хүлээн зөвшөөрнө.

*Холбогдох санхүүгийн хэрэгслийн салшгүй хэсэг болох хураамжийн орлого.* Банкны холбогдох санхүүгийн хэрэгслийн салшгүй хэсэг болох хураамжийн орлого нь: зээл олголтын шимтгэл, татан авагдах магадлалтай зээлүүд дээр зээлийн үйлчилгээний шимтгэл болон зээлтэй холбоотой бусад шимтгэлүүд орно. Эдгээр шимтгэл нь (өсөн нэмэгдэх аливаа зардлыг хамт) зээлийн үр ашигт хүүгийн залруулга гэж хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө. Харин татан авахгүй нь сөнхийдөө тодорхой болсон зээлүүдийн зээлийн үйлчилгээний шимтгэлийг хугацааны эцэст орлогоор хүлээн зөвшөөрнө.

**Арилжааны цэвэр орлого**

Арилжааны цэвэр орлогод арилжаалахад зориулагдсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт, түүнтэй холбоотой хүүгийн орлого/зардал, ногдол ашиг багтана.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
Т:58966 , 5903858



MCCS

СЗХ
2021 -11- 10
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ 03



**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүсэх цэвэр ашиг, алдагдал**

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийг үл хүлээн зөвшөөрөхөд үүсэх цэвэр ашиг, алдагдал нь хорогдуулсан өртгөөр хэмжигдэх эсвэл бодит үнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийг борлуулах эсвэл үл хүлээн зөвшөөлөх үеийн хүлээн авсан орлого болон дансны үнэ (үнэ цэнэ бууралт тооцсон) хоорондын зөрүүгээр тооцсон алдагдал (эсвэл ашиг)-аар хэмжигдэнэ.

**Санхүүгийн хэрэгсэл - анхны хүлээн зөвшөөрөлт**

Санхүүгийн хэрэгсэл нь нэг байгууллагад санхүүгийн хөрөнгө болж нөгөө байгууллагад санхүүгийн ер төлбөр эсвэл өмчийн хэрэгсэл болох гэрээг хэлнэ.

*Хүлээн зөвшөөрөх өдөр.* Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, харилцагчдын харилцах болон хадгаламжаас бусад бүх санхүүгийн хөрөнгө, ер төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдрөөр (Банк нь тухайн хэрэгслийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвлөөрнө. Үүнд хэвийн нөхцөлтэй арилжаа буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэмжээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаардлаг арилжаа орно. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь хөрөнгийг харилцагчдын дансанд шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Банк нь харилцагчдын харилцах, хадгаламжийг Банкинд шилжсэн үед хүлээн зөвшөөрнө.

*Санхүүгийн хэрэгслийн анхны хэмжилт.* Санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөх үеийн ангилал нь гэрээний нөхцөл болон бизнес загвар дээр үндэслэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон ер төлбөрөөс бусад бүх санхүүгийн хэрэгслүүдийн анхны хэмжилт нь тэдгээрийн бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүн байна. Худалдааны авлагын анхны хэмжилт нь гүйлгээний дүнгээр байна. Санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнэ нь ажил гүйлгээний үнээс ялгаатай үед Банк дор дурьдсан "Эхний өдөр"-ийн ашиг ба алдагдал гэх бүртгэлийн аргачлалыг баримталдаг.

*"Эхний өдөр" -ийн ашиг ба алдагдал.* Ажил гүйлгээний үнэ нь бодит үнэ цэнээсээ ялгаатай бөгөөд бодит үнэ цэнэ нь зах зээлийн ажил гүйлгээнээс ажиглагдахуйц өгөгдөлд суурилсан үнэлгээний аргачлал ашигласан байвал Банк нь бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн зөрүүг цэвэр арилжааны орлогоор хүлээн зөвшөөрнө. Зарим өгөгдөл нь ажиглагдахуйц мэдээлэлд суурилаагүй үнэлгээний загвараар тооцсон тохиолдолд ажил гүйлгээний үнэ болон бодит үнэ цэнийн зөрүүг зөвхөн орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл санхүүгийн хэрэгслийг үл хүлээн зөвшөөрөх тохиолдолд л орлого зардалд хүлээн зөвшөөрнө.

*Санхүүгийн хөрөнгө болон ер төлбөрийг хэмжих ангилал.* Банк өөрийн бүх хөрөнгийг бизнесийн загвар болон гэрээний нөхцөл дээр үндэслэн дараах аль нэгээр нь ангилна:

- Хорогдуулсан өртгөөр бүртгэх;
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх;
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх

Банк нь үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон арилжааны үнэт цаасны багцыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөр ангилж хэмжинэ. Хэмжилт болон хүлээн зөвшөөрөлт нь орлого үр дүнгийн тайлангийн хэлбэлзлийг бууруулж байгаа нөхцөлд Банк нь санхүүгийн хэрэгслийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх гэж тодорхойлж болно.

Зээлийн баталгаанаас бусад санхүүгийн ер төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэх эсвэл арилжаалах санхүүгийн үүсмэл хэрэгсэл эсвэл бодит үнэ цэнийн зорилгоор зээмшиж байгаа бол бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэхээр ангилна.

**Бодит үнэ цэнийн тодорхойлолт**

Банк нь үнэлгээний аргачлалуудыг ашиглан санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

- Түвшин 1- санхүүгийн хэрэгслүүд - Үнэлгээнд ашиглагдсан өгөгдлүүд нь хэмжилтийн өдрөөрх бирж дээр бүртгэлтэй ижил төсөөтэй хөрөнгө болон ер төлбөрийн (зарруулагүй) идэвхитэй зах зээл дээрх үнэ юм. Банк нь хэмжээ болон хэрвээ чадварын хувьд адил төсөөтэй хөрөнгө болон ер төлбөрийг санхүүгийн тайлангийн өдрөөр боломжтой, заавал болон хэрэгжих үнийн хангалттай арилжааны үйл ажиллагаатай байхыг идэвхтэй зах зээл гэж үзнэ.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ0966 - 5903558

ЭМ АЙ СИ СИ ҮЦК ХХК
5011558
MICC
ГҮГ № 6719
УЛААНБАА

СЗХ
он сар
2021 11 10
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Бодит үнэ цэнийн тодорхойлолт (үргэлжлэл)**

- Түвшин 2- санхүүгийн хэрэгслүүд - Үнэлгээнд ашигласан өгөгдлүүдийг санхүүгийн хэрэгслийн дуусах хугацааны туршид боломжтой байх зах зээлийн бүх өгөгдлүүдээс шууд болон шууд бусаар үнэлгээнд ашигласан өгөгдлүүд юм. Эдгээр өгөгдлүүдийн дотор идэвхтэй зах зээл дээрх ижил төстэй хөрөнгө болон өр төлбөрийн үнэ, идэвхтүй зах зээл дээрх ижил төстэй хэрэгслийн үнэ болон үүнээс өөр хүүгийн түвшин, өгөөжийн муруй, харгалзах холбэлээл, зээлийн эрсдэлийн үнэ гэх зэрэг ажиглагдахуйц өгөгдлүүд орно. Мөн түүнчлэн, тухайн хөрөнгийн шинж байдал болон байршил, харьцуулах зүйлсийн аль нь үнэлгээ тогтоосон хэрэгсэлтэй холбогдох зэргээс хамааран залруулга хийж болно. Гэвч ажиглагдахуйц бус өгөгдөл дээр үндэслэн нийт хэмжилтэнд чухал ач холбогдолтой дээрх залруулгыг хийсэн бол Банк нь хэрэгслүүдийг Түвшин 3-р ангилна.
- Түвшин 3 - санхүүгийн хэрэгслүүд - Эдгээрт, хэмжилтийн хувьд бүхэлдээ чухал ач холбогдол бүхий нэг болон түүнээс дээш ажиглагдахуйц бус өгөгдлүүд багтана.

Банк нь үнэлгээний техник болон хэрэгжүүлж буй аргачлалууд болон загварын тохируулгуудыг тогтмол шалгаж үздэг. Гэвч суурь загвар нь Банкны санхүүгийн хэрэгслийг үнэлэхтэй холбоотой бүх хүчин зүйлүүд болох зээлийн эрсдэл, өөрийн зээлийн болон/эсвэл санхүүжилтийн зардал зэргийг бүрэн дүүрэн хамруулж чадахгүй байх магадлалтай юм. Иймд Банк нь бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой зээлийн эрсдэлийг тооцоолохоод төрөл бүрийн техник хэрэглэдэг ба үүнд хөрөнгө тус бүрийн хувьд ашиглалтын хугацааны туршид холбогдох талд хүлээгдэж буй зээлийн эрсдэлийг багцад суурилан тооцох аргачлал багтдаг бөгөөд энэ нь холбогдох талд хүлээгдэж буй барьцаагүй санхүүгийн хэрэгслийн зээлийн эрсдэлийг тустахын тулд хийгддэг. Банк өөрийн зээлийн үнэ цэнийг зах зээлийн бодит өгөгдлүүдээс, тухайлбал, ярилжаалагдсан өрийн хөрөнгө үнэ зэргээс тооцдог.

Тайлант хугацааны эцэс бүрт Банк нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг.

**Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр**

***Бусад Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хэрэгслүүд***

Банк нь доорх нөхцлүүд хангагдсан тохиолдолд бусад Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон бусад санхүүгийн хэрэгслүүдийг хорогдуулсан өртгөөр бүртгэхэд ангилна:

- Бизнесийн загварын зорилго нь гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг
- Санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний нөхцөл нь тодорхой үеүүдэд үлдэгдлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн мөнгөн гүйлгээг исэгэдэг.

Эдгээр нөхцөлүүдийн дэлгэрэнгүй тайлбарыг дор үзүүлэв.

*Бизнесийн загварын үнэлгээ.* Банкны бизнес загвар нь хэрэгслийн түвшинд биш нийлмэл бөгдын түвшинд хянагдаг ба дараах ажиглагдахуйц хүчин зүйлсээс хамаарна:

- Бизнес загварын (тухайн бизнес загварт хамаарагдах санхүүгийн хөрөнгө) үр дүнд нөлөөлж буй эрсдэл ба эдгээр эрсдэлийг хэрхэн хянах аргачлал
- Эдгээр хөрөнгүүдээс мөнгөн гүйлгээ өмнө нь хэрхэн хүлээн авч байсан туршлага
- Багцын гүйцэтгэлийг хэмжих болон тайлагнахад ашигласан хэмжигдэхүүнүүд
- Байгууллагын удирдлагуудад хэрхэн урамшуулал олгодог (санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл гэрээний цуглуулсан мөнгөн урсгал дээр үндэслэдэг)

Борлуулалтын хүлээгдэж буй давтамж, үнэ цэнэ ба хугацаа нь үнэлгээ хийхэд чухал хүчин зүйл болно.

Бизнес загварын тест нь хамгийн боломжит хувилбар дээр үндэслэдэг ба ‘хамгийн муу’ эсвэл ‘стрэсс’ нөхцөлүүдийг харгалзан үздэгтүй. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах мөнгөн урсгал нь анхны таамагласан хүлээлтээс өөр байвал Банк тухайн бизнес загварт хамааралтай санхүүгийн хөрөнгийн ангиллыг солихгүй бөгөөд харин уг мэдээллийг санхүүгийн хөрөнгө шинээр худалдаж авах үед үнэлгээндээ оруулдаг.

*Үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн шалгуур (ҮТХТ шалгуур).* Санхүүгийн хэрэгслийн ангиллын хөөр дахь шат бол Банк үндсэн болон хүүгийн төлбөрийн шалгуурын шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд санхүүгийн хэрэгслийн гэрээний нөхцлийг дүгнэдэг.

Энэхүү шалгуурын хүрээнд ‘Үндсэн’ гэдэг нь анхны хүлээн зөвшөөрөх үеийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бөгөөд санхүүгийн хөрөнгийн ашиглах хугацааны туршид өөрчлөгдөж болно (жишээ нь үндсэн төлбөрийн эргэн төлөлт эсвэл урамшуулал/хөнгөлөлтийн хорогдуулалт).



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
MICC

СЗХ
2021 .11. 10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
MSE-COB-03



**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**2. Цэгтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Цэгтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)**

***Бусад Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)***

Зээлийн гэрээн дэх хүүгийн хамгийн гол элемент нь мөнгөний өнөөгийн үнэ цэнэ болон зээлийн эрсдэл байдаг. Үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн шаардуурын үнэлгээг хийхийн тулд Банк нь хүүгийн түвшнийг тогтоосон хугацаа гэх мэт холбогдох хүчин зүйлс, үнэлэмжийг авч үздэг. Цөгөө талаас, эрсдэл үүрэх магадлал багатай гэрээний завлт эсхүл үндсэн зээлийн зохицуулалттай холбоогүй гэрээний мөнгөн урсгалын тогтворгүй байдал зэрэг нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл дүнгийн гэрээний мөнгөн урсгалд нөлөөлөхгүй. Иймд тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

***Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх үүсмэл санхүүгийн хэрэгслүүд.*** Үүсмэл санхүүгийн хэрэгсэл нь санхүүгийн хэрэгсэл эсвэл бусад гэрээ байхын тулд доорх гурван шинж чанарыг бүхэлд нь агуулах шаардлагатай:

- Үнэ цэнэ нь тодорхой хүүгийн түвшин, санхүүгийн хэрэгслийн үнэ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ, валютын ханшийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон гэрээний холбогдох талын үүрэг хариуцлагад хамаарахгүй бусад хувьсагчийн өөрчлөлтөөс хамаардаг бол
- Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаардлагүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил байдлаар хандахаар хүлээгдэж буй адил төсөөтэй гэрээнд шаардлагатайгаас бага анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг бол
- Ирээдүйд төлөгдөхөөр бол

Банк нь төрөл бүрийн харилцагчилтай үүсмэл санхүүгийн хэрэгслийн хэлцлүүл хийдэг бөгөөд эдгээрт кросс своп, гадаад валютын болон хүүгийн форвард гэрээ хэлцлүүд зэрэг орно. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хейджийн нягтлан бодох бүртгэл хэрэглэж байгаагаас бусад үед "Ариллжааны цэвэр орлого"-д бүртгэдэг.

***Ариллжаалах зорилалттай санхүүгийн хөрөнгө.*** Банк нь санхүүгийн хөрөнгийг ариллжааны үйл ажиллагаагаар дамжуулан богино хугацаанд ашиг олох зорилгоор худалдаж авсан эсвэл багцаар нь удирдаж буй санхүүгийн хэрэгслийн багцын нэг хэсэг болгон ариллжаалах зорилалттай гэж ангилдаг. Ариллжаалах зорилалттай хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь хэмжин бүртгэдэг. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр ариллжааны орлогод хүлээн зөвшөөрнө. Хүү, ногдол ашгийн орлого болон зардлыг гэрээний нөхцлийн дагуу, эсвэл төлбөр хийх эрх нь тогтоогдсон үед ариллжааны цэвэр орлогод бүртгэнэ. Энэ ангилалд зарах эсвэл богино хугацаанд эргүүлэн худалдаж авах зорилгоор эзэмшсэн өрийн болон өмчийн үнэт цаасууд болон МИК-д зарахаар төлөвлөж буй ипотекийн зээлийн багц багтсан болно.

***Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх өмчийн хэрэгсэл.*** Банк нь өрийн хэрэглийг доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэгсэлд ангилна:

- Бизнесийн загварын дагуу гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон санхүүгийн хэрэглийг борлуулах зорилгоор эзэмших
- Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь зөвхөн үндсэн төлбөр ба хүүний шалгуурыг хангах

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл нь бодит үнэ цэнээр хэмжигдэх бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэнэ. Хүүгийн орлого болон гадаад валютын ханшийн олз, гарзыг хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийн адил ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгслийн зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоолыг доорх тодруулгуудад тайлбарласан. Банк нь нэг төрлийн үнэт цаасаас нэгээс олныг зээмшдэг бол эхэлж авсаныг эхэлж зарлагадахаар бүртгэнэ. Үл хүлээн зөвшөөрөх үед бусад орлогод хуримтлагдсан олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдана.

***Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэгсэл.*** Анх хүлээн зөвшөөрсөний дараа, Банк НББОУС-32 санхүүгийн хэрэгсэл толилуулга болон ариллжаалах зорилгоор эзэмшдэггүй өмчийн тодорхойлолтонд нийцсэн зарим өмчийн хэрэглийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өмчийн хэрэгсэл рүү бууаах боломжгүйгээр ангилна. Энэ ангилал нь хэрэглийн түвшинд суурилан тодорхойлогдог.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТЕ8966 - 5903858

MICC

СЗХ
2021 оны 11 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)**

***Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэгсэл (үргэлжлэл)***
Энэ өмчийн хэрэгслийн олз гарзыг хэзээ ч ашиг алдагдлын тайланд бүртгэхгүй. Банк хүлээн авах орлогын санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой зардлыг нөхөн төлбөрт ашигласан тохиолдолд ашиг нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх бол бусад үед төлбөрийн эрх нь батлагдаж, тохиолдолд ногдол ашгийг бусад үйл ажиллагааны орлого гэж ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх өмчийн хэрэгсэл нь үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамаарахгүй.

***Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр.***
Энэ ангилал дахь санхүүгийн хөрөнгө нь ариллагалах зорилгоор эзэмшээгүй бөгөөд анх хүлээн зөвшөөрөхдөө удирдлагаас тодорхойлогдсон эсвэл СТОУС-9-н дагуу бодит үнэ цэнээр хэмжих зайлшгүй шаардлагатай гэж тодорхойлсон. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө нь санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөд тодорхойлсон хэрэгслүүдээс олсон хүүгийн орлого эсвэл зардал нь үр ашгит хүүг ашиглан мөн хөнгөлөлт/урамшууллыг нь харгалзах дүнгээр тооцдог.

***Гаргасан өрийн хэрэгсэл ба зээлээр авсан санхүүжилт.*** Анх хүлээн зөвшөөрөгдөх дараа, зээллэгүүдийг дараагийн тайлант хугацаанд үр ашгит хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашгит хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг ангуулсан нийлмэл санхүүгийн хэрэгслүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, хүлээн зөвшөөрөгдөх өдөр салгана.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг ангуулсан нийлмэл санхүүгийн хэрэгслүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, хүлээн зөвшөөрөгдөх тусад нь бүртгэнэ.

Банк нь эдгээр үүсмэл бус санхүүгийн хэрэгслүүдийг бүртгэлд тусгахдаа, эхлээд тухайн хэрэгсэл нь нийлмэл эсэх талаар болон тухайн хэрэгслүүд болон бүрэлдэхүүн хэсгүүдийг НББОУС 32-н дагуу санхүүгийн өр төлбөр болон хөрөнгө эсвэл өөрийн хөрөнгө гэж ангилна. Банк нь санхүүгийн хэрэгслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө: (а) Банкинд санхүүгийн өр төлбөр болж байвал, (б) Тухайн хэрэгслийг эзэмшигчид, Банкны өөрийн хөрөнгөнд хөрвөх боломж олгож байвал. Хөрвөх хэрэгслийн өр төлбөр болон өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнүүдийн ангилал нь, тухайн хөрвөх нөхцөл нь зарим нэг эзэмшигчдийн хувьд эдийн засгийн давуу талтай байсан ч хөрвөх нөхцөл нь хэрэгжих эсэх болон түүний өөрчлөгдөх магадлалаас шалтгаалан өөрчлөгддөггүй. Хөрвөх санхүүгийн хэрэгслийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүртгэлийн дүнг хувааралдаа, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүний дүн нь тухайн хэрэгслийн нийт бодит үнэ цэнээс өр төлбөрийн бүрэлдэхүүн гэж тусад нь тодорхойлсон дүнг хассанаас үлдсэн дүн байна. Нийлмэл санхүүгийн хэрэгслэд ангуулагдсан өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнээс (өөрийн хөрөнгийн хөрвөх нөхцөл гэх мэт) бусад аливаа үүсмэл хэрэгслийн үнэ цэнэ нь (худалдан авах опцион гэх мэт) өр төлбөрийн бүрэлдэхүүнд багтана. Банк нь тухайн хэрэгслийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүнүүдийг тусад нь бүртгэх гэж буй бол тухайн өр төлбөрт салгах шаардлагатай ангуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл байгаа эсэхийг үнэлнэ.

Банк нь ангуулагч гэрээ болон дансаас ангуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгслийг зөвхөн доорх нөхцөлд салгана:

- Ангуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн эдийн засгийн болон эрсдэлийн шинж чанар нь ангуулагч гэрээний эдийн засгийн болон эрсдэлийн шинж чанартай нягт холбоотой биш үед
- Ангуулагдсан санхүүгийн үүсмэл хэрэгслээс ижил нөхцөлтэй салангад хэрэгсэл нь санхүүгийн үүсмэл хэрэгслийн тодорхойлолтыг хангаж буй тохиолдолд
- Холимог (нэгтгэсэн) хэрэгсэл нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэдсэн өөрчлөлттэйгээ бодит үнэ цэнээрээ бүртгэгдэхгүй (жишээ нь, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого зарлагын дансанд бүртгэдэх санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрт ангуулагдсан санхүүгийн үүсмэл хэрэгсэл)

***Санхүүгийн баталгаа, аккредитив болон ашиглагдаагүй зээлийн үүрэг.*** Банк нь санхүүгийн баталгаа, аккредитив болон зээлийн амлалт гаргадаг. Санхүүгийн баталгаа гаргаж өгсний улмаас хүлээн авсан урамшууллыг санхүүгийн тайлангуудад анхлан бүртгэхдээ бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Иймхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараагийн тайланг үед баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хэмжихдээ анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс ашиг, алдагдлын тайланд бүртгэсэн хуримтлагдсан хорогдлыг хассан дүн хоёрын аль өндөрөөр нь хэмжинэ.

Хүлээн авсан урамшууллыг баталгааны хугацааны туршид ашиг, алдагдлын тайланд "Хураамж ба шимтгэлийн орлого"-оор хүлээн зөвшөөрнө.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТӨ8966 • 5903858



МСС

СЭХ
2021 .11. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)**

***Санхүүгийн баталгаа, аккредитив болон ашиглагдаагүй зээлийн үүрэг (үргэлжлэл)***
Ашиглагдаагүй зээлийн үүрэг болон аккредитив нь амлалт бөгөөд энэхүү амлалтын хугацаанд Банк нь урьдчилан тодорхойлсон нөхцөлтэй зээлийг харилцагчид олгох шаардлагатай. Санхүүгийн баталгааны гэрээнүүдийн адилхан төдгээр гэрээнүүдэд "Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал"-ын шаардлагуудын дагуу сан байгуулна. Санхүүгийн баталгаа, аккредитив болон ашиглагдаагүй зээлийн гэрээний үнэ цэнэ нь зах зээлд олгогдох зээлийн гэрээний нөхцөлтэй ижил байхаас гадна санхүүгийн байдлын тайланд тусгагдахгүй. Энэхүү санхүүгийн хэрэгслүүдийн нэрлэсэн үнэ болон үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй алдагдал нь Тодруулга 28-д тусгагдсан.

***Харилцагчдын харилцах, хадгаламж.*** Үүнд харилцагчдаас авсан харилцах, хугацаагүй, хугацаатай хадгаламж болон Банкны баталгааны эх үүсвэр хамаарна. Анхны хэмжилтийн дараа үед харилцагчдад өгөх өр төлбөрүүдийг үр ашигт хүүгийн аргаар ашигтан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

***Бусад санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж.*** Бусад Банк, санхүүгийн байгууллагуудаас татсан төгрөгийн болон валютын хадгаламжууд болон дотоод гадаадын арилжааны банкууд, Монголбанкны хугацаатай хадгаламжууд мөн хамаарна. Банк нь, харилцагчдийн харилцах хадгаламжийг мөнгөн хөрөнгө нь Банкинд шилжсэн үед хүлээн зөвшөөрдөг. Анхны хэмжилтийн дараа бусад Банкуудад өгөх өр төлбөрийг үр ашигт хүүний аргыг ашигтан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

***Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал.*** Банк санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш бизнесийн шугам худалдан авах, дуусгах болон цуцлах онцгой нөхцөл байдлаас бусад нөхцөлд дахин ангилахгүй. Санхүүгийн өр төлбөр дахин ангилагддагүй.

**Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр үл хүлээн зөвшөөрөлт**

***Хугацаа болон нөхцөлд их хэмжээний өөрчлөлт орсоны улмаас үл хүлээн зөвшөөрөх.*** Харилцагчдад олгосон зээл гэх мэт санхүүгийн хөрөнгийг гэрээний нөхцөл нь шинэ зээл шиг болж өөрчлөгдөхөд үл хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд эдгээр хөрөнгийн хувьд зөрүү нь үл хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзаар бүртгэнэ. Шинээр хүлээн зөвшөөрсөн зээл нь худалдаж авсан эсвэл үүссэн үнэ цэнэ буурсан зээл биш бол уг зээл нь зээлийн үнэ цэнийн хүлээгдэх буй алдагдал тооцооллох үүднээс 1-р шатлалд ангилагдана.
Банк харилцагчид олгосон зээлийг үл хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэхдээ доорх нөхцөлүүдийг авч үздэг:

- зээлийн валют өөрчлөгдсөн
- өмчийн шинж чанартай болсон
- бизнесийн түнш өөрчлөгдсөн
- өөрчлөлтийн улмаас УТХТ-ийн шалгуурыг хангахгүй болсон

Хэрвээ өөрчлөлт нь мөнгөн урсгалд мэдэгдэхүйц өөрчлөлт үзүүлээгүй бол энэ өөрчлөлтийг үл хүлээн зөвшөөрөх гэж авч үзэхгүй. Мөнгөн урсгалын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр хорогдуулсан дүнд үндэслэн Банк үнэ цэнийн бууралтын алдагдал бүртгээгүй бол өөрчлөлтийг нь ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

***Их хэмжээний өөрчлөлтөөс бусад үед үл хүлээн зөвшөөрөх***

*Санхүүгийн хөрөнгө.* Банк санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төстэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсэг) тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан үед үл хүлээн зөвшөөрнө. Мөн Банк нь хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангаж байгаа нөхцөлд хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө. Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсэг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн, эсвэл
- "Дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн.

"Дамжуулан өнгөрөөх" хэлцэл нь Банк тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээх гэрээний эрхээ хадгалж үлдэх бөгөөд (анхны хөрөнгө) доорх гурван нөхцөл бүхий тохиолдолд гэрээний үүргийн дагуу төдгээр хүлээн авсан мөнгөн урсгалыг нэг болон түүнээс дээш байгууллагад (эцсийн хүлээн авагчид) шилжүүлнэ:

- Хэрэв тухайн нэг байгууллагын зээлдүүлсэн дүн дээр зах зээлийн хүүгээр хуримтлагдсан хүүтэй хамт бүрэн төлөх эрхтэй богино хугацаат урьдчилгаар оруулалгүйгээр Банк нь эцсийн хүлээн авагчид анхны хөрөнгө нь дүйцэх хэмжээний мөнгөн урсгалыг цуглуулаагүй цагт ямар нэгэн төлбөр төлөх үүрэггүй болно;
- Банк нь эцсийн хүлээн авагчдаас үнэт цаасаас бусад нөхцөлөөр анхны хөрөнгийг зарах эсвэл барьцаалж болохгүй;
- Банк нь эцсийн хүлээн авагчдын өмнөөс цуглуулсан мөнгөн урсгалыг удаан хугацаагаар саатуулалгүйгээр шилжүүлэх үүрэгтэй



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТӨ8966...3903858

ЭМ АЙ СИ СИ ҮЦК ХХК
MCC
УЛААНБААТАР

СЗХ
БҮРТГЭВ-03
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр үл хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)**

***Их хэмжээний өөрчлөлтөөс бусад үед үл хүлээн зөвшөөрөх (үргэлжлэл)***

Дамжуулалтыг зөвхөн доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө:

- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй болон хадгалж үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Хэрвээ шилжүүлэгч холбогдолгүй гуравдагч этгээдэд хөрөнгийг бүхэлд нь зарах болон шилжүүлэхэд нэмэлт хязгаарлалтгүйгээр тухайн чадварыг зээмшдэг гэж үзсэн үед Банк хяналтыг шилжүүлсэн гэж үзнэ.

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгетэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны үг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Хэрэв шилжүүлсэн хөрөнгөд үргэлжилсэн оролцоо бичгээр эсвэл худалдан авах опцион (эсвэл аль аль нь) хэлбэрээр байвал, Банкны үргэлжилсэн оролцоо нь эргүүлэн худалдан авахад төлөх шаардлагатай дүнгээр хэмжигдэнэ. Хөрөнгөд бичгээр худалдан авах опцион заасан байгууллагын үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон нөхцөлийн хэрэгжих үнийн аль багаар хязгаарлагдана.

*Санхүүгийн өр төлбөр.* Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Санхүүгийн өр төлбөрийн анхны бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

***"Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)" аргын ерөнхий ойлголт.*** Банк "санхүүгийн хэрэгсэл" ангилалд хамаарах зээлийн үүрэг болон санхүүгийн баталгаа, бодит үнэ цэнийн өөрчлөлт ашиг, алдагдлын тайланд бүртгэгдээгүй бусад өрийн хэрэгсэл болон бүх зээлд зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын сан байгуулсан. СТОУС-9-н дагуу өмчийн хэрэгсэл нь үнэ цэнийн бууралтанд орохгүй.

Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал нь хөрөнгийн ашиглалтын нийт хугацаанд үүсэх зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Хэрвээ анх бүртгэснээс алдагдал нь мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн бол алдагдал нь 12 сарын хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өөрчлөгдсөнийг хэмжих Банкны бодлого журмыг тодруулга 29-д тусгасан.

Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА аргын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэглийн чанаргүйдлийн магадлалын үр дүнгээр ЗҮЦХА-г илэрхийлнэ.

Санхүүгийн хэрэглийн үндсэн батцаас шалтгаалан нийт хугацааны ЗҮЦХА болон ирээдүйн 12 сарын ЗҮЦХА-г тусгай болон бүлгийн үнэлгээгээр тооцоолно. Банк нь бүдэг санхүүгийн хөрөнгийг бүлгийн үнэлгээний аргаар хэмжинэ.

Банк нь үнэлгээ хийх журмыг тодорхойлсон бөгөөд тайлант үеийн эцэс бүрт санхүүгийн хэрэглийн үлдэх хугацаанд үүсч болох эрсдэлийн өөрчлөлтийг харгалзан санхүүгийн хэрэглийг анх бүртгэснээс хойш ЗҮЦХА-д мэдэгдэхүйц өссөн эсэхийг харгалзан авч үзнэ.

Дээр дурьдсан процесс дээр тулгуурлан, доор дурьдсанаар Банк зээлийг шатлал 1, шатлал 2, шатлал 3 гэж ангилсан:

- Шатлал 1: Зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед Банк нь 12 сарын ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 1-рүү үүсч болох эрсдэл нь буурсан шатлал 2-ын зээлүүд дахин ангилагдана.
- Шатлал 2: Анх хүлээн зөвшөөрсөн үеэс зээлийн үүсч болох эрсдэл ихэссэн үед Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 2-руу үүсч болох эрсдэл нь буурсан шатлал 3-ын зээлүүд дахин ангилагдана
- Шатлал 3: Үнэ цэнийн бууралтанд орсон зээлүүд баттана. Банк нь нийт хугацааны турш ЗҮЦХА-г бүртгэнэ.

Банк нь санхүүгийн хөрөнгийг төлөгдөх нийт дүн эсвэл зарим хэсгийг төлөгдөх боломжгүй гэж үзвэл санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулна. Үүнийг санхүүгийн хөрөнгийн (хэсэгчилсэн) үл хүлээн зөвшөөрөлт гэнэ.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 ▲ 5903838



MICC
370

СЗХ
2021 .11 ар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

***ЗҮЦХА тооцоолол.*** Банк нь магадлалын-жигнэсэн гурван хувилбарыг үр ашигт хүүгээр хорогдуулсан хүлээгдэж буй мөнгөний дутагдлаар ЗҮЦХА-г тооцоолдог. Мөнгөний дутагдал нь гэрээний дагуух мөнгөн гүйлгээ болон эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний зөрүү юм.

ЗҮЦХА тооцооллын механизм болон гол элементийн хамт доор үзүүлэв:

- Чанаргүйдлийн магадлал (ЧМ) – ЧМ нь өгөгдсөн цаг хугацаанд төлөбөрийн чадваргүй болох магадлалаар тооцоолно. Хэрвээ хэрэгсэл нь өмнө нь үл хүлээн зөвшөөрч байгаагүй мөн харгалзах багцад үргэлжлүүлэн байгаа бол үнэлсэн хугацааны тодорхой хугацаанд нэг удаа алдагдал үүсэх боломжтой.
- Чанаргүйдэлд ертөх дүн (ЧӨД) нь тайлагналын даралх зээлийн хүлээгдэж буй өөрчлөлт, гэрээний дагуух үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт, зээлийн үүргийн хүрээнд нэмж олгосон дүн болон төлбөр хоцорсноор үүссэн хуримтлагдсан хүүг харгалзсан, ирээдүйн ЧӨД-ийн тооцоолдог.
- Алдагдалд хүргэх чанаргүйдэл (АХЧ) – Алдагдал хүргэх чанаргүйдэл гэдэг нь өгөгдсөн цаг хугацааны туршид чанаргүйдлийн үеийн алдагдлын тооцоолол юм. Энэ нь гэрээний дагуу мөнгөн урсгал болон зээлдэгч хүлээн авахаар тооцоолсон дүн, барьцаа хөрөнгө борлуулсан дүнгийн нийлбэрийн зөрүүнээс тооцно.

ЗҮЦХА-г ЧМ, ЧӨД, АХЧ-г ирээдүйн сар бүр болон тусгайлсан эсвэл бүлгийн сегмент бүрээр тесвөлөн тодорхойлдог. Эдгээр гурван үндсэн бүрэлдэхүүнийг хооронд нь үржүүлэн, цаашид эдгээр нь хэвээр үйлчлэх магадлалаар мөн тохируулна (тухайлбал, чанаргүйдэлд ертөх дүн нь ойрын саруудад урьдчилан төлөгдөхгүй эсвэл чанаргүйдэхгүй). Үүгээр ирээдүйн сар бүрээрхи ЗҮЦХА-г тооцох ба тайлагналын өдрөөр үүнийг буцаан дискаунтлан нийлбэрийт нь авдаг. ЗҮЦХА-ийн тооцоололд ашиглагдах дискаунтын хувь нь зээлийн анхны үр ашигт хүүний хувь байх эсвэл түүний ойролцоо хувь байна. Үнэ цэнийн бууралтын зардал болон буцаалт нь санхүүгийн хөрөнгийн дансны үнийн өөрчлөлтийн ашиг, алдагдлын тохируулгаас тусдаа бүртгэгдэх болон толилуулагдана. ЗҮЦХА-ын тооцоллын аргыг доор хураангуйлав:

| | |
|---|---|
| Шатлал 1: | Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА загварын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэглэлийн чанаргүйдлийн үр дүнгээр ЗҮЦХА-ыг илэрхийлнэ. Банк нь ирээдүйн 12 сарын ЗҮЦХА тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор ЧМ-д үндэслэн тооцдог. ЧӨД-ийн урьдчилсан төсөөлөлд 12 сарын дотор хүлээгдэж буй ЧМ-ыг хэрэглэх бөгөөд хүлээгдэж буй АХЧ-аар үржүүлэгдэж анхны үр ашигт хүүтэй ойролцоо дүнгээр хорогдуулна. |
| Шатлал 2: | Зээлийг анх олгосноос хойш тухайн зээлд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлттэй байгаа нь тогтоогдсон зээлүүдэд Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-ын сан байгуулан бүртгэнэ. Санг байгуулахдаа хэд хэдэн хувилбарууд дээр үндэслэн тооцоолох боловч ЧМ болон АХЧ-ыг нь нийт хугацаанд тооцоолж гаргана. Хүлээгдэж буй мөнгөний дутагдалыг үр ашигт хүүтэй ойролцоо хувиар хорогдуулна. |
| Шатлал 3: | Үнэ цэнэ буурсан гэж үзсэн зээлийн хувьд, Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-ыг бүртгэнэ. Энэ ангилал нь Шатлал 2-т ашигласантай ижил ангилалаар тооцогдох бөгөөд ЧМ-ыг 100% гэж үзнэ. |
| Худалдаж авсан болон үүссэн үнэ цэнийн бууралт ("ХАҮҮЦБ") | ХАҮҮЦБ хөренге анх хүлээн зөвшөөрөх үед үнэ цэнэ буурсан санхүүгийн хөренге юм. Банк нь зөвхөн анх хүлээн зөвшөөрсөн үеэс хойшхи магадлалаар жигнэсэн гурван хувилбарыг зээлээр тохируулсан үр ашигт хүүгээр хорогдуулсан хуримтлагдсан нийт хугацааны ЗҮЦХА-г хүлээн зөвшөөрнө. |
| Зээлийн үүрэг болон аккредитив | Зээлийн үүрэгт нийт хугацааны ЗҮЦХА тооцохдоо, Банк нь ирээдүйн олгогдох зээлийн үүргийн дүнг тооцоолно. Зээл олгогдох тохиолдолд ЗҮЦХА нь магадлалаар жигнэсэн гурван хувилбараар хүлээгдэж буй мөнгөний дутагдлын өнөөгийн үнэ цэнээр тооцогдоно. Хүлээгдэж буй мөнгөний дутагдал нь хүлээгдэж буй үр ашигт хүүгээр хорогдуулсан байна.<br>(Зээл болон үүргийг ангуулсан зээлийн картны хувьд, ЗҮЦХА-г зээлтэй нь хамт тооцон, толилуулна.) Зээлийн үүрэг болон аккредитивийн хувьд, ЗҮЦХА нь бусад еглөгт хүлээн зөвшөөрегдөнө. |
| Санхүүгийн баталгааны гэрээнүүд | Банкны санхүүгийн баталгаа тус бүрийн үүрэг нь анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрегдсөн хуримтлагдсан хорогдол хассан дүн болон ЗҮЦХА сангийн аль ихээр нь хэмжигдэнэ. Банк нь ЗҮЦХА-г зээмшигчид нөхөн олгох дүнгийн онөөгийн үнэ цэнэ дээр үндэслэн тооцно. Эрсдлээр тохируулсан хүүгээр дутагдлыг хорогдуулна. Тооцоолол нь магадлалын-жигнэсэн гурван хувилбар дээр хийгдэнэ. Санхүүгийн баталгааны ЗҮЦХА нь бусад еглөгт хүлээн зөвшөөрегдөнө. |



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8966 • 5903858

СЭХ
2021 .11 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

***Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх өрийн хэрэгсэл.*** Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгслийн ЗҮЦХА нь санхүүгийн байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй бөгөөд бодит үнэ цэнэ нь хэвээр үлдэнэ. Үүний оронд, хэрвээ хөрөнгө нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн байсан бол үүсэх үнэ цэнийн бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хуримтлагдсан үнэ цэнийн бууралт гэж бүртгэх ба үр дүнг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ. Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдсэн хуримтлагдсан алдагдлыг хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлын тайланд шилжүүлэн бүртгэнэ.

***Кредит карт ба бусад зээлийн шугамууд.*** Банк харилцагчидлаа төрөл бүрийн байгууллагын болон иргэдийн овердрафт, зээлийн картны бүтээгдэхүүн санал болгодог ба Банк нэг өдрийн өмнө мэдэгдэл өгч уг хэрэгслийг цуцлах, эсвэл зээлийн эрхийн хэмжээг бууруулах эрхтэй. Банк зээлийн алдагдлын эрсдэлийг гэрээний мэдэгдлийн хугацаанаар хязгаарладагтүй бөгөөд харин үйлчүүлэгчдийн зан төлөв, чанартүй болох магадлал болон цаашдын эрсдэлийг бууруулах арга аргачлалууд болох зээлийг цуцлах, зээлийн хэмжээг бууруулах гэх мэт зүйлсүүдийг тусгасан байдаг.

Эдгээр бүтээгдэхүүнүүдийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц ихэссэн эсэх талаархи үнэлгээ нь зээлийн бусад бүтээгдэхүүнүүдийн үнэлгээтэй адил юм. Үнэлгээ нь харилцагчийн дотоод зээлжих зэрэглэлийн өөрчлөлтөд суурилсан боловч тухайн хэрэглэлийн хэрэглээний өөрчлөлт гэх мэт чанарын хүчин зүйлсд мөн гол ач холбогдлыг өгдөг.

Зээлийн карт болон овердрафтын ЗҮЦХА-г дискаунтлахад ашиглах хүүний хувь нь тухайн бүтээгдэхүүнүүдийн нийт ашиглагдах хугацаанд тооцогдох жилийн дундаж үр ашигт хүү байна. Энэхүү тооцоо нь олон зээл сар бүр бүрэн төлөгдөж, дараа сараасаа хүү тооцохгүй байхаар хийгдсэн.

***Ирээдүйн мэдээлэл.*** ЗҮЦХА-ын загвартаа Банк нь доорхи эдийн засгийн өгөгдлүүдийг ирээдүйн мэдээлэл болгон ашигладаг. Үүнд:

- Дотоодын нийт бүтээгдэхүүн (“ДНБ”)
- Ам.долларын ханшийн төсөөлөл
- Экспортын хувь
- Мөнгөний нийлүүлэлт
- Инфляцийн түвшин
- Өрийн зардал
- Ажилгүйдлийн түвшин

ЗҮЦХА-ын тооцоололд ашигласан буй энэхүү мэдээлэл нь санхүүгийн тайлангийн өдрөөрх зах зээлийн бүх шинж чанаруудыг агуулаагүй байх магадлалтай. Үүний нөлөөг тооцоололд тусгахын тулд зарим тохиолдолд, чанарын тохируулгууд болон давхаралуудыг зөрүү материаллаг үед түр тохируулга хийдэг.

***Зээлийн сайжруулалт: Барьцаа хөрөнгийн үнэлгээ болон санхүүгийн баталгаа.*** Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийг бууруулах үүднээс, Банк барьцаа хөрөнгө авдаг. Барьцаа хөрөнгө нь төрөл бүрийн хэлбэрээр байдаг, жишээ нь: мөнгөн хөрөнгө, үнэт цаас, аккредитив болон баталгаа, үл хөдлөх хөрөнгө, авлага, бараа материал, бусад санхүүгийн бус хөрөнгө болон үр дүнгийн тооцооны гэрээ байна. Барьцаа хөрөнгийг зээмшээгүй тохиолдолд Банкны санхүүгийн байдлын тайланд бүртгэхгүй.
Зээлийн сайжруулалтаас хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг, СТОУС-ын дагуу тусад нь хүлээн зөвшөөрөх шаардлагагүй бөгөөд ер төлбөрийн хэрэгслийн гэрээний нөхцлүүдийн салшгүй хэсэг гэж тооцогдог ба зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын хэмжилтэд оруулдаг. Үүний үндсэн дээр барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ нь үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоонд нөлөөлдөг. Барьцаа хөрөнгийг ерөнхийд нь хамгийн багадаа анх хүлээн зөвшөөрөхдөө болон хагас жилийн хугацаанд дахин үнэлдэг.

Боломжийг нэмэгдүүлэх зорилгоор, Банк нь барьцаа хөрөнгийн зорилгоор зээмшиж буй санхүүгийн хөрөнгийг үнэлэхдээ идэвхтэй зах зээлийн мэдээллийг ашигладаг. Идэвхтэй зах зээл дээр аригжаалагддагтүй бусад санхүүгийн хөрөнгийг үнэлгээний арга ашиглан үнэлдэг. Санхүүгийн бус барьцаа хөрөнгийг (жишээ нь: үл хөдлөх хөрөнгө) ипотекийн зуучлагч буюу гуравдагч этгээдээс ирсэн мэдээлэлд эсвэл орон сууцны үнийн индексүүдэд үндэслэн үнэлнэ.

Барьцаалагдсан зээл нь зээлийн гэрээний нөхцөлд тустагдсан эсвэл зээлийн салшгүй хэсэг болох ба зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоонд хамрагдсан болно.

Зээлийн гэрээний нөхцөлтэй холбоогүй баталгааг балансын гадуурх зүйл ангид салангид үзүүлэх бөгөөд үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг хийдэг.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

***Хураан авсан барьцаа хөрөнгө.*** Хураан авсан барьцаа хөрөнгө нь уг хөрөнгийг бүртгэсэн өдрөөрх холбогдох зээлийн үлдэгдлийн хорогдуулсан ертөг болоп бодит үнэ цэнээс борлуулах ертгийг хассан дүнгийн аль багаар анхлан хүлээн зөвшөөрдөг ба холбогдох зээл болон урьдчилгаа мөн тэдгээрийн үнэ цэнийн бууралтын санг балансын бүртгэлээс хасдаг. Дараагийн тайлант үеүдэд, хураан авсан барьцаа хөрөнгийг ертөг болон бодит үнэ цэнээс түүний борлуулахтай холбоотой гарах зардлыг хассан дүнгийн аль багаар бүртгэдэг ба эдгээр хөрөнгүүд нь тайлагд бусад хөрөнгө хэсэгт тайлагнагддаг.

Борлуулах зориулалттай хөрөнгийн ангилалын шалгуур нь зөвхөн борлуулах өндөр магадлалтай байх бөгөөд хөрөнгийг одоогийн нөхцөлд нь шууд борлуулах боломжтой тохиолдолд л энэхүү шаардлагыг хангадсан гэж үзнэ. Тухайн хөрөнгийн борлуулах шийдвэр нь бүцаагүй байх эсвэл борлуулахад ямар нэгэн өөрчлөлт орох эсэхээс хамааран борлуулах үйл ажиллагаа нь тодорхойлогдоно. Удирдлага нь хөрөнгийг зарах төлөвлөгөөтэй байх шаардлагатай бөгөөд, ангилал хийсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд борлуулахаар төлөвлөж байх ёстой.

Борлуулах зориулалттай хөрөнгө гэж ангилсны дараа эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн элэгдлийг тооцохгүй. Худалдах зориулалттай гэж ангилагдсан хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн зүйл болгон тусад нь үзүүлнэ. Нэмэлт тодруулгыг Тодруулга 18-д тусгасан болно.

***Данснаас хасах.*** Банк нь хөрөнгийн эргэн төлөлтийг зогсоосон үед санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн данснаас хасна. Хэрэв данснаас хасах үнэ хуримтлагдсан алдагдлаас их тохиолдолд, зөрүүгээр нь алдагдлыг нэмэгдүүлж дараа нь данснь нийт үнийн дүнг бууруулна. Дараах үеийн эргэн төлөлтүүд нь зээлийн алдагдлын зардлыг бууруулна.

***Гэрээний нөхцөлд оөрчлөлт орсон зээлүүд.*** Банк заримдаа барьцаа хөрөнгийг хураах гэхээсээ илүү зээлдэгчийн санхүүгийн хүндрэлийн үзмвас зээлийн анхны нөхцөлд хөнгөлөлт, өөрчлөлт оруулдаг.

Зээлдэгчийн одоогийн эсвэл хүлээгдэж буй санхүүгийн хүндрэлээс үүдэн хөнгөлөлт, өөрчлөлтийг Банк хийж болно гэж үздэг бөгөөд зээлдэгч санхүүгийн хувьд хэвийн байсан бол Банк энэхүү хөнгөлөлт, өөрчлөлтийг зөвшөөрөхгүй болно. Санхүүгийн хүндрэлийг харуулсан үзүүлэлтүүд нь Гэрээг биелүүлээгүй байх эсвэл Зах зээл болон Зээлийн Эрсдэлийн хэлтэсээс гаргасан үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно. Энэхүү өөрчлөлтүүдэд төлбөрийн хугацаг сунгах, зээлийн шинэ нөхцлийг зөвшөөрөх зэрэг орно. Гэрээний нөхцөл өөрчлөгдсөний дараа аливаа үнэ цэнийн бууралтыг тооцохдоо өөрчлөлтөөс өмнө тооцоолсон анхны үр ашгит хүүг ашиглан хэмжинэ. Шинэчилсэн зээлийн ирээдүйн төлбөрийг үргэлжлэх боломжтой гэдгийг хянах нь Банкны бодлого юм.

Зээлийг дахин тохируулж, өөрчилсөн болович хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд зээлийн эрсдэл ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн гэж үздэг тул зээлийг 2-р шатанд ангилдаг. Хөрөнгө нь 2-р шатанд ангилагдсаны дараа зөвхөн дараах шалгууруудыг хангаж байж тодорхой төрөлд ангилагдах боломжтой:

- Бүх зээлүүд нь хэвийн байх ёстой
- Шинэчилсэн төлбөрийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу зургаан сарын хугацаанд тогтмол төлбөрийг хийсэн байх
- Үйлчлүүлэгч хугацаа нь 30 хоногоос хэтэрсэн ямар ч гэрээ байгуулаагүй байх

Шинэчлэгдсэн буюу Өөрчлөлт орсон хөрөнгийн талаархи мэдээллийг 29-р тодруулгад тусгасан болно.

**Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгөн гүйлгээний тайланд заасняар бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд касс дахь мөнгө, Монголбанкин дахь хязгаарлалтгүй харилцах данс, Засгийн газрын үнэт цаас болон бусад Банкин дахь харилцах ба 3 сар түүнээс бага хугацаатай хадгаламжууд орно.

***Төв Банкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн үлдэгдэл.*** Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн үлдэгдлийг хорогдуулсан өртгөөр бүртгэх бөгөөд Банкны өдөр тутмын үйл ажиллагаг санхүүжүүлэхэд ашиглах боломжгүй, заавал байлгах нөөцийн хүүгүй хадгаламж тул үүнийг мөнгөн гүйлгээний тайлан дахь мөлгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

**Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг түрээсийн орлого олох болон үнийн өсөлтөөс ашиг олох зорилгоор эзэмшдэг. Хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь Банкинд орж ирэх нь магадлалтай болсон үед л хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг. Хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа болох 25 жилийн туршид шулуун шугамын аргаар тооцно.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

ХЭХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (үргэлжлэл)**

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед данснаас хасна. Үүнтэй холбоотойгоор үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Хөрөнгийн худалдан борлуулах үнийн тодорхойлохдоо Банк нь мөнгөн-бус төлбөр, худалдан авагчид өгөх өглөг зэрэг хөрөнгийг борлуулах санхүүгийн хүчин зүйлсийг тусган тодорхойлдог.

Хэрэв хөрөнгийн зориулалтад өөрчлөлт орсон бол хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс/-д шилжүүлдэг. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс Банкны түрээслүүлдэгүй үндсэн хөрөнгөд шилжүүлвэл, хүлээн зөвшөөрөх ертөг нь хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх өдрийн бодит үнэ цэнээр тодорхойлогдоно. Хэрэв банкны үндсэн хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөд шилжвэл, Банк нь тухайн өдрөөр дагаж мөрдөж буй Үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хүлээн зөвшөөрнө.

**Үндсэн хөрөнгө**

Барилга болон газраас бусад үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртгийг тухай бүрт нь энэ өртөгт оруулна. Үндсэн хөрөнгийн томоохон хэсгийг үе шаттайгаар солих шаардлагатай болсон үед Банк нь иймэрхэсгүүдийг тусдаа ашиглалтын хугацаа, элэгдэлтэй бие даасан хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Үүнтэй адил, үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан бол үндсэн хяналт хийх үед түүний өртгийг үндсэн хөрөнгийн бүртгэлийн дүнд оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Хүлээн зөвшөөрснийдараах үед үндсэн хөрөнгүүд нь хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцно:

| Хөрөнгө | Ашиглалтын хугацаа |
|---|---|
| Барилга | 25 |
| Тоног төхөөрөмж | 10 |
| Оффисын тавилга | 10 |
| Тээврийн хэрэгсэл | 10 |
| Компьютер | 2 – 10 |

Үндсэн хөрөнгө ба түүний томоохон хэсгүүдийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед данснаас хасна. Үүнтэй холбоотойгоор үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

**Түрээс**

Банк нь гэрээ байгуулагдах үед түрээсийн шинж чанар агуулсан эсэхийг үнэлдэг. Өөрөөр хэлбэл гэрээнд тодорхойлогдож байгаа хөрөнгийг хэсэг хугацааны турш ашиглан хянах эрхийг шилжүүлсэн болно.

***Банк - Түрээслэгч.*** Банк нь богино хугацаатай түрээс эсвэл бага өртөгтэй хөрөнгийг түрээслэхээс бусад тохиолдолд бүх түрээсийг хүлээн зөвшөөрөх, хэмжих нэг аргыг ашигладаг. Банк нь түрээсийг төлөх түрээсийн өр төлбөрийг болон хөрөнгийг ашиглах эрхийг хүлээн зөвшөөрдөг.

*Ашиглах эрхтэй хөрөнгө.* Банк нь ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрдөг (жишээлбэл, үндсэн хөрөнгийг ашиглах боломжтой болсон өдөр). Ашиглах эрхтэй хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасч өртгөөр нь хэмжиж, түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт түрээсийн өр төлбөр, хүлээн авсан түрээсийн эхний өртөг, түрээсийн урамшууллыг авалгүйгээр эхлэхээс өмнө хийсэн түрээсийн төлбөр орно. Ашиглах эрхтэй эд хөрөнгийг түрээсийн хугацаанд шулуун шугамын дагуу элэгдэлд оруулдаг. Ашиглах эрх нь тодруулга 20-т тусгагдсан бөгөөд Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэ цэнийн бууралтын үнэлгээ хийгдэнэ.



БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
MICC

СЗХ
ХҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Түрээс (үргэлжлэл)**

*Түрээсийн өр төлбөр.* Түрээсийн эхлэх өдөр Банк нь түрээсийн хугацаанд хийгдэх түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөрт тогтмол төлбөр (түрээсийн урамшууллыг авааруй), индекс эсвэл хувь хэмжээнээс хамаарах хувьсах түрээсийн төлбөрүүд, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөх хүлээгдэж буй төлбөрүүд орно. Индекс эсвэл хувь хэмжээнээс хамаарагүй хувьсах түрээсийн төлбөрийг дэмжих үйл явдал, нөхцөл байдлын үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө.

*Банк - түрээслүүлэгч.* Түрээсийн хөрөнгийн бүх эрсдэл ба өгөөжийн их хэмжээгээр шилжүүлээгүй түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилдаг. Түрээсийн орлого нь түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар ашиг алдагдлын тайлангийн бусад орлогод хүлээн зөвшөөрөгдөнө. Үйл ажиллагааны түрээсийг тохиролцох, зохицуулахтай холбоотой анхны шууд зардлыг түрээсэлсэн хөрөнгийн дансанд нэмж, түрээсийн хугацаанд орлоготой адил зарчмаар бүртгэнэ. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн хугацаанд бусад орлогод хүлээн зөвшөөрнө.

**Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгөд компьютерийн программ хангамж орно.

Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь Банкинд орж ирэх нь магадлалтай болсон үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Түсад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.
Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашиггай байх хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулах хугацаа болон аргыг хэмгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг.

Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө. Биет бус хөрөнгийн өртгийг 3-10 жилийн ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна.

**Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайланг хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд хамгийзх эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараах бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно. Үнэлгээний үржүүлэгч, нийтэд хувьцаагаа зардаг охин компанийн хөрөнгийн биржээрх хувьцааны үнэ эсвэл бодит үнэ цэнийн бусад үзүүлэлтүүдээр эдгээр тооцооллыг хэмжиж болно.

Гүүдвиллээс бусад хөрөнгүүд дээр, тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл Банк нь тухайн хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн нөхөн төлөгдөх дүнг ойролцоогоор тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Буцаалт нь хязгаартай байх ба ингэснээр хөрөнгийн бүртгэлийн дүн нь цуглуулан авах дүн ба өмнөх жилүүдэд хөрөнгийн үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.



БОГД БАНК ХХК
БӨГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ2866 ... 3903859

MCC

375

СЗХ
2021 -11- 10
БҮРТГЭВ
№ 01



**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Ажиллагсдын тэтгэмж**

*Богино хугацаат тэтгэмж.* Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад эзлэжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд евчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

*Заавал төлөх даатгалын шимтгэлүүд.* Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдлын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

**Нөөц**

Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа энэхүү үүргээ бислүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө. Меңгөний шаг хугацааны үнэ цэнэ материаллаг нөлөөтэй байх үед Банк нь тухайн өглөгтэй холбогдох хүүний түвшинг татварын өмнөх түвшинд тохируулж дискаунтлах замаар нөөцийн хэмжээг тодорхойлно. Аливаа нэг нөөцтэй холбоотой зардлыг ашиг, алдагдлаар аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь бусад үйл ажиллагааны зардалд толилуулна.

**Татвар**

*Тайлант хугацааны орлогын албан татвар.* Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар Банкны үйл ажиллагаагаа явуулж буй улсад хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Эздийн өмч ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн зүйлтэй холбоотой тайлант хугацааны орлогын албан татвар нь ашиг алдагдлын тайланд бус эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тухайлан хүлээн зөвшөөрөгдөнө. Удирдлага нь татварын тайланд тусгасан өөрийн байр суурийг үе үе үнэлж, тайлбар тодруулга шаардлагатай холбогдох татварын зохицуулалтыг харгалзан үздэг.

*Хойшлуулсан татвар.* Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан гэнцийн аргыг хэрэглэн тооцдог.
Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөр нь түүдвилгээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол.
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүүний буцаалт нь ойрын ирээдүйд арилахгүй ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлалгүй байгаа бол

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

Өөрийн хөрөнгөнд шууд хүлээн зөвшөөрсөн зүйлүүдтэй холбоотой тайлант жилийн болон хойшлуулсан татваруудыг мөн өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрөх ба ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрехгүй.

Нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2021 . 11 - 10
БҮРТГЭВ
№ 31



Үнэт цаасны танилцуулга

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021 -11- 03
БҮРТГЭВ-03



**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)**

**Өөрийн хөрөнгө**

*Энгийн хувьцаа.* Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөд ангилна. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэгдэл зардлыг хувьцаа гаргасан орлогоос татварыг хассаны дараах байдлаар өөрийн хөрөнгийг хорогдуулах байдлаар толилуулна.

*Хуримтлагдсан ашиг.* Хуримтлагдсан ашиг нь зарласан погдол ашгаар буурдаг хуримтлагдсан ашиг, алдагдлыг илэрхийлнэ. Үүнд мөн нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн нөлөө, өмнөх тайлант үеийн залруулга багтана.

*Бусад нөөц.* Бодит үнэ цэнийн нөөц нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд-д ангилагдсан өрийн хэрэгслийн бодит үнийн хуримтлагдсан цэвэр өөрчлөлт, хүлээгдэж буй алдагдалыг хассан дүнгээр, өмчийн хэрэгслийн бодит үнийн хуримтлагдсан цэвэр өөрчлөлтөөс бүрдэнэ.

**Холбоотой талуудын ажил гүйлгээ**
Холбоотой талууд гэдэгт Банктай дараах байдлаар холбогдсон аж ахуйн нэгж болон хувь хүн орно. Үүнд:

Банктай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:
(i) Банкинд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
(ii) Банкинд томоохон нөлөөлөлтэй эсвэл;
(iii) Банкны гол удирдах албан тушаалтнуудын нэг.

Дараах нөхцүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуйн нэгж нь Банкинд хамааралтай болно. Үүнд:
(i) Аж ахуйн нэгж болон Банкны нэг ижил Группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
(ii) Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуйн нэгж нь гишүүн болох Банкны хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
(iii) Аль аль аж ахуйн нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
(iv) Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани.
(v) Аж ахуйн нэгж нь Банкны эсвэл Банктай холбоотой аж ахуйн нэгжийн ажилчагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлттийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Банк нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажилчагсад нь мөн Банктай холбоотой тал болно.
(vi) Аж ахуйн нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
(vii) (в)(i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл аж ахуйн нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
(viii) Аж ахуйн нэгж нь эсвэл Банкны аль нэг гишүүн эсвэл Банкны толгой компанид гол удирдах албан тушаалтай.

Холбоотой талуудтай хийсэн бүх материаллаг ажил гүйлгээ болон үлдэгдлийг санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудад тодруулсан бөгөөд дэлгэрэнгүй тодруулга 31-с харна уу.

**2.5 СТОУС-ын анхлан хэрэгжүүлэлт**

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн энэхүү санхүүгийн тайлан нь Банкны СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн анхны тайлан юм. 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу бэлтгэсэн.

Иймд Банк СТОУС 1-ийг хэрэгжүүлж 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх харьцуулсан үзүүлэлтүүдийг нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудад тодорхойлсноор СТОУС-ын дагуу бэлтгэв. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ СТОУС-д анх шилжсэн өдөр болох 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр Банкны санхүүгийн байдлын тайлангийн эхлэлтийн балансыг бэлтгэв. Энэхүү тодруулгад тайлан бэлтгэх үндэслэлийн дагуу өмнөх жилүүдэд бэлтгэсэн Банкны 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлангуудыг дахин толилуулахад хийсэн гол залруулгуудыг тайлбарлав.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТБ0946...5003858



MICC

СЭХ
БУРТГЭВ
2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.5 СТОУС-ын анхлан хэрэгжүүлэлт (үргэлжлэл)**

Санхүүгийн байдлын тайлангийн тохируулга - 2019 оны 1 дүгээр сарын 1-нээр (СТОУС-т шилжсэн өдөр):

| | Тодруулга | СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас батлсан заавар, журмын дагуу мянга.төг | Дахин хэмжилт мян.төг | Дахин ангилал* мян.төг | СТОУС-ын дагуу мян.төг |
|---|---|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | б | 7,441,692 | (16,102) | 76,080,001 | 83,505,591 |
| Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | б | 17,006,309 | (39,249) | (1,607,269) | 15,359,791 |
| Репо хэлцэл | | 19,993,976 | – | (19,993,976) | – |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн | | 13,246,023 | (13,246,023) | – | – |
| *Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөрүү* | а, б | – | 13,246,023 | 246,588 | 13,492,611 |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт - дуусгавар хугацаа хүртэл эзэмших | | 58,744,869 | (5,402,127) | (53,342,742) | – |
| *Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэрэгслүүрүү* | а, б | – | 5,380,231 | (246,588) | 5,133,643 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | | 5,951 | – | – | 5,951 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | б | 53,501,467 | 217,776 | 508,956 | 54,228,199 |
| Бусад хөрөнгө | | 4,374,101 | - | (898,181) | 3,475,920 |
| Хөрөнгө оруулалтын зорилгоор эзэмшлийн хөрөнгө | | 3,852,421 | – | – | 3,852,421 |
| Үндсэн хөрөнгө | | 1,899,605 | – | (107,007) | 1,792,598 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | в | – | 1,791,945 | – | 1,791,945 |
| Биет бус хөрөнгө | | 898,098 | – | (639,782) | 258,316 |
| **Нийт хөрөнгө** | | **180,964,422** | **1,932,474** | **–** | **182,896,896** |
| **Өр төлбөр** | | | | | |
| Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | | 31,106,211 | – | 29,919,056 | 61,025,267 |
| Репо хэлцэл | | 22,986,145 | – | 6,928 | 22,993,073 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | 38,827,592 | – | 2,165,129 | 40,992,721 |
| Зээлээр авсан эх үүсвэр | | 29,748,968 | – | (29,748,968) | – |
| Баталгаа | | 1,784,013 | – | (1,784,013) | – |
| Бусад өр төлбөр | б, г | 4,610,247 | 109,917 | (558,132) | 4,162,032 |
| Түрээсийн өр төлбөр | в | – | 1,791,945 | – | 1,791,945 |
| | | **129,063,176** | **1,901,862** | **-** | **130,965,038** |
| **Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох өөрийн хөрөнгө** | | | | | |
| Энгийн хувьцаа | | 50,000,000 | – | – | 50,000,000 |
| Бусад нөөц | б | (286,995) | 78,863 | – | (208,132) |
| Хуримтлагдсан ашиг | б, г | 2,188,241 | (48,251) | – | 2,139,990 |
| | | **51,901,246** | **30,612** | **–** | **51,931,858** |
| **Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө** | | **180,964,422** | **1,932,474** | **–** | **182,896,896** |

*Өмнөх жилийн эцэст дуусч тайлан жилийн төгсгөлд үлдэгдэлтэй дахин ангилсан.

БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**

**2.5 СТОУС-ын анхлан хэрэгжүүлэлт (үргэлжлэл)**

Санхүүгийн байдлын тайлангийн тохируулга - 2019 оны 12 дугаар сарын 31-нээр

| | Тодруулга | СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас батлагдсан журам, журмын дагуу мян.төг | Дахин хэмжилт мян.төг | Дахин ангилал* мян.төг | СТОУС-ын дагуу мян.төг |
|---|---|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | б | 54,853,711 | (17,575) | 44,848,211 | 99,684,347 |
| Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | б | 30,981,673 | (184,189) | 179,346 | 30,976,830 |
| Репо хэлцэл | | 8,994,579 | – | (8,994,579) | – |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн | | 57,759,085 | (22,359,779) | (35,399,306) | – |
| *Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдах өөрийн хөрөнгөөрөө* | а | – | 20,874,779 | – | 20,874,779 |
| *Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд тусгагдах анхнаас хөрөнгөөрөө* | а | – | 1,485,000 | – | 1,485,000 |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт - дуусгавар хугацаа хүртэл эзэмших | | 2,020,277 | (2,063,465) | 43,188 | – |
| *Хорогдуулах өртөөр хэмжих өөрийн хөрөнгөөрөө* | а | – | 2,052,617 | – | 2,052,617 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | б | 82,332,663 | 508,661 | (4,330,839) | 78,510,485 |
| *Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөрөө* | | – | – | 5,197,489 | 5,197,489 |
| Бусад хөрөнгө | б | 4,841,563 | (417,720) | (1,519,660) | 2,904,183 |
| Хөрөнгө оруулалтын зорилгоор эзэмшиж буй хөрөнгө | | 3,753,641 | – | – | 3,753,641 |
| Үндсэн хөрөнгө | | 2,435,519 | – | (40,828) | 2,394,691 |
| Аппидах эрхтэй хөрөнгө | в | – | 2,693,246 | – | 2,693,246 |
| Биет бус хөрөнгө | | 851,571 | – | (47,465) | 804,106 |
| **Нийт хөрөнгө** | | **248,824,282** | **2,571,575** | **(64,443)** | **251,331,414** |
| **Өр төлбөр** | | | | | |
| Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | | 58,170,622 | – | 31,452,615 | 89,623,237 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | 93,256,516 | – | 1,484,284 | 94,740,800 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | | 5,653 | – | – | 5,653 |
| Зээлээр авсан эх үүсвэр | | 38,889,715 | – | (29,626,665) | 9,263,050 |
| Батлагаа | | 610,548 | – | (610,548) | – |
| Бусад өр төлбөр | б, г | 3,125,680 | 324,657 | (2,776,077) | 674,260 |
| Түрээсийн өр төлбөр | в | – | 2,545,505 | – | 2,545,505 |
| Орлогын албан татварын өглөг | | – | – | 11,948 | 11,948 |
| | | **194,058,734** | **2,870,162** | **(64,443)** | **196,864,453** |
| **Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох өөрийн хөрөнгө** | | | | | |
| Энгийн хувьцаа | | 50,000,000 | – | – | 50,000,000 |
| Бусад нөөц | б | (345,790) | 102,710 | – | (243,080) |
| Хуримтлагдсан ашиг | б, в, г | 5,111,338 | (401,297) | – | 4,710,041 |
| | | 54,765,548 | (298,587) | – | 54,466,961 |
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**20. Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөр (үргэлжлэл)**

Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөрийн дансны дүн ба тайлант жилийн хөдөлгөөнийг дор харуулав:

| | Ашиглах эрхтэй хөрөнгө мян.төг | Түрээсийн өр төлбөр мян.төг |
|---|---|---|
| **2019 оны 1 сарын 1-нээр** | 1,791,945 | 1,791,945 |
| Нэмэгдсэн | 1,205,275 | 938,874 |
| Тайлант жилийн элэгдэл (Тод.10) | (303,974) | – |
| Хүүний зардал (Тод.5) | – | 363,640 |
| Түрээсийн төлбөр | – | (548,954) |
| 2019 оны 12 сарын 31 | **2,693,246** | **2,545,505** |
| Нэмэгдсэн | – | – |
| Тайлант жилийн элэгдэл (Тод.10) | (423,712) | – |
| Хүүний зардал (Тод.5) | – | 394,619 |
| КОВИД-19 холбоотой хөнгөлөлт (Тод.8) | – | (38,553) |
| Түрээсийн төлбөр | – | (608,851) |
| **2020 оны 12 сарын 31** | **2,269,534** | **2,292,720** |

Банк нь Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлөөс гаргасан практик зөвлөмжийг хэрэгжүүлж, түрээсийн хөнгөлөлт гэж Ковид-19 тахлын шууд үр дагавар болох түрээсийн хөнгөлөлтийг тооцоогүй болно. Үүний оронд Банк эдгээр хөнгөлөлтийг 2021 оны 12-р сарын 31-нээрх жилийн ашиг, алдагдалд тусгасан болно. Дараах нөхцлүүд хэрэгжсэн тохиолдолд практик үр дүнг ашиглаж болно.
- Өөрчлөгдсөн түрээсийн төлбөр нь түрээсийн хөнгөлөлт үзүүлэхээс өмнөх төлбөртэй бараг ижил буюу бага байсан;
- Бууралт нь зөвхөн 2021 оны 6-р сарын 30-наас өмнө төлөх төлбөрт хамаарна; болон
- Түрээсийн гэрээний нөхцлүүдэд өөрчлөлт ороогүй байх.

**21. Бичиг бус хөрөнгө**

| | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|
| **Өртгөөр** | | |
| 1 дүгээр сарын 1 | 1,316,966 | 584,986 |
| Нэмэгдсэн | 188,842 | 731,980 |
| Данснаас хассан | (25,069) | – |
| 12 сарын 31 | 1,480,739 | 1,316,966 |
| **Хуримтлагдсан хорогдуулалт** | | |
| 1 дүгээр сарын 1-ээр | 512,860 | 326,670 |
| Тайлант жилд байгуулсан (Тодруулга 10) | 185,893 | 186,190 |
| Данснаас хассан | (25,069) | – |
| 12 сарын 31 | 673,684 | 512,860 |
| **Цэвэр дансны үнэ** | **807,055** | **804,106** |

**22. Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж**

| | 2020 мян.төг | 2019 мян.төг | 2019 оны 1 сарын 1 мян.төг |
|---|---|---|---|
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах данс | – | 4,999,791 | 31,141,818 |
| Банк санхүүгийн байгууллагын хугацаат хадгаламж | 27,048,795 | 54,731,031 | – |
| Хадгаламжийн Даатгалын Корпорацаас байршуулсан хөрөнгө сруулалтын эх үүсвэр | – | 29,892,415 | 29,883,449 |
| | **27,048,795** | **89,623,237** | **61,025,267** |



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 31
2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**22. Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж (үргэлжлэл)**

2020 оны 12-р сарын 31-ийн өдрөөрх бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжид дотоод аргажаны банк болон бусад санхүүгийн байгууллагуудын харилцах данснь болон хугацаат хадгаламжийн данснуг оруулсан. 2019 болон 2018 оны 12-р сарын 31-ээр Банк нь Хадгаламжийн Даатгалын Корпорацид Төв банкны үнэт цаас авч огох зуучлалын гэрээтэй байсан. Хугацаатай хадгаламж жилийн 1% - 12.5% (2019: 5% - 11.75%) хүүтэй, 2-оос 31 хүртэлх хоногийн (2019: 3-365) хугацаатай байна

**23. Репо хэлцэл**

| | 2020 мян.төг | 2019 мян.төг | 2019 оны 1 сарын 1 мян.төг |
|---|---|---|---|
| Монгол Улсын Хөгжлийн Банк | 14,992,608 | – | 9,993,976 |
| Монгол Банк | 10,056,265 | – | – |
| Бусад банк, санхүүгийн байгууллага | – | – | 12,999,097 |
| | **25,048,873** | – | **22,993,073** |

Банк нь 2020 оны 12-р сарын 31-ээр Монголбанктай урт хугацаат бууцаж худалдан авах нөхцөлтэй гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний барьцаанд 2021 оны 1-р сарын 18-д дуусах 10,096,000 мянган төгрөгийн Төв банкны үнэт цаас (Тод.12) байршуулсан байна. Түүнчлэн, Банк нь Монгол Улсын Хөгжлийн банктай төв банкны үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй богино хугацаатай хоёр гэрээ байгуулсан. Энэхүү хоёр гэрээний нийт дүн нь 15,000,000 мянган төгрөг (Тод.12) бөгөөд жилийн 6% хүүтэй, 2021 оны 1-р сарын 4-д хугацаа нь дуусна.

**24. Харилцагчдын харилцах, хадгаламж**

| | 2020 мян.төг | 2019 мян.төг | 2019 оны 1 сарын 1 мян.төг |
|---|---|---|---|
| **Засгийн газар** | | | |
| - Хугацаагүй хадгаламж | 20,244,296 | – | – |
| - Харилцах данс | 3,532,550 | 30,862,790 | 10,543,465 |
| **Хувийн сектор** | | | |
| - Хугацаат хадгаламж | 13,963,754 | 7,630,492 | 6,550,000 |
| - Харилцах данс | 12,518,869 | 29,043,905 | 7,480,365 |
| - Баталгааны эх үүсвэр | 4,252,045 | 610,548 | 1,784,013 |
| - Хугацаагүй хадгаламж | 1,110,761 | – | – |
| **Иргэд** | | | |
| - Хугацаат хадгаламж | 39,259,382 | 20,877,545 | 172,907 |
| - Харилцах данс | 3,662,655 | 5,455,297 | 14,458,203 |
| - Хугацаагүй хадгаламж | 2,130,215 | 260,223 | 3,768 |
| | **100,674,527** | **94,740,800** | **40,992,721** |

**25. Зээлээр авсан эх үүсвэр**

| | Хүү /жилийн/ | Дуусах огноо | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|---|---|
| **Гадаадын банк санхүүгийн байгууллагаас зээлээр авсан санхүүжилт** | | | | |
| Өвөр Монголын банк | 7% | 1/8/2021 | 4,489,813 | 3,949,230 |
| **Төрийн байгууллагаас зээлээр авсан санхүүжилт** | | | | |
| Монголбанк - Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр | 1% - 4% | 7/31/2021 | 2,641,166 | 3,787,467 |
| Сангийн яам - Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр | 4% | 8/2/2021 | 243,753 | 1,526,353 |
| Ажлын байр нэмэгдүүлэх төсөл | 7% | 7/1/2022 | 90,000 | – |
| | | | **7,464,732** | **9,263,050** |

Дээрх эх үүсвэрүүд нь барьцаагүй болно. 2021 онд Өвөр Монголын Банкнаас авсан зээлийн хугацаа дууссн, бүрэн төлөгдсөн болно.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТТӨ8966 - 5903858
396

СЗХ
2021 -11- 10
БҮРТГЭВ
№ 01

2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**26. Бусад өр төлбөр**

| | 2020 мян.төг | 2019 мян.төг | 2019 оны 1 сарын 1 мян.төг |
|---|---|---|---|
| **Бусад санхүүгийн өр төлбөр** | | | |
| Клирингийн түр саатал | 34,062 | 100,751 | 3,964,770 |
| Компанидад өгөх өглөг | 116,207 | 94,613 | 63,077 |
| Тэнцлийн гадуурх үүргийн эрсдэлийн сан (Тод.28) | 9,088 | 2,315 | 369 |
| | 159,357 | 197,679 | 4,028,216 |
| **Бусад санхүүгийн бус өр төлбөр** | | | |
| Орлогын албан татварас бусад татварын өглөг | 410,792 | 64,351 | 14,376 |
| Бусад | 364,566 | 412,230 | 119,440 |
| | 775,358 | 476,581 | 133,816 |
| **Нийт бусад өр төлбөр** | **934,715** | **674,260** | **4,162,032** |

Клирингийн түр саатал нь бэлэн мөнгө болон төлбөр тооцооноос үүдэлтэй өглөг бөгөөд дараагийн ажлын өдөрт бүрэн төлөгддөг

**27. Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох өөрийн хөрөнгө**

**Энгийн хувьцаа**

| | 2020 | 2019 | 2019 оны 1 сарын 1 |
|---|---|---|---|
| Нэг бүр нь 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй энгийн хувьцааны тоо | 50,000 | 50,000 | 50,000 |
| Дүн (мянгачилсан) | 50,000,000 | 50,000,000 | 50,000,000 |

Монголбанкны ерөнхийлөгчийн А-276 тоот тушаалаар арилжааны банкуудын дүрмийн санг 2021 оны 12 сарын 31-ний өдөр хамгийн багадаа 100 тэрбум төгрөгт хүргэх шаардлага тавигдсан.

Банк нь 2020, 2019 онд ногдол ашиг хуваарилаагүй.

**Бусад нөөц**

| | Өмчийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн нөөц мян.төг | Өрийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн нөөц мян.төг | Журмын сан мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|
| **2020 оны 1-р сарын 1** | – | (243,080) | – | (243,080) |
| Бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт (Тод.14) | 500,000 | 408,111 | – | 908,111 |
| Борлуулалтаас ашиг, алдагдал руу шилжүүлсэн | – | 345,788 | – | 345,788 |
| Хүлээгдэж буй алдагдлын сан (Тод.9, 14) | – | (37,638) | – | (37,638) |
| Журмын сангийн цэвэр өөрчлөлт | – | – | 68,010 | 68,010 |
| **2020 оны 12-р сарын 31** | **500,000** | **473,181** | **68,010** | **1,041,191** |
| **2019 оны 1-р сарын 1** | – | (208,132) | – | (208,132) |
| Бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт | – | (186,882) | – | (186,882) |
| Борлуулалтаас ашиг, алдагдал руу шилжүүлсэн | – | 128,087 | – | 128,087 |
| Хүлээгдэж буй алдагдлын сан (Тод.9) | | 23,847 | | 23,847 |
| **2019 оны 12-р сарын 31** | **–** | **(243,080)** | **–** | **(243,080)** |

Журмын сан нь СТОУС 9 -ийн дагуу байгуулсан эрсдэлийн сан дээр нэмэлтээр Монголбанкны эрсдэлийн сан байгуулах журмын дагуу байгуулсан сан юм.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
7758966 ▲ 5903858

МСС

СЗХ
2021 -11- 10
БҮРТГЭВ
№ 31

2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**28. Болзошгүй өр төлбөр ба үүрэг**

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд, Банк нь төрөл бүрийн буцалтгүй үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд тусгагүй байж болох ч, эдгээр нь зээлийн эрсдэл, улмаар Банкны нийт эрсдэлийг бүрдүүлж байдаг.

| | 2020<br>мян.төг | 2019<br>мян.төг |
|---|---|---|
| **Зээлтэй холбоотой болзошгүй өр төлбөр ба үүрэг** | | |
| Эх үүсвэргүй баталгаа | 16,853,114 | 9,133,389 |
| Кредит картын ашиглагдаагүй үлдэгдэл | 108,251 | 83,245 |
| | **16,961,365** | **9,216,634** |
| **Хөрөнгөтэй холбоотой үүрэг** | | |
| Үндсэн хөрөнгө | 56,289 | 7,070 |

Доорх хүснэгтэд зээлийн чанар, Банкны дотоод үнэлгээний систем дээр үндэслэсэн зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлыг агуулсан зээлийн эрсдэлийн хамгийн их хэмжээ болон жишиг эцсийн ангиллыг харуулав. Зээлтэй холбоотой болзошгүй өр төлбөр ба үүргийн чанар 2020, 2019 онуудад "маш сайн" ангилалд байсан.

**Тэнцлийн гадуурх өр төлбөр ба хүлээж болзошгүй үүргийн үнэ цэнийн бууралтын сан**

| | Баталгаа<br>Шатлал 1<br>мян.төг | Олгогдоогүй кредит карт<br>Шатлал 1<br>мян.төг | Нийт<br>Шатлал 1<br>мян.төг |
|---|---|---|---|
| 2020 оны 1 сарын 1-ээрх дансны дүн | 9,133,389 | 83,245 | 9,216,634 |
| Нэмэгдсэн | 15,967,589 | 3,923,657 | 19,802,046 |
| Хасагдсан | (8,247,864) | (3,898,651) | (12,057,315) |
| 2020 оны 12 сарын 31 | **16,853,114** | **108,251** | **16,961,365** |
| 2020 оны 1 сарын 1-ээрх ЗҮЦХА-н сан | – | 2,315 | 2,315 |
| Тайлант жилд байгуулсан (Тод.9) | 1,490 | 5,283 | 6,773 |
| 2020 оны 12 сарын 31 (Тод.26) | **1,490** | **7,598** | **9,088** |
| 2019 оны 1 сарын 1-ээрх дансны дүн | 1,593,382 | 25,380 | 1,618,762 |
| Нэмэгдсэн | 8,575,510 | 1,270,216 | 9,845,726 |
| Хасагдсан | (1,035,503) | (1,212,351) | (2,247,854) |
| 2019 оны 12 сарын 31 | **9,133,389** | **83,245** | **9,216,634** |
| 2019 оны 1 сарын 1-ээрх ЗҮЦХА-н сан | 369 | – | 369 |
| Тайлант жилд байгуулсан/(буцаасан) (Тод.9) | (369) | 2,315 | 1,946 |
| 2019 оны 12 сарын 31 (Тод.26) | – | **2,315** | **2,315** |

**Болзошгүй өр төлбөр**

Баталгаа нь тендер гэх мэт тодорхой үйл явдалтай холбоотойгоор харилцагчийн өмнөөс төлбөр хийх үүргийг Банкинд ногдуулдаг. Баталгаа нь хэдийгээр болзошгүй шинж чанартай ч зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг болно. Эдгээр гүйлгээнүүдийн улмаас материаллаг алдагдал гарахгүй гэсэн хүлээлттэй байна.

**Үүрэг**

Үүрэг гэдэг нь Банкны зүгээс зээл олгох гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байхад тус үүргийн хугацаа нь дуусаж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйд гарч болох мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн үг биш юм.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2021 .11.10
БҮРТГЭВ
№ 31

2021 -11- 03
БҮРТГЭВ



**28. Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)**

**Ашиглагдаагүй кредит картын үлдэгдэл**

Энэхүү хэрэгслийн гол зорилго нь харилцагчид шаардлагатай хэмжээний санхүүжилт бэлэн байгааг баталгаажуулах юм. Батлагдсан кредит картын эрхээс ашиглагдаагүй байгаа хэсэг нь зээлийг нэмэгдүүлэх үүргийг тодорхойлно. Зээлийг нэмэгдүүлэх үүргийн эрдэл нь, ашиглагдаагүй кредит картын эрхийн хэмжээгээр Банк алдагдал хүлээх эрдэл юм. Гэсэн хэдий ч, зээлийн эрхийг хэвийн байлгах тодорхой шалгуур үзүүлэлтүүдээс хамаран алдагдлын дүн нь нийт ашиглагдаагүй зээлийн эрхийн хэмжээнээс бага байх талтай байдаг.

**Шүүхийн нэхэмжлэл**

Бизнесийн онцлог шинж чанарын улмаас Банкны салбарт шүүхээр асуудлыг шийдэх явдал энгийн үзэгдэл байдаг. Банк нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон журам, хяналттай. Мэргэжлийн зөвлөгөө авч, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолсон бол Банк нь тухайн нэхэмжлэлийн банкны санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөг холбогдох дансыг тохируулан толилуулдаг.

Тайлант жилийн эцэст Банкинд томоохон үүрэг хүлээх шүүхийн нэхэмжлэл байгаагүй.

**29. Эрсдэлийн удирдлага**

**29.1 Оршил**

Банкны үйл ажиллагааны салшгүй гол эрсдэлүүд бол зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, валютын ханшийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлүүд байдаг ба эдгээр эрсдэлүүдийг Эрсдэлийн Нэгдсэн Удирдлагын Газар удирдаж байдаг. Эрсдэлийн Нэгдсэн Удирдлагын Газар нь Гүйцэтгэх Захиралд шууд тайлагнадаг бие даасан нэгж юм. Эрсдэлийн Удирдлагын үндсэн зорилго нь бизнесийн сегментэд эрсдэл өгөөжийн түвшинтэй нь уялдуулан капиталыг зөв хуваарилах болон Банкны хөрөнгийн эрсдэл тохируулсан өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд байнгын илрүүлэгт, хэмжилт, хяналтын үйл явцуудаар дамжуулан эрсдэлийг удирдах явдал юм. Энэ үйл явц нь Банкны тасралтгүй ашиг ажиллагаанд маш чухал үүрэгтэй ба Банкны ажилтан бүрийн оролцоо, тэдний ажил үүргийн хариуцлагын хүрээнд эрсдэлийг илрүүлэхтэй шууд холбоотой юм.

Дээр дурьдсан эрсдэлийн удирдлагын явцад бизнесийн эрсдэлийн удирдлага багтаагүй болно. Бизнесийн эрсдэл гэдэг нь бизнесийн хүрээлэн буй орчин, технологи, болон үйл ажиллагаа явуулж буй салбарт гарсан өөрчлөлтүүдээс үүссэн эрсдэлийг хэлнэ. Эдгээр бизнесийн эрсдэлүүд нь Банкны стратеги төлөвлөлтийн хүрээнд хянагдаж байдаг.

Банк нь эрсдэлийг бүрмөсөн арилгахад чиглэхээс илүүтэйгээр эрсдэл, өгөөжийг хамгийн оновчтой хослуулахад чиглэсэн эрсдэлийн удирдлагын бодлоготой. Одоо мөрдөж буй эрсдэлийн удирдлагын систем нь дараах зарчмуудыг агуулсан байна. Үүнд:

- Эрсдэлүүдийг удирдаж буй этгээд нь зохицуулалтын болон хэмжилтийн системийг сайн ойлгож байна;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ("ТУЗ") баталсан хязгаарын хүрээнд эрсдэлийг илрүүлж байна;
- ТУЗ-өөс баталсан бизнесийн бодлогын дагуу эрсдэлийг хэмжиж байна;
- Капиталын хуваарилалт нь эрсдэлийн түвшинтэйгээ уялдаж байна;
- Банкны гүйцэтгэлийн зорилт нь эрсдэл даах байдалтай уялдаж байна.

**Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт**

Банкны ТУЗ нь Банкны эрсдэлийн удирдлагын ерөнхий тогтолцоог хариуцах ба эрсдэлийн удирдлагын бодлого болон эрсдэл хүлээх чадвар болон хүлээн зөвшөөрөх эрсдэлийг тусгасан зээлийн бодлогыг батлах үүрэгтэй. Мөн удирдлагын бүх түвшинд эрсдэлийн талаарх нэгдсэн ойлголттой байж дараах шатны хороод эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

**Эрсдэлийн Удирдлагын Хороо ("ЭУХ")**

Эрсдэлийн Удирдлагын хороо нь Банкны бизнес нэгжүүдийн болон банкны үйл ажиллагаанд учирсан болон учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, мөн үйл ажиллагааны эрсдэл, зах зээлийн эрсдэл болон бусад эрсдэлүүдийг багасгах зорилгоор тэдгээрийг үнэлэх, түүнийг хэрэгжүүлэх заавар удирдамж өгч ажилладаг.

**ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо**

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь Банкны санхүүгийн тайлангууд болон тодруулгуудын үнэн зөв байдлыг хянах, хууль эрх зүйн болон зохицуулалтын хүрээнд зохистой байдал, дотоод хяналт болон аудитын хүрээнд ТУЗ-д дэмжлэг үзүүлж ажилладаг.

**Гүйцэтгэх удирдлагын хороо**

Гүйцэтгэх удирдлагын хороо нь Банкны нийт гүйцэтгэх удирдлагуудаас бүрдэх бөгөөд Гүйцэтгэх захирал даргалан сар болгон хуралддаг. Хурлаар Банкны стратегийн асуудлууд болон тогтвортой бизнесийн удирдлагыг хангахад шаардлагатай төлөвлөлтийн асуудлуудыг хэлэлцдэг.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
TT68766 ▪ 5903858

СЭХ
2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлагнагийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**29. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**29.1 Оршил (үргэлжлэл)**

**Актив пассивын удирдлагын хороо ("АПУХ")**

АПУХ нь Банкны эх үүсвэр, төлбөрийн чадвар, гадаад валют, эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацаа, хүүний эрсдэлүүдийн ерөнхий актив пассивын удирдлагыг гүйцэтгэнэ. АПУХ-ны зорилго нь Банкны санхүүгийн тайлангийн актив пассивын бүтцийг Банкны тогтвортой хөгжлийг хангах байдлаар тогтоох, актив пассивын ерөнхий удирдлагаар ашигт ажиллагаа болон хөрвөх чадварыг хангах мөн валютын, хүүний болон зах зээлийн бусад эрсдэлийг удирдахад оршино. АПУХ-г Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч даргалдаг.

**Зээлийн хороод**

Банкны зээлийн хороо болоп Эрсдэлийн Нэгдсэн Удирдлагын Газар нь /цаашид ЭНУГ гэх/ нь Банкны зээлийн эрсдэлийг удирддаг. Зээлийн хорооны бүтэц, зохион байгуулалт нь Банкны түвшин бүр дэхь зээлийн эрсдэлийг удирдахаар зохион байгуулагдсан. Банк нь зээл батлах, хяналт тавих доорхи гурван шатны зээлийн хороотой:

1. Зээлийн хороо нь 100.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зээлийн хүсэлтийг хэлэлцэн баталдаг. Түүнчлэн, одоогийн мөрдөгдөж буй бодлого журмын дагуу 3.0 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй зээлийн хүсэлтийг мөн ТУЗ-д танилцуулан батлуулдаг.
2. Зээлийн дээд хороо нь орон нутгийн салбар болон зээлийн нэгжүүдийн зээлийн хорооны зээл батлах эрхээс давсан буюу 100 сая төгрөг хүртэлх зээлийн хүсэлтийг хэлэлцэн батлаадаг.
3. Салбарын Зээлийн хороо өөрийн эрхийн хүрээнд зээлийн хүсэлтийг батална. Мөн өөрийн харьяа тооцооны төвүүдийн зээлийн эрх хамаарах бөгөөд салбарын зээлийн багцыг удирдана.

**Дотоод аудит**

Банкны эрсдэлийн удирдлагын үйл явцад Дотоод аудитын газар жилд нэгудаа аудит хийх ба аудитын үед банкны журмуудын зохистой байдал хийгээд Банк эдгээр журмуудыг хэр мөрдөж байгаад хяналт хийдэг. Дотоод аудитын газар нь хийсэн бүх үнэлгээнийхээ үр дүнг банкны удирдлагатай хэлэлцэж, илрүүлсэн алдаа, дутагдал болоод өгөх зөвлөмжүүдийн талаар ТУЗ-ын дэргэдэх аудитын хороонд тайлагнана.

**Эрсдэлийг хэмжих болон тайлагнах систем**

Банк нь статистик загваруудын гүсламжтайгаар түүхэн алдагдлаас ойролцоолон тооцсон ердийн тохиолдолд хүлээж болзошгүй алдагдал болон гэнэтийн тохиолдолд учирч болзошгүй онцгой алдагдлыг давхар хэмжиж чадах системийг ашиглан эрсдэлийг хэмждэг. Эдгээр статистик загваруудыг түүхэн өгөгдлөөр тооцсон магадлалыг эдийн засгийн өнөөгийн орчинд нийцүүлэх байдлаар хэрэглэдэг. Эрсдэлийн удирдлага, хяналт нь гол төлөв Банкнаас тогтоосон хязгаарын биелэлтэд суурилна. Эдгээр хязгааруудад Банк өөрийн бизнесийн стратеги зорилт, тухайн зах зээлийн орчин, мөн цаашид хүлээх боломжтой эрсдэлийн түвшинг тусгаж өгсөн байна. Үүнээс гадна Банк нь өөрийн эрсдэл даах чадварыг бүх үйл ажиллагаа болон эрсдэлийн төрлүүдээр тодорхойлон хэмжиж, түүнд хяналт тавьж байдаг. Эрсдэлийг цаг алдалгүй олж таних, шинжлэх, хянах үүднээс бизнесийн бүх нэгжүүдээс цуглуулсан мэдээллүүдийг шинжилж үздэг. Ингэж боловсруулсан мэдээллийг ТУЗ, АПУХ, ЭУХ, зээлийн хороод болон бүх газар, хэлтсийн захирлуудад танилцуулж, тайлбарладаг. Тайланд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцын хэмжээ, кредит метрикийн тааамглал, тогтоосон лимитийн тажилт, VaR, хөрвөх чадварын харьцаа болон эрсдэлийн үгтүүдын өөрчлөлтийг тусгана. Улирал бүр Актив пассивын удирдлагын хороо болон Эрсдэлийн хороо нь Банкны эрсдэлд үнэлэлт, дүгнэлт өгөхөд бүх шаардлагатай мэдээллээр хангах зорилготой иж бүрэн эрсдэлийн тайланг хүлээн авдаг. Долоо хоног бүр Актив пассивын удирдлагын хороонд VaR, хөрвөх чадварын шинжилгээ, зах зээлийн эрсдэлийн лимитийн биелэлт болон бусад аливаа эрсдэл үүсгэх хүчин зүйлийн талаар танилцуулна.

**Эрсдэлийг бууруулах**

Хүүний түвшний эрсдэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй эрсдэлийн хэмжээг мэдрэмжийн шинжилгээ болон VaR аргаар тооцон, хялбаж ажилладаг. Банк зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгө болон хувь хүнээр батлан даалт гаргуулдаг.

**Эрсдэлийн хэт төвлөрөл**

Ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, эсвэл нэгэн ижил газар зүйн бүсэд болон эдийн засгийн тухайлсан нэг салбарт бизнес эрхэлдэг харилцагчлын үйл ажиллагаанд улс төр, эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал төвлөрөл нь бий болдог. ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ нь эдийн засгийн салбарын төвлөрөл, нинэ бүтээгдэхүүний төвлөрөл болон хэвийн бус зээлийн харьцаа зэрэгт тавигдах хязгаарлалт, стандартуудыг тогтоодог. Төвлөрөл нь тухайн нэгж салбарт болон газар зүйн байрлалд нөлөөлж буй нөхцөл байдалд Банк хэрхэн гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ. Банкны гүйцэтгэлийг өсөлттэй тодорхой нэг эдийн засгийн салбар болон газарзүйн бүсээс хэр хамааралтай байгааг төвлөрөл нь илэрхийлдэг.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
МІСС

## 29. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### 29.1 Оршил (үргэлжлэл)

Эрсдэлийн хэт төвлөрөөс зайлсхийх үүднээс Банк өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Тус зохицуулалтад дурдсанаар зээлийн төвлөрлийн эрсдэлийг Банк хянаж удирддаг. Монголбанк нь дараах стандарт хязгаарлалтуудыг тогтоож, биелүүлэхийг шаарддаг. Үүнд:

- Нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд олгох нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн нийлбэр дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 20%-иас хэтрэхгүй.
- Банк холбогдох этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20%-иас тус тус хэтрэхгүй.

Банкны бодлого нь эх үүсвэрийн төвлөрлийн хэмжээтэй уялдуулсан хөрвөх чадварын хүрэлцээтэй байхыг шаарддаг.

### 29.2 Зээлийн эрсдэл

Банкны харилцагч, үйлчлүүлэгч, зээлдэгчид нь зээлийн хүү, үндсэн төлбөрийг төлөх чадваргүй болох эсвэл төлөхийг хүсэхгүй байх, зээлийн гэрээний болон бусад санхүүгийн хэрэглүүдтэй холбоотой үүрэг биелүүлэхгүй байх эрсдэлийг зээлийн эрсдэл гэдэг. Банк нь зээлийн өргөдлүүдийг анхааралтай хянах, эрсдэлийн түвшинд тохируулсан хүүний хувь хэмжээг тогтоох, харилцагч талуудыг тогтмол шинжлэх гэх мэт)-ийг эртнээс олж таних зорилгоор зээлийн чанарын хяналтын процессийг нэвтрүүлсэн. Зээлийн чанарын хяналтын процесс нь Банкинд болзошгүй алдагдлыг тодорхойлох, засах арга хэмжээнүүдийг эрт авах боломжийг олгодог. Банк зээлийн үйл ажиллагааг сайжруулахын тулд зээлийн журам зааврыг олон улсын стандарт болон Монголбанкны хэрэгжүүлж буй эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн тогтмол шинэчлэн сайжруулж байдаг.

**Зээлтэй холбоотой болзошгүй үүргийн эрсдэл**
Банк нь харилцагчийн өмнөөс үүрэг хүлээх төлбөрийн баталгаануудыг гаргах боломжийг харилцагч нарт бий болгодог. Ийм төлбөрийг баталгааны нөхцөлд тулгуурлан харилцагчдаас эргүүлэн тятдаг. Эдгээр нь Банкинд зээлтэй нэгэн адил эрсдэлийг учруулах ба түүнийг мөн зээлийн үйл ажиллагааны бодлого, журмаар зохицуулдаг.

**Үнэ цэнийн бууралтын үнэлгээ**

***Чанаргүйдэл, үнэ цэнийн бууралт ба сайжруулалтын тодорхойлолт***

Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрөө 90 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн эсвэл Банк зээлдэгчийн барьцаа хөрөнгийг борлуулах замаар эргэн төлөлтийг гүйцээх магадлалтай бүх тохиолдолд тухайн санхүүгийн хэрэгслийг үл төлөгдөх магадлалтай гэж үзэн хүлээгдэж буй алдагдлыг тооцдог.
Харилцагчдын санхүүгийн хэрэгслийг чанарын үнэлгээгээр үнэлж зээлийг "үнэ цэнийн бууралтай" гэж үзэх болон эргэн төлөгдөхгүй байх магадлалуудыг Банк авч үздэг. Энэ тохиолдолд Банк харилцагчийн санхүүгийн хэрэгслийг үл төлөгдөх магадлалтай эсэхийг нарийвчлан шинжиж хүлээгдэж буй алдагдлыг 2-р шатлал эсвэл 3-р шатлалын аль нь тооцоологдохыг тодорхойлох замаар үнэлгээг хийнэ. Чанарын үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлийг харгалзан үздэг. Үүнд:

- Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрөө 90 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн
- Дараах нөхцөлөөр зээлдэгч нь санхүүгийн бэрхшээлтэйн улмаас зээлийн бүтцэд өөрчлөлт оруулсан:
  - 90-ээс дээш хоногоор хүүний тооцооллыг зогсоосон
  - Зээлийн үндсэн төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулж ирэх 12 сарын нийт зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт нь анхны эргэн төлөлтийн хуваариас 50%-аар буурсан
  - Зээлийн эргэн төлөгдөх хугацааг анхны хугацаатай харьцуулахад 12 сараас дээш хугацаагаар сунгасан
  - Зээлийн хүүгийн болон үндсэн төлөлтийн эргэн төлөлтийн хуваарь болон хүүгийн түвшинд өөрчлөлт оруулсан нь анхны зээлийн гэрээгээр хүлээсэн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг 10%-иас дээш хувиар бууруулсан
- Зээлдэгч нь дампуурал зарласан эсвэл дампуурлын үйл ажиллагаа эхлүүлсэн.
- Тайлагналын өдрөөр үнэ цэнийн бууралттай (үл төлөгдөх) гэж үзэх шинж тэмдэг байгаа үед зээлдэгчийн бусад санхүүгийн хэрэгслүүдийг 3-р шатлалд ангилна. Үүний зэрэгцээ, нэг зээлдэгчид олгосно өөр өөр салбарын зээлүүдийг ("байгууллагад олгосон бизнесийн зээл" болон "хуулийн этгээдэд олгосон төслийн зээл") тусад нь авч үзэхгүй.

Үл төлөгдөх магадлалд орох эсэх шалгууруудын хүчин зүйл нь дараалсан зургаан сар үргэлжлэн илрэгдүй бол санхүүгийн хэрэгслийг "үнэ цэнэ сайжирсан" гэж үзэн 3-р шатлалаас шилжүүлэх эсэхийг Банк өөрийн бодлогоор зохицуулна. Хөрөнгийн зээлийн үнэлгээ сайжирсаны улмаас 1-р шатлал болон 2-р шатлалд дахин ангилах эсэх шийдвэр нь тухайн зээлийн болон зээл олгох үеийн дотоод үнэлгээтэй харьцуулахад эрсдэл хэрхэн өөрчлөгдсөн байгаагаас хамаарна.



СЗХ
2021 11 10
БҮРТГЭВ
№ 11
2021 -11- 03
Үнэт цаасны танилцуулга
БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
401

**29. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**29.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

***Банкны дотооддоо хэрэглэдэг үнэлгээний систем болон ЧМ-ын тооцоолол***

Банкны эрсдэлийн удирдлагын хэлтэс нь дотоод үнэлгээний загварыг гаргадаг. Энэхүү загварууд нь чанарын болон тоон мэдээллийг ашиллаг бөгөөд зээлдэгчийн онцлог мэдээллээс гадна зээлдэгчийн зан төлөвт нөлөөлж болох гадны нэмэлт мэдээллийг ашигладаг. Практик боломжтой үед Банк нь олон улсын, тухайлбал Мүүдийс, Фитч үнэлгээний байгууллагуудын мэдээллийг ашигладаг. Аль шаталд хөрөнгийг ангилахад дээрх эх сурвалжуудыг ашигладаг.

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа төлбөрийн чанаргүйдлийн магадлалыг тооцохдоо түүхэн мэдээллүүд дээр үндэслэн тооцох бөгөөд холбогдох макро эдийн засгийн хүчин зүйлсийг ашиглан урьдчилан таамаглалын тохируулгыг хийнэ. ЧМ нь нөхцөлт ЧМ гэж тодорхойлогдог бөгөөд энэ нь өмнөх хугацаанд тухайн дансны хувьд хийгдсэн бүрэн ба хэсэгчилсэн төлөлтийг харгалзан үзэж ЧМ муруйг бий болгодог. Мөн түүнчлэн, Банк ЧМ муруйг янз бүрийн хугацааны хувьд тооцоолохын тулд банк "кохорт" дүн шинжилгээг ашигладаг.

Зээл болон урьдчилгаанаас бусад санхүүгийн хөрөнгийн хувьд ашигладаг ЧМ загвар нь үнэлгээний матриц дээр суурилсан бөгөөд энэ нь холбоотой талуудын олон улсын зээлийн үнэлгээний мэдээлэлээс гардаг. Энэхүү зээлийн үнэлгээний мэдээллүүд нь ирээдүйн мэдээллүүдийг агуулсан байдаг.

*Хөрөнгө зохицуулалт, арилжаа ба банк хоорондын харилцаа*

Банкны хөрөнгө зохицуулалт, арилжаа ба банк хоорондын харилцаа болон хамтрагч талуудад санхүүгийн байгууллагууд, банк, брокер-дилерүүд, хөрөнгийн биржүүд болон клиринг төвүүд багтана. Эдгээр харилцагч байгууллагын хувьд, Банкны Хөрөнгө зохицуулалтын газраас олон улсын үнэлгээний агентуудын (тухайлбал, Мүүдис) нийтэд нээлттэй гаднаа мэдээлэлд дүн шинжилгээ хийж дотооддоо үнэлгээ өгдөг.

*Бизнесийн зээл*

Бизнесийн зээлийн эрсдэлийг үнэлэхдээ харилцагчийн санхүүгийн түүхэн, одоо, ирээдүйн нөхцөл байдлыг харгалзан үздэг. Үүнд:

- Харилцагчийн санхүүгийн тосөөлөл болон түүхэн мэдээлэл. Энэхүү санхүүгийн мэдээлэл нь харилцагчийн санхүүгийн гүйцэтгэлийн хэрэглэгдэхүүн, хүлээгдэж буй үр дүн, төлбөрийн чадварын харьцаа, хөрвөх чадварын харьцаа болон бусад холбогдох санхүүгийн чадамжийг үнэлэх харьцаануудыг агуулна. Эдгээр үзүүлэлтүүдийн зарим нь үйлчлүүлэгчидтэй хийсэн гэрээнүүд дээр тулгуурласан байдаг тул илүү анхаарч авч үздэг.
- Харилцагчдын талаарх бусад эх сурвалжаас гаралтай нийтэд нээлттэй мэдээлэл.
- Макро-эдийн засгийн болон геополитикийн аливаа мэдээлэл
- Банкны гүйцэтгэлд хамаарах харилцагчийн менежментийн чанар, ур чадварын талаарх бодитой мэдээлэл

Үнэлгээний арга барилын нарийн төвөгтэй байдал нь зээлийн хэмжээ болон харилцагчийн цар хүрээнээс шалтгаалан өөр өөр байдаг. Зарим бизнесийн зээл нь жижиг бизнест зориулсан Банкны дотоод загвараар үнэлэгддэг.

*Хэрэглээний зээл болон орон сууцны зээл*

Хэрэглээний зээлд иргэдийн бүх төрлийн хэрэглээний зээл, кредит карт болон орон сууцны зээлүүд багтдаг. Эдгээр зээлийн бүтээгдэхүүнүүд болон зарим жижиг бизнесийн зээлийн эрсдэлийн үнэлгээг зээлдэгчийн хугацаа хэтрэх магадлалыг тодорхойлох аргачлал бүхий программын загвараар үнэлдэг. Үүнд: хүн амзүй, зээл хүсэгчийн зээлийн түүх, барьцаа хөрөнгө, одоогийн орлогын түвшин, дансны орлогын өөрчлөлт, өр төлбөрийн үлдэгдэл болон хүссэн зээлийн нөхцөл зэргийг харгалзан үздэг.

*Банкны дотоод үнэлгээ*

Санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарыг Банк дотооддоо боловсруулсан зээлийн үнэлгээг ашиглан удирдлаг. Эрсдэлийн түвшинг зээлийн багц даяар үнэн зөв, тууштай байлгах нь Банкны бодлого юм. Энэ нь холбогдох эрсдэлийн удирдлага, болон зээлийн эрсдэлийг зээлийн бүтээгдэхүүний төрөл бүрээр харьцуулах боломжийг олгодог. Үнэлгээний систем нь санхүүгийн болон статистикийн олон төрлийн дүн шинжилгээнүүдээс бүрдэх бөгөөд үүнд багцын ба зах зээлийн мэдээллүүд пэттэгдэж, харилцагч талын эрсдэлийг хэмжих гол хүчин зүйл болдог. Эрсдэлийн бүх түвшинг олон төрлийн зээлд нийцүүлэн боловсруулсан бөгөөд үл төлөлтийн эрсдэлийн зэргийг, зээлийн барьцаа хөрөнгө байгаа эсэх эсвэл бусад зээлийн эрсдэлийг бууруулах аргыг харуулан Банкны үнэлгээний бодлогын дагуу гаргадаг. Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаанаас бусад санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарыг Мүүдисийн үнэлгээ, Стандард & Пүүрсийн эсвэл Фитч үнэлгээний дагуу ангилдаг.



СЗХ
2021 . 11 . 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01
Үнэт цаасны танилцуулга
2021 -11- 03
БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
MICC
402

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**29. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**29.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**Банкны дотоод үнэлгээ**

| Дотоод үнэлгээ | Дотоод үнэлгээний тайлбар | Олон улсын үнэлгээ |
|---|---|---|
| А | Маш сайн | A- to AA+ зэрэгтэй |
| Б | Сайн | BBB- to BBB+ |
| В | Хэвийн бус | B- to BB+ |
| Г | Хугацаа хэтэрсэн | Caa-C |
| Д | Үнэ цэнэ буурсан | – |
| Үнэлэгдээгүй | Үнэлэгдээгүй | – |
| Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан | Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан | – |

***Чанаргүйдэлд өртөх дүн ("ЧӨД")***

Чанаргүйдэлд өртөх дүн нь харилцагчийн алдагдал хүлээх дүн болон эрт эргэн төлөлт хийх чадвар зэргийг харгалзан үзэж санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ буурах үед тооцсон бодит хэмжээг хэлнэ. Зээлийн карт болон бусад зээлийн шугамын чанаргүйдэлд өртөх дүнг тодруулга 2.4-өөс харна уу.

1-р шатлалд буй зээлийн ЧӨД-г тооцоолохдоо Банк нь 12 сар дотор үүсэж болох чанаргүйдэх үйл явдлыг 12 сарын ЗҮЦХА-г тооцоход авч үзнэ. 2-р шатлал болон 3-р шатлалуудад ЧӨД-г тодорхойлохдоо нийт хугацааны түүхэн чанаргүйдэх үйл явдлыг авч үзнэ.

12 сарын болон зээлийн хугацааны ЧӨД нь бүтээгдэхүүний төрлөөс хамааран хүлээгдэж буй төлбөрийг үндэслэн тодорхойлогддог:

- Хорогдуулсан болон нэг удаагийн эргэн төлөлттэй зээлийн, зээлдэгчийн 12 сарын хугацаанд эсвэл зээлийн хугацаанд нь төлөх гэрээний төлбөрт үндэслэнэ. Мөн түүнчлэн зээлдэгчийн хүлээгдэж буй илүү төлөлтийг тохируулж өгнө. Энэхүү тооцоололд эрт төлөлт/дахин санхүүжүүлэлтийн тавмагдалыг мөн тусгаж өгнө.
- Зээлийн шугамын бүтээгдэхүүний хувьд, нийт лимитээс ашигласан хувиар ЧӨД-г тооцдог.

***Алдагдалд хүргэх чанаргүйдэл***

Алдагдалд хүргэх чанаргүйдэл (АХЧ)-ийг эрсдэлийн удирдлагын хэлтсийн зээлийн эрсдэлийн шинжээчид жил бүр үнэлдэг. АХЧ нь Банкны хүлээгдэж буй үл төлөгдөх зээлийн хэмжээг илэрхийлнэ. АХЧ нь харилцан тохиролцсон хэлбэр, нэхэмжлэлийн төрөл болон зэрэглэл, барьцаа хөрөнгө эсвэл бусад зээлийн дэмжлэг зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. АХЧ нь зээл/авлага дефолт болох үед хүлээх алдагдлын нэгж хувиар илэрхийлэгдэнэ. АХЧ-ийг 12 сар эсвэл зээлийн хугацааны туршид тооцдог бөгөөд 12 сарын АХЧ нь дараагийн 12 сард дефолт болох тохиолдолд гарах алдагдлын хувийг тооцдог бөгөөд зээлийн хугацааны туршид АХЧ нь үлдэгдэл зээлийн хугацаанд гарах алдагдлын хувийг тооцдог.

АХЧ нь барьцааны үнэ болон төлөлтөөс хамааран цаг хугацаа өнгөрөх тусам өөрчлөгдөж байдаг. АХЧ -ийн коэффициентийн гол элементүүд нь:

- Цагийн хэмжээс (ЧӨД параметрийг баталгаатай, баталгаагүй хэсэгт хуваах) ба
- Барьцаа хөрөнгийн үнэ цэнэ өөрчлөгдөхөд (үл хөдлөх хөрөнгө гэх мэт барьцааны тохиолдолд үнэ нь өөрчлөгдөхгүй хэвээр байх болно)

Санхүүгийн хэрэгсэлд барьцаа хөрөнгө байхгүй, үл төлөлтийн түүхэн өгөгдөл хангалттай байгаа тохиолдолд Банк шинжээчдийн дүгнэлтийг ашигладаг. Тайлангийн өдрөөрх нөхцөл байдал, өгөгдлийн бүрэн гүйцэд байдлаас хамааран Банк АХЧ-ийн коэффициентийн үе шатыг тодорхойлохын тулд түүхэн мэдээллийн хандлагаэсвэл гадаад эх сурвалжаас авсан түүхэн өгөгдлийг ашигладаг.

***Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт***

Банк нь ЗҮЦХА-д хамаарах бүх хөрөнгийг тасралтгүй хянадаг. Тухайн нэг санхүүгийн хэрэгсэл эсвэл багц хэрэгсэл нь 12 сарын ЗҮЦХА эсвэл нийт хугацааны ЗҮЦХА-т хамаарах эсэхийг тодорхойлохын тулд Банк нь уг хөрөнгүүдийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг үнэлдэг.

Банк нь гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн тохиолдолд чанарын шинжилгээ хийдэг. Зарим тохиолдолд зээлийн эрдслийн мэдэгдэхүйц өсөлтийн шалтгааныг чанаргүйдэл бус "Чанаргүйдлийн тодорхойлолт"-д дурьдагдсан үйл явдлуудтай холбож тайлбарладаг. Зээлийн ангиллын өөрчлөлтийг үл харгалзан 30 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн байна гэж үздэг.

Ижил тестэй бүлэг хөрөнгүүдийн ЗҮЦХА-г тооцохдоо, анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг шинжлэхдээ ижил арга, аргачлалуудыг ашигладаг.



БОГД БАНК ХХК
БӨГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
MICC

СЭХ
БҮРТГЭВ
№ 31
2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**29. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**29.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

***Бүлгийн үнэлгээгээр санхүүгийн хөрөнгүүдийг ангилах нь***

Доорх хүчин зүйлээс хамаарч "ЗҮЦХА зарчмуудын тойм" 2.4-т тайлбарласнаар Банк нь ЗҮЦХА -ыг нөөцийг бүлгийн болон тусгай үнэлгээгээр тооцдог.

Банк нь ЗҮЦХА -йг тусгай үнэлгээгээр тооцоолох хөрөнгийн ангилалд зээлийн багц үл хамааран үлдэгдэл балансаар эхний 40 эсвэл зээлийн багцаас үл хамааран 500 сая төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 3-р шатны зээлдэгч нар орно.

Банк нь ЗҮЦХА -йг бүлгийн үнэлгээгээр тооцоолох үед тусгай үнэлгээнд ороогүй бүх зээлийг оруулна. Банк нь зээлийн зориулалт, бүтээгдэхүүнээс хамааран доорх жижиг багцуудад ангилдаг.

- Бизнесийн зээлүүд
- Хэрэглээний зээлүүд
- Орон сууцны зээлүүд

**ЗҮЦХА -ын загварын өгөгдөлд дүн шинжилгээ хийх нь**

Банк нь ЧМ болон ЗҮЦХА-г тооцоолохдоо ирээдүйг илтгэх мэдээллийг ашиглан ирээдүйн макро эдийн засгийн өөрчлөлт ЗҮЦХА-д хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж үздэг. Энгийн шугаман хамаарлын арга ашиглан ажиглагдахуйц чанаргүйдлийн/дефолтын хувь болон макро эдийн засгийн хүчин зүйл хоорондын харилцан хамаарлыг тооцдог. Ашигласан мэдээллийн багцад зээлийн бүтээгдэхүүн бүрд хамаарах ЧМ болон голлох макро хүчин зүйлүүдийн улирал бүрийн мэдээллүүд ордог. Макро эдийн засгийн хүчин зүйлийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооны мэдээллийн сангаас татдаг бол ЧМ хувь нь банкны дотоод мэдээллийн сангаас болон Мүүдийс зэрэг олон улсын үнэлгээний байгууллагуудаас гаргасан түүхэн мэдээллийг ашигладаг. Банкны хувьд бизнесийн зээлд дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляцийн түвшин, ажилгүйдэл ба ам долларын ханш, орон сууцны зээлд инфляцийн түвшин болон өрхийн хэрэглээ, хэрэглээний зээлд өрхийн хэрэглээ, экспорт, ажилгүйдлийн түвшин болон мөнгөний нийлүүлэлт зэрэг макро эдийн засгийн хүчин зүйлсийг ашигладаг.

Арга зүйн хувьд, эхлээд оновчтой макро эдийн засгийн хүчин зүйлүүдийг урьдчилан сонгохдоо шугаман хамаарлын шинжилгээ хийсэн. Дараа нь коэффициентуудыг энгийн регресийн шинжилгээ ашиглан тооцоолсон. Тооцоллын үр дүнд гарсан коэффициентууд болон таамаглалуудаас ЧМ-д хамаарах ирээдүйн талаарх мэдээлэл хүчин зүйлүүдийг тохируулан авч үзсэн тул урьдчилсан чанаргүйдлийн хувь болон түүхэн дундаж чанаргүйлийн хувийн харьцааг ЧМ болгон авч үзсэн. Эдгээр тохируулга нөлөөлөгч хүчин зүйлс болон тохируулсан ЧМ хувиуд нь ирээдүйн эдийн засгийн өсөлтийн талаар хамгийн бодитой төсөөлөл өгч чадна гэж үзсэн тул ЗҮЦХА загварын суурь төсөөлөл болно. Сайн болон муу төсөөллүүдийг тухайн загвараар таамагласан чанаргүйдлийн хувь дахь түүхэн тохируулагч хүчин зүйлүүдийг үндэслэн тооцсон ба тохируулагч хүчин зүйлийн тархалтыг тодорхой тоонуудаар хэмжсэн. Төсөөлөл бүрийн ЗҮЦХА-г тухайн төсөөлөлд хамаарах ЧМ хувьд үндэслэн тооцсон бол бодит ЗҮЦХА-г дээрх гурван төсөөллийн дараах пропорцоор жигнэсэн дунджаар авсан байна. Үүнд: сайн төсөөллийн 10%, муу төсөөллийн 20% ба суурь төсөөллийн 60%.

Тооцоллын 3 төсөөлөлд хамаарах тохируулгын коэффициентыг доорх хүснэгтээс харна уу.

**2020 болон 2019 оны 12 сарын 31-ээр**

| | Бизнесийн зээл | Орон сууцны зээл | Хэрэглээний зээл |
|---|---|---|---|
| Муу төсөөлөл | 1.023 | 1.0032 | 1.0047 |
| Суурь төсөөлөл | 1.019 | 1.0028 | 1.0041 |
| Сайн төсөөлөл | 1.014 | 1.0025 | 1.0034 |

**Бүтцийн өөрчлөлт орсон зээлийн тойм**

Эрсдэлийн удирдлагын үүднээс зээлд бүтцийн өөрчлөлт орсон бол Банкны тусгай хөрөнгийн хэлтэс нь зээлийг эргэн төлөгдөх хүртэл хянаж тавьдаг.

Доорхи хүснэгтэд бүтэц өөрчлөгдсөн 2, 3-р үе шатын хөрөнгүүдийг багтаав.

Доорхи хүснэгтэд бүтэц өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгө нийт дансны дүн болон холбогдох ЗҮЦХА-г 2020 оны болон 2019 оны 12 сарын 31-ээр тус бүр харуулав:

| | 2020 мян.төг | 2019 мян.төг |
|---|---|---|
| *Бүтэц өөрчлөгдсөн зээлүүд:* | | |
| Дансны нийт үнэ | 14,306,135 | 707 |
| Холбогдох ЗҮЦХА | 96,823 | 256 |



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ
ТГ53966 • 5903858

СЭХ
2021 .11.10
БҮРТГЭВ
№ 11

2021 -11- 03
БҮРТГЭВ-03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**29. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**29.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**Эргэн төлөлтийн хойшлуулалт, баталгаатай зээл болон бусад дэмжлэг**

Ковид-19-ийн улмаас Монгол Улсын Засгийн газраас зээлийн төлбөрийг тодорхой шалгуургүйгээр бүх зээлдэгчдэд хойшлуулах арга хэмжээ авсан. Зээлийн бүтэц өөрчлөлттэй холбоотой гарз нь материаллаг бус байсан.

**Эрсдэлийн төвлөрлийн шинжилгээ**

Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний систем, шатлалыг ашиглан гаргасан зээлийн чанар болон зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнтэй холбоотой тодруулгуудыг 12, 13, 14 ба 15-р тодруулгаас харна уу.

Дараах хүснэгтэд Банкны харилцагчдад олгосон зээл, урьдчилгаат (Тодруулга 15) аж үйлдвэрийн салбараар нь ангилан, нийт дүнгээр (зээлийн барьцаа хөрөнгө эсвэл зээлийн чанарыг сайжруулах бусад зүйлүүдийг авч үзэхээс өмнөх нь) үзүүлэв:

| | Нийт багцын хэмжээ | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2020 | | 2019 | | 2018 | |
| | мян.төг | % | мян.төг | % | мян.төг | % |
| Барилга | 20,244,090 | 19.58% | 16,408,960 | 19.32% | 15,749,110 | 29% |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 19,549,600 | 18.91% | 22,787,720 | 26.84% | 12,268,690 | 23% |
| Бөөний болон жижиглэнгийн худалдаа | 17,926,460 | 17.34% | 15,530,640 | 18.29% | 8,803,930 | 16% |
| Цахилгаа эрчим хүч ба шатахуун | 14,569,820 | 14.09% | 7,586,960 | 8.93% | 2,628,920 | 5% |
| Боловсрол | 11,581,640 | 11.20% | 10,040,200 | 11.82% | – | 0% |
| Санхүү болон даатгалын үйл ажиллагаа | 7,200,500 | 6.97% | 1,174,840 | 1.38% | 6,456,900 | 12% |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ | 3,094,100 | 2.99% | 3,093,730 | 3.64% | 4,420 | 0% |
| Бусад | 1,991,360 | 1.93% | 1,396,810 | 1.64% | 16,620 | 0% |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 1,827,000 | 1.77% | 2,642,900 | 3.11% | 6,531,170 | 12% |
| Эрүүл мэндийн үйлчилгээ | 1,183,840 | 1.15% | 63,420 | 0.07% | – | 0% |
| Боловсруулах үйлдвэрлэл | 1,324,250 | 1.28% | 1,154,250 | 1.36% | – | 0% |
| Урлаг үзвэр, тоглоом наадам | 1,101,300 | 1.07% | 1,163,530 | 1.37% | – | 0% |
| Зочид буудал, байр сууц, хоолны үйлчилгээ | 824,610 | 0.80% | 712,080 | 0.84% | 650,047 | 1% |
| Мэдээлэл холбоо | 832,190 | 0.81% | 1,159,224 | 1.37% | – | 0% |
| ХАА, ойн аж ахуй, ан агнуур | 51,730 | 0.05% | – | 0.00% | – | 0% |
| Хэрэглээ | 72,688 | 0.07% | – | 0.00% | – | 0% |
| Бусад | – | 0.00% | – | 0.00% | 1,270,450 | 2% |
| **Нийт** | **103,375,178** | **100%** | **84,915,264** | **100%** | **54,380,257** | **100%** |

**Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд**

Шаардлагатай барьцаа хөрөнгийн үнэлгээний дүн болон төрөл нь зээлдэгч болон харилцагчийн зээлийн эрсдэлийн үнэлгээ ба олгох зээлийн төрлөөс хамаарна. Барьцаанд авсан хөрөнгийн гол төрлүүдийг дор үзүүлэв. Үүнд:

- Байгууллагуудад олгосон зээлийн хувьд үл хөдлөх хөрөнгө, бараа материал, үйлдвэр ба тоног төхөөрөмж, машин механизм;
- Жижиг бизнесийн зээлийн хувьд үл хөдлөх хөрөнгө, бараа материал
- Хэрэглээний зээлийн хувьд автомашин, санхүүжилтийн орлого, болон үл хөдлөх хөрөнгө, гэх мэт;
- Орон сууц худалдан авах зээлийн хувьд орон сууц.

Банк нь барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тогтмол хянаж байдаг ба тухайн гэрээний дагуу шаардлагатай үед нэмэлт барьцаа хөрөнгө гаргуулахаар хүсэлт тавьдаг.

Банкны журмаар өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгүүдийг Банк нь зохион байгуулалттайгаар борлуулдаг. Хөрөнгийг борлуулсанаас орж ирсэн орлогыг зээлийн үлдэгдэл төлбөрийг багасгах эсвэл төлж дуусгахад зориулна. Банк нь өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг өөрийн бизнесийн хэрэгцээнд ашигладаггүй.

Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний систем ба жилийн эцсийн шатлалын ангиллыг ашиглан гаргасан зээлийн чанар болон зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнтэй холбоотой тодруулгуудыг 12, 14, 13 ба 15-р тодруулгаас харна уу.

Санхүүгийн хэрэглүүд нь бодит үнэ цэнээрээ бүртгэгддэг санхүүгийн хэрэглүүдийн хувьд тодруулга 14-д, ирээдүйн үнэлгээний өөрчлөлтөөс үүдэн гарах зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнг бус харин одоогийн байгаа зээлийн эрсдэлийг харуулсан.



БОГД БАНК ХХК
БОГД БАНК
BOGD BANK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭСЭН
2021 -11- 03

**БОГД БАНК ХХК**
**Санхүүгийн тайлангийн тодруулга – 2020 оны 12 дугаар сарын 31**

**29. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**29.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд (үргэлжлэл)**

Банкны харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны барьцаат доор харуулав.

| | Дансны үнэ мян.төг | Барьцааны дүн мян.төг | Эрсдэлд өртөх дүн мян.төг |
|---|---|---|---|
| **2020 оны 12 сарын 31** | | | |
| Бизнесийн зээл | 75,019,174 | 140,721,521 | (65,702,347) |
| Хэрэглээний зээл | 14,569,824 | 24,991,078 | (10,421,254) |
| Орон сууцны зээл | 13,786,180 | 22,134,135 | (8,347,955) |
| | **103,375,178** | **187,846,734** | **(84,471,556)** |
| **2019 оны 12 сарын 31** | | | |
| Бизнесийн зээл | 69,445,485 | 123,091,011 | (53,645,526) |
| Хэрэглээний зээл | 7,586,967 | 9,412,915 | (1,825,947) |
| Орон сууцны зээл | 7,882,812 | 12,480,254 | (4,597,443) |
| | **84,915,264** | **144,984,180** | **(60,068,916)** |

**29.3 Төлбөрийн чадварын эрсдэл**

Санхүүгийн хэвийн болон тогтворгүй нөхцөл байдалд харилцагчийн өмнө хүлээсэн төлбөр тооцооны үүргээ гүйцэтгэж чадахгүй байвал Банк төлбөрийн чадварын эрсдэлд орно. Үг эрсдэлийг хязгаарлахын тулд удирдлага нь өөрийн үндсэн харилцах, хадгаламжийн эх үүсвэрээс гадна олон төрлийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн ба ирээдүйн мөнгөн урсгал болон төлбөрийн чадварыг өдөр тутам хянаж байдаг. Үүний тулд нэмэлт эх үүсвэр шаардагдсан үед яаралгүй авч болох өндөр үнэлгээтэй барьцаа хөрөнгийн бэлэн байдал болон хүлээгдэж буй мөнгөн урсгал зэргийн үнэлгээ хийхийг шаардаг.

Банк нь Монголбанкнаас тогтоосон Төлбөрийн чадварын шаардлагаас илүү хэмжээтэй гүргэн борлогдох активыг байнга барьж байдаг. Үүнээс гадна Банк нь харилцагчдын нийт харилцах, хадгаламжийн 6%- 15%-тай тэнцэх бэлэн мөнгийг Монголбанкинд заавал байршуулж байх ёстой.

**Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ**

Дараах хүснэгтэд 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн өр төлбөр болон хөрөнгийн даруссавар хугацаат төлгээрийн аливаа нэг хөнгөлөлтгүйгээр, гэрээний дагуу эргэн төлөх үүрэг дээр үндэслэн харуулаа. Гэсэн хэдий ч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээг хугацаалаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гээн хүлээлттэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдөл дээр үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно.

| | Хугацаагүй мян.төг | 3 сараас доош мян.төг | 3-аас 6 сар мян.төг | 6-аас 1 жил мян.төг | 1-ээс 5 жил мян.төг | 5-аас дээш жил мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12 сарын 31-нээр** | | | | | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 14,166,775 | 39,500,000 | – | – | – | – | 53,666,775 |
| Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 1,305,843 | 36,240,447 | – | – | – | – | 37,546,290 |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт | – | 4,995,546 | 1,144,811 | 280,302 | 2,242,415 | 17,555,048 | 26,218,122 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | – | – | – | – | – | – | – |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 408,633 | 19,418,386 | 14,060,603 | 24,239,241 | 85,666,917 | 30,709,378 | 174,503,158 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | – | 762,595 | – | – | – | – | 762,595 |
| **Нийт санхүүгийн хөрөнгө** | **15,881,251** | **100,916,974** | **15,205,414** | **24,519,543** | **87,909,332** | **48,264,426** | **292,696,940** |
| Бусад банкны харилцах, хадгаламж | – | 27,071,623 | – | – | – | – | 27,071,623 |
| Репо хэлцэл | 25,078,317 | – | – | – | – | – | 25,078,317 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 43,199,346 | 25,395,552 | 14,295,880 | 11,501,731 | 10,156,353 | 11,439 | 104,560,301 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | – | – | – | – | – | – | – |
| Зээлээр авсан эх үүсвэр | – | 4,524,517 | 28,204 | 3,900,952 | – | – | 8,453,673 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | – | 150,269 | – | – | – | – | 150,269 |
| Түрээсийн өглөг | – | 155,131 | 155,131 | 310,939 | 2,927,493 | – | 3,548,694 |
